

J. K. ROWLING



ХАРРИ ПОТТЕР  

---

ЭРЛИЙЗ ХУНТАЙЖ

# Харри Поттер ба Эрлийз Хунтайж

Зохиолч:	J. K. Rowling <a href="http://www.jkrowling.com/">http://www.jkrowling.com/</a>
Орчуулагч:	Asuult Forum-ийн гишүүн CROFT <a href="http://forum.asuultserver.com">http://forum.asuultserver.com</a>
Эмхэтгэл, хөрвүүлэлт:	Б.Болдхүү Имэйл: <a href="mailto:bxbenny@gmail.com">bxbenny@gmail.com</a> Блог: <a href="http://www.boldkhuu.com">http://www.boldkhuu.com</a> Facebook: <a href="http://facebook.com/bxbenny">http://facebook.com/bxbenny</a> Twitter: <a href="http://twitter.com/bxbenny">http://twitter.com/bxbenny</a>

Эхийг Asuult Forum-аас авав.

## ГАРЧИГ

БҮЛЭГ 1: ӨӨР САЙД.....	4
БҮЛЭГ 2: ЭЭРҮҮЛИЙН МУХАР ГУДАМЖ .....	15
БҮЛЭГ 3: БОЛНО БОЛОХГҮЙ .....	27
БҮЛЭГ 4: ГОРАЦИЙ СЛИЗНОРТ .....	38
БҮЛЭГ 5: ХЭТЭРХИЙ ОЛОН ФЛЕГМИ .....	53
БҮЛЭГ 6: МАЛФОЙН ТОЙРУУ ЗАМ .....	69
БҮЛЭГ 7: СЛИЗНЕЙН КЛУБ .....	84
БҮЛЭГ 8: СНЕГГ ХӨӨРӨН БАЯРЛАВ .....	101
БҮЛЭГ 9: ЭРЛИЙЗ ХУНТАЙЖ .....	111
БҮЛЭГ 10: МРАКСЫН ГЭР БҮЛ .....	126
БҮЛЭГ 11: ГЕРМИОНА ТУСЛАМЖЫН ГАРАА СУНГАВ .....	141
БҮЛЭГ 12: МӨНГӨ БА БАДМААРАГ .....	154
БҮЛЭГ 13: РЕДДЛИЙН НУУЦ .....	168
БҮЛЭГ 14: ФЕЛИКС ФЕЛИЦИС.....	182
БҮЛЭГ 15: ҮЛ ЭВДЭГДЭХ АМЛАЛТ .....	198
БҮЛЭГ 16: МАШ ХҮЙТЭН ЗУЛ САР .....	213
БҮЛЭГ 17: СУЛХАН ДУРСАМЖ .....	229
БҮЛЭГ 18: ТӨРСӨН ӨДРИЙН ГЭНЭТИЙН БЭЛЭГ .....	245
БҮЛЭГ 19: ЭЛЬФ МӨРДӨГЧИД.....	261
БҮЛЭГ 20: ЛОРД ВОЛАН-ДЕ-МОРТЫН ХҮСЭЛТ.....	276
БҮЛЭГ 21: ТАЙЛАГДАШГҮЙ ӨРӨӨ.....	291
БҮЛЭГ 22: ОРШУУЛГЫН ДАРАА.....	305
БҮЛЭГ 23: КРЕСТРАЖУУД.....	320
БҮЛЭГ 24: СЕКТУСЕМПРА.....	333
БҮЛЭГ 25: ҮЗМЭРЧИЙГ СОНССОН НЬ.....	346
БҮЛЭГ 26: АГУЙ.....	360
БҮЛЭГ 27: АЯНГАТ ЦАМХАГ .....	375
БҮЛЭГ 28: ЭРЛИЙЗ ХУНТАЙЖ ЗУГТСАН НЬ .....	386
БҮЛЭГ 29: ГАЛТ ШУВУУНЫ НУЛИМС.....	394
БҮЛЭГ 30: ЦАГААН БУНХАН .....	408

## БҮЛЭГ 1: ӨӨР САЙД

Ойролцоогоор шөнө дунд болж байлаа. Ерөнхий сайд өрөөндөө ганцаар суугаад урт нот бичиг уншиж байв. Мөрүүд нүдний өмнүүр жирэлзэх хэдий ч толгойд ер төвлөрсөнгүй. Ерөнхий сайд эх орны нөгөө өнцгөөс утасдах ерөнхийлөгчийн утасдахыг хүлээх зуураа хэзээ ярих талаар нь бодтол ер бусын хүнд хэцүү урт долоо хоногийн таагүй дурсамж зурсхийж толгойд нь өөр бодол багтах зай үлдсэнгүй. Тэр хуудсан дээр төвлөрөхийг хичээсэн ч улс төрийн өрсөлдөгчийнх нь царай урдаас нь тавлангуй ширтэж байв. Өнөөдөр өрсөлдөгчийнх нь тоочсон эдгээр зүйлс сүүлийн долоо хоногт болсон аймшигт зүйлсийн жагсаалтыг тус бүрд нь засгийн газар буруутайгаар тайлбарласан байлаа.

Ерөнхий сайд шударга бус буруутгалыг уншаад судасны цохилт нь түргэсэв. Ертөнц дээрх ямар засгийн газар гүүрний нуралтыг зогсоож чадах юм бэ? Ямар зэвүү хүрэм амьтан гүүрний талаар дурьдах өөдгүй арга бодож олдог байна. Гүүрний барилга арваас доошгүй жил болсон ч хамгийн шилдэг мэргэжилтэнгүүд яагаад гэнэт дундуураа хоёр хэсэг болон хуваагдаж арван хоёр машин голын ёроол руу илгээсний учрыг тайлбарлаж чадахгүй байлаа. Тэгтэл бас цагдаагийнхан илрүүлж чадахгүй байгаа хоёр онц хэрцгий аллагын тухай мэдээлэл тарсныг хэлэх үү. Ямар засгийн газар эх орны баруун өмнө зүгт гэнэтийн хүчтэй хар шуурга дэгдэж ихээхэн хэмжээний хор хохирол учруулана гэдгийг урьдаас мэдэх юм бэ? Бас түүний орлогч сайд Гэрберт Чорли энэ долоо хоногт биеэ хачин жигтэй авч явсан учраас ихэнхи цагаа гэр бүлийнхэнтэйгээ өнгөрүүлж байгаа нь түүний буруу хэрэг үү?

«Эх орныг уйтгар гуниг нөмрөн аваад байна» гэж өрсөлдөгч нь яриагаа төгсгөхдөө сэтгэл хангалуун инээмсэглэлээ бараг нуусангүй.

Золгүй нь гэвэл тэр цэвэр үнэнийг хэлжээ. Ерөнхий сайд үүнийг мэдэрч байлаа. Хүмүүс дасал болоогүй өөдгүй зүйлс хийдэг болж. Тэр ч байтугай цаг агаар хүртэл бараан дүнсгэр болж чийглэг хүйтэн манан долоон сарын дундуур суунаглав ... энэ бол буруу, хэвийн биш.

Тэр хоёр дахь хуудсыг эргүүлээд базаахгүй ажлынх нь талаар хэр их үлдсэнийг харах найдлагагүй оролдлого хийв. Толгойгоороо гараа бариад өрөөгөө гунигтай харлаа. Энэ нь сайхан гантиг ханан зуух бүхий сүрлэг өрөө байсан бөгөөд өндөр хүрээтэй цонх нь улирлын бус жихүүнд хаалттай байх аж. Ерөнхий сайд үл ялиг чичирснээ босож цонх руу очоод шилний цаана суунаглах манан руу харлаа. Тэгтэл түүний ард хэн нэгэн аяархан ханиалгах сонсогдов.

Ерөнхий сайд хөшөөд өөрийнхөө айсан тусгалыг харанхуй шилэнд харлаа. Чимээ түүнд танил байв. Тэр урьд нь энэ ханиадыг сонсож байсан билээ. Тэр хоосон өрөө рүүгээ алгуурхан эргэж хараад,

- Юу болоо вэ? гэж аль болох хатуу дуугарахыг хичээв.

Хэдхэн хормын турш түүнд хэн ч хариулахгүй байх гэсэн бүтэшгүй найдлага төрөв. Тэгтэл урьдаас бэлтгэсэн мэдээлэл уншиж буй мэт шийдэмгий ажил хэрэгч хоолой

сонсогдлоо. Энэ хоолой ерөнхий сайдын хүлээж байсанчлан мэлхийтэй төстэй мөнгөлөг урт хиймэл үс бүхий жижигхэн хүнийг дүрсэлсэн өрөөний булан дахь тосон зурагнаас гарч байв.

- Маглуудын ерөнхий сайдад. Даруйхан уулзах хэрэгтэй байна. Яаралтай хариу өгнө үү. Таныг хүндэтгэсэн, Фаж гээд зурган дээр байсан хүн ерөнхий сайд руу асуунгуй харлаа.

- Э-э ... сонсооч одоо тохиромжтой цаг биш байна ... намайг утасны дуудлага хүлээж байгааг харж байгаа биз дээ ... ерөнхийлөгчөөс ...

- Утасны дуудлагыг хүлээж болно гэж хөрөг даруй хэлэв. Ерөнхий сайдын зүрх палхийлээ. Тэр үүнээс л айж байсан юм.

- Гэхдээ би үнэхээр ярина гэж найдаж байгаа юмсан ...

- Бид ерөнхийлөгчийг утасдахаа мартахаар зохион байгуулъя. Тэр тань руу маргааш орой утасдана. Ноён Фажын хүсэлтэнд даруйхан хариулахыг хүсье.

- Би ... өө ... маш сайн байна. Тиймээ, би Фажтай уулзахыг зөвшөөрч байна гэж сайд сулхан хоолойгоор хэлэв.

Тэр яаран ширээ рүүгээ очих замдаа зангиагаа заслаа. Түүнийг дөнгөж суудалдаа суугаад царайгаа аль болох төлөв түвшин болгохтой зэрэг гантиг гадартай хоосон ханан зууханд ногоон дөл дүрсхийж махлаг хүн гарч ирэхэд өчүүхэн ч гайхаж түгшсэн төрх гаргахгүйг хичээлээ. Хормын дараа тэр сахлаг зузаан хивсэн дээр буугаад урт судалтай жанчныхаа ханцуйгаар үнсээ гөвж, гартаа ногоон өнгийн бүрх малгай барьсан байлаа.

- Аан ... ерөнхий сайд. Таньтай ахин уулзсандаа баяртай байна гээд Корнелиус Фаж гараа сунгав.

Ерөнхий сайд хариу мэндчилж чадсангүй тул дуугүй байлаа. Тэр ховорхон уулздаг ч гэлээ Фажыг харахдаа баяртай бус байдаг нь үргэлж таагүй мэдээ сонсгодогт байж болох юм. Энэ удаад Фаж ихээхэн зовж зүдэрсэн төрхтэй харагдав. Тэр суугаад үрчийн харлаа. Ерөнхий сайд урьд нь энэ төрхийг харж байсан болохоор ердийнхөөрөө сайн зүйл болохгүйг мэдэв.

- Юугаар туслах вэ? гээд Фажын сунгасан гарыг бариад бичгийн ширээний дэргэдэх сандалд суухыг зангав.

- Юунаас эхлэхээ мэдэхгүй байна гэж Фаж бувтнаад сандал дөхүүлэн суунгаа өвдөг дээрээ ногоон бүрхээ тавилаа. Энэ долоо хоногт ... энэ долоо хоногт ...

- Таньд ч гэсэн хүнд долоо хоног байсан хэрэг үү? гэж ерөнхий сайд хөндий асуугаад энэ нь түүнийг хангалттай ажилтай гэдгийг ойлгуулна байх гэж найдав.

- Тиймээ, тэгэлгүй яахав гээд Фаж ядрангуй нүдээ нухлан баргар харав.

- Надад ч гэсэн таны адил долоо байлаа, ерөнхий сайдаа. Брокдейлийн гүүр ...

Боунс, Вэнс хоёрын аллага ... баруун өмнө зүгт гарсан дуулиан гээд л ...

- Та ... э-э ... таны ... таны хүмүүс бас үүнд оролцсон хэрэг үү ... энэ үйл явдалд? Фаж түүн рүү ширүүн харав.

- Мэдээж тэд байсан. Гэхдээ та юу болсныг ойлгож байна уу?

- Би ... гэж ерөнхий сайд түгдэрлээ.

Тэр Фажын ирэлтэнд дургүй байсан юм. Ямар гэсэн ерөнхий сайдад хичээлээ давтаагүй сурагч адил таагүй мэдрэмж төрөв. Тэдний хамгийн анхны уулзалт ерөнхий сайд болсон үдэш болсон билээ. Тэр үед юу болсныг санатал дурсамж нь алслан холдов.

Тэр тэгэхэд өрөөндөө ганцаар олон жилийн дараа мөрөөдөж байсан зүйлдээ хүрсэн ялалтын цэнгэл амсан сууж байтал гэнэтхэн нурууны ард өнөөдрийнх шиг аяархан ханиалт сонсогджээ. Түүнийг эргэж харахад ёозгүй хүний хөрөг ярьж сайд танилцах хүсэлтэй байгааг дуулгажээ.

Тэр үүнийг урт удаан сонгуулийн компаниг ажилд биеэ хэт дайчилсны улмаас галзуурч байна гэж бодлоо. Хэдийгээр түүнийг ярьдаг хөрөг ихэд айлгасан ч гэлээ ханан зуухнаас шидтэн үсрэн гарч ирээд гар барьсантай харьцуулахын аргагүй байлаа. Ерөнхий сайд нэг ч үг хэлээгүй ч Фаж дуртайгаар энэ дэлхий дээр шидтэнгүүд нууцаар амьдардаг бөгөөд түүнд санаа зовох хэрэггүй, ид шидийн яам бүхий л шидэт ертөнцийн оршин байгааг мэдэгдэхгүйн тулд хариуцлагатайгаар хатуу мөрдөн сахиж байдаг гэж тайлбарлажээ. Фаж бас шүүрэн дээрх нислэгийг хянах болон луунуудыг хяналтанд байлгах (ерөнхий сайд үүнийг сонсоод ширээнээсээ золтой л уначихсангүй) зэрэг олон янзын асуудлыг багтаасан хүнд ажил гэдгийг тайлбарласан байна. Тэрбээр эцэст нь мэлэрсэн ерөнхий сайдын мөрөн дээр зөөлөн алгадав.

- Юунд ч түгших хэрэггүй дээ. Хачирхалтай нь гэвэл та намайг ахиж хэзээ ч харахгүй байх. Би зөвхөн манай оронд маглуудын ... шидгүй хүмүүсийн амьдралд нөлөөлж болохоор ноцтой зүйл болсон тохиолдолд анхааруулж байх болно. Үлдсэн цагт бид зарчмын хувьд өөр өөрсдийнхөөрөө амьдрах юм. Та намайг өмнөх ерөнхий сайдаасаа дээр угтсан гэдгийг хэлэх ёстой. Тэр намайг наргисан гэж бодоод цонхоор гарган хаяхыг оролдсон л доо.

Тэр агшинд ерөнхий сайд сэхээ оров.

- Тэгэхээр та наргисан биш байх нь ээ ...? Энэ түүний сүүлчийн цөхөрсөн найдлага байлаа.

- Үгүй. Харамсалтай нь үгүй гэж айж байна. Үүнийг хар даа. Тэрбээр ерөнхий сайдын цайны аягыг алаг даага болон хувиргав.

- Гэхдээ яагаад ... яагаад хэн ч надад хэлээгүй юм гэж ерөнхий сайд алаг даага баримтынх нь үзүүрээс мэрэхийг хараад хэллээ.

- Ид шидийн яам зөвхөн маглуудын ерөнхий сайдтай харьцдаг юм. Бид ингэсэн нь нууцыг хадгалах найдвартай арга гэж үзсэн гээд Фаж шидэт саваагаа хүрэмнийхээ дотор руу шургуулав.

- Тэгвэл яагаад эхний ерөнхий сайд надад анхааруулаагүй юм ... гэж ерөнхий сайд өрөвдөлтэй дуугарав.

Фаж энэ үгэнд хөхөрлөө.

- Хүндэт ерөнхий сайд минь, та өөрөө хэн нэг хүнд энэ тухай ярих байсан уу? Фаж үргэлжлүүлэн инээсээр ханан зууханд нэгэн төрлийн чимх дарь хийж маргад ногоон дөл рүү алхан ороод исгэрэх чимээ гарган алга болов. Ерөнхий сайд зогссон хэвээр үлдээд хэнд ч энэ тухай хэлэхгүй байхаар шийдлээ. Учир нь хэн түүнд итгэх юм бэ?

Цочирдол түүнээс удтал арилсангүй. Тэр эхэндээ Фаж үнэн хэрэгтээ хий юм харагдсан хэрэг гэж өөрийгөө ятгахыг оролдсон бөгөөд сонгуулийн компанит ажлын ядаргаа гэж үзжээ. Тэгээд хий хоосон зүйлээс ангижрахын тулд таагүй уулзалтыг санагдуулж болох алаг даагыг ач охиндоо бэлэглээд дараа нь хувийн нарийн бичигтээ Фажын ирэхийг мэдээлсэн ёозгүй хүний хөргийг зайлуулахыг үүрэгдлээ. Гэвч түүний эмээсэн ёсоор хөргийг зайлуулах боломжгүй байв. Түүнийг хананаас авахын тулд ээлж дараалан мужааны бүхэл бүтэн баг, барилгын хэдэн ажилтан, уран зургийн түүхч оролдоод амжилт олсонгүй. Эцэст нь ерөнхий сайд цөхрөн гараа зангаад түүнийг хөдөлгөөнгүй чимээгүй байгаасай гэж найдав. Заримдаа түүнийг нүдний булангаар харах үед зурагны эзэн эвшээх юмуу хамраа маажиж нэг хоёр удаа бүр зурагнаасаа яваад бохир хүрэн хоосон зотон үлдээсэн байх нь үзэгджээ. Гэвч ерөнхий сайд зураг руу харахгүйг хичээн энэ бол нүд хуурсан үзэгдэл гэж өөртөө хэлж билээ.

Гурван жилийн өмнө энэ үдэштэй жигтэйхэн адил нэг орой ерөнхий сайд өрөөндөө ганцаар сууж байтал хөрөг ахин Фажын ирж айсуйг мэдэгдсэн бөгөөд ханан зуухнаас норж сандралд автсан байртай үсрэн гарчээ. Ерөнхий сайд түүний яагаад хивсэн дээр ус дуслуулж буйн учрыг асуух гэсэн ч Фаж түүний амьдралдаа хэзээ ч сонсоогүй Серый Ус Блэк гэдэг хүн шоронгоос оргосон тухай зэвүүцэнгүй ярьж, ямар нэг «Хогвартс» гэсэнтэй ойролцоо үг болон Харри нэртэй хүүгийн тухай ярьжээ.

- Би сая Азкабанаас ирлээ гэж Фаж амьсгаадан хэлээд шалан дээр бүрх малгайныхаа усыг сэгсэрлээ.

- Энэ хойд зүгийн тэнгисийн дунд оршдог болохоор нисэхэд таагүй юм ... Дементорууд санаа зовж байна. Тэднээс хэн ч урьд нь зугтаж байгаагүй юм. Би ямар ч гэсэн таньтай уулзахаар ирлээ ерөнхий сайдаа. Блэк урьд нь маглуудыг алж байсан болохоор Хэцүү нэрттэй ахин нэгдэхийг төлөвлөж байгаа ... Ингэхэд та чинь Хэцүү нэртийг мэдэхгүй билүү! гээд түүн рүү найдлагагүй ширтсэнээ,

- За яахав, суу би таньд тайлбарласан нь дээр бололтой ... Шарз уух уу гэв

Ерөнхий сайд түүний өөрийн өрөөнд суухыг урьж түүнчлэн шарзаар зочлох гэсэн явдалд ихэд эгдүүцсэн авч юутай ч гэсэн суулаа. Фаж шидэт саваагаа даллан агаарт хоёр том шилэн аяга бүхий хуван шар өнгийн шингэн гаргаж ирээд нэг гараа ерөнхий сайд руу сунган нөгөөгөөрөө сандал дөхүүлэн суулаа.



Фаж ихэнхи цагийг нь ярилаа. Ямар нэг агшинд тэр тодорхой нэрийг чанга дурьдахаас зайлсхийж байсан бөгөөд үүнийхээ оронд цаасны өөдөс дээр бичин сайдын сул гарт атгуулав. Фаж эцэст нь явахаар босох үед ерөнхий сайд араас нь бослоо.

- Тэгэхээр та тэгж бодож байгаа юм уу ... гээд зүүн гартаа барьсан цаасны өөдөс рүү нүдээ онийлгосноо,

- Лорд Вол ...

- Хэцүү нэрт гэж хэл! хэмээн Фаж тасхийв.

- Өршөөгөөрэй ... Та Хэцүү нэртийг амьд гэж бодож байгаа хэрэг үү?

- Юу гэж хэлэх юм дээ ... Дамблдор түүнийг амьд гэдгийг нь баталж байгаа гээд Фаж судалтай жанчныхаа хоолойг товчилсноо,

- Гэхдээ бид түүнийг олоогүй л байна. Хэрвээ та миний бодлыг сонирхож байвал тэр дэмжигчидгүй болохоор аюулгүй болсон ийм учраас хамгийн гол нь Блэкэд л санаа зовох хэрэгтэй байна. Та анхааруулга тараах уу? Сайн байна. Бид ахин уулзахгүй гэж найдна, ерөнхий сайдаа. Тавтай нойрсоорой! гэв.

Гэвч тэд ахин уулзлаа. Ойролцоогоор жилээс багагүй хугацаа өнгөрсөний дараа сэтгэл нь хямарсан Фаж өрөөний голд суугаад ерөнхий сайдад квиддичийн дэлхийн аваргын тэмцээн дээр (энэ нь юу юм болоо) хэдэн маглуудын оролцоотой явдал болсон тухай ярьж гэхдээ ерөнхий сайдыг санаа зовох хэрэггүй бөгөөд Хэцүү нэртийн Хар тамга илгээгдсэн явдал нь ямар ч ач холбогдол илэрхийлэхгүй гэж хэлжээ. Фаж үүнийг тохиолдолын явдал гэдэгт итгэлтэй байсан бөгөөд маглуудтай харилцаа тогтоох хэлтэс үйл явдалд оролцогсдын ой санамжыг арчсан талаар ярьсан байна.

- Өө, арай мартсангүй гээд тэр эцэст нь,

- Бид хилээр Гурван шидтэний тэмцээнд зориулан гадаадаас гурван луу болон нэг сфинксийг оруулаад байгаа. Энэ бол шидэт амьтныг хянан зохицуулах хэлтсийн хувьд ердийн дадал болсон зүйл ч таньд манай оронд аюултай амьтад байгааг мэдэх хэрэгтэй гэж үзлээ гэв.

- Би ... юу ... луунууд гэнээ? хэмээн ерөнхий сайд шүлсээ үсчүүлэн орилов.

- Тиймээ, гурван ширхэг гэж Фаж батлаад,

- Бас нэг сфинкс. За өдрийг сайхан өнгөрүүлээрэй! гэв.

Ерөнхий сайд луунууд болон сфинксээр ажил хэрэг хязгаарлагдана гэж найдсан ч үгүй бололтой. Хоёр жил ч өнгөрөөгүй байтал Фаж ханан зуухнаас ахин гарч ирээд Азкабаны шоронгоос бүлэг гэмт хэрэгтэн оргосон гэж мэдээлжээ.

- Бүлэг гэмт хэрэгтэн оргосон гэнээ? хэмээн ерөнхий сайд сөөнгөтөв.

- Санаа зовох хэрэггүй дээ, санаа зовох хэрэггүй! Бид тэднийг бүгдийг нь барьж авна. Зүгээр л таныг мэдэж байх хэрэгтэй гэж бодсон юм! хэмээн Фаж нэг хөлөө дөл давуулан тавиад хашгирлаа.



Ингээд ерөнхий сайдыг «Хөөе, түр хүлээгээрэй!» гэж хашгирахын зуургүй ногоон очис дунд алга боллоо.

Сөрөг талынхны хэлдэгчилэн ерөнхий сайд тэнэг хүн байсангүй. Тэр Фажын анх уулзахдаа өгсөн амлалтыг мартаагүй болохоор ирэх болгондоо сэтгэл нь улам үймэрсэн байхыг анзаарчээ. Тэр яамны сайдын тухай бодох дуртай байсан ч (эсвэл түүнийг өөр сайд гэж нэрлэдэг байв) дараагийн удаа ирэхдээ илүү ноцтой зүйлийн шалтгаан болох вий гэж эмээхгүй байж чадсангүй. Тэгтэл Фаж ханан зуухнаас гарч ирэхдээ уурсаж тавгүйцсэн төрхтэй байгаагаас үзэхэд аялалын зорилгыг нь тааж чадаагүй хэдий ч хүнд долоо хоног өнгөрсөн нь тодорхой байлаа.

- Танай энэ юу гэж хэлэх юм дээ ... э-э ... шидэт ертөнцөд юу болж байгааг мэдэх нь надад ямар хэрэгтэй юм бэ? Надад үүнгүйгээр сэтгэл зовох ажил хангалттай байна гэж ерөнхий сайд татгалзав.

- Бидэнд санаа тавих нэг л зүйл байгаа хэмээн Фаж түүний үгийг таслаад,

- Брокдейлийн гүүр өөрөө эвдрээгүй. Шуурга ч үнэн хэрэгтээ шуурга биш байсан. Бас алуурчид зөвхөн маглуудыг алаагүй. Герберт Чорли гэр бүлээсээ тусдаа аюулгүй байдалд байгаа. Одоо бид түүнийг гэгээн Мунгогийн ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгт хэвтүүлэх гэж байгаа гэв.

- Та юуны тухай яриад байна ... би ... юу? гэж ерөнхий сайд дуу алдав.

Фаж гүнзгий санаа алдлаа.

- Ерөнхий сайдаа би түүнийг эргэж ирснийг гүн харамсалтайгаар мэдэгдэх ёстой. Хэцүү нэрт эргэн ирсэн.

- Эргэн ирсэн гэнээ? Та эргэн ирсэн гэж ... түүнийг «амьд» байгаа гэж хэлэхийг хүсээ юу? Миний бодлоор ...

Ерөнхий сайд яаран гурван жилийн өмнөх аймшигт дурсамжаа онгичлоо. Фаж түүнд бусад шидтэнгүүдийг айлгадаг нэг хүн байдаг, тэр шидтэн тоо тоомшгүй олон гэмт хэрэг хийсэн бөгөөд арван таван жилийн өмнө нууцлагаар алга болсон гэж ярьсан билээ.

- Тиймээ, тийм амьд. Ер нь бол ... мэдэхгүй байна ... магадгүй алж болохооргүй хүн ч юмуу? Би үүнийг ойлгохгүй байгаа ч Дамблдор тайлбарлахыг хүсэхгүй байгаа. Гэхдээ ямар ч байсан тэр одоо ярьж, явж, алж биетэй болсон. Бидний уулзалтын зорилго нь түүний амьд гэдгийг хэлэх гэсэн юм.

Ерөнхий сайд юу хэлэхээ мэдсэнгүй ч шургуу дадал зуршилынхаа ачаар эртний ярианыхаа нарийн ширийн бүрийг санаж чаддаг байлаа.

- Харин тэр Серый Ус Блэк ... э-э ... Хэцүү нэрттэй хамт байгаа юу?

- Блэк? Блэк гэнээ? хэмээн Фаж сэтгэлээр унан давтаад гартаа малгайгаа түргэн эргэлдүүлэв.

- Та Сириус Блэкийн тухай ярьж байна уу? Үгүй дээ, Мерлиний сахлаар андгайлая! Блэк үхсэн ... Яаж тайлбарлах юм дээ бид ... э-э ... түүний тухайд эндүүрч

байсан байна. Ямар ч гэсэн тэр буруугүй. Бас хэзээ ч Хэцүү нэртийн талд байгаагүй. Би түүнийг үхсэн гэж хэлэх байна. Ер нь бол түүнийг алсан. Ид шидийн яамны байшинд. Энэ талаар мөрдлөг явагдаж байгаа гээд гартаа малгайгаа улам түргэн эргэлдүүлэв.

Ерөнхий сайд Фажыг өрөвдсөн явдалдаа өөрөө ч гайхлаа. Гэхдээ тэр ханан зууханд шилжин алга болж чаддаггүйдээ болон түүний захиргааны байшинд аллага болоогүйд ... сэтгэл хангалуун байв.

Ерөнхий сайд нууцхан модон ширээ цохих үед Фаж үргэлжлүүлэн,

- Одоо Блэк гол бус. Хамгийн гол нь бид дайны байдалд байгаагаа ойлгох хэрэгтэй байна гэв.

- Дайн гэнээ? Жижигхэн зүйлийг хэтрүүлээд байгаа юм биш үү? хэмээн ерөнхий сайд түгшин асуув.

- Хэцүү нэрт Азкабаны шоронгоос нэг сард зугтсан дагалдагч нартайгаа ахин нэгдсэн гээд Фаж улам түргэн ярьж малгайгаа ууртайгаар эргэлдүүлсэнд цайвар ногоон өнгийн толбо болон бүүдгэртэв.

- Тэд ил гарч ирж чадахгүй болохоор уур хорслоо сүйрлээр илэрхийлж байна.

Брокдейлийн гүүр бол тэдний хийсэн ажил, ерөнхий сайдаа. Тэр л намайг садаа болохоо болин зам тавьж өгөхгүй бол маглуудыг бөөнөөр нь ална гэж заналхийлсэн.

- Бурхан минь, таны буруугаас болж хүмүүс үхэж байхад харин би зэвэнд идэгдсэн төмөр тоноглол уулзвараараа салсан тухай асуултанд хариулахад хүрч байна! гэж ерөнхий сайд ууртай хашгирав.

- Миний буруу гэнээ? Та намайг иймэрхүү байдлаар дарамтална гэж бодоо юу?

- Магадгүй үгүй ч байсан гээд ерөнхий сайд босч өрөөн дундуур холхиж эхлэв.

Би ахиж тийм аймшигт хэрэг гаргахгүйн тулд бүх хүчээ гарган дарамтлах болно!

- Та намайг үнэхээр ямар ч чармайлт гаргаагүй гэж бодож байна уу? гэж Фаж шаардангуй хэлээд,

- Ид шидийн яамны бүх мракоборец энэ асуудалд тохоон томилогдоод байгаа ч одоо хүртэл түүнийг болон дагалдагчдыг нь барьж чадаагүй байна. Гэхдээ бид бараг арван гурван жилийн турш хэнд ч баригдаагүй цаг үеийнхээ хамгийн хүчирхэг шидтэнгийн тухай ярьж байна шүү дээ! гэв.

- Та саяхан өмнө зүгт гарсан шуургыг тэр дуудсан гэж хэлээгүй билүү? гээд ерөнхий сайдын алхаа улам ууртай боллоо. Тэр одоо бүх аймшигт аваар ослын шалтгааныг нээж илрүүлсэн ч олон нийтэд хэлж чадахгүйдээ эцсийн эцэст бүгд засгийн газрын буруу болж байгаад хилэгнэж байлаа.

- Энэ шуурга биш байсан гэж Фаж золгүй хоолойгоор хэлэв.

- Өршөөгөөрэй! гэж ерөнхий сайд дэлбэрээд хөлөө дэвслэн,

- Үндсээрээ булгарсан модод, хийссэн байшингийн дээвэр, хазайсан гэрлийн шон, аймшигтай гэмтсэн цогцос ... гэв.

- Энэ бол Үхэл залгигчдын хийсэн ажил. Хэцүү нэртийн талынхныг тэгж нэрлэдэг юм. Бас ... бас бид үүнд аварга биетүүд оролцсон гэж сэжиглэж байгаа.

Ерөнхий сайд үл үзэгдэх хананд тулсан мэт зогсов.

- Хэн оролцсон гэнээ? Фаж ярвайлаа.

- Тэр сүүлчийнхэд сүр жавхлантай сэтгэгдэл төрүүлэхийн тул аварга биетүүдийг оролцуулсан. Үүнд ой санамж арчих бүтэн алба ажиллаж үйл явдлыг харсан гэрчүүдийн ой ухааныг арчсан. Бас шидэт амьтныг хянан зохицуулах хэлтсийн тусламжтай золгүй явдал болсон газар хайж байгаа ч аварга биетүүдийг одоо хүртэл олоогүй л байна ...

- Та юу яриад байна! гэж ерөнхий сайд зандарлаа.

- Ид шидийн яамныхны өрөвдөлтэй байдалд ороод байгааг нуух юм алга. Бас дээр нь нэмээд Амелий Боунсыг алдаад байна.

- Хэнийг алдсан гэнээ?

- Амелий Боунс. Тэр шидтэний хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийг толгойлдог байсан юм. Бид түүнийг Хэцүү нэрт өөрийн биеэр алсан байж болзошгүй гэж үзэж байгаа. Учир нь тэр их ер бусын авъяаслаг шидтэн болохоор дийлэхэд амаргүй л дээ.

Фаж хоолой засан ханиалгаад эцэст нь малгайгаа эргүүлэхээ болилоо.

- Тиймээ энэ аллагын тухай сонинд бичсэн байсан. Манай сонинд. Амелия Боунс ... тэнд бичснээр бол хамгийн жирийн ганцаар амьдардаг нас тогтсон эмэгтэй гэсэн байсан. Хэрвээ эндүүрээгүй бол аллага онц хэрцгий байсан байхаа? Энэ түүх олон нийтэд зарлагдсан. Мөрдөн шалгасан ч мухардалд орсон гэж ерөнхий сайд саяхан уурлаж байснаа мартан хэллээ.

Фаж санаа алдав.

- Зөвхөн тэр ч мухардалд ороогүй! Аллага болсон өрөө дотроосоо түгжээтэй байсан. Харин бид хэн хийснийг нь мэдэж байгаа ч буруутанг барихад тус болохгүй байна. Бас Эмелина Вэнсийг ч тэгсэн байх боломжтой. Магадгүй та түүний тухай сонсоогүй байх л даа ...

- Юу гэж дээ, сонссон! Энэ эндээс холгүй булангийн цаана болсон. Сонинд ерөнхий сайдын арын хашаанд хууль зөрчигдөж байна гэж бичсэн байсан ...

- Зөвхөн энэ бүхэн ч биш Дементорууд эргэн тойрон тэнүүчилж хүмүүсийг баруун зүүнгүй довтолж байна ...

Энэ үг илүү жаргалтай үед ерөнхий сайдад утгагүй санагдах байсан хэдий ч одоо тэр илүү цэцэн болжээ.

- Харин би Дементорууд Азкабаны шоронг харгалздаг гэж бодсон юмсан гэж болгоомжтой хэлэв.

- Харгалздаг байсан. Гэхдээ одоо харгалзахаа больсон. Тэр өөрийн байраа орхиод Хэцүү нэрттэй нэгдсэн. Энэ хүнд цохилт болсныг танаас нуух юун гэж Фаж ядрангуй хэлэв.

- Гэхдээ та надад энэ амьтан хүмүүсийн найдвар баяр хөөрийг сордог гээ биз дээ? гэж ерөнхий сайд айдаст автан хэлэв.

- Яг үнэн. Ийм зүйлээр л үрждэг юм. Энэ бүх манангийн учир энэ.

Ерөнхий сайдын хөл сулраад ойролцоох сандал руу лагхийтэл суучихлаа. Түүнд ямар нэг үл үзэгдэх амьтан хотоор тэнүүчилж цөхрөл найдлагагүй байдлын энерги түгээж байна гэсэн аймшигт бодол төрөв.

- Сонсооч, Фаж ямар нэг зүйл хийх ёстой! Энэ таны болон ид шидийн яамны чинь үүрэг биз дээ!

- Хүндэт ерөнхий сайд минь, та энэ бүх явдлын дараа намайг сайдаар үлдэнэ гэж үнэхээр бодож байна уу? Би хэдийн гурван өдрийн өмнө буусан! Хоёр долоо хоногийн турш бүхий л шидэтний ертөнц намайг ажлаасаа халагдахыг шаардаж байлаа. Миний албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд нэг ч ийм явдал гарч байсангүй! гээд Фаж инээмсэглэхийг оролдов.

Ерөнхий сайд энэ агшинд сэхээ орлоо. Хэдийгээр эгдүүцэж байсан ч гэлээ түүнд эсрэг талын суудалд дээр атийн сууж буй хүнийг өрөвдөх сэтгэл төрлөө.

- Их харамсалтай байна. Би таньд ямар нэг зүйлээр тус болж чадах уу? гэж эцэст нь хэлэв.

- Таны зүгээс их эелдэг хэрэг байлаа, ерөнхий сайдаа гэхдээ юугаар ч туслах боломжгүй. Өнөөдөр миний ийшээ ирсний учир гэвэл таныг өөрийн залгамжлагчтай танилцуулах гэсэн юм. Би түүнийг хэдийн энд ирсэн байх ёстойг мэдэж байгаа ч их завгүй болохоор удахгүй ирэх байх ...

Фаж мөнгөлөг урт хиймэл үстэй ёозгүй хүний хөрөг рүү харлаа. Тэр галууны өдөөр чихээ ухаж байв.

Фаж харцыг ажиглангуут хөрөг,

- Тэр энд хормын дараа ирнэ. Дамблдор бичих захиагаа дуусгаж байгаа гэлээ.

- Түүнд амжилт хүсье гэж Фаж хэлэхэд хоолойд нь анх сонсогдсон гашуун өнгө сонсогдов.

- Сүүлчийн хоёр долоо хоногийн турш би Дамблдор өдөрт хоёр удаа захиа илгээж байгаа ч хуруугаа ч хөдөлгөхийг хүсэхгүй байна. Хэрвээ тэр хүүг жаахан ятгах юм бол ... магадгүй Скримжерт илүү аз таарахыг хэн байг гэхэв дээ.

Фаж гоморхсон байртай чимээгүй болоход нам гүмийг хөрөг даруйхан эвдэж гэнэтхэн өөдрөг албаны хоолойгоор,

- Маглуудын ерөнхий сайдад. Уулзахыг хүсч байна. Яаралтай. Даруйхан хариу өгнө үү. Ид шидийн яамны сайд Руфус Скримжер гэв.

- Тиймээ тийм, би зөвшөөрч байна гэж ерөнхий сайд уйман хэлэхэд ханан зууханд ахин маргад ногоон дөл дүрсхийж ярсхийсэн дөл дундаас хоёр дахь шидтэн эргэлдэн гарч ирээд сахлаг хивсэн дээр уналаа.

Фаж хормын төдий тээнэгэлзсэнээ түүнийг хөл дээрээ босоход туслахад тоостой хар жанчаа гүвснээ ийш тийшээ харлаа.

Анхны агшинд ерөнхий сайдад Руфус Скримжер хөгшин арслантай төстэй гэсэн тэнэгдүү бодол төрөв. Тэр зогдор адил хүрэн шаргал өнгийн үс, өтгөн хөмсөгтэй агаад эвэр хүрээтэй шилний цаанаас шаргал өнгийн нүд ширтэж хөдөлгөөн нь уян налархай бөгөөд явахдаа үл мэдэг доголох ажээ. Энэ хүн хурц ухаан хатуу араншинтай гэдэг нь илт байлаа. «Яагаад шидтэний ертөнц энэ аюултай үед Фажыг биш Скримжерыг сонгосон болохыг ойлгож болох юм» гэж ерөнхий сайд бодлоо.

- Юу байна даа? гээд ерөнхий сайд эелдэгээр гараа сунгалаа.

Скримжер товчхон гар барихдаа өрөөг тойруулан харахаа больсонгүй дараа нь өврөөсөө шидэт саваа гаргаж ирлээ.

- Фаж таньд бүгдийг хэлсэн үү? гээд үүд рүү очин цоожны нүхэнд саваагаа хүргэхэд ерөнхий сайдад цоож шархийх чимээ сонсогдов

- Э-э ... тийм л дээ. Хэрвээ та эсэргүүцэхгүй бол би хаалга нээлттэй байхыг эрхэмлэдэг юм.

- Харин би бидэнд хэн ч саад болохгүйг эрхэмлэж байна. Бас харахгүй гээд саваагаа даллан цонхны хөшгийг татав.

- Ингээд болно. Би их завгүй хүн болохоор ажил хэрэгтээ шууд орёе. Юуны түрүүнд таны аюулгүй байдлын тухай ярих хэрэгтэй байна.

Ерөнхий сайд айдаст автан өндийн бослоо.

- Баярлалаа таньд гэхдээ би өөрийн хамгаалалтандаа сэтгэл хангалуун ...

- Харин бид үгүй гэж Скримжер түүний яриаг таслав.

- Хэрвээ ерөнхий сайдыг нь Имперкус шившлэгэн дор удирдаж байвал маглуудад таагүй зүйл болно. Таны шинэ нарийн бичиг ...

- Би Кингсли Брустеврыг солихгүй. Хэрвээ та энэ тухай ярьж байгаа бол! Тэр маш сайн ажилчин болохоор бусдаас хоёр дахин илүү ажил хийдэг гэж ерөнхий сайд дуу алдав.

- Учир нь гэвэл тэр шидтэн болохоор. Таны хамгаалалтанд өндөр бэлтгэгдсэн мракоборецыг тавьсан гэж Скримжер огт инээмсэглэлгүй хэлэв.

- Зогс зогс, хүлээгээрэй! Та өөрийнхөө хүнийг миний албанд тавьсан байна. Би хэнийг ажилд авахаа өөрөө шийднэ гэж ерөнхий сайд хашгирлаа.

- Харин та надад Брустеврт сэтгэл хангалуун байх шиг санагдсан юмсан? гэж

Скримжер хүйтнээр хэлэв.

- Би тэгж хэлсэн л дээ ... би сэтгэл хангалуун байсан.
- Тэгвэл бүх зүйл хэвийн шив дээ?
- Би ... хэрвээ тэр цаашид ажиллах юм бол ... э-э ... тэгвэл бүх зүйл сайн байна гэж ерөнхий сайд яриагаа эв хавгүйхэн төгсгөхөд Скримжер түүнийг сонссонгүй.
- Одоо таны орлогч, Герберт Чорлид хамаатай зүйлсийн талаар ярилцъя. Тэр олон нийтэд нугасыг дуурайн үзүүлсэн байхаа.
- Тэр яасан гэж? хэмээн ерөнхий сайд асуулаа.
- Түүнийг Имperiус шившлэгийн тусламжтай удирдаж байсан нь ойлгомжтой.

Түүний оюун ухаан гэмтсэн болохоор аюултай байж болзошгүй.

- Тэр чинь зөвхөн гуагласан! Жаахан амрахад л болно ... магадгүй спиртийн төрлийн зүйлээ багасгах...
- Бид энд түүнийг гэгээн Мунгогийн ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгт анагаагч нарын бүтэн баг харж байгаа тухай ярьж байна. Тэр хэдийн гурван хүнийг нь боомилж алахыг оролдсон. Би түүнийг маглуудаас тусгаарлавал дээр байх гэж бодсон юм.
- Би ... юу ... тэр дээрдэж байгаа гэж найдаж болох уу? гэж ерөнхий сайд сэтгэл зовон хэллээ.

Скримжер мөрөө хавчаад ханан зуух руу явав.

- Энэ миний хэлэхийг хүссэн зүйл бүхэн. Ерөнхий сайдаа би ажил ихтэй завгүй хүн болохоор Фажыг явуулсан юм. Тэр үлдэж надад зөвлөхийг зөвшөөрсөн юм л даа.

Фаж инээмсэглэхийг оролдсон ч бүтсэнгүй бөгөөд шүд нь өвдсөн юм шиг ярвайлаа. Скримжер халааснаасаа нууцлаг дарь гаргаж ирээд ханан зууханд хийхэд ногоон дөл дүрэлзэв. Ерөнхий сайд тэдэн рүү найдлагагүй хараад ийм хүнд үдшийг тэсвэрлэсэний эцэст тэсэрлээ.

- Бурханы авралаар, та нар шидтэнгүүд биз дээ! Та нар илбэдэж чадна! Та нар мэдээж ямар ч зүйлийн учрыг олж чадна!

Скримжер удаанаар эргэж харахад Фаж чихэндээ итгэхгүй шахам харлаа. Тэгээд энэ удаад эелдэгээр инээмсэглэн,

- Асуудал гэвэл ерөнхий сайдаа, бидний өрсөлдөгчид бас илбэдэж чаддагт гол учир оршиж байгаа юм гэлээ.

Хоёр шидтэн ар араасаа дараалан маргад ногоон дөл дунд алга боллоо.

## БҮЛЭГ 2: ЭЭРҮҮЛИЙН МУХАР ГУДАМЖ

Ерөнхий сайдын цонхны гадаа суунагласан жихүүн манангаас олон милийн тэртээ бохир голын хөвөөгөөр хог хаягдал энд тэндгүй хаягджээ. Ойролцоох хэрэглэгдэхээ больсон үйлдвэрийн том яндангийн сүүдэр муу ёрлон харлана. Энд харанхуй ус шуугихаас ондоо чимээгүй бөгөөд хатангир үнэг эрэг дээгүүр гэтэн өндөр ургасан зэрлэг өвсөн дунд шарсан төмсний хаягдал цаас найдангуй шиншлэхээс өөр амьдралын шинж тэмдэггүй байлаа.

Гэтэл аяархан тасхийх чимээ гарч усны дэргэд юүдэнтэй өндөр дүрс гарч ирэв. Үнэн хөшиж энэ хачирхалтай үзэгдлийг болгоомжлон харлаа. Дүрс ийш тийшээ харснаа урт жанчныхаа хормойгоор өвс шүүрдэн түргэн алхав.

Тэгтэл ахин тасхийх чимээ сонсогдож хоёр дахь юүдэнтэй дүрс шилжин гарч ирлээ.

- Хүлээгээрэй!

Айсан үнэг муухай чарлаад хогийн ургамал дундуур шурдхийн ганц харайлтаар эрэг рүү үсрэн гараад нуугдах газар эрэн зугтав. Тэгтэл ногоон гэрэл гялсхийж үхсэн үнэг газар уналаа.

Хоёр дахь дүрс шаахайгаараа алсан амьтанаа эргүүлэв.

- Зүгээр л үнэг байж гэх эмэгтэй хүний хайхрамжгүй хоолой юүдэн дороос гараад, Харин би мракоборец юм болов уу гэж бодлоо ... Цисси, хүлээ! гэв.

Тэр түүний араас харахад хэдийн үнэг унаж үхсэн эрэг өөд авирч байв.

- Цисси! Нарцисса! Намайг сонс!

Хоёр дахь эмэгтэй эхнийхийгээ гүйцэж гараас нь зуурсан ч цаадах нь мултарлаа.

- Буц, Белла!

- Чи намайг сонсох ёстой!

- Хэдийн сонссон! Би шийдвэр гаргасан. Намайг тайван орхи!

Нарцисса нэртэй эмэгтэй хуучин хашлагаар тусгаарлагдсан бул чулуун давчуу гудамж руу өгслөө. Хоёр дахь эмэгтэй, Белла түүнээс алхам ч холдсонгүй. Тэд харанхуйд зогсоод хэмхэрхий тоосгон байшингийн цонхноос тусах бүдэг гэрэл рүү харлаа.

- Тэр энд амьдардаг хэрэг үү? гэж Белла зэвүүцэнгүй асуулаа.

- Энд үү? Маглуудын шивхэн дунд уу? Бидний хэн ч ийшээ ...

Гэвч Нарциасса сонссонгүй. Тэр зэвэнд идэгдсэн хашлагын нүхээр шургалаад замаар цааш гүйлээ.

- Цисси, хүлээ!

Белла жанчаа дэрвүүлэн ухасхийгээд Нарциссаг ижилхэн байшингийн дундуур гүйхийг харав. Эндхийн ихэнхи дэнлүү хагарсан болохоор хоёр эмэгтэйн гүйж буй



зам дээр алаг цоог гэрэл тусна. Хөөгч олзоо ахин буланд шахах оролдлого хийв. Энэ удаад амжилттай болж олзныхоо гараас чанга зуураад өөр лүүгээ татан эргүүлэв.

- Үүнийг бүү хий, Цисси. Түүнд итгэж болохгүй ...
- Хар лорд итгэдэг биз дээ?
- Хар лорд гэнээ ... минийхээр бол ... алдсан байх гэж Белла амьсгаадан хэлээд ойр хавьд хүн байгаа эсэхийг шалган харахад юүдэнгийн дорхи нүд нь гялсхийв.
- Ямар ч тохиолдолд биднийг төлөвлөгөөний тухай хэнд ч хэлж болохгүй гэж зарлигдсан. Энэ бол Хар лордоос урвасан хэрэг ...
- Тавь, Белла! гэж Нарцисса зандраад жанчнаасаа шидэт саваа гарган түүний царай луу сүрдүүлэн чиглүүлэв.

Белла хариуд нь инээлээ.

- Төрсөн эгч рүүгээ юу, Цисси! Чи ингэж чадахгүй!
- Би одоо бүгдийг чадна! гэж Нарцисса хэлэхэд самгардсан өнгө хоолойд нь сонсогдов. Тэр саваагаа хутга шиг зангахад гэрэл гялсхийж Белла дүүгийнхээ гарыг түлэгдсэн мэт тавилаа.
- Нарцисса!

Гэвч Нарцисса хэдийн цааш гүйжээ. Мөрдөгч гараа үрээд ахин хөөхдөө аюулгүй зай барихыг хичээв. Тэд төөрдөг байшин адил хүн оршин суудаггүй тоосгон байшингуудын гүнд орлоо. Нарцисса эцэст нь «Ээрүүлийн мухар» нэртэй гудамжинд гүйж гарахад үйлдвэрийн яндан аварга том заналхийлсэн хуруу шиг сүндэрлэж байлаа. Түүний алхаа бул чулуун дээр цуурайтана. Эмэгтэй эвдэрсэн самбартай цонхны дэргэдүүр гүйн өнгөрөөд нэг давхарын хөшигний цаана сулхан гэрэл ассан хамгийн сүүлчийн байшингийн өмнө зогсов.

Түүнийг хаалга цохих агшинд Белла хараасаар гүйцэн ирлээ. Эгч дүүс үл мэдэг амьсгаадан хүлээхэд шөнийн сэвшээ салхинд бохир голын үнэр ханхална. Хэдэн хормын дараа байшинд хөдөлгөөн сонсогдож үүд ялимгүй нээгдэн завсраар нь шарангуй царай, хар нүдийг нь урт хар үс хүрээлсэн хүн шагайлаа.

Нарцисса толгойноосоо юүдэнгээ буулгав. Тэр цонхийн цайсан болохоор харанхуйд бараг гэрэлтэж байлаа. Урт цайвар үсээ нуруу руугаа унжуулжээ.

- Нарцисса! Ямар гэнэтийн таатай явдал вэ! гээд хүн хаалгаа онгойлгоход гэрэл эгч дээр нь тусав.
- Северус, би чамтай ярьж болох уу? Маш яаралтай гэж тэр хүчилсэн хоолойгоор шивнэлээ.
- Тэгэлгүй яахав!

Тэр арагшаа ухран байшин руу орох зам тавьж өглөө. Түүний эгч нь юүдэнгээ тайлалгүй урилга хүлээлгүй орохдоо,

- Снегг гэж дэргэдүүр нь өнгөрөхдөө товчхон хэлэв.

- Беллатриса гэж тэр шоолонгуй мушийн хэлээд зочдынхаа ард хаалга хаав.

Гурвуулаа шоронгийн тасалгаа юмуу галзуу эмнэлгийн өрөөг санагдуулам жижигхэн харанхуй зочны өрөөнд орлоо. Ханын тавиурт хуучны арьсан хавтастай хүнд ботиуд өржээ. Элэгдсэн буйдан, хуучин зөөлөн сандал, яйжгий ширээг адраас унжсан суурьтай лааны бүдэг гэрэл гэрэлтүүлнэ. Эндхийн зөнд хаягдсан байдлаас үзвэл эртнээс хэн ч амьдраагүй бололтой.

Снегг Нарциссаг занган буйданд суухыг урилаа. Нарцисса нөмрөгөө тайлж дэргэдээ тавьж суугаад өвдгөн дээрх цайж чичирсэн гараа анхааралтай харлаа. Беллатриса яаралгүйхэн юүдэнгээ буулгав. Хар үсээрээ дүүгээсээ ялгаатай тэрбээр Снеггээс нүд салгалгүй ширтэн Нарциссагийн ард зогсов.

- Тэгэхээр би та нарт юугаар тусалж чадах вэ? гээд Снегг эсрэг талын сандал дээр суулаа.

- Бид ... зөвхөн бид байна уу? гэж Нарцисса аяархан асуув.

- Тиймээ, тэгэлгүй яахав. Ер нь бол Сүүлт энд байгаа ч өтийг хүний тоонд оруулж болно гэж үү?

Тэр шидэт саваагаараа ардаа байсан номын тавиур руу зангахад тас хийх чимээ гаран нууц хаалга нээгдэж нарийхан шатан дээр зогсож байсан намхан хүн хөшлөө.

- Сүүлтээ чи өнөөдөр бидний зочинтой байгаа гэдгийг ажиглаа юу гэж Снегг залхуутай хэлэв.

Хүн гэтэн бөгтийсөөр хэдэн гишгүүр уруудан өрөөнд орж ирлээ. Тэр жижигхэн усархаг нүд, шовх хамартай бөгөөд царайд нь таагүй инээмсэглэл тодрон. Тэр гялалзсан мөнгөн бээлий өмссөн мэт зүүн гараараа баруунаа илбэв.

- Нарцисса! Беллатриса! Ямар таатай юм бэ ...

- Хэрвээ таатай байгаа бол, Сүүлтээ бидэнд уух юм авчир. Дараа нь эргэж өрөөндөө ороорой гэж Снегг хэлэв.

Сүүлт хүнд зүйлээр цохиулсан аятай давхийгээд,

- Би чиний зарц биш! гэж Снеггийн нүд рүү харалгүй дуугарав.

- Тийм гэж үү? Харин надад Хар лорд чамайг туслуулахаар явуулсан гэсэн сэтгэгдэл төрсөн юмсан.

- Тиймээ, туслуулахаар ... гэхдээ уух юм зөөлгөж гэр цэвэрлүүлэхээр биш!

- Харин би чамайг аюултай даалгавар хүсэж байгаа гэж ер сэжиглэсэнгүй. Энэ бол амархан учрыг нь олж болохоор зүйл. Би Хар лордтой ярилцах болно ...

- Би өөрөө хүсэх юм бол түүнтэй ярьж чадна!

- Тэгэлгүй яахав чадна. Харин одоохондоо бидэнд уух юм аваад ир гэж Снегг мушийн хэлэв.

Сүүлт маргах гэснээ больж өөр нууц хаалгаар алга болов. Тэр хаалганы цаана шилэн зүйл хангинуулах нь сонсогдож байлаа. Хормын дараа эргэж ирэхдээ тавиур дээр

тоостой лонх бүхий дарс, гурван шилэн аяганы хамт авчрав. Тэр үүнийгээ яйжгий ширээн дээр тавиад номын тавиурын араар орон хаалга хаалаа.

Снег гурван аягыг улаан хүрэн өнгийн дарсаар дүүргэж хоёрыг нь эгч дүүст өгөв. Нарцисса ямар нэг талархлын үг бувтнасан бол харин Беллатриса юу ч хэлэлгүй Снеггийг дайсагнасан харцаар ширтсээр байлаа.

- Хар лордын төлөө! гээд тэр шилэн аягатайгаа ганц балгалтаар хоослов.

Эгч дүүс мөн адил тэглээ. Снег ахин аягуудыг дүүргэв. Хоёр дахь хувиа уугаад

Нарцисса гэнэтхэн,

- Северус, чам руу хүрч ирсэн явдалд өршөөгөөрэй. Гэхдээ би чамтай уулзах хэрэгтэй байлаа. Чамаас өөр хэн ч надад тусалж чадахгүй гэж бодсон юм ... гэв.

Снег гар өргөн түүний яриаг зогсоогоод шидэт саваагаа ахин нууц хаалга руу чиглүүлэв. Чанга тасхийх чимээ сонсогдоод гонгинох чимээ гарч Сүүлт шат түжигнүүлэн өгслөө.

- Намайг өршөөхийг гуйя. Тэр сүүлийн үед хаалга сонсох дадалтай болоод байгаа ч энэ нь түүнд ямар хэрэгтэйг төсөөлөхгүй юм ... Тэгэхээр чи юу ярьж байлаа, Нарцисса?

Тэр хүндээр санаа алдаад чичирснээ ахин эхлэв.

- Северус би ийшээ ирэх ёсгүй байсан гэдгээ мэднэ. Намайг хэнд ч хэлж болохгүй гэж тушаасан ч ...

- Тэгвэл амаа тат! Ялангуяа ийм нөхцөлд! гэж Беллатриса ууртай дуу алдав.

- Ийм нөхцөлд гэнээ? гэмээн Снег даажигнан асуугаад,

- Үүнийг чинь юу гэж ойлгох вэ, Беллатриса? гэлээ.

- Би чамд итгэдэггүй, Снег. Чи үүнийг сайн мэдэж байгаа.

Нарцисса мэгших лугаа адил чимээ гаргаснаа нүүрээ гараараа таглав. Снег шилэн аягаа тавиад гараа сандлын түшлэгэн дээр тавин налж Беллатрисагийн царай руу ширтэн инээмсэглэв.

- Бид Беллатрисагийн хэлэх гэсэн зүйлийг сонсох хэрэгтэй гэж бодож байна, Нарцисса. Үргэлжлүүл Беллатриса. Чи яагаад надад итгэдэггүй юм бэ?

- Үүнд зуун янзын шалтгаан байна! гэж тэр чанга хэлээд буйданг тойрон ирж шилэн аягаа ширээн дээр жингэнэтэл тавилаа.

- Алинаас нь эхлэхээ ч мэдэхгүй байна! Ингэхэд чи Хар лордыг унахад хаана байсан бэ? Яагаад түүнийг алга болсны дараа эрж олохыг хичээгээгүй юм бэ? Юуны учраас эдгээр жилүүдэд Дамблдорын хамар дор амьдарч байна? Чи яагаад Хар лордыг гүн ухааны чулуу авахад саад болов? Яагаад Хар лордыг эргэн төрсөн даруй шууд ирсэнгүй вэ? Чи биднийг Хар лордын зөгнөлийн төлөө тэмцэлдэж байхад хаана байсан юм? Бас яагаад Харри Поттер чиний захиргаан дор таван жилийн турш байсан хэр нь одоо хүртэл амьд байгаа гэдгийг хэл, Снег?

Беллатриса чимээгүй болоод давчдан амьсгалахад хацар нь улайлаа. Түүний ард Нарцисса хөдөлгөөнгүй суугаад өмнөхийн адил нүүрээ тагласан хэвээр байв. Снегг инээмсэглэв.

- Хариулахаас өмнө ... Өө тийм л дээ, Беллатриса би чамд хариулъя! Чи миний үгийг Хар лордын араар шивнэлдэгч итгэл эвдсэн хуурамч амьтаддаа дамжуулж хэлээрэй! Тэгэхээр хариулахын өмнө чи надад асуулт тавих боломж олго. Чи үнэхээр Хар лорд надаас энэ бүхнийг асуугаагүй гэж бодож байна уу? Бас намайг хангалттай хариулт өгөөгүй бол энд суугаад чамтай ярьж чадахгүй байсан гэдгийг ойлгохгүй байна уу?

Беллатриса тээнэгэлзлээ.

- Би түүний чамд итгэдэгийг нь мэднэ гэхдээ ...

- Чинийхээр бол тэр алдсан юм биз дээ? Эсвэл намайг ямар нэгэн аргаар түүнийг мэхэлсэн гэж бодоо юу? Дэлхий дээрх легилменцийн урлагын мастер болох аугаа их шидтэн Хар лордыг мангууруулсан гэж бодсон хэрэг биш биз дээ?

Беллатриса юу ч хэлээгүй ч анх удаагаа тэвдсэн байртай харагдав. Снегг хариулт шаардсангүй. Тэр ахин аягатайгаасаа балгаад үргэлжүүлэн,

- Чи намайг Хар лордыг хүчээ алдахад хаана байсан гэж асуулаа. Би түүний байхыг тушаасан газар болох ид шидтэн илбэчний Хогвартс сургуульд Альбус Дамблдорыг тагнаж байсан. Намайг энэ ажилд Хар Лордын тушаалаар орсон болохыг мэднэ биз дээ? гэв.

Беллатриса үл мэдэг толгой дохиод ам нээсэн ч Снегг түүнээс урьтан дуугарлаа.

- Чи намайг яагаад түүнийг алга болсны дараа эрж олохыг хичээсэнгүй вэ гэлээ. Тийм нөхцөлд түүнийг Эйвери, Яксли, Кэрроу, Сивый, Люциус болон бусад нь хайж олохыг хичээгээгүй. Би түүнийг үхсэн гэдэгт итгэлтэй байсан. Бахархах зүйл байхгүй ч би зөв зүйл хийгээгүй ... хэрвээ тэр бидэнд итгэн цаг үрснийг минь өршөөгөөгүй бол түүнд их цөөхөн дагалдагч үлдэх байсан.

- Түүнд би үлдсэн! Би түүний төлөө Азкабанд олон жил хоригдсон! гэж

Беллатриса омогтой хашгирав.

- Тиймээ үнэхээр биширмээр магтууштай хэрэг шүү гэж Снегг уйдсан янзтай хэлээд,

- Үнэндээ чи шоронд суугаад түүнд ашиг багатай байсан болохоор ... гэв.

- Ашигтай багатай байсан гэнээ! хэмээн тэр галзууртлаа уурсан хашгираад,

- Намайг Дементорууд зовоож байхад чи Хогвартсад суугаад Дамблдорын уяаны нохой болсон биз дээ! гэв.

- Тийм биш. Тэр надад итгэж хар урлагийн багшаар ажиллахыг зөвшөөрөөгүй болохыг чи мэднэ. Харваас болгоомжилсон бололтой. Би гэнэтхэн хуучин зам руугаа буцаад орчихвол яах вэ.

- Энэ Хар лордын төлөө өөрийгөө золиослох тухай болохоос дуртай хичээлдээ багшлах тухай биш! Тэгвэл чи яагаад энэ бүхний дараа тэнд үлдсэн юм бэ, Снегг? Үхсэн эзнийхээ төлөө Дамблдорыг үргэлжлүүлэн тагнах гээ юу?

- Бараг л. Гэхдээ Хар лорд намайг байраа орхиогүйд сэтгэл хангалуун байсан.

Би Дамблдорын тухай арван зургаан жилийн мэдээлэл дамуулсан. Энэ бол түүнийг эргэж ирэхэд Азкабанд хэрхэн таагүй сууж байсан тухайгаа эцэс төгсгөлгүй дурсахаас үнэ цэнэтэй бэлэг байсан ...

- Гэхдээ чи үлдсэн тэндээс яваагүй ...

- Тиймээ, Беллатриса би үлдсэн гэж Снегг энэ бүх хугацааны туршид анх удаагаа тэвчээр алдан хэллээ.

- Надад Азкабанд суухаас илүү зохимжтой ажил байсан. Тэд Үхэл залгигчидын ихэнхийг барьсаныг санаж байна уу. Дамблдор намайг шоронгоос аврахад би энэ аятай тохиолдлыг ашигласан юм. Давтаж хэлье Хар лорд миний үлдсэн шалтгаанд гомдоллохгүй байхад чи сэтгэл хангалуун бус байна гэж үү?

- Цаашаа чиний мэдэхийг хүсч байгаа зүйлийн тухайд гэвэл хэмээн Снегг Беллатрисаг эсэргүүцэхээр завдахад дуугаа чангаруулав,

- Намайг яагаад Хар лордын гүн ухааны чулуу авах замд хөндөллөсөн бэ гэж үү. Үүнийг хариулахад хялбархан. Тэр үед надад Хар лорд итгэж болохыг мэдээгүй. Тэр чиний адил үнэнч Үхэл залгигчид нь Дамблдорын тогломын хүн болон хувирсан гэж бодож байсан юм. Тэр тэгэхэд өрөвдөлтэй нөхцөлд аймшигтай суларч доройтон тааруухан шидтэний биеийг эзэмдсэн байсан. Тэр ойролцоо холбоотонтой болохыг зүрхлээгүй болгоомжилсон. Магадгүй энэ холбоотон түүнийг Дамблдорт юмуу ид шидийн яаманд тушаачих ч юм билүү. Гүн харамсалтайгаар хэлэхэд тэр надад итгээгүй. Гэхдээ энэ бол түүний хүчээ алдсан байсан өмнөх үеийн явдал. Харин би зөвхөн шунахай Квирелл гүн ухааны чулуу хулгайлахыг оролдохыг хараад түүнд саад болохын тулд хүч хүрэх бүхнээ хийсэн.

Беллатриса гашуун эм уусан мэт уруулаа ярвайлаа.

- Гэхдээ чи түүнийг эргэж ирэх үед очоогүй. Чи Хар тамга төөнөхийг мэдэрсэн ч буцаж очоогүй ...

- Үнэн. Би хоёр цагийн дараа Дамблдорын тушаалаар очсон.

- Дамблдорын тушаалаар гэнээ? хэмээн Беллатриса хилэгнэн дуу алдлаа.

- Жаахан бод! гээд Снегг ахин тэвчээр алдав.

- Бод! Ердөө хоёр цаг, хоёрхон цаг хүлээгээд би Хогвартет тагнуулаар үлдэх боломж олдсон! Би Дамблдорт сэтгэгдэл төрүүлэхийн тулд Хар лорд руу буцах тушаалыг биелүүлэн үүний хариуд талархан хүндэт Дамблдорын гэрчлэлээр Фениксийн бүлгэмд багтсан! Толгойгоо ажиллуул, Беллатриса. Хар тамга хэдэн сарын өмнөөс тод болж эхэлсэн. Би түүнийг удахгүй эргэж ирнэ гэдгийг мэдэж

байсан. Бүх Үхэл залгигчид мэдэж байсан! Надад энэ тухай бодох хангалттай цаг байсан ч Каркаров шиг зугтаагүй. Үгүй гэж хэлэх үү?

- Анхны удаа Хар лорд миний хоцролтонд таагүй байсан ч чамд итгүүлэн хэлэхэд түүний энэ байдал намайг урьдын адил үнэнч зүтгэн Дамблдор өөрийн хүнээр тооцдог болсныг сонсоод ул мөргүй алга болсон. Тиймээ, Хар лорд эхэндээ намайг үүрд явсан гэж бодсон ч тийм байгаагүй.

- Гэхдээ энэ чинь ямар ашигтай юм? Бид чамаас ямар үнэ цэнэтэй мэдээлэл авсан юм? гээд Беллатриса тургилав.

- Би мэдээлэлээ Хар лордод шууд хүргэдэг. Хэрвээ тэр чамайг хуваалцана гэж бодоогүй бол ...

- Тэр надтай олон зүйл хуваалцсан. Тэр намайг хамгийн үнэнч, хамгийн итгэлтэй ...

- Тийм гэж үү? хэмээн Снегг үл итгэсэн байртай хэлэв. Тэр үнэхээр ид шидийн яаманд болсон бүтэмжгүй явдлын дараа тэгж хэлсэн гэж үү?

- Тэгэхэд миний буруу байгаагүй! Өнгөрсөн удаа Хар лорд надад итгэн чухал даалгавараа өгөөгүй ... хэрвээ Люциус байгаагүй бол ... гээд Беллатриса улайлаа.

- Бүү зүрхэл! Буруугаа миний нөхөрт бүү тох! гэж Нарцисса үхлийн аюултай хоолойгоор хэлээд эгч рүүгээ толгой өргөн харлаа.

- Одоо хэн их бага буруутай нь чухал биш. Хулгайлж чадаагүй гэдэгт л гол учир байна гэж Снегг тайван хэлэв.

- Харин чи хамаагүй хэрэг үү! Чи ахиад л бусад нь эрсдэлд орж байхад хойно хоцорсон биз дээ, Снегг гэж Беллатриса уурсан хашгирлаа.

- Би намайг байхыг тушаасан газар байсан. Магадгүй чи Хар лордыг зөвшөөрөхгүй байгаа хэрэг үү? Магадгүй чи Дамблдор намайг Үхэл залгигчдын эгнээнд ороод Фениксийн бүлгэмийнхэнтэй тэмцэхийг анзаарахгүй байсан гэх нь үү? Бас ... намайг уучлаарай, гэхдээ чи осолтой ярьж байна... хэрвээ андуураагүй бол та нарын өрсөлдөгч чинь зургаан ширхэг өсвөр насны хүүхэд байсан байх аа?

- Чи тэдэнд туслахаар бүлгэмийн хагас нь ирснийг сайн мэдэж байгаа ...

Ингэхэд бүлгэм гэснээс ... чи урьдын адил тэдний удирдлагын байрыг хаана байдгийг хэлэх боломжгүй гэж баталсаар байна уу?

- Би нууц хадгалагчын тоонд ородоггүй болохоор хэнд ч энэ газрын нэрийг хэлж чадахгүй. Чамайг энэ шившлэг яаж үйлчилдэгийг мэднэ гэж бодож

байна. Тэгээд ч Хар лордод миний дамжуулсан мэдээлэл хангалттай. Чи магадгүй иймээс л саяхан Эммелина Вэнсийг устгасан болохыг тааварласан биз дээ. Бас чамд Сириус Блэкийг дуусгахад тусалсан.

Снегг толгойгоо бөхийлгөөд хундагатайгаа өргөв. Гэвч Беллатрисагийн царай тайвширсангүй.

- Чи миний сүүлчийн асуултанд хариулсангүй, Снегг. Харри Поттер. Чи түүнийг өнгөрсөн таван жилийн туршид дурын агшинд алж болох байсан. Чи үүнийг хийгээгүй. Яагаад?

- Чи энэ сэдвээр Хар лордтой ярьсан уу?

- Тэр ... бид сүүлийн удаа ... Би чамаас асууж байна, Снегг!

- Хэрвээ би Харри Поттерыг алсан бол Хар лорд түүний цусыг ашиглан ахин төрж чадахгүй байсан ...

- Чи хүүг түүнд шаардагдахыг урьдчилан харсан гэх гээд байна уу! гэж тэр шоолонгуй асуулаа.

- Би ингэж батлаагүй ч түүний төлөвлөгөөг ойлгоогүй. Би Хар лордыг үхсэн гэж бодож байснаа хэдийн хэлсэн. Би зөвхөн тэр яагаад өнгөрсөн жил хүртэл Поттерыг амьд байсанд гомдоогүй гэдгийг тайлбарлахыг оролдож байна.

- Тэгвэл үүний дараа яагаад амьд үлдээсэн юм?

- Чи миний яриаг ойлгохгүй байна гэж үү? Зөвхөн Дамблдор намайг Азкабанаас аварсан! Түүний хайртай сурагчыг алах нь Дамблдорыг миний эсрэг босгох байсан. Гэхдээ зөвхөн энэ ч биш. Чамд сануулахад Поттерыг Хогвартст орох үед Хар лордын дайралтанаас мултарсан хамгийн хүчирхэг хар шидтэн гэсэн цуу яриа тарсан. Үнэн хэрэгтээ Хар лордын тал байсан олон хүмүүс Поттер манай шинэ алдартан болж бид түүнийг тойрон хүрээлж болох юм гэж бодсон. Гэхдээ би түүнийг сургуульд хөл тавьсан даруй алаагүйн учир нь сонирхолтой байсан юм.

- Надад удалгүй түүнд ямар ч ер бусын авъяас байхгүй нь тодорхой болсон.

Хэдэн удаа хүнд хэцүү явдал тохиолдоход авъяаслаг найз нөхдийнхөө тусламжтайгаар амжилттай давж байсан. Тэр өөрөө тааруухан хэдий ч үхсэн эцгийнхээ адил сэтгэл хангалуун байдаг. Би түүнийг Хогвартсаас хөөлгөхийн тулд бүхнийг хийсэн. Эсвэл түүнийг өөрөө алах байсан хэрэг үү? Зөвхөн тэнэг хүн л Дамблдорын хамар дор тийм алхам хийх байх.

- Чи энэ бүхний дараа Дамблдор чамайг нэг ч удаа сэжиглэж байгаагүй гэж итгүүлэх гээд байна уу? Тэр чиний үнэн хэрэгтээ хэнд зүтгэж байгааг тааварлахгүй бүрэн итгэж байсан гэх гээ юу?

- Би өөрийн дүрдээ сайн тоглосон. Чи Дамблдорын томоохон сул талыг мартаад байна. Тэр хүмүүст итгэдэг юм. Би өчигдөрхөн Үхэл залгигч байсан хүн түүнд гүнзгий төөрөгдлийнхөө тухай сайхан түүх зохиож ярихад гараа тэнийлгэн хүлээж авсан. Гэхдээ давтаж хэлэхэд хар урлагаас хамгаалах хичээлийн багш болгоогүй. Дамблдор эрин үеийнхээ аугаа шидтэн байсан.

Тиймээ тийм байсан гэж Снегг Беллатрисагийн зэвүүцэн дуу алдахыг харж хэлээд,

- Хар лорд үүнийг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ би Дамблдор хөгширч эхлэхийг ажигласан. Саяхан Хар лордтой тулгарсан явдал түүнийг хүчийг бууруулсан. Харваас тэр хүнд шарх авсан бололтой хариу үйлдэл нь тийм хурдан биш болсон.



Гэхдээ эдгээр жилүүдэд тэр хэзээ ч Северус Снеггт итгэх итгэлээ алдаж байгаагүй учраас би Хар лордод үнэ цэнэтэй хүн юм.

Беллатриса урьдын адил сэтгэл хангалуун бус байсан ч Снегг рүү хэрхэн дайрахаа мэдсэнгүй. Снегг түүний чимээгүй байхыг хараад дүүд нь хандан,

- Тэгэхээр чи надаас тусламж хүсч ирээ юу, Нарцисса гэв? Нарцисса түүн рүү цөхрөл дүүрэн нүдээр харлаа.

- Тиймээ, Северус. Би ... би чамаас өөр надад хэн ч тусалж чадахгүй гэж бодлоо. Би хэнд ч хандаж чадсангүй. Люциус шоронд байгаа болохоор ...

Тэр нүдээ анихад зовхийг нь даган хоёр том нулимс урсав.

- Хар лорд намайг энэ тухай ярихыг хориглосон. Тэр төлөвлөгөөг нь хэн ч мэдэхийг хүсэхгүй байгаа. Энэ бол... их том нууц. Гэхдээ ...

- Хэрвээ тэр чамайг хориглосон юм бол юу ч хэлэх хэрэггүй. Хар лордын үг бол хууль гэж Снегг түргэн хэлэв.

Нарцисса нүүр лүүгээ хүйтэн усаар цацуулсан мэт агзасхийлээ. Беллатриса энэ гэрт орж ирсэн цагаасаа хойш анх удаагаа сэтгэл хангалуун харагдав.

- Харж байна уу! Снегг хүртэл тэгж бодож байна. Чамайг чимээгүй байхыг тушаасан болохоор дуугүй бай! гэж хөөрөн хэллээ.

Гэвч Снегг суудлаасаа босоод жижигхэн цонх руу очиж хөшигний завсраар хоосон гудамж руу харснаа ахин битүү хаалаа. Тэр хөмсөг зангидан Нарцисса руу эргэлээ.

- Би энэ тухай мэднэ. Би Хар лордын төлөвлөгөөгөө ярилцдаг цөөн хүмүүсийн нэг. Гэхдээ Нарцисса чи Хар лордоос урван тэрсэлж буруутах гэж байна.

- Би чамайг мэдэх ёстой гэж бодож байна! Тэр чамд итгэдэг, Севериус ...

- Чи түүний төлөвлөгөөг мэдэх юм биз дээ? гэж Беллатриса асуухад сэтгэл хангалуун байдал нь алга болж уур хилэн болон өөрчлөгдөв. Мэдэх хэрэг үү?

- Эргэлзээгүй гэж Снегг батлав.

- Тэгээд чамд ямар тусламж хэрэгтэй юм бэ, Нарцисса. Хэрвээ чи намайг Хар лордын бодлыг өөрчлөхөөр ятгахыг хүлээж байгаа бол урам хугарал хүлээж байгаа гэж айж байна.

- Северус гээд түүний цайвар хацар дээгүүр нулимс урслаа.

- Миний хүү ... миний цорын ганц хүү ...

- Драко бахархах ёстой гэж Беллатриса хайхрамжгүй хэлээд,

- Хар лорд түүнд том хүндэтгэл ногдуулсан. Би энэ тухай Дракод хэлэхэд үүрэг хүлээлгэсэн явдалд айж дагжаагүй бөгөөд харин ч өөрийгөө харуулах боломж олдсонд баяртай байх шиг санагдсан гэв.

Нарцисса мэгшин уйлж Снеггээс гуйсан харцаар нүд салгалгүй ширтлээ.

- Тэр ердөө арван зургаан настай. Тэр юу хүлээж байгааг ойлгохгүй байгаа!

Яагаад, Северус? Яагаад миний хүү гэж? Энэ чинь хэтэрхий осолтой! Үүнийг

Люциусын алдааны төлөө өшөө авах гэж байгааг би мэдэж байна!

Снегг юу ч хэлсэнгүй. Тэр Нарциссагийн нулимстай царайнаас харц буруулсан ч сонсохгүй байгаа дүр эсгэсэнгүй.

- Ийм учраас л Драког сонгосон хэрэг үү? Люциусыг шийтгэхийн тулд гэж тэр шаардангуй давтав.

- Хэрвээ Драко амжилт гаргавал хэний ч зүүдэнд оромгүй хүндэтгэл хүлээж байгаа гэж Снегг өөр тийшээ харан хэлэв.

- Гэхдээ тэр амжилтанд хүрэхгүй! Тэр хаанаас чадах юм бэ Хар лорд өөрөө байсан ч ... гэж Нарцисса цурхирав.

Беллатриса дуу алдахад Нарцисса ажиглагдам эмээлээ ...

- Би зөвхөн бодлоо хэлэхийг хүссэн юм ... хэн ч амжилт олохгүй ... Северус гуйж байна ... Драко чамайг хүндэлдэг. Чи үргэлж түүний дуртай багш нь байсан. Чи Люциусын эртний найз ... Би чамаас гуйж байна! Чи Хар лордын ойрын холбоотон, тэр чамд хэнээс ч илүү итгэдэг. Түүнийг ятгахаар ярилц л даа.

- Хар лордыг ятгах боломжгүй бөгөөд би тэгж хичээхээр тэнэг хүн биш билээ.

Хар лорд Люциусд уурласан гэдгийг нуух юун. Люциус ажиллагааг зохион байгуулаад зөгнөлийг авч чадалгүй бусадтайгаа баригдсан. Тиймээ, Нарцисса Хар лорд уурлаж байна, тэр хилэгнэж байна!

- Тэгэхээр Драког өс хонзонгоо авахаар сонгосон гэсэн миний зөв юм биз дээ!

Түүнд Драко амжилт гаргах эсэх нь хамаагүй. Тэр түүний үхлийг хүсч байна!

гэж Нарцисса нулимс цувуулан хэлэв.

Снегг ахин чимээгүй болоход Нарцисса биеэ барих чадвараа алдлаа. Тэр найган ганхсаар Снегг рүү очоод жанчных нь захнаас татан нүүрээ наах шахам ойртуулж,

- Чи үүнийг хийж чадна. Чи үүнийг Дракогын оронд хийж чадна, Северус. Чи амжилт гаргана, тэр чамайг шагнана ... гэв.

Снегг түүний бугуйнаас барин гарыг нь жанчнаасаа холдуулаад нулимстай царай руу нь харснаа удаанаар,

- Тэр намайг эрт орой нэг цагт хийлгэхээр төлөвлөсөн гэж бодож байна. Гэхдээ эхлээд Драког оор хийлгэнэ гэж шийдсэн. Харж байна уу хэрвээ Драко амжилт гаргавал би цаашид Хогвартсад үлдэн өөрийнхөө ашигтай ажлаар хөөцөлдөх болно.

- Түүнд бүгд хамаагүй, Драког алах болно!

- Хар лорд их ууртай байгаа гэж Снегг аяархан давтаад,

- Тэр зөгнөлийг сонсоогүй. Чи түүний амархан уучлах хүн биш гэдгийг надаас дутахгүй мэднэ, Нарцисса гэв.

Нарцисса түүний хөлд унаад ёолон шалан дээгүүр өнхөрлөө.

- Миний цорын ганц хүү ... миний цорын ганц хүү ...
  - Чи үүгээр бахархах ёстой! гэж Беллатриса хэрцгий хэлээд,
  - Надад хүү байсан бол хувь заяаг нь баяртайгаар Хар лордод атгуулах байлаа!
- гэв.

Нарцисса аяархан цурхирч цөхөрсөндөө урт цагаан үсээ зулгаав. Снегг бөхийж түүнийг хөл дээр нь босгоод буйдан дээр суулгав. Тэгээд дарс дүүргэж гарт нь бариулав.

- Хангалтгай, Нарцисса. Үүнийг уу. Намайг сонс.

Тэр чимээгүй болж балгахдаа дарсаа өөр лүүгээ цалгиулан асгачихлаа.

- Магадгүй ... би Дракод тусалж чадах байх.

Тэр цагаан царайдаа том нүдээ гялалзуулсаар огцом бослоо.

- Северус ... ай даа Северус ... чи түүнд туслах уу? Чи түүнд санаа тавьж юу ч тохиолдуулахгүйн төлөө харж байх уу?

- Би хичээе.

Тэр аягаа ширээн дээр тавиад буйдангаас гулган Снеггийн өвдөг рүү ухасхийн гарыг нь бариад уруулдаа наалаа.

- Хэрвээ чи дэргэд нь байх юм бол ... хэрвээ чи түүнийг хамгаалах юм бол ...

Северус чи надад үүнийг амалж байна уу? Чи Үл эвдэгдэх амлалт өгөх үү?

- Үл эвдэгдэх амлалт гэнээ? хэмээн Снеггийн царай ойлгомжгүй болоход Беллатриса баясгалантайгаар хөхрөв.

- Чи түүнийг сонсов уу, Нарцисса? Тэр хичээх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй.

Үргэлж байдаг шигээ хоосон үг! Бас Хар лордын тушаал гэнэ шүү, өө тийм л дээ!

Снегг Беллатриса руу харсангүй. Түүний хар нүд нулимс дүүрэн гараас нь зуурсан хэвээр байгаа Нарцисса руу харлаа.

- Мэдээж, Нарцисса би үл эвдэгдэх амлалт өгөх болно. Магадгүй чиний эгч биднийг батлахыг зөвшөөрч болох юм.

Беллатриса гайхсандаа амаа ангайлаа. Снегг Нарциссагийн эсрэг талд өвдөглөн суулаа. Беллатрисагийн гайхсан харцан дор тэд баруун гараа барилцав.

- Чамд шидэт саваа шаардагдана, Беллатриса гэж Снегг хүйтнээр хэлэв. Тэр гайхсан хэвээр шидэт саваагаа гаргаж ирлээ.

- Арай ойрт гэж Снегг хэлэв.

Тэр урагшаа алхаад тэдний холбоотой гарт шидэт саваагаа хүргэлээ.

- Северус чи миний хүү Драког Хар лордын тушаалыг биелүүлэхэд харж байна гэдгээ амалж байна уу? гэж Нарцисса хэлэв.

- Амлаж байна.

Саваанаас гялалзсан нарийхан дөл гарч тэднийг гарыг улайссан төмөр мэт ороолоо.

- Чи түүнийг бүх хүчээрээ хамгаалахыг амалж байна уу?

- Амлаж байна.

Хоёр дахь дөл шидэт саваанаас гарч эхнийхтэйгээ холбогдоход гялалзсан нарийхан гинж боллоо.

- Хэрвээ шаардагдахад хүрвэл ... хэрвээ Драко бүтэлгүйтвэл ... гэж Нарцисса шивнэхэд (Снеггийн гар татвалзсан хэдий ч холдуулсангүй) чи түүний өмнөөс Хар лордын тушаалыг биелүүлнэ гэдгээ амалж байна уу?

Агшин зуур нам гүм болов. Беллатриса тэднийг нүдээ томруулан хараад шидэт саваагаа гарт нь хүргэлээ.

- Амалж байна.

Беллатрисагийн мэл гайхширсан царай улаан болоход шидэт саваанаас гурав дахь дөл гарч эхний хоёрыгоо болон Снегг, Нарцисса хоёрын барилцсан гарыг галт могой адил ороолоо.

### БҮЛЭГ 3: БОЛНО БОЛОХГҮЙ

Харри Поттер чанга хурхирч байв. Тэр бараг дөрвөн цагийн турш цонхны хажуугийн сандалд харанхуй гудамж руу харан суусан болохоор эцэстээ ядраад хүйтэн шилэнд хацраа наан унтаж байлаа. Нүдний шил нь хэлтийж, амаа том ангайжээ. Түүний амьсгалд цантсан цонхоор гудамжны дэнлүүний шаргал гэрэл туяарч цонхигор царай зүг бүр тийш арзайсан хар үсийг нь гэрэлтүүлнэ.

Өрөөний бүх зүйл ундуй сундуй хогтой холилдон хөглөрч байв. Шалан дээр уулийн өд, алимны гол, чихрийн цаас хэвтэж орон дээр сурах бичиг, жанч овоолон ширээний гэрэлд бүтэн боодол сонин харагдана. Тэдний гарчиг дээр:

#### ХАРРИ ПОТТЕР СОНГОГДСОН УУ?

Саяхан ид шидийн яаманд болсон эмх замбараагүй байдлын цуу яриа замхарч амжаагүй байхад Хэцүү нэрт ахин эргэн ирлээ.

«Юу ч асуух хэрэггүй. Бидэнд энэ тухай ярихыг хориглосон» гэж өчигдөр үдэш ид шидийн яамны үүдэн дээр нэрээ хэлэхийг хүсээгүй нэгэн сэтгэл түгшсэн ой санамж арчигч хэлжээ.

Зарим эх сурвалжаас үзэхэд үйл явдал ид шидийн яамны домогт зөгнөлийн танхимын төвд болсон бололтой.

Хэдийгээр ид шидийн яамны албан ёсны төлөөлөгчид энэ тухай мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа ч Азкабаны шоронгоос оргосон Үхэл залгигчид хууль бус нэвтрэх оролдлого хийн зөгнөл хулгайлахыг хүсчээ. Зөгнөлд юу байсныг хэн ч мэдээгүй боловч ихэнхи хүмүүс үүнийг үхлийн хараалын дараа амьд үлдсэн цорын ганц амьд хүн болох яаманд үймээн дэгдэх үеэр тэнд байсан нь тодорхой болсон Харри Поттерт хамаатай гэж үзэж байгаа юм. Зарим хүмүүс Поттерыг «сонгогдсон» гэж нэрлэж зөгнөлийг зөвшөөрөн зөвхөн тэр л биднийг Хэцүү нэртээс аварч чадна гэж үзэж байна.

Одоогоор зөгнөл хаана байгаа нь тодорхойгүй ч (үргэлжлэлийг хоёрдугаар хуудасны тавдугаар баганаас үргэлжүүлэн уншина уу).

Дэргэд нь хэвтэж байсан өөр сонины гарчиган дээр:

#### СКРИМЖЕР ФАЖЫГ ЗАЛГАМЖЛАН АВЛАА

гэсэн байх бөгөөд тэргүүн нүүрний ихэнхи хэсгийг арслангийн дэл шиг өтгөн үстэй хүнд сорилт дүүрэн амьдралыг туулсан нь илэрхий хүний хар цагаан том зураг эзэлсэн байлаа. Зурган дээрх хүн гараа даллаад адар руу заав.

Руфус Скримжер Корнелиус Фажын сайдын суудлыг залгамжлан халааг авахаас өмнө мракоборецуудын хэлтэсийг толгойлж, ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх салбарт ажиллаж байсан юм. Шидтэнгүүдийн ертөнц шинэ сайд Скримжер болон саяхан Визенгамотын дээд шүүхийн албандаа эргэн орсон Альбус

Дамблдор хоёрын дунд анхны уулзалтаараа хагарал болсон гэсэн цуу яриаг эс тооцон халуун дотноор хүлээн авлаа.

Скримжерийн төлөөлөгчид энэ сэдвээр мэдэгдэл хийхээс татгалзсан байна. Альбус Дамблдор (үргэлжлэлийг 3 хуудас хоёрдугаар баганаас үзнэ үү)

Зүүн талд нь ахин нэг сонин байлаа.

**ИД ШИДИЙН ЯАМ СУРАГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД САНАА ТАВЬЖ БАЙНА** Саяхан шинээр томилогдсон ид шидийн яамны сайд Руфус Скримжер энэ намар

Хогварте руу эргэн ирэх сурагчдын аюулгүй байдалд баталгаа өгч байна гэсэн мэдэгдэл хийлээ.

«Ид шидийн яамнаас хамгаалалтыг хүчирхэгжүүлэх төлөвлөгөөний талаар тодорхой ярихгүй байх шалтгаан бий гэдэг нь ойлгомжтой» гэж сайд хэлээд үүнд хамгаалалтын шившлэг болон хараалын эсрэг шившлэгийн цогцолбор түүнчлэн Хогварстын хамгаалалтанд зориулан багахан мракоборецуудын бүлгийг гаргасан гэжээ.

Ихэнхи шидтэнгүүд шинэ сайд сурагчдын аюулгүй байдалд санаа тавьж байгаа алхамыг баяртайгаар хүлээн авлаа. Бидэнд хатагтай Август Долгопупс хэлэхдээ:

«Миний ач Невилл Харри Поттерын ойрын найзуудын нэг бөгөөд энэ зургаан сард ид шидийн яаманд Үхэл залгигчдын эсрэг тэмцэхэд хамт байсан юм ...»

Сурвалжлагын үлдсэн хэсэг шувууны тор доор байв. Дотор нь сайхан цагаан ууль байлаа. Түүний хуван шар нүд өрөөг захирангуй ажиглаж үе үе унтаж байгаа эзнийхээ зүг толгойгоо эргүүлж байлаа. Хоёр гурван удаа хошуугаа тэвчээргүйхэн тас няс хийлгэсэн ч Харри бөх унтсан хэвээр юу ч сонссонгүй.

Өрөөний голд том чеомдан байв. Таг нь нээлтэй ёроолд нь хуучин дотуур хувцас, чихэр, хоосон бэхийн сав, хугарсан үзэг, захиа хэвтэхийг эс тооцвол бараг хоосон байлаа. Ойролцоо шалан дээр хэвтэж байсан жижигхэн ягаан өнгийн ухуулах хуудсан дээр:

Ид шидийн яамны тушаалаар бүтээв

**ӨӨРИЙН ГЭР БОЛОН ГЭР БҮЛИЙНХНЭЭ ХАР УРЛАГААС ЯАЖ ХАМГААЛАХ ВЭ** Шидэтний ертөнцөд өөрсдийгөө Үхэл залгигч гэж нэрлэсэн хүмүүсээс аюул

заналхийлж байна. Аюулгүй байдлын гарын авлага таньд өөрийгөө болон гэр бүл, байшингаа дайралтаас хамгаалахад туслах болно.

1. Гэрээсээ ганцаараа гарахгүй байхыг хичээ.
2. Ялангуяа шөнийн цагаар онц болгоомжтой бай. Болж өгвөл гадуур явах ажлаа харанхуй болохоос өмнө дуусга.
3. Гэрийнхээ аюулгүй байдлыг нягтлан үзэж гэр бүлийн бүх гишүүдээ өөрийгөө хамгаалах арга болох Бамбай шид, Хувиргах шид мэдэх эсэхийг шалган насанд хүрээгүй хүүхдүүдээ холгүй шилжиж сурга.

4. Үхэл залгигч Хувиргагч уусмалын тусламжтай зүсээ хувиргасан байж болзошгүй тул ойр дотны найзууд болон төрөл төрөгсөддөө нууцлалын асуулт тавьж бай (2 хуудас).

5. Хэрвээ таньд гэр бүлийн гишүүн, хамт ажиллагсад, найз нөхөд болон хөршүүдээс чинь биеэ хачирхалтай авч явж байгаа тохиолдол илэрвэл даруйхан Ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтэст мэдэгд. Та Имперуус шидийн нөлөөн дор байгаа хүнтэй тулгарсан байж болзошгүй (4 хуудсыг үзнэ үү).

6. Хар тамга оршин сууж буй газарт чинь болон өөр байшингийн дээр үзэгдвэл ЯМАР Ч ТОХИОЛДОЛД ДОТОГШ БҮҮ ОР. Даруйхан мракоборецуудад ханд.

7. Батлагдаагүй мэдээнээс үзэхэд Үхэл залгигчид инферналуудыг ашиглаж байж болзошгүй. Инферналуудтай тааралдвал ДАРУЙХАН энэ тухайгаа яаманд мэдэгд.

Харри зүүдэндээ бувтнаснаа царай нь шил даган гулгахад нүдний шил нь улам хазайсан ч сэрсэнгүй. Түүний хэдэн жилийн өмнө зассан сэрүүлэгтэй цаг цонхны тавцан дээр чангаар цохилон арван нэг болоход нэг хором дутуу болохыг үзүүлж байлаа. Харрийн суларсан гарын дэргэд налуу бичгийн хэвтэй захиа хэвтэж байв. Харри энэ захиаг гурван өдрийн өмнө ирснээс нь хойш олон удаа уншсан болохоор хуйлаас нь бүр тэнийжээ.

Хүндэт Харри!

Хэрвээ чамд таатай бол би Улаан модон гудамжны дөрвөн тоот байшинд баасан гаригийн оройн арван нэгэн цагаас сургуулийн үлдсэн амралтаа өнгөрүүлэхийг урьсан Үүрэнд аваачихаар очих болно.

Хэрвээ эсэргүүцэхгүй бол Үүрэнд хүрэх замдаа чиний тусламжтайгаар нэг ажил амжуулахдаа би баяртай байх болно. Уулзаад тодорхой тайлбарлая.

Энэхүү уулиараа хариу илгээхийг гуйж байна. Баасан гаригт чамтай уулзана гэж найдна.

Хүндэтгэсэн

Альбус Дамблдор

Харри захиаг цээжилсэн болохоор оройн долоон цагаас эхлэн цонхны дэргэд Улаан модон гудамжны эхлэл төгсгөлийг харж болохуйц байр эзлээд таван хором тутамд захидал руу хяламхийн харж байлаа. Тэр мөнхүү уулиар зөвшөөрсөн хариу явуулсан бөгөөд одоо зөвхөн ирэх эсэхийг нь хүлээх л үлджээ.

Гэвч Харри замынхаа юмыг багласангүй. Дурслийнхантай ердөө хоёр долоо хоног өнгөрүүлснийхээ дараа хамаатнуудаасаа салах нь итгэмээргүй бэрх санагдаж байлаа. Түүнчлэн заавал тэгэх албагүй гэсэн мэдрэмжээсээ салж чадсангүй. Дамблдор илгээсэн захиа замаасаа гээгдэх юмуу, өөр зүйл түүнийг ирэхэд саад болох эсвэл захиа ерөөсөө түүнээс ирээгүй байж хэн нэгний тоглоом юмуу эсвэл дайсных нь урхи байж болох юм. Хэрвээ Харри юмаа баглавал бүх зүйлээ ахин задлах хэрэг гарч үүнийг тэсэж чадахгүй. Тэр зөвхөн аялалд бэлтгэн Хэдвигийг торонд нь түгжжээ.



Сэрүүлэгтэй цагны хормын зүү арван нэг хүрэх агшинд цонхны цаана гудамжны дэнлүү унтарлаа.

Харри харанхуйд сэрүүлгийн дуунаар цочин сэрэв. Тэр яаран нүдний шилээ засаад хацраа цонхноос холдуулан оронд нь хамраа нааж гадагшаа шагайн харлаа. Цэцэрлэгийн зам дээр намирсан урт дээл өмссөн өндөр дүрс гарч ирэв.

Харри цахилгаанаар цохиулсан аятай сандлаа унагаад үсрэн босч шалан дээрх зүйлсээ шүүрэн авангаа чемодан руугаа чихэж эхлэв. Түүнийг өрөөн дундуураа гүйж сургуулийн жанч, шившлэгийн хоёр ном шүүрэн авах агшинд үүдний хонх дуугарлаа.

Нэг давхарын зочны өрөөнөөс Вернон ахын орилох чимээ сонсогдов.

- Ямар чөтгөр нь ийм шөнө ирдэг байна?

Харри нэг гартаа зэс дуран авай, нөгөө гартаа хос кэт бариад байрандаа хөшлөө. Тэр Дурслийнханд Дамблдорын ирэхийг анхааруулахаа мартсан юм байна шүү дээ. Сандрах инээд хүрэх зэрэгцэн чемодан дээгүүрээ үсрэн гарч хаалгаа онгойлгоход,

- Оройн мэнд. Та ноён Дурслэ уу. Харри таньд миний ирэхийг анхааруулсан болов уу? гэв.

Харри шат уруудан хоёр гишгүүр алгасан үсрээд ёроолд нь хүрэхээс өмнө нагац ахынхаа сунгасан гар хүрч чадахааргүй зайд огцом зогслоо. Хаалган дээр өндөр туранхай, бүсэлхий хүрсэн урт мөнгөлөг үс сахалтай хүн зогсож байв. Тэр махигар хамартаа нүдний шил зүүж, аян замын урт хар дээл, шовгор оройтой бүрх малгай өмсчээ. Вернон ахын сахал Дамблдорын адил өтгөн ч зөвхөн хар бөгөөд улаан хүрэн өнгийн гэрийн халаттай зогсоод зочин руугаа жижигхэн нүдэндээ итгэхгүй шахам харав.

- Таны гайхширсан байдлаас үзэхэд Харри миний ирэхийг анхааруулаагүй бололтой. Гэсэн хэдий ч намайг зочломтгойгоор орохыг зөвшөөрнө үү. Энэ хүнд хэцүү үед босгон дээр хэтэрхий удаан зогсох гэдэг бол ухаалаг бус хэрэг гэж Дамблдор эелдэгээр хэлээд урагш алхан орж үүдний хаалга хаангаа,

- Би удтал энд ирсэнгүй. Таны африкийн лиш цэцэг сайхан ургасныг харж байна гэж Вернон ах руу доош харж хэллээ.

Вернон Дурслэ чимээгүй байв. Харри түүнийг үг хэлж чадна гэдэгт эргэлзсэн ч нагац ахынх нь чамархайн судас аюул ойртсоны тэмдэг болон цохилохгүй байхыг үзэхэд Дамблдор түүний эсэргүүцэх хүслийг унтраасан бололтой. Вернон ах түүний урд зогсоо хүнийг айлгахад бэрх гэдгийг ухаарчээ.

- Оройн мэнд, Харри. Сайн байна, маш сайн байна гэж Дамблдор түүн рүү сэтгэл хангалуун харж хэллээ.

Энэ үгийн дараа Вернон ах сэхээ орсон мэт болов. Түүний хараанд байгаа хүн Харриг «сайн байна» гэж байвал түүнтэй нүүр тулан ярилцах боломжгүй нь ойлгомжтой байлаа.

- Эелдэг бус байхыг хүсэхгүй байна л даа гэж тэр үг болгоноо бүдүүлгээр дуугаран хэллээ.

- Гэвч түгшээх бол бүдүүлэг явдал гэж Дамблдор түүнийг яриаг дуусгаад,

- Өөр үг хэлэх хэрэггүй дээ, эрхэм хүн минь. Аан энэ Петунья байх гэв.

Гал зуухны үүд нээгдэж Харрийн нагац эгч унтлагын цамцан дээгүүрээ гэрийн халат углаж, гартаа хаймран бээлий өмсөөд ердийнхөөрөө унтахын өмнө хоолны өрөөгөө зүлгэж байсан бололтой гарч ирлээ. Түүний морь шиг царайд цочирдлоос өөр юу ч илэрсэнгүй.

- Альбус Дамблдор гэж Вернон ах түүнд эхнэрээ танилцуулаагүй явдалд Дамблдор дуугарлаа.

- Бид мэдээж захидлаар харьцаж байсан.

Харрид энэ үг нь түүний Петунья эгчид дэлбэрдэг захиа явуулсныг сануулж байгаа юм шиг санагдав.

- Харин энэ танай хүү Дадли байхаа?

Дадли энэ агшинд зочны өрөөний хаалгаар гарч ирэв. Түүний цайвар үстэй толгой судалтай хүрэмнийх нь захнаас агаарт өлгөгдсөн юм шиг цухуйх бөгөөд гайхсандаа амаа ангайлаа.

Дамблдор нэг хоёр хормын турш Дурслийнхнийг юм хэлэх болов уу гэж хүлээснээ чимээгүй байсан тул инээмсэглэн,

- Намайг зочдын өрөөндөө урьсан гэж бодож болох уу? гэв.

Дамблдор түүн рүү очих үед Дадли хажуу тийшээ үсрэн холдов. Харри шатны сүүлчийн хэдэн гишгүүрийг гартаа дуран, кэт барьсан хэвээр харайгаад бас зочны өрөөнд орлоо. Дамблдор ханан зуухны дэргэдэх сандалд суугаад өрөөг сониучирхан харав. Түүний энд байгаа нь туйлын хачирхалтай харагдаж байлаа.

- Бид ... бид эндээс явах уу, ноёнтоон? гэж Харри түгшин асуулаа.

- Тиймээ эргэлзээгүй явна. Гэхдээ явахын өмнө зарим нэг зүйлийн талаар ярилцах хэрэгтэй байна. Харин би үүнийг гудамжинд хийхийг эрхэмлээгүй тул нагац ах, эгч хоёрын чинь зочломтгой занг ашиглан хэтрүүлсэн хэрэг.

- Энд юмаа цуглуултал саатах уу?

Вернон Дурсль зочны өрөөнд орж ирэхэд Петунья эгч түүний мөрөн дээгүүр шагайж араас нь Дадли цухуйв.

- Тиймээ жаахан саатна.

Дамблдор саваагаа маш түргэн даллахад Харри хөдөлгөөнийг нь дагуулан харж амжсангүй. Тас няс хийх дуу гарахын хамтаар буйдан урагш ухасхийн гурван Дурслийн өвдөгний нугалаасыг мөргөхөд тэд суулаа. Ахин нэг даллахад буйдан ердийн байрандаа оров.

- Ингэсэн нь илүү аятайхан гэж Дамблдор нөхөрсгөөр хэлэв.

Түүнийг шидэт саваагаа халаасандаа далд хийхэд Харри гар нь түлэгдсэн юм шиг харлаж үрчийснийг харлаа.

- Ноёнтоон ... таны гар яагаа вэ?

- Дараа, Харри. Сууж үз.

Харри цорын ганц чөлөөтэй суудалд суугаад гайхширч гөлөрсөн Дурслийнхан руу харахгүйг хичээв.

- Би таныг ямар нэг уух юмаар зочлохыг хүлээж байна гэж Дамблдор Вернон ахад хэлэв.

Тэр гурав дахь удаагаа саваагаа даллахад агаарт тоостой лонх таван шилэн аяганы хамтаар бий болов. Лонх бөхийхөд шилэн аяганууд балын өнгөтэй шингэнээр дүүрч өрөөнд сууж байсан хүн бүрийн өмнө хөөрлөө.

- Хатагтай Розмертагийн царсан торхонд дарсан хамгийн сайн балын ундаа гээд Дамблдор аягатайгаа өргөхөд Харри өөрийнхийгөө аваад уулаа.

Өмнө нь хэзээ ч амталж байгагүй гэлээ ундаа их таалагдлаа. Дурслийнхан айсан байртай бие бие рүүгээ хараад аягануудыг тоохгүй байхыг хичээсэн ч толгойны хажуугаас нь нударч байхад амаргүй байлаа. Үүнийг хараад Харрид Дамблдор болж буй үйл явдалд тааламжтай байна гэсэн гүнзгий сэжиг төржээ.

- Ингээд Харри бидэнд хэцүү асуудал тулгарсныг чамайг шийдвэрлэнэ байх гэж найдаж байна. Бидэнд гэж Фениксийн бүлгэмийн тухай ярьж байна л даа. Гэхдээ юуны түүрүүнд долоо хоногийн өмнө Сириус чамайг өв залгамжлагчаараа үлдээснийг нээн илрүүлснээ хэлэх ёстой байх.

Буйдан дээр сууж байсан Вернон ахын толгой эргэхэд Харри түүн рүү харалгүй юу ч бодохгүйг хичээн,

- Ойлгомжтой гэв.

- Энэ тухай илэн далангүй ярилцъя. Чиний Гринготтс банкин дахь хадгаламж дээр чинь Сириусын эзэмшил хувь нэмэгдэнэ. Гэхдээ өв залгамжилахад нэг багахан асуудал үүсээд байна л даа ...

- Түүний загалмайлан эцэг үхсэн хэрэг үү? гэж Вернон ах буйдан дээрээс чанга асуулаа.

Дамблдор, Харри хоёр түүн рүү зэрэг эргэн харав. Балын ундаатай шилэн аяга шанааных нь хажууд хөөрөхөд цохиулахгүйн тулд зайлсхийж байлаа.

- Тэр үхсэн юм уу? Загалмайлан эцэг нь?

- Тийм гэж Дамблдор хэлэхдээ Харригаас Дурслийнханд яагаад энэ тухай хэлээгүй болохыг асуусангүй.

- Бидний асуудал бол гэж тэр цааш Харрид хандан үргэлжлүүлээд,

- Сириус чамд Гриммогийн арван хоёр дугаар байшинг гэрээслэн үлдээсэн гэдэгт байгаа юм гэв.

- Тэр түүнд бүтэн байшин үлдээгээ юу? гэж Вернон ах шунахай жижигхэн нүдээ онийлгон асуухад хэн ч хариулсангүй.

- Цаашид түүнийг штабын байраар ашиглаж болно. Надад хамаагүй. Түүнийг ав надад хэрэггүй гэж Харри хэллээ.

Тэр ахин хэзээ ч Гриммогийн арван хоёрдугаар байшинд орохыг хүссэнгүй. Магадгүй түүнийг үргэлж Сириусын харанхуй хоосон өрөөнд ганцаараа хоригдож байсан дурсамж дагалдах байх.

- Чи их өгөөмөр юм. Гэхдээ бидэнд эхлээд байшинг чөлөөлөх шаардлага гараад байна.

- Яагаад?

- Харж байна уу гэж Дамблдор Вернон ахын зулайг аяга хүчтэй цохиход уурсан бувтнахыг тоолгүй хэлээд,

- Блэкийн гэр бүлийн уламжлал ёсоор байшин дараагийн эрэгтэй залгамжлагчид очих ёстой. Түүний дүү Регулус эрт үхсэн болохоор Сириус сүүлчийн хүн байсан тэгээд ч хоёулаа үр хүүхэдгүй. Тэр чамд өгөхийг хүссэн нь тодорхой ч байшин зөвхөн цэвэр цусны шидтэн эзэмшиж чадах шившлэгтэй юм гэлээ.

Харрид арван хоёр дугаар байшингийн дүр зураг зурсхийхэд Сириусын ээжийн шүлсээ үсчүүлэн орилж хашгирсан хөрөг хурцаар төсөөлөгдөв.

- Би ч гэсэн тэгж бодож байна.

- Яг тийм. Хэрвээ байшин үнэхээр Блэкийн төрөл төрөгсдөд үе залгамжлагдах шившлэгтэй бол түүний үеэл эгч Беллатриса Стрейнжэд шилжих болно.

Харри хөл дээрээ үсрэн боссоноо өөрөө ч анзаарсангүй. Түүний өвдөг дээр байсан дуран авай, кэт хоёр шалан дээр уналаа. Сириусын алуурчин Беллатриса Лейстрейнж түүнийг байшинг авах хэрэг үү?

- Яагаад ч үгүй!

- Бид ч гэсэн байшинг түүнд өгөхийг бодохгүй байгаа. Үйл явдлын ярвигтай хэцүү байна. Бас цаашид манай шившлэг үйлчлэхийг мэдэхгүй байна. Жишээлбэл үүний ачаар байшинг ямар ч газрын зурган дээр олж болохгүй гэх мэт. Гэхдээ дурын агшинд босгоор нь Беллатриса орж ирээд өөрийн дүрмээ тогтоох болно. Тодорхой хэлбэл бид байрлалаа орхих шаардлагатай.

- Гэхдээ байшинд надад ирсэн эсэхийг яаж мэдэх юм?

- Аз болоход шалгах энгийн арга бий.

Тэр хоосон аягаа сандлын хажуугийн жижигхэн ширээн дээр тавьтал Вернон ах,

- Энэ бүдүүлэг зүйлээ биднээс холдуул гэж орилов.

Харри эргэж харахад гурван Дурсль гараараа толгойгоо хаан бөхийгөөд шилэн аяганууд зулай дээр нь баяртайгаар үсчиж байлаа.

- Өө, намайг өршөөнө үү. Гэхдээ хүмүүжилтэй хүмүүс уудаг л юм даа гэж Дамблдор эелдэгээр хэлээд шидэт саваагаа ахин өргөлөө. Гурван аяга алга болов.

Вернон ах уцаарлан үг сөргөх гэснээ больж нуруугаараа буйдан налаад жижигхэн торойн нүдээ Дамблдорын гарт байгаа шидэт саваанаас салгасангүй.

- Ойлгож байна уу хэрвээ чамд байшин үнэхээр өвлөгдсөн бол гэрээслэл хүч өгөх ёстой гэж Дамблдор хэлэхэд Вернон ах тэдний ярианд оролцсонгүй.

Тэрбээр таван удаа шидэт саваагаа даллав. Чанга тасхийх чимээ гараад Дурслийн сахлаг хивсэн дээр богинохон хамар, сарьсан багваахай адил дэлдэн чих, том цусан улаан нүд, бохир алчууртай хувцас бүхий гэрийн үйлчлэгч газардав. Петунья эгч орь дуу тавьснаас үзэхэд энэ гэрт хэзээ ч ийм бохир амьтан орж ирж байгаагүй бололтой. Дадли айсандаа ойлгомжгүй амьтан өмднөөс нь зуурахаас эмээн бүдүүн ягаан хөлөө шалнаас өргөхөд Вернон ах,

- Энэ чинь одоо юу гэдэг чөтгөр вэ? гэлээ.

- Кикимер гэж Дамблдор хэлэв.

- Кикимер хүсэхгүй байна, Кикимер тэгэхгүй, Кикимер тэгэхгүй! гэж гэрийн үйлчлэгч чангаар сөөнгөтөн тавхайгаа дэвслэхэд Вернон ах чихээ таглав.

- Кикимер хатагтай Беллатрисад харьяалагдана. Кикимер Блэкийнд харьяалагдана. Кикимер шинэ эзэгтэй хүсч байна, Кикимер энэхүү Поттерд очихийг хүсэхгүй байна, тэгэхгүй, тэгэхгүй!

- Харри чи харж байна уу? гэж Дамблдор Кикимерийн «тэгэхгүй, тэгэхгүй» гэсэн сөөнгөтөлтөн дундаас чанга хэлээд,

- Кикимер чиний эзэмшилд байх ямар ч хүсэлгүй болохыг харж байгаа биз дээ гэв.

- Надад хамаагүй гэж Харри ахин хэлээд гэрийн үйлчлэгчийн дэвсэлж буй хөл рүү зэвүүцэн харлаа.

- Би түүнийг авахыг хүсэхгүй байна.

- Тэгэхгүй, тэгэхгүй, тэгэхгүй ...

- Чи түүнийг Беллатриса Лейстрейнжийн эзэмшилд өгөхийг хүсч байгаа хэрэг үү? Тэр бүтэн жил жилийг Фениксийн бүлгийн штабын байранд өнгөрүүлснийг мэдэж байгаа биз дээ?

- Тэгэхгүй, тэгэхгүй, тэгэхгүй.

Харри Дамблдор руу харлаа. Тэр Кикимерийг Беллатриса Лестрейнж рүү явуулж болохгүйг ойлгож байсан ч Сириусээс урвасан амьтныг эзэмших нь тэвчиж боломгүй санагдав.

- Түүнд тушаал өг. Хэрвээ тэр чиний мэдлийнх бол сонсох л болно. Хэрэв үгүй бол бид хууль ёсны эзэгтэйд нь өгөхгүй байх ямар нэг арга бодож олохоос.

- Тэгэхгүй, тэгэхгүй, ТЭГЭХГҮЙ!

Кикимерийн хоолой дээд цэгтээ хүрэн хашгирлаа. Харри юу хэлэхээ бодож ч амжсангүй.

- Кикимер чимээгүй!

Агшин зуур Кикимер багалзуурдуулсан юм шиг санагдав. Гэрийн үйлчлэгч хоолойгоо бариад нүд нь бүлтийсэн хэдий ч уруул нь ууртай хөдөлсөн хэвээр байлаа. Хэдэн хормын турш тэр амаа ангалзуулснаа нүүрээрээ хивсэн дээр унаад (Петунья эгч дуу алдав) хөл гараараа шал нүдэв.

- Энэ бүгдийг хялбарчилж байна. Харваас Сириус юу хийхээ мэдсэн бололтой.

Чи Гриммогийн арван хоёрдугаар байшин болон Кикимерийн хууль ёсны эзэмшигч гэж Дамблдор хөгжилтэй хэлэв.

- Би түүнийг өөртэйгээ үргэлж хамт авч явах ёстой юу? гээд Харри Кикимерийг айдаст автан харлаа.

- Үгүй дээ. Хэрвээ хүсэхгүй байвал чамд зөвлөхөд Хогвартсын гал зууханд ажиллуулахаар илгээсэн нь дээр байх. Тэгвэл бусад гэрийн үйлчлэгчид түүнийг харж чадна.

- Тийм шүү гээд Харрийн санаа амарч,

- Би тэгж хийх болно. Хөөе ... Кикимер ... Хогвартс руу явж тэндхийн гал зууханд бусад үйлчлэгчдийн хамт ажилла гэв.

Кикимер нуруугаараа хэвтээд гар хөлөө нүдэж байснаа Харри руу зэвүүцэнгүй харж чанга тасхийх чимээ гарган ирсэн шигээ алга болов.

- Сайн байна. Одоо Клювокрылын тухайд нэг асуудал үлдлээ. Сириусын үхлийн дараа түүнийг Хагрид арчилж байгаа ч хэрвээ чи хүсвэл ...

- Үгүй, Хагридад үлдсэн нь дээр. Би тэгж бодож байна. Клювокрыл ч үүнийг өөрөө хүсч байгаа байх.

- Хагрид хөөрөх байх даа. Тэр Клювокрылыг ахин хараад их баярласан шүү.

Бид ямар ч атугай Клювокрылын аюулгүй байдлын тулд шинэ нэр өгөхөөр шийдсэн. Одоо түүнийг Махаон гэж дуудаж байгаа болохоор ид шидийн яамны хэн нэгэн үхэх ёстой байсан гиппогриф гэж тааварлана гэж бодохгүй байна. За Харри, чемодан чинь бэлэн үү?

- М-м ...

- Намайг үнэхээр ирнэ гэж итгээгүй байх нь ээ?

- Би одоохон гүйгээд ... дуусгачихъя гээд Харри яаран шалан дээрээс дуран, кэтээ авлаа.

Түүнд хэрэгтэй бүх зүйлээ янзлахад арваас багагүй хором оров. Эцэст нь орон дороос үл үзэгдэх цув, өнгө нь хувирдаг бэхээ гаргаад тогоондоо хийж чемоданыхаа тагийг тасхийтэл хаалаа. Нэг гартаа хүнд чемодан, нөгөө гартаа Хэдвигийн торыг барьсаар ахин нэг давхарт бууж ирэв.

Түүний урмыг хугалан Дамблдор үүдэнд гарч ирээгүй байсанд зочны өрөөнд орлоо. Зочны өрөөнд хэн ч ярьсангүй. Дамблдор хамар дороо аяархан дуу гүнгэнэж уур амьсгал хүндхэн байсанд Харри Дурслийнхан руу харалгүй,

- Профессор ... би бэлэн боллоо гэв.
- Сайн байна. Одоо ганц л зүйл үлдлээ гээд тэр Дурслийнхан руу эргэв.
- Та нар Харри жилийн дараа насанд хүрнэ гэдгийг эргэлзээгүй мэдэж байгаа ...
- Үгүй гэж Дамблдорын ирсэн цагаас хойш чимээгүй байсан Петунья эгч дуу алдав
- Өршөөгөөрэй? гэж Дамблдор эелдэгхэн гайхлаа.
- Үгүй, хүрэхгүй. Тэр Дадлигаас нэг сараар дүү. Харин Дадли хоёр жилийн дараа арван найман нас хүрнэ.
- Аан. Гэвч шидтэнгүүдийг арван долоон нас хүрэх үед нь насанд хүрсэн гэж тооцдог юм.
- Шал дэмий юм гэж Вернон ах бувтнасан хэдий ч Дамблдор түүнд анхаарал хандуулсангүй.
- Та нар Волан-де-Морт нэртэй шидтэн манай оронд эргэн ирснийг мэдэж байгаа. Шидтэний ертөнцөд дайн дэгдэж байна. Лорд Волан-де-Морт өмнө нь хэдэн удаа Харриг алахыг оролдсон болохоор одоо танай зээд арван таван жилийн өмнө босгон дээр эцэг эхийнх нь аллагын тухай болон та нарыг түүнд анхаарал тавин хүүхэд шигээ өсгөхийг хүссэн захиатай орхисон үеийнхээс илүү аюул заналхийлж байна.

Дамблдор чимээгүй болоход хоолой нь тайван байсан хэдий ч уур хилэн мэдрэгдэхэд Харри хүйтэн болохыг анзаартал Дурслийнхан бие биендээ наалдав.

- Та нар миний гуйлтыг биелүүлээгүй. Та нар хэзээ ч Харрид хүү шигээ хандаж байгаагүй. Тэр та нарт басамжлагдах ямар ч зүйл хийгээгүй ч үргэлж хэрцгий байсан. Цорын ганц баярлах зүйл гэвэл аймшигтай аюулаас мултарсан золгүй хүү одоо та бидний дунд сууж байна.

Петунья эгч, Вернон ах хоёр өөрийн мэдэлгүй хэн нэгнийг хайсан мэт харахад Дадли тэдний дунд сууж байлаа.

- Бид ... Дадлиг ад үзсэн гэх нь үү? Та юуны тухай ...? гэж Вернон ах ууртай эхэлсэн ч Дамблдор хуруугаа өргөн чимээгүй болгоход хэлгүй юм шиг боллоо.
- Би арван таван жилийн өмнө Харрид хүчирхэг хамгаалалтын шид хэрэглэн танай гэртэй холбосон. Хэдийгээр тэр энд аз жаргалгүй хэцүү байсан ч, та нар түүнтэй муу харьцаж дургүй байсан ч гэлээ түүнийг гэртээ авсан. Шидийн үйлчлэл Харриг арван долоон нас хүрэх буюу өөрөөр хэлбэл насанд хүрэх үед алга болох юм. Би та нараас ганц л зүйл гуйя. Харриг ердөө ирэх жил ахин нэг удаа ирүүлэхийг гуйж байна. Тэгвэл хамгаалалт түүнийг арван долоон нас хүртэл хамгаалах юм.

Дурслийнхан чимээгүй байв. Дадли түүнд ямар аюул заналхийлж буйг төсөөлөв боллоотой хөмсгөө зангидлаа. Вернон ах хоолойд нь юм тээглэсэн аятай болж, Петунья эгчийн сэтгэл донслон хачирхалтай улайжээ.

- За, Харри ... бидний явах цаг болж гээд Дамблдор босч,
- Дараа уулзая гэж Дурслийнханд хэлээд малгайгаа өмсөж өрөөнөөс гарлаа.
- Баяртай гэж Харри яаран хамаатнууддаа хэлээд араас нь гарахад Дамблдор чемодан болон Хэдвигийн торны хажууд зогсон хүлээж байлаа.
- Бидэнд одоо энэ саад болно гээд Дамблдор ахин халааснаасаа шидэт саваа гаргаж ирэв. Би чиний юмыг Үүр лүү явуулчихъя. Гэхдээ чамайг үл үзэгдэх цуваа авахыг хүсэх байна ...

Харри Дамблдорт дотор нь аймшигтай замбараагүй байгааг харуулахгүйн тулд чемоданаасаа цуваа хүндхэн гаргаж ирлээ. Тэр үл үзэгдэх цуваа хүрэмнийхээ дотор халаасанд хийхэд Дамблдор саваагаа даллан чемодан, Хэдвигийн тор хоёрыг алга болгов. Түүнийг саваагаа ахин даллахад үүдний хаалга нээгдэн хүйтэн манантай харанхуй угтлаа.

- Харин одоо Харри минь шөнийн адал явдалдаа оръё!



## БҮЛЭГ 4: ГОРАЦИЙ СЛИЗНОРТ

Сүүлчийн хэдэн өдрийн турш Харри Дамблдорыг жинхэнээсээ ирнэ гэж цөхөртлөө найдаж байсан хэр нь одоо түүний хамт Улаан модон гудамжнаас явахад гэнэтхэн амаргүй болов. Тэр хэзээ ч Дамблдортой сургуульд байхад нь ч тэр энгийн яриа өрнүүлж байсангүй. Тэдний хооронд үргэлж захирлын ширээ байдаг байлаа. Түүнчлэн сүүлчийн уулзалтын тухай дурсамж зурсхийхэд аймшигтай хашгирч Дамблдорын өрөөний үнэт зүйлийг эвдэхийг хичээж байснаа санахад ичгүүртэй байв.

Гэвч Дамблдор юу ч болоогүй мэт тайван байлаа.

- Саваагаа бэлхэн барь, Харри гэж урамтай зөвлөв.
- Харин би сургуулиас гадуур ид шид хэрэглэх хориотой гэж бодсон юмсан.
- Хэрвээ бидэн рүү дайрвал толгойд чинь орж ирсэн ямар ч шившлэг хэрэглэхийг зөвшөөрөх болно. Гэхдээ хэн нэгэн өнөөдөр чамайг дайрна гэж бодохгүй байна.
- Яагаад, ноёнтоон?
- Чи надтай хамт явж байна гэж Дамблдор энгийнээр өгүүлэв. Тэр Улаан модон гудамжны буланд гэнэтхэн зогслоо.
- Чи шилжих шалгалт өгөөгүй юу?
- Үгүй. Үүний тулд насанд хүрсэн байх ёстой биз дээ?
- Тийм шүү. Тэгэхээр чи миний гараас чанга барих хэрэгтэй. Зүүнээс нь бариарай баруун нь эрүүл бус байгаа болохыг харж байгаа биз дээ.

Харри Дамблдорын сунгасан гараас барилаа.

- Их сайн байна. За, урагшаа.

Харри Дамблдорын гар хуруунаас нь мултрахыг мэдээд бүх хүчээ гарган зуурлаа. Дараагийн агшинд дотор нь харанхуйлж, цээжийг нь төмөр бүслүүрээр ороосон аятай давчдан амьсгалж чадахаа болиход, нүд нь ухархайдаа буцаж шигдэн, чихний хэнгэрэг нь даралтанд шахагдсанаа гэнэтхэн ...

Тэр шөнийн хүйтэн агаарыг цээж дүүрэн амьсгалаад нүдээ нээлээ. Түүнд мохоо хаймар хоолойгоор нүдүүлчихсэн аятай мэдрэмж төрөв. Харри хэдэн хормын дараа Улаан модон гудамж алга болсныг анзаарчээ. Тэр Дамблдорын хамт төвдөө дайны дурсгалын хөшөө бүхий хэдэн сандалтай тосгоны хүнгүй талбайд зогсож байлаа. Харри дөнгөж сая амьдралдаа анх удаа шилжсэн гэдгээ ойлгов.

- Чи зүгээр үү? Энэ мэдрэмжинд дасах хэрэгтэй шүү гэж Дамблдор анхаарсан байдалтай хэлэв.
- Зүгээр гэж Харри хариулаад чихээ үрэн Улаан модон гудамжыг орхисноо дургүйхэн мэдэрлээ. Гэхдээ шүүрээр ниссэн нь дээр юм байна.

Дамблдор инээмсэглээд жанчныхаа хоолойг товчилж,

- Ийшээ гэлээ.

Тэр түргэн алхаагаар урагшлан хоосон баар болон хэд хэдэн байшинг өнгөрөв. Тосгоны сүмийн цаг бараг шөнө дунд болж байлаа.

- Надад хэлээч, Харри. Чиний сорви ... ахиад өвдсөн үү? Харри өөрийн мэдэлгүй цахилгаан хэлбэртэй сорвио иллээ.

- Үгүй. Би бүр яагаад гэдгийг нь гайхаж байна. Уул нь Волан-де-Мортыг хүчээ авсан цагаас хойш үргэлж өвддөг байсан.

Харри Дамблдорын сэтгэл хангалуун байхыг нь олж харлаа.

- Харин би эсрэгээрээ бодож байна. Лорд Волан-де-Морт эцэстээ чамайг өөрийн бодол мэдрэмждээ нэвтрүүлэх нь аюултай гэдгийг ойлгожээ. Тэр чамаас окклюменцийн тусламжтай тусгаарлагдсан бололтой.

- Надад харамсах юм алга гэж Харри хэлэв. Түүнд түгшүүртэй зүүд болон гэнэтийн Волан-де-Мортын сэтгэл хөдлөлд нэвтрэхгүйгээр амьдрахад амар байлаа.

Тэд булан тойрч телефон утасны бүхээг болон автобусны буудлыг өнгөрөв. Харри ахин Дамблдор руу харлаа.

- Профессор!

- За, Харри?

- Бид одоо хаана байгаа юм бэ?

- Энэ бол Бадли-Бэббертон гэдэг тосгон, Харри.

- Бид энд юу хийж байгаа юм?

- Аан тийм л дээ, би чамд хэлээгүй билүү. Би хэдийн тооцоо алдсан болохоор сүүлийн жил бидэнд ахиад нэг багш хэрэг болсон. Бид энд урьд нь миний хамт ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан хүнийг ятгахаар ирээд байна.

- Би үүнд юугаар туслах вэ, ноёнтоон?

- Өө, би чамайг хэрэг болох арга олно гэж бодож байна гэж тэр тодорхойгүй хэлээд,

- Зүүн тийшээ, Харри гэв.

Тэд давчуу эгнэсэн байшингуудын дундуур өгслөө. Байшингуудын цонх харанхуй байв. Энд ч гэсэн Улаан модон гудамжинд хоёр долоо хоногийн өмнө болсонтой адил хачирхалтай хүйтэн ясанд хүртэл жиндэнэ. Харри Дементоруудын тухай бодоод мөрөн дээгүүрээ эргэн харж халаасандаа байгаа шидэт саваагаа чанга атгалаа.

- Профессор, бид яагаад таны хуучин танилын байшингийн хажууд шууд шилжчихэж болоогүй юм бэ?

- Яагаад гэвэл энэ нь бусдын үүдний хаалгыг эвдэх аюултай. Хуулинд бусдыг шидтэнгүүдийн гэрт хөндлөнгөөс нэвтрүүлэхгүй байх тусгай заалт байдаг. Иймээс

шидтэнгүүдийн оршин сууж буй газар хүсээгүй шилжилтээс хамгаалах шидийн хамгаалалт байдаг юм. Жишээлбэл Хогвартсын адилаар ...

- Шилтгээний нутаг дэвсгэрт шилжих боломжгүй. Надад Гермiona Грэйнджер хэлсэн гэж Харри түргэн хэлэв.

- Түүний зөв. Одоо зүүн тийшээ.

Сүмийн цаг шөнө дунд болсныг зааж байлаа. Харрид Дамблдор яагаад урьд нь хамт ажиллаж байсан хүнтэйгээ эелдэг бусаар орой болсон үед уулзах гэж байгаа нь ойлгомжгүй байсан ч илүү чухал асуулт асуухыг хүслээ.

- Ноёнтоон би «Өдөр тутмын зөнч» сонингоос Фажын огцорсныг уншсан ...

- Тиймээ. Чи эргэлзээгүй түүний оронд мракоборецуудын хэлтсийг удирдаж байсан Руфус Скримжер томилогдсоныг уншсан байх.

- Харин тэр ... та түүнийг сайн сайд болно гэж бодож байна уу?

- Сонирхолтой асуулт байна. Тэр хүний хувьд мэдээж авъяастай. Корнелиусыг бодвол илүү шийдэмгий хүчирхэг.

- Тиймээ, гэхдээ би ...

- Би чиний юуны тухай ярьсныг ойлгож байна. Руфус амьдралынхаа ихэнхи хэсгийг хар шидтэнгүүдтэй тэмцэн өнгөрүүлсэн болохоор лорд Волан-де-Мортыг дутуу үнэлэхээргүй хүн.

Харри үргэлжлэл хүлээсэн авч Дамблдор «Өдөр тутмын Зөнч» сонинд дурьдсанчилан Скримжертэй санал зөрөлдсөн талаар хэлсэнгүйд цааш асуух зүрх хүрсэнгүй өөр юм ярилаа.

- Бас ноёнтоон ... би хатагтай Боунсын тухай уншсан.

- Тиймээ гэж Дамблдор аяархан хэлээд,

- Аймшигтай гарз. Тэр гайхалтай шидтэн байсан юм. За, бид ирчих шиг боллоо ... ёо! гэв.

Тэр өвчтэй гараараа мартаад заачихлаа.

- Профессор, таны гар яагаа вэ ...?

- Одоо тайлбарлах цаг нь биш. Энэ сэтгэл зовоосон түүх болохоор ярихыг хүсэхгүй байна.

Тэр инээмсэглэхэд Харри ярьж болохгүйг нь ойлгоод цааш нь өөр зүйл асуулаа.

- Ноёнтоон, надад ид шидийн яамнаас Үхэл залгигчид дайрсан тохиолдолд яаж хамгаалах тухай ухуулах хуудас ирсэн ...

- Би ч гэсэн тийм хуудас авсан. Чи түүнээс ашигтай юм олов уу? гэж Дамблдор өмнөхийн адил инээмсэглэн хэллээ.

- Үгүй дээ.

- Би ч гэсэн тэгж бодож байна. Жишээлбэл чи намайг хууран мэхлэгч биш жинхэнэ Дамблдор гэдгийг мэдэхийн тулд дуртай жимсний чанамал минь юу болохыг асуусангүй.

- Би ... гэж Харри эхэлсэн ч юу хэлэхээ мэдсэнгүй.

- Ирээдүйд лавлаарай, Харри бөөрөлзгөнө шүү ... гэхдээ мэдээж би Үхэл залгигч байсан бол зүсээ хувиргахаас өмнө надад ямар жимсний чанамал таалагддагыг эртхэн мэдэх байлаа.

- Ойлгомжтой. Тэгэхээр энэ ухуулах хуудсанд ямар нэг инферналын тухай ярьсан байсан. Энэ юу юм бэ? Хуудсанд тодорхой дурьдаагүй байсан.

- Энэ бол үхдэлүүд. Үхэгсдийг хар шидтэн илбэдэн өөртөө зүтгүүлдэг юм. Ер нь бол инферналуудыг Волан-де-Мортын сүүлд ноёрхож байсан үеэс хойш хэн ч хараагүй. Тэр хангалттай тооны хүн алсан болохоор инферналын бүхэл бүтэн арми цуглуулсан байгаа. За энэ байна, Харри бид ирчихлээ.

Тэд нямбайлан зассан цэцэрлэгтэй жижигхэн чулуун байшингийн өмнө ирлээ. Харрийн толгойноос аймшигт инферналуудын тухай бодол гараагүй байсан болхоор Дамблдор үүдний хаалганы өмнө огцом зогссоныг анзааралгүй мөргөөд золтой л уначихсангүй.

- Бурхан минь, бурхан минь, бурхан минь ...

Харри цэцэрлэгийн тахирласан зам руу харахад зүрх нь палхийлээ. Үүдний хаалга нэг нугасан дээрээ тогтож байв.

Дамблдор эргэн тойрноо харахад гудамж хоосон байлаа.

- Шидэт саваагаа бэлэн бариад миний араас дага, Харри.

Тэр хаалгыг түлхээд цэцэрлэгийн замаар түргэн чимээ шуугиангүй явлаа. Харри түүнээс алхам ч холдолгүй дагав. Дамблдор үүдийг удаанаар онгойлгохдоо шидэт саваагаа урдаа өргөлөө.

- Люмос!

Савааны үзүүрээс гэрэл тусан гийгүүлэв. Зүүн талд хагас нээлттэй үүд байв. Дамблдор толгой дээрээ гэрэлтэй саваагаа өргөөд зочны өрөөнд ороход Харри араас нь дагав.

Тэдний өмнө сүйрлийн дүр зураг угтав. Хөл дор хагарсан нүүртэй хэмхэрхий дүүжин цаг хэвтэж санжлага нь дайны хөлд унасан илд шиг ёрдойгоод, төгөлдөр хуур харуулдан унаж товчлуур нь шалаар нэг асгарчээ. Дэргэд нь гэрлийн бүрхүүлийн хагархай гялалзаж, буйдангийн дэр задран өд сөд цухуйжээ. Бүх зүйл тоосонд дарагдсан байх агаад бяцарсан хятад дэнлүүний хагархай гялалзана. Дамблдор шидэт саваагаа дээш нь өргөхөд хананд цацагдсан хар хүрэн зүйл харагдав. Харри аяархан дуу алдахад Дамблдор эргэж харлаа.

- Таагүй юм тийм үү? Энд ямар нэг аймшигтай зүйл болсон бололтой гэж гашуудалтай хэлэв.

Тэр өрөөний дунд болгоомжтой очоод хөл дорхи хэмхэрхийг нягтлан харлаа. Харри түүний араас явахдаа эвдэрсэн төгөлдөр хуур, хөмөрсөн буйдангийн ар луу эмээнгүй шагайсан ч үхсэн хүний бие байсангүй.

- Магадгүй тэд тэмцээд ... түүнийг хүчээр аваачсан юм болов уу, профессор?

гээд Харри ханан дээр үсэрсэн байсан зүйлийн бодохгүй байхыг хичээв.

- Магадгүй л юм гээд Дамблдор зөөлөн сандал руу харлаа.

- Та түүнийг ...

- Энд хаа нэгтээ байгаа гэж үү? Тиймээ.

Тэр гэнэтхэн бөхийж шидэт савааныхаа үзүүрээр зөөлөн сандлыг хатгалаа.

- Ёо-ёо! гэж сандал дуу алдав.

- Оройн мэнд, Гораций гээд Дамблдор өндийн бослоо.

Харри амаа ангайлаа. Хормын өмнө сандал хажуулдан хэвтэж байсан газар итгэмээргүй бүдүүн халзан толгойтой хөгшин хүн атиралдаж байв. Тэр гэдсээ илснээ Дамблдор руу нулимс гүйсэн нүдээр гомдонгуй харж,

- Тийм хүчтэй хатгах хэрэггүй байсан юм. Өвдөж байна шүү дээ гэж ууртай үглээд хөл дээрээ босов.

Шидэт савааны гэрэл түүний гялалзсан халзан толгой дээр тусаж бүлтгэр нүд, далайн морь лугаа адилхан өтгөн мөнгөлөг сахал, гялгар товчтой бор өнгийн хамба хилэн гэрийн хүрмийг гийгүүлэв. Түүний зулай Дамблдорын эрүүнд хүрч байлаа.

- Чи яаж мэдэв ээ? гэж махлаг хүн бувтнаад гэдсээ иллээ. Тэр сандал байсныг нь илрүүлсэн явдалд гайхалтай хэнэггүй байлаа.

- Хүндэт Гораций минь, хэрвээ чамтай үнэхээр Үхэл залгигчид тулгарсан бол байшин дээр чинь Хар тамга байх байсан гээд Дамблдор инэвхийлэв.

Махлаг шидтэн цулцгар гараараа халзан духаа алгадав.

- Хар тамга. Би ямар нэгэн зүйл алдсан гэж мэдээд байсан юмаа ... Юу гэвэл!

Хангалттай цаг байсангүй. Чамайг өрөөнд орж ирэхэд би дөнгөж бүрээсээ хийж амжсан юм.

Тэр хүндээр санаа алдахад сахлынх нь үзүүр чичигнэлээ.

- Цэвэрлэхэд туслах уу? гэж Дамблдор эелдэгээр снаал болгов.

- Тэгэлгүй яахав.

Тэд хоёул нуруугаа нийлүүлэн зогсоод шидэт саваагаа зэрэг даллав.

Гэрийн тавилгууд өөрсдийн байрандаа эргэн орж, хагархай агшин зуур бүтэн болоод, өд дэрэндээ чихэгдэн, номнууд тавиуртаа ярайн өрөгдөж, хуучин дэнлүү агаарт хөөрөөд ширээний дээр газардан аслаа. Түүнчлэн гялалзсан мөнгөн жаазтай зурагнууд өрөөн дундуур нисэн бичгийн ширээн дээр өрөгдөж, хана ахин цэвэрхэн боллоо.

- Ингэхэд энэ юуны цус вэ? гэж Дамблдор дүүжин цаг түжигнэн хэвдээ орох чанга чимээнд асуулаа.

- Ханан дээрх үү? Лууны! гэж Гораций нэртэй шидтэн хашгирлаа.

Тэр агшинд чих дөжрөм жингэнэсэн дуу гараад бүрхүүл таазанд эрэгдэн тогтов. Эцэст нь төгөлдөр хуур байрандаа ороод нам гүм боллоо.

- Тиймээ, лууны гэж шидтэн давтаад,

- Сүүлчийн лонх байсан юмсан. Одоо ч тэнгэрт хадсан үнэтэй болж дээ. Гэхдээ түүнийг ахиж ашиглаж болно байх гэв.

Тэр шүүгээ рүү очоод жижигхэн шилэн лонх авч өтгөн шингэнийг гэрэлд харлаа.

- Хм-м ... жаахан тоостой болчихож.

Тэр ахин шилэн савыг шүүгээн дээр тавиад санаа алдсанаа Харри дээр харц тусгав.

- Ай! ай! гэж түүний дугуй том нүд Харрийн духан дээрх цахилгаан хэлбэртэй сорви дээр тусаад хашгирлаа.

- Энэ бол Харри Поттер. Харри энэ бол миний хуучин хамтран ажиллагч, Гораций Слизнорт гэж Дамблдор танилцуулаад урагш алхав.

Слизнорт Дамблдор руу цоо ширтэн харлаа.

- Тэгэхээр чи намайг ятгах гэсэн юм биз дээ? Тэгвэл миний хариулт үгүй, Альбус.

Тэр Харрийн дэргэдүүр шийдэмгий эсэргүүцсэн өнгөтэй түлхэн өнгөрлөө.

- Бидэнд уух юм санал болгохгүй юм уу? Хуучин танилын хувьд гэж Дамблдор хэлэв.

Слизнорт тээнэгэлзсэнээ,

- За яахав, балга болох л юм гэж таагүй хэлэв.

Дамблдор Харри руу инээмсэглээд Слизнортын саяхан хувирсан сандалтай адилхан галын дэргэдэх буйдан руу түлхэв. Харри суухдаа Дамблдор түүнээс ямар нэг юм хэрэгтэй байна гэсэн сэтгэгдэл төржээ. Тэгтэл Слизнорт графин болон аяга барьсаар ирээд ахин Харриг харснаа,

- Хмф. Үүнийг авна уу гээд өвдөхөөс айсан мэт харцаа буруулав.

Тэр Дамблдор аягатайг өгөөд Харрид гарт тавиураа сунгангаа буйдангийн дэрэн дээр лагхийн сууж эвгүйцсэн нам гүм болов. Түүний хөл богинохон болохоор шаланд хүрэхгүй байлаа.

- Чи ямаршуухан аж төрж байна даа, Гораций? гэж Дамблдор асуув.

- Тийм ч сайн биш. Цээжээр хатгуулаад амьсгааддаг болсон. Бас үе мөч хатгуулаад. Урьдных шигээ хөдөлж чадахаа больжээ. Настай хүн юу хийх вэ дээ. Би хөгширчээ. Ядарч байна.

- Чи түрүүн хуурамч зүйл зохион байгуулахдаа түргэн хөдөлсөн шүү. Бидний ирэхийг гурван хормын өмнө мэдсэн үү?

Слизнортын хоолойд уур бахархал нэгэн зэрэг сонсогдлоо.

- Хоёр. Би угаалгын өрөөнд байсан болохоор урилгагүй зочноос хамгаалсан шидийн анхааруулгыг сонссоогүй. Тэгсэн ч гэсэн баримт бол баримтаараа л үлдэнэ. Би хөгшин хүн, Альбус. Нам гүм тухтай амьдрахыг хүсч байгаа ядарсан хөгшин хүн.

«Тэр ч үнэхээр тэгсэн байна» гэж Харри бодоод өрөөг тойруулан харлаа. Энд бүгчим давчуу болохоор хангалттай тухтай гэж хэлж чадахгүй ч зөөлөн сандлын дор хөлийн тавиур тавилж, уух юм болон номнууд, шоколадтай чихэр, зөөлөн дэр байлаа. Хэрвээ Харри хэн энд амьдардагыг мэдээгүй байсан бол баян хөгшин хатагтай гэж төсөөлөх байлаа.

- Чи надаас залуу, Гораций гэж Дамблдор хэлэв.

- Чамд ч гэсэн тэгтгэвэрт гарах тухай бодох цаг болж гэж Слизнорт хэлснээ Дамблдорын гэмтсэн гар дээр харц тусав.

- Хариу үйлдэл чинь тийм ч хурдан биш болсныг харж байна.

- Чиний зөв гэж Дамблдор тайван хэлээд ханцуйгаа хойш нь сэгсэрч түлэгдэж харласан хуруугаа харлаа. Үүнийг хараад Харрийн нуруугаар шоргоолж гүйх шиг болов.

- Би эргэлзээгүй урьдынх шигээ хурдан биш болсон. Гэхдээ нөгөө гараараа бол ч ...

Тэр мөрөө хавчаад хөгширсөн гэж хэлэх мэт гараа дэлгэхэд Харри гэнэтхэн гарт нь урьд нь хэзээ ч харж байгаагүй бөгж байхыг харлаа. Том бүдүүлэг хийцтэй харваас алт бололтой бөгөөд голдоо том хар чулуун шигтгээтэй аж. Слизнортын харц мөн бөгжин дээр тусахад өргөн дух нь үрчийлээ.

- Ингэхэд энэ бүх гэнэтийн зочдоос болгоомжилсон урьдчилан сэргийлэх арга хэмжээгээрээ хэнээс ингэж нуугдаа вэ, Гораций ... Үхэл залгигчдаас уу надаас уу?

- Үхэл залгигчидад над шиг өрөвдөлтэй зовж зүдэрсэн хөгшин юуны учраас хэрэгтэй гэж? хэмээн Слизнорт шаардав.

- Би тэднийг чиний багагүй авъяасын чинь төлөө айлгаж тамлаж алах гэсэн байх гэж төсөөлж байна. Эсвэл тэд чамайг элсүүлэхгүй гэж хэлэх гээ юу?

Слизнорт Дамблдор руу уурсан харснаа,

- Би тэдэнд тийм боломж өгөхгүй. Би бүтэн жилийн турш зугтаж байна. Нэг газраа долоо хоногоос илүү тогтдоггүй. Маглуудын нэг гэрээс нөгөө рүү нь зугтаж байлаа ... Эндхийн эзэд амралтаа Канарын аралд өнгөрүүлэхээр явсан. Энд их таатай болохоор явахад харамсалтай байна. Тэгээд ч яаж хийхээ мэдэж байвал бүгд их амархан зүйл. Ганц энгийн Хөлдөөх шившлэг хулгайчаас сэргийлэх дохиоллыг ажиллагаагүй болгочихно гэв.

- Ухаалаг бодож шүү. Гэхдээ энэ чинь зовж зүдэрсэн хөгшин хүн тайван амьдралыг эрж байгаа юм шиг сонсогдож байна. Хэрвээ чи Хогвартст эргэн ирвэл ...

- Чи миний тайван амьдралд өөдгүй сургуулийнхаа тухай ярих гэж ирсэн бол цагаа дэмий үрж, Альбус! Би нуугдаж байхдаа Долорес Амбрижтай хэрхэн харьцсан тухай чинь цуу яриа сонссон! Хэрвээ чи бүх багш нартаа ингэж ханддаг бол ...

- Профессор Амбриж сүрэг хүн морьдтой мөргөлдсөн. Харин чамд Хориотой ойд хүн морьдыг бохир хагас цустангууд гэж нэрлэхгүй байх ухаан байгаа байх гэж бодож байна, Гораций.

- Тэгэхээр тэр тэгсэн юм биз дээ! Тэнэг амьтан! Тэр надад хэзээ ч таалагддаггүй байсан.

Харри тэсэлгүй инээд алдахад Дамблдор, Слизнорт хоёр зэрэг харлаа.

- Өршөөгөөрэй. Тэр надад ч гэсэн таалагддаггүй юм гэж Харри яаран хэлэв. Дамблдор гэнэтхэн босов.

- Явах гэж байна уу? хэмээн Слизнорт баярлав.

- Үгүй дээ, би боломжтой бол эндхийн жорлонг ашиглах гэсэн юм.

- Аан гэж сэтгэлээр унасан Слизнорт хэлээд,

- Хонгилын зүүн талаасаа хоёр дахь хаалга гэв.

Дамблдор өрөөнөөс гарлаа. Түүний ард хаалга хаагдахад нам гүм болов. Хоёр минутын дараа Слизнорт боссон ч юу хийхээ мэдэхгүй байгаа бололтой. Тэр Харри руу хяламхийн харснаа ханан зуух руу очиж ар нуруугаа ээлээ.

- Тэр чамайг яах гэж ийш нь авчирсныг мэдэхгүй юм.

Харри түүн рүү чимээгүй харав. Слизнортын усархаг нүд түүний сорвин дээр ахин тусав.

- Чи эцэгтэйгээ их төстэй юм.

- Тиймээ, надад хэлсэн.

- Зөвхөн нүд нь л биш. Нүд чинь ...

- Ээжийнх гээд Харри үргэлж энэ тухай сонсдог болохоор залхуутай санагдлаа.

- Хмф. Тиймээ байж. Багш нар болгонд хайртай сурагч байдгийн адил тэр ч гэсэн миний хайртай сурагч байсан. Чиний ээж гэж Слизнорт Харрийн асуунгуй харцны хариуд хэлээд,

- Лили Эванс. Их авъяаслаг. Хөгжилтэй. Дур булаам охин байсан юм. Түүнд манай тэнхимд суралцвал дээр гэж хэлснээ санаж байна. Тэр надад ямар бүдүүлэг хариу хэлсэн гээч ... гэв.

- Та ямар тэнхим хариуцдаг байсан юм?

- Би Слизерин тэнхимийн эрхлэгч гэж Слизнорт хэлснээ Харрийн нүүрний хувирлыг харж,



- Өө, намайг үүний төлөө буруутгах хэрэггүй. Чи ээж шигээ Гриффиндорынх биз дээ? Тиймээ энэ ихэнхидээ гэр бүлд тохиолддог юм. Үргэлж биш л дээ. Сириус Блэкийн тухай сонссон уу? Хоёр жилийн өмнө сонинд бичиж байсан болохоор сонссон чи байх. Тэр саяхан үхсэн ... гэв.

Үл үзэгдэх гар Харийн дотрыг мушгих шиг боллоо.

- Тэр танай эцэгтэй чинь сургуулийн дотно андууд байсан юм. Бүх Блэкчүүд миний тэнхимд байхад Сириус ганцаараа Гриффиндорт байсан! Харамсалтай байна тэр их авъяаслаг хүү байсан. Дараа нь би түүний дүү Регулусыг сургасан ч бүгдийг нь цуглуулахыг хүссэн л дээ.

Тэр дуудлага худалдаан дээр мөнгөөр зоддог цуглуулагч аятай урам зоригтой ярьж байлаа. Тэгснээ мартагдсан дурсамжаа санах гэсэн бололтой эсрэг талын хана руу ширтсэнээ нуруунаас нь халуу төөнөхөд нөгөө тийш эргэлээ.

- Чиний ээж маглуудаас гаралтай байсан. Би энэ тухай сонсоод ер итгээгүй. Тэр гялалзсан сурагч байсан болохоор цэвэр цусны шидтэн гэдэгт нь итгэлтэй байлаа.

- Миний хамгийн сайн найз маглуудын гэр бүлээс гаралтай хэдий ч бүгдээс илүү сурдаг.

- Заримдаа энэ тохиолддог юм. Хөгжилтэй байгаа биз, тийм үү? гэж Слизнорт хэллээ.

- Тийм ч их биш гэж Харри хүйтнээр хэлэв. Слизнорт түүн рүү гайхан харлаа.

- Чи намайг мухар сүжигтэй хүн гэж бодох хэрэггүй! Үгүй ээ, үгүй, үгүй! Би зөвхөн чиний ээжийг энэ бүх жилүүдэд миний хамгийн хайртай сурагч байсан гэж хэлээгүй! Бас Дирк Крессвелл түүнээс нэг насаар дүү байсан ... одоо альбингуудтай хамтран ажиллах хэлтсийн дарга болсон ... бас л маглуудын гэр бүлээс гаралтай хэр нь ер бусын авъяаслаг хүү байсан даа.

Одоо хүртэл надад Гринготс банкинд юу болж байгаа тухай мэдээлэл өгдөг юм!

Тэр хоёр ч удаа дээшээ үсэрснээ сэтгэл хангалуун инээмсэглэн шүүгээн дээрх гялалзсан жаазтай зургуудыг заахад тус бүрд нь жижигхэн дүрсүүд хөдөлж байлаа.

- Энэ зурган дээрх бүгд миний сурагч байсан. Энэ Варнава Каффаг анхаараарай «Өдөр тутмын зөнч» сонины ерөнхий эрхлэгч бөгөөд үргэлж сүүлийн үеийн мэдээний талаарх миний бодлыг сонирхдог юм. Харин энэ «Амтат ван»-гийн эзэн Амброзиус Флюм төрсөн өдөр болгоноор минь сагс дүүрэн амттан явуулдгийн учир нь би түүнийг анх ажилд авсан Цицерноном Харкисстай танилцуулсан юм! Харин арын эгнээнд чи Гвеног Жонсыг олж харна. Тэр

«Холихед Харпий» багийн ахмад алдартай хүн. Хүмүүс үргэлж намайг дуртай үедээ «Харпий» багийн тэмцээн үзэх үнэгүй билет авдагыг гайхдаг юм! гээд энэ бодол түүний сэтгэлийг хөгжөөв бололтой.

- Энэ бүх хүмүүс таньд янз бүрийн зүйл илгээхдээ хаанаас олохоо мэддэг хэрэг үү? гэж Харри асуугаад Үхэл залгигчид Слизнортод сагс дүүрэн амттан, квиддичийн

тасалбар, зөвөлгөө хүсэх болон бас бус зүйлс илгээж байхад яагаад мэддэггүй юм бол гэж гайхширлаа.

Слизнортын инээмсэглэл хананд цагцагдсан цус шиг түргэн алга болов.

- Мэдээж үгүй гэж Харри руу доош харж хэлээд,
- Би жилийн турш хэнтэй ч харьцаагүй гэв.

Харрид тэр хэлсэн үгэндээ өөрөө ч гайхах шиг сэтгэгдэл төржээ. Агшин зуур Слизнорт сэтгэлээр уналаа. Тэгснээ мөрөө хавчив.

- Юу гээч ... ухаалаг шидтэнгүүд толгойгоо алдахгүй байхыг хичээх үе ирж байна. Дамблдор намайг Хогвартс сургуульд багшаар орох уу гэж санал болгосноороо хувийн Фениксийн бүлгэмдээ элсүүлэх гэсэн байх! Бүлэгт гайхалтай зоригтой хүмүүс байдаг хэдий ч би хувьдаа тэдний үхлийн аюулд

...

- Хогвартст багшилахын тулд заавал бүлэгт элсэх албагүй гэж Харри хэлэхдээ шоолонгуй дуугарахгүй байхыг хичээлээ.

- Ихэнхи багш нар бүлэгт хамаардаггүй тэднийг хэн ч алдаггүй ... хэрвээ Квиррелийг эс тооцвол. Гэхдээ тэр Волан-де-Мортын талд ажиллаж байсан болохоор зүй ёсны шангаа хүртсэн.

Харри Слизнорт бусад шидтэнгүүдийн адил Волан-де-Мортын нэрийг тайван сонсож чадахгүй гэдэгт итгэлтэй байлаа. Тэгтэл ч үнэхээр Слизнорт цочин давхийхэд Харри тоосонгүй.

- Минийхээр бол Хогвартст Дамблдор байгаа болохоор бусад газраас аюулгүй.

Түүнийг Волан-де-Мортын айдаг цорын ганц шидтэн гэж ярьцгаадаг биз дээ?

гэж үргэлжлүүлэв.

Слизнорт хоосон газар ширтлээ. Тэр харваас Харрийн үгийн талаар тунгааж буй бололтой.

- Энэ үнэн л дээ. Хэцүү нэрт хэзээ ч Дамблдортой тулгарах гэж оролдож байгаагүй. Би Үхэл залгигчдтай нэгдэхгүй болохоор Хэцүү нэрт намайг найзуудынхаа тоонд тооцохгүй нь лавтай ... энэ тохиолдолд би Альбусд ойрхон байснаараа аюулгүй байдалд байх болно ... Амелий Боунсын үхэл намайг түгшээснийг нуух юун ... хэрвээ тэр яамны хэлхээ холбоогоо ашигласан бол хамгаалагдаж болох байсан ...

Энэ агшинд өрөөнд Дамблдор эргэн ирэв. Слизнорт түүний байгааг мартсан байсандаа давхийн цочлоо.

- Аан энэ чи юу, Альбус. Их удлаа шүү. Гэдэс чинь өвдөө юу?

- Үгүй дээ, би зөвхөн маглуудын сэтгүүл уншсан юм. За, Харри бид Горацийн зочломтгой занг ашиглан хангалттай удаан байлаа. Одоо явсан нь дээр байх.

Харри явахад бэлэн үсрэн бослоо. Слизнорт үл мэдэг сэтгэлээр унав.

- Явах гэж байна уу?
- Тиймээ явлаа. Би үргэлж ялагдлаа хүлээн зөвшөөрдөг байсан.
- Ялагдал гэнээ?

Слизнорт хирдхийн сандарлаа. Тэр суудал дээрээ хавчганан хуруугаа оролдонгоо Дамблдор хэрхэн дээлээ товчилж, Харри хүрэмнийхээ цахилгааныг татахыг харлаа.

- Ингэхэд чи бидэнтэй ажиллахыг хүсэхгүй байгаа чинь харамсалтай байна, Гораций гээд Дамблдор эрүүл гараараа салах ёс гүйцэтгэн даллав.

- Хогвартс чамайг эргэн ирвэл баяртай байх болно. Хэрвээ хүсвэл бидэн дээр зочилж ирээрэй ...

- Тийм ээ, тийм ... урьсанд баярлалаа ... би ...
- Баяртай!
- Баяртай гэж Харри хэлэв.

Тэднийг гудамжинд гарсан хойно ард нь хашгиралт сонсогдож,

- За сайн байна, сайн байна би зөвшөөрлөө! гэв.

Дамблдор эргэж харахад Слизнорт амьсгаадсаар зочны өрөөний хаалган дээр зогсож байв.

- Чи ажилдаа эргэж орохыг зөвшөөрч байна уу?
- Тийм ээ тийм. Би ухаан солирсон бололтой. Гэхдээ зөвшөөрч байна гэж тэвчээр алдан хэлэв.
- Гайхамшигтай! Тийм тохиолдолд, Гораций есөн сарын нэгэнд уулзацгаая гэж Дамблдор баясан хэллээ.
- Тиймээ удахгүй уулзая гэж Слизнорт буйтнав.

Тэднийг цэцэрлэгийн зам дээр гарах үед араас нь Горацийн хоолой,

- Би өндөр цалин хүсч байгаа шүү, Дамблдор! гэлээ.

Дамблдор инээд алдав. Тэдний ард цэцэрлэгийн хаалга хаагдахад харанхуй гудамжаар буцах замдаа эргэж орлоо.

- Сайн байна, Харри гэж Дамблдор хэлэв.
- Би юу ч хийгээгүй шүү дээ хэмээн Харри гайхлаа.
- Үгүй дээ, хийсэн. Чи Горацийд Хогвартст эргэн очих ямар таатай болохыг үзүүлсэн. Тэр чамд таалагдсан уу?
- Ээ ...

Харри Слизнорт таалагдсан эсэхийг өөрөө ч мэдэхгүй байлаа. Тэр аятайхан хэдий ч бардам бөгөөд маглуудын гэр бүлээс гаралтай охин сайн шидтэн болно гэдэгт хэтэрхий гайхширч байгаагаа хэлсэн.

Дамблдор Харрийн хариултыг хүлээсэнгүй.

- Гораций ая тухтай байдалд дуртай. Бас өөрийгөө алдартай, хүчирхэг, эрх мэдэлтэй хүмүүсээр хүрээлүүлэх дуртай. Тэд түүнийг сонсох нь таалагддаг юм. Тэр хэзээ ч хаан суух хүн биш ч ард нь суухыг эрхэмлэдэг юм. Хогвартст байх үедээ хайртай сурагчидаа хүсэл зорилго, дур булаах чадвар болон авъяасаар нь шилэн цуглуулдаг байсан. Гораций тэр ч байтугай хайртай сурагчдынхаа клубыг байгуулж өөрөө толгойлдог. Тэр тэднийг хэрэгтэй хүмүүстэй танилцуулан гишүүдийн хоорондох хэлхээ холбоог ашиглан өөрийнхөө хүнийг албинтай хамтран ажиллах хэлтсийн дэд гишүүнээр санал болгодог юм.

Харри гэнэтхэн ер бусын дүр зураг харав. Аварга том аалз нэхсэн торон дотуураа явж тарган шүүслэг ялаа руу ойртож байгаа.

- Би энэ бүгдийг чамайг Горацигийн эсрэг болгохын тулд яриагүй. Эсвэл бид одоо түүнийг профессор Слизнорт гэж дуудсан ч болох юм. Тэр эргэлзээгүй чамайг цуглуулгадаа багтаахыг хичээнэ, Харри. Чи түүний цуглуулгын хамгийн үнэт зүйл байх болно. Амьд үлдсэн хүү ... сонгогдсон гэж тэд одоо чамайг нэрлээд байгаа биз дээ.

Эдгээр үгсийг сонсоод Харрийн дотор хүйт даан ердөө хоёр долоо хоногийн өмнө сонссон үгээ саналаа.

«Нэг нь нөгөөгөө үхэх хүртэл тайван амьдрах боломжгүй». Дамблдор Слизнортынх хүрэх замд байсан сүмийн өмнө зогслоо.

- Эндээс цааш явж болохгүй. Миний гараас бариарай, Харри.

Харри энэ удаад шилжихэд урьдчилан бэлтгэсэн болохоор таагүй мэдрэмж төрсөнгүй. Тэр даралтан дор шилжин алга болоод ахин Дамблдорын хажууд зам дээр гарч ирэхэд урд нь дэлхий дээрх хамгийн дуртай хоёр дахь зүйл болох Үүрний тахир дүрс тодорлоо. Агшин зуур хүйтэн айдас алга болоод дотор нь бүлээн оргив. Тэнд Рон байгаа ... бас хатагтай Уизли. Харри түүнээс сайн хоол хийж чаддаг хүнийг мэдэхгүй юм байна ...

- Хэрвээ чи эсэргүүцэхгүй бол, Харри гэж Дамблдор хашааны хаалгаар орохдоо хэлээд,

- Чамтай орохын өмнө хэдэн үг солих гэсэн юм. Ийшээ орох уу? гэв.

Дамблдор Уизлийнхны шүүрээ хадгалдаг чулуун саравчны зүг заалаа. Харри гайхширсаар араас нь чохарсан хаалгаар орж ердийн саравчнаас арай багахан өрөөнд орлоо. Дамблдор савааныхаа үзүүрээс гэрэл асаагаад Харриг дээрээс нь инээмсэглэн ширтэв.

- Намайг энэ тухай дурьдсан явдалд уучлах байх гэж найдна. Гэхдээ би чамайг ид шидийн яаманд болсон үйл явдлын дараа биеэ хэр сайн авч явж байгааг хараад бахархах сэтгэл төрж байна. Сириус ч бас чамаар бахархах байсан гэж бодож байна.

Харри шүлсээ залгихад хоолой нь хөндүүрлэв. Тэр Сириусын тухай ярилцана гэж бодсонгүй. Вернон ах «Түүний загалмайлан эцэг нь үхсэн хэрэг үү?» гэж асуухад хичнээн хэцүү байсаны дээр Слизнорт түүнийг нэрийг дурьдахад улам дор байлаа.

- Чи Сириустэй удаан хамт байж чадаагүй нь харамсалтай. Хэрцгий тохиолдол та нарыг салгаагүй бол удтал аз жаргалтай байх байлаа.

Харри толгой дохиод Дамблдорын малгай дээр авирч буй аалз руу харлаа. Тэр Дамблдорын ойлгож байгааг мэдэрч байв. Магадгүй түүнээс захиа ирэхгүй болсныг тааварласан ч байж болох юм. Харри Дурслийнд өнгөрүүлсэн ихэнхи цагтаа орон дээр хоол ундгүй хэвтээд манантсан цонхоор хүйтэн хоосонг харахад үргэлж Дементорууд санагддаг байсан.

- Тэр надад ахин хэзээ ч захиа бичихгүй гэж бодоход хүнд байна гэж Харри аяархан хэлэв.

- Сириус чамд олон зүйлийг өгсөн болохоор чи гашуудаж байгаа байх гэж Дамблдор аяархан хэлэв.

- Гэхдээ би Дурслийнд байсан гэж Харри хатуу хэлээд,

- Би бүгдээс тусгаарлагдсаныг нь ойлгож байна ... Гэхдээ Сириус үүнийг хүсээгүй биз дээ? Хэтэрхий богино амьдрал ... Жишээлбэл Хатагтай Боунс юмуу Эмелина Вэнс нарыг аваад үз л дээ ... Дараагийнх нь би ч байх юмуу? Гэхдээ тэгэхэд хүрвэл гээд Дамблдорын савааны гэрэлд гялалзах цэнхэр нүд рүү уурсан хараад,

- Би өөртэйгээ аль болох олон Үхэл залгигчийг авч явахыг хичээнэ. Чадвал Волан-де-Мортыг ч гэсэн гэв.

- Чи жинхэнэ эцэг эхийн хүү болон, загалмайлан эцгийн хүү шиг ярьж байна! гээд Дамблдор Харрийн нуруун дээр дэмжин алгадаад,

- Малгайгаа өмс! Аалзнаас айхгүй байсан ч гэсэн өмс. Харин одоо өөр сэдэвт орьё, Харри ... Би чамайг сүүлчийн хоёр долоо хоногийн турш «Өдөр тутмын зөнч» сонин уншсан гэж ойлголоо гэв.

- Тиймээ гэж Харри хэлэхэд зүрх нь хүчтэй цохилон.

- Тийм нөхцөлд чи зөгнөлийн танхимд болсон адал явдалтай холбоотой мэдээллийг уншсан уу?

- Тиймээ. Одоо бүгд намайг мэдэх болсон болохоор ...

- Үгүй ээ, мэдэхгүй гэж Дамблдор түүний яриаг таслаад,

- Зөвхөн энэ дэлхий дээр хоёр хүн л Волан-де-Морт та хоёрт хамаатай бүтэн зөгнөлийг мэднэ. Тэгээд тэд хоёулаа энэ муухай үнэртэй аалзаар дүүрэн саравчинд зогсож байна. Гэхдээ олонхи хүмүүс Волан-де-Морт Үхэл залгигчдаа зөгнөл

авхуулахаар явуулсан гэдгийг зөв тааварласан. Цааш нь хэрвээ би алдаагүй бол чи энэ тухай хэнд ч хэлээгүй байх тийм үү? гэв.

- Үгүй.

- Энэ чинь ухаалаг шийдвэр байлаа. Гэхдээ би чамайг ноён Рональд Уизли болон хатагтай Грэйнджер хоёрт ярих ёстой гэж бодож байна. Тиймээ гэж Харрийн харцыг харж батлаад,

- Би тэднийг энэ тухай мэдэх ёстой гэж бодож байна. Чи тэднээс ийм чухал зүйлийг нууснаараа базаахгүй тус хүргэж байна гэв.

- Би хүсэхгүй ...

- Тэднийг айлгахаас эмээгээ юу? Эсвэл айж түгшсэн гэдгээ мэдэгдэхийг хүсээгүй юу? Харин чамд найзууд чинь хэрэгтэй, Харри. Сириус чамайг бүгдээс тусгаарлагдахыг хүсэхгүй байсан гэдгийг мэднэ.

Харри чимээгүй болов Дамблдорт хариулт шаардсангүй. Тэр цааш үргэлжлүүлэн,

- Бас үүнтэй төстэй өөр нэг зүйлийн тухай ярилцъя. Би энэ жил чамд ганцаарчилан хичээл орохыг хүсч байна.

- Ганцаарчилан хичээл орох гэнээ? хэмээн Харри баргар бодлоо мартан гайхлаа.

- Тиймээ. Би чиний боловсролд илүү идэвхтэй оролцох цаг болжээ.

- Та яагаад намайг сургаж байгаа юм, ноёнтоон?

- Ердөө л жаахан гэж тэр хайхрамжгүй дуугарав.

Харри амьсгаа даран хүлээсэн ч Дамблдор тодорхой зүйл хэлсэнгүйд сэтгэл түгшээсэн асуултаа тавилаа.

- Хэрвээ би таньтай хамт хичээлэх юм бол Снеггийн окклюменцийн хичээлд суух хэрэггүй болно гэсэн үг үү?

- Профессор Снег гээч, Харри ... үгүй, хэрэггүй.

- Сайн байна гэж Харри баярлаад,

- Учир нь бид ...

Тэр үнэн хэрэгтээ юу бодож байгаагаа хэлж чадсангүй.

- Би үүнд «бүтэлгүйтсэн» гэсэн үг зохино гэж бодож байна гээд Дамблдор толгой дохилоо.

Харри инээлээ.

- Тэгэхээр би одоо профессор Снегтэй бараг уулзахгүй боллоо. Хэрвээ шалгалтан дээр онц дүн аваагүй бол тэр надад уусмалын хичээл үргэлжлүүлэн заахгүй байх.

- Ууль ирэх хүртэл бүү яар гэж Дамблдор чухалчлан хэлээд,

- Ер нь бол би уулийн шууданг маргааш ирнэ гэж бодож байна. Харин одоо салахын өмнө ахин хоёр үг хэлэхэд, Харри. Нэгдүгээрт энэ мөчөөс эхлэн үл үзэгдэх цуваа өөртөө үргэлж авч яв. Хогвартсад байхдаа хүртэл. Чи миний хэлснийг ойлгов уу? гэлээ.

Харри толгой дохилоо.

- Одоо хамгийн сүүлчийн үг үлдлээ. Чамайг энд байхад ид шидийн яамнаас Үүрийг өндөр түвшинд хамгаалах болно. Энэ нь Артур, Молли хоёрт таагүй зүйл болно. Жишээлбэлт тэдний шууданг яамныхан шалгах гэх мэт. Гэхдээ тэд чиний аюулгүй байдлын төлөө эсэргүүцээгүй. Чи тэдэнд муу талархаж өөрийгөө энд байхдаа эрсдэлд оруулах юм бол.

- Би ойлгож байна гэж Харри түргэн хэлэв.

- Их сайн байна гээд Дамблдор саравчны үүдийг түлхэн гарлаа.

- Би гал зуухны өрөө гэрэлтэй байгааг харж байна. Алив Моллид чамайг хооллох боломж өгөхгүй бол бүр турчихаж.

## БҮЛЭГ 5: ХЭТЭРХИЙ ОЛОН ФЛЕГМИ

Харри, Дамблдор хоёр Үүрний үүд рүү очиход дэргэд нь Уизлийн хуучин гутал дүүрэн хийсэн танил зэвэнд идэгдсэн тогоо байлаа. Ойролцоох пинд унтаж буй тахиануудын аяархан гооглох сонсогдоно. Дамблдор гурван удаа үүд цохиход Харри цонхны цаана хөдөлгөөн гарахыг харлаа.

- Тэнд хэн байна? Нэрээ хэл! гэх хатагтай Уизлийн түгшүүртэй дуу сонсогдов.
- Дамблдор байна Харриг авчирлаа.

Хаалга шуудхан нээгдлээ. Үүдэн дээр хуучин ногоон халат өмссөн намхан булцгар хатагтай Уизли зогсож байв.

- Харри, хонгор минь! Бурхан минь, Альбус та намайг ямар их айлгав аа. Өглөө хүртэл хүлээх хэрэггүй гэж хэлээгүй билүү!

- Бидэнд аз таарсан юм гэж Дамблдор инээмсэглэн хэлээд Харриг урдуураа оруулав.

- Слизнортыг ятгахад миний бодож байсан шиг тийм хүнд байсангүй. Энэ гарцаагүй Харригийн гавъяа. Өө, сайн байна уу, Нимфадора!

Харри хатагтай Уизли гал зууханд ганцаараа биш болохыг харлаа. Цайвар царай саарал үстэй залуухан шидтэн ширээний цаана суугаад хоёр гараараа том сэнжтэй аяга барьжээ.

- Сайн байна уу, профессор. Сайн уу, Харри.
- Сайн уу, Тонкс!

Харрид тэр өвдсөн юм шиг ядрангүй санагдсаны дээр инээмсэглэл нь хүртэл зовж шаналсан шинжтэй байлаа. Түүний гаднах байдал үргэлж байдаг шигээ өнгөлөг тод ягаан өнгийн үстэй биш байлаа.

- Миний явах цаг боллоо. Цайгаар зочилсон явдалд баярлалаа, Молли гэж тэр түргэн хэлээд босч жанчаа өмслөө.

- Өршөөгөөрэй, надад санаа зовох хэрэггүй. Би энд үлдэхгүй. Руфус Скримжертэй яаралтай асуудлаар зөвлөлдөх хэрэгтэй байна гэж Дамблдор хэлэв.

- Үгүй ээ, үгүй би үнэхээр явах хэрэгтэй байна гэж Тонкс Дамблдорын нүд рүү харалгүй хэлээд,

- Тавтай нойрсоорой гэв.

- Хонгор минь чи бямба юм уу ням гаригийн нэгэнд оройн хоолонд ирээрэй.

Римус, Хурц нүдэт хоёр бас ирнэ ...

- Үгүй дээ, Молли чадахгүй нь ... Гэхдээ баярлалаа ... Бүгдэд тавтай нойрсохыг хүсье ...



Тонкс Харри, Дамблдор хоёрын дэргэдүүр яаран өнгөрч хашаанаас гарлаа. Тэр хаалганаас хэдэн алхам холдсоноо өсгий дээрээ эргээд агаарт уусан алга болов. Харри хатагтай Уизли сэтгэлээр унасан төрхтэй байхыг ажиглажээ.

- За Хогвартст уулзая, Харри. Биеэ бодож байгаарай. Молли чиний мэдэлд өглөө шүү гэж Дамблдор хэлэв.

Тэр хатагтай Уизлид бөхийн ёслоод хашаанаас гарч Тонксын адил газар алга боллоо. Хатагтай Уизли хаалгаа хаагаад Харрийн мөрнөөс барин гэрэлд ойртуулж хөлөөс нь толгой хүртэл анхааралтай харав.

- Чи яг Ронтой адил байна. Та хоёр хоёулаа Сунгадаг шидээр өсгөчихсөн юм шиг болж. Үнэнийг хэлэхэд Рон миний сүүлд сургуулийн шинэ жанч авч өгснөөс хойш дөрвөн инчээр өсөөд байгаа. Ингэхэд чи өлсөж байна уу, Харри?

- Тиймээ гээд Харри гэнэтхэн аймшигтай өлсөж байгаагаа мэдэрлээ.

- Суу хонгор минь, би чамд одоохон нэг юм хийгээд өгье.

Харри суухад өвдөг дээр нь няцарсан юм шиг нүүртэй сахлаг шаргал өнгийн муур үсрэн гарч ирээд ууртай хүржигнэв.

- Гермiona энд байгаа юм уу? гэж тэр баяртай хэлээд Живоглотын чихний арыг маажлаа.

- Тиймээ, уржигдар ирсэн.

Хатагтай Уизли шидэт саваагаараа хоолны том суулга тогшлоо. Суулга цахилгаан зуухан дээр хангинатал үсрэн гараад шуудхан буцалж эхлэв.

- Бид чамайг ирнэ гэж мэдээгүй болохоор бүгд унтацгаасан. Алив идээрэй.

Тэр ахин саваагаараа суулгыг тогшиход агаарт хөөрөөд Харрийн урд тонгойход хатагтай Уизли уур савсуулсан сонгинотой шөлний дор таваг амжиж тавилаа.

- Талх авах уу?

- Баярлалаа, хатагтай Уизли.

Тэр саваагаа мөрөн дээгүүрээ даллахад талх хутганы хамтаар ширээн дээр үсрэн гарч ирээд өөрөө зүсэгдэхэд, шөлтэй хоолны сав цахилгаан зуух руугаа буцав. Хатагтай Уизли ширээний эсрэг талд Харрийн урдаас харан суув.

- Тэгэхээр чи Гораций Слизнортыг ажилд нь эргүүлж оруулахаар ятгасан хэрэг үү?

Харри амаараа дүүрэн халуун шөлтэй байсан болохоор үг хэлж чадсангүй толгой дохив.

- Слизнорт Артур бид хоёрын багш байсан. Тэр Хогвартст бараг зуун жилийн өмнөөс багшилсан. Дамблдортой ойролцоо үед эхэлсэн байх. Тэр тэгээд чамд таалагдав уу?

Одоо Харри амаараа дүүрэн талх чихсэн байлаа. Тэр толгойгоо сэгсрэхээс зайлсхийхийн тулд мөрөө хавчлаа.

- Би чиний юу хэлэх гэснийг ойлгож байна. Тэр тааламжтай байж чаддаг хэдий ч Артур үргэлж түүнд дургүй байсан. Ид шидийн яаманд алхам бүр түүний хайртай сурагчид байгаа. Слизнорт хүмүүсийг дэмжихдээ гаргууд ч Артурт цагаа үрэлгүй өндөр нисэж чадахгүй шувуу гэж бодсон байх. Түүнийг алдсан гэж бодож байна. Рон чамд бичсэн эсэхийг мэдэхгүй ч ... саяхан Артур тушаал дэвшсэн!

Хатагтай Уизли эхнээсээ л үүнийг хэлэх гэж тэсч ядаж байсан нь тодорхой болов. Харри халуун шөл залгиад хоолой нь хэрхэн зурагдан түлэгдэхийг мэдэрлээ.

- Ямар сайхан юм бэ! гэж дуу алдав.

- Баярлалаа чамд, хонгор минь гэж хатагтай Уизли баясан хэлээд Харрийн нүдэнд нулимс цийлэгнэсэн явдлыг шинэ мэдээнд баярласан хэрэг гэж бодов бололтой.

- Тиймээ, Руфус Скримжер сүүлийн үед хэд хэдэн шинэ хэлтэс зохион байгуулж, Артурыг Хуурамч хамгаалалтын шившлэг болон эд зүйлсийг илрүүлж хураан авах хэлтсийн даргаар томилсон. Энэ их хариуцлагатай ажил болохоор одоо түүний дор арван хүн ажиллаж байгаа!

- Яадаг гэнээ? ...

- Одоо бүгд Хэцүү нэртээс болж сандралд ороод байгаа учир Хэцүү нэрт болон Үхэл залгигчидаас хамгаалах эд зүйлсийн худалдаа хаа сайгүй дэлгэрээд байгаа. Чи төсөөлөөд үздээ ... хамгаалагч уусмал гэдэг нь бубонтюберийн идээ нэмсэн шүүс, хамгаалалтын шившлэгийг нь хэрэглээд чих унаж ч магадгүй ... Үүгээр Наземникус Флетчер мэтийн цэвэр хөдөлмөрөөр амьдарч дадаагүй хүмүүс бүгдийн үймээн сандралыг ашиглан элдвийн зүйлс зарж байна. Заримдаа бүр ч таагүй зүйлс байдаг юм. Артур нэг удаа Үхэл залгигч л хийснээс гарцаагүй хайрцаг хараал идсэн вредноскоп хураан авсан шүү. Ямар чухал ажил болохыг нь харж байгаа биз дээ. Би түүнд үргэлж цахилгааны залгуур, талх шарагч зэрэг маглуудын дэмий зүйлсээ орхи гэж хэлдэг юм гээд хатагтай Уизли Харри л цахилгааны залгуур санал болгосон аятай ширүүн харлаа.

- Ноён Уизли ажлаасаа эргэж ирээгүй байгаа юм уу?

- Тиймээ, ирээгүй байна. Үнэнийг хэлэхэд тэр жаахан саатсан ... Гэртээ шөнө дундын үед ирнэ гэсэн ...

Тэд хоёул ширээний төгсгөл дэх цагаан хэрэглэлийн сагсан дээрх том цаг руу харлаа. Харри тус бүр дээрээ Уизлийн гэр бүлийн гишүүдийн нэрийг бичсэн есөн зүүтэй цагийг шууд танилаа. Одоо бүх зүү «үхлийн аюул» гэсэн үгийг зааж байв.

- Энэ ч түүний хувьд Хэцүү нэртийг эргэн ирснээс хойш дасал болсон зүйл дээ.

Одоо зөвхөн бид ч биш бүгд үхлийн аюулд байгаа ... Үнэндээ бидний танил

хүмүүст ийм цаг байхгүй гэдэгт итгэж чадахгүй нь. Гэхдээ хэн нэгэнд ийм цаг байгаа эсэхийг би мэдэхгүй. Өө!

Тэр гэнэтхэн уулга алдаад цагны нүүр рүү заав. Ноён Уизлийн зүү замд гэсэн үгийг зааж байв.

- Тэр ирж байна!

Тэгтэл ч дараагийн агшинд хэн нэгэн хаалга цохив. Хатагтай Уизли үсрэн босоод бариулаас барин аяархан дуугаар,

- Артур энэ чи юу? гэж асуулаа.

- Тиймээ гэх ноён Уизлийн ядрангуй хоолой сонсогдов. Гэхдээ миний оронд Үхэл залгигч ч байж магадгүй, хонгор минь. Асуултаа асуу!

- Өө, үнэндээ ...

- Молли!

- За яахав, за яахав ... чиний мөрөөдөл юу билээ?

- Онгоц агаарт яагаад унадаггүй нисдэгийг мэдэх.

Хатагтай Уизли толгой дохиод хаалганы бариулыг эргүүлсэн ч ноён Уизли нөгөө талаас нь онгойлгохгүйн тулд чанга барилаа.

- Молли! Би эхлээд чамд асуулт тавих ёстой!

- Артур, үнэнийг хэлэхэд энэ чинь тэнэг хэрэг ...

- Би чамтай хоёулхнаа үлдэх үедээ юу гэж дууддаг вэ?

Дэнлүүний бүдэг гэрэлд хатагтай Уизлийн царай час улайлаа. Харри гэнэтхэн чих нь халуу оргихыг мэдрээд яаран шөл халбагадахдаа аль болох чанга чимээ гаргахыг хичээв.

- Моллипушенька гэж хатагтай Уизли хаалганы завсраар шивнэв.

- Зүйтэй. Одоо намайг оруулж болно.

Хатагтай Уизли хаалга нээлээ. Үүдэн дээр өндөр туранхай, орой хэсгээрээ халцарсан шаргал үс, эвэр хүрээтэй нүдний шил бүхий түүний нөхөр тоосонд дарагдсан урт жанчтай зогсож байв.

- Бид яагаад чамайг ирэх болгонд энэ тэнэг зүйлийг үргэлж давтаж байх ёстойг ойлгохгүй байна гэж царай нь ягаарсан хатагтай Уизли нөхрийнхөө жанчыг тайлахад туслан хэллээ. Хэрвээ энэ ямар нэг зүсээ хувиргасан Үхэл залгигч байсан бол тэр асуулт асуухаас чинь өмнө хүч хэрэглэх байсан!

- Би мэднэ, хонгор минь гэвч яамны журмын дагуу үлгэр үзүүлэх ёстой юм.

Ямар сайхан үнэртэж байна! Сонгинотой шөл үү? гээд ноён Уизли ширээ рүү найдангуй эргэснээ,

- Харри! Бид чамайг өглөө ирнэ гэж хүлээж байлаа! гэв.

Тэд гар барилцаад ноён Уизли Харрийн дэргэд суув. Хатагтай Уизли түүний өмнө дүүрэн шөлтэй таваг тавилаа.

- Баярлалаа, Молли. Хүнд шөнө байлаа. Ямар нэг тэнэг нь хувиргадаг медаль зарчихжээ. Түүнийг хүзүүндээ зүүсэн хүн гадна төрхөө хүссэнээрээ хувиргах боломжтой. Зуун мянган зүсээ хувиргалт ердөө арван галлеон!

- Хэрвээ түүнийг зүүх юм бол үнэн хэрэгтээ юу болох юм?

- Эхлээд чиний бие эвгүй шаргал өнгөтэй болж хувирна. Хоёр ч хүний биенээс тэмтрүүл шиг зүйл ургасан. Гэгээн Мунгогийн эмнэлэг үүнтэй үүнгүй хангалттай завгүй байгаа!

- Энэ ч Фред, Жорж хоёрын бодож олсон зүйл шиг сонсогдож байна шүү. Чи итгэлтэй байна уу ...? гэж хатагтай Уизли тээнэгэлзэн хэллээ.

- Мэдээж, би итгэлтэй байна! Хөвгүүд хүмүүсийг хамгаалах арга хайн цөхөрч байхад үүгээр нь далимдуулан тоглож болохгүй!

- Тэгэхээр чи хувиргадаг медалаас болж саатсан хэрэг үү?

- Үгүй, бид өнөөдөр Элефант-энд-Каслд эвгүй шившлэгтэй таарсан. Гэхдээ аз болоход ид шидийн хуулийг хүчээр хэрэгжүүлэх хэлтсийнхэн цагаа олж ирээд ...

Харри суниан эвшээлээ.

- Ор луугаа! Би чамд Фред, Жорж хоёрын өрөөг бэлтгэсэн гэж үүнийг ажигласан хатагтай Уизли даруйхан хэлэв.

- Тэд хаана байгаа юм бэ?

- Тэд одоо Тахир гудамжинд шидэт тоглоомын дэлгүүрийнхээ ажлаар оролдоод завгүй байгаа. Хэдийгээр би эхэндээ энэ дэлгүүрийн санааг дэмжээгүй ч гэсэн тэдний бизнест авъяастай болохыг нь хүлээн зөвшөөрч байна! Явъя хонгор минь, чиний чемодан дээр байгаа.

- Тавтай нойрсоорой, ноён Уизли гээд Харри сандлаа түлхэн бослоо. Живоглот аяархан дуугараад өвдөг дээрээс нь үсрэн бууж өрөөнөөс гарлаа.

- Тавтай нойрсоорой, Харри гэж ноён Уизли хэлэв.

Харри гал зуухнаас гарахдаа хатагтай Уизлийн харц цагаан эдлэлийн сагсан дээрх цаган дээр тусахыг ажиглав. Бүх зүү ахин үхлийн аюул гэсэн үгийг зааж байлаа.

Фред, Жорж хоёрын унтлагын өрөө хоёр давхарт байлаа. Хатагтай Уизли шидэт саваагаа даллан орны хажуугийн шүүгээн дээрх дэнлүүг асаахад өрөөнд дулаахан алтлаг гэрэл тусав. Цонхны нүүрэн талын бичгийн ширээн дээрх том ваартай цэцэгнээс анхилам үнэр ханхлах нь Харрид даринь үнэрийг санагдуулав. Өрөөний ихэнхи хэсэгт хатуу цаасан хайрцагтай янз бүрийн зүйлс байв. Дэргэд нь Харрийн чемоданыг тавьжээ. Харваас энэ өрөөг агуулах маягаар ашиглаж байсан бололтой.

Хэдвиг Харрийн ирэхийг хараад том шүүгээний орой дээрээс баяртай гууглаад дараа нь цонхоор нисэж одоход Харри анд гарахын өмнө хүлээж байсан болохыг нь ойлгов. Тэр хатагтай Уизлид тавтай нойрсохыг хүсээд унтлагын хувцсаа өмсөж хоёр орны нэгд нь шургалав. Тэгтэл дэрний уутан дотор ямар нэг хатуу юм мэдрэгдэхэд

гараа шургуулан наалдамхай улаан шаргал өнгийн зүйл гаргаж ирээд Бөөлжүүлдэг чихэр болохыг нь танилаа. Тэр инээмсэглээд нөгөө хажуугаараа эргэн агшин зуур унтлаа.

Түүнд ердөө хэдхэн хором өнгөрөх шиг санагдсан хэдий ч хаалга үхэр буугаар буудах адил чанга тасхийн нээгдэхэд сэрэв. Харри өндийн суугаад цонхны хөшиг харжигнатал нээгдэхийг сонсож хурц нарны гэрэлд гялбан нүдээ анилаа. Тэр алгаараа нүүрээ дараад нүдний шилээ эрэн тэмтчив.

- Юу болоо вэ?

- Харин бид чиний энд байхыг мэдсэнгүй! гэх чанга хөгжилтэй дуу гараад хэн нэгэн шилэн хүзүү рүү нь хүчтэй цохив.

- Рон, түүнийг битгий цохь! гэх зэмлэнгүй хоолой гарлаа.

Харри эцэст нь нүдний шилээ олж зүүсэн ч нүд гялбам хурц гэрэлд юу ч харж чадсангүй. Түүний урд урт сүүдэр сүүмэлзэхэд нүдээ анивчаад харвал Рон Уизли нүүр дүүрэн инээмсэглэн зогсож байв.

- Амьдрал ямар байна?

- Хэзээ ч үүнээс ч сайн байсангүй! гээд Харри шилэн хүзүүгээ үрэн дэрэн дээрээ хэвтлээ.

- Харин чи хэр байв даа?

- Муугүй шүү гээд Рон цаасан хайрцаг дээр суулаа. Чи хэзээ ирсэн бэ? Ээж дөнгөж сая бидэнд хэллээ!

- Шөнийн нэг цагт.

- Маглуудтай хэр байв даа? Чамтай сайн харьцаж байсан уу?

- Үргэлжид байдаг шигээ гэж Харри хэлэхэд Гермiona орны ирмэг дээр суулаа.

- Тэд надтай бараг ярьдаггүй. Гэхдээ энэ нь надад дээр байдаг. Харин чи хэр байв даа, Гермiona?

- Сайн гээд Гермiona Харрийг өвчтөн аятай шинжин харлаа.

Харри энэ юу болохыг тааварлаад одоо юунаас ч илүү Сириусын үхлийн тухай юм уу өөр золгүй явдлын тухай ярихыг хүссэнгүй тул,

- Цаг хэд болж байна? Би өглөөний цайг алгасчихсан уу? гэв.

- Санаа зовох хэрэггүй дээ, ээж чамд тавиуртай нь авчраад өгнө. Тэр чамайг сайнгүй харагдаж байгаа гэж бодож байгаа юм гээд Рон тургилан нүдээ эргэлдүүлснээ,

- За юу болсныг яриад байгаарай? гэлээ.

- Юу ч болоогүй. Та нар намайг нагац ах, эгчийндээ байсан гэдгийг мэднэ биз дээ.

- За боль доо! Дамблдор та хоёр хаана байсан юм!

- Ямар ч сонирхолтой зүйл болоогүй. Дамблдор зүгээр л урьд нь байсан багшийг ажилд нь ахин авахад туслахыг хүссэн. Түүний нэрийг Гораций Слизнорт гэдэг.

- Аан. Харин бид бодохдоо ... гэж Рон урам хугаран хэлэв. Гермiona түүн рүү анхааруулан харахад түргэн засаж,

- ... бид ч бас тэгж бодсон гэв.

- Тийм гэж үү? хэмээн Харри инээвхийлэв.

- Аанхан. Одоо Амбриж явсан болохоор сургуульд гарцаагүй хар урлагаас хамгаалах хичээлийн багш хэрэг болсон байж таарна? Ингэхэд тэр ямаршуу юм дээ?

- Далайн морьтой жаахан төстэй урьд нь Слизерин тэнхимийн эрхлэгч байсан гээд Харри,

- Гермiona яасан бэ? гэлээ.

Тэр түүн рүү дурын агшинд ойлгомжгүй шинж тэмдэг илрэх юм шиг харж байснаа яаран инээмсэглэхийг оролдов.

- Яагаа ч үгүй! М-м энэ Слизнорт чинийхээр бол сайн багш байна уу?

- Мэдэхгүй. Магадгүй Амбрижаас дор байж магадгүй. Та нар юу гэж бодож байна?

- Би хэн Амбрижаас дор болохыг мэдэх юм байна гэх хоолой үүдний зүгээс гаран Роны бага дүү өрөөнд унтууцсан төрхтэй орж ирлээ.

- Сайн уу, Харри.

- Чи яагаа вэ? гэж Рон асуув.

- Түүнээс л болж байхгүй юу. Тэр намайг галзууруулах нь байна гэж Жинни бувтнаад Харрийн орны хөлд суув.

- Тэр яасан юм? гэж Гермiona өрөвдөнгүй асуув.

- Түүнийг надтай гурван настай хүүхдийн адил ... ярьж байгааг сонсож чадахгүй нь!

- Би чамайг ойлгож байна гэснээ Гермiona дуугаа намсган,

- Тэр зөвхөн өөрийгөө боддог гэлээ.

Харри Гермiona хатагтай Уизлийн тухай тэгж ярьсанд ихэд гайхширан Роныг дэмжихэд бэлтгэтэл тэр ууртайгаар,

- Сонсож бай, та хоёр түүнийг таван секунд ч болтугай тайван орхиж болохгүй юу! гэлээ.

- Тиймээ тийм зүйтэй, түүнийгээ хамгаалж байх шив. Бүгдэд чиний түүнд яаж ханддаг чинь ойлгомжтой гэж Жинни уцаарлав.

Тийм тайлбар Роны эхтэйгээ харьцах харьцаанд хачирхалтай сонсогдлоо. Харри ямар нэг зүйл мэдсэнгүй өнгөрсөн болохоо ойлгов.

- Та нар хэний тухай ...

Гэвч тэр асуултаа дуусгаж амжсангүй. Унтлагын өрөөний хаалга ахин нээгдэхэд Харри өөрийн мэдэлгүй хөнжлөө эрүү рүүгээ татсанд Гермиона, Жинни хоёр шалан дээр уналаа.

Хаалган дээр залуухан итгэмээргүй хөөрхөн охин зогсож байлаа. Өндөр гоолиг биетэй бөгөөд урт цайвар үс нь мөнгөлөгөөр туяарах аж. Энэ хачирхалтай үзэгдэл гартаа дүүрэн өглөөний цай дүүрэн овоолсон тавиур барьсан байв.

- ‘Арри, бид удаан уулзсангүй шүү! гэж тэр дуу алдав.

Түүнийг босгон дээрээс ирэхэд хатагтай Уизли араас нь ууртай цухуйв.

- Тавиур зөөх хэрэггүй байсан юм. Би өөрөө түүнийг авчирч дөнгөнө!

- Надад энэ ерөөсөө хэцүү биш гээд Флер Делакур тавиураа Харрийн өвдөг дээр тавьж бөхийн хоёр хацар дээр нь үнслээ. Тэр уруул хүрсэн газар халуу оргихыг мэдрэв.

- Би түүнийг ахин харахыг ямар их хүсч байв аа! Чи миний дүү Габ’гиэлийг санаж байна уу? Тэр эцэс төгсгөлгүй ‘Арри Поттерийн тухай ярьдаг юм. Тэр чамайг ахин харахдаа баяртай байх болно.

- Аа ... тэр ч гэсэн энд байгаа юм уу? гэж Харри сөөнгөтөв.

- Үгүй, үгүй тэнэг хүү минь! гээд Флер цангинатал инээд алдлаа. Чи ирэх зун биднийг ... мэдээгүй хэрэг үү?

Түүний цэнхэр нүд томорсноо хатагтай Уизли руу зэмлэнгүй хартал,

- Бид түүнд хэлж амжаагүй байгаа гэлээ.

Флер мөнгөлөг үсээрээ хатагтай Уизлийн нүүрийг шавхуурдан эргэв.

- Билл бид хоёр гэрлэхээр шийдсэн!

- Өө гэж Харри мэгдэн хэлээд хатагтай Уизли, Гермиона, Жинни нар харцаа буруулахыг ажиглахгүй байж чадсангүй.

- Хөөх. Э-э ... баяр хүргэх хэрэгтэй байх! Тэр түүн рүү бөхийгөөд ахин үнсэв.

- Билл одоо ажил ихтэй байгаа болохоор завгүй байгаа. Харин би Гринготтс банкинд англи хэлээ сайжруулахаар хагас цагаар ажиллаж байсан юм. Иймээс тэр намайг хэдэн өдрийн өмнө эцэг эхтэйгээ танилцуулахаар явуулсан. Чамайг ирнэ гэдгийг мэдээд таатай байсан шүү. Энд зөвхөн гал зуух болон тахианаас өөр хийх зүйл юу ч байхгүй! За ... сайхан хооллоорой ‘Арри!

Ингэж хэлснийхээ дараа тэрбээр өрөөнөөс гунхалзан гарч хаалга аяархан хаалаа.

Хатагтай Уизли ямар нэг «Түй!» гэсэнтэй ойролцоо учир нь ойлгогдохгүй чимээ гаргалаа.

- Ээж түүнийг үзэн яддаг юм гэж Жинни аяархан хэлэв.

- Үзэн яддаг гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж хатагтай Уизли ууртай шивнэн эсэргүүцээд,

- Би зөвхөн тэднийг сүй тавихаар хэтэрхий яарч байна гэж бодож байна, тэгээд л тэр! гэв.

- Тэд бараг жилийн өмнө танилцсан гэж хаалга руу гөлөрч байсан Рон хэлэв.

- Жил гэдэг чинь тийм ч урт биш! Би юу болсныг ойлгож байна. Хэцүү нэрт эргэн ирсэн учраас хүмүүс маргааш хүртэл амьд байхаа мэдэхгүй жирийн амьдралдаа бол арав дахин бодох зүйлийг хэтэрхий яаран шийдвэр гаргаж байна. Энэ түүнийг сүүлд ноёрхож байх үед залуу хүмүүс гэрээсээ зугтан гарч эцэг эхийнхээ зөвшөөрөлгүй гэрлэж байсантай адилхан ...

- Жишээлбэл аав та хоёр шиг үү гэж Жинни егөөдөнгүй хэлэв.

- Аав бид хоёрын чинь хувьд өөр хэрэг. Бид нэг нэгийгээ сайн мэдэх болохоор хүлээх хэрэг байгаагүй. Харин Билл, Флер хоёрын хувьд ... Тэдэнд ойролцоо зүйл юу байгаа юм? Билл бол жирийн ажилсаг залуу харин тэр ...

- Үнээ гээд Жинни толгой дохисноо,

- Ер нь бол Билл жирийн залуу биш. Тэр шившлэг цуцлагчаар ажилд орохдоо адал явдалд дурлаж орсон ... гарцаагүй энэ л Флегми рүү түлхсэн байх гэв.

Харри, Гермiona хоёр инээлдэхэд хатагтай Уизли охиндоо хандан ширүүнээр,

- Түүнийг тэгж нэрлэхээ больж үз, Жинни гэснээ, За би явсан нь дээр бололтой.

Жаврайгаа хөрөхөөс нь өмнө идээрэй, Харри гэлээ.

Тэр халамжлангуй байртай өрөөнөөс гарч явлаа. Рон мэлэрсэн чигээр байснаа уснаас гарсан нохой аятай толгойгоо болгоомжтой сэгсрэв.

- Чи түүнтэй нэг гэрт хамт амьдарч байгаадаа дасаагүй байгаа юмуу? гэж Харри асуулаа.

- Дасч байна. Гэхдээ түүнийг гэнэтхэн чам руу үсэрч ирэхэд нь ...

- Өрөвдөлтэй амьтан гэж Гермiona ууртай хэлээд Ронoос холдон гараа энгэртээ зөрүүллээ.

- Чи түүнийг үргэлж энд торохыг хүсэхгүй байгаа биз дээ? гэж Жинни гайхан асуулаа. Рон хариуд нь мөрөө хавчив. Зүгээр дээ, ээж энэ бүхнийг болиулахын тулд хүч хүрэх бүх зүйлээ хийж байгаа.

- Тэр юу хийж байгаа юм? гэж Харри асуув.

- Тэр эцэс төгсгөлгүй Тонксыг оройн хоолонд урьж байгаа. Минийхээр бол Биллийг Тонкст дурлана гэж найдаад байх шиг ... Би ч гэсэн тэгж найдаж байна. Тонкс хамаагүй дээр.

- Үгүй ер, энэ ч бүтэх байх даа гэж Рон даажигнан хэлээд,



- Сонсоцгоо нэг ч хэвийн залуу Тонксыг Флерийн дэргэд байхад нь олж харахгүй. Тэгээд ч Тонкст хамар болон үсээ тэнэг хувиргахаас ондоо юу ч байхгүй ... гэлээ.

- Тэр хараал идсэн Флегмигээс зуу дахин дээр! гэж Жинни хэлэв.

- Бас мракоборец болохоор ухаантай! гэж Гермиона булангаас дэмжив.

- Флер ч гэсэн тэнэг биш болохоор Гурван шидтэний тэмцээнд оролцсон гэж

Харри хэллээ.

- Чи ч гэсэн оролцсон биз дээ! гэж Гермиона гашуунаар дуу алдав.

- Магадгүй түүнд Флегмигийн 'Арри гэж хэлэх нь таалагдаж байгаа байх л даа? гэж Жинни зэвүүцэнгүй асуув.

- Үгүй гээд Харри ам нээсэндээ харамслаа. Би зүгээр л Флегмигийн тухай ярьсан юм ... Түй, Флер гэх гэсэн юм л даа ...

- Минийхээр бол Тонкс хамаагүй илүү гэж Жинни хатуу батлаад,

- Ямар ч гэсэн түүнтэй байхад хөгжилтэй гэв.

- Тэр сүүлийн үед хөгжилтэй биш байгаа. Түүн рүү харах болгонд Уйланхай

Миртлтэй төстэй санагдах юм гэж Рон хэллээ.

- Энэ чинь шударга биш шүү дээ! гэж Гермиона уурсаад,

- Тэр болсон явдлаас хойш сэхээ орж чадахгүй байгаа ... Та нар ойлгож байгаа биз дээ ... Тэр түүний үеэл ах байсан шүү дээ! гэв.

Харрийн зүрх ёгхийлээ. Тэд ахиад л Сириусын тухай ярьж байна. Тэр сэрээгээ авч амандаа жаврай чихэхдээ энэ нь ярианд оролцохоос зайлсхийхэд тулсана байх гэж найдав.

- Тонкс, Сириус хоёр бие биеийгээ бараг мэдэхгүй. Сириус амьдралынхаа ихэнхийг Азкабанд сууж өнгөрүүлсэн болохоор тэдний гэр бүлтэй нэг их уулзаж байгаагүй гэж Рон хэлэв.

- Энэ чухал биш. Тонкс түүний үхэлд буруутай гэдэгтээ итгэлтэй байгаа юм! гэж Гермиона хэллээ.

- Яагаад тэр вэ? гэж Харри тэссэнгүй асуув.

- Тэр л Беллатриса Лестрейнжтэй үзэлцэж байсан биз дээ? Магадгүй Тонкс Беллатрисаг дуусгасан бол Сириусыг алахгүй байсан гэж бодсон байх.

- Тэнэг юм гэж Рон бувтналаа.

- Ер нь бол амьд үлдэгсэд үргэлж гэм буруу мэдэрдэг юм. Би Люпин түүнтэй ярилцахаар оролдохыг харсан. Түүний зүсээ хувиргах явдалд ч асуудал гарч эхэлсэн!

- Яасан гэнээ?

- Тэр гаднах төрхөө хувиргаж чадахгүй байгаа. Шидийн хүчинд нь сэтгэл санааны байдал нөлөөлсөн бололтой гэж Гермиона тайлбарлав.
- Би тийм зүйл байдаг гэж мэдсэнгүй хэмээн Харри хэлэв.
- Би ч гэсэн мэдээгүй. Магадгүй хүчтэй сэтгэлийн хямралд ороод ... Хаалга ахин онгойж хатагтай Уизли толгойгоо өрөө лүү шургуулаад,
- Жинни доошоо бугаад надад үдийн хоол бэлтгэхэд тусал гэж шивнэлээ.
- Би хүүхдүүдтэй ярьж байна! гэж Жинни дургүйцэв.
- Яг одоо! гэж хэлээд хатагтай Уизли алга боллоо.
- Тэр зүгээр л Флегмитэй ганцаар үлдэхийг хүсэхгүй байгаа юм! гэж Жинни уурсан хэлээд шаргал үсээ Флертэй тун адилханаар хаяж гараа дээш нь бүжгийн жүжигчин аятай өргөснөө,
- Та нар ч гэсэн түргэн бууж ирээрэй гээд гарч одлоо.

Харри нам гүм болсныг ашиглан өглөөний хоолоо идлээ. Гермиона өрөөний дундуур холхиж Фред, Жорж хоёрын хайрцагыг харах зуураа үе үе Харри руу хяламхийн харж байлаа. Рон Харрийн шарсан талхнаас авч идэнгээ хаалга руу мөрөөдөнгүй ширтэв.

- Энэ чинь одоо юу вэ? гээд Гермиона гэнэтхэн жижигхэн дуран авайтай адил зүйл авлаа.
- Мэдэхгүй. Гэхдээ Фред, Жорж хоёрын бэлэн болоогүй зүйл байсан бол чи болгоомжтой байсан нь дээр гэж Рон бувтнав.
- Ээж чинь тэдний худалдаа сайн байгаа гэсэн. Фред, Жорж хоёрыг бизнесийн авьяастай гэсэн шүү.
- Багаар хэлж. Тэд галлеоныг хүүдий хүүдийгээр олж байгаа! Дэлгүүрийг нь Тахир гудамжинд очиж харахыг ямар их хүсч байна гээч! Ээж хэлэхдээ аавын нэмэлт хамгаалалтгүйгээр очиж болохгүй гэсэн. Гэхдээ тэр үргэлж завгүй ажил дээрээ байдаг болохоор.
- Персигээс сурагтай юу? Тэр гэр бүлийнхэнтэйгээ харьцахгүй байгаа хэвээр юм уу? гэж Харри асуулаа.
- Тийм гэж Рон хэлэв.
- Гэхдээ тэр эцэг эхийн чинь Волан-де-Морт эргэн ирэлтийн талаарх яриа зөв байсныг мэдэж байгаа биз дээ ...
- Дамблдор хүмүүс бие биенийхээ бурууг зөвөөс хялбархан өршөөдөг гэж хэлсэн. Би түүний ээжтэй чинь ярьж байхыг сонссон гэж Гермиона хэлэв.
- Тэр энэ жил надад ганцаарчилан хичээл заана гэсэн гэж Харри хэллээ. Рон шарсан талхандаа хахаж харин Гермиона дуу алдав.
- Тэгээд чи яагаад дуугүй байсан юм! гэж Рон гайхлаа.

- Би сая л саналаа. Тэр өчигдөр орой танай шүүр хадгалдаг саравчинд байхад хэлсэн гэж Харри үнэнээ хэлэв.

- Чөтгөр гэж! Дамблдорoor ганцаарчилан хичээл заалгана! Сонирхолтой юм, тэр яагаад ... гэж гайхаж биширсэн Рон хэлэв.

Рон гэнэтхэн чимээгүй боллоо. Харри түүний Гермионатай харц солилцохыг ажиглалаа. Тэр хутга сэрээгээ авахад зүрх нь түргэн цохилон. Дамблдор түүнд тэдэнд хэлэхийг зарлигдсан ... Яагаад одоо биш гэж? Харри нарны гэрэлд гялалзах сэрээ рүүгээ харлаа.

- Би сайн мэдэхгүй ч тэр надад зөгнөлөөс болоод хичээл заахыг хүссэн байх. Рон, Гермиона хоёр чимээгүй хөшлөө. Тэр өмнөхийн адил сэрээндээ хандан,

- Тэдний яамнаас хулгайлахыг оролддог зөгнөл гэв.

- Хэн ч түүнд юу байсныг мэдэхгүй. Тэр хагарсан гэж Гермиона түргэн хэлэв.

- «Зөнч» сонинд бичихдээ ... гэж Рон эхэлсэн ч Гермиона,

- Чшш! гэлээ.

- «Зөнч» сонинд үнэнийг бичсэн гээд Харри арай ядан харцаа өргөж найзууд руугаа харлаа. Гермиона айсан төрхтэй байсан бол, Рон гайхширсан янзтай байлаа.

- Зөвхөн зөгнөлийг бичсэн шилэн бөмбөлөг хагарсан юм. Би бүгдийг нь бүтнээр нь Дамблдорын өрөөнд сонссон. Тэр зөгнөлийг хэлэх үед хамт байсан болохоор надад энэ тухай хэлсэн юм. Тэнд хэлэхдээ ... гээд Харри гүнзгий амьсгаа авлаа ...

- Намайг Волан-де-Мортыг дуусгах хүн гэсэн ... Бас нэг нь нэгийнхээ амьд байхад тайван амьдарч чадахгүй гэсэн.

Гурвуул чимээгүй удтал бие биенээ ширтлээ. Гэнэтхэн чанга тасхийх чимээ гараад Гермиона хар утаан үүлэн дунд алга болов.

- Гермиона! гэж Харри, Рон хоёр орилоход өглөөний цай шалан дээр тархийн унаж асгарлаа.

Гермиона утаан дундаас гартаа дуран бариад том хөхөрсөн нүдтэй гарч ирэв.

- Би түүнийг базтал ... миний нүд рүү цохьчихлоо!

Тэгтэл ч үнэхээр дурангаас жижигхэн пүрштэй нударга цухуйж байлаа.

- Санаа зовох хэрэггүй гэж Рон инээдээ арай ядан барьж хэлээд,

- Ээж чамайг дор нь хэвийн болгочихно. Ийм өчүүхэн шарх сорвийг сайн эмчилдэг юм гэлээ.

- Тэр яахав, одоо энэ чухал биш! гэж Гермиона түргэн хэлээд,

- Харри, өө, Харри минь дээ гэж уулга алдсанаа ахин орны ирмэг дээр суулаа.

- Бид ид шидийн яамнаас эргэж ирсэн цагаас хойш бүгдийг бодож үзсэн ... бид тэгэхэд Люциус Малфойн зөгнөл Волан-де-Морт та хоёрт хамаатай гэж хэлсэн тухай ярихыг хүсээгүй ... Өө, Харри минь ... гэснээ,

- Чамд аймшигтай байна уу? гэж нүдээ томруулан шивнэлээ.

- Одоо тийм ч их биш. Би анх удаагаа энэ тухай сонсох үед жинхэнээсээ айсан ... Харин одоо бол надад эрт орой хэдий ч түүнтэй нүүр тулан уулзахаа мэддэг байсан юм шиг санагдаж байна.

- Бид Дамблдор чамайг авч явсныг мэдэнгүүтээ ямар нэг зөгнөлтэй холбоотой зүйл хэлсэн байх гэж бодсон. Бид таасан байгаа биз, тийм үү? Тэр чамд боломж байхгүй гэж бодсон бол хичээл заахгүй байсан биз дээ? Цагаа үрэхгүй байсан. Тэр чамайг ялах боломжтой гэж бодож байгаа юм байна! гэж Рон хэлэв.

- Яг үнэн! гэж Гермиона хэлээд,

- Гэхдээ тэр чамайг юунд сургах гэж байгаа юм бол, Харри? Магадгүй хамгаалалтын аймшигтай хэцүү шид юмуу ... хүчирхэг эсрэг шид байх ... гэв.

Харри бараг юу ч сонссонгүй. Нарны гэрэл нуруунаас нь дулаахнаар ээхэд цээжинд нь зангирсан бүхэн уусан алга болох шиг санагдлаа. Тэр Рон, Гермиона цочирдсоноо үзүүлэхгүй байхыг хичээж байгааг мэдэж байсан ч хамгийн гол нь тэд дэргэд нь суугаад тайвшируулан ...

- ... эсвэл бултах шид байж болох юм гэж Гермона яриагаад дуусгаад,

- Ямар ч байсан чи ирэх хичээлийн жилд нэг хичээл орохыг мэдлээ. Ингэхэд бидний С.И.Ш-ийн шалгалтын дүн юу болсон юм бол? гэв.

- Сараас наашгүй байх гэж Рон хэлэв.

- Хүлээгээрэй! гээд Харри өчигдөр үдшийн ярианаас зарим нэг зүйл саналаа.

Дамблдор С.И.Ш.-ийн дүнг өнөөдөр ирнэ гэсэн.

- Өнөөдөр гэнээ! хэмээн Гермиона дуу алдаад,

- Өнөөдөр гэж үү! Гэхдээ чи яагаад ... бурхан минь! Явж харъя хэдийн ирсэн байх гээд хөл дээрээ үсрэн бослоо.

Арван хормын дараа Харри хувцаслаад хоосон тавиуртай гал зууханд орох үед Гермиона аймшигтай сэтгэл зовсон байртай ширээний ард суугаад хатагтай Уизли хөхрөлтийг нь арилгахыг оролдож байлаа.

- Юу ч бүтэхгүй нь! гэж Гермионагийн хажууд нэг гартаа шидэт саваа болон нөгөө гартаа «Анагаагчын туслах» номын «Хөхрөлт, шарх, шалбархай» гэсэн хуудсыг нээсэн хатагтай Уизли халаглаад,

- Урьд нь үргэлж тус болдог байсан юмсан. Юу ч ойлгохгүй нь гэв.

- Фред, Жорж хоёрын тоглоом хөхрөлтийг арилгахгүйн тулд байх гэж Жинни хэлэв.

- Гэхдээ арилах ёстой! гэж Гермиона орилоод,
  - Би үүрд ийм байдалтай явж чадахгүй гэлээ.
  - Тэгэхгүй дээ, хонгор минь тайвшир бид эмчлэх арга заавал олох болно гэж хатагтай Уизли хэлэв.
  - Билл надад Фред, Жорж хоёрыг их инээдтэй гэж хэлсэн! хэмээн Флер инээмсэглэв.
  - Өө тийм л дээ, би бүр инээдээ барьж чадахгүй байна гэж Гермиона дүрсхийгээд үсрэн босч өрөөн дундуур гараа базлан холхиж эхлэв.
  - Хатагтай Уизли та үнэхээр өнөө өглөө ууль ирээгүй гэдэгт итгэлтэй байна уу?
  - Тиймээ, хонгор минь би ажиглах л байсан. Есөн цаг болоогүй болохоор хангалттай хугацаа байна ...
  - Би эртний дүрс үсэг дээр унаснаа мэдэж байна. Би сүүлчийн орчуулгандаа ноцтой алдаа гаргасан. Харин хар урлагаас хамгаалах хичээлийн дадлагын шалгалт тийм ч сайн болоогүй. Гэхдээ хувиргал дээр хамаагүй дээр болсон гэж бодож байгаа ч одоо ...
  - Гермона амаа тат, гуйя. Чи ганцаараа бухимдаагүй байна! гэж Рон тэсэлгүй дуу алдаад,
  - Чи тэртээ тэргүй арван нэгэн С.И.Ш-ээ авах л юм чинь гэлээ.
  - Больж үз, больж үз гэж Гермиона гараа савчин хашгираад,
  - Би бүгдэд нь унасан гэдгээ мэдэж байна! гэлээ.
  - Хэрвээ уначихвал яах вэ? гэж Харри асуув.
  - Тэнхимийн эрхлэгчтэйгээ сонголтын тухай ярилцах ёстой. Би профессор МакГонагаллаас өнгөрсөн хичээлийн жилийн төгсгөлд энэ тухай асуусан гэж Гермиона хариуллаа.
- Харрийн гэдэс тулахад хэтэрхий их өглөөний хоол идсэндээ харамслаа.
- Харин манай Шармбатонд бол өөр системтэй. Түүнийг хамаагүй дээр гэж бодож байна. Бид шалгалтаа тав биш зургадугаар дамжаандаа өгдөг ...
- Флерийн үг хашгиралт болон хувирлаа. Гермиона гал зуухны цонх руу хуруугаараа заав. Цэлмэг тэнгэрт гурван хар цэг харагдаад түргэн томорлоо.
- Уульнууд байна гэж Рон сөөнгөтөн хэлээд үсрэн босч Гермионагийн хамт цонх руу ухасхийлээ.
  - Гурван ширхэг гээд Харри яаран тэдэн лүү очлоо.
  - Хүн тус бүрт гэж Гермиона чичирсэн хоолойгоо шивнэснээ,
  - Өө, чадахгүй нь ээ ... чадахгүй нь ... чадахгүй нь ... гэлээ. Тэр бүх хүчээ гарган Харри, Рон хоёрын тохойноос зуурлаа.

Гурван сайхан шаргал ууль Үүр лүү чиглэн нисч ирээд доошлохдоо тус бүрдээ дөрвөлжин дугтуй зуужээ.

- Ёо, чадахгүй нь ээ! гэж Гермiona уулга алдав.

Хатагтай Уизли тэдний дундуур чихэн орж гал зуухны цонхыг нээлээ. Уульнууд нэг нэгнийхээ араас нисэн орж ирээд ширээн дээр газардаж баруун сарвуугаа өргөлөө.

Харри урагш алхав. Түүнд хаяглагдсан захиа дунд талын уулинд байлаа. Тэр уяаг тайлахаар эв дүйгүйхэн оролдов. Зүүн талд нь Рон дугтуйгаа салгаж авахаар мунгинана. Баруун талд нь Гермioангийн гар чичирч байсан болохоор ууль бас чичирч байлаа.

Гал зууханд нам гүм боллоо. Эцэст нь Харри дугтуйгаа аваад урж дотор нь байсан цаасыг дэлгэв.

СҮПЕР ИД ШИД ШАЛГАЛТЫН ҮР ДҮН Амжилттай үнэлгээ

Онц (O)

Илүү ихийг хүлээж байгаа (И) Хангалттай (X)

Тааруу үнэлгээ Тааруу (Т) Аймшигтай (А) Савдаг (С)

ХАРРИ ЖЕЙМС ПОТТЕРЫН ҮНЭЛГЭЭ Одон орон ..... X

Шидэт амьтныг арчлах хичээл ..... И

Шившлэг ..... И Хар урлагаас хамгаалах ..... O

Мэргэ төлөг ..... Т Ургамал судлал ..... И

Ид шидийн түүх ..... А Уусмал ..... И

Хувиргал ..... И

Харри цаасыг хэдэнтээ уншаад тайвширлаа. Бүгд хэвийн байв. Тэр мэргэ төлгийн хичээл дээр унахаа мэдэж байсан бөгөөд ид шидийн түүх дээр шалгалтын дундуур ухаан алдсан учир боломж байгаагүй, үлдсэнд нь сайн дүн авчээ. Харри хуруугаа үнэлгээ дээгүүр гүйлгэв. Хувиргал болон ургамал судлалыг муугүй өгч тэр ч байтугай уусмал дээр «илүү ихийг хүлээж байгаа» авчээ. Хамгийн гол нь хар урлагаас хамгаалах хичээл дээр түүнд онц дүн тавьсан байлаа!

Тэр эргэн тойрноо харав. Гермiona цаашаа харан бөхийн суугаад, Рон баясан гийлээ.

- Зөвхөн мэргэ төлөг болон ид шидийн түүх дээр унасан байна. Ер нь тэд хэнд хэрэгтэй юм? гэж хөгжилтэй хэлээд,

- Алив өөрийнхийгөө сольж үзье гэлээ.

Харри Роны үнэлгээг харахад онц дүн байсангүй.

- Тэгэхээр чи хар урлагаас хамгаалах хичээл дээр хамгийн дээд үнэлгээг авчээ гээд Рон Харрийн мөрөн дээр алгадан,

- Бид сайн биш үү? гэв.

- Сайн байна! гэж хатагтай Уизли бардам хэлээд Роны үсийг сөргүүлэн илж,

- Долоон С.И.Ш энэ ч Фред, Жорж хоёрынхыг нийлүүлснээс их байна шүү! гэв.
- Гермиона! гэж Жинни болгоомжтой дуудаад,
- Чинийх ямар байна? гэлээ.
- М-муугүй гэж Гермиона сулхан хоолойгоор хэлэв.
- Больж үз гээд Рон том алхлан очиж дүнтэй цаасыг авлаа.
- Хөөх! Арван ширхэг онц үнэлгээ болон ганц «илүү ихийг хүлээж байгаа» хар урлагаас хамгаалах хичээл дээр авсан байна гээд түүн рүү шоолонгуй харж,
- Чи чинь одоо сэтгэлээр унаад байгаа юм уу даа? гэлээ. Гермиона толгой сэгсрэхэд Харри инээлээ.
- Одоо бидэнд зургадугаар дамжааны Ж.А.Б.А-гийн шалгалт үлдлээ! гэж Рон нүүр дүүрэн инээмсэглээд,
- Ээжээ зайдас үлдээгүй биз? гэв.

Харри ахин үнэлгээ рүүгээ харлаа. Тэд найдаж байсан шиг нь сайн байлаа. Зөвхөн ганц зүйл харамсалтай байх аж ... Мракоборец болох мөрөөдөл бөхжээ. Тэр уусмалын хичээл дээр өндөр үнэлгээ авсангүй. Урьд нь бүтэхгүй гэдгийг мдээж байсан нь хэр нь жижигхэн хар «И» үсэг рүү харах болгонд сэтгэл нь шимширч байв.

Хачирхалтай нь хэрвээ санах аваас Харриг сайн мракоборец болно гэж хэлсэн хүн үнэн хэрэгтээ зүсээ хувиргасан Үхэл залгигч байсан. Энэ бодол орж ирэхэд амьдралдаа цаашид юу хийхээ бодож чадсангүй. Тэр зөгнөлийг сонсоход энэ л түүний хувь заяа шиг санагдсан ... «Тэдний нэг нь нөгөөгөө амьд байхад тайван амьдарч чадахгүй ...» Магадгүй зөгнөлийн дагуу өндөр бэлтгэгдсэн шидтэн болж ажилд орохын оронд Волан-де-Мортыг алахаар оролдох ёстой ч байж болох юм.

## БҮЛЭГ 6: МАЛФОЙН ТОЙРУУ ЗАМ

Дараагийн хэдэн долоо хоногийг Харри Үүрэнд цэцэрлэгээс нь гаралгүй өнгөрүүлээ. Өдөржингөө хоёрын эсрэг хоёр квиддич тоглож (Харри, Гермiona хоёр Рон, Жинни хоёрын эсрэг. Гермiona аймшигтай муу тоглож байхад Жинни сайн тоглож байв), үдэш нь хатагтай Уизлийн түүнд бэлтгэсэн гурав дахин илүү хувь янз бүрийн амттан идэж байлаа.

Энэ нь хэрвээ «Өдөр тутмын зөнч» сонин бараг өдөр бүр нууцлаг алга бололт, хачирхалтай золгүй явдал болон, амь үрэгдсэн шидтэнгүүдийн тухай мэдээлдэггүйсэн бол тайван жаргалтай амралт гэж болохоор байлаа. Заримдаа Билл, ноён Уизли хоёр мэдээг сонинд нийтлэгдэхээс өмнө урьдчилан дуулгаж байв. Харрийн арван зургаан насны төрсөн өдөр дээр хатагтай Уизлиг ихэд гомдоон улам турж баргар болон, үс нь бууралтаж хувцас нь өмнөхөөсөө илүү элэгдэж ноорсон Римус Люпин таагүй зүйлийн талаар багагүй ярьсан юм.

- Ахиад Дементорын хоёр гурван дайралт гарсан гэж тэр хатагтай Уизлийн гарын бялууны томоохон зүсмэлээс татгалзан мэдэгдлээ.

- Игор Каркаровыг хойд зүгт алсад үхсэн байхыг нь олсон. Түүний дээр Хар тамга байсан. Үнэнийг хэлэхэд би түүнийг Үхэл залгигчдаас ахин нэг жил зугтсан бол гайхах байлаа. Сириусын дүү Регулус хэдхэн өдөр тэссэнийг сайн санаж байна.

- Тиймээ, тийм магадгүй өөр зүйлийн талаар яривал дээр байх гэж хатагтай Уизли хөмсөг зангидан хэлэв.

- Флориан Фортескьюгийн тухай дуулсан уу, Римус гэж Флерт дарс хундгалж байсан Билл асуулаа.

- Тахир гудамжны зайрмагын мухлагын эзэн үү? гэж Харри асуугаад дотор нь таагүй болов. Тэр намайг үнэгүй зайрмагаар зочилж байсан. Түүнд юу тохиолдоо вэ?

- Түүнийг хүчээр аваад явсан байсан.

- Яагаад? гэж Рон гайхахад хатагтай Уизли Билл рүү анхааруулан харав.

- Хэн мэдэх юм? Тэднийг ямар нэг зүйлээр уурлуулсан байх. Флориан сайн хүн байсан юм.

- Тахир гудамж гэснээс Олливандерт ч гэсэн тийм юм тохиолдсон гэсэн хэмээн ноён Уизли хэлэв.

- Шидэт саваа хийдэг үү? гэж Жинни айн асуулаа.

- Яг мөн. Дэлгүүр нь хоосон. Ямар ч тэмцлийн ул мөр байхгүй. Хэн ч түүнийг өөрөө явсан юмуу хулгайлагдсан эсэхийг нь мэдэхгүй байгаа.

- Тэгвэл шидэт саваагүй хүмүүс яах болж байна?

- Бусад үйлдвэрлэгчдэд хандах болно. Гэхдээ Олливандер хамгийн шилдэг нь байсан болохоор өөр талд орсон бол бидний хувьд л муу юм болно гэж Люпин хэллээ.



Энэхүү баргар төрсөн өдрийн дараа Хогвартсаас сурах бичгийн жагсаалт бүхий захианы хамтаар Харрид гэнэтийн бэлэг ирлээ. Түүнийг квиддичийн багийн ахлагчаар сонгожээ.

- Одоо чи ахлагч нартай адил түвшинд боллоо! Бидний тусгай угаалгын өрөөнд орох ч юмуу өөр бас бус зүйлд! гэж Гермiona баяртай дуу алдав.

- Хөөх, би Чарлид ийм тэмдэг байсныг санаж байна гэж Рон ахмадын тэмдгийг хөөрөн харж хэлээд,

- Харри энэ чинь сайхан хэрэг шүү, чи одоо миний ахмад боллоо ... хэрвээ намайг ахин багтаа үлдээвэл, хаха! гэв.

- Тахир гудамж руу очих хугацааг цаашдаа сунгахааргүй болжээ. Хэрвээ аавыг чинь ахиад дуудчихгүй бол хагас сайнд явахаас. Би түүнгүй хаашаа ч хөдлөхгүй гэж Роны сурах бичгийн жагсаалтыг харж байсан хатагтай Уизли санаа алдан хэлэв.

- Ээжээ та үнэхээр Хэцүү нэрт «Флориш Флоттс» дэлгүүрийн номын тавиурын цаана нуугдаж байгаа гэж бодоо юу? хэмээн Рон хөхөрлөө.

- Фортескью, Олливандер хоёр чинийхээр бол амралтаа авахаар шийдсэн байх нь уу? гэж хатагтай Уизли дүрсхийгээд,

- Хэрвээ аюулгүй байдал чамд инээдтэй бол гэртээ үлд. Би чамд бүгдийг худалдаад авчихна! гэв.

- Үгүй би таньтай явж Фред, Жорж хоёрын дэлгүүрийг харахыг хүсч байна! гэж Рон яаран хэлэв.

- Тийм тохиолдолд амаа татаж бай залуу хүн минь. Чамайг бидэнтэй явна гэж би шийдээгүй л байгаа шүү! гэж хатагтай Уизли уурсан хэлээд дуртай цаг руугаа харахад есөн зүү өмнөхийн адил «үхлийн аюул» гэсэн үгийг зааж байлаа. Хогвартс руу буцаж очсон ч энэ чамд хамаатай!

Рон Харри руу итгэлгүйхэн харав. Түүний ээж нь цагаан хэрэглэлтэй сагс бариад өрөөнөөс ууртай гарч одлоо.

- Чөтгөр гэж тоглож ч болохоо байх нь.

Дараагийн хэдэн өдрийн турш Рон ихэд болгоомжтой байж Волан-де-Мортын талаар тоглоом хийсэнгүй. Бямба гаригийн өглөө хатагтай Уизли хүүхдүүдээ сэрээгээд түгшсэн байртай өглөөний цай уулаа. Флертэй гэртээ үлдэх ёстой Билл (Гермиона, Жинни хоёр ихэд баярлажээ), Харрид ширээн дээгүүр дүүрэн мөнгөтэй түрийвч сунгалаа.

- Харин надад? гэж Рон даруйхан нүдээ томруулж шаардав.

- Энэ чинь Харригийнх, тэнэг минь. Би шүүгээнээс нь авсан юм. Албингууд аюулгүй байдлыг чангатгасан болохоор Харри алтаа зорчигчийн таван цагаас авах ёстой.

- Баярлалаа, Билл гээд Харри алтаа халаасандаа хийлээ.

- Тэр үргэлж халамжлангуй байх юм гэж Флер бахдан хэлээд Биллийн хамрыг илбэв.

Жинни Флерийн ард дотор нь муухайрсан аятай тавагтай будаа руугаа тонгойв. Харри эрдэнэ шишийн хөөсөнд хахахад Рон нуруун дээр нь алгадлаа.

Бүрхэг өдөр байв. Тэднийг жанчаа өмсөн гэрээс гарахад үүдэнд ид шидийн яамны машин хүлээж байв. Харри хэдийн ийм машинд сууж үзсэн билээ.

- Ашгүй аавд ахин өгсөн нь сайн хэрэг гэж Рон урамтай хэлээд тансаг суудал дээр лагхийн суулаа.

Машин байрнаасаа аяархан хөдлөн Үүрийг орхиход Билл, Флер хоёр гал зуухны цонхоор гараа даллав. Рон, Харри, Гермиона, Жинни нар хамтдаа арын өргөн суудал дээр ая тухтай суусан байлаа.

- Чи үүнд дасах хэрэггүй шүү зөвхөн Харрид зориулсан юм гэж ноён Уизли хойшоогоо анхааруулав. Тэр хатагтай Уизлийн хамтаар жолоочийн хажуугийн урд талын суудалд суужээ. Суудал тэнийж хоёр хүний буйдан шиг болсон байлаа. Түүнийг одоо дээд зэргээр хамгаалж байгаа. Бас биднийг

«Цоорхой тогоон»-нд хүч нэмэгдүүлсэн хамгаалалт хүлээж байгаа.

Харри чимээгүй байлаа. Тэр дэлгүүр хэсэхэд мракоборецуудын отряд дагадаг явдалд дасал болоогүй байв. Үл үзэгдэх цув цүнхэнд нь нуугаастай байсан бөгөөд энэ нь Дамблдор ч тэр, яамныханд ч тэр хангалттай сайн зүйл хэдий ч яамныхныг энэ талаар мэдэж байгаа эсэхэд нь эргэлзлээ.

- Ирлээ. Би та нарыг энд хүлээж байя. Ойролцоогоор хэр хугацааны дараа эргэж ирэх вэ? гэж жолооч гайхалтай түргэн мэдэгдээд машинаа Чаринг- Кросс-Роудад удаашруулан «Цоорхой тогоо»-ны үүдэнд зогсоов.

- Ойролцоогоор хоёр цаг болох байх гэж ноён Уизли хэлээд,

- Өө, тэр энд байна гэдэг чинь ямар сайн хэрэг вэ! гэлээ.

Харри ноён Уизлийн харцыг дагуулан цонхоор хараад зүрх нь баяртай цохилон. Түүнийг буудлын гадаа мракоборецуудын отряд биш Рубеус Хагридын том хар сахалтай дүрс хүлээж байлаа. Хогвартсын ойн сахиул минжний арьсаар хийсэн урт дээл өмссөн бөгөөд дэргэдүүр нь өнгөрсөн маглууд гайхан харах аж.

- Харри! гэж тэр нүргэлүүлээд Харриг машинаас гарахад ясыг нь нужигнатал тэвэрч,

- Клювокрыл ... би Махаон гэж хэлэх гэсэн юм л даа ... чи түүнийг харсан бол, Харри. Тэр ахин нисэх болсондоо их баяртай байсан шүү ... гэв.

- Түүнийг сайн байгаа гэдэгт би баяртай байна. Бид хамгаалалт гэдэг нь чамайг гэж мэдсэнгүй гэж Харри инээмсэглэн хэлээд хавиргаа үрлээ.

- Хуучны сайхан цаг шиг байгаа биз, тийм үү? Яамныхан бүлэг мракоборец явуулахыг хүссэн ч Дамблдор намайг ганцаараа хангалттай гэж хэлсэн гээд Хагрид бахархалтай цээжээ түхийлгэн хуруугаараа халаасаа бөмбөрдлөө.

- За явцгаах уу тэгээд. Молли, Артур та нарын дараа!

Харрийн ой ухаанд анх удаагаа «Цоорхой тогоо» хоосон байсан явдал болов. Зөвхөн үрчгэр шүдгүй хөгшин Том байрандаа зогсож байлаа. Тэр тэднийг ороход найдангуй хараад үг хэлэх гэсэн ч Хагрид албархуу байдалтай,

- Бид зөвхөн орох ёстой, Том ойлгож байгаа биз дээ ... Хогвартсын ажил хэргээр гэлээ.

Том гунигтай толгой дохиод шилэн аягаа ахин арчлаа. Харри, Гермiona болон дөрвөн Уизли хүйтэн давчуу хогийн сав бүхий арын хашаанд гарлаа. Хагрид ягаан шүхрээ өргөөд ханан дахь тоосгонуудыг тогшиход тэдний өмнө нуман хаалга нээгдэв. Хаалгаар ороод бүгд ийш тийшээ харав.

Тахир гудамж өөрчлөгджээ. Гялалзсан үзмэрийн цонхонд өнгө алаглуулан тавьсан байдаг шившлэгийн ном, шидэт уусмалын орц, тогооны оронд ид шидийн яамны зурагт хуудсаар дүүрчээ. Энхүү баргар хүрэн өнгийн зурагт хуудасны ихэнхи хэсгийг Үхэл залгигчдын хөдөлгөөнт хар цагаан зураг эзэлжээ. Ойролцоох эмийн сангийн лангуун дээр уруулаа шоолонгуй мушийлгасан Беллатрис Лестрйнжийн зураг байв. Хэд хэдэн цонхны самбар хаалттай байсны тоонд Флориан Флортескьюгийн зайрмагны мухлаг оржээ. Гудамжинд борооны дараах мөөг адил ноорхой майхнууд нэмэгджээ. «Флориш блоттс» дэлгүүрийн ойролцоох судалтай майхны хаалган дээр цаасан дээр бичсэн хаяг хатгасан байв.

## САХИУС

Дементор, инфернал болон хүн чонын эсрэг өндөр үр нөлөөтэй.

Ядруухан туранхай шидтэн гартаа барьсан мөнгөлөг гинжтэй зүүлтийг санжигнуулангаа,

- Охиндоо сахиус сонирхохгүйсэн болов уу, хатагтай? Түүний хөөрхөн хүзүүг хамгаалах болно гэж хатагтай Уизлиг дэргэдүүрээ өнгөрөхөд Жиннигийн зүг инээмсэглэн хэллээ.

- Би хэрвээ жижүүртэй байсан бол ... гэж ноён Уизли унтууцаад сахиусны наймаачин руу ууртай харлаа.

- Тиймээ, хонгор минь зөвхөн одоо л битгий баривчилж үзээрэй, бид их яарч байна гээд хатагтай Уизли жагсаалтаа сэтгэл зовон харж,

- Эхлээд хатагтай Малкины дэлгүүр лүү орсон нь дээр байх. Гермionад шинэ жанч хэрэгтэй бас Роны сургуулийн дүрэмт хувцас багадсан байдаг. Харри чи ч гэсэн их өссөн болохоор сургуулийн шинэ дүрэмт хувцас хэрэгтэй болж ... За бүгдээрээ явцгаая! гэлээ.

- Молли бүгдээрээ хатагтай Малкиных руу орж яах гэсэн юм. Тэр гурвыг Хагридтай явуулаад харин бид «Флориш Блоттс» орж сурах бичгүүдээ худалдаж авъя хэмээн ноён Уизли эсэргүүцэв.

- Би мэдэхгүй байна гэж хатагтай Уизли шийдвэргүйхэн хэлэв. Тэр худалдааг түргэхэн дуусгахыг хүсч байсан ч хоорондоо хуваагдах хүсэлгүй байлаа.

- Хагрид чи юу гэж бодож байна?

- Санаа зовох хэрэггүй дээ, Молли тэд надтай хамт явахад аюулгүй! гэж Хагрид түүнийг тайвшируулаад хогийн савны таглаанаас багагүй хэмжээтэй гараа хайхрамжгүй даллав. Хатагтай Уизли түүн рүү эргэлзэн харсан ч ямар ч гэсэн хүч хуваагдах явдлыг зөвшөөрч нөхөр болон Жиннигийн хамтаар

«Флориш Блоттс» номын дэлгүүр лүү яаран ороход, Харри, Рон, Гермиона, Хагрид нар хатагтай Малкиных руу явлаа.

Харри хүмүүсийн ихэнхи нь хатагтай Уизлийн адил түгшиж сандарсан төрхтэй байхыг ажиглажээ. Хүмүүс бие биентэйгээ ярилцахаар зогсохгүй бөөнөөрөө явахыг эрхэмлэж худалдаагаа яаран хийж байлаа. Хэн ч дэлгүүрт ганцаар байсангүй.

- Бид нар бүгдээрээ тийшээ орж болохгүй байх гэж Хагрид хатагтай Малкины үзмэрийн цонх руу өнгийн хэлээд,

- Би гадаа хүлээж байя, орцгоо гэлээ.

Харри, Рон, Гермиона гурав хамтдаа оров. Эхэндээ хоосон байх шиг санагдсан ч хаалга хаагдаж амжаагүй байтал лангууны ард цэнхэр ногоон жанч гялсхийн танил хоолой дуулдлаа.

- ... Би хүүхэд биш болсныг та ажиглахгүй байгаа юм уу, ээжээ. Би хэрэгтэй бүх зүйлээ өөрөө худалдан авч чадна.

Хэн нэгэн шогшроход Харри хатагтай Малкины хоолойг танилаа.

- Юу гэж дээ хонгор минь, ээжийн чинь зөв. Одоо хэн ч ганцаараа явахгүй байгаа болохоор гол нь насанд хүрсэн гэдэгтээ байгаа юм биш.

- Зүүгээ хаашаа хатгаад байгаа юм бэ! Болгоомжтой бай, гуйя!

Лангууны цаана өсвөр насны цонхигор царай, цайвар үстэй хүү сайхан ногоон өнгийн жанч өмсөн зогсоод хацуйных нь хөвөөнд зүү гялсхийв. Тэр толь руу очиж өөрийгөө ажиглангаа Харри, Рон, Гермиона нарын тусгалыг харлаа. Түүний саарал нүд нарийслаа.

- Ээжээ хэрвээ та яагаад өмхий үнэртэж байгаад гайхаж байгаа бол ийшээ бохир цустан орж иржээ гэж Драко Малфой хэлэв.

- Манай дэлгүүрт ийм үг хэрэглэхгүй байхыг гуйя гээд хатагтай Малкин лангууны араас гартаа шугам болон шидэт саваа барин гүйн гарч ирлээ.

- Бас энд шидэт саваагаа даллахгүй байхыг гуйя! гэж хаалганы өмнө Малфой руу шидэт саваагаа чиглүүлэн зогсож байсан Харри, Рон хоёрыг хараад яаран нэмэрлэв. Тэдний ард зогсож байсан Гермиона,

- Хэрэггүй, орооцолдох хэрэггүй үнэн шүү гэж шивнэлээ.

- Тийм шүү, сургуулиас гадуур ид шид хэрэглэж зүрхлэхийг чинь харъя гэж Малфой даажигнан хэлээд,

- Ингэхэд хэн чиний нүдийг хөхрүүлчихээ вэ, Грэйнджер? Би түүнд цэцэг илгээх гэсэн юм! гэлээ.

- Хангалттай! гэж хатагтай Малкин ширүүн хэлээд мөрөн дээгүүрээ дэмжлэг эрэн харж,

- Хатагтай ... танаас гуйя! гэлээ.

Нарцисса Малфой тавиурын араас яаралгүйхэн гарч ирэв.

- Үүнийгээ даруйхан холдуул! Хэрвээ миний хүүг дайрах юм бол энэ та нарын хийсэн хамгийн сүүлчийн зүйл чинь байх болно шүү гэж хүйтнээр Харри, Рон хоёрыг харан хэлэв.

- Тийм гэж үү? гээд Харри алхам урагшилж эгчийгээ санагдуулсан их зантай хямсгар царай луу харлаа. Харри түүнтэй өндрөөрөө чацуу байв. Та тэгээд яах юм. Хэдэн найз Үхэл залгигч нараа дуудах гээ юу?

- Тийм зүйлийн талаар яаж ярьж болох юм ... эрсдэлтэй буруутгал ... алив саваагаа буулга! гэж хатагтай Малкин зүрхээ даран хашгирав.

Гэсэн ч Харри саваагаа буулгасангүйд Нарцисса Малфой таагүйхэн инээмсэглэв.

- Чамайг Дамблдорын хайртай сурагч болсон болохоор бүх зүйлийг амраар төсөөлж байгааг харж байна, Харри Поттер. Гэхдээ Дамблдор үргэлж чамайг хамгаалаад байж чадахгүй.

Харри шоолон инээмсэглээд эргэн тойрноо харав.

- Хөөе ... ийшээ хараач ... тэр энд байна! Та нар юу хүлээгээ вэ? Магадгүй та нарт түүнийг авъяасгүй нөхрийнх нь хамт суулгахад Азкабанд хоёр хүний өрөө хэрэг болох байх!

Малфой Харрийн зүг ухасхийх гэсэн ч урт жанчныхнаа хормойд тээглээд бүдэрчихлээ. Рон чанга хөхрөв.

- Миний ээжтэй тэгж бүү ярь, Поттер! гэж Малфой заналхийлэв.

- Зүгээр дээ, Драко. Поттер намайг Люциустай уулзахаас өмнө өөрийнхөө Сириустэй уулзах байх гэж бодож байна гээд Нарцисса хүүгийнхээ мөрөн дээрээс нарийхан цагаан хуруугаараа барин тогтоов.

Харри шидэт саваагаа өргөлөө.

- Харри хэрэггүй! Ухаар л даа ... чи болохгүй ... таагүй юм болно гэж Гермiona гуйгаад гараас нь зүүгдлээ.

Хатагтай Малкин юу ч болохгүй гэж найдсан мэт байрнаасаа хөдлөв. Тэр Харри руу муухай харсаар Малфой руу тонгойлоо.

- Зүүн ханцуйгаа жаахан дээшлүүлсэн нь дээр байх, хонгор минь алив би одоохон ...

- Ёо! гэж Малфой орилоод гараа угз татан авлаа.

- Хатгасан зүүгээ харж байгаач, эмэгтэй минь! Ээжээ би эндээс юу ч авахыг хүсэхгүй байна ...

Тэр жанчаа толгой дээгүүрээ тайлаад хатагтай Малкины хөлд хаялаа.

- Чиний зөв, Драко гэж Нарцисса Гермиона руу жигшүүртэй харж хэлээд,

- Би энд ямархуу төрлийн амьтад цугладгийг харж байна ... Твилфитт Таттингт очсон нь дээр бололтой гэв.

Ингэж хэлээд тэрбээр дэлгүүрээс бардам гарлаа. Малфой гарах замдаа Роныг мөрөөрөө аль болох чанга нудрахыг хичээв.

- Үгүй ер! хэмээн хатагтай Малкин дуу алдаад шалан дээр унасан жанчаа авч савааныхаа үзүүрээр тоос сорогч адил тоосыг нь сорууллаа.

Тэр сэтгэлээр унасан байртай Рон, Харри хоёрт шинэ жанч тохируулахдаа тасралтгүй үглэж Гермионад золтой л эрэгтэй хүний жанч өгөлгүй эцэст нь тэднийг дэлгүүрээс ёслон гарахдаа ийм эргэлзээтэй үйлчүүлэгч нараас салж байгаадаа баяртай харагдав.

- Бүгдийг авсан уу? гэж Хагрид тэднийг ирэхэд хөгжилтэй асуув.

- Бүгдийг. Чи Малфойг харав уу? гэж Харри хэлэв.

- Харсан гэж Хагрид хайхрамжгүй хэлээд,

- Чи санаа зовох хэрэггүй дээ, Харри. Тэд Тахир гудамжинд асуудал үүсгэж зүрхлэхгүй болохоор тоох хэрэггүй гэлээ.

Харри, Рон, Гермиона нар харц солилцоод Хагридад ярьж амжаагүй байтал ноён ба хатагтай Уизли Жиннигийн хамтаар гартаа дүүрэн хүнд номтой ирлээ.

- Бүгд хэвийн үү? Жанчаа худалдаж авсан уу? Тэгвэл сайн байна Фред, Жорж хоёрын дэлгүүр лүү очих замдаа Илопсын эмийн санг дайраадахъя ... холдох хэрэггүй ойрхон яваарай гэж хатагтай Уизли хэлэв.

Харри, Рон хоёр уусмалын хичээл судлах хэрэггүй болсон болохоор эмийн сангаас ямар ч орц авсангүй оронд нь Хэдвиг, Гахай хоёрт зориулан уулийн том хайрцагтай самар авлаа. Дараа нь Фред, Жорж хоёрын дэлгүүр лүү очих замд хатагтай Уизли хором тутамд цагаа харж байлаа.

- Тийм ч их цаг үлдсэнгүй. Зөвхөн шагайнгуутаа машин руугаа буцна шүү.

Бараг ирчихсэн байх. Энд ерэн хоёрдугаар байшин байна ... ерэн дөрөв ...

- Үгүй ерөө! гэж Рон дуу алдаад хөшсөн юм шиг зогсов.

Ид шидийн яамны бараан зурагт хуудастай дэлгүүр мухлагуудын дэргэд Фред, Жорж хоёрын үзмэрийн шилэн цонх галын наадам шиг харагдав. Дэргэдүүр нь өнгөрч буй хүмүүс мөрөн дээгүүрээ эргэн харах бөгөөд, зарим нь мэгдсэн янзтай алмайран ширтэж байлаа. Лангуу зүүнээсээ эхлээд нүд булаам янз бүрийн бараа таваараар дүүрэн байсан нь эргэлдэж, дэвхцэн, гялалзаж, үсчин орилж байсан тул энэ бүх нүд эрээлжилсэн зүйлийг харахад хэцүү байлаа. Үзмэрийн цонхны баруун

талд ид шидийн яамныхныг санагдуулам аварга том ягаан зурагт хуудас нааж дээр нь шаргал өнгийн үсгээр,

ЯАГААД БҮГД ХЭЦҮҮ НЭРТЭЭС САНАА ЗОВНО ВЭ? АРД ТҮМЭН САНАА ЗОВСНООС

ГЭДЭС НЬ ТҮГЖИРЧ БАЙНА ТЭР ЗАЛЬТАЙ, ОВСГООТОЙ ТҮҮНЭЭС БОЛЖ ЭРТНЭЭС

БҮХ ОРОН ДАЯАР ТҮГЖРЭЛ ҮҮСЭЖ БАЙГАА! гэж бичжээ.

Харри инээхэд дэргэд нь сулхан дуу алдах чимээ сонсогдоод хатагтай Уизли зурагт хуудаснаас нүд салгахгүй хөшин зогслоо. Түүний уруул чимээгүйхэн хөдлөн «гэдэс нь түгжирсэн» гэж уншсанаа,

- Тэр тэднийг оронд нь алах байх даа! гэж шивнэлээ.

- Алахгүй! Энэ чинь гайхамшигтай шүү дээ! гэж Рон Харрийн адил хөхрөн хэлэв.

Тэр Харрийн хамт дэлгүүрт түрүүлэн ороход дүүрэн худалдан авагчидтай байв. Харри тавиурууд руу шууд очиж чадсангүй адар хүртэл өрөөстэй хайрцаг руу харлаа. Тэдний дунд ихрүүдийн Хогвартст суралцсан сүүлчийн жилдээ хийсэн болох Ажлаас зайлсхийгч зууш байлаа. Түүнчлэн томоохон эрэлт хэрэгцээтэй байсан Цус гоожуулдаг самар зүүн талын тавиур дээр ганцхан боодол үлджээ. Бүтэн том саваар дүүрэн хуурамч саваа байсан нь хамгийн хямд бөгөөд даллахад резинэн тахиа, боксын бээлий болон хувирч зарим сэрэмжгүй үйлчлэгч нар толгой руугаа цохиулж байлаа. Бас хайрцаг дүүрэн өөрөө бичдэг үзэг, алдаа засдаг үзэг, өөрөө хариулагч үзэгнүүд байлаа. Харри цугласан хүмүүсийн завсраар чихэн лангуу руу очоод ойролцоогоор арваад насны хүүхдүүд жижигхэн модон хүн удаанаар дүүжлүүр рүү өгсөхийг хөөрөн харахыг ажиглав. Хайрцаган дээр нь «Олон дахин ашигладаг дүүжлүүр. Хэрвээ чи алдаатай бичвэл дүүжлүүртээ ганхана!» гэсэн байлаа.

- Патентлагдсан мөрөөдлийн ид шид.

Гермиона ойролцоох шилэн шүүгээний урд царайлаг хөөрхөн охин дээрэмчдийн усан онгоцон дээр зогсож байгаа зурагтай хайрцагны зааврыг чанга уншлаа.

- «Нэг энгийн шившлэг чамайг дээд зэргийн бодит байдалд гучин минут мөрөөдөлд автуулна. Дунд сургуулийн хичээлд ажиглагдахгүй хэрэглэх боломжтой (Зарим шалтгааны улмаас царай гөлийж, шүлс гоожиж болзошгүй). Арван зургаагаас доош насныханд худалдахгүй». Чи мэдэх үү энэ ч ёстой ид шидийн гайхамшигтай түвшин байна даа! гэж Харри руу харан хэллээ.

- Гермиона чи үүнээс нэгийг үнэгүй авч болно шүү гэх хоолой түүний ард сонсогдов.

Тэдний өмнө баясан гийсэн Фред гал шаргал үстэйгээ сүр жавхлантай зохицсон улаан жанчтай инээмсэглэн зогсож байв.

- Юу байна даа, Харри? гээд гар барьснаа,

- Гермiona чиний нүд яагаа вэ? гэлээ.
- Танай дуран цохьсон юм гэж тэр гашуудалтай хэлэв.
- Чөтгөр гэж, би түүнийг мартчихаж. Май үүнийг ав гэж Фред хэллээ.

Тэр халааснаасаа жижигхэн сав гаргаж сунгав. Гермiona түүнийг болгоомжтой онгойлгоход дотор нь зууралдсан шар өнгийн нухаш байлаа.

- Арчаад хөхрөлт цагийн дотор зүгээр болно. Бид хөхрөлтийг арилгах дажгүй арга олсон болохоор одоо бараг бүх бараандаа туршиж үзэж байгаа.

Гермiona түгшсэн байртай харагдав.

- Энэ чинь аюулгүй биз?
- Тэгэлгүй яахав гэж Фред тайвшируулаад,
- Явъя Харри би чамайг аялал хийлгэе гэв ...

Харри Гермionaг хөхрөлт арилгагчтай нь үлдээгээд Фредийн араас дэлгүүрийн гүн рүү дагав. Тэр тэнд жаазанд хийн босгон тавьсан хөзрийн тоглоом харав.

- Маглуудын илбэ жилбэ! Манай аав шиг маглуудын эд зүйлд дуртай этгээд хүмүүс байдаг юм. Орлого нь шалихгүй ч эрэлт ихтэй болохоор амжилттай болсон ... Өө, энэ Жорж байна ...

Хоёр дахь ихэр Харриг халуун дотноор гар барилаа.

- Дурсгал үзэж байна уу? Нөгөө танхим руу очвол Харри чи биднийг тэнд жинхэнэ мөнгө хийж байхыг харах болно ... Хөөе чи галлеон төлөөгүй байж халаасандаа хийхгүй шүү! гэж ширүүн хэлэхэд жижигхэн хүү яаран «Иддэг Хар тамга – Хэний ч дотрыг муухайруулна!» гэсэн бичигтэй харцагийг тавилаа.

Жорж маглуудын илбэ шидний дэргэдэх хөшгийг түлхэхэд Харри хүнгүй харанхуй өрөө байхыг харлаа. Энд арай даруу бараа таваар тавиур дээгүүр ярайж байв.

- Бид саяхнаас илүү чухал бараа таваар үйлдвэрлэж эхэлсэн. Энэ ч хөгжилтэй болсон шүү гэж Фред хэллээ.

- Чи хичнээн олон хүн тэр дундаа ид шидийн яамныхан хүртэл Бамбай шидийг хийж чаддаггүйг сонсоод итгэхгүй дээ. Үнэдээ тэд чамаас сураагүй болохоор тэр, Харри гэж Жорж хэлэв.

- Тийм шүү ... бид хөгжилтэй Бамбай малгай бодож олсон. Чи найзтайгаа шившлэгээр үзэлцье гэвэл малгайгаа өмсөөд түүний бие дээр чамаас ойсон шившлэг яаж үйлчилэхийг харах болно. Ид шидийн яамнаас таван зуун ширхэг малгай өөрийн ажилчиддаа зориулан захиалсан гээч! Бид одоо их хэмжээний захиалгатай байгаа!

- Одоо бид төрөл зүйлээ өргөтгөн бамбай дээл, бамбай бээлий гаргах гэж байгаа ...

- Тэд уучлашгүй шидээс хамгаалж чадахгүй ч дундаж шившлэгүүд болон хараалаас хамгаална ...



- Дараа нь бид хар урлагаас хамгаалах руу орон гүнзгийрэхээр шийдсэн. Энэ ч жинхэнэ мөнгөний ажил даа! Сайхан зүйл байгаа юм! Харж байна уу тэнд бидний Перугаас оруулж ирсэн хар дарь байна. Чи хэн нэгнээс түргэхэн зугтахыг хүссэн бол их тохиромжтой.

- Харин манай хуурамч сатааруулагч тавиур дээр алхаад явж байна гээд Фред бүрээ санагдуулам хар зүйлийг заахад тэд түлхэлцэн нуугдахыг хичээж байв.

- Ийм зүйлээс хэдийг газар анзаарагдалгүй унагачихсан байхад зүг бүр тийш гүйлдэн чанга чимээ гаргана.

- Эвтэйхэн юм гэж Харри бахдав.

- Үүнийг ав гээд гэж Жорж хоёрыг Харрид өглөө.

Хөшигний цаанаас богинохон цайвар үстэй залуухан шидтэн шагайв. Харри түүний бас улаан жанч өмссөн болохыг харлаа.

- Тэнд худалдан авагчид тогоо эрж байна, ноён Уизли болон ноён Уизли гэж мэдэгдэв.

Харри Фред, Жорж хоёрыг ноён Уизли гэж дуудахад сонсож дасаагүй ч тэд тэгэх ёстой юм шиг хүлээж авав.

- Баярлалаа, Верити би очлоо гэж Жорж түргэн хэлээд,

- Харри чи хүссэн зүйлээ аваарай за юу? Чамаас төлбөр авахгүй гэлээ.

- Би чадахгүй! гэж Харри эсэргүүцлээ. Тэр хэдийн сатааруулагчын мөнгийг төлөхөөр түрийвчээ гаргаж иржээ.

- Энэ дэлгүүрт чамаас мөнгө авахгүй гэж Фред хатуу хэлээд Харрийн мөнгийг буцааж түлхэв.

- Гэхдээ ...

- Чи бидэнд эхлэлийн хөрөнгө өгснийг санаж байна. Юу хүссэнээ аваад зөвхөн хаанаас авсныг асуусан хүмүүст манай дэлгүүрийг сурталчилахаа бүү мартаарай гэж Жорж хэллээ.

- Жорж хөшигний араас гарч худалдан авагч нарт туслахаар явахад Фред Харрийг Гермiona, Жинни хоёр патентлагдсан мөрөөдлийн ид шид харж буй танхим руу хүргэв.

- Охидоо манай тусгай худалдаа болох «Гайхалтай шидтэн»-г үзэхгүй юм уу? Миний араас, хатагтай нараа ... гэж Фред мэдэгдэв.

Тэд цонхны дэргэд ягаан шилтэй зүйлийн бүхэл бүтэн үзэсгэлэнг тойроод хэсэг охид зогсон инээлдэхийг харлаа. Гермiona, Жинни хоёр болгоомжлон харцгаав.

- Өршөөнө үү! Зөвхөн бидэнд л хамгийн шилдэг хайрын ундаа байгаа! гэж Фред бардам хэлэв.

Жинни хөмсгөө сэжиглэнгүй өргөлөө.

- Тэд яаж үйлчилдэг юм?
- Хорин дөрвөн цагийн дотор бүх хөвгүүдэд түргэн үйлчилэн ...
- Охидод дурлуулах болно гэж тэдний дэргэд ирсэн Жорж яриаг дуусгаснаа гэнэтхэн ширүүнээр,
- Гэхдээ бид дүүдээ худалдахгүй. Түүнд үүнтэй үүнгүй таван дагалдагч байгаа гэж нэмэрлэв.
- Роныг бүү сонс тэр чинь худал хэлж байгаа юм гэж Жинни хүйтнээр хэлээд тавиур дээрээс жижигхэн ягаан сав авлаа.
- Энэ юу вэ?
- Арван секундын дотор батга арилгагч. Хар толботой батганд маш сайн үйлчилнэ гэсэн ч сэдэв өөрчлөгдөхгүй. Чи одоо Дин Томас гэдэг залуутай уулзаж байгаа гэсэн чинь үнэн үү?
- Тиймээ уулзаж байгаа. Биднийг сүүлд уулзах үед тэр тав биш нэг байсан. Энэ чинь одоо юу вэ?

Жинни торны ёроолд өнхрөлдөн часхийсэн дуугаар орилолдох үс ноостой ягаан бөмбөлөг рүү заалаа.

- Жижигхэн одой бөмбөлөг бид тэднийг хангалттай тэжээж чадахгүй байгаа. Ингэхэд чиний Майкл Корнер юу болоо вэ?
- Би түүнийг хаясан гээд Жинни тор луу хуруугаа сунгахад үстэй бөмбөлөгнүүд цугларлаа.
- Ямар хөөрхөн юм бэ!
- Тиймээ тэд аятайхан гэж Фред зөвшөөрснөө,
- Гэхдээ чи залуучуудыг бээлий шиг хэтэрхий яаран сольж байгаа юм биш үү? гэлээ.

Жинни ах руугаа гараа ташаандаа аван эргэлээ. Түүний ширүүн төрх хатагтай Уизлиг санагдуулахад Харри тэр ч байтугай Фред яагаад айхгүй байгааг гайхлаа.

- Энэ чамд хамаагүй! Харин чамайг ах нартаа миний тухай хэлэхгүй бол баярлах байна гэж саяхан Жоржын дэргэд гартаа дүүрэн бараа таваартай ирсэн Ронд хандан ууртай хэлэв.

Фред Роны гар дахь хайрцагыг тооллоо.

- Гурван галеон, есөн сикль нэг кнат. Алив тооцоогоо хий!
- Би дүү чинь биз дээ!
- Харин энэ манай бараа. Гурван галлон, есөн сикль. Нэг кнатыг нь хаслаа.
- Надад гурван галлеон есөн сикль байхгүй!
- Тэгвэл бүгдийг байсан газар нь буцааж тавьсан чинь дээр.

Рон хэдэн хайрцаг унагаад Фредийг хараан зохимжгүй хөдөлгөөн үзүүлэхэд азгүй нь гэвэл энэ агшинд хатагтай Уизли ирлээ.

- Чамайг ахиж ингэж байхыг харах юм бол гарыг чинь атгаж чадахааргүй болтол илбэднэ шүү гэж тэр хашгирав.
- Ээжээ би үстэй бөмбөлөг авч болох уу? гэж Жинни асуув.
- Юу гэнээ? хэмээн хатагтай Уизли болгоомжлон асуулаа.
- Хардаа, ямар хөөрхөн болохыг нь ...

Хатагтай Уизли үстэй бөмбөлөг харахаар явах үед Харри, Рон, Гермиона гурав цонх руу харлаа. Гудамжинд Драко Малфой ганцаар эхгүй явж байв. Тэр «Уизлийн шидэт эдлэлүүд» дэлгүүрийг өнгөрөхдөө мөрөн дээгүүрээ харлаа. Агшины дараа цонхноос холдон хараанаас алга болов.

- Тэр ээжгүйгээрээ хаашаа явж байгаа юм бол? гэж Харри хөмсөг зангидав.
- Түүнээс бултчихаж гэж Рон хэлэв.
- Яах гэж тэр вэ? хэмээн Гермиона гайхлаа.

Харри чимээгүй болж бодлогоширов. Нарцисса Малфой үнэт хүүгээ хараанаасаа тийм амархан алдахгүй. Малфойд түүний сарвуунаас мултрах нь их хэрэгтэй байж. Харри Малфойн талаар сайн мэддэг болохоор санаатайгаар гэдэгт өчүүхэн ч төдий эргэлзсэнгүй.

Тэр ийш тийшээ харлаа. Хатагтай Уизли, Жинни хоёр үстэй бөмбөлөг рүү тонгойжээ. Ноён Уизли маглуудын дүрстэй хөзрийг хөөрөн харна. Фред, Жорж хоёр худалдан авагчидтай завгүй байв. Шилний цаана Хагрид нуруугаа харуулан зогсоод гудамж ширтэнэ.

- Ийшээ түргэлээрэй! гээд Харри цүнхнээсээ үл үзэгдэх жанчаа гаргалаа.
- Өө ... би мэдэхгүй байна Харри гээд Гермиона итгэлгүйхэн хатагтай Уизли руу харлаа.
- Алив л дээ! гэж Рон шавдуулав.

Гермиона агшин зуур тээнэглзсэнээ Харри, Рон хоёрын хамт жанчин дор шурган орлоо. Бүгд Фред, Жорж хоёрын барааг сонирхож байсан тул тэдний алга болсныг хэн ч ажигласангүй. Харри, Рон, Гермиона гурав шахцалдан үүдээр түргэн гудамж руу гарлаа. Малфой бас үл үзэгдэх цувтай аятай үзэгдэхээ больжээ.

- Тэр тийшээ явсан. Алив! гэж Харри хамар дороо юм гүнгэнэж буй Хагридад сонсогдохгүйн тулд аяархан хэллээ.

Тэд гудамжаар явж ийш тийш дэлгүүрийн үүд цонх өөд харахад Гермиона урагшаа заагаад,

- Тэр байна! Зүүн тийшээ эргэчихлээ! гэв.
- Яаж дээ гэж Рон шивнэлээ.

Малфой эргэн тойрноо харснаа Догшин гудамж руу орлоо.

- Түргэлээрэй бид түүнийг алдах нь байна гээд Харри хурдаа нэмлээ.
- Бидний хөл харагдах нь байна! гэж Гермиона түгшихэд үл үзэгдэх цув шагайных нь хажууд хөвж гурвуулаа зэрэг нуугдахад хэцүү болсон байв.
- Тэр хамаагүй. Түргэлээрэй! гэж Харри тэвчээргүйхэн хэлэв.

Гэвч Догшин гудамжны хар урлагийн дэлгүүрүүд хоосон байлаа. Найзууд эргэн тойрны үзмэрийн цонх руу харсан авч нэг ч мухлагт худалдан авагч байсангүй. Харри энэ аюултай сэжигтэй үед хэн ч хар урлагтай холбоотой зүйл худалдан авч харагдахыг хүсээгүй байх гэж бодлоо.

Гермиона гараас нь өвдтөл чимхэв.

- Ёо!
- Чш-ш! Хараач! Тэр энд байна! гэж Харрийн чих рүү шивнэв.

Тэд Харрийн нэг удаа Догшин гудамжинд ирэхдээ орж байсан дэлгүүр лүү ухасхийв. Энэ бол «Горбин ба Бэркс» мухлаг байсан бөгөөд муу ёрын хэрэгслийн томоохон цуглуулга зардаг байлаа. Дүүрэн гавлын яс, хуучин лонхоор дүүрэн лангууны хажууд Драко Малфой цонх руу нуруугаа харуулан зогсож байв. Түүний биеийн нэг хэсэг нь Харрийн Малфой болон ааваас нь нуугдаж байсан том хар шүүгээнд далдлагджээ. Малфой гараа хөдөлгөн ямар нэг зүйлийн талаар ярьж байв. Түүний эсрэг талд мухлагын эзэн тослог үстэй бөгтөр ноён Горбин зогсчээ. Түүний царай таагүй айсан төрхтэй байлаа.

- Тэдний юу ярьж байгааг сонсох юмсан! гэж Гермиона хэлэв.
- Болно шүү дээ! гэж Рон баярлаад,
- Хүлээгээрэй ... Түй, чөтгөр гэж! шивнэлээ.

Тэр гартаа байсан хэдэн хайрцагыг унагаад хамгийн томыг нь онгойлгов.

- Хараач. Уртасгагч чих!
- Гайхамшигтай! гээд Гермиона Рон хэрхэн биений өнгөтэй урт олсыг дэлгэн хаалганы доогуур шургуулахыг харав. Өө, хаалга хүрч болохгүй шившлэгтэй битгий байгаасай билээ ...
- Үгүй ээ, тэнд цэвэр байна! Сонсооч! гэж Рон баяртай мэдэгдэв.

Гурвуулаа тонгойн олсны үзүүрээс барин сонсоход Малфойн хоолой радиогоор ярьж байгаа юм шиг тод сонсогдов.

- Та энэ зүйлийг яаж засахыг мэдэх үү?
- Магадгүй л юм гэж Горбин дурамжхан дуугарлаа. Гэхдээ би түүнийг харах хэрэгтэй. Та яагаад энд авчирч болохгүй гэж?
- Чадахгүй. Тэр байрандаа үлдэх ёстой. Та надад зөвхөн юу хийх ёстойг нь хэлчих.

Харри Горбин уруулаа долоохыг харлаа.

- Тэгвэл би ганц л зүйлийг хэлж чадах байна. Энэ бол маш хүнд ажил бөгөөд боломжгүй ч байж магадгүй. Би ямар ч баталгаа өгч чадахгүй.

- Боломжгүй гэнээ? Та үүндээ итгэлтэй байна уу гэж Малфой басамжлангуй хэлэв.

Тэр Горбин руу алхаад шүүгээний цаагуур далд оров. Харри, Рон, Гермиона гурав түүнийг хараанаас алдахгүйн тулд хажуу тийш болсон ч зөвхөн Горбин харагдаж байв. Тэр үхтлээ айсан байлаа.

- Хэн нэгэнд хэлэх юм бол хатуу цээрлүүлнэ шүү. Фенрир Сивог мэдэх үү? Тэр манай гэр бүлийн эртний найз болохоор чамайг энэ асуудлыг шийдэх хүртэл үе үе ирж байх болно.

- Үгүй ямар ч хэрэггүй ...

- Үүнийг би шийднэ! За, би явлаа. Тэгээд нэгийг нь аюулгүй хадгалж байхаа бүү мартаарай. Надад дараа хэрэгтэй.

- Та одоо авч явж болохгүй юм уу?

- Үгүй тэнэг минь, би үүнийг яаж гудамжаар авч явах юм? Өөртөө хадгалаад хэнд ч бүү худалдаарай.

- Ямар ч тохиолдолд ... эрхэмээ.

Горбин Харрийн нүдэн дээр Люциус Малфойд бөхийн ёсолж байсаны адил гүнзгий бөхийн ёслов.

- Энэ тухай хэнд ч миний эхэд хүртэл бүү хэлээрэй ойлгомжтой юу, Горбин?

- Тэгэлгүй яахав гэж Горбин бувтнаад ахин бөхийн ёсоллоо.

Дараагийн агшинд хаалганы хонх чанга жингэнэхэд Малфой мухлагаас сэтгэл хангалуун гарч одлоо. Тэр Харри, Рон, Гермиона нарын дэргэдүүр ойрхон өнгөрөхөд өвдөгнийх нь жанч хийсэх нь мэдэгдэв. Дэлгүүрийн дотор Горбин хөшсөн юм шиг зогсч үлдээд нялуун инээмсэглэл нь алга болж түгшсэн царайтай боллоо.

- Энэ чинь юу гэсэн үг юм бол? гэж Рон Уртасгагч чихээ хумин аваад асуув.

- Мэдэхгүй гэж Харри бодлогоширон хэлээд,

- Тэр ямар нэг зүйлийг засахыг хүсэж байна ... бас өөр нэг зүйлийг хэрэг болох хүртэл хадгалахыг хүслээ ... та нар түүний энэ гэж юу заасныг харсан уу?

- Үгүй, тэр шүүгээний ард байсан ...

- Та хоёр энд хүлээж байгаарай гэж Гермиона шивнэлээ.

- Чи хаачих нь вэ?

Гэвч Гермиона хэдийн жанчин дороос шурган гарчээ. Тэр үзмэрийн цонхонд үсээ шалган харснаа мухлаг руу ороход ахин хонх жингэнэлээ. Рон яаран хаалган доогуур Уртасгагч чихийг шургуулаад нэг үзүүрийг нь Харрид өглөө.

- Сайн уу, өнөөдөр аймшигтай цаг агаартай байна тийм үү? гэж Гермиона эзэнд хөгжилтэй хэлэв.

Горбин хариулсангүй сэжигтэй хялайн харлаа. Гермиона хөгжилтэй дуу аялсаар лангуунд өрөөстэй зүйлүүдийг үзлээ.

- Энэ зүүлтийг худалдах уу? гэж тэр асуугаад шилэн лангууны өмнө зослоо.

- Хэрвээ таньд таван зуун галлеон байвал гэж Горбин хүйтнээр хэлэв.

- Өө. .. үгүй дээ ... надад ийм их мөнгө байхгүй гээд Гермиона цааш явлаа.

- Харин энэ дур булаам ... м-м ... сайхан гавал?

- Арван зургаан галлеон.

- Тэгэхээр түүнийг худалдах юм биз дээ? Та түүнийг ... хэн нэгэнд зориулж хадгалаагүй юу?

Горбин түүнийг анхааралтай дагуулан харлаа. Харрийн дотор мухлагын эзэн Гермиона юун тухай ярьсныг мэдэж байна гэсэн таагүй мэдрэмж төрөв. Гермиона ч бас үүнийг ойлгосон бололтой гэнэтхэн болгоомжтой болов.

- Та ... саяхан энд байсан хүүг харсан байлгүй, Драко Малфой. Тэр миний найз залуу болохоор төрсөн өдрөөр нь юм худалдаж авч өгөх гэсэн юм. Гэхдээ тэр энд хэдийн юм захиалсан бол би тийм зүйл бэлэглэхийг хүсэхгүй байна л даа

... мм ...

Харрийн бодлоор түүх маш тааруухан боллоо Горбин ч бас тэгж бодов бололтой.

- Зайл! Эндээс зайл! гэж ууртай хэлэв.

Гермиона хоёр удаа давтуулахыг хүлээсэнгүй хаалга руу ухасхийлээ. Горбин түүний араас өсгий даран мөрдөв. Хонх ахин нэг жингэнэхэд Гермионагийн ард хаалга хаагаад «Хаалттай» гэсэн хаяг өлгөлөө.

- Дэндүү илэрхий зүйл хэлэх юм ... гэж Рон Гермионаг жанчин дор орж ирэхэд хэлэв.

- Дараагийн удаа чи надад яаж хийдгийг нь үзүүлээрэй нууцлаг мастер минь! гэж тэр тасхийлээ.

Рон, Гермиона «Уизлийн шидэт эдлэлийн дэлгүүр» лүү буцах замын турш маргалдав. Тэд байхгүйг нь мэдээд сэтгэл зовсон хатагтай Уизли, Хагрид хоёрын дундуур ажиглагдамгүй орлоо. Дэлгүүрт ороод Харри найзуудаа үл үзэгдэх цуван дороос гарган, цуваа цүнхэндээ эвхэж хийгээд хатагтай Уизли тэр гурвыг шалгаахаар ирэхэд энэ хугацаанд арын өрөөнд байсан, та нар муу хайж гэж хэлээ.

## БҮЛЭГ 7: СЛИЗНЕЙН КЛУБ

Харри амралтын үлдсэн долоо хоногийн ихэнхи хэсгийг Малфойн Догшин гудамжинд хийсэн айлчлал юу болохыг бодож өнгөрүүлэв. Ялангуяа түүнийг Малфойн сэтгэл хангалуун мухлагаас гарсан царай түгшүүлж байлаа. Түүнийг баярлуулах зүйл зөвхөн ямар нэг өөдгүй зүйл байж таарна. Гэхдээ Харригийн уурыг хүргэн Рон, Гермиона хоёр Малфойн үйл ажиллагааг огт сонирхсонгүй.

- Тиймээ, Харри би үүнийг сэжигтэй болохыг нь хүлээн зөвшөөрч байна гэдгээ хэлсэн. Гэхдээ бид түүнд олон янзын тайлбар байж болохыг зөвшөөрсөн биз дээ? гэж Гермиона тэвчээр алдан хэллээ. Тэр Фред, Жорж хоёрын өрөөний цонхны тавцан дээр суугаад нэг хөлөө цаасан хайрцаг дээр тавьж «Эртний дүрс бичгийн орчуулга» гэдэг шинэ сурах бичгээ дургүйхэн эргүүлж байв.

- Магадгүй түүний алдрын гар хугарсан байж болох юм. Түүнд нэг тийм хатсан гар байсныг санаж байна уу? гэж шүүрнийхээ сүрлийг тэгшилэхийг оролдож байсан Рон хэлэв.

- Тэгвэл тэр яагаад нэгийг нь аюулгүй хадгалж байхаа бүү мартаарай гэж хэлсэн юм бэ? гэж Харри зуу дахь удаагаа асуугаад,

- Энэ чинь Горбинд өөр нэг эвдэрсэн зүйл байгаад Малфой хоёуланг нь хүсч байгаа юм шиг сонсогдож байгаа биз дээ гэв.

- Чи тэгж бодож байна уу? гэж Рон бувтнаад шүүрний ишний шороог маажин арилгахыг оролдов.

- Тиймээ, би тэгж бодож байна гэж Харри батлаад,

- Малфойн эцэг Азкабанд сууж байгаа болхоор тэр өшөөгөө авахыг хүсч байгаа гэж бодож байна уу? гэв.

Рон толгойгоо өргөөд нүдээ анивчлаа.

- Малфой өшөө авах гэнээ? Тэр чадна гэж үү?

- Би үүний чинь л талаар яриад байна. Чадах эсэхийг нь мэдэхгүй юм. Гэхдээ маш чухал зүйлд хамаатай бодож байна. Түүний эцэг нь Үхэл залгигч болохоор ...

Харри чимээгүй болоод Гермионагийн арын цонхыг амаа ангайн ширтлээ. Түүнийг гэнэтийн бодол цочирдуулав.

- Харри? Юу болоо вэ? гэж Гермиона түгшлээ.

- Чиний сорви ахиад өвдсөн юм уу? гэж Рон айн асуулаа.

- Тэр өөрөө Үхэл залгигч гэж Харри удаанаар хэлээд,

- Тэр эцгийнхээ оронд Үхэл залгигч болж! гэлээ. Нам гүм болоход Рон инээд алдав.

- Малфой юу? Тэр чинь ердөө арван зургаан настай, Харри! Чи Хэцүү нэрт

Малфойг эгнээндээ авна гэж бодож байгаа хэрэг үү?

- Үнэмшихэд бэрх юм, Харри. Чи хаанаас тэгж бодоо вэ? гэж Гермиона залхсан янзтай дуугарав.

- Хатагтай Малкиныг санаж байна уу. Тэр түүнд хүрээгүй зөвхөн ханцуйг нь дээшлүүлэхийг хүсэхэд орилсон. Түүний зүүн гар дээр Хар тамга байсан байж таарна.

Рон, Гермиона хоёр бие бие лүүгээ харлаа.

- Гэхдээ ... гэж Рон итгэлгүйхэн хэлэв.

- Би түүнийг зүгээр л түргэхэн гарахыг хүссэн гэж бодож байна, Харри гэж Гермиона хэлэв.

- Тэр Горбинд ямар нэг юм үзүүлэхэд бид хараагүй гэж Харри зөрүүдлээд,

- Тэгэхэд Горбин их айсан байсан. Энэ Хар тамга болохыг нь би мэдэж байна ... Тэр үүнийгээ Горбинд үзүүлсэний дараа ямар чухлаар хүлээн авахыг нь та нар харсан биз дээ! гэв.

Рон, Гермиона хоёр ахин бие бие лүүгээ харлаа.

- Би итгэлтэй биш байна, Харри ...

- Тийм шүү, би Хэцүү нэрт Малфойг өөртөө элсүүлнэ гэж бодохгүй байна ...

Уурссан хэдий ч өмнөхийн адил өөрийн зөв гэдэгт итгэлтэй байсан Харри квиддичийн бохир жанчаа шүүрч аван өрөөнөөс гарлаа. Хатагтай Уизли тэднийг угаалгах зүйлээ цаг тулган өгөхгүй байхыг шаарддаг байсан юм. Тэр шатны талбай дээр өрөө лүүгээ цэвэр хувцастай буцаж байгаа Жиннитэй мөргөлдлөө.

- Би чиний оронд байсан бол одоо гал зуух руу орохгүй байсан даа. Тэнд Флегми асгаруулж байгаа гэж анхааруулав.

- Хальтирахгүй байхыг хичээе гэж Харри инээмсгэлэв.

Тэгтэл ч үнэхээр гал зууханд орох үед Флер ширээний ард суугаад Биллтэй хийх хуримын тухай төлөвлөгөө дэлгэж хатагтай Уизли баргар царайлан брүселлийн байцаа арилгаж байв.

- Билл бид хоёр бэрийг дагах бүсгүй хоёр байх ёстой гэж шийдсэн. Жинни, Габ'гиэль хоёр х'мтдаа их хөөрхөн харагдана. Би тэдэнд цайвар алтлаг хувцас өмсгөвөл зүгээр юмуу гэж бодож байгаа ... Ягаан өнгө Жиннигийн 'стэй зохьцохгүй 'ймшигтай харагдана ...

- Өө, Харри! гэж хатагтай Уизли Флерийн эх адаггүй хөрвүүлэлтийг таслан чангаар хэлээд,

- Сайн байна, би чамд маргааш та нарыг Хогвартс буцахад хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах гэж байгаа талаар ярих гэж байсан юм. Бидэнд ахиад

ид шидийн яамнаас машин өгч буудал дээр мракоборецууд хүлээж байх болохоор ...



- Тонкс бас байх уу? гээд Харри хатагтай Уизлид спорт хүрмээ өглөө.
- Үгүй ээ, тэгж бодохгүй байна. Артур түүнийг өөр газар жижүүрлэж байгаа гэж хэлсэн санагдаж байна.
- Тэр үргэлж Тонксын тухай ярьж байх юм. Би үүнийг том алдаа гэж бодож байна ... гэж Флер гүн бодлогоширон бувтнаад нүд гялбам тусгалаа цайны халбаганд харав.
- Тиймээ, тийм баярлалаа гэж хатагтай Уизли Флерийн яриаг ахин таслаад,
- Чи явж юмаа янзалсан чинь дээр байх, Харри. Маргааш бид ердийнх шигээ бужигналдахгүй байх шүү гэв.

Тэгтэл ч үнэхээр маргааш өглөө дасал болоогүй тайван байлаа. Ид шидийн яамны машин довжоон дээр ирэхэд бүгдийн ачаа тээш бэлхэн байж Гермионагийн муур Живоглот аян замын сагсанд найдвартай түгжээстэй, Хэдваг, Роны Гахай болон, Жиннигийн шинэ ягаан үстэй бөмбөлөг Арнольд торон дотроо сууж байлаа.

- Өө 'Арри гээд Флер салах ёс гүйцэтгэн түүнийг үнслээ.

Рон ч гэсэн урагш найдангуй тэмүүлсэн авч Жинни дэгээ тавиад Флерийн хөлд харуулдан унагачихлаа. Тэр уурсаж улайгаад салах ёс гүйцэтгэлгүй шалавхан машинд орж суув.

Кингс Кросс буудал дээр тэднийг баясан гийсэн Хагрид угтсангүй. Түүний оронд баргар төрх бүхий сахалтай маглуудын хүрэм өмссөн хоёр мракоборец байсан бөгөөд машин зогсмогц урагш алхан чимээгүйхэн зэрэгцэн зогсоод бүгдийг буудлын барилга руу оруулав.

- Түргэлээрэй хаалт руу гэж ширүүн төрхтэй мракоборецуудыг харж сандарсан хатагтай Уизли яаруулав. Харри түрүүлж яваарай, түүнтэй ...

Тэр нэг мракоборец руу асуунгүй харахад толгой дохиод Харрийн гараас барьж есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцангийн хаалт руу явав.

- Баярлалаа би өөрөө явж чадна гэж Харри уурсан хэлээд гараа татан авлаа.

Тэр тээшийн тэргээ хаалт руу түлхэхдээ чимээгүй дагалдагч руугаа харсангүй. Хормын дараа «Хогвартс экспресс» буухиа галт тэрэгнээс өтгөн утаа суунаглах есөн бүхэл дөрөвний гурав дугаар тавцан дээр зосож байлаа.

Түүний дэргэд Гермиона болон Уизлийнхан ирэв. Харри ширүүн мракоборецоосоо зөвшөөрөл хүлээлгүй Рон, Гермиона хоёрыг хоосон тасалгаа хайхаар хамт явъя гэж зангалаа.

- Бид чадахгүй, Харри. Рон бид хоёр ахлагч нарын эхний вагонд явж хонгилоор эргүүл хийх ёстой гэж Гермиона уучлал гуйсан маягтай хэллээ.
- Өө тийм л дээ, би мартчихаж гэж Харри бувтнав.
- Алив түргэн галт тэргэндээ ороорой хөдлөхөд ердөө хэдхэн минут үлдэж гэж хатагтай Уизли цагаа харан хэлснээ,

- Хичээлийн жилд чинь амжилт хүсье, Рон ... гэв.
- Ноён Уизли би таньтай хэдэн үг сольж болох уу? гэж Харри гэнэтхэн асуулаа.
- Тэгэлгүй яахав.

Ноён Уизли Харрийн араас үл мэдэг гайхширан дагаад бусдын чихэнд сонсогдохооргүй газар хүрэв.

Харри бүгдийг урьдчилан бодож үзээд өөрийн таавраа хэлвэл хамгийн зохих хүн ноён Уизли гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Нэгдүгээр тэр ид шидийн яаманд ажиллаж байгаа учир хэн нэгнийг мөрдөн шалгахад туйлын зохимжтой, хоёрдугаарт гэвэл уурлах эрсдэл бага байлаа.

Харри хатагтай Уизли болон ширүүн мракоборецууд тэднийг сэжигтэй харцаар үдэхийг харав.

- Биднийг Тахир гудамжинд байхад гэж Харри эхэлсэн ч ноён Уизли ярвайн яриаг нь тасаллаа.
- Би үнэхээр Гермiona, Рон та гурав Фред, Жорж хоёрын арын өрөөнд байхдаа хааш алга болсны учрыг мэдэх нь энэ үү?
- Та хаанаас ...
- Харри, чи Фред, Жорж хоёрыг өсгөсөн хүнтэй ярьж байна!
- Э-э ... Тиймээ зөв, бид арын өрөөнд байгаагүй.
- Их сайн байна. Тэгвэл хамгийн мууг нь сонсоё.
- Ойлгож байна уу, бид Драко Малфойн араас дагасан юм. Үл үзэгдэх цуван дор нуугдаад.
- Та нарт шалтгаан байсан юмуу эсвэл өөрсдөө тэгж хүссэн юм уу?
- Учир нь надад Малфой ямар нэг зүйл төлөвлөсөн юм шиг санагдсан гэж Харри тайлбарлахдаа ноён Уизлийн шоолонгуй төрхийг анхаарахгүй байхыг хичээв. Тэр ээжээсээ салаад би энэ нь түүнд ямар учраас хэрэг болсныг мэдэхийг хүссэн юм.
- Тэгэлгүй яахав. Тэгээд юу мэдэв дээ? гэж ноён Уизли санаа алдлаа.
- Тэр «Горбин ба Бэркс» мухлаг руу очсон. Тэнд Горбиныг дарамтлан ямар нэг зүйлийг засахад туслахыг шаардсан. Бас Горбиныг юм хадгалахыг хүссэн. Тэр нь засах гээд байгаа зүйлтэй нь адилхан юм шиг байсан. Хоёр байсан байх. Бас ... гээд гүнзгий амьсгаа авснаа,
- Бас нэг зүйл. Бид нар Малфойг хатагтай Малкин зүүн гарт нь хүрэхийг хүсэхэд хойш үсрэхийг харсан. Би тэнд Хар тамга байсан гэж бодож байна. Тэр эцгийнхээ оронд Үхэл залгигч болсон байх гэв.

Ноён Уизли гайхширан чимээгүй болсноо,

- Харри би Хэцүү нэрт арван зургаан настай хүүг авна гэдэгт эргэлзэж байна ... гэв.

- Хэцүү нэргийн чадах эсэхийг хэн мэдэх юм бэ? гэж Харри уурсаад,
  - Ноён Уизли намайг уучлаарай. Гэхдээ үүнийг шалгаж болохгүй юу? Хэрвээ Малфой ямар нэг зүйл засахыг хүсэн үүний тулд Горбиныг сүрдүүлж байгаа бол харшидийн ямар нэг осолтой зүйл байх тийм үү? гэв.
  - Үнэнийг хэлэхэд Харри би үүнд чинь эргэлзэж байна гэж ноён Уизли удаанаар хэлээд,
  - Люциус Малфойг баривчилсны дараа бид гэрийг нь анхааралтай нэгжээд аюултай байж болох бүх зүйлийг хураасан гэв.
  - Та нар юм орхисон байлгүй гэж Харри зөрүүдэв.
  - Болох л юм гэж ноён Уизли маргахыг хүссэнгүй бололтой дуугарлаа.
- Тэгтэл тэдний ард шүгэл дуулдаж бараг бүх хүүхэд суусан галт тэрэгний хаалга хаагдлаа.
- Чи яарсан чинь дээр байх! гэж ноён Уизли хэлэхэд хатагтай Уизли,
  - Харри, түргэлээрэй! гэж хашгирлаа.

Тэр галт тэрэг рүү гүйхэд ноён ба хатагтай Уизли чемоданыг нь оруулахад туслав.

- Удахгүй уулзая хонгор минь, бидэн дээр зул сараар ирээрэй. Бид хэдийн Дамблдортой тохиролцсон! гэж хатагтай Уизли Харрийн араас хашгирахад галт тэрэг байрнаасаа хөдөллөө.
- Өөрийгөө бодож яваарай ... Галт тэрэг хурдаа авч эхлэв.
- ... бас биеэ сайн авч яваарай ... Тэр хэдийн араас нь гүйж эхэлжээ.
- ... таагүй явдалд бүү орооцолдоорой!

Харри галт тэрэг булан тойрохоос өмнө ноён ба хатагтай Уизли руу гар даллаад эргэж бусад нь хаачсаныг харав. Рон, Гермиона хоёр харваас эхний вагонд бусад ахлагч нарын хамт суухаар явсан бололтой, Жинни найзуудтайгаа хонгилд ярьж байв. Харри түүний зүг тээшээ чирэн явлаа.

Хүмүүс түүн рүү нүд салгахгүй ширтэнэ. Тэдний дэргэдүүр өнгөрөхөд зарим сурагчид тасалгааныхаа шилэн цонхонд хамраа наан харж байлаа. Тэр энэ хичээлийн жилд «Зөнч» сонины сонгогдсон гэсэн цуу ярианаас болж анхаарал татна гэдгээ мэдэж байсан ч хурц гэрэлтэй прожектор тусгасан мэт эвгүй байлаа. Тэр Жиннигийн мөрөнд хүрлээ.

- Явж сул өрөө олох уу?
- Чадахгүй нь Харри. Би Динтэй уулзана гээд амалчихсан. Дараа уулзъя! гэж Жинни хөгжилтэй хэлэв.
- За яахав гэж Харри хэллээ.

Түүнийг урт шаргал үсээ савчуулан холдоход яагаад ч юм дотор нь хачирхалтай мэдрэмж төрөв. Тэр зун дэргэдээ байхад нь дассан болохоор сургуульд Рон,

Гермиона хоёрыг бодвол бага харьцдагаа мартсан байлаа. Харри анивчин эргэж харахад хэсэг шагширсан охид тойрон хүрээлэв.

- Сайн уу, Харри! гэх танил дуу түүний ард сонсогдов.
- Невилл! гэж Харри баярлаад эргэж харахад дугуй нүүртэй хүү урдаас нь зүтгэлэн ирлээ.
- Сайн уу, Харри гэж Невиллийн араас ирж байсан урт үс, том бүүдгэр нүдтэй охин хэлэв.
- Полумна сайн уу, амьдрал ямар байна даа?
- Маш сайн, баярлалаа.

Тэр хавтсан дээрээ том үсгээр хос нүдний шил үнэгүй өгнө гэж бичсэн сэтгүүл энгэртээ тэвэрчээ.

- «Шүүмжлэгч» цэцэглэж байна уу? гэж Харри өнгөрсөн онд түүний ярилцлагыг нийтэлсэн явдалд таатай ханддаг болсон болохоор асуулаа.
- Өө, тийм шүү гүйлгээ нь гурав дахин нэмэгдсэн гэж Полумна сэтгэл хангалуун хэлэв.
- Явж өрөө олох уу гэж Харри санал болгоод гурвуул цааш явахад сурагчид тэднийг чимээгүйхэн дагуулан харлаа.

Тэд эцэст нь сул өрөө олоход Харри түрүүлж оров.

- Биднийг чамтай явж байгаа болохоор хараад байна гэж Невилл Полумна болон өөрийгөө зааж хэлэв.
- Та нарыг ид шидийн яаманд байсан учир харж байгаа юм гэж Харри эсэргүүцээд чемоданаа тээшийн тавиур руу гаргаж,
- Чи бидний адал явдлын тухай «Өдөр тутмын Зөнч» сонинд бичсэнийг уншсан байлгүй гэв.
- Би эмээг уурлах байх гэж бодсон ч эсрэгээрээ баярласан шүү. Намайг эцэстээ аавтайгаа төстэй болж байна гэж хэлсэн. Бүр надад шинэ саваа худалдаж авч өгсөн, хараач!

Тэр саваагаа гарган Харрид үзүүлэв.

- Интоорын мод ганц эвэртийн хялгас гэж бардам хэлээд,
- Бид үүнийг Оливандерын худалдсан сүүлчийн саваа байх гэж бодож байна, тэр маргааш өдөр нь алга болсон болохоор. ... Одоохон эргээд ир, Тревор!

Невилл чөлөөлөгдөх ээлжит оролдлогоо хийж буй бахаа барихаар суудал доогуур тонгойлоо.

- Бид нар энэ жил ДА-гаар хичээлэх үү, Харри? гэж Полумна асуугаад «Шүүмжлэгч» сэтгүүлийн голд байсан солонгорсон нүдний шилийг мулталж авлаа.

- Одоо Амбрижаас салсан болохоор ямар хэрэгтэй гэж хэмээн Харри хэлээд суув.

Невилл суудал падхийгтэл мөргөөд дороос нь урам хугарсан төрхтэй цухуйлаа.

- Харин надад ДА таалагдаж байсан юмсан! Би чамаас их зүйл сурсан!

- Надад ч гэсэн таалагдсан. Бид бүгд найзууд болсон гэж Полумна хэлэв.

Полумна үргэлж амаргүй ярьдаг учир Харрийн дотор ичиж өрөвдөх сэтгэл зэрэгцэн төрлөө. Түүнийг хариулж амжаагүй байтал тасалгааны гадаа хөл хөдөлгөөн дэгдэж дөрөвдүгээр дамжааны хэсэг охид хөхрөлдөн цонхоор шагайв.

- Түүнээс асуу!

- Үгүй, чи асуу!

- Би орьё!

Тэдний хамгийн зоригтой хар нүдтэй, товгор эрүүтэй урт хар үстэй охин хаалга түлхэн орж ирэв.

- Сайн уу, Харри. Би Ромилда, Ромильда Вейн гэж итгэлтэй чанга хэлээд,

- Манай өрөөнд орохыг хүсэж байна уу. Чи эд нартай заавал суух албагүй гээд жүжигчилсэн байдалтай суудал доогуур бахаа эрэн тэмтчиж байгаа Невилл болон солонгорсон уультай төстэй шил зүүсэн Полумна руу заалаа.

- Эд нар миний найзууд гэж Харри хүйтнээр хэлэв.

- Өө! гэж охин гайхшираад,

- Тэгвэл ч яахав гэлээ.

Тэр гарахдаа хаалга чанга хаалаа.

- Хүмүүс чамайг бидэн шиг найзтай байх ёсгүй гэж бодож байна гэж Полумна ахин цэвэр үнэнийг хэлэв.

- Чи шилдэг шүү дээ. Тэдний хэн ч яаманд байгаагүй. Бас миний дэргэд тэмцээгүй гэж Харри хэлэв.

- Чи их сайхан хэллээ гэж Полумна баярлаад хамар дээрээс гулгах шилээ засаж «Шүүмжлэгч» сэтгүүл шагайлаа.

- Гэхдээ бид түүнтэй нүүр тулан тэмцээгүй гэж тоос шороо болсон үстэй Невилл суудал дороос гарч ирээд дуугарлаа. Тэр гартаа Тревороо барьжээ.

- Чи тэдэнтэй ганцаараа тэмцсэн. Чиний тухай манай эмээ ярихыг сонссон болоосой. «Энэ Харри Поттерд ид шидийн яамны бүх хүнийг нийлүүлснээс илүү зан чанар бий шүү!» Тэр чамайг ач нь байсан бол бүгдийг өгөх байсан даа ...

Харри эвгүйцэн инээд алдаад ярианы сэдвийг өөрчлөн С.И.Ш-ийн дүнгийн тухай ярилаа. Невилл зөвхөн ургамал судлалын хичээл дээр онц авчээ. Харри түүний яриаг бараг сонсолгүй урдаас нь ширтлээ.

Невиллийн хүүхэд насыг Харрийн адил Волан-де-Морт сүйрүүлсэн ч хувь заяа нь хэрхэн өөрчлөгдөж болох байсныг гадарласангүй. Зөгнөл тэдний хэнд ч хамааралтай байж болох байсан ч Волан-де-Морт үл мэдэх шалтгаанар шалтгаанаар Харриг сонгон авсан билээ.

Хэрвээ Волан-де-Морт Невиллийг сонгосон бол одоо Харрийн эсрэг талд цахилгаан хэлбэртэй сорвитой суугаад зөгнөлийн ачааг мөрөндөө үүрэх байлаа ... Эсвэл суухгүй байсан юм болов уу? Невиллийн эх хүүгийнхээ төлөө Лилигийн адил амиа өгөх байсан болов уу? Мэдээж өгөх байсан ... Гэхдээ түүнд өөрийн хүүгээ Волан-де-Мортоос хамгаалах хүч байсан болов уу? Тэгвэл ямар ч сонгогдсон гэж байхгүй байсан. Невиллийн сууж байгаа суудал хоосон байж Харри сорвигүй буудал дээрээс Роны биш өөрийнхөө ээжээр үдүүлэх байсан.

- Чи яагаа вэ, Харри? Нэг л биш харагдаад байх чинь гэж Невилл асуув.
- Уучлаарай ... би зүгээр л ...
- Тархи сатааруулагч уу? гэж Полумна асуугаад Харриг солонгорсон том шилнийхээ цаанаас харлаа.
- Юу гэнээ?
- Тархи сатааруулагч. Тэд үл үзэгдэх байдаг юм. Агаарт нисээд чихээр дамжин толгойд ордог. Би тэдний нэг энд эргэлдэхийг мэдэрч байна.

Тэр үл үзэгдэх эрвээхэй цохиж байгаа аятай алгаа агаарт ташлаа. Харри, Невилл хоёр бие бие рүүгээ харснаа яаран квиддичийн тухай ярьж эхлэв.

Цонхны цаадах цаг агаар зуных шиг тогтворгүй байв. Тэд цонхигор нарны гэрэл туссан жихүүн манан дундуур давхин өнгөрлөө. Ингээд нар бараг толгой дээрээс тусах үед өрөөнд Рон, Гермиона хоёр орж ирэв.

- Удахгүй тэргэнцэртэй хоол ирэхгүй бол өлсөж үхэх нь! гэж Рон дуу алдаад Харрийн дэргэд гэдсээ илэн лагхийтэл сууж,

- Сайн уу, Невилл. Сайн уу, Полумна гэснээ, Мэдэж байна уу? Малфой бусад ахлагч нартай жижүүрлэсэнгүй. Өрөөндөө бусад Слизеринчүүдийн хамт сууж байхыг бид сая харлаа гэж Харрид хандан хэлэв.

Харри сониучирхсандаа суудал дээрээ өндийн суулаа. Малфой өөрийн ахлагчын эрх мэдлээ гаргах боломж алдаж байгаа гэдэг нь сонирхолтой байв. Тэр өнгөрсөн жил үүнийг ямар баяртайгаар хэтрүүлэн хэрэглэсэн билээ.

- Тэр чамайг хараад яаж байна?
- Үргэлж байдаг шигээ гэж Рон хайхрамжгүй хэлээд гараа бүдүүлгээр зангаж,
- Гэхдээ түүнтэй адилгүй байгаа биз дээ? Тэр яагаад явж нэгдүгээр дамжааныхныг дээрэлхэхгүй байгаа юм бол? гэв.
- Мэдэхгүй гээд Харрийн тархи ахин хурдтай ажиллав. Харваас Малфойн ухаанд бага ангийн сурагчдыг айлгахаас илүү чухал юм байгаа бололтой.

- Түүнд шалгалтын бүлэг илүү таалагддаг байж болох юм. Магадгүй ахлагч үүний хажууд онцгүй санагдаа биз гэж Гермiona хэлэв.

- Тэгж бодохгүй байна. Би бодохдоо түүнийг ...

Гэхдээ Харриг онолоо хэлж амжихаас урьтаж өрөөний хаалга нээгдэн амьсгаадсан гуравдугаар дамжааны сурагч орж ирлээ.

- Надад үүнийг Невилл Долгопупс болон Харри Поттерт өгөхийг тушаасан гэж сулхан хэлээд Харрийн харцтай тулгаран улайлаа. Тэр гартаа хөх ягаан туузаар ороосон хоёр хуйлаастай цаас барьжээ.

Гайхширсан Харри, Невилл хоёр хаяглагдсан зүйлээ авахад охин бүдчин өрөөнөөс гарлаа.

- Энэ юу вэ? гэж Рон Харри хуйлаасыг тэнийлгэхэд шаардан асуулаа.

- Урилга байна.

Харри!

Би чамайг «Ц» тасалгаанд өдрийн хоолонд нэгдвэл их баяртай байхсан.

Хүндэтгэсэн

Профессор Г.Э.Ф.Слизнорт

- Профессор Слизнорт гэдэг чинь хэн юм бэ? гэж Невилл урилга бодлогоширон харж асуулаа.

- Шинэ багш. За явах уу? гэж Харри хэлэв.

- Би яагаад түүнд шаардагдсан юм бол? гэж Невилл шийтгэл хүлээхээс айсан мэт түгшин хэллээ.

- Мэдэх юм алга гээд Харри хэдийгээр энэ нь худал байсан ч түүний таавар үнэн гэх баталгаа байсангүй. Сонсооч үл үзэгдэх цув өмсөөд замдаа Малфойн юу хийж буйг харах уу.

Гэхдээ энэ санаа бүтэшгүй байв. Хонгилд тэргэнцэртэй хоол хүлээсэн дүүрэн хүүхэд байсан болохоор үл үзэгдэх цув нэвтрэх боломжгүй байлаа. Харри харамсалтайгаар жанчаа цүнхэнд далд хийхдээ харагдахгүй байх нь ямар таатай юм бэ гэж бодлоо. Тэгвэл хэн ч түүн рүү нүдээ бүлтийлгэн амаа ангайлган харахгүй байх болно. Одоо түүнийг түрүүнийхээс ч илүү харж байлаа. Зөвхөн Чжоу Чанг л эсрэгээрээ Харрийн ирэхийг харангуут өрөөндөө оров. Тэр дэргэдүүр нь өнгөрөхдөө цонхоор батгаа далдлахаар зузаан крем түрхсэн найз Мариэттайгаа яриа өрнүүлэхийг харав. Харри хорон инээмсэглээд цааш явлаа.

Тэднийг «Ц» тасалгаанд хүрэх үед Слизнорт зөвхөн Харри, Невилл хоёрыг уриагүй гэдгийг шууд олж харлаа. Гэхдээ урам зоригтойгоор урьсныг үзвэл Харри хамгийн хүсэн хүлээсэн зочин нь байсан бололтой.

- Харри хүү минь! гэж Слизнорт түүнийг харангуут дуу алдан үсэрч босохдоо цүдгэр гэдсээрээ арай л бүх тасалгааг дүүргэсэнгүй. Түүний гялалзсан халзан толгой, өтгөн мөнгөлөг сахал нарны гэрэлд хүрэмнийх нь алтан товчин хамт гялсхийв.

- Чамайг харсандаа баяртай байна, их баяртай байна! Харин та ноён Долгопупс байх тийм үү!

Невилл айсан байртай толгой дохив. Слизнортын урилгаар тэд цорын ганц үлдсэн суудал болох хаалганы хажууд өөд өөдөөсөө харан суулаа. Харри бусад зочдыг харав. Тэр нэг дамжаанд сурдаг болох Слизериний урт хар үс, өндөр шанааны ястай хүүг танилаа. Тэнд бас долдугаар дамжааны хоёр танихгүй хөвгүүн болон яах гэж энд ирснээ мэдэхгүй Жинни буланд сууж байлаа.

- Та нар бүгд бие биенээ танина биз дээ? гэж Слизнорт Харри, Невилл хоёроос асуулаа. Энэ Блез Забини танай дамжааных ...

Забини тэднийг таних ямар ч шинж үзүүлсэнгүйд Харри, Невилл хоёр тийм маягаар хариулав. Гриффиндор болон Слизериний сурагчид зарчмын хувьд бие биеэ тэвчиж чаддаггүй байлаа.

- Энэ Кормак Маклагген магадгүй та нар уулзаж байсан байх тийм үү? Үгүй гэж үү?

Маклагген гэх ширүүн үстэй биерхүү хүү гараа өргөхөд Харри, Невилл хоёр хариу дохив.

- Энэ Маркус Белби таних уу? Туранхай Белби хүчлэн инээмсэглэв.

- Харин энэ залуу хатагтай та хоёрыг танина гэж хэлсэн! хэмээн Слизнорт төгсгөв.

Жинни түүний араас ярвайлаа.

- За их тааламжтай байна! гэж Слизнорт сэтгэл хангалуун хэлээд,

- Би та нарыг бүгдийг нь танилцууллаа. Энэ амны алчуурыг аваарай. Би хоолоо өөрөө бэлтгэсэн. Миний санаж байгаагаар вагонд тэргэнцэртэй чихэртэй саваа зардаг нь хөгшин хүний хоол боловсруулах системд таардаггүй юм. Гургуул идэх үү, Белби?

Белби цочсоноо хүйтэн гургуулын томоохон хэрчим авлаа.

- Би сая Маркусд өвөг эцэг Дамоклаг нь хэрхэн сургаж байсан тухай ярьж байлаа гэж Слизнорт Невилл, Харри хоёр хэлээд талхтай сагсыг дамжуулж,

- Тэр их гаргууд шидтэн байсан болохоор Мерлиний одон хүртсэн юм. Та өвөөтэйгээ үргэлж уулздаг уу, Маркус? гэв.

Золгүй нь гэвэл Белби амаараа дүүрэн гургуул чихсэн болохоор яаран хариулахын тулд огцом залгиад улайн хахлаа.

- Анапнео гэж Слизнорт тайван хэлээд саваагаа Белби рүү чиглүүлэхэд хоолой нь чөлөөлөгдөв.



- Үгүй ... тийм ч үргэлж биш гэж Белби нүдэндээ нулимс гүйлгэнүүлэн хэлэв.
- Мэдээж тэр их завгүй хүн болохоор гэж Слизнорт хэлээд Белби руу асуунгүй харж,
- Тэр хүн чонын эсрэг уусмалыг удаан хугацааны хүнд ажлын эцэст зохиосон биз дээ! гэв.
- Тийм байх ... гээд Белби Слизнортыг асууж дуусах хүртэл гургуулаа хазахаас айсан мэт харагдав.
- Ээ ... тэр ... ойлгож байна уу тэр миний аавтай нэг уулздаггүй болохоор ... би түүний талаар сайн мэддэггүй юм ...

Тэр чимээгүй боллоо. Слизнорт түүнийг хүйтэн инээмсэглэлээр шагнаад Маклагген руу эргэв.

- Харин одоо таны хувьд, Кормак. Би таныг үргэлж өвөө Тивертэйгээ хамт байдгийг мэдэх юм байна. Түүнд байсан гайхалтай зураг дээр хэрвээ эндүүрээгүй бол та түүнтэй Норфолк агнаж байсан байх аа?
- Өө, тийм л дээ энэ хөгжилтэй байсан. Бид Берти Хиггс болон Руфус Скримжертэй явсан ... Гэхдээ мэдээж тэр сайд болоогүй байсан л даа.
- Аан та бас Берта, Руфус хоёрыг мэдэх хэрэг үү? гэж Слизнорт хөхүүн хэлээд бүгдийг жижигхэн тавиуртай бялуугаар зочилохдоо Белбиг алгасч,

- Надад хэлээч гэв.

Бүх зүйл Харрийн сэжиглэж байснаар боллоо. Харваас энд байгаа Жиннигээс бусад хүн бүр алдартай хамаатан садантайн учир уригджээ. Маклаггены дараа Забинигийн байцаагдах ээлж болоход ээж нь нэрд гарсан үзэсгэлэнтэй шидтэн байжээ (Харрийн ойлгосноор бол тэр долоон удаа гэрлэсэн бөгөөд ээлжит нөхөр нь нууцлагаар үхэх болгондоо алт орхиж байжээ). Дараа нь Невиллийн ээлж болоход эцэг эх болох алдартай мракоборецуудыг Беллатриса Лейстренж тэргүүтэй хоёр Үхэл залгигч ухаан алдтал нь тамалсан тухай ярианы хүнд хэцүү арван хором болов. Эцэст нь Харрид Слизнорт Невиллд эцэг эхийнх нь авъяас өвлөгдсөн эсэхийг харах гэсэн байх хэмээсэн сэтгэгдэл төржээ.

- Харин одоо гэж Слизнорт үндсэн хөтөлбөрөө зарлаж буй танилцуулагч аятай хэлээд,
- Харри Поттер! Юунаас эхлэх вэ? Надад бидний зуны уулзалтаар таатай сэтгэгдэл төрсөн юмсан! гэв.

Хормын турш тэр бодлогоширон Харриг том шүүслэг гургуул шиг харснаа дараа нь,

- Таныг одоо сонгогдсон гэж нэрлэж байгаа! гэлээ.

Харри юу ч хэлсэнгүй. Белби, Маклагген, Забини нар түүн рүү ширтлээ.

- Мэдээж гэж Слизнорт Харриг нүд салгалгүй харж хэлээд,
- Цуу яриа эртнээс дэгдсэн ... би санаж байна ... хм ... аймшигт шөнийн дараа...

Лили ... Жеймс хоёр ... харин та амьд үлдсэн ... Таньд ямар нэг итгэмээргүй авъяас байх ёстой гэж ярьж байна гэв.

Забини үл итгэсэн байртай шоолонгуй ханиалгахад Слизнортын ард ууртай хоолой сонсогдож,

- Тиймээ, Забини чамд үнэхээрийн их авъяас байгаа! гэлээ.

- Ай, бурхан минь! гэж Слизнорт инээмсэглээд Забини руу уурсан харж байгаа

Жинни рүү ширтэн,

- Блез, болгоомжтой байсан чинь дээр шүү! Би энэ залуу хатагтайн өрөөний дэргэдүүр өнгөрөх үед сарьсан багваахайн хараалыг маш сайхан хийж байсан юм! Би таны оронд байсан бол түүний замд тээглэхгүй байсан даа! гэв.

Забини зэвүүцэн харлаа.

- Ямар ч гэсэн гээд Слизнорт ахин Харри руу эргэж,

- Энэ зун цуу яриа их дэгдсэн! «Зөнч» сонинд итгэх эсэхээ мэдэхгүй байгаа ч таныг ид шидийн яаманд болсон үймээний гол дунд байсан гэдэг яриа явж байна! гэв.

Харри хариу хэлэхээс бултах ямар ч замгүй болоод толгой дохьсон ч юу ч хэлсэнгүй. Слизнорт зальжин инээмсгэлэв.

- Ямар даруухан, юутай даруухан билээ. Дамлбдор таньд хайртай байдаг гэдэгт гайхах юм алга ... Тэгэхээр та үнэхээр тэнд байсан хэрэг үү? Гэхдээ шуугианд гарснаар бол ... юунд нь итгэхээ мэдэхгүй байна л даа! Жишээлбэл энэ домогт зөгнөлийн хувьд ...

- Бид ямарч зөгнөл сонсоогүй гэж Невилл шимтгэлэй цэцэг адил улайн хэллээ.

- Энэ үнэн шүү гэж Жинни дэмжээд,

- Невилл бид хоёр бас тэнд байсан болохоор энэ сонгогдсон гэдэг дэмий яриа бол зөвхөн «Зөнч» сонины ердийнхөөрөө бодож олсон зүйл гэж бодож байна гэв.

- Та хоёр бас тэнд байсан юм уу? гэж Слизнорт сониучирхаад Невилл, Жинни хоёрыг гүйлгэн харахад хоёулаа амандаа ус балгасан дуугаа хураагаад дэмжин инээсэнгүй.

- Тиймээ ... юу гэвэл ... үнэндээ «Зөнч» сонин заримдаа жаахан хэтрүүлдэг юм ... гэж Слизнорт урам хугарсан байртай хэлээд,

- Гвеног надад хэлснийг санаж байна ... би мэдээж «Холихедск гарпий» багийн Гвеног Жонс хоёрын тухай ярьж байна л даа ...

Цаг хугацаа өнгөрсөөр Слизнорт Хогвартет сургаж байсан янз бүрийн алдартай шидтэнүүдийг Слизнейн клубт хэрхэн элсүүлж байсан тухайгаа аз жаргалтайгаар ярилаа. Харри явахыг хүсэж байсан ч үүнийг яаж эелдэгээр хийхийг мэдсэнгүй. Эцэст нь галт тэргэнд манан дундах жаргаж буй нарны улаан гэрэл тусахад Слизнорт бүрэнхий рүү нүд цавчин харлаа.

- Авралт бурхан минь хэдийн харанхуй болчихож! Би гэрэл ассаныг ажигласангүй. Та нар явж сургуулийн жанчаа сольж өмссөн нь дээр байх! Маклагген над дээр ирж Норфолкын тухай ном уншихаар аваарай. Харри, Блейз хоёр дуртай үедээ ирж болно. Энэ бас таньд хамаатай, хатагтай гээд Жинни рүү нүд ирмэснээ,

- За явцгаа гэлээ.

Забини Харриг түлхэн түрүүлж харанхуй хонгилд гараад, Харри түүнд хариуг нь өгөхөд ууртай харцаар харав. Тэр, Жинни, Невилл нарын хамт гарахад Забини галт тэрэгний төгсгөл рүү явж байлаа.

- Энэ бүхэн дууссанд их баяртай байна. Хачирхалтай хүн юм тийм үү? гэж Невилл бувтналаа.

- Тиймээ, жаахан гээд Харри Забинигийн араас харж,

- Чи тэнд яаж очсон юм бэ, Жинни? гэлээ.

- Тэр намайг Захария Смитэд шившлэг илгээж байхыг харчихсан юм.

Пуффендуйн нөгөө тэнэг бидэнтэй хамт ДА-д байсныг санаж байна уу? Тэр ид шидийн яаманд юу болсон тухай асууж уур хүргэхээр нь би түүнийг шившчихсэн ... Тэгтэл Слизнорт ороод ирсэн. Би түүнийг шийтгэх байх гэж бодсон ч шившлэг сайн илгээсэнд баярлаад хоолонд урьсан. Шал утгагүй байгаа биз?

- Энэ ч зарим хүнийг зөвхөн алдартай ээжийнх нь төлөө урьсанаас дээр юм байна. Эсвэл өвөө нь ч юмуу ... гээд Харри Забинигийн шилэн хүзүү рүү муухай харав.

Тэр чимээгүй боллоо. Толгойд нь гэнэтхэн үр дүнтэй сайхан бодол ороод иржээ ... Хормын дараа Забини Слизеринчүүдийн зургадугаар дамжааныхан сууж байгаа тасалгаанд орно. Харин тэнд Малфой суугаад Слизериний найзуудаас нь өөр хэн ч сонсохгүй гэдэгт итгэлтэй байгаа ... Хэрвээ тийшээ ажиглагдахгүй орчихвол юу харж сонсохыг хэн мэдэх юм? Үнэндээ Хогсмидийн буудалд хүрэхэд хагас цаг үлдээд байсан ч хэн ч Харригийн сэжгийг тоохгүй байгаа болохоор баримт олохын тулд өөрөө хөдөлмөрлөх хэрэгтэй.

- Дараа уулзая гэж Харри шивнээд үл үзэгдэх цуваа гарган нөмөрлөө.

- Харин чи юу... гэж Невилл эхлэв.

- Дараа! гэж Харри шивнээд хэдийгээр галт тэрэг чимээ шуугиан ихтэй байсан ч Забинигийн араас чимээ гаргалгүй гүйцэхийг хичээлээ.

Хонгилд бараг хэн ч үлдсэнгүй. Бүгд өрөөндөө орж тээшнээсээ сургуулийн дүрэмт хувцсаа сольж өмсөн юм хумаа цуглуулж байв. Харри Забинид хүрэлгүй ойртохыг хичээсэн ч араас нь даган орж амжсангүй тэр хэдийн хаалгаа хааж байлаа. Харри хөлөө тавиад хаалгуулсангүй.

- Энэ чинь одоо юу вэ? гэж Забини уурсан хэлээд Харрийн үл үзэгдэх хөлд тээглэсэн хаалгыг угзарлаа.

Харри хаалганаас бариад бүх хүчээрээ түлхэхэд бариулаас барьж байсан Забини Грегори Гойлын өвдөг рүү унан зууралдав. Харри өрөө рүү шурдхийн ороод Забинигийн хоосон суудал дээр гишгэн тээшийн тавиур дээр гарлаа. Энэ агшинд бүгд Гойл, Забини хоёрын зууралдааныг ширтэж байсан тул амжилттай боллоо. Харри түүний хөл нөмрөг дороос гарсан гэдэгт итгэлтэй байв. Аймшигтай нэг агшины турш Малфой түүний кэтийг хялайн харах шиг санагдсан ч дээш нь өргөөд нуулаа. Гойл эцэст нь хаалга чанга хааж Забиниг түлхлээ. Уурсаж бухимдсан Забини суудалдаа суухад, Винсент Крэбб ахин зурагтай номоо эргүүлж, Малфой инээд алдаад хоёр суудал эзлэн хэвтэж толгойгоо Пэнси Паркинсоны өвдөг дээр тавилаа. Харри тавиур дээр атиралдан биеэ бүх талаас нь ороогоод Пэнси Паркинсон Малфойн цайвар үсийг сэтгэл хангалуун инээмсэглэн илэхийг харлаа. Адраас санжигнах гэрэл энэ үйл явдлыг гэрэлтүүлэхэд Харри дороо зурагтай ном үзэж буй Гойлын үг бүрийг уншиж чадахаар байлаа.

- За яасан Забини Слизнортод юу хэрэгтэй байна? гэж Малфой хэлэв.
- Зөвхөн хэлхээ холбоотой хүмүүсийг цуглуулж гэж Забини Гойл руу ууртай хялайн хэлээд,
- Гэхдээ тийм ч олныг олж чадаагүй гэж хэлэх байна гэв. Энэ хариулт Малфойд таалагдсангүй бололтой.
- Тэр хэнийг дуудаа вэ? гэж шаардангуй асуулаа.
- Гриффиндорын Маклагген.
- Өө тийм л дээ, түүний өвөө ид шидийн яаманд томоохон булдруу байсан юм.
- Өөр бас Когтевраны Белби овогтой ...
- Бас нэг тэнэг! гэж Пэнси хэлэв.
- Бас Долгопулс, Поттер, Уизлийн охин гэж Забини яриагаа төгсгөв. Малфой огцом суугаад Пэнсигийн гарыг авч хаялаа.
- Тэр Долгопупсыг урьсан хэрэг үү?
- Тиймээ урьсан Долгопус байсан гэж Забини хайхрамжгүй хэлэв.
- Долгопупсын юуг нь Слизнорт сонирхоо вэ?

Забини мөрөө хавчлаа.

- Поттер ч ойлгомжтой Слизнорт сонгогдсон хүүг харахыг хүссэн байх гэж Малфой хорсолтой инээмсэглээд,
- Харин энэ Уизлийн охин! Түүний юу нь тийм онцгой байгаа юм? гэв.
- Олон хөвгүүдэд тэр таалагддаг гэж Пэнси Малфойн хариу үйлдлийг хяламхийн харж хэлээд,
- Чи хүртэл түүнийг дажгүй гэж боддог биз дээ, Блейз? Бид нар чиний шилэмтгий занг чинь мэднэ! гэв.

- Тэр хэдийгээр хөөрхөн байсан ч би түүн шиг бохир цустангуудад урван тэрслэгчдэд хүрэхгүй гэж Забини хүйтнээр хэллээ.

Пэнси ихэд сэтгэл хангалуун харагдав. Малфой түүний өвдөг дээр ахин хэвтээд үсийг нь илэх боломж олгов.

- Ер нь бол Слизнортын мэдрэмжийг өрөвдөж байна. Магадгүй тэр зөнөсөн байх. Харамсалтай нь аав түүнийг цаг үеийнхээ муугүй шидтэн байсан гэж ярьдаг юм. Аав түүний хайртай сурагч байсан. Магадгүй Слизнорт намайг энэ галт тэргэнд явсныг мэдсэн бол ...

- Би чиний оронд байсанд бол урилга хүлээхгүй байсан даа. Намайг дөнгөж орох үед эцэг Ноттын минь талаар асуусан. Тэд хуучны найзууд хэдий ч ид шидийн яаманд баривчлагдсаныг нь сонсоод Ноттыг урьсандаа тийм ч их баярлаагүй шүү. Минийхээр бол Слизнорт Үхэл залгигчдад дургүй юм шиг байна лээ.

Малфой уурласан хэдий ч биеэ барин хөгжилтэй бус инээмсэглэв.

- Хэнд түүний сонирхолтой хамаатай юм бэ? Ер нь тэр хэн юм бэ? Зүгээр л нэг тэнэг багш гээд бардам эвшээснээ,

- Би ирэх жил Хогвартст суралцахгүй ч байж магадгүй болохоор надад бүдүүн хөгшин яах нь ямар ч хамаагүй гэлээ.

- Ирэх жил Хогварстад суралцахгүйг гэдэг чинь юу гэж байгаа юм? гээд Пэнси гайхсандаа Малфойн үсийг илэхээ болилоо.

- Тиймээ, ер нь хэн мэдэх юм магадгүй ... би ... цаашид илүү чухал ажлаар оролдох ч юм билүү гээд сэтгэл хангалуун инээмсэглэв.

Үл үзэгдэх цувтай тээшийн тавиур дээр атийн хэвтэж байсан Харри зүрхний цохилт нь түргэсэхийг мэдэрлээ. Энэ тухай Рон, Гермiona хоёр юу хэлэх бол? Крэбб, Гойл хоёр Малфой руу гөлрөн амаа ангайнаас үзэхэд илүү чухал зүйлээр нь оролдох төлөвлөгөөнийх нь талаар мэдээгүй боллохтой. Тэр ч байтугай Забини хүртэл ихэмсэг царайдаа сонирхол тодруулан харлаа. Пэнси ахин удаанаар Малфойн үсийг илж эхлэхдээ гэвдсэн байртай харагдав.

- Чи түүний ... тухай ярьж байна уу?

Малфой мөрөө хавчлаа.

- Ээж намайг сургуулиа төгсөхийг хүсч байгаа ч би хувьдаа энэ чухал биш гэж бодож байна. Та нар өөрсдөө бодоод үз л дээ ... Хар лорд хүчээ авах үед хэн С.И.Ш. болон Ж.А.Б.А-ийн шалгалтан дээр ямар үнэлгээ авсан нь ямар хамаатай юм бэ? Мэдээж үгүй ... Тэр хэн түүнд үнэнч зүтгэж байсныг л харах болно ...

- Чи тэгээд түүнд зүтгэж болно гэж бодож байна уу? Арван зургаан настай сургуулиа төгсөөгүй баж уу? гэж Забини егөөдөнгүй сонирхов.

- Би зүгээр л энэ тухай ярьж байна. Магадгүй түүнд би сургуулиа төгсөх эсэх нь чухал биш байж болох юм гэж Малфой аяархан хэлэв.

Крэбб, Гойл хоёр амаа ангайн суулаа. Пэнси Малфой руу хэзээ ч байгаагүйгээрээ биширсэн байртай харав.

- Хогвартс харагдаж байна. Бид хувцсаа сольж өмсөн нь дээр байх гэж Малфой харанхуй цонх руу харан хэллээ.

Харри Малфойгоос нүд салалгүй харж байсан учир Гойл тээш рүүгээ гар сунгахыг харсангүй. Түүний чемодан тавиураас гулгахдаа Харрийн чамархай руу өвдтөл дэлсчихлээ. Тэр өвдсөндөө аяархан дуу алдахад Малфой тээшийн тавиур руу харснаа бодлогоширон хөмсгөө өргөв.

Харри Малфойгоос айсангүй ч үл үзэгдэх цувтай нөхөрсөг бус Слизеринчүүдийн дунд байхыг хүссэнгүй. Нүдэнд нь нулимс цийлэгнэн толгой нь өвдөхөд шидэт саваагаа болгоомжтой гаргаад амьсгал даран хүлээлээ. Аз болоход Малфой андуурсан гэж бодов бололтой. Тэр бусдын хамт дүрэмт хувцсаа өмсөн чемоданаа хаагаад галт тэрэг удааширч эхлэхэд шинэ жанчныхаа хоолойг түргэн товчиллоо.

Харри хонгилд хүүхдүүд гарахыг хараад Рон, Гермiona хоёр түүний юмыг тавцан дээр гаргана байх гэж чимээгүйхэн найдав. Тэр өөрөө тасалгаа хоосрохоос нааш хөдөлж чадсангүй. Эцэст нь галт тэрэг чичигнэснээ зогслоо. Гойл хаалга нээгээд хоёр дугаар дамжааныханыг түлхэлсээр гарав. Крэбб, Забини хоёр түүний араас гарлаа.

- Чи явж бай гэж Малфой гараас нь барихаар найдангуй хүлээн зогсох Пэнси Паркинсонд хэлээд,

- Надад шалгах юм байна гэлээ.

Пэнси явчихлаа. Одоо өрөөнд зөвхөн Харри, Малфой хоёр үлджээ. Сурагчид нэг нэгнийхээ араас цувж харанхуй тавцан руу гарав. Малфой хаалга руу очоод хөшгийг нь татав. Одоо өрөөнд юу болж байгаа нь хонгилоос харагдахгүй боллоо. Дараа нь бөхийгөөд чемоданаа ахин онгойлгов.

Харри тээшийн тавиур дээрээс бөхийхөд зүрхний цохилт нь түргэсэв. Малфой Пэнсигээс юу нуухыг хүссэн юм бол? Харри одоо үнэхээр засах шаардлагатай нууцлаг зүйлийг харах юм болов уу?

- Петрификус тоталус!

Малфой шидэт саваагаа Харри руу чиглүүлэхэд агшин зуур мэдээ алдлаа. Дараа нь удаашруулсан кино шиг тээшийн тавиур дээрээс гулган унахад өрөөний хана доргив. Тэр Малфойн хөлд хэвтээд үл үзэгдэх цув нь сөхөгдөн бие нь ил гарлаа. Тэр хөдөлж чадсангүй зөвхөн Малфойн инээмсгэлэхийг цавчилгүй харлаа.

- Тэгж бодсон юмаа гэж тэр хөөрөн хэлээд,

- Би Гойлын чемодан чамайг цохьсоныг сонссон. Бас надад Забини эргэж ирэхэд нэг цагаан юм гялсхийх шиг санагдсан гээд Харрийн шаахай дээр агшин зуур харц тогтов.

- Чи ямар ч чухал зүйл сонсоогүй, Поттер. Харин оронд нь надад баригдлаа ... Тэрбээр Харрийн нүүр лүү хүчтэй дэвслээ. Харрийн хамар хугарч цус гоожив.

- Үүнийг миний эцгийн төлөө ... Харин одоо ...

Малфой Харрийн хөдөлгөөнгүй бие дороос үл үзэгдэх цув гаргаж ирээд дээрээс нь хучив.

- Чамайг галт тэрэг Лондонд эргэж очихоос өмнө олно байх гэж найдъя. Дараа уулзъя, Поттер ... Магадгүй уулзахгүй ч байж болох юм гэж аяархан хэлэв.

Ингээд замдаа Харрийн хурууг гишгэхээ марталгүй өрөөнөөс гарч одлоо.

## БҮЛЭГ 8: СНЕГТ ХӨӨРӨН БАЯРЛАВ

Харри нэг ч булчингаа хөдөлгөж чадсангүй. Тэр үл үзэгдэх цуван дор хэвтээд хугарсан хамраас нь халуун цус гожигдон нүүр лүү нь урсахыг мэдэрлээ. Хонгилд хоолой болон хөлийн чимээ сонсогдов. Харрийн бодлоор бол замд буцаж гарахаас өмнө галт тэргэнд хүн үлдсэн эсэхийг шалгах ёстой байлаа. Тэгтэл зовж шаналсан бодол төрөв. Хэрвээ хэн нэгэн өрөө рүү шагайдаг юмаа гэсэн ч түүнийг харж сонсож чадахгүй. Зөвхөн дээр нь санамсаргүй гишгэж магадгүй гэж найдах л үлдлээ.

Харри хэзээ ч Малфойг одооных шигээ үзэн ядаж байсангүй. Тэр дээшээ харсан яст мэлхий шиг утгагүй байдалтай хэвтээд ам руу нь цус урсан ороход дотор нь муухайрав. Тэгтэл сүүлчийн хүний алхаа сонсогдож бүгд харанхуй тавцан дээр гараад шуугилдаж ачаа тээшээ зөөх нь сонсогдож байлаа.

Рон, Гермiona хоёр түүнийг тэдэнгүй явсан гэж бодоод хүлээгээгүй байх. Тэд Хогвартет хүрээд Их танхимд суудлаа эзлэх үед хэдэнтээ Гриффиндорын ширээ рүү харж хүлээгээд Харриг байхгүй гэдгийг ойлгомогц тэр эргэлзээгүй Лондон хүрэх замын хагаст байх нь тодорхой.

Тэр ямар нэг чимээ гаргахыг оролдсон ч шуухитнаж ч чадсангүй. Тэгснээ Дамблдорын адил зарим шидтэнгүүд шившлэгийг чанга дуудалгүй хийж чаддагыг санаад шидэт саваагаа барихын тулд «Акцио, шидэт саваа!» гэж бодолдоо давтсан ч юу ч бүтсэнгүй.

Гадаа нуурын эргийн мододын навчис сэрчигнэх, алсад уулийн гууглахаас ондоо эрж хайж буй ямар ч дуу чимээ сонсогдохгүй байлаа. Тэгтэл фестрал хөллөсөн сүйх тэрэг сургууль руу ойртоход Малфойн болон найзуудынх нь сууж яваа тэрэгнээс хөхрөлт сонсогдож Харриг хэрхэн элэглэж байгаа нь бодогдов.

Галт тэрэг хөдлөхөд Харри хажуугаараа эргэлээ. Тэр одоо адар руу биш тоостой суудлын доод хэсэг рүү харж байв. Шал чичигнэн хөдөлгүүр ажиллаж эхэлснээс үзвэл уурын галт тэрэг «Хогвартс экспресс» буцах замдаа ороод Харрийн үлдсэнийг хэн ч мэдээгүй бололтой.

Тэр гэнэтхэн үл үзэгдэх цув дээрээс нь алга болохыг мэдрээд хэн нэгний хоолой,

- Ашгүй дээ, Харри гэх нь сонсогдов.

Улаан гэрэл гялсхийгээд Харри хөдлөх чадвартай боллоо. Тэр өндийн суугаад цустай нүүрээ яаран шороотой гарынхаа араар арчин Тонксыг харлаа. Тэр саяхан хуулан авсан үл үзэгдэх цуваа бариад зогсож байв.

- Алив эндээс түргэн гарцгаая. Харайх хэрэгтэй гэж тэр хэлэв. Цонхны цаана утаа суунаглан галт тэрэг хөдөлж эхэллээ.

Харри түүний араас хонгилд гарав. Тонкс галт тэрэгний үүдийг нээгээд тавцан руу үсрэхэд бүх зүйл хажуугаар жирэлзэн өнгөрч галт тэрэг бүх хүчээ авлаа. Харри бас үсрээд гуйвлан тогтож харвал уурын улаан галт тэрэг хурдтайгаар булан тойрон үзэгдэх бараанаас алга болов.



Шөнийн хүйтэн агаар хугарсан хамрыг нь таатай сэрүүцүүлнэ. Тонкс түүн рүү харлаа. Харрид ийм тэнэг байдалтай олдсондоо ичгүүртэй байв. Тонкс чимээгүйхэн үл үзэгдэх цувьг нь сунгалаа.

- Хэн үүнийг хийсэн юм?
- Драко Малfoy гэж Харри гашуунаар хэлээд,
- Баярлалаа ... гэв.
- Зүгээр дээ гээд Тонкс инээмсэглэсэнгүй. Харри харанхуйд түүний үс саарал хэвээр царайд нь Үүрэнд харсны адил золгүй төрх илрэхийг харлаа.
- Тайван зогсож бай, би хамрыг чинь засаадхя.

Энэ санаа Харрийг нэг их баярлуулсангүй. Тэр анагаах шившлэгт итгэснээс хатагтай Помфрийн эмнэлэгээр шагайхыг илүүд үзэж байсан ч хэлэхэд эвгүй байсан тул хөдөлгөөнгүй зогсож нүдээ анилаа.

- Эпискей! гэж Тонкс хэлэв.

Харрийн хамар гэнэтхэн халуу оргисноо маш хүйтэн боллоо. Харри гараа өргөж хамраа болгоомжтой барьж үзэв. Бүх зүйл хэвийн болсон бололтой.

- Маш их баярлалаа!
- Чи жанчаа товчилсон чинь дээр байх бид сургууль руу чинь явган явах болно.

Харри жанчаа баглах үед Тонкс шидэт саваагаа даллаж том мөнгөлөг дөрвөн хөлтэй зүйл гаргаад харанхуйд алга боллоо.

- Энэ Патронус байсан уу? гэж Харри асуув. Тэр урьд нь Дамблдор тийм аргаар мэдээлэл илгээхийг харж байсан билээ.
- Тиймээ би шилтгээнд чамайг надтай байгаа тул санаа зовох хэрэггүй гэж мэдэгдэхийг хүссэн юм. Алив, явцгаая.

Тэд зөрөг замаар сургууль руу явлаа.

- Чи намайг яаж олоо вэ?
- Би чамайг галт тэрэгнээс гараагүйг ажиглаад гэнэтхэн энэ цув байгаа гэдгийг чинь санасан. Чамайг яагаад нуугдсан юм бол гэж бодлоо. Хөшиг нь хаалттай өрөө хараад шалгахаар шийдсэн юм.
- Гэхдээ чи энд юу хийж байгаа юм? гэж Харри асуув.
- Би энд Хогсмидэд жижүүрлэж байгаа. Сургуулийн нэмэлт хамгаалалт гэж Тонкс тайлбарлав.
- Зөвхөн чи ганцаараа жижүүрлэж байгаа юмуу эсвэл ...
- Үгүй бас Прадуфут, Сэвиж, Долиш нар бас жижүүрлэж байгаа.
- Долиш гэж өнгөрсөн жил Дамблдор руу дайрдаг мракоборец уу?
- Тиймээ мөн.

Тэд сүйх тэрэгний мөр гарсан харанхуй хоосон замаар явлаа. Харри Тонкс руу хяламхийн харав. Өнгөрсөн жил тэр сонирхолтой (энэ нь заримдаа жаахан уурлуулдаг) үргэлж инээж тоглож байдаг байсан. Харин одоо Тонкс илүү ахмад буурьтай болж. Энэ бүхэн үнэхээр ид шидийн яаманд болсон үйл явдлаас болсон гэж үү? Харри Гермiona түүнийг Тонкстой Сириусын тухай ярьж буруугүй гэж тайвшируулахыг хүсэх байсан даа гэж эвгүйцэн бодсон ч чадсангүй. Тэр түүнийг Сириусын үхэлд буруутгаагүй ч зүгээр л түүний үхлийн тухай ярихад хүнд байсан тул энэ тухай ярихаас зайлсхийж байлаа. Тэд чимээгүйхэн харанхуй хүйтэн дундуур явлаа. Тонксын урт жанчны хормой газар шүргэнэ.

Харри урьд нь үргэлж ийшээ сүйх тэргээр ирдэг байсан болохоор одоо л Хогсмидын буудал хэр хол болохыг ойлгож эхлэв. Эцэст нь хоёр талдаа далавчтай гахайн хөшөө бүхий баганатай хаалгыг хараад санаа амарлаа. Тэр даарч өлсөн энэхүү шинэ баргар Тонкстой байж тэсэхгүй болсон байлаа. Тэгээд хаалга түлхэхээр гар сунгатал гинжээр түгжээтэй байв.

- Алохомаро! гэж Харри итгэлтэй хэлээд саваагаа цоож руу чиглүүлсэн ч юу ч болсонгүй.

- Энд үйлчилэхгүй. Дамблдор өөрөө хаалгыг илбэдсэн гэж Тонкс хэлэв.

Харри эргэн тойрноо харлаа.

- Би хашаа даваад орчихъё.

- Үгүй болохгүй гэж Тонкс уйтгартай хэлээд,

- Хашаа гадны биет нэвтрэхийн эсрэг шившлэгтэй. Энэ зун аюулгүй байдлыг зуу дахин нэмэгдүүлсэн байгаа гэв.

- Тэгвэл гээд Харриг түүний хайхрамжгүй байдалд уурлуулж эхэллээ. Би энд хоноглож өглөөг хүлээх хэрэгтэй болох нь.

- Хэн нэгэн чамайг авахаар ирж байна. Хараач.

Алсад шилтгээнээс дэнлүүний гэрэл тусав. Харри баяртайгаар Филчийн хоцорсон талаарх сөөнгө шүүмжилсэн яриаг тэвчиж болох юм гэж бодлоо. Гэвч шаргал туяа арван футын зайд ирэхэд Харри үл үзэгдэх цуваа гаргасан ч гэнэтхэн унжуу хамар, тослог хар үстэй Северус Снегг болохыг танилаа.

- Үгүй ер гээд Снегг шидэт саваагаа өлгөөстэй цоож руу шургуулахад гинж шаржигнан гүйж хаалга хоёр тийш чахран нээгдэв.

- Та эцэстээ хүрэлцэн ирсэн чинь таатай хэрэг байна, Поттер. Та харваас сургуулийн жанч өмсөх нь гаднах үзэмжийг чинь гутаана гэж бодсон бололтой.

- Би хувцсаа сольж чадаагүй, надад ... гэж Харри эхэлсэн ч Снегг түүний яриаг таслав.

- Хүлээх хэрэггүй, Нимфадора. Поттер надтай байхад ... хм-м ... бүрэн аюулгүй.

- Миний мэдээлэл Хагридад хүрсэн гэж бодсон юмсан гэж Тонкс хөмсөг зангидан хэлэв.

- Хагрид яг л Поттерын адилаар хичээлийн жилийн эхний цайллагаас хоцорсон болохоор би оронд нь хүлээж авсан юм. Дашрамд чиний шинэ Патронусыг харахад сонирхолтой байлаа шүү гэж Снегг Харриг оруулахын тулд хажуу тийшээ холдоод хэллээ.

Тэр хаалганы цоожинд шидэт саваагаа хүргэхэд гинж хангинан байрандаа орлоо.

- Минийхээр бол өмнөх нь хамаагүй дээр байсан юм. Шинэ нь сул юм байна лээ гэж Снегг хорсолтой өнгөө нуулгүй хэллээ.

Тэрбээр дэнлүүгээ савчуулан эргэхэд Харри агшин зуур Тонксын уурссан царайг харлаа. Дараа нь тэр харанхуйд алга болов.

Харри Снеггийн араас сургууль руу хөдлөв.

- Тавтай нойрсоорой. Хийсэн бүх зүйлд чинь ... баярлалаа! гэж арагшаа эргэн хашгирлаа.

- Баяртай, Харри.

Бараг бүтэн хормын турш Снегг юу ч ярьсангүй. Харри хүчтэй үзэн ядалт нөмрөн авахыг мэдрээд Снегг халууныг нь мэдрэхгүй байна гэдэг нь итгэмээргүй санагдав. Тэр Снеггийг хамгийн анхны уулзалтаас хойш тэвчиж чадахаа больсон билээ. Дамблдор юу ч хэлсэн байлаа гэсэн Харри өнгөрсөн зун тэр Сириусын үхдэг шөнө Фениксийн бүлгийн бусад гишүүд Волан-де-Морттой тэмцэн эрсдэлд орж байхад аюулгүй нуугдан үлдэж байна гэж ёжлонгүй хэлсэн байх гэж бодож байлаа. Харри энэ бодолдоо харамссангүй яагаад гэвэл Снеггийг буруутгах нь таатай өгөөд хэрвээ энэ дэлхий дээр Сириусын үхэлд харамсаагүй хүн байдаг бол одоо хажууд нь харанхуйд алхаж байгааг сайн мэдэж байв.

- Таны хоцролтноос болж Гриффиндороос тавин оноо хасах хэрэгтэй болох нь.

Дээрээс нь нэмээд маглуудын хувцасны төлөө хорин оноо хаслаа. Би тэнхимүүдэд хичээлийн жилийн эхэнд амтанд амжаагүй гарч байсан ямар ч тохиолдлыг санахгүй байна. Та дээд амжилт тогтоолоо, Поттер.

Харри уур хилэн үзэн ядалт дотроос нь дүрсхийхийг мэдрээд Лондон руу хөдөлгөөнгүй эргэж очоод Снеггэд яагаад хоцорсон тухайгаа хэлсэн бол яах байсан бол гэж бодлоо.

- Та сэтгэгдэл төрүүлэхийг хүсээ юу? Нисдэг машин байхгүй болохоор Их танхимд цайллагын ид үеэр нь ирэхийг хүссэн юм биз дээ.

Харри чимээгүй байсан ч дотроо түүнийг хэдэн хэсэг болгон хаяхыг хүслээ. Тэр Снегг түүн рүү гэрчгүйгээр хорыг нь маажих хэдэн хормын төлөө ирсэн гэдгийг мэдэж байв.

Тэд эцэст нь шилтгээний довжоонд хүрэхэд том царсан хаалга нээгдэн уужим чулуун шалтай өрөөнд орлоо. Их танхимын зүгээс инээд, яриа хөөр, аяга таважингэнэх дуу сонсогдоно. Харри Гриффиндорын ширээнд ажиглагдахгүй хүрэхийн тулд үл үзэгдэх цуваа өмсдөг юмуу гэж бодлоо.

Гэвч Снегг түүний бодлыг уншсан бололтой.

- Цувгүй. Бүгдийн нүдэн дээр ор. Би таныг үүнийг л хүссэн байх гэдэгт итгэлтэй байна гэв.

Харри эргээд онгорхой хаалгаар орлоо. Их танхимд ердийнхөөрөө дөрвөн тэнхимийн урт ширээ болон багш нарын ширээ сүндэрлэж агаарт хөвөн хөөрч буй лааны гэрэл ширээн дээрх аяга цомыг гэрэлтүүлнэ. Харри нүд бүрэлзээд бүх зүйл тодорхойгүй харагдав. Тэр хэн нэгэн ажиглаж амжихаас урьтан түргэн алхаж Пуффендуйн ширээг өнгөрсөн ч хэд хэдэн хүүхдүүд түүнийг сайн харахын тулд хөл дээрээ үсрэн босов. Тэр Рон, Гермиона хоёр дунд суулаа.

- Чи хаана байсан бэ? Хөөх нүүр чинь яагаа вэ? гэж Рон асуугаад хажуугаас нь нүдээ бүлтийлгэн харлаа.

- Яасан байна? гээд Харри халбаганд өөрийн тусгалаа харав.

- Чи битүү цус болчихож! гэж Гермиона дуу алдаад,

- Алив гэлээ.

Тэр шидэт саваагаа даллан «Тергео!» гэхэд хатсан цус агшин зуур саваанд сорогдов.

- Баярлалаа гээд Харри царайгаа цэвэрхэн болохыг мэдэрч,

- Миний хамар ямар харагдаж байна? гэлээ.

- Зүгээр гээд Гермиона түгшсэн байртай,

- Ямар харагдах ёстой юм? Харри юу болоо вэ? Бид айсандаа бараг үхэх шахлаа! гэв.

- Дараа ярья гэж Харри товчхон хэллээ.

Тэр Жинни, Невилл, Дин, Симус нар чих тавьж тэр ч байтугай Гриффиндор тэнхимийн хий үзэгдэл бараг толгойгүй Ник хүртэл сонсохоор ойртон ирэхийг харлаа.

- Гэхдээ ...

- Одоо биш, Гермиона гэж Харри баргар хоолойгоор учиртай хэллээ.

Тэр бүгд түүнийг баатар болохын тулд Үхэл залгигч болон, Дементоруудтай тааралдсан байх гэж тааварлаж байгаа болохыг мэдэж байв. Мэдээж Малфой үнэнийг хэлсэн байж болох ч ихэнхи Гриффиндорынхон сонсоогүй байлаа.

Тэр Роны цаана байсан тахианы хөл, шарсан төмсийг авах гэтэл амжсангүй алга болж оронд нь амттанаар дүүрлээ.

- Чи хуваарилалтыг өнгөрөөсөн гэж Гермиона мэдэгдэхэд Рон том шоколадтай бялуу руу шумбан оров.

- Малгай ямар нэг сонирхолтой юм хэлсэн үү? гээд Харри бурамтай бялуу авлаа.

- Үргэлж байдаг шигээ л ... Дайсантайгаа нүүр тулахын тулд нэгдэх хэрэгтэй гэж зөвлөсөн.
- Дамблдор Волан-де-Мортын тухай ярив уу?
- Үгүй тэр үргэлж цайллагын төгсгөлд ярьдаг биз дээ. Удахгүй болох байх.
- Снегг Хагридыг цайллаганаас хоцорсон гэж хэлсэн ...
- Чи Снеггтэй уулзаа юу? Хаана? гэж Рон ам дүүрэн шоколадтай бялуу залгин асуулаа.
- Замдаа тааралдсан юм гэж Харри булзан хэлэв.
- Хагрид хэдхэн минут л хоцорсон. Хараач, Харри тэр чам руу даллаж байна гэж Гермiona хэлэв.

Харри багш нарын ширээний зүг харахад Хагрид нүүр дүүрэн инээмсэглэн гар даллаж байв. Тэр багш нарын ширээнд Гриффиндор тэнхимийн эрхлэгч профессор МакГонагалл шиг биеэ намбатай авч явахад суралцаагүй болохоор зулай руу нь тохойгоороо ёвроход таагүйхэн хяламхийж ууртай бувтналаа. Харри Хагридын нөгөө талд мэргэ төлгийн багш профессор Трелони сууж байхыг хараад гайхлаа. Тэр цамхагийн орой дахь өрөөгөө ховорхон орхидог бөгөөд нэг ч удаа хичээлийн жилийн эхний цайллага дээр харагдаж байгаагүй билээ. Тэр үргэлж байдаг шигээ хачирхалтай хувцаслан хүзүүний зүүлт гялалзуулан нүд нь шилнийхээ цаанаас итгэмээргүй том хэмжээтэй харагдаж байв. Харри үргэлж түүнийг ердийн хууран мэхлэгч гэж боддог байсан ч өнгөрсөн хичээлийн жилийн төгсгөлд Волан-де-Морт Харрийн эцэг эхийг алан Харриг устгахыг оролдсон зөгнөлийг хэлсэн гэдгийг мэдээд ихэд гайхсан билээ. Харин үүний дараа түүнд ердийнхөөрөө хандаж чадсангүй. Аз болоход энэ онд мэргэ төлгийн хичээл судлах хэрэггүй байлаа. Түүний харц Харрийн зүг тусахад яаран Слизериний ширээний зүг харлаа. Бөөн хөхрөлт алга ташилтан дунд Драк Малфой хэн нэгний хамрыг хугалсан тухайгаа дүрслэн үзүүлж байв. Харри зүсэм бялуутай таваг руугаа тонгойход дотор нь ахин халуу оргилоо. Малфойтой нэгийн эсрэг нэг үзэх юмсан! ...

- Тэгвэл профессор Слизнорт яагаад урьсан юм? гэж Гермiona асуулаа.
- Ид шидийн яаманд үнэн хэрэгтээ юу болсныг мэдэхийг хүссэн юм.
- Бүгд л хүсч байгаа! гэж Гермiona тургилаад,
- Хүмүүс галт тэргэнд энэ тухай биднээс эцэс төгсгөлгүй асуусан тийм биз дээ, Рон? гэв.
- Аанхан. Бүгд чиний үнэхээр сонгогдсон эсэхийг мэдэхийг хүсч байгаа ...
- Энэ тухай яриа хий үзэгдлүүдийн дунд ч өрнөсөн гэж бараг толгойгүй Ник ярианд оролцоод Харри руу бөхийхөд захан дээрх толгой нь осолтой ганхлаа.
- Намайг Поттерын гарын үсэг авахыг хүссэн. Бидний нөхөрсөг харьцаатай гэдгийг мэддэг болохоор. Би ийм харьцааг ашиглан чамайг залхаах хүн биш

гэдгээ хэлсэн. «Харри Поттер надад итгэж болно гэдгээ мэддэг юм. Би түүний итгэлийг алдсанаас үхсэн нь дээр» гэж хэлсэн.

- Гэхдээ чи хэдийн үхсэн биз дээ гэж Рон хэлэв.

- Чи үргэлж мохоо сүх шиг болхи мэдрэмжтэй байх юм даа гэж бараг толгойгүй Ник доромжлонгуй хэлээд агаарт хөөрөн Гриффиндорын ширээний төгсгөл рүү нислээ.

Тэр үед багш нарын ширээнд Дамблдор хөл дээрээ босов. Инээд яриа хөөрөө агшин зуур бөхлөө.

- Бүгдэд сайхан үдшийг хүсье! гээд Дамблдор инээмсэглэн бүх сургуулийг тэврэхийг хүссэн мэт гараа дэлгэв.

- Түүний гар яагаа вэ? гэж Гермiona дуу алдлаа.

Зөвхөн тэр үүнийг анзаарсангүй. Дамблдорын баруун гар Харриг Дурслийн гэрээс авахаар ирсэн шөнийх шигээ харлаж түлэгдсэн байлаа. Танхимд шивнэлт түгэв. Дамблдор бүгдийг ойлгоод инээмсэглэн гараа ханцуйндаа нуулаа.

- Юунд ч санаа зовох хэрэггүй дээ. Харин одоо ... манай шинэ сурагчид тавтай морилоорой, манай хуучин сурагчид тавтай морилоорой! Та нарыг ид шидийн боловсролд сурах ахин нэг жил хүлээж байна ...

- Түүний гар зун бас ийм байсан. Би эдгэрсэн л юм байх гэж бодлоо ... эсвэл хатагтай Помфри түүнд тусалж чадаагүй байх гэж Харри Гермionaгийн чихэнд шивнэлээ.

- Энэ үхэжсэн юм шиг харагдаж байна гээд Гермiona шаналгангуй үрчийснээ,

- Зарим шархыг эмчилж болдоггүй юм ... эртний хараал ... хортой байсан бол эсрэг үйлчлэлгээтэй эмийг нь олохоос нааш ... гэв.

- ... сургуулийн харуул ноён Филч надаас «Уизлийн бүх төрлийн шидэт эдлэлүүд» гэдэг дэлгүүрийн бараа таваарыг хатуу хориглохыг гуйсан.

- Тэнхимийн квиддичийн шигшээд тоглохыг хүссэн хүмүүс өөрийн эрхлэгчдээ хандаарай. Түүнчлэн бидэнд квиддичийн шинэ тайлбарлагч хэрэгтэй болсон тул сонирхсон хүмүүс мөн л эрхлэгчдээ хандаарай.

- Энэ жил би та нарт шинэ багшийг танилцуулахдаа баяртай байна. Профессор Слизнорт (Слизнорт лааны гэрэлд халзан толгойгоо гялалзуулан босоход бүдүүн гэдэс нь ширээн дээгүүр цүлхийв) миний хуучин хамт ажиллаж байсан нөхөр бөгөөд бидэнд ахин уусмалын хичээл заахыг зөвшөөрсөн юм.

- Уусмалын гэнээ?

- Уусмалын гэнээ?!

Энэ үг их танхимаар цуурайтахад сурагчид зөв сонссон эсэхээ гайхан бие биенээсээ асуув.

- Уусмалын гэнээ? гэж Рон, Гермiona хоёр зэрэг давтаад Харри руу харж,

- Гэхдээ чи хэлэхдээ ... гэв.

- Иймээс профессор Снегг хар урлагаас хамгаалах хичээлийн багшийн үүргийг өөртөө авч байгаа юм гэж Дамблдор шивнэлдэх чимээг давахын тулд дуугаа өндөрсгөн хэллээ.

- Үгүй! гэж Харри чанга хэлсэн учир хүүхдүүд түүн рүү эргэн харлаа.

Түүнд хамаагүй байв. Тэр уур хилэнд автан багш нарын ширээ рүү харлаа. Яаж Снеггэд энэ бүх хугацааны дараа хар урлагаас хамгаалах хичээл заахыг зөвшөөрч болох юм бэ? Бүгдэд Дамблдор түүнд олон жилийн турш энэ ажлыг итгэн өгөөгүй нь тодорхой байдаг биш үү?

- Гэхдээ Харри чи Слизнорт хар урлагаас хамгаалах хичээл заана гэж хэлсэн биз дээ! гэж Гермиона хэлэв.

- Би тэгж бодсон юм! гээд Харри Дамблдор энэ тухай юу хэлснийг саналаа.

Хэрвээ бодоод үзэх аваас Дамблдор профессор Слизнортыг ямар хичээлд багшилахыг хэлээгүй байлаа.

Дамблдорын баруун талд сууж байсан Снегг нэрийг нь хэлэхэд босолгүй залхуутайхан гараа өргөхөд Слизериний ширээний зүгээс алга ташилт сонсогдож Харри дургүй царайдаа хөөрсөн өнгө тодорхыг харлаа.

- Ганц л сайн зүйл байна. Бид хичээлийн жилийн эцэст Снеггээс салах нь байна гэж тэр хэрцгий хэллээ.

- Юу гэсэн үг юм? гээд Рон ойлгосонгүй.

- Энэ чинь хараал идсэн ажил. Хэн ч жилээс илүү багшилдаггүй ... Квирелл үхсэн. Би хувьдаа өөр нэг үхэл болоосой гэж хуруугаараа загалмайлах байна

...

- Харри! гэж Гермиона зэмлэнгүй дуу алдав.

- Эсвэл тэр хичээлийн жилийн төгсгөлд уусмалын хичээлдээ эргэн орж болох юм. Гэнэтхэн Слизнорт удаан багшилахыг хүсэхгүй бол яана. Грюм хүсээгүй гэж Рон хэллээ.

Дамблдор хоолой засан ханиалгалаа. Зөвхөн Харри, Рон, Гермиона төдийгүй танхим даяар Снегг эцэст нь мөрөөдөлдөө хүрсэн шинэ сонинг гайхан хэлэлцэж байлаа. Хэлсэн зүйлээс нь шуугиан дэгдсэнийг анзаарсан бололтой Дамблдор томилогдсон багш нарын тухай өөр зүйл хэлсэнгүй чимээгүй болохыг хүлээгээд дараа нь ахин ярилаа.

- Цааш нь энэ танхимд байгаа хүн бүхэн лорд Волан-де-Морт болон түүний дагалдагч нар ахин гарч ирээд хүчээ цуглуулж байгааг мэдэх билээ.

Дамблдорыг ингэж хэлэхэд хүчилсэн нам гүм бий болов. Харри Малфой руу харлаа. Тэр Дамблдор руу харалгүй шидэт савааныхаа тусламжтай агаарт сэрээ тогтоогоод сургуулийн захирал анхаарлыг нь ер татахгүй мэт байлаа.

- Би зарим зүйлийг цохон тэмдэглэхийг хүсч байна. Одоо нөхцөл байдал аюултай болж хүндэрсэн болохоор хүн бүр Хогвартсын аюулгүй байдалд санаа тавих нь чухал байна. Шилтгээний шидийн хамгаалалтыг зун бэхжүүлэн илүү шинэ хүчирхэг хамгаалалт нэмсэн учир сурагчид төдийгүй багш нар өчүүхэн ч сэрэмжгүй байдал гаргалгүй болгоомжтой байх ёстой. Иймээс би та бүхнийг аюулгүйн байдлын хязгаарыг баримтлан сахиж төвөгтэй байсан ч ялангуяа унтлагынхаа өрөөнөөс гарахгүй байх дүрмийг сахихыг гуйж байна. Хэрвээ та бүхэн шилтгээний эргэн тойронд хачирхалтай юмуу сэжигтэй зүйл ажиллавал даруйхан энэ тухай багш нарт мэдэгдэх хэрэгтэй. Би та нарыг өөрийнхөө болон бусад сурагчдын аюулгүй байдлын тулд ойлгосон байх гэж найдаж байна.

Дамблдорын цэнхэр нүд танхимыг гүйлгэн харснаа инээмсэглэв.

- Харин одоо та нарыг тохилог дулаахан ор дэр чинь хүлээж байна. Та нарын хамгийн гол үүрэг бол маргаашийн хичээлийн өмнө сайн унтаж амрах явдал юм. Одоо бие биендээ «Тавтай нойрсоорой! баяртай!» гэж хэлээрэй.

Үргэлж байдаг шигээ сандал түжигнэх чих дөжрөм чимээ гарч зуугаад сурагчид Их танхимаас гаран унтлагын өрөө лүүгээ явлаа. Харри түүнийг бүгд гөлөрч байхад хүмүүсийн дунд явж Малфойн хамар хугалсан түүхийг сонсох хүсэлгүй байсан болохоор яарсангүй. Тэр ард үлдээд Гриффиндорынхон танхимаас гарахыг хүлээлээ. Гермиона ахлагчын үүргээ биелүүлэн шинэ сурагчдыг дагуулан явахад Рон Харрийн хамт үлдэв.

- Чиний хамар нээрээ яасан юм? гэж тэр хүмүүсийн ард хоцрон хэн ч сонсохооргүй болсон үед асуулаа.

Харри товчхон ярилаа. Тэгтэл тэдний нөхөрлөл хичнээн бат бөхийн баталгаа болон Рон инээсэнгүй.

- Би Малфойг хамартай холбоотой ямар нэг зүйл үзүүлж байхыг харсан юм байна гэж баргар хэлэв.

- Тиймээ. Сонсооч тэр юуны тухай ярьсан гээч ...

Харри Роныг түүний ярианд гайхширахыг хүлээлээ. Гэсэн ч Рон хайхрамжгүй Харрийн бодлоор бол дүйнгэ ч юм шиг үлдээд,

- Боль доо Харри, тэр зөвхөн Паркинсонд гайхуулахыг хүсээ биз ... Хэцүү нэрт түүнд ямар чухал даалгавар өгнө гэж? гэв.

- Чи Волан-де-Мортод Хогвартсад өөрийн хүн хэрэг болоогүй гэдгийг хаанаас мэдэх юм? Энэ ч анхны удаагаа биш шүү дээ ...

- Энэ нэрийг битгий чанга хэл, Харри гэх зэмлэнгүй дуу Харрийн ард сонсогдов. Харри эргэж хараад Хагрид толгойгоо сэгсэрч байхыг харлаа.

- Дамблдор энэ нэрийг хэлдэг гэж Харри зөрүүдлэв.

- Дамблдор юм чинь тийм үү? гэж Хагрид нууцгай хариулснаа,

- Чи яагаад хоцроо вэ, Харри? Миний санаа зовоод гэв.



- Би галт тэргэнд саатсан юм. Харин чи яагаад хоцроо вэ?
- Гроххтой хамт байсан юм. Цаг хугацаа хэрхэн өнгөрснийг анзаарсангүй. Тэр одоо ууланд байгаа. Дамблдор түүнд маш сайн агуй олж өгсөн. Тэнд ойд байхаас хамаагүй дээр байх болно. Бид одоо маш сайн ярилцаж байгаа.
- Үнэн үү? гээд Харри Рон руу харахгүй байхыг хичээв. Тэр сүүлд Хагридын дүү болох ургаа модыг үндсээр нь булгалах дуртай ууртай аварга биеттэй хийсэн уулзалтанд тавхан үг хэлсэн билээ.
- Тийм ээ, тэр үнэхээр олон зүйл сурсан гэж Хагрид бардам хэлээд,
- Та нар лав төсөөлөхгүй дээ. Би түүнийг туслахаараа авахаар бэлтгэж байгаа гэв.

Рон чанга тургилснаа нуух гэж найтаасан дүр эсгэв. Тэд хэдийн царсан хаалгатай үүдэнд хүрчээ.

- За маргааш эхний хичээл шууд үдийн хоолны дараа болно. Клювокрылтэй мэндлэхийг хүсвэл эртхэн ирээрэй ... би Махаон гэж хэлэх гэсэн юм л даа!

Тэр гараа хөгжилтэй даллаад харанхуйд уусан одлоо. Харри, Рон хоёр бие бие рүүгээ харав.

- Чи шидэт амьтны хичээлийг үргэлжлүүлэх гэж байна уу? Рон толгойгоо сэгсэрлээ.
- Харин чи үргэлжлүүлэх үү? Харри ч гэсэн толгойгоо сэгсэрлээ.
- Харин Гермiona? Тэр бас үгүй юу? гэж Рон асуув.

Харри ахин толгой сэгсэрлээ. Тэр Хагрид гурван хайртай сурагч нь түүний хичээлийг үргэлжлүүлэн сурахаас татгалзсан гэдгийг мэдвэл юу хэлэх байсан талаар бодохгүй байхыг хичээв.

## БҮЛЭГ 9: ЭРЛИЙЗ ХУНТАЙЖ

Маргааш өглөө нь Харри, Рон хоёр Гермионатай өглөө амралтын өрөөнд уулзав. Гермиона түүний онолыг дэмжих байх гэж найдсандаа Харри яаран «Хогвартс Экспресс» галт тэргэнд Малфойгоос сонссон түүхээ ярилаа.

- Гэхдээ тэр Паркинсоны өмнө өөрийгөө үзүүлэх гэсэн хэрэг байгаа биз дээ? гэж Рон Гермионаг ямар нэг зүйл хэлж амжихаас урьтаж хэлэв.

- Юу гэвэл ... Мэдэхгүй юм ... Малфой өөрийгөө чухал харагдуулахыг хүсээд ... худал ярьсан байх ... Гэхдээ тийм зүйл бодож олно гэдэг чинь ...

- Яг тийм гээд Харри цааш нь тодорхой ярихыг хүссэнгүй. Учир нь амралтын өрөөнд яриа сонсогдож болохоос гадна олон хүүхдүүд түүн рүү ширтэн сэмхэн шивнэлдэж байлаа.

- Хүмүүжилтэй хүмүүс хуруугаараа заадаггүй юм! гэж Рон жижигхэн нэгдүгээр дамжааны хүүг хөргөн нүхээр гарахын өмнө зандарлаа.

Харрийн тухай найзтайгаа шивнэлдэж байсан хүү час улайгаад яаран хөргөн нүхээр гарав. Рон араас нь инээлээ.

- Зургадугаар дамжаанд байх чинь ямар сайхан юм бэ! Тиймээ бидэнд энэ жил чөлөөт цаг их байна. Хичээлийн дараа суугаад тайвширч болно.

- Энэ цагийг чинь биеэ дааж хичээллэхэд зориулж өгч байгаа юм, Рон! гэж Гермиона түүний араас хонгилоор явахдаа хэлэв.

- Гэхдээ зөвхөн өнөөдөр л биш шүү гэж Рон эсэргүүцэв.

- Зогс! гээд Гермиона гартаа цайвар ногоон таваг атгаад гүйн өнгөрч байсан дөрөвдүгээр дамжааны сурагчын гараас барьж аваад,

- Хаздаг нисдэг таваг хориотой алив наашаа өг гэж ширүүн хэлэв.

Хүү хөмсөг зангидан тавгаа өгөөд Гермионагийн гараас сулран найзуудынхаа араас гүйв. Рон түүнийг далд орохыг хүлээгээд хаздаг нисдэг тавгыг авлаа.

- Сайн байна, би үргэлж иймийг хүсдэг байсан юмсан!

Гермионагийн эсэргүүцэл чанга инээдэнд дарагдав. Лаванда Браун Роны үгийг хөгжилтэй гэж бодов бололтой. Тэр үргэлжлүүлэн инээсээр дэргэдүүр нь өнгөрөхдөө хойшоо эргэж харлаа. Рон сэтгэл хангалуун харагдав.

Их танхимын адар цэнхэртэн хөвсгөр үүл сэвсийж өндөр цонхноос ургасан дөрвөлжин тэнгэр адил харагдав. Тэд будаа, өндгөн жаврай идэх зуур Харри, Рон хоёр Гермионад Хагрідтай өчигдөр ярилцсан тухайгаа хэллээ.

- Гэхдээ тэр биднийг шидэт амьтны хичээлийг үргэлжүүлэн судлана гэж жинхэнээсээ бодоогүй баймаар юм! Бид нар хэзээ нэг цагт ... та нар ойлгож байгаа биз дээ. .. урам зоригтой байсан уу?

- Тиймээ зүйтэй гээд Рон шарсан өндөг бүтнээр нь залгиж,

- Бид нар хичээлдээ хүч гарган хичээж байсны учир нь гэвэл Хагридад хайртай байсандаа тэр. Харин тэр биднийг тэнэг хичээлдээ дуртай гэж бодсон бололтой. Та нар хэн түүгээр Ж.А.Б.А өгнө гэж бодож байна? гэв.

Харри, Гермиона хоёр хариулсангүй тэгэх ч шаардлагагүй байлаа. Тэд нэг ангийхний хэн нь ч шидэт амьтны хичээлийг үргэлжүүлэн судлахыг хүсэхгүй байгааг ойлгож байв. Тэд Хагридын зүг харж чадсангүй ч тэр арван хормын дараа багш нарын ширээнээс өндийн урам зоригтойгоор даллахад хулчгардуухан хариу даллав.

Өглөөний цайны дараа бүгд байрандаа үлдэн профессор МакГонагаллыг ирэхийг хүлээв. Энэ жил хичээлийн хуваарь өөрчлөгдөн ярвигтай хэцүү болж профессор МакГонагалл хүн бүрийг хичээлээ үргэлжлүүлэн Ж.А.Б.А-д бэлтгэхийн тулд С.И.Ш-ийн шаардлагатай оноо авсан эсэхийг шалгах ёстой байлаа.

Гермиона агшин зуур шившлэг, хар урлагаас хамгаалах хичээл болон хувиргал, ургамал судлал, шидэт тооны ухаан, эртний дүрс үсэг, уусмалын хичээлийг үргэлжлүүлэх зөвшөөрлөө аваад эхний цаг нь эртний дүрс үсэг орох байв. Невиллийн хувьд ажил хэрэг хүндэрч дугуй царай нь профессор МакГонагалл С.И.Ш-ийн шалгалтын дүнг шалгах үед түгшүүртэй боллоо.

- Ургамал судлал сайн байна. Профессор Стебль онц үнэлгээ авсан хүнийг баяртайгаар үргэлжлүүлэн сургах болно. Хар урлагаас хамгаалах хичээл дээр

«илүү ихийг хүлээж байгаа» авсан цааш нь үргэлжлүүлж болно. Харин хувиргалын хичээлийн хувьд оноо хүрэхгүй нь. Надад их харамсалтай байна, Долгопупс гэвч «Хангалттай» хангалттай үнэлгээ Ж.А.Б.А-ийн түвшинд багадана. Таныг энэ хичээлийг үргэлжлүүлж чадахгүй байх гэж айж байна.

Невилл толгойгоо унжуулав. Профессор МакГонагалл түүнийг дөрвөлжин шилнийхээ цаанаас анхааралтай харлаа.

- Таньд хувиргалын хичээлийг үргэлжлүүлэн судлах нь ямар хэрэгтэй юм бэ?

Энэ хичээл таньд таалагддаг гэсэн сэтгэгдэл хэзээ ч төрж байгаагүй юмсан. Невилл золгүй төрхтэйгээр «эмээ хүсч байгаа» гэсэн үг бувтналаа.

- Хм гэж профессор МакГонагалл тургилаад,

- Танай эмээ чинь ач хүүгээрээ бахархах ёстой бишүү. Ялангуяа ид шидийн яаманд болсон үйл явдлын дараа гэв.

Невилл улайгаад ичингүйрлээ. Тэр хэзээ ч профессор МакГонагаллаас магтаал сонсож байгаагүй билээ.

- Харамсалтай нь Долгопупс таныг Ж.А.Б.А-д бэлтгэх ангидаа авч чадахгүй нь.

Намайг шившлэгийн хичээлд «илүү ихийг хүлээж байгаа» гэсэн үнэлгээ хүлээж байгаа болохыг мэдсээр байж яагаад бэлдээгүй юм бэ?

- Эмээ шившлэгийг сул гэж боддог юм.

- Шивлэгийн хичээлээ үргэлжлүүл харин би Августад шившлэгийн хичээлийн С.И.Ш дээрээ унаж байсан тухай нь хэдэн үг хэлье ... тэр өөрөө ч үүгээрээ бахархахгүй байх.

Невиллийн хөөрсөн итгэлгүйхэн царайг харж профессор МакГонагалл инээмсэглээд шидэт саваагаараа хоосон цаас тогшиж хичээлийн хуваарийг нь өглөө.

Дараа нь профессор МакГонагалл Парвати Патил руу эргэв. Тэр эхлээд Флоренц гэдэг үзэсгэлэнтэй сайхан хүн морь мэргэ төлгийн хичээлийг үргэлжлүүлэн заах эсэхийг асуулаа.

- Энэ жил профессор Трелони тэр хоёр ангиудыг хуваан авч байгаа гэж профессор МакГоаналл таагүйхэн хэллээ. Бүгд түүнийг мэргэ төлгийн хичээлийг үзэн яддаг болохыг мэддэг байв.

- Харин зургадугаар дамжааны хувьд профессор Трелони хичээл заах болно.

Парвати таван хормын дараа мэргэ төлгийн хичээлийг алгасаад сэтгэлээр унасан төрхтэй болов.

- Тэгэхээр Поттер, Поттер гээд профессор МакГонагалл бичгээ харж,

- Шившлэг, хар урлагаас хамгаалах, ургамал судлал, хувиргал ... бүгд их сайн байна. Поттер би таны хувиргалын хичээлийн шалгалтын дүнд сэтгэл хангалуун байгаагаа хэлэх ёстой. Маш сэтгэл хангалуун шүү. Харин та яагаад уусмалын хичээлийг үргэлжлүүлэхийг сонгосонгүй вэ? Надад та мракоборец болохыг хүсч байгаа гэж санагдсан юмсан гэв.

- Тиймээ, профессор гэхдээ та хэлэхдээ үүний тулд шалгалтан дээр онц гэсэн үнэлгээ авах хэрэгтэй гэсэн шүү дээ.

- Тэр чинь профессор Снегг уусмалын хичээлийн багш байх үеийнх. Харин одоо профессор Слизнорт Ж.А.Б.А-д бэлтгэх сурагчдаа «илүү ихийг хүлээж байгаа» үнэлгээ авахыг зөвшөөрч байгаа. За тэгээд уусмалын хичээлийг үргэлжлүүлэхийг хүсч байна уу?

- Тиймээ, гэхдээ би сурах бичиг, уусмалын орц болон бусад зүйлсийг худалдан аваагүй ...

- Би профессор Слизнорт таньд чухал шаарлагатай зүйлсийг зээлдүүлэх байх гэдэгт итгэлтэй байна. Маш сайн байна, Поттер энэ таны хичээлийн хуваарь. Ингэхэд Гриффиндорын квиддичийн багт орох хүсэлтэй арван хоёр хүн хэдийн бүртгэсэн байгаа. Би таньд жагсаалтыг өгөөд боломжтой үедээ сорилтыг явуулаарай.

Хэдэн хормын дараа Рон Харрийн адил хичээл үргэлжлүүлэх зөвшөөрөл аваад хоёул ширээнээс бослоо.

- Хараач гээд Рон баяртайгаар хичээлийн хуваариа судлан,

- Бидэнд одоо сул цаг байна ... хичээлийн дараа ... бас үдийн хоолны дараа ... энэ ч сайхан хэрэг шүү! гэв.

Тэднийг амралтын өрөөнд эргэн ирэхэд долдугаар дамжааны Кэти Белл тэргүүтэй хэдэн сурагчдаас өөр хүн байсангүй. Тэр ганцаараа Харриг нэгдүгээр дамжаанд орсноос хойш квиддичийн багийн үндсэн гишүүн болж үлджээ.

- Би чамайг авна гэж мэдсэн юмаа, сайн байна! гэж тэр өрөөн дундуур хашираад Харрийн энгэр дэх ахлагчын тэмдгийг зааж,

- Тэгээд сонголт хэзээ эхлэх гэж байна даа! гэлээ.

- Тэнэг юм бүү ярь. Чи шалгаруулалтанд орох ямар хэрэгтэй юм бэ, би таван жилийн турш яаж тоглодогыг чинь харлаа ...

- Үгүй ээ, тэгж болохгүй. Чи тэнхимд надаас өөр сайн тоглогч байгаа эсэхийг яаж мэдэх болж байна. Хамгийн сайн баг бол ахмад нь тоглочдоо хуучин дурсамж юмуу найз нөхөд болон танилуудаа цуглуулдаггүй явдал юм.

Рон эвгүйцсэнээ Гермionaгийн дөрөвдүгээр дамжааны сурагчаас хураасан хаздаг нисдэг тавгаар тоглож эхлэв. Таваг өрөөн дундуур нисээд архиран зурагны үзүүрээс шүдээрээ зуухыг оролдов. Живоглотын шар нүд түүнээс салахгүй ширтэж байснаа хэтэрхий ойртох үед чанга исгэрлээ.

Цагийн дараа Харри, Рон хоёр нарны гэрэлтэй амралтын өрөөнөөс дургүйхэн гарч дөрвөн давхарт байдаг хар урлагаас хамгаалах хичээлийн анги руу явлаа. Гермiona хэдийн хаалганы өмнө бусад сурагчдын хамт зогсоод гартаа хүнд ном барьжээ.

- Бидэнд эртний дүрс үсгийн хичээл дээр ямар их гэрийн даалгавар өгсөн гээч гэж Рон, Харри хоёрыг ойртоход түгшин хэлээд,

- Арван таван инчийн урттай зохион бичлэг, хоёр орчуулга бас үүнийг лхагва гариг гэхэд уншиж дуусгах ёстой! гэлээ.

- Аймшиг гээд Рон эвшээлээ.

- Хүлээгээрэй гэж тэр эгдүүцэн хэлээд,

- Снег бас бидэнд их гэрийн даалгавар өгнө гэдэгт мөрийцсөн ч болох юм! гэлээ.

Тэгтэл ангийн хаалга нээгдэн шарангуй царайг нь тослог хар үс эмжин унжсан Снег гарч ирлээ. Ангийн гадаа байсан хүүхдүүд чимээгүй болов.

- Дотогшоо! гэж Снег тушаав.

Харри босго алхан ороод ийш тийшээ харлаа. Энд Снегийн хувийн бүх зүйл хэдийн байрлалаа олжээ. Цонхны хөшиг хаалттай байсан улмаас өрөөнд харанхуй байлаа. Хананд өвдсөндөө зовж шаналсан болон аймшигтай шархдаж эсвэл эсвэл тарчилсандаа атиралдаж байгаа аймшигт шинэ зургууд бий болжээ. Сурагчид чимээгүйхэн суугаад дотор эвгүйцэм зураг руу түгшин харцгаав.

- Би та нарыг сурах бичиг авчир гэж хэлээгүй гээд Снег хаалга хааж багшийн ширээний дэргэд зогслоо. Гермiona яаран сурах бичгээ ширээн доор байсан цүнхэнд хийлээ.

- Зүгээр л намайг сонсож сатаарахгүй байхыг гуйя.

Түүний хар нүд сурагчдыг өнгөрөөд Харрийн царай дээр бусдаас удаан тогтов.

- Та нар энэ хичээлийг сурах хугацаандаа таван багш сольсон нь надад илэрхий байна.

«Надад илэрхий гэнэ шүү. Чи тэднийг элээ шиг дагалдаж дараагийн хүн нь болно гэж найдаж байсан биз дээ» гэж Харри хорсон бодов.

- Эдгээр багш нар бүгд өөрсдийн арга барилтай байсан. Ийм системгүй сургалтанд та нарын ихэнх чинь С.И.Ш өгсөн явдал гайхуулж байна. Бас өөр илүү гайхуулсан зүйл гэвэл та нар ийм мэдлэгтэйгээр илүү өндөр түвшний Ж.А.Б.А-д бэлтгэх гэж байгаа явдал юм.

Снегг хана даган явахдаа дуугаа намсгахад сурагчид хүзүүгээ эргүүлэн харлаа.

- Хар урлаг бол маш олон янзын үргэлж хувиран өөрчлөгдөж байдаг зүйл юм.

Түүнтэй тэмцэнэ гэдэг нь олон толгойтой мангастай тэмцэхтэй адил. Нэг толгойг нь таслахад оронд нь шинэ ургаж өмнөхөөсөө илүү хэрцгий ухаалаг болно. Энэ бол тогтворгүй, баригдашгүй үргэлж гаднах төрхөө өөрчилж байдаг дийлдэшгүй өрсөлдөгчтэй хийх тулаан юм.

Харри Снегг рүү харлаа. Тэр хар урлаг бол аюултай дайсан гэдэг ганц зүйлийг хүлээн зөвшөөрч байсан ч Снегг түүний тухай хайртай юм шиг ярьж байлаа.

- Та нарын хамгаалалт уян хатан сэргэлэн байх ёстой. Эдгээр зурагнууд та нарт зөв төсөөлөл өгөх болно. Жишээлбэл энэ Круциатус шидийн үйлчлэл дор зовж байгаа хүн (зовж шаналсандаа атиралдан хашгирч буй шидтэн рүү заалаа), Дементорын үнсэлт (зурган дээр хүчгүй болсон шидтэн хана налан суугаад урагшаа хоосон нүдээр ширтэж байв), инферналын дайралтын дараа (газар цусанд будагджээ).

- Тэгэхээр инферналууд үнэхээр байдаг хэрэг үү? Тэр тэднийг ашиглаж байгаа гэдэг нь илэрхий биз дээ? гэж Парвати Патил нарийхан хоолойгоор асуув.

- Өнгөрсөн удаад Хар лорд инферналуудыг ашиглаж байсан. Тиймээс энэ удаад ахин ашиглаж болзошгүй. Тэгэхээр ...

Тэр эсрэг талын хананаас багшийн ширээ рүү жанчаа намируулан буцлаа.

- ... одоо та нарыг үгэн бус шившлэгтэй танилцаагүй байгаа гэж бодож байна.

Үгэн бус шившлэг гэж юу болохыг хэн хэлэх вэ?

Гермионагийн гар дээш өргөгдөв. Снегг яаралгүйхэн ангийг тойруулан хараад сонголт үгүй болсон гэдгийг мэдмэгц,

- Их сайн байна. Хатагтай Грэйнджер! гэлээ.

- Өрсөлдөгчдөө ямар шившлэг хэрэглэх гэж байгаагаа мэдэгдэхгүй хэрэглэх шидийн төрлийг хэлнэ. Энэ нь агшин зуур болдогоороо давуу талтай.

- Та «Шившлэгийн сурах бичиг» номд байгаа үгийг давтаж байна гэж Снегг үл тоомсорлон хэлээд, (Малфой буланд хорсолтой хөхөрлөө)

- Гэхдээ хариулт зөв байна. Үнэхээр хашгиралгүйгээр шившлэгийг хэрэглэж чаддаг хүн цаг хугацаа хожих болон дайснаа гэнэдүүлэх давуу талтай. Мэдээж үүнийг тийм ч олон шидтэнгүүд эзэмшиж чадахгүй. Энд нь гол нь сэтгэлдээ хүчээ цуглуулан төвлөрөх явдал юм гээд Харри дээр харц нь тогтлоо.

Харри Снегг өнгөрсөн жил бүтэлгүйтлээр төгссөн окклюменцийн хичээлийн талаар бодож байгааг мэдэж байв. Тэр Снеггийг ууртай ширтэхэд харц буруулсангүй.

- Одоо та нар хос болон хуваагд. Нэг нь нөгөөгийнхөө эсрэг үгүй шившлэг илгээхийг хичээ. Нөгөөдөх нь ч гэсэн чимээгүй хариулахыг оролд. Эхэлцгээ.

Снегг Харри өнгөрсөн жил дамжааныхны хагаст (ДА-гийн бүх гишүүд) Бамбай шидийг заасныг мэдээгүй байлаа. Гэхдээ тэдний хэн нь ч үүнийг үггүй хийж байсангүй. Олонхи нь шившлэгийг чанга бус шивнэж байлаа. Хичээл эхлээд арван хором болсны дараа Гермiona нэг ч чимээ гаралгүй Невилл рүү Хөл хөшөөх шившлэг илгээв. «Ямар ч багш ийм амжилт гаргасны төлөө Гриффиндорыг хориос доошгүй оноогор шагнах байсан даа» гэж Харри гашуунаар бодсон ч Снегг юу ч ажиглаагүй дүр эсгэв. Тэр сурагчдыг сургуулилах зуур анги дундуур том сарьсан багваахай мэт явж Харри, Рон хоёрын даалгаварыг хэрхэн биелүүлж буйг харав.

Роны Харрид шившлэг илгээх ээлж болоход царай нь улайгаад санаандгүй шившлэгийг шивнэхгүйн тулд уруулаа чанга жимийжээ. Харри саваагаа өргөөд дурын агшинд шившлэгийг няцаахыг хүлээсэн ч тэгэх хэрэг гарсангүй.

- Ямар дорой юм бэ, Уизли гэж Снегг тэднийг хэсэг зуур харсны дараа хэлээд,

- Алив би үүнийг яаж хийхийг үзүүлье гэв.

Тэр шидэт саваагаа түргэн даллаад Харри руу чиглүүлэхэд өөрийн мэдэлгүй үггүй шившлэгийн тухай мартаад,

- Протего! гэж ориллоо.

Түүний Бамбай шид хүчирхэг байсан болохоор Снегг хойшоо нисээд ширээ мөргөн унав. Бүгд зогсоод Снегг хэрхэн ууртай хөмсөг зангидан босч ирэхийг харлаа.

- Та бидний өнөөдөр үггүй шившлэгээр хичээллэж байгаа гэдгийг санаж байна уу, Поттер?

- Тиймээ.

- Тиймээ, ноёнтоон.

- Намайг заавал ноёнтон юмуу профессор гэж дуудах ёстой.

Үг гарахаас урьтаж Харри түүний юу хэлэхийг ойлгожээ. Хэд хэдэн хүн дуу алдсаны дотор Гермiona орлоо. Рон, Дин, Симус нар Снеггийн араас дэмжингүй инээмсэглэв.

- Бямба гаригийн үдэш миний өрөөнд ирэх шийтгэл оноолоо. Поттер би ичгүүргүй хэнийг ч ... тэр ч байтугай сонгогдсоныг ч хүртэл тэвчиж чадахгүй.

- Энэ ч янзтай байсан шүү, Харри! гэж Рон хичээл дууссаны дараа аюулгүй газар очоод инээд алдан хэллээ.

- Чи тэгж хэлэх хэрэггүй байсан юм гээд Гермiona Рон руу муухай харан,

- Чамайг юу хатгаа вэ? гэлээ.

- Хэрвээ чи ажиглаагүй бол тэр намайг гэмтээхийг хүссэн. Надад энэ окклюменцийн хичээл хангалттай! Тэр яагаад өөртөө өөр усан гахай олж болдоггүй гэж. Ер нь Дамблдорын толгойд яахаараа түүнд хамгаалах хичээлийг өгөх санаа орсон юм бол? Хар урлагын талаарх яриаг нь сонссон уу? Тэр түүнийг хүндэлж байна! Бүх тогтворгүй дийлдэшгүй зүйлийх нь хамтаар ...

- Гэхдээ би түүнийг чамтай адил ярьж байна гэж бодсон юмсан.

- Надтай адил гэнээ?

- Тиймээ чи бидэнд Волан-де-Морттой тэмцсэн тухайгаа яриа биз дээ. Чи тэгэхэд олон шившлэг сурахдаа биш зүрх зориг тэвчээр гол нь гэсэн ... Үүнийг л Снег хэлсэн биз дээ? Хамгийн гол нь зоригтой байж түргэн сэтгэхэд байгаа юм.

Харри түүний үгийг цэгнэж үзэхэд «Хувиргалын хичээлийн онол»-ыг цээжилсэн ч маргаж чадахааргүй байлаа.

- Харри! Хөөе, Харри!

Харри эргэж харлаа. Өнгөрсөн жил Гриффиндорын шигээ багт байсан хоёр довтлогчын нэг болох Жек Слоупер гартаа хуйлаастай цаас барин гүйцэв.

- Үүнийг чамд гэж тэр амьсгаадан хэлээд,

- Сонсооч би чамайг шинэ ахлагч болсон гэж дууллаа. Сонголт хэзээ болох юм бэ? гэв.

- Би шийдээгүй байна гээд Харри Слоуперт томоохон аз таардаггүй л юм бол багтаа буцаж орохгүй байх гэж бодов. Би чамд хэлье.

- За ойлголоо. Би энэ амралтын өдөр байх гэж найдаж байна ...

Гэвч Харри хэдийн сонсохоо болиод хуудсан дээрх Дамблдор налуу бичгийн хэвийг танилаа. Тэр Слоуперийг орхиод Рон, Гермiona хоёрын хамт холдож цаасыг дэлгэв.

Хүндэт Харри!

Бидний хичээл энэ бямба гаригт эхлээсэй гэж хүсч байна. Миний өрөөнд оройн найман цагаас ирээрэй. Хичээлийн анхны өдөр чинь таатай өнгөрсөн гэж найдна.

Хүндэтгэсэн

Альбус Дамблдор

Жич: Би исгэлэн мөсөн чихэрт их дуртай.

- Тэр исгэлэн мөсөн чихэрт дуртай гэнээ? хэмээн Харрийн мөрөн дээгүүр уншиж байсан Рон асуулаа.



- Энэ бол түүнийг өрөөг хамгаалдаг лууны нууц үг гэж Харри аяархан хэлээд,
- Ха! Снегг баярлахгүй л байх даа ... Би одоо түүний шийтгэлд үлдэж чадахгүй боллоо гэв.

Хичээлийн үлдсэн хэсэгт найзууд Дамблдор Харрид юу заахыг тааж өнгөрүүлэв. Рон үүнийг Үхэл идэгч нарын ч мэдэхгүй гайхамшигтай үр нөлөөтэй шившлэг гэж бодож байлаа. Гермiona энэ нь хууль бус гэсэн бөгөөд Дамблдор түүнийг өндөр түвшиний хамгаалах шидэд сургахыг хүсэж байгаа гэж бодож байв. Хичээлийн дараа түүнийг шидэт тооны ухаандаа явахад Харри, Рон хоёр амралтын өрөөндөө эргэж ирэн Снеггийн гэрийн даалгаварыг дургүйхэн авлаа. Энэ нь маш ярвигтай хэцүү байсан болохоор дуусгаж чадсангүй тул Гермiona тэдэнтэй үдийн хоолны дараах чөлөөт цагаар нэгдлээ. Тэднийг эцэстээ хийж дуусгах үед уусмалын хоёр цагийн хичээлийн хонх дуугаран танил замаар доош уруудан Снеггийн удтал орогнож байсан газар болох газар дорхи хонгилд ирлээ.

Тэднийг хонгилд ирэх үед Ж.А.Б.А-г үргэлжүүлэн судлахаар арван хоёроос илүүгүй сурагч үлдсэн байв. Крэбб, Гойл хоёр С.И.Ш. дээр хангалтай оноо авч чадаагүй нь илэрхий ч ямар ч гэсэн дөрвөн Слизеринчүүд хэрэгтэй дүнг авсны тоонд Малфой оржээ. Өөр бас хонгилд Когтевраны дөрвөн хүүхэд, Пуффендуйгаас ганцхан Эрни Макмиллан байлаа. Харрид тэр сүржин зантай ч гэсэн таалагддаг байв.

- Харри гээд Эрни албархуу байдалтай гар барьж,
- Надад өнөөдөр хар урлагаас хамгаалах хичээл дээр хэлэх боломж олдсонгүй.

Минийхээр бол сайн хичээл байлаа Бамбай шид хуучин ДА-гийн ... Рон, Гермiona юу байна даа?

Тэднийг дөнгөж хариулж амжаад байтал ангийн хаалга нээгдэн эхлээд Слизнортын гүзээ цухуйснаа дараа нь өөрөө гарч ирлээ. Тэр өтгөн сахал дороо баяртай инээмсэглэн сурагчдыг нэг нэгээр нь оруулахдаа Харри, Забини хоёртой урам зоригтой мэндлэв.

Газар дорх хонгилд дасал болоогүй өнгө бүрийн уур манан дүүрч гайхалтай үнэр ханхалж байлаа. Харри, Рон, Гермiona гурав буцаж байгаа том тогоонуудын дэргэдүүр өнгөрөхдөө сониучирхан үнэрлэж үзэв. Дөрвөн Слизеринчүүд нэг ширээнд хамт суухад нөгөөг нь дөрвөн Когтевранчууд эзлэн, Харри, Рон, Гермiona гурав үлдсэнд нь Эрнигийн хамт суув. Тэд анхилам үнэртэй алтлаг шингэнтэй тогооны ойролцоо ширээ сонгон суулаа. Харрид нэгэн зэрэг бурамтай бялууны үнэр болон шүүрний бариулын үнэр, Үүрэнд үнэртэж байдаг нэг төрлийн цэцгийн үнэр ханхлав. Тэр удаанаар гүнзгий амьсгалахад уусмалын үнэр бүх биеийг нь гайхамшигтай ундаа мэт дүүргэлээ. Тэр баяртайгаар Рон руу инээмсэглэхэд урдаас нь хариу инээмсэглэв.

- Ингээд гэж Слизнорт хэлээд нүсэр бие нь янз бүрийн өнгийн ууран дундуур бүртгэлээж,
- Та нар жинлүүр, уусмалын орц болон хэрвээ мартаагүй бол бас сурах бичгээ гаргацгаа ... гэв.

- Ноёнтоон! гээд Харри гараа өргөв.
- Харри, хүү минь?
- Надад сурах бичиг, жинлүүр юу ч байхгүй ... Ронд ч гэсэн ... бид үргэлжүүлэн сурна гэдгээ мэдээгүй болохоор ...
- Аан тийм л дээ, энэ талаар профессор МакГонагалл дурссан санагдаж байна ... санаа зовох хэрэггүй дээ, юунд ч санаа зовох хэрэггүй, хонгор хүү минь. Өнөөдөр миний шүүгээнээс орц жинлүүр болон бусад зүйлс олдох байх гэж бодож байна. Бас хуучин сурах бичгийн нөөц дундаас Флориш Блоттсоос ном ирэх хүртэл эхэн үедээ хэрэглэж болох олдох байх.

Слизнорт булангийн шүүгээ рүү эргээд Либациус Борагогийн хоёр үнгэгдэж навтарсан сурах бичиг авч Рон, Харри хоёрт өнгөө алдсан жинлүүрийн хамт өглөө.

- Тэгэхээр гээд Слизнорт ахин самбарын урд очоод цээжээ төвийлгөхөд хантаазны товч нь бүлт үсрэх шахав.
- Би та нарт хэдэн сонирхолтой уусмал бэлдсэн. Тийм төрлийн уусмалыг та нарыг Ж.А.Б.А-гийн шалгалт өгөхдөө бэлдэж чаддаг байх ёстой. Та нар чанаж байгаагүй ч гэсэн тэдний талаар сонсож байсан байх. Энэ уусмалын юу болохыг надад хэлэх хүн байна уу?

Тэр Слизеринчүүдийн дэргэдэх ширээн дээр байгаа тогоо руу заалаа. Харри сандлаасаа өндийгөөд тогоонд ердийн устай төстэй шингэн буцалж байхыг харав.

Гермиона бусдаас түрүүлэн гар өргөхөд Слизнорт түүнийг заав.

- Энэ бол Үнэнийг хэлүүлэгч уусмал өнгөгүй, үнэргүй. Үүнийг уусан хүн үнэнийг хэлдэг юм.
- Их сайн байна, их сайн байна! гэж Слизнорт урамшуулаад,
- Харин одоо гээд Когтевранчуудын дэргэдэх тогоо руу заав.
- Энэ уусмал ч гэсэн алдартай ... сүүлийн үед ид шидийн яамны ухуулах хуудсанд гараад байгаа ... Хэн мэдэх вэ?

Гермиона ахин бусдаас түргэн гараа өргөлөө.

- Энэ бол Хувиргагч уусмал.

Харри ч гэсэн удаанаар буцалж буй шавар шиг шингэнийг таниад Гермионаг түрүүлж хариулсан явдалд гомдсонгүй. Эцсийн эцэст тэр л энэ уусмалыг хоёр дугаар дамжаандаа амжилттай бэлтгэж байсан билээ.

- Сайн байна, маш сайн байна! Харин одоо энэ ... за, хонгор минь гэж Слизнорт Гермионаг ахин гараа өргөхөд гайхширан хэлэв.

- Энэ бол Амортенция!

- Үнэхээр мөн. Энэ хэдий тэнэг байж болох ч гэхдээ яаж үйлчилдэгийг нь мэднэ биз дээ?

- Энэ бол дэлхий дээрх хамгийн хүчтэй хайрын уусмал!
- Яг зөв! Та харваас түүнийг танан цагаан гялалзсан өнгөөр нь таньсан бололтой?
- Уур нь онцгой эргэлдэж байна гэж Гермиона урам зоригтой хэлээд,
- Бас хүн бүрт юу таалагддагаар нь ялгаатай үнэртдэг. Жишээлбэл би шинэхэн хадсан өвс болон, шинэ цаасны үнэр бас ...

Тэр үл мэдэг улайснаа өгүүлбэрээ дуусгасангүй.

- Таны нэрийг мэдэж болох уу, хонгор минь? гэж Слизнорт Гермионагийн ичингүйрснийг ажиглалгүй асуулаа.
- Гермиона Грэйнджер, ноёнтоон.
- Грэйнджер? Грэйнджер? Та санамсаргүй Ер бусын үйлчилгээтэй уусмалын нийгэмлэгийн Гектор Дагварт-Грэйнджерийн хамаатан биш биз дээ?
- Үгүй, тэгж бодохгүй байна, ноёнтоон. Би маглуудын гэр бүлээс гаралтай.

Харри Малфой Нотт руу бөхийн чихэнд нь ямар нэгэн зүйл шивнээд хоёул инээлдэхийг ажигласан ч Слизнорт өчүүхэн ч гомдсонгүй бөгөөд эсрэгээрээ инээмсэглэн Гермионагийн дэргэд сууж байгаа Харриг харлаа.

- Аанхан! Миний хамгийн сайн найз маглуудын гэр бүлээс гаралтай хэдий ч бүгдээс илүү сурдаг! Тэгэхээр та энэ найзынхаа тухай ярьсан байх нь ээ, Харри?
- Тиймээ, ноёнтоон гэж Харри хэлэв.
- Их сайн байна, Гриффиндорт хорин оноо өглөө, хатагтай Грэйнджер.

Малфой Гермиона түүний нүүр лүү цохьсон мэт төрхтэй болов. Гермиона баясан гийгээд Харри руу эргэн шивнэж,

- Чи үнэхээр түүнд намайг хамгийн сайн сурдаг гэж хэлсэн юм уу? Өө, Харри минь дээ! гэв.
- Үүнд чинь сэтгэгдэл төрмөөр юм юу байгаа юм? гэж Рон ойлгомжгүй шалтгааны улмаас уурсан хэлээд,
- Чи дамжаандаа хамгийн шилдэг нь болохоор би ч гэсэн түүнийг асуусан бол тэгж хэлэх байсан! гэв.

Гермиона инээмсэглээд Слизнорт ахин ярьж эхлэхэд хуруугаараа уруулаа дарлаа. Рон бухимдсан төрхтэй болов.

- Үнэн хэрэгтээ Амортенция хайрыг бүтээж чадахгүй. Хайрыг үйлдвэрлэж хуулбарлах нь боломжгүй хэрэг юм. Үгүй, энэ жирийн ундаа зүгээр л хүчтэй дур булаан толгой эргүүлэх үйлчилгээтэй. Энэ нь аюултай байж болох хэдий ч хүчирхэг уусмал одоо энэ өрөөнд хадгалагдаж байна. Харин одоо ажилдаа орцгооё.
- Ноёнтоон та энэ тогоонд юу байгааг хэлсэнгүй гээд Эрни Макмиллиан Слизнортын ширээн дээр байгаа жижигхэн хар тогоо руу заалаа. Түүн дотор алтлаг

шингэн хөгжилтэй буцалж томоохон дуслууд нь алтан загас шиг дээшээ үсэрч байсан ч гадагш асгарсангүй.

- Аанхан гэж Слизнорт ахин хэлэхэд Харрид тэр энэ уусмалын тухай мартсан биш зөвхөн асуулт хүлээж байсан нь ойлгомжтой болов.

- Тиймээ. Энэ. Юу гэвэл ноёд хатагтай нараа энэ сонирхолтой уусмалыг «Феликс Фелицис» гэдэг юм. Би ойлгож байна гээд чанга дуу алдсан

Гермиона руу эргэн инээмсэглэж,

- Та «Феликс Фелицис»-ийн үйлчлэлийг мэдэх үү, хатагтай Грэйнджер? гэлээ.

- Энэ бол азын шингэн! Тэр аз авчирдаг юм!

Бүгд суудал дээрээсээ өндийлөө. Харри Малфойн цайвар үстэй шилэн хүзүү өлийхийг харлаа.

- Зүйтэй, Гриффиндорт арван оноо өглөө. Тиймээ энэ хөгжилтэй уусмалыг «Феликс Фелицис» гэдэг юм. Бэлтгэхэд итгэмээргүй хэцүү үйл явцыг нь жаахан л зөрчих юм бол аюултай. Гэхдээ зөв хийсэн тохиолдод жишээлбэл оролдого бүрт чинь аз авчирна ... үйлчлэлээ гарах хүртэл.

- Яагаад хүмүүс түүнийг үргэлж уудаггүй юм бэ, ноёнтоон? гэж Терри Бут тэсч ядан асуулаа.

- Яагаад гэвэл толгой эргүүлж хариуцлагагүй болгон өөртөө хэт итгэх аюултай. Их хэмжээгээр хэрэглэвэл хортой.

- Та түүнийг хэзээ нэгэн цагт хэрэглэж байсан уу, ноёнтоон? гэж Майкл Корнер ихэд сониучирхан асуулаа.

- Амьдралдаа хоёр удаа. Нэг удаа хорин дөрвөн настай байхдаа, бас нэг удаа тавин долоон настай байхдаа. Хоёр халбага өглөөний цайн дээрээ уусан. Хоёр маш сайхан өдөр байсан.

Тэр хоосон орон зай руу мөрөөдөнгүй харлаа. Жүжиглэж байгаа юм болов уу гэж Харри бодсон ч сэтгэгдэл төрүүлэм харагдаж байлаа.

- Ингээд өнөөдрийн хичээл дээр энэ уусмалыг хийсэн хүнийг шагнах болно. Нам гүм болоход тогоон дахь уусмал арав дахин чанга буцаллаа.

- Нэг жижигхэн лонх «Феликс Фелицис» арван хоёр цаг аз авчирна. Үүр цайхаас авхуулаад үдэш болох хүртэл хийсэн бүх зүйл чинь азтай байх болно гээд Слизнорт халааснаасаа жижигхэн шилэн лонх гаргаж ирээд бүгдэд түүнийгээ үзүүлэв.

- Гэхдээ та нарт анхааруулахад «Феликс Фелицис»-ийг албан ёсны спортын тэмцээн уралдаан, шалгалт, сонголтын өмнө хэрэглэх хориотой болохыг хэлэх байна. Учир нь ялалт зөвхөн ер бусын өдөр байх юм ... бусад өдөр ер бусын байж чадахгүй!

- Тэгэхээр энэ гайхамшигтай шагналыг хожихын тулд юу хийх ёстой вэ? гэвэл гээд Слизнорт гэнэтхэн ажил хэрэгч өнгөөр,

- «Уусмалын дамжааны сурах бичиг»-ийн арав дугаар хуудсыг нээ. Бидэнд багахан цаг үлдсэн ч энэ хугацаанд та нар амьд үхлийн ундаа чанаж амжина. Би одоо хүртэл та нарыг тийм хэцүү найрлагатай уусмал чанаж үзээгүйг мэдэж байгаа учир сайн үр дүн хүлээхгүй. Гэхдээ хамгийн сайн үр дүнд хүрсэн хүнийг энэ жижигхэн Феликсээр шагнах болно. За, эхэлцгээ! гэлээ.

Сурагчид нэгэн зэрэг тогоогоо хангинуулж, зарим нэг нь жинлүүрээ дуугаргасан хэдий ч хэн ч үг хэлсэнгүй. Ангид нам гүм болж бүрэн төвлөрөл бий болов. Харри Малфой номоо идэвхийлэн шагайхыг харав. Тэр харваас амжилттай өдөр хүсч байгаа бололтой. Харри яаран Слизнортын өгсөн элэгдсэн сурах бичиг рүү тонгойв.

Түүний урмыг хугалан түрүүчийн эзэмшигч бүх хуудас дээгүүр сараачин мөр хоорондын зайг хар бэхээр дүүргэжээ. Харри орцны найрлагыг харахын тулд улам тонгойлоо (өмнөх эзэмшигч дээр нь баллан тайлбар бичсэн байв). Дараа нь шүүгээнээс чухал шаардлагатай орц авахаар ухасхийв. Тэгээд буцах замдаа Малфой асар их хурдтайгаар бамбай өвсний үндэс хэрчихийг харлаа.

Хүн бүр эргэн тойрны хөршүүдийнхээ юу хийж буйг харав. Уусмалын хичээлийн таагүй нь гэвэл хэн ч өөрийнхөө ажлаа бусдаас нууж чаддаггүй байлаа. Арван хормын дараа өрөөнд цэнхэр уур битүү суунаглаж Гермiona үргэлжид байдаг шигээ бусдаас түргэн хөдөлж байлаа. Түүний уусмал хэдийн хар үхрийн нүдийг санагдуулам өнгөтэй болоод байв.

Харри үндсээ хэрчиж дуусаад ахин ном руугаа тонгойлоо. Тэр өмнөх эзэмшигчийн тэнэг сараачилтан дор аймшигтай уурлан байж уншихыг оролдоод сополхорусын буурцгыг хэрчих жор дор өөр заавар бичсэнийг олж харав.

Мөнгөн чичлүүр хутгаар хавтгайлан дарвал хэрчихэд хялбар болно.

- Ноёнтоон, би таныг миний өвөө Абракс Малфойг мэдэх байх гэж бодлоо? Харри сурах бичгээсээ хөндийрөн харав. Слизнорт Слизеринчүүдийн ширээний

дэргэдүүр явж байлаа.

- Тиймээ. Би түүний үхэлд ихэд харамссан ч ... түүний насан дээр лууны тууралт гардаг гэж бодоогүй юмсан гэж Слизнорт Малфой руу харалгүй хэлэв.

Ингээд цааш явлаа. Харри тогоо руугаа бөхийгөөд инээмсэглэв. Малфой түүнтэй

Харри, Забини хоёрын адил харьцана гэж бодсон нь тодорхой. Тэр үүнд Снеггээс

дасал болсон байсан юм. Энэ нь Малфой «Феликс Феллицис» хожих тэмцэлд онцгой авъяас хэрэг болно гэж найдсан мэт харагдаж байлаа.

Сополхорусын буурцаг хэрчихэд маш хэцүү байлаа. Харри Гермiona руу эргэлээ.

- Чиний мөнгөн хутгыг авч болох уу?

Тэр тэвчээргүйхэн толгой дохиод уусмалаасаа харц салгасангүй. Тэр өтгөн ягаан өнгөтэй байсан бөгөөд хэрвээ номонд итгэх юм бол цайвар ягаан өнгөтэй болох ёстой байв.

Харри буурцгаа хутганы хажуугаар няцлав. Түүний гайхлыг түрүүлэн шуудхан шүүс гоожиход атган базлаа. Харри яаран шүүсийг тогоо руугаа хийгээд уусмал даруй сурах бичигт бичигдсэний адил өнгөтэй болохыг хараад гайхлаа.

Номны түрүүчийн эзэмшигчид уурласан уур сураггүй алга болов. Харри дараагийн мөрийг анхааралтай харлаа. Сурах бичгийн дагуу цаашид уусмалыг цагийн зүүний эсрэг хутгахад ус шиг тунгалаг болох ёстой байлаа. Харин өмнөх эзэмшигчийн хувилбарыг зөвшөөрөх юм бол цагийн зүүний дагуу нэг, цагийн зүүний эсрэг долоо хутгах ёстой байлаа. Хэрвээ өмнөх эзэмшигчийн зөв байвал яана?

Харри цагийн зүүний эсрэг хутгаад дараа нь амьсгал авч цагийн зүүний дагуу нэг удаа эргүүлэв. Үр дүн нь даруйхан илэрлээ. Уусмал зөөлөн ягаан өнгөтэй болов.

- Чинийх яаж ийм болов? гэж нүүр нь улаан хүрэнтэж үс нь сэгсийсэн Гермiona уур савсуулж буй тогоон дээрээсээ асуулаа. Түүний уусмал өтгөн ягаан өнгөтэй хэвээр байв.

- Цагийн зүүний дагуу нэг хутгана.

- Үгүй ээ, гэхдээ сурах бичигт эсрэгээр гэж бичсэн байна шүү дээ! гэж тэр татгалзлаа.

Харри мөрөө хавчаад өөрийнхийгөө үргэлжлүүлэв. Долоон удаа цагийн зүүний эсрэг ... нэг удаа цагийн зүүний дагуу ... Долоон удаа цагийн зүүний эсрэг ... Нэг удаа цагийн зүүний дагуу...

Ширээний нөгөө өнцөгт Рон шүд зуун хараал тавьж уусмал нь чихэр өвсний өнгөтэй болжээ. Харри эргэн тойрноо харав. Хэний ч уусмал цайвар өнгөтэй болоогүй байлаа. Тэр газар дорхи хонгилд хэзээ ч мэдэрч байгаагүй сэтгэл хөөрлийг мэдэрлээ.

- Цаг боллоо! Бүгд хийж байгаа ажлаа орхицгоо! гэж Слизнорт мэдэгдэв. Тэрбээр удаанаар ширээ хоорондуур явж тогоо руу өнгийв. Тэгэхдээ ямар ч тайлбар хийлгүй заримдаа уусмалыг хутгах юмуу үнэрлэж үзэж байлаа. Эцэст нь Харри, Рон, Гермiona, Эрни нарын сууж байсан ширээ рүү дөхөж ирлээ. Тэр давирхайг санагдуулам Роны тогоо руу гашуудалтай инээмсэглэв. Эрнигийн бараан хөх уусмалын дэргэдүүр өнгөрлөө. Гермionaгийн уусмалын дэргэд зогсож сайшаангүй толгой дохив. Тэгээд Харрийн уусмалыг харснаа царайд нь итгэлгүйхэн өнгө тодорч хөөрөн,

- Эргэлзээгүй ялалт! гэж ангиа даяар хашгирав.

- Сайн байна, сайн байна, Харри! Бурхан минь та эхийнхээ авъяасыг өвлөн авсныг харж байна. Лили уусмалын агуу мастер байсан юм! Ингээд таньд нэг лонх «Феликс Фелицисс» амласан ёсоороо өгье, зохистой ашиглаарай!

Харри жижигхэн лонхтой алтлаг шингэнийг аваад дотор халаасандаа хийх зуураа уурласан Слизеринчүүд, сэтгэлээр унасан Гермионаг хараад гэмших баярлах зэрэгцсэн хачирхалтай мэдрэмж төрлөө. Рон мэгдсэн янзтай харж байв.

- Чи яаж үүнийг чадав аа? гэж тэр Харригаас ангиас гарах үедээ асуулаа.

- Зүгээр л аз таарсан юм гэж Харри Малфой чих тавихыг хараад хэлэв.

Гэхдээ оройн хоолны үеэр Гриффиндорын ширээнд аюулгүй суугаад бүх үнэнийг ярилаа. Түүний үг болгонд Гермионагийн царай ширүүн болж байв.

- Чи намайг мэхэлсэн гэж бодож байна уу? гэж Харри түүний цухалдсан нүүрний хувирлыг хараад хэллээ.

- Гэхдээ чи үүнийг өөрөө хийх ёстой байсан биз дээ?

- Тэр зүгээр л өөр заавраар хийсэн байна тэгээд л гүйцээ. Осолтой байж болох байсан. Гэхдээ тэр эрсдэл гаргаад түүнийхээ хариуг авлаа гээд Рон санаа алдлаа.

- Слизнорт надад энэ номыг өгч болох л байсан даа. Гэхдээ надад дээрээ юу ч бичээгүй оногдсон. Зөвхөн тавин хоёрдугаар хуудсан дээр хэн нэгний дотор муухайрсан бололтой ...

- Хүлээгээрэй гэх хэн нэгний хоолой Харрийн зүүн талд гараад гэнэтхэн Слизнортын газар дорхи хонгилд гарсан цэцгийн үнэр үнэртэв. Тэр эргэж хараад Жинниг харлаа.

- Би зөв сонсов уу? Чи номон дээр бичсэн хэн нэгний зааврыг биелүүлж байгаа юм уу, Харри?

Тэр уурлаж түгшсэн байлаа. Харри шуудхан түүний юу бодож байгааг ойлгов.

- Энэ юу ч бишээ гэж тайвшируулан хэлээд,

- Редллийн тэмдэглэлийн дэвтэртэй адил биш. Энэ бол ердөө л дээр нь сараачсан хуучин сурах бичиг гэв.

- Гэхдээ чи тэнд бичигдсэнийг биелүүлээ биз дээ?

- Ердөө л хэдхэн зөвөлгөө оролдож үзсэн юм. Үнэн шүү, Жинни тэнд өөр юу ч байхгүй.

- Жиннигийн зөв гэж Гермиона даруйхан хэлэв. Бид түүнийг шалгаж үзэх хэрэгтэй. Би бүх сэжигтэй зааврыг нь гэж хэлэх гэсэн юм.

- Хөөе! гэж Харри түүнийг цүнхнээс нь сурах бичиг гаргахад эгдүүцэн ориллоо.

- Специалис ревелио! гээд Гермиона саваагаараа хавтсыг огцом цохилоо.

Юу ч болсонгүй. Ном бохир элэгдсэн нугларсан булантай хэвтсэн хэвээр байв.

- Дууссан уу? Эсвэл арагш нь эргүүлж үзэх юм уу? гэж Харри уурсан хэллээ.

- Бүгд хэвийн гэж Гермиона хэлсэн ч ном руу сэжигтэй харав.

- Энэ үнэхээр ... жинхэнэ сурах бичиг бололтой.

- Гайхамшигтай. Би түүнийг авч болох уу? гээд Харри номыг ширээн дээрээс авахад гараас нь гулган шалан дээр унаад нээгдэв.

Хэн ч үүнийг харсангүй. Харри номоо авахаар тонгойхдоо хавтасны дотор талд чемоданд нь оймсны дор найдвартай хадгалагдаж буй жижигхэн лонх «Феликс Фелицисс» хожиход хүргэсэн заавартай адилхан бичгээр үг сараачсан байхыг харжээ.

Энэ ном эрлийз хунтайжийн хувийн өмчид хамаарагдана.



## БҮЛЭГ 10: МРАКСЫН ГЭР БҮЛ

Харри долоо хоногийн турш уусмалын хичээл дээр эрлийз хан хүүгийн зааврыг биелүүлж Либациус Борагогын зааврыг гажуудуулан үр дүнд нь дөрөв дэх хичээл дээр Слизнорт Харригийн авъяасыг бахдаж ийм авъяаслаг сурагчид багшилж байгаагүй хэмээн эцэс төгсгөлгүй давтжээ. Рон, Гермиона хоёр энэ бүгдийг хүйтнээр хүлээн авав. Хэдийгээр Харри тэдэнтэй сурах бичгээ хувцаалцахад бэлэн байсан авч Рон өмнөх эзэмшигчийн бичгийн хэвийг хүндхэн учрыг нь олж Харригаас уншиж өгөхийг гуйсан ч энэ нь хэтэрхий сэжигтэй харагдах байлаа. Гермиона албан ёсны зааврыг дагахыг дээрд үзэж ааш нь улам муудсан бөгөөд үр дүнг нь хун тайж амслаа.

Харри заримдаа энэ эрлийз хунтайж хэн байж болох талаар бодлогоширдог байв. Уул овоо шиг гэрийн даалгавар дуустал нь хүртэл унших цаг өгөөгүй ч гэлээ номоо гүйлгэж хараад хунтайж нэг ч хуудсыг шидэт уусмал бэлтгэх тухай өөрийн нэмэлт тэмдэглэлгүй өнгөрөөгөөгүй болохыг ажиглажээ. Зарим хоосон газар шившлэгтэй төстэй зүйл бичсэн нь хунтайж өөрөө зохиосон бололтой.

- Эсвэл гэж Гермиона Харрийн Ронд шившлэгийн тухай амралтын өрөөнд бямба гаригийн үдэш ярьж байхыг сонсоод,
- Энэ охин байх. Минийхээр бол бичгийн хэв нь эмэгтэй хүнийхтэй төстэй юм гэв.
- Түүнийг эрлийз ханхүү гэж нэрлэдэг гэж Харри сануулаад,
- Чи хичнээн олон ханхүү охидыг мэдэх вэ? гэлээ.

Гермиона үүнд хариулж чадсангүй. Тэр Роны уншиж байсан «Зарчмын эргэн биелэлт» зохион бичлэг рүүгээ муухай хараад угз татан холдуулав.

Харри цаг руу хараад яаран цүнх рүүгээ номоо шургууллаа.

- Долоо тавин тав би явахгүй бол Дамблдороос хоцрох нь байна.
- Ө-өө! гэж Гермиона дуу алдаад,
- Амжилт хүсье! Бид унталгүй чамайг хүлээж байя. Түүний юу заасныг мэдэхийг хүсч байна! гэлээ.
- Бүх зүйл сайн болно гэж найдаж байна гэж Рон хэлээд Харрийн хөргөн нүхээр гарахыг дагуулан харлаа.

Харри хоосон хонгилоор явлаа. Тэгтэл булангаас профсоор Трелони гарч ирэхэд хөшөөний цаагуур нуугдах хэрэг гарав. Тэр амандаа юм үглэн гартаа навсархай хөзөр бариад холингоо явах зуураа уншиж байлаа.

- Хоёрын гил мөргөлдөөн гэж Харрийн нуугдсан газрын дэргэдүүр өнгөрөхдөө хэлэв.
- Долоогийн гил муугийн тэмдэг. Арвын гил албадлага. Хөзрийн боол залуухан хар үстэй хүү хар санаа дайсагнасан харьцаа ...

Тэр гэнэтхэн Харрийн нуугдсан хөшөөний баруун талд хөшсөн юм шиг зогслоо.

- Гэхдээ энэ чинь байж боломгүй юм гэж уурсан хэлээд хэзрөө холин холдохдоо ардаа дарсны үнэр үлдээв.

Харри түүнийг хараанаас далд ормогц цааш гүйгээд долоон давхарын хананы дэргэдэх ганц луу руу очлоо.

- Исгэлэн мөсөн чихэр гэж Харри хэлэхэд луу хажуу тийш үсрэн холдож ард нь хана нээгдэн эргүүлгэн шат гаргав. Харри түүгээр дугуйран эргэлдэж зэс цохиуртай Дамблдорын өрөөнд хүрлээ.

Харри хаалга цохилоо.

- Ороорой гэх Дамблдорын хоолой сонсогдов.

- Оройн мэнд, эрхэмээ гэж Харри захирлын өрөөнд орохдоо хэллээ.

- Оройн мэнд, Харри. Суу. Чамайг хичээлийн жилийн эхний долоо хоногийг таатай өнгөрүүлсэн байх гэж найдна хэмээн Дамблдор инээмсэглэн хэлэв.

- Тиймээ, баярлалаа эрхэмээ.

- Би чамайг цаг үрэлгүй хэдийн шийтгэл хүртэж амжсаныг харж байна!

- Э-э ... гэж Харри эв хавгүйхэн хэлэхэд Дамблдор тийм ч ширүүн харагдсангүй.

- Би профессор Снеггтэй чиний шийтгэлийг дараагийн бямба гаригт болгон хойшлуулахаар ярьсан.

- Ойлгомжтой.

Түүнийг одоо Снеггийн шийтгэлээс илүү чухал зүйл хүлээж байлаа. Тэр эргэн тойрноо нууцгайхан хараад Дамблдор өнөөдөр түүнд юу үзүүлэхээр төлөвлөснийг олж харахыг хичээв. Дугуй өрөө урьдынх шигээ хэвээрээ байлаа. Урт хөлтэй ширээн дээр хэврэгхэн мөнгөн эдлэлүүд аяархан жингэнэж, өмнөх захирлын хөргүүд жаазандаа үүрэглэн, Дамблдорын сүр жавхлантай галт шувуу Фоукс хаалганы дэргэдэх хонуур дээрээ суугаад Харриг гялалзсан нүдээрээ сониучирхан харав. Дамблдор халз тулааны сургууль хийх зай бэлтгэн гаргаагүй байлаа.

- Тэгэхээр Харри чамд миний юу үзүүлэхээр төлөвлөсөн нь сонирхолтой байгаа байх ... хичээл гэдэг нь илүү тохирох юм байна гэж Дамблдор ажил хэрэгчээр хэлэв.

- Тиймээ, ноёнтоон.

- Би чамайг лорд Волан-де-Морт яагаад арван таван жилийн өмнө нэгэн мэдээллээс болж алах гэснийг одоо мэддэг болсон байх гэж бодож байна.

Нам гүм болов.

- Өнгөрсөн хичээлийн жилийн эцэст та надад бүгдийг хэлсэн гэж Харри зэмлэнгүй өнгөө нуулгүй хэлээд,

- Ноёнтоон гэж нэмэрлэв.

- Тиймээ би бүгдийг хэлсэн гэж Дамблдор тайван хэлээд.

- Би чамд мэдэх бүх зүйлээ хэлсэн. Энэ мөчид бид хатуу суурьтай баримтад тулгуурлан ой ухааны харанхуй намаг дахь шигүү таавар дунд аялал хийнэ. Магадгүй энэ агшинд би Хамфри Белчер бяслаган тогоог бэлэн болсон гэж итгэж байсантай адил алдаж байж болох юм гэв.

- Гэхдээ та зөв гэж бодож байна уу?

- Хэдийгээр би зөв гэж бодож байгаа чамд хэдийн баталсан ч бусад хүмүүсийн адил алдаа гаргаж байж болох юм. Өөрөөр хэлбэл намайг уучлаарай ... ихэнхи ухаалаг хүмүүс алдааг зөв болгон залруулж хүлээж авдаг юм.

- Ноёнтоон та надад зөгнөлтэй холбоотой юм хэлэхийг хүсээ юу? Энэ надад ... амьд үлдэхэд туслах уу? гэж Харри болгоомжтой асуулаа.

- Энэ зөгнөлтэй шууд холбоотой бөгөөд чамайг амьд үлдэхэд тус болно гэж найдаж байна хэмээн Дамблдор түүнтэй маргаашийн цаг агаарын тухай ярьж байгаа юм шиг энгийн өгүүллээ.

Дамблдор хөл дээрээ босоод бичгийн ширээгээ тойрон Харрийн дэргэдүүр өнгөрөхөд толгойгоо эргүүлээд дагуулан харав. Дамблдор хаалганы хажуугийн шүүгээ руу тонгойлоо. Тэр өндийн босохдоо гартаа хөвөөгөөрөө хачирхалтай нууцлаг тэмдэгтүүд бүхий танил чулуун суулга барьсан байлаа. Тэр гүн ухааны цүнхээлээ Харрийн урдах ширээн дээр тавилаа.

- Чамайг ямар нэг зүйл зовоогоод байна уу?

Харри үнэхээр ч гүн ухааны цүнхээл рүү түгшин харсан юм. Өмнөх туршлагаас үзэхэд энэ хачирхалтай эд маш сургамжтай тэр ч байтугай эвгүйцэм дурсамж хадгалдаг байлаа. Өнгөрсөн удаад Харри түүнээс хүссэнээсээ илүүг харсан. Гэсэн ч Дамблдор инээмсэглэв.

- Энэ удаад чи гүн ухааны цүнхээл рүү надтай хамт явах болно ... хамгийн ер бусын нь гэвэл миний зөвшөөрлөөр.

- Бид хаашаа явах вэ, ноёнтоон?

- Боб Огдены дурсамжаар аялал хийнэ гээд Дамблдор халааснаасаа дотор нь мөнгөлөг цайвар зүйл хуйлран эргэлдсэн болор хуруу шил гаргалаа.

- Боб Огден гэдэг чинь хэн юм бэ?

- Тэр шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийн ажилтан байсан юм.

Хэдэн жилийн өмнө үхсэн хэдий ч би өмнө нь түүнийг хайж олоод энэ дурсамжыг өгөхийг итгүүлсэн юм. Одоо бид хоёр түүнийг дагах болно. Босоод наашаа хүрээд ир дээ, Харри.

Дамблдор болор лонхыг онгойлгох гэсэн ч шархадсан гар нь хөдөлж өгсөнгүй.

- Алив ... алив би, эрхэмээ.

- Зүгээр дээ, Харри.

Дамблдор лонх руу саваагаа чиглүүлэхэд бөглөө нь мулт үсрэв.

- Ноёнтоон ... та гараа яаж гэмтээсэн юм бэ? гэж Харри ахин асуугаад харласан хуруу руу өрөвдөх жигших сэтгэл холилдон харлаа.

- Одоо энэ тухай ярьж байх цаг биш, Харри. Биднийг Боб Огден хүлээж байгаа. Дамблдор хуруу шилэн дэх мөнгөлөг цагаан зүйлийг сэгсрэхэд гялалзсан гүн ухааны цүнхээл рүү эргэлдэн орлоо.

- Чиний дараа гээд тэр сав руу урин зангав.

Харри суулга руу тонгойгоод гүн амьсгал авч нүүрээ мөнгөлөг шингэнд дүрлээ. Тэр хөл дороос нь шал хөндийрөхийг мэдрээд харанхуйд эргэлдэн унаж унаж гэнэтхэн нарны хурц гэрэлд нүдээ анивчин зогсож байв. Нүдээ дасгаж амжаагүй байтал Дамблдор дэргэд нь газардлаа.

Тэд өтгөн амьд бургасаар хүрээлэгдсэн хөдөө нутгийн зам дээр зогсоод дээр нь зуны цэлмэг тэнгэр цэнхэртэж байлаа. Тэдний урд арван футын зайд итгэмээргүй зузаан линз шил зүүсний улмаас нүд нь байгаагаасаа илүү жижигхэн харагдах намхан махлаг хүн зогсож байв. Тэр тосгоны модон заагчыг уншаад бөөрөлзгөнөтэй зүүн талын замаар явав. Харри энэ Огден болохыг ойлголоо. Эргэн тойрон хэн ч байсангүй ч тэр туршлагагүй шидтэнгүүд магл шиг харагдахыг оролддог үедээ өмсдөг болох хачирхалтай хувцаслан урт хормойтой сюртук дээр судалтай трико өмсчээ. Харри түүний этгээд байдлыг бүрэн харж амжихаас өмнө Огден урамтай алхсаар цааш одлоо.

Дамблдор, Харри хоёр түүнийг дагав. Тэднийг заагчын дэргэдүүр өнгөрөх үед Харри хоёр талын сум руу нь харав. Нэг нь урагшаа ирсэн зүг рүү нь зааж «Том-Хэнглтон, 5 миль» гэж байхад нөгөө нь Огдены явсан зүг рүү заан «Бага-Хэнглтон, 1 миль» гэжээ.

Тэднийг явах үед амьд бургасан хашаанаас ондоо юу ч үзэгдэлгүй дээр нь цэнхэр тэнгэр тодрон урд нь түргэн алхлах дүрс алслан холдож байв. Дараа нь зам зүүн тийшээ эргэн эгц толгодыг уруудахад гэнэтхэн урд нь хөндий гарч ирлээ. Харри хоёр толгодын дундах тосгоныг хараад эргэлзээгүй Бага-Хэнглтон байх гэж бодов. Эндхийн сүм болон оршуулгын газар нь харагдаж байлаа. Тосгоны эсрэг талын толгод дээр хилэн ногоон зүлэг эмжээрлэсэн үзэсгэлэнтэй байшин сүндэрлэж байв.

Огден дургүйхэн эгц өөдөөс налуу руу уруудав. Дамблдор алхаагаа хурдасгахад Харри түүний араас яаран гүйлээ. Тэр Бага-Хэнглтон руу Слизнортынд очсон шөнө шиг явж байна гэж бодсон ч яагаад удтал явган явж байгаа болохыг нь гайхаж байлаа. Гэвч удахгүй алдсан болохоо ойлгов. Тэд тосгон руу явсангүй. Зам баруун тийш эргэхэд булангийн эргэлтэн дээр Огдены сюртук урд нь гялсхийн үзэгдээд бутан дунд алга болов.

Дамблдор, Харри хоёр түүний араас давчуу зөргөөр эргэхэд хөвөөлсөн амьд бургасан хашаа улам шигүү өндөр боллоо. Зам тахирлан чулуурхаг болж толгод

уруудах адил хэлбийснээ харанхуй модон дундах ташуу руу хөтлөн авчирлаа. Төдхөн зам шугуйд хүрэхэд Дамблдор, Харри хоёр шидэт саваагаа гарган зогссон Огдены ард үлдэв.

Тэнгэрт нэг ч үүлгүй хэдий ч хөгшин мододын харанхуй хүйтэн сүүдэрт нуугдаастай байгаа байшинг Харри хэдэн секунтын турш ялган харж чадсангүй. Түүнд модод нарны гэрлийг хааж байгаагаас ч тэр үү байшин барихаар сонгоход маш хачирхалтай газар санагдав. Хана нь хөвдөнд хучигдан, дээврийн ваар нь ховхорч олон тооны нүх гаран шувуу нуруу нь үзэгдэхүйц болжээ. Эргэн тойрон халгай битүү ургаж үзүүр нь жижигхэн цонхны бохир шилэнд хүрч байлаа. Харри энд хүмүүс амьдардаггүй байх гэж бодтол цонхны нэг нээлттэй бөгөөд түүгээр тачигнах чимээ гаран нарийхан утаа суунаглахыг үзвээс дотор хэн нэгэн хоол бэлтгэж байгаа бололтой.

Огден Харрид болгоомжтой байхыг анхааруулах мэт урагш чимээгүйхэн алхав. Модны сүүдэрт тэр ахин зогсоод үхсэн могой хадсан хаалганаас нүд салгалгүй харав.

Шаржигнах чимээ сонсогдоод тас няс хийхэд ойролцоох модноос үстэй хувцас өмссөн хүн харайн Огдены урд газардав. Тэр цочин ухрахдаа хормойгоо гишгээд арай л бүдэрч унасангүй.

- Таныг ийшээ хэн ч дуудаагүй.

Түүний урд зогсож байсан хүн өтгөн цайвар үстэй ч маш бохир учир ямар өнгөтэйг нь тэр гэж хэлэхийн тэмдэггүй ажээ. Аман дахь хэдэн шүд нь байхгүй жижигхэн хар нүд нь хоёр тийшээ солийж байв. Энэ нь инээдтэй хэдий ч үүнээс илүү аймшигтай харагдсан учраас Харри Огден ярихынхаа урд хэдэн алхам ухарсныг буруутгасангүй.

- Э-э ... өглөөний мэнд. Би ид шидийн яамнаас ирлээ ...

- Таныг ийшээ хэн ч дуудаагүй.

- Э-э ... өршөөгөөрэй ... би таныг ойлгохгүй байна гэж Огден бухимдан хэлэв.

Харри Огденыг мангуу юм болов уу гэж бодлоо. Харрийн бодлоор бол үл таних хүн маш ойлгомжтой хэлсэн бөгөөд гартаа барьсан шидэт саваагаа сүрдүүлэн зангахад нөгөө гартаа хутга барьжээ.

- Харри, чи түүний яриаг ойлгов уу? гэж Дамблдор аяархан асуув.

- Тиймээ, ойлгосон. Харин Огден яагаад түүнийг ... гэж Харри бодлогоширон хэллээ.

Тэгтэл түүний харц хаалганд өлгөөстэй байсан үхсэн могой дээр тусахад гэнэтхэн ойлголоо.

- Тэр могойн хэлээр ярьсан юм уу?

- Сайн байна гээд Дамблдор урамшуулан толгой дохилоо.

Тэр үед ноорхой хүн Огден руу хутга, саваагаа чиглүүлэн довтлов.

- Хөөе, сонсооч гэж Огден хэлсэн хэдий ч хожимджээ.

Ямар нэг зүйл чанга тасхийгээд Огден газар хамраа даран унахад хурууны завсраар нь шаргал шингэн годгодлоо.

- Морфин! гэх чанга хоолой сонсогдов.

Байшингаас хижээл насны хүн яаран гарч ирээд хаалга хүчтэй саван хаахад золгүй могой дороо эргэлдлээ. Энэ хүн эхнийхээсээ намхан бөгөөд хачирхалтай биеийн харьцаатай аж. Өргөн мөр урт гар, гялалзсан хүрэн нүдтэй, богинохон ширүүн үс, үрчлээтэй нүүр нь түүнийг хөгширсөн хүчирхэг сармагчин шиг харагдуулна. Тэр хутгатай инээн зогсож хүний дэргэд зогсоод газар хэвтэж байгаа Огден руу харав.

- Ид шидийн яамнаас уу? гэж хижээл хүн хэлээд Огдены дээрээс харлаа.

- Яг тийм! гээд Огден уурсан нүүрээ арчиж,

- Харин би таныг ноён Мракс гэж ойлголоо? гэв.

- Тиймээ. Тэр нүүр лүү чинь цохио юу?

- Тиймээ цохьсон! гэж Огден уурслаа.

- Анхааруулах хэрэгтэй байсан юм. Энэ бол хувийн эзэмшил. Өөрөө урилгагүй ирчихээд дараа нь миний хүүг биеэ хамгаалахыг оролдоход гайхах юм.

- Юунаас хамгаалах гэж? хэмээн Огден бувтнаад арай ядан өндийн бослоо.

- Хүний хэрэгт хошуугаа дүрэгчид, урилгагүй зочид, бузар маглуудаас.

Огден шингэн идээ шиг зүйл урсаж байгаа хамраа саваагаараа засахад даруй зогсов. Ноён Мракс Морфин руу эргэж уруулаа нээлгүй шахам,

- Гэр лүүгээ ор. Маргах хэрэггүй гэлээ.

Харри энэ удаад урьдчилан анхааруулгагүй могойн хэлийг танилаа. Тэр бүгдийг ойлгож байсан ч Огден зөвхөн хачирхалтай исгэрсэн чимээ гарахыг сонсож байв. Морфин эсэргүүцэхийг хүссэн ч эцгийнхээ ширүүн харцанд захирагдан бодлоо өөрчилж байшин руу ороод хаалга хаахад могой ахин гунигтайгаар эргэлдэв.

- Би ийшээ танай хүүтэй уулзахаар ирсэн юм, ноён Мракс гээд Огден цамцнаасаа идээний үлдэгдлийг арилгаж,

- Энэ Морфин байсан байх тийм үү? гэв.

- Тиймээ энэ Морфин гэж тэр хайхрамжгүй хэлээд,

- Та цэвэр цусны шдтэн үү? гэж гэнэтхэн асуулаа.

- Тэр энд ямар хамаатай юм? гэж Огден хүйтнээр хэлэхэд Харри түүнийг хүндэлж эхлэхээ мэдэрлээ.

Мракс үүнд өөрөөр хандсан нь ойлгомжтой. Тэр нүдээ онийлгон Огдены царай луу харснаа доромжилсон өнгөөр,

- Хэрвээ бодоод үзвэл би таных шиг ийм хамрыг тосгонд харсан юм байна гэв.

- Үүнд эргэлзэхгүй байгаа ч би танай хүүгийн талаар ярих гэсэн юм. Бид яриагаа гэрт чинь үргэлжлүүлж болох уу?

- Гэрт гэнээ?
- Тиймээ, ноён Мракс. Би таньд Морфинтой ярилцахаар ирсэн гэдгээ хэдийн хэлсэн. Бид таньд ууль илгээсэн ...
- Бид ууль ашигладаггүй. Би хэзээ ч захиа уншиж байгаагүй.
- Тийм тохиолдолд урилгагүй зочид ирдэг явдалд гомдоллох хэрэггүй гэж Огден гашуунаар хэлээд,
- Намайг энд өглөө эрт шидтэний хуулийг ноцтой зөрчсөн явдлын улмаас явуулсан ... гэв.
- За болно, болно! гэж Мракс орилоод,
- Алив гэрт орж учраа олцгооё! гэв.

Байшин гурван жижигхэн өрөөтэй байлаа. Хоёрыг нь гол өрөө гэж нэрлэж болохоор агаад гал зуух нь зочны өрөөтэйгээ шууд нийлжээ. Морфин түлээ овоолсон ханан зуухны хажуу дахь хуучин түшлэгтэй сандалд суугаад бүдүүн хуруугаа могой шиг тахийлган түүндээ хандан аяархан могойн хэлээр дуулж байлаа.

Могой, могой исгэрээрэй Шалан дээгүүр мөлхөөрэй Морфинг харин уурлуулах юм бол Хаалган дээр өлгөнө шүү

Булангийн нээлттэй цонхны дэргэд ямар нэг шар шур хийхэд Харри гэнэтхэн өрөөнд бас нэг хүн байгааг ажиглав. Саарал даашинзтай охин бохир хана руу нуруугаа харуулан зогсож байлаа. Тэр харанхуй зуухны дэргэд зогсоод саванд ямар нэг юм буцалж эргэн тойрных нь тавиур дээр бохир суулга, хайруулын таваг байв. Тэр бүүдгэр өнгөгүй шулуун үс, дүнсгэр царайтай байлаа. Нүд нь ахынх шигээ хоёр тийшээ сөлийжээ. Охин хоёр эрэгтэйгээсээ арай цэвэр харагдаж байсан ч Харри амьдралдаа хэзээ ч ийм золгүй хүнийг харж байсангүй гэж бодлоо.

- Миний охин, Меропа гэж Мракс Огдены асуунгүй харцны хариуд дургүйхэн бувтнав.
- Өглөөний мэнд гэж Огден хэллээ.

Тэр хариулсангүй эцэг рүүгээ айсан байртай хараад цааш эргэн ахин саваа тавиур дээр тавилаа.

- За, ноён Мракс ажилдаа орьё. Шуудхан хэлэхэд бидэнд таны хүү Морфин өнгөрсөн шөнө маглуудын нүдэн дээр шид үзүүлсэн гэж бодох шалтгаан байна.

Ямар нэг зүйл түжигнээд Меропа саваа унагалаа.

- Алив дээш нь ав! гэж Мракс орилов.
- Шалыг бохир магл шиг малтаж байхын оронд саваагаа яагаад хэрэглэдэггүй юм болхи амьтан минь?
- Ноён Мракс, танаас гуйя! гэж Огден цочирдон дуу алдав.

Меропа савыг хэдийн авсан байснаа улайн унагаад чичирсэн гараар халааснаасаа шидэт саваа гаргаж ирээд сав руу зангасан ч хэтэрхий яарсандаа шившлэгээ дуулдах

төдий хэлсэн тул сав өрөөн дундуур нисээд эсрэг талын хана мөргөн хоёр хэсэг болон хуваагдав.

Морфин чимэтгүй инээд алдахад Мракс,

- Түүнийгээ одоохон зас, ухаангүй тэнэг минь одоохон зас! гэлээ.

Меропа бүдчин өрөөн дундуур гүйсэн ч Огден түүнийг хориглолоо. Тэр саваагаа өргөөд хатуу хоолойгоор,

- Репаро! гэв.

Сав агшин зуур бүтэн боллоо.

Мракс одоохон Огден руу хашгирах гэж байгаа юм шиг харагдсан ч тэслээ. Тэр үүнийхээ оронд охин руугаа дооглонгуй,

- Чиний аз болоход ид шидийн яамны сайхан сэтгэлтэй ах чинь байж таарлаа!

Магадгүй тэр бохир сангасваагийн зүйлийг засаагүй бол ... гэв.

Меропа Огдены зүг харж талархалгүй суулгыг чичирсэн гараар аваад ахин тавиур дээр тавилаа. Дараа нь зуух цонхны хоорондох хананд нуруугаа наан зогсоод чулуу нэвтлээд алга болохыг хүссэн юм шиг харагдав.

- Ноён Мракс би ирсэн зорилгоо хэдийн хэлсэн гэж Огден ахин эхлэв.

- Би анхны удаад нь сайн сонссон! гэж Мракс зандрaad,

- Тэгээд юу гэж? Морфин өмхийг маглыг жаахан сургаад өгч ... Тэгээд яасан гэж? гэлээ.

- Морфин шидийн хуулийг зөрчсөн гэж Огден ширүүн хэлэв.

- Морфин шидийн хуулийг зөрчсөн гэнээ! хэмээн Мракс Огдены хоолойг дуурайн элэглэн хэлэхэд Морфин ахин хөхөрлөө.

- Бохир маглыг жаахан сургаад өгөх чинь гэмт хэрэг болж байна уу?

- Тиймээ. Тийм гэж айж байна хэмээн Огден хэлэв.

Тэр цамцныхаа дотор халааснаас жижигхэн хуйлаастай цаас гаргаад дэлгэлээ.

- Энэ чинь түүний шийтгэл үү? гэж Мракс уурандаа хоолойгоо өндөрсгөн асуулаа.

- Энэ бол ид шидийн яамны сонсголын дуудлага ...

- Дуудлага гэнээ? Дуудлага? Та миний хүүг дууддаг хэн юм бэ?

- Би ид шидийн хуулийг албадан хэрэгжүүлэх хэлтсийн ажилтан.

- Харин таныхаар бол бид нийгмийн шаарууд уу? гэж Мракс хашгираад Огден руу ухасхийн цээж рүү нь бохир шар хумстай хуруугаараа чичлэн байж,

- Нийгмийн шаар ид шидийн яамны дуудлаганд гүйгээд очих ёстой юу? Чи хэнтэй ярьж байгааг мэдэж байна уу, бохир цустан минь? гэв.



- Би ноён Мракстай ярьж байна гэж бодож байна хэмээн Огден болгоомжтой хэлэв.

- Энэ ч тодорхой! гэж Мракс орилов.

Харрид агшин зуур Мракс Огден руу ичгүүргүй хөдөлгөөн үзүүлэх шиг санагдсан ч хамрын урд нь хуруундаа зүүсэн хар чулуун бөгжөө сунгалаа.

- Үүнийг харав уу? Харсан уу? Юу болохыг нь мэдэх үү? Хэдэн зуун жилийн өмнөөс манай гэр бүлд хадгалагдаж ирсэн зүйл. Бид өөрийн төрөлдөө хамгийн эртнийх нь болохоор энэ бүх хугацаанд цэвэр цусаа хадгалж ирсэн! Энэ бол Певереллын сүлдтэй чулуу! Энэ зүйлийн талаар мэдэх үү?

- Ойлгох юм алга гээд Огден урдаа байгаа бөгж рүү үрчийн харлаа. Гэхдээ энэ хамаагүй, ноён Мракс. Таны хүү хэрэг хийсэн ...

Мракс уур хилэндээ автан орь дуу тавиад охин руугаа ухасхийлээ. Харри түүний хоолойг боох нь гэж бодсон ч хөгшин Огден руу чирж авчираад хүзүүнд нь зүүсэн алтан гинжийг үзүүлэв.

- Үүнийг харж байна уу? гэж тэр дэлбэрээд хүнд алтан гинжийг сэгсчихэд Мeroпа агаар дутагдан хахаж цацлаа.

- Харж байна, харж байна! гэж Огден яаран хэлэв.

- Энэ бол Слизеринээс өвлөгдөж ирсэн зүйл! Салазар Слизеринийх! Бид түүний цорын ганц амьд үлдсэн удам энэ талаар юу хэлэх вэ, аан? гэж Мракс орилов.

- Ноён Мракс, таны охин! гэж Огден түгшин хашгирсан ч Мракс Меролопаг хэдийн тавьж буландаа эргэн очоод хүзүүгээ илэн агаар амьсгаллаа.

- Энэ л байхгүй юу! гэж Мракс хэн нэгэнд эргэлзээтэй ер бусын хүнд зүйл баталсан мэт хөөрөн хашгираад,

- Бидэнтэй гутлыг чинь бохирдуулах юм шиг ярих хэрэггүй! Цэвэр цусны шидтэнгүүдийг та тэгж хэлж болохгүй! гэв.

Тэр Огдены хөл рүү өгшиглөлөө. Морфин ахиад л хөхрөв. Мeroпа чимээгүй цонхны дэргэд шигдэн суугаад толгойгоо бөхийн нүүрээ нуув.

- Ноён Мракс таны өвөг эцэг надад ямар ч шалтгаан төрүүлсэнгүй гэж айж байна. Би энд Морфины төлөө ирсэн. Морфин өнгөрсөн шөнө маглуудыг хоргоон танхайрсан үйлдэл гаргасан. Бидэнд ирсэн мэдээллийн дагуу гээд Огден хуйлаастай цаас руугаа харснаа,

- Морфин маглуудын эсрэг шившлэг хэрэглэн өвтгөсөн байна гэв.

Морфин хөхрөв.

- Чимээгүй, хүү минь гэж Мракс могойн хэлээр исгэрэхэд Морфин чимээгүй боллоо.

- Тэгээд юу гэж? хэмээн Мракс Огденаас асуув. Та маглуудын царайг түүгээр арчуулахгүй гэж байгаа бол түүний дурсамж ...

- Зөвхөн энэ ч биш, ноён Мракс. Болсон явдалд ямар ч шалтгаангүй дайрсан байна ...

- Би таныг маглуудад хайртай хүн болохыг шуудхан мэдсэн юмаа гээд Мракс шал дэвслэв.

- Энэ тухай ярих нь юугаар ч туслахгүй гэж Огден шийдэмгий хэлээд,

- Таны хүү өөрийн үйлдэлдээ гэмшиж байгаа талаар хэлэх ёстой гээд ахин цаас руу харснаа,

- Морфиныг есөн сарын арван дөрвөний сонсголд маглуудыг илбэдэн гэмтэл учруулсны улмаас ...

Огден уншихаа болилоо. Онгорхой цонхоор морины туурай тачигнан чанга хөгжилтэй хоолой сонсогдов. Харваас тосгоны зүгийн замаас бололтой ойртон ирээд байшингийн хажууд зогсов. Мракс байрандаа хөшөөд чимээ анирдан нүдээ томрууллаа. Морфин чимээг сонсоод хэрцгий исгэрлээ. Меропа толгойгоо өргөхөд царай нь цонхийн цайжээ.

- Бурхан минь ямар муухай юм бэ! гэх эмэгтэй хүүхдийн хоолой гарахад өрөөнд байгаа юм шиг тод дуулдлаа. Танай эцэг чинь үнэхээр энэ овоохойг зайлуулж чаддаггүй юм уу, Том?

- Тэр бидэнд харъяалагддаггүй гэх залуу хүний хоолой гараад,

- Хөндийн нөгөө тал нь биднийх харин энэ ажилгүй хөгшин Мракс болон түүний хүүхдүүдэд хамаарагддаг юм. Хүү нь галзуу чи түүний тухай тосгонд юу ярихыг сонссон ч болоосой ... гэв.

Охин инээлээ. Жингэнэсэн чимээ гаран төвөргөө улам ойртлоо. Морфин сандлаасаа босохыг хүссэн мэт өндийв.

- Байрандаа суу гэж эцэг нь могойн хэлээр анхааруулан хэллээ.

- Том магадгүй би алдсан байж болох ч хэн нэгэн хаалганд могой өлгөө юу? гэх охины хоолой гарахад энэ удаа дэргэд дуулдсаныг бодвол морьтонгууд улам ойртож ирсэн бололтой.

- Бурхан минь тийм байна! Энэ түүний хүү л байх. Би чамд түүний толгой хэвийн биш гэж хэлсэн биз дээ. Тийшээ битгий хар, Сесилия хонгор минь. Жингэнэх чимээ гараад төвөргөө ахин бүдгэрлээ.

- Хонгор минь гэж Морфин могойн хэлээр шивнээд эгч рүүгээ харав.

- Тэр түүнийг хонгор минь гэхийг сонсов уу. Тэр чамд ямар ч хамаагүй.

Меропа хувхай цайхад Харри түүнийг одоохон ухаан алдаж унах нь гэж бодов.

- Энэ чинь юу гэсэн үг юм? Чи юу хэлсэн бэ, Морфин? гэж Мракс могойн хэлээр ширүүн асуугаад охин руугаа харлаа.

- Тэр энэ маглыг харах дуртай гэж Морфин исгэрээд айсан эгч рүүгээ хэрцгий ширтэв.

- Үргэлж цэцэрлэгийн дэргэдүүр өнгөрөхөд бутны цаанаас ширтдэг биз дээ?

Харин шөнө бол ...

Меропа гуйн толгойгоо сэгсэрсэн ч Морфин өрөвдөх сэтгэлгүй үргэлжүүлэв.

- Толгойгоо цонхоор цухуйлгаад түүнийг дэргэдүүр явахыг хүлээдэг биз дээ?

- Толгойгоо маглыг харахын тулд цонхоор цухуйлгадаг гэнэ ээ? хэмээн Мракс аяархан асуулаа.

Гурвуул Огдены байгааг мартаад уурсан харахад тэр энэ шивнэлтээс юу ч ойлгож чадсангүй.

- Энэ үнэн үү? гэж Мракс аймшигтай хоолойгоор асуугаад үхтлээ айсан охин руугаа хоёр алхам ойртов.

- Миний охин цэвэр цусны шидтэн Салазар Слизериний удам бохир муухай маглын тухай мөрөөдөж байна гэнэ ээ?

Меропа цөхрөн толгой сэгсрээд хананд наалдлаа. Тэр ярьж чадахааргүй төрхтэй болсон харагдав.

- Би түүнд хүрсэн, аав аа! гэж Морфин сөөнгөтөн инээмсэглээд,

- Түүнийг дэргэдүүр өнгөрөхөд нь дайрсан. Тэр чамайг нуугдахаар тийм ч үзэсгэлэнтэй биш юм билээ, Меропа?

- Өө чи бохир авъяасгүй зэвүүн бохир сангасваа! гэж Мракс дэлбэрээд биеэ барих чадвараа алдан охиныхоо хоолойноос зуурлаа.

Харри, Огден хоёр зэрэг орилов.

- Битгий тэг!

Огден шидэт саваагаа өргөөд,

- Релашио! гэж хашгирлаа.

Мракс арагшаа огло үсрээд сандалд тээглэн нуруугаараа унав. Уурсан Морфин хүрхрээд сандлаасаа үсрэн босож Огден руу хутгаа эргэлдүүлэн саваагаа замбараагүй занган ухасхийлээ.

Огден зугтаж амиа аварлаа. Дамблдор араасаа явах дохио өгөхөд Харри дагалаа. Меропагийн хашгиралт түүний чихэнд удтал хадгалагдан үлджээ.

Огден явган зам руу гараа толгой дээрээ өргөн ухасхийн гараад элгэн хүрэн морь унасан хар үстэй царайлаг залуутай мөргөлдчихлөө. Залуугийн дэргэд саарал морь унасан хөөрхөн охин байсан бөгөөд Огден морины ташаа мөргөөд тоосонд дарагдсан сюртукаа толгойдоо углан гүйхийг хараад хөгжилтэй инээлдэв.

- Би үүнийг хангалттай гэж бодож байна, Харри гэж Дамблдор хэлэв.

Тэр Харригийн тохойноос барилаа. Дараагийн агшинд тэд харанхуйд хөөрснөө ахин

Дамблдорын өрөөнд газардахад бүрэнхий болсон байв.

- Байшинд байсан охинд юу тохиолдсон бол? Түүнийг Меропа гэж дуудаж байсан уу? хэмээн Харри Дамблдор шидэт саваагаараа хэд хэдэн лаа асаахад хэлэв.

- Тэр амьд үлдсэн гээд Дамблдор ширээндээ суугаад Харрид эсрэг талдаа суухыг зангав.

- Огден ид шидийн яам руу шилжээд арван таван минутын дараа нэмэлт хүчтэй эргэж ирсэн. Морфин эцэгтэйгээ тэмцэхийг оролдсон ч хоёулаа дийлдэн гэрээс нь авч яваад Визенгамотын шүүхээр шүүгдсэн. Морфин маглуудын эсрэг урьд нь дайралт хийж байсан болохоор Азкабаны шоронд гурван жил хорихоор шийтгэсэн. Марвало Огден болон ид шидийн яамны бусад ажилчдыг шархдуулсан учир зургаан сар хоригдсон.

- Марвало гэнээ? хэмээн Харри мэгдэн асуулаа.

- Яг тийм гэж Дамблдор дэмжингүй инээмсэглээд,

- Би чиний толгой ажиллаж байгаад баяртай байна гэлээ.

- Тэгэхээр энэ хөгшин ...?

- Волан-де-Мортын өвөө. Марвало түүний хүү Морфин, охин Меропа нар Мраксын гэр бүлийн эртний шидтэний сүүлчийн удам байсан бөгөөд тогтворгүй хэрцгий явдал нь хоёр үеэл гэрлэснээс үүдэлтэй юм. Хосууд үрэлгэн загнан Марвалог төрөхөөс өмнө гэр бүлийнхээ алтыг тараан цацалсан. Тэр өөрөө бохир ядуу зүдүү амьдарч хэрцгий зан авиртай ч гэр бүлийн үнэт зүйлдээ их зантай бардам загнан хүү охиндоо хандахыг харсан биз дээ.

- Тэгэхээр Меропа гэж Харри Дамблдорын нүднээс харц салгалгүй хэлэв,

- Меропа ... ноёнтоон тэр ... Волан-де-Мортын эх үү?

- Яг зөв. Бас бид түүний эцгийг хальт харлаа. Чамайг түүнд анхаарал хандуулсан эсэхийг мэдэхгүй юм ...

- Морфины дайрсан магл уу? Морин дээр сууж байсан уу?

- Маш сайн байна гэж Дамблдор баяртайгаар инээмсэглэв.

- Тиймээ энэ бол Том Реддл байсан. Царайлаг магл Мраксын гэрийн дэргэдүүр өнгөрөх болгонд Меропа Мракс хайр дурлалдаа автан нууцаар хардаг байсан юм.

- Тэгээд тэд гэрлэсэн хэрэг үү? гэж Харри үл итгэн асуулаа. Түүнд бие биетэйгээ огт төсгүй хоёр хүний талаар бодоход хэцүү байв.

- Би чамайг Меропаг шидтэн гэдгийг мартсан гэж бодож байна. Би түүнийг эцгээсээ айсны улмаас ид шидийн хүч болон давуу талаа гаргаж чаддаггүй байсан гэж бодож байна. Гэвч Марвало болон Морфин Азкабанд хоригдоход тэр амьдралдаа анх удаа ганцаар үлдээд эрх чөлөөтэй болсон. Тэр авъяасаа түүнийг эргэн ирүүлэхийн тулд ашиглан арван найман насандаа цөхөрсөн амьдралаасаа салах төлөвлөгөө зохиосон байна.

- Мeroпa ямар аргаар Том Реддэлд маглуудыг нь мартуулж шидтэнд дурлахад хүргэсэн бэ?
- Имперуус шившлэг. Эсвэл хайрын ундаа?
- Маш сайн байна! Би хувьдаа түүнийг хайрын ундаа ашигласан байх гэж боддог юм. Энэ нь түүнд илүү романтик санагдах байсан. Аль нэг халуун өдөр Реддл дэргэдүүр нь ганцаараа өнгөрөхөд аяга ус уухыг санал болгох тийм ч хэцүү биш байсан. Ямар байлаа ч гэсэн хэдэн сарын дараа тийм үйл явдал болоход бидний сая харсан Бага-Хэнглтоны оршин суугчид багагүй үймээн шуугианы гэрч болсон юм. Чи газрын эзний хүү тэнүүлчний охин Меропатай зугтсан тухай хичнээн их хов жив дэгдсэн тухай төсөөлж байгаа биз дээ.
- Гэхдээ тосгоны оршин суугчдийн цочирдол Марвалогынхтай харьцуулахын аргагүй байлаа. Тэр Азкабанаас эргэн ирэхдээ үнэнч охин болон ширээн дээрх халуун хоол угтана гэж итгэлтэй байсан байх. Гэвч үүнийхээ оронд тоосонд дарагдсан гэр охиныхоо салах ёс гүйцэтгэсэн зурвасыг олжээ.
- Би түүний хэзээ ч охиныхоо нэрийг дурсалгүй түүнийг огт байхгүй мэт амьдарч байсныг мэдэх юм байна. Магадгүй хаягдсан цочирдол түүнийг үхэлд хүргэсэн байж болох ч эсвэл тэр зүгээр л хоол хийж сураагүйгээс болсон болж мэднэ. Азкабан Марвалог сульдаж доройтуулсан болохоор хүү Морфиныхоо буцаж ирэхийг хүлээж чадсангүй.
- Харин Мeroпa? Тэр ... тэр бас үхсэн, тийм үү? Волан-де-Морт асрамжын газар өссөн биз дээ?
- Тиймээ үнэн. Энд ахин тааварлах хэрэг гарч байгаа ч би юу болсныг таахад тийм ч хэцүү биш гэж бодож байна. Тэдний зугтаж нууцлагаар гэрлэснээс хойш хэдэн сарын дараа Том Редл Бага-Хэнглтонд эцэг эхийнхээ гэрт эхнэргүй ганцаар иржээ. Тэр эргэн тойрны хөршүүддээ хуурагдсан гэж хэлсэн байна. Үнэн хэрэгтээ би түүнийг шидийн үйлчлэл дор байсанаа мэдэж байсан гэдэгт итгэлтэй байгаа ч шид тайлагдахад галзуу гэж бодуулахаас эмээн энэ тухай ярихыг хүсээгүй байх. Тосгоны оршин суугчид Мeroпa Том Реддлд хүүхэдтэй болсон гэж худал хэлсэн учраас гэрлэсэн гэж бодоцгоожээ.
- Гэхдээ тэр үнэхээр хүүхэдтэй болсон биз дээ!
- Тиймээ гэрлэснээсээ хойш жилийн дараа болсон. Том Реддл түүнийг хаях үед хүүхэд төрөөгүй байсан юм.
- Тэдэнд юу тохиолдсон юм бэ? Яагаад хайрын ундаа үйлчилэхээ больсон юм бэ?
- Энэ ахиад л таавар. Гэхдээ би бодохдоо Мeroпa нөхөртөө хязгааргүй хайртай байсан учир цаашид шидийн тусламжтай барьж байхыг хүсэлгүй хайрын уусмалыг өгөхөө больжээ. Магадгүй тэр өөртөө түүнийг жинхэнээсээ хайртай болсон гэж итгүүлсэн байж мэднэ. Магадгүй хүүхдийнхээ төлөө үлдэнэ гэж найдсан ч байж болох юм. Хоёр тохиолдолд хоёуланд нь алджээ. Тэр түүнийг хаяад ахиж хэзээ ч уулзалгүй хүүдээ юу тохиолдсоныг ч мэдээгүй байна.

Цонхны цаадах тэнгэр бэхэн хар өнгөтэй болоход Дамблдорын өрөөний лаанууд улам хурцаар гэрэлтлээ.

- Өнөөдөр бидний хувьд хангалттай гэж бодож байна, Харри гэж Дамблдор хоёр хормын дараа хэллээ.

- Тиймээ, ноёнтоон гэж Харри хэлэв. Тэр боссон ч явсангүй.

- Ноёнтоон ... би Волан-де-Мортын өнгөрсөн үеийн тухай мэдэх нь чухал уу?

- Би маш чухал гэж бодож байна.

- Энэ ... зөгнөлтэй ямар нэг холбоотой юу?

- Шууд холбоотой.

- Ойлгомжтой гэсэн ч Харри эргэлзсэн хэвээр байлаа.

Тэр хаалга руу хөдлөхдөө толгойд нь нэг асуулт орж ирэхэд эргэн харлаа.

- Ноёнтоон би Рон, Гермиона хоёрт таны ярьсан зүйлийн тухай хэлж болох уу? Дамблдор хормын турш бодлогширсоноо,

- Тиймээ ноён Уизли хатагтай Грэйнджер хоёрт итгэж болно гэж бодож байна.

Гэхдээ Харри тэднээс энэ тухай хэнд ч хэлэхгүй байхыг гуйгаарай. Бүгдэд би

Волан-де-Мортын нууцын тухай мэддэг гэж сэжиглэгдэхийг хүсэхгүй байна.

- Тиймээ, ноёнтоон. Би Рон, Гермиона хоёроос өөр хэн ч энэ тухай мэдэхгүй гэдэгт итгэлтэй байна. Тавтай нойрсоорой.

Тэр ахин эргээд гарч бараг хаалга хүрэх үедээ гэнэтхэн урт нарийхан хөлтэй ширээний нэгэн дээр хэврэгхэн мөнгөн эдлэл дунд том хар чулуун шигтгэсэн алтан бөгж байхыг харлаа.

- Ноёнтоон энэ бөгж ...

- За, Харри?

- Тэр биднийг профессор Слизнортын очдог шөнө таны хуруунд байсан.

- Тиймээ, байсан гэж Дамблдор батлав.

- Гэхдээ энэ чинь ... ноёнтоон энэ чинь Марвало Мраксын Огденд үзүүлсэн бөгж байна шүү дээ?

Дамблдор толгойгоо бөхийлгөв.

- Яг мөн.

- Гэхдээ яаж...? Тэр таньд үргэлж байсан хэрэг үү?

- Үгүй. Тэр надад саяхнаас олдсон. Үнэндээ би чамайг нагац ах эгчийнхээс чинь авахаас хэдхэн өдрийн өмнө.

- Тэгвэл энэ таны гараа гэмтээдэг үе мөн үү, эрхэм ээ?

- Тиймээ, Харри тэр үетэй ойролцоо.

Харри цааш үргэлжүүлэх эсэхээ шийдсэнгүй. Дамблдор инээмсэглэв.

- Ноёнтоон, юу болоо...?
- Цаг оройтсон байна, Харри! Энэ түүхийг чи хэзээ нэгэн цагт сонсох болно.

Тавтай нойрсоорой.

- Тавтай нойрсоорой, эрхэм ээ.

## БҮЛЭГ 11: ГЕРМИОНА ТУСЛАМЖЫН ГАРАА СУНГАВ

Гермионагийн хэлсэн ёсоор зургадугаар дамжааныханд чөлөөт цаг Роны найдсан шиг олдсонгүй бөгөөд гэрийн даалгавар уул овоо шиг нөмрөн ирлээ. Бүх хичээл маргааш нь шалгалт болох гэж байгаа юм шахуу байсан бөгөөд урьд урьдынхаасаа илүү хүнд хэцүү болж байлаа. Харри профессор МакГонагаллын тайлбарын талыг нь ойлголгүй тэр ч байтугай Гермиона хүртэл хоёр дахин асуухад хүрч байв. Гермионагийн эгдүүцлийг хүргэн Харри уусмалын хичээлдээ хамгийн амжилттай байж үүндээ эрлийз хунтайжид талархав.

Үгэн бус шившлэг одоо зөвхөн хар урлагаас хамгаалах хичээл дээр ч биш шившлэг, хувиргалын хичээл дээр орох болжээ. Харри нэг ангийхнаа Грффиндорын зочны өрөө юмуу Их танхимын ширээнд гэдэсний түгжрэл болсон аятай улаан хүрэгтэн суугаад үнэн хэрэгтээ чимээ гаргалгүй шид давтах сургууль хийж байгааг мэдэж байв. Ургамал судлалын хичээлийн хүлэмжинд одоо илүү аюултай ургамал орох болсон ч хортой тэмтрүүл гэнэтхэн араас чинь хатгахад чанга харааж болдогоороо арай давуу талтай байлаа.

Овоорсон их гэрийн даалгавар болон үгэн бус шившлэгийн сургуулилтын үр дүнд Харри, Рон, Гермиона гурав Хагридын зочлох цаг гаргаж чадсангүй. Тэр Их танхимын багш нарын ширээнд үзэгдэхээ больсон нь муугийн тэмдэг болсон бөгөөд тэдэнтэй ховорхон хонгилд юмуу гадаа тааралдах үедээ нууцлагаар ажиглаагүй дүр үзүүлэх юмуу мэндлэхийг нь сонсоогүй дүр эсгэдэг байв.

- Бид түүнтэй очиж ярилцах хэрэгтэй гэж Гермиона бямба гаригийн өглөөний цайн дээр Хагридын багш нарын ширээн дэх хоосон суудлыг хараад санаа алдан хэллээ.

- Бид нар өнөөдөр квиддичийн сорилттой! Бас Флитвикийн өсгөдөг шившлэгийг сургуулилах хэрэгтэй байдаг. Ер нь тэгээд очоод юу ярих болж байна? Бид түүний тэнэг хичээлийг нь үзэн яддагаа яаж тайлбарлах болж байна? гэж Рон хэлэв.

- Бид нар түүнийг үзэн ядаагүй! гэж Гермиона уурсав.

- Үүнийгээ өөртөө хэл. Би хувьдаа одоо хүртэл соплохвостуудыг мартаж чадахгүй байна. Бид нар харин ч хөнгөхөн саллаа. Чи түүнийг ухаангүй дүү Гроххыгоо гутлынхаа үдээсийг үдэж чаддаг болгон сургаж байгааг сонссон биз дээ.

- Надад Хагридтай уулзахгүй байх нь таалагдахгүй байна гэж Гермиона сэтгэлээр унан хэллээ.

- Түүн рүү квиддичийн дараа очье гэж Харри амлалаа. Тэр ч гэсэн Хагридыг санаж байсан ч Роны адил Гроххын үгүйд хамаагүй дээр гэж бодож байв.

- Гэхдээ олон хүн цугласан болохоор сонголт өглөөний турш үргэлжилэх нь байна! гээд Харри ахлагчын үүрэгтээ анх удаагаа ялимгүй бухимдлаа. Квиддич ийм алдартай гэдгийг ер мэдсэнгүй шүү.

- Өө, алив л дээ Харри. Энэ бол квиддич биш чи алдартайгаас болж байгаа юм!



Чи хэзээ ч ийм сонирхолтой үнэнийг хэлэхэд анхаарал татам байгаагүй гэж

Гермиона хэлэв.

Рон утсан загасны томоохон хэсэгт хахлаа. Гермиона түүн рүү дээрэнгүй харснаа ахин Харри руу эргэв.

- Одоо бүгд чамайг энэ бүх хугацааны турш үнэнийг хэлснийг мэдэж байгаа биз дээ? Бүхий л шидэтний ертөнц чиний Волан-де-Мортыг эргэж ирсэн тухай болон өнгөрсөн жилүүдэд хоёр удаа золоор аврагдсан тухай үнэн хэлсэнийг чинь мэдэж байгаа. Одоо чи бас «сонгогдсон» гэж болохоор яагаад бүгд чамайг бахдаж байгаа нь ойлгомжгүй байна гэж үү?

Харрид гэнэтхэн Их танхим халуун болж адар хүртэл уйтгартай бүрхэг болох шиг санагдлаа.

- Бүгд чамайг ид шидийн яам худал хэлсэн гэж мөрдөж байсныг мэдсэн. Бас гар дээр чинь одоо хүртэл тэр зэвүүн эмэгтэй цусаар чинь бичүүлэх үед үлдсэн тэмдэг бий ...

- Надад ч гэсэн ид шидийн яаманд тархи барихад үлдсэн ором бий гээд Роны ханцуйгаа шуулаа.

- ... дээрээс нь чи энэ зун бараг бүтэн фут өссөн ч үүндээ бардаагүй гэж Гермиона Роныг үл тоомсорлон яриагаа дуусгав.

- Би ч гэсэн хангалттай өндөр гэж Рон хэллээ.

Тэгтэл уулийн шуудан ирлээ. Тэд борооны дусал үсчүүлэн цонхоор нисэн орж ирээд хаа сайгүй ус дусаав. Бараг бүх сурагчдад ердийнхөөрөө захиа иржээ. Сэтгэл зовсон эцэг эхчүүд хүүхдүүддээ гэрт нь бүх зүйл сайн гэдгийг мэдэгдэж тэдний тухай мэдэхийг хүссэн байлаа. Харри хичээлийн жилийн эхэнд нэг ч захиа аваагүй ганц хүн боллоо. Түүнд цорын ганц бичдэг хүн үхсэн учир Люпиныг бичнэ гэж найдсан ч энэ найдлага биелсэнгүй. Ийм учраас саарал бор уульнууд дунд цасан цагаан Хэдвиг эргэлдэхийг хараад ихэд гайхлаа. Ууль Харрийн урд том дөрвөлжин хайрцагтай газардав. Дараагийн агшинд мөн адил ачаатай хоёр дахь ууль болох Роны жижигхэн Гахай томдсон ачаандаа эцэж ядарсаар буулаа.

- Ха! гээд Харри хайрцагыг нээж Флориш Блоттс дэлгүүрээс илгээсэн шинэхэн номоо авлаа.

- Сайн байна. Одоо л чи хуучнаа эргүүлж өгөх боломжтой боллоо гэж Гермиона баярлав.

- Чи чинь галзуураа юу? гэж Харри хэлээд,

- Би буцааж өгөхгүй! Хараач би юу бодож олсныг ... гэв.

Тэр цүнхнээсээ хуучин сурах бичиг гарган аваад хавтсан дээр нь савааныхнаа үзүүрийг хүргэн,

- Диффиндо! гэж шивнэлээ.

Хавтас саллаа. Харри мөн түүнчлэн шинэ сурах бичгийнхээ хавтсыг салгав (Гермиона балмад явдлыг зэвүүцэнгүй харлаа). Дараа нь хавтсыг сольж ном болгонд хүрээд,

- Репаро! гэв.

Ингээд түүний өмнө хунтайжын ном шинэ сурах бичгийн хавтсан дор зүсээ хувирган хэвтэж дэргэд нь «Флориш Блоттс» дэлгүүрийн шинэхэн хувилбар хуучин ном адил харагдана.

- Би Слизнортод шинийгээ буцааж өгнө. Есөн галлеон төлсөн болохоор түүнд гомдоллох хэрэг гарахгүй дээ.

Гермиона уруулаа жимийгээд ууртай зэмлэнгүй харагдсан ч урд нь гурав дахь уул ирээд «Өдөр тутмын зөнч» сонины шинэхэн дугаар тавилаа. Тэр яаран сонины эхний нүүрийг гүйлгэн харав.

- Хэн нэгэн танил хүн үхэж үү? гэж Рон хайхрамжгүй асуулаа. Тэр энэ асуултыг Гермиона сонинг дэлгэх болгонд асуудаг байлаа.

- Үгүй ээ, зөвхөн хэдэн Дементоруудын дайралт байна. Бас нэг хүн баривчлагдаж.

- Хэн гэдэг нь гайхамшигтай? гээд Харри Беллатриса Лестрейнжийн тухай бодлоо.

- Стэн Шанпайк.

- Юу гэнээ? хэмээн Харри гайхлаа.

- «Шөнийн хүлэг баатар» автобусны тасалбар хураагч Стэнли Шанпайк Үхэл залгигчтай холбоотой хэмээн буруутгагдсаны улмаас баривчлагджээ. Ноён Шанпайк хорин нэгэн настай бөгөөд өнгөрсөн шөнө түүнийг гэрээс нь баривчлан ...

- Стэн Шанпайк Үхэл залгигч гэнээ? хэмээн Харри бувтнаад гурван жилийн өмнө танилцсан батгатай залуугаа саналаа.

- Юун дэмий үг вэ!

- Магадгүй түүнийг Империиус шидээр удирдсан юм болов уу? гэж Рон санал болгов.

- Үгүй ээ, тийм биш гээд Гермиона үргэлжүүлэн уншлаа.

- Энд хэлэхдээ түүнийг бааранд Үхэл залгигчдын нууц төлөвлөгөөний тухай ярьж байхыг сонссоны дараа баривчилсан гэж байна. Хэрвээ тэр Империиус шидийн нөлөөлөл дор байсан бол төлөвлөгөөнийхөө талаар хэлэх байсан уу? гээд найзууд руугаа харлаа.

- Минийхээр бол тэр өөрийгөө чухал харагдуулах гэсэн байх. Тэр вейлад тоогдохыг хүсэхдээ ид шидийн яамны сайд болохыг оролдож байсан биз дээ? гэж Рон хэллээ.

- Аанхан тэр. Ид шидийн яамны тэнэгүүд яагаад Стэний үгийг ноцтой хүлээж авсныг ойлгохгүй юм гэж Харри хэллээ.

- Магадгүй ямар нэг зүйл хийж харагдахыг хүссэн байх гээд Гермиона хөмсөг зангидав. Хүмүүс айж сандарч байна. Та нар ихэр хоёр Патилийн эцэг эх гэр лүү нь авч явахыг хүссэнийг мэдэх үү? Элоиза Миженийг хэдийн аваад явчихсан. Өчигдөр орой эцэг нь ирээд.

- Юу! гээд Рон нүдээ бүлтийлгэв.

- Гэхдээ Хогвартсад гэрээс илүү аюулгүй биз дээ! Бидэнд мракоборецууд янз бүрийн хамгаалалтын шившлэгүүд болон Дамблдор байна!

- Минийхээр бол тэр үргэлж энд байхгүй байх шиг санагдсан гэж Гермиона аяархан хэлээд «Зөнч» сонины дээгүүр багш нарын ширээ рүү хяламхийн харснаа,

- Та нар ажиглаагүй юм уу? Өнгөрсөн долоо хоногт түүний суудал Хагридын адил хоосон байсан гэв.

Харри, Рон хоёр багш нарын ширээ рүү харлаа. Захирлын суудал үнэхээр хоосон байв. Харри Дамблдорыг өнгөрсөн долоо хоногт хичээл заалгаснаасаа хойш олж харсангүй.

- Би түүнийг бүлгийн ямар нэг ажилтай байгаа байх гэж бодож байна.

Магадгүй их ноцтой байх, тийм үү? гэж Гермиона дуугаа намсган хэлэв.

Тэд хариулсангүй ч Харри бүгд ижил зүйл бодож байгааг мэдэж байв. Өчигдөр өглөө тэдэнд аймшигтай тохиолдол болж ургамал судлалын хичээл дээр Ханна Эбботод ээжийнх нь үхсэн тухай мэдээ иржээ. Тэд үүнээс хойш Ханнаг харсангүй.

Тэд таван хормын дараа Гриффиндорын ширээнээс боссон цэнгэлдэх хүрээлэн рүү явахдаа Лаванда Браун болон Парвати Патил нарын дэргэдүүр ойрхон өнгөрлөө. Гермонагийн үгээр бол тэдний эцэг эхүүд Хогвартсаас авч явахыг хүссэн гэсэн болохоор Харри найзууд сэтгэлээр унасан байртай шивнэлдэж байсан явдалд гайхсангүй. Тэгтэл Рон охидын дэргэдүүр өнгөрөхөд Парвати гэнэтхэн Лавандаг тохойгоороо нудраад нүүр дүүрэн инээмсэглэв. Рон нүдээ анивчсанаа итгэлгүйхэн хариу инээмсэглэв. Тэр гэнэтхэн мөрөө тэгшилэн цээжээ төвийлгөлөө. Харри Рон Малфой хамрыг хугалах үед инээгүйг санаад инээх хүслээ арай ядан барилаа. Гермиона үүнд хүйтнээр хандаж манан татсан шиврээ бороотой цэнгэлдэх хүрээлэнд хүрэх үед Ронд амжилт хүсэлгүй үзэгчдийн суудалд суулаа.

Харрийн хүлээж байсанчлан сорилт бүх өглөөг эзлэв. Тэнхимийн хагас нь ирсэн юм шиг санагдана. Гартаа сургуулийн аймшигтай сүрэл нь сэгсийсэн хуучин шүүр барьсан эмээнгүй нэгдүгээр дамжааныханаас авхуулаад долдугаар дамжааныхан хүртэл цугларчээ. Тэдний нэг болох «Хогвартс Экспресс» галт тэргэнд харсан өсгөлүүн залууг Харри танилаа.

- Бид галт тэргэнд хөгшин Слиззигийн өрөөнд уулзсан гэж залуу итгэлтэй хэлээд хүмүүсийн дундаас гарч Харритай гар барилаа.

- Кормак Макклагген, хаалгач.

- Өнгөрсөн жил чи сорилтонд байгаагүй биз дээ? гээд Харри Маклаггены өргөн мөрийг ширтэн онооны цагирагийг байрнаасаа хөдлөлгүй халхлах юм байна гэж бодлоо.

- Өнгөрсөн жил сорилтын үеэр би эмнэлэгт хэвтэж байсан юм. Мөрийцөөд доксины арван хоёр өндөг идсэн гэж Маклагген ихэмсгээр хэлэв.

- Ойлгомжтой. За яахав ... энд хүлээж байгаарай ...

Тэр Гермionaгийн суудлаас холгүй байгаа үзэгчдийн суудлын эхний эгнээг заалаа. Тэгтэл Маклаггены царайд таагүй өнгө зурсхийхийг үзвээс тэр харваас хөгшин Слизнейн танилдаа хөнгөлттэй хандана гэж бодсон бололтой.

Харри шалгалт хийхээр шийдээд хүн бүрийг арван хүнтэй бүлэг болон хуваагдахыг хүслээ. Энэ нь амжилттай шийдвэр болж эхний арав болох нэгдүгээр дамжааныхан зогсоход тэд хэзээ ч нисэж үзэж байгаагүй нь ойлгомжтой байлаа. Зөвхөн нэг хүү агаарт хагас хором тогтоод үүндээ гайхснаа даруйхан онооны цагариг мөргөв.

Хоёр дахь бүлэгт Харрийн амьдралдаа хэзээ ч харж байгаагүй тэнэг охид цугларчээ. Тэд шүгэл үлээхэд нисэхийг оролдох нь бүү хэл хөхрөлдөн бие биетэйгээ хэлхэлдэв. Тэдний дунд Ромильда Вейн байлаа. Харри тэднийг талбайгаас гарахыг тушаахад өчүүхэн ч гомдсонгүй бөгөөд үзэгчдийн суудалд бусад оролцогчдыг даажигнахаар нэгдэв.

Гурав дахь бүлгийн хагас нь нисэж чадсангүй. Дөрөв дэх бүлгийн бараг хэн ч шүүр авчирсангүй. Тав дахь бүлэгт Пуффендуйнхан байлаа.

- Хэрвээ энд өөр тэнхимээс хэн нэгэн байгаа бол одоохон явж үз! гэж Харри уурсан орилов.

Нам гүм болсноо хоёр жижигхэн Когтевранчууд талбайгаас инээлдэн гүйн гарав. Хоёр цагийн дараа олон тооны уур цухал доор сүрэл нь хугарсан ганц «Сүүлт од-

260» шүүрээр Харри багтаа амжилттай сорилтын дараа багтаа эргэн ирсэн Кэтти

Белл болон блажераас ер бусын бултсан шинэ оролцогч болох Демельза Робинс түүнчлэн бүх өрсөлдөгчдөөсөө түргэн нисэн онооны цагаригт далан оноо оруулсан Жинни Уизли нар тэргүүтэй гурван ангууч авлаа. Харри сонголтондоо сэтгэл хангалуун байсан ч хасагдсан довтлогч нараа талбайгаас хөөхийн тулд хоолойгоо сөөтөл хашгирах хэрэг гарчээ.

- Эцсийн шийдвэр гарсан хэрвээ та нар хаалгачын талбайг чөлөөлөхгүй бол бүгдийг чинь шившлээ шүү!

Нэг ч довтлогч Фред, Жорж хоёрын адил гялалзсан тоглогчид байсангүй ч Харри сэтгэл ханамжтай байлаа. Намхан өргөн цээжтэй гурав дугаар дамжааны Жимми Пикс Харрийн шилэн хүзүү рүү блажерыг хүчтэй цохьсон болохоор тахианы өндөг шиг булдруу гарчээ. Ричи Кут цохиурыг сайн эзэмшиж байлаа. Одоо хоёул Кэти, Жинни, Демельза нарын дэргэд суугаад багийн сүүлчийн гишүүний сонголт хэрхэн явагдахыг харав.

Харри санаатайгаар хаалгачын сорилтыг төгсгөлд үлдээсний учир нь энэ үед цэнгэлдэх хүрээлэн хоосорч сэтгэл зовсон дарамт багасна байх гэж найджээ. Гэвч харамсалтай нь бүх хасагдсан тоглогчид үзэгчдийн суудалд үлдэж өшөө бүлэг хүмүүс өглөөний цайгаа дуусган ирээд үзэгчид эхнээсээ илүү олон боллоо. Онооны цагаригийн өмнө хөөрсөн ээлжит хаалгач болгоныг үзэгчдийн угтан хашгиралт шоолон инээлт дагалдаж байлаа. Харри Рон руу хяламхийхэд урьдныхаас илүү түгшсэн харагдав. Харри түүнийг сүүлчийн тэмцээнд ялалт хийсэн үеийнх шигээ байна гэж найдсан ч бүтсэнгүй. Рон цайвар ногоон болжээ.

Эхний тавын хэн ч хоёроос илүү бөмбөг барьж чадсангүй. Харрийн урмыг ихэд хугалан Кормак Маклагген бүх таван торгуулийн цохилтоос дөрвийг нь барьж авлаа. Тэбээр тав дахь удаагийн торгуулийн цохилтын үед өөр тийш ухасхийжээ. Үзэгчид хөхрөлдөн шүгэлдэхэд Маклагген газар буугаад уурсан шүдээ зуув.

Рон ухаан алдах гэж буй байдалтайгаар «Зүлгэгч-11»-ээ уналаа.

- Амжилт хүсье! гэх хоолой үзэгчдийн суудлаас дуулдлаа.

Харри Гермiona байх гэж бодон харсан ч Лаванда Браун байв. Тэр гараараа нүүрээ хаахад Харри ч мөн адил тэгэхийг хүссэн ч ахмад хулчийлгүй Роны оролдлогыг харах ёстой байв.

Харри дэмий түгшсэн бололтой. Рон нэг, хоёр, гурав, дөрөв, тав дахь торгуулийн цохилтыг барьж авлаа. Тэр сэтгэл хангалуун баяртайгаар үзэгчидтэй нэгдэхэд Харри Маклагген руу Рон хожсоныг хэлэхээр эргэн хараад түүний уурсан ууртай царайтай нүүр тулгарав. Тэр яаран алхам ухарлаа.

- Дүү нь түүнийг дэмжсэн! гэж Маклагген заналхийлэн хэлэхэд чамархайн судас нь Вернон ахынх шиг гүрэлзэв. Тэр түүнд амархан бөмбөг дамжуулсан.

- Дэмий яриа. Тэр сүүлчийн бөмбөгийг нь алдах шахсан биз дээ гэж Харри хүйтнээр хэллээ.

Маклагген Харри руу алхам ойртлоо.

- Надад ахин нэг боломж өг.

- Үгүй. Чамд хэдийн боломж байсан. Чи дөрвөн бөмбөг барьсан. Рон тавыг барьсан. Рон хаалгач болно. Тэр шударга тулаанд хожсон. Алив замаас холд.

Хормын турш түүнд Маклагген одоохон цохих гэж байгаа юм шиг санагдсан ч уурсан ярвайснаар хязгаарлагдаж сүрдүүлсэн бувтнасаар холдлоо.

Харри эргээд шинэ багаа бүрэн бүрэлдэхүүнээр нь инээмсэглэн харлаа.

- Сайн байна. Бүгд сайн нисэж байна ...

- Чи гайхалтай байлаа, Рон!

Энэ удаад Гермiona талбай дээр гарч ирлээ. Харри Лавандаг бухимдангуй цэнгэлдэх хүрээлэнгээс Парватитай хөтлөлцөн холдохыг харав. Рон итгэмээргүй сэтгэл хангалуун байсныхаа улмаас тэр ч байтугай өссөн юм шиг санагдаж бусад тоглогчид болон Гермiona руу нүүр дүүрэн инээмсэглэв.

Харри эхний бэлтгэлээ дараагийн пүрэв гаригт товлож Рон, Гермиона хоёрын хамтаар бусадтайгаа салах ёс гүйцэтгээд Хагридын зочлохоор явлаа. Шиврээ бороо зогсож цонхигор наран үүлсийн завсраар нэвтрэхийг хичээнэ. Харри аймшигтай өлсөж байгаагаа мэдрээд Хагридыг ямар нэг идэх өгөх юм болов уу гэж найдлаа.

- Би сүүлчийн бөмбөгийг барьж авч чадахгүй нь гэж бодлоо шүү хэмээн аз жаргалд автсан Рон хэлээд,

- Демельза маш зальжин эргэлттэй цохьсон болохоор ... гэв.

- Тиймээ, тийм чи гайхамшигтай байсан гээд Гермиона үл мэдэг инээвхийлэв.

- Ямар ч гэсэн Маклаггенаас дээр гэж Рон сэтгэл хангалуун хэлээд,

- Тэр тав дахь бөмбөгөн дээр буруу тийш ухасхийхийг харсан уу? Яг л хэн хэн нэгэн түүнийг Конфундус шившлэгээр шившсэн юм шиг! гэв.

Харрийн гайхлыг төрүүлэн Гермиона гэнэтхэн час улайлаа. Рон бусад бөмбөгийг хэрхэн барьсан тухайгаа нарийвчлан яриад туйлаас завгүй байсан тул юу ч ажигласангүй.

Хагридын овоохойноос том саарал гиппогриф Клювокрыл уяатай байлаа. Андуудыг ойртох үед тэр сахлын хутга адил хурц хошуутай толгойгоо тэдний зүг эргүүлэв.

- Ээж минь. Тэр ийм аймшигтай бил үү? гэж Гермиона түгшин дуугарлаа.

- Боль доо чи дээр нь суусан биз дээ? гэж Рон инээмсэглэв.

Харри урагш алхаад нүд цавчилгүй харж байгаа гиппогрифт гүнзгий бөхийн ёсоллоо. Хормын дараа Клювокрыл ч гэсэн толгойгоо бөхийлгөв.

- Чи хэр байна даа? гэж Харри аяархан асуугаад толгойных нь сөрвийсөн өдийг илэв.

- Түүнийг санаж байна уу? Гэхдээ Хагридын муугүй байгаа биз тийм үү?

- Хөөе! гэх чанга хоолой сонсогдов.

Хагрид овоохойн булангаас том алхлан гарч ирлээ. Тэр цэцэгтэй хормогч өмсөөд гартаа шуудай төмс барьжээ. Том анч нохой Соёт араас нь гүйж байлаа. Соёт чих дөжрөм хуцсанаа урд нь гарлаа.

- Алив түүнээс холд! Тэр одоохон хурууг чинь хазах болно ... аа энэ та нар байсан юм уу ...

Соёт Рон, Гермиона хоёрыг тойрон үсэрч чихээ маажуулахыг хичээв. Хагрид агшин зуур зогсон тэдэн рүү харснаа эргээд овоохойдоо орж хаалга хаав.

- За, энэ дээ! гэж Гермиона гашуунаар санаа алдлаа.

- Тайвшир гэж Харри баргар хэлэв.

Тэр хаалга руу очоод чанга цохилоо.

- Хагрид! Онгойлго бид ярилцах хэрэгтэй байна! Ямар ч чимээ гарсангүй.

- Хэрвээ чи онгойлгохгүй бол бид хаалгыг чинь эвдлээ шүү! гээд Харри халааснаасаа шидэт саваагаа гаргалаа.

- Харри! Чи тэгж болохгүй ... гэж Гермiona цочирдон хэллээ.

- Болно! Холд ...

Гэвч түүнийг өөр үг хэлж амжихаас урьтаж хаалга нээгдэн цэцэгтэй хормогч өмссөн Хагрид түгшсэн байртай гарч ирээд Харри руу муухай харав.

- Би багш! Багш, Поттер! Чи яаж миний хаалгыг эвдэлнэ гэж сүрдүүлж чадаж байна! гэж тэр Харри руу ориллоо.

- Уучлаарай, ноёнтоон гэж Харри сүүлчийн үгээ өргөн хэлээд саваагаа жанчныхаа дотор халаасанд хийлээ.

Хагрид мэгдсэн шинжтэй харагдав.

- Чи хэзээнээс намайг ноёнтон гэж дууддаг болоо вэ?

- Намайг Поттер гэж дуудаг болсон үеэс чинь хойш.

- Аан их ухаалаг байлаа гэж Хагрид үглээд,

- Маш хөгжилтэй байна. Намайг залилсандаа баяртай байна уу? За яахав орцгоо хүний тус мэддэггүй жижигхэн амьтад минь ... гэв.

Тэр ууртай үглэсээр тэднийг гэртээ оруулав. Гермiona айсан янзтай Харрийн араас орлоо.

- За? гэж Хагрид Харри, Рон, Гермiona нарыг нүсэр том модон ширээнд суухад асуулаа. Соёот хошуугаа Харрийн өвөр дээр тавьж шүлсээрээ жанчыг нь норгов.

- Яах гэж ирцгээв? Намайг өрөвдөх гээ юу? Ганцаардсан гэж бодов уу?

- Үгүй гэж Харри түргэн хэлээд,

- Бид чамтай уулзахыг хүссэн юм гэлээ.

- Бид чамайг санасан! гэж Гермiona чичирсэн хоолойгоор хэлэв.

- Санасан юм биз дээ, тийм үү? Аан, тэгэлгүй яахав гэж Хагрид тургилав.

Тэр ханан зуух руу очоод гал дээр байгаа том зэс данхтай цайг авахдаа бувтнахаа больсонгүй. Эцэст нь чангаар ширээн дээр тасхийтэл тавиад хувин шиг хэмжээтэй гурван сэнжтэй аяганд улаан модны цай хийж, таваг дүүрэн жигнэмэг тавилаа. Харри их өлсөж байсан болохоор шууд жигнэмэг авлаа.

- Хагрид гэж Гермiona ойн харуул ширээнд суугаад ууртайгаар төмс арилгаж эхлэхэд шийдвэргүйхэн эхлэв.

- Бид үнэхээр шидэт амьтаны хичээлийг үргэлжүүлэхийг хүссэн ...

Хагрид хамраа чанга шуухитналаа. Харрид түүний нусны ихэнхи хэсэг төмс рүү орох шиг санагдсан болохоор оройн хоолонд үлдэхгүйдээ баяртай байв.

- Үнэн шүү! Бид зүгээр л энэ хичээлийг хуваарьтаа бичиж болохгүй байлаа.

- Тэгэлгүй яахав гэж Хагрид ахин үл тоов.

Тэгтэл хачирхалтай цалгилах дуу сонсогдоход найзууд түгшин ийш тийшээ харав. Гермиона аяархан дуу алдахад, Рон байрнаасаа яаран үсрэн бослоо. Ширээний нөгөө өнцөгт том торх байхыг тэд сая л ажиглажээ. Дотор нь ямар нэг авгалдайтай төстэй урт цагаан зүйл мөлхөж байв.

- Энэ юу вэ, Хагрид? гэж Харри сониучирхсан байдалтай асуухыг хичээгээд чулуу шиг жигнэмэгээ доош тавилаа.

- Жирийн аварга аварга.

- Хэн тэднийг өсгөсөн юм бэ? гэж Рон айдаст автан асуув.

- Хэн ч тэднийг өсгөөгүй. Би тэднээр Арагогыг тэжээж байгаа. Тэр гэнэтхэн цурхирлаа.

- Хагрид! Юу болсон бэ? гээд Гермиона түүн рүү ухасхийхдээ авгалдайтай торхонд хүрэхгүйн тулд ширээг бүтэн тойроод чичирсэн мөрөн дээр нь гараа тавилаа.

- Тэр ... тэр гэж Хагрид мэгшүүлээд цох хорхой шиг нүдээ хормогчоороо арчив.

- Тэр ... Арагог ... үхэж байх шиг байна ... зуны турш ямар ч сайжрал авсангүй ... би түүнийг яахаа мэдэхгүй байна ... хэрвээ тэр ... хэрвээ тэр ... бид хичнээн удаан хамтдаа байлаа даа ...

Гермиона Хагридын мөрийг илэхдээ юу хэлж байгааг нь ойлгосонгүй бололтой. Харин Харри түүнийг маш сайн ойлголоо. Тэр Хагридыг аймшигт жижигхэн луутай чихмэл баавгай аятай харьцаж, аварга том хатгууртай хилэнцийг тэжээн, хэрцгий аварга биет дүүгээ ухаан суулгахыг оролдож байхыг харсан ч энэ бүх холбоо харилцаа нь ойлгомжгүй байлаа. Тэр аварга том аалз Арагогтой Хориотой ойн гүнд ярилцах үедээ дөрвөн жилийн өмнө золтой л хөлд нь үрэгдчихээгүй билээ.

- Бид ... бид ямар нэг зүйлээр туслах уу? гэж Гермиона асуухдаа Роны цөхөрсөндөө ярвайж толгойгоо сэгсрэхийг анзаарсангүй.

- Хэрэггүй дээ, Гермиона гэж Хагрид нулимсаа арчин хэлээд,

- Чи ойлгож байна уу түүний төрөл төрөгсөд ... Арагогын хүүхдүүд. .. Тэд түүнийг өвдсөнд хачирхалтай догшин болсон ... ямар нэг зүйлд түгшээд ... гэв.

- Тиймээ бид ч үүнтэй тулгарч байсан гэж Рон сонсдох төдий шивнэв.

- Одоо надаас өөр хэнийг ч нутаг дэвсгэртээ ойртуулна гэж бодохгүй байна гэж Хагрид төгсгөөд хормогч руугаа нусаа чанга нийлээ. Гэдээ тэр хамаагүй санал болгосон явдалд баярлалаа, Гермиона ... энэ бүхэн надад олон зүйлийг ...

Үүний дараа уур амьсгал мэдэгдэм хөнгөрлөө. Хэдийгээр Харри, Рон хоёр аварга том үхэж буй аалзыг тэжээх хүсэлгүй байсан ч Хагрид эцэст нь тэднийг ахин өөртэйгээ гэж бодов бололтой.



- Би та нар намайг шахуу хичээлийн хуваарьтаа оруулахгүй гэдийг мэдэж байсан. Хэрвээ бүгдэд чинь цаг хугацааны эрчлүүр байсан бол ...

- Одоо энэ боломжгүй. Бид зун ид шидийн яаманд бүгдийг нь хагалсан. Энэ тухай «Өдөр тутмын зөнч» сонинд бичсэн гэж Гермiona хэлэв.

- Аан тэгвэл ч яахав. Та нар тэгвэл амжихгүй байх ... намайг уучлаарай ...

Ойлгож байна уу Арагогоос болж сэтгэлээр жаахан унаад ... гэхдээ профессор

Граббли Дерг та нарыг сайн сургах байсан гэж бодож байна ...

Гурвуулаа Хагридад профессор Граббли Дерг ямар аймшигтай муу багш болохыг хатуу нотлоход үр дүнд нь Хагрид арай хөгжилтэй болж тэдэнтэй салах ёс гүйцэтгэв.

- Өлсөж үхэх нь гэж Харри тэдний ард хаалга хаагдахад хэлээд гурвуул шилтгээн рүү харанхуй нуга дундуур яаран явлаа. Тэр чулуу шиг жигнэмэг идэх оролдлогоо нэг араа нь чахрах чимээг сонсоод орхижээ.

- Аан бас өнөөдөр бас Снеггэд шийтгэлтэй байдаг гэхдээ хооллож амжих байх

...

Тэд шилтгээнд ороод Кормак Маклаггеныг Их танхим руу орох оролдлого хийхийг харлаа. Тэр хоёр дахь оролдлого хиймэгц эхнийхээ адил буцаж ойлоо. Рон тавлангуй хөхрөөд Их танхим руу ороход Харри Гермionaгийн тохойноос зууран хойш татлаа.

- Яасан? гэж Гермiona гайхширлаа.

- Чамаас асуух зүйл байна. Маклаггенд өглөө яг л хэн нэгэн Конфндус шившлэг илгээсэн юм шиг харагдсан. Харин тэр чиний суудлын эсрэг талд зогсож байсан.

Гермiona улайлаа.

- За яахав би үүнийг хийсэн юм. Чи түүнийг Рон, Жинни хоёрын тухай юу ярихыг нь сонсоо биз дээ! Тэгээд ч аймшигтай муухай араншинтай юм байна лээ. Чамайг багтаа аваагүйн төлөө яахыг харсан биз дээ? Чамд багт чинь тийм хүн хэрэгтэй гэж ҮҮ.

- Үгүй л дээ. Гэхдээ энэ чинь шударга бус, Гермiona! Чи чинь ахлагч биз дээ?

- За боль доо гээд тэр Харрийн сэтгэл хангалуун царайг харж инээлээ.

- Та хоёр тэнд юугаа хийгээд байгаа юм? гэж Рон шаардангуй хэлээд Их танхимын үүдээр цухуйн сэжигтэй ширтэв.

- Юу ч биш гэж Харри, Гермiona хоёр зэрэг хэлээд Их танхим руу яарлаа.

Шарсан махны үнэр Харрийн гэдэс дотрыг маажилахад тэд Гриффиндорын ширээ рүү бараг гурван алхам хийж амжаагүй байтал профессор Слизнорт замыг нь хөндөлслөө.

- Харри, Харри би чамайг хайж байлаа! гээд элэгсгээр далайн нохойн сахлыг хөдөлгөн хэлээд,

- Би чамайг оройн хоолны өмнө барьж авна гэж найдаж байлаа! Үүний оронд миний өрөөнд оройнд зоогонд ирэхгүйсэн болов уу? Хэдхэн хүн цуглах юм. Маклагген, Забини, Мелинда Боблин та түүнийг таних бил үү? Түүний гэр бүл эмийн сангийн томоохон сүлжээ эзмшдэг юм ... Ингээд мэдээж би бас хатагтай Грэйнджер таныг миний хүндэтгэлийг хүлээн авч хүрэлцэн ирнэ гэж найдаж байна хэмээн Слизнорт яриагаа төгсгөөд Гермионад бөхийн ёслол.

Роныг энд огт байхгүй аятай Слизнорт түүний зүг нэг ч удаа харсангүй.

- Би очиж чадахгүй, профессор. Профессор Снегг надад шийтгэл оноосон гэж Харри даруйхан хэлэв.

- Ай, бурхан минь! гэж Слизнорт дуу алдаад царай нь инээдтэй болж,

- Тэгвэл чамайг тооцсон гэж бодож болох нь, Харри! Би Северустэй ярилцан үйл явдлын тухай тайлбарлах гээд үзье. Мэдээж тэр зөвшөөрч шийтгэлийг өөр цаг руу шилжүүлнэ байх. Тиймээ, тийм хоёулантэй чинь уулзах болно! гэв.

Тэр яаран танхимаас гарлаа.

- Түүнд Снеггийг ятгах боломж байхгүй байх гэж Харри Слизнорт сонсож чадахгүй газар холдсон хойно хэлээд,

- Снегг нэг удаа Дамблдорын гуйлтаар шийтгэлээ хойшлуулсан болохоор өөр хэн нэгний хүсэлтээр үүнийг хийхгүй байх гэлээ.

- Өө, чи надтай явж чадахгүй чинь харамсалтай байна. Би тийшээ ганцаараа явахыг хүсэхгүй байна гэж Гермиона сэтгэл зовон хэлэхэд Харри түүнийг Маклаггены тухай бодол айлгаж байгаа болохыг нь ойлголоо.

- Чамайг тэнд ганцаар очино гэдэгт чинь эргэлзэж байна. Жинни ч бас уригдсан байх гэж Рон Слизнортын үл ойшоосон явдалд эгдүүцэн бувтнав.

Хоолны дараа тэд Гриффиндорын цамхаг руу буцлаа. Амралтын өрөөнд бүгд хоолоо дуусгаж амжсан болохоор дүүрэн хүнтэй байсан ч Харри, Рон, Гермиона гурав сул ширээ олоод суулаа. Рон Слизнорттой тулгарснаас хойш сэтгэл санаа тааруухан байсан болохоор энгэртээ гараа зөрүүлэн адар ширтэнэ. Гермиона хэн нэгний сандал дээр мартсан «Өдөр тутмын зөнч» сонины дугаар дэлгэв.

- Шинэ юм байна уу? гэж Харри асуулаа.

- Юу ч алга гээд Гермионаг сонинг гүйлгэн харж,

- Хөөх хараач Рон чиний аавын тухай бичиж ... түүний бүх зүйл хэвийн дээ!

гэж Рон айдаст автахыг харж яаран тайлбарлаад,

- Энд зөвхөн Малфойн гэрт очсон тухай бичиж. «Үхэл залгигчийн оршин суудаг газар хийсэн хоёр дахь эрэл ямар ч үр дүнд хүрсэнгүй. Артур Уизли хэлтэстээ ирсэн мэдээлийн дагуу дагуу шалгалт хийсэн байна».

- Аанхан миний! гэж Харри хэлээд,

- Би түүнд Кинге Кросс буудал дээр байх үеэр Малфой Горбиныг ямар нэг зүйлийг засахыг хүсэж байгаа тухай хэлсэн юм. Гэхдээ түүний гэрт юу ч байхыг бодвол Хогвартет авчирсан байх гэв.

- Тэр үүнийг яаж хийж чадах юм бэ, Харри? Биднийг бүгдийг нь үүдэн дээр шалгасныг санаж байна уу? гэж Гермиона гайхан асуугаад сонингоо доош нь тавилаа.

- Шалгасан гэнээ? Намайг лав үгүй ...

- Өө тийм л дээ, чиний хоцорсоныг мартчихаж ... Биднийг үүдний танхимд орох үед Филч нууц зүйл илрүүлэгчээр шалгасан. Тэр биднээс хар талын зүйл эрсэн юм билээ. Би Крэббээс хатсан толгой олдсоныг сайн мэдэж байна. Чи Малфой шилтгээнд ямар ч аюултай зүйл авч чадахгүй байсныг харж байгаа биз дээ!

Харри үүнийг хариулахад амаргүй байсан тул хэсэг зуур Жинни Уизли үстэй бөмбөлөг Арнольдоороо тоглож байхыг харав. Эцэст нь эсэргүүцэх арга бодож олоод,

- Хэн нэгэн түүнд уулиар илгээсэн байх. Ээж нь ч юмуу хэн нэгэн гэв.

- Уулийг ч гэсэн шалгаж байгаа. Филч бидэнд илрүүлэгч хаа сайгүй байгаа гэж анхааруулсан.

Энэ удаад Харри мухардалд орсон болохоор юу ч хэлсэнгүй. Малфойд үнэхээр сургууль дээр хар талын аюултай зүйл оруулах боломж байсангүй бололтой. Тэр Рон руу найдангуй харсан ч энгэртээ гараа зөрүүлээд Лаванда Браун руу нүд салгалгүй ширтэж байв.

- Харин чи Малфой ямар аргаар хуурсан гэж бодож байна ...?

- Боль доо, Харри гээд Рон үрчийлээ.

- Сонсож бай, Слизнорт Гермиона бид хоёрыг тэнэг үдэшлэгт урьсан явдалд бид ямар ч буруугүй. Чи биднийг тийшээ явахыг хүсэхгүй байгааг мэдэж байгаа биз дээ!

- Тэгсэн ч би ямар ч үдэшлэгт уригдаагүй болохоор явж унтлаа гээд Рон хөл дээрээ өндийн бослоо.

Тэр чанга дэвслэн хөвгүүдийн унтлагын өрөө рүү ороод хаалга хаахад Харри, Гермиона хоёр түүнийг дагуулан харж үлдэв.

- Харри! гэж шинэ ангууч Демельза Робинс гэнэтхэн араас нь гарч ирээд,

- Надад чамд үүнийг дамжуул гэж хэллээ гэв ...

- Хэн тэгсэн юм? Профессор Слизнорт уу? гэж Харри найдангуй асуулаа.

- Үгүй, профессор Снегг гэхэд Харри сэтгэлээр унав.

- Тэр чамайг өрөөндөө найм хагаст ирэхийг тушаасан. Э-э ... хэчнээн ч үдэшлэгт уригдсан байлаа гэсэн шийтгэлээ эдлэх ёстой гэсэн. Бас чамайг ялзарсан

флорбер-өтнүүдийг ангилан уусмалын хичээлд хэрэглэж болох сайныг нь ялгах тул хамгаалалтын бээлийгээ авчраарай гэсэн.

- Бүгд ойлгомжтой. Чамд их баярлалаа, Демельза гэж Харри баргар хэллээ.

## БҮЛЭГ 12: МӨНГӨ БА БАДМААРАГ

Дамблдор хаана юу хийгээд байгаа юм бол?

Дараагийн долоо хоногт нь Харри сургуулийн захирлын барааг ердөө хоёр удаа харжээ. Тэр бараг Их танхимд үзэгдэхгүй байсан тул Харри түүнийг хэдэн өдөр сургуульд байгаагүй гэсэн Гермionaгийн зөв гэдэгт итгэлтэй байлаа. Магадгүй тэр Харрид хичээл өгөхөө мартсан юм болов уу? Дамблдор хичээл зөгнөлтэй ямар нэг талаар холбоотой гэж хэлсэн. Харри үүнийг дэмжиж байсан ч тайвширч одоо түүний тухай мартсан юм шиг санагдах болжээ.

Арван сарын дунд үеэр Хогсмид явах эхний ээлж болов. Харри зугаалгыг хүч нэмэгдүүлсэн хатуу хамгаалалтын үүднээс хориглож магадгүй гэж болгоомжилж байсан ч тэгсэнгүй. Тэр үргэлж шилтгээнээс хэдэн цаг гарахдаа баяртай байдаг байв.

Хүчтэй салхитай бороо шавхуурдсан өдөр байлаа. Харри өглөө эрт сэрээд өглөөний цай хүртэл цаг нөгцөөхийн тулд уусмалын хичээлийн сурах бичгээ авлаа. Ер нь бол тэр орондоо хэвтэж ном уншихад дадаагүй тул Рон хэлдэгчлэн жирийн үед Гермionaгаас бусад хүн зохимжгүй гэдэг нь шударга үг байлаа. Удалгүй Харри эрлийз хунтайж бусад сурагчидтай адилгүй гэдэгт итгэлтэй болов. Харри сурах бичгийг унших тусам ашигтай зүйл ихээр олдон зөвхөн уусмалын хичээлийн бяцхан заль биш Слизнортын талархалыг хүлээж болохоор жижигхэн уран сэтгэмжтэй шившлэг мөр хооронд сараачин бичээд олон удаа зассанаас үзэхэд эрлийз хунтайж өөрөө бодож олсон бололтой.

Харри хэдийн хунтайжын зохиосон хэдэн шившлэгийг оролдож үзжээ. Тэдний нэг болох аймшигтай хурдан хөлийн хумс ургуулах (Харри түүнийг Крэбб дээр тусахад хөгжилтэй үр дүн гарчээ), хэл тагнайндаа цавуудах (энэ шившлэгийг Харри хоёр ч удаа юу ч сэжиглээгүй Аргус Филчэд хэрэглээд алга ташилт хүртсэн байна), хамгийн ашигтай нь гэвэл Дүлийрүүлэх шившлэг байсан бөгөөд түүнийг хэрэглэхэд чихэнд ойлгомжгүй шулганалтаас ондоо зүйл дуулдахаа болих учир гадны хүн сонсож болно гэдгээс айлгүй ярьж болох байлаа. Зөвхөн ганц хүн л эдгээр шившлэгүүдийг хөгжилтэй гэж бодохгүй байв. Гермiona өмнөхийн адил энэ бүх тоглоомыг дэмжилгүй хэрвээ Харри хэн нэгэнд Дүлийрүүлэх шившлэг илгээх юм бол хатуу чанд байр суурьтайгаар ярихаас татгалздаг байв.

Харри орон дээрээ суугаад номоо эргүүлж хунтайж хүндхэн зохиосон бололтой шившлэгийн жижигхэн мөрүүдийг ялгахын тулд ойртуулан харлаа. Тэрбээр олон тооны удаа баллаж сохолсны дүнд хуудасны буланд эцсийн үр дүнгээ тавьсан байв.

Левикорпус (ү-бс)

Бороон дусал нойтон цас болж хувираад цонхны шил нүдэх, Невиллийн чанга хурхиралтан дунд Харри хаалтанд хийсэн үсгийг харлаа. Ү-бс ... энэ үгэн бус гэсэн үг байх. Харри шившлэг бүтнэ гэдэгт эргэлзлээ. Тэр одоо хүртэл үгэн бус шившлэгийг Снеггийн хар урлагаас хамгаалах хичээл дээр хэрэглэж сураагүй байв. Гэвч нөгөө талаас эрлийз хунтайжаас суралцах нь Снеггийнхээс илүү сэтгэгдэл төрүүлж байлаа.

Тэр шидэт саваагаа чиглэсэн юмгүй зангаж огцом даллаад бодолдоо «Левикорпус!» гэлээ.

- А-а-а-а-а-а-а-а!

Хурц гэрэл гялсхийгээд өрөөгөөр дүүрэн хашгиралт үүсэхэд бүгдийг Роны зэрлэг хашгиралт сэрээлээ. Харри номоо унагалаа. Рон үл үзэгдэх дэгээнээс шагайгаараа өргүүлсэн мэт агаарт толгойгоо уруугаа харуулан өргөгджээ.

- Уучлаарай! гэж Харри орилоход Дин, Симус хоёр хөхрөлдөн инээлдэж, Невил орноосоо унаад босож ирэв.

- Түр хүлээгээрэй, би одоохон ...

Тэр уусмалын хичээлийн сурах бичгээ аваад сандралд орон түргэн эргүүлж эцэст нь хэрэгтэй газраа олоход учрыг нь олоход бэрх үг сараачсан байв. Харри дотроо эсрэг шид үйлчлэхийг гуйн байж бүх хүчээ гарган «Либеракорпус!» гэж бодлоо.

Ахин нэг гэрэл гялсхийхэд Рон орон дээрээ газардав.

- Уучлаарай гэж Харри чичирсэн хоолойгоор хэлэхэд Дин, Симус хоёр ахин хөхрөлдөв.

- Маргааш чамайг сэрүүлгийн оронд тавьсан дээр байх гэж бодож байна хэмээн Рон бувтналаа.

Тэд хатагтай Уизлийн нэхсэн хэдэн цамц давхарлан өмсөж жанчаа углаад, ороолт ороож бээлий өмсөх үед Рон жаахан тайвширч Харри их инээдтэй шившлэг олсон тухай өглөөний цайны үеэр Гермионад ярьжээ.

- ... тэгтэл ахин нэг гэрэл гялсхийхэд би орон дээрээ хэвтэж байлаа! гэж тэр баяртай хэлээд тавгандаа зайдас дүүргэв.

Гермиона түүний яриаг сонсоод огтхон ч инээмсэглэлгүй Харри руу хүйтнээр харлаа.

- Энэ шившлэг санамсаргүй чиний уусмалын хичээлийн хайртай сурах бичгийнх чинь биш биз?

Харри хөмсөг зангидав.

- Шуудхан муу зүйл сэжиглэх юмаа?

- Үгүй юм уу?

- Тийм л дээ ... тэгээд юу гэж?

- Хэрвээ чи үл таних хүний гараар бичсэн шившлэгийг оролдож үзэхээр шийдсэн бол юу болохыг харж байгаа биз дээ?

- Гараар бичсэнд ямар ялгаа байгаа юм бэ?

- Учир нь шившлэгийг ид шидийн яамнаас батлаагүй гэдэгт байгаа юм. Тэгээд ч гээд Гермиона Рон, Харри хоёр руу ууртай харж,

- Би танай энэ хунтайжыг эргэлзээтэй хүн гэж бодож эхлээд байна гэв. Харри, Рон хоёр зэрэг түүн рүү дайрлаа.

- Энэ чинь тоглоом шүү дээ! гэж Рон хашгираад сүмсний шилийг уруугаа харуулан зайдас руугаа сэгсэрлээ. Зүгээр л инээдтэй тоглоом, Гермиона тэгээд гүйцээ!

- Хүнийг шагайнаас нь уруугаа харуулан дүүжлэх чинь сайхан тоглоом байна даа! гээд Гермиона толгой сэгсэрснээ,

- Хэн ийм шившлэгэнд цагаа үрдэг байна? гэлээ.

- Фред, Жорж хоёр. Энэ тэдний төрлийнх гэж Рон мөрөө хавчин хэлэв.

- Миний аав гэж Харри хэллээ. Тэр сая л санажээ.

- Юу? гэж Рон, Гермиона хоёр зэрэг асуулаа.

- Миний аав энэ шившлэгийг ашиглаж байсан. Би ... Люпин надад хэлсэн юм гэж Харри хэллээ.

Сүүлчийн баталгаа нь худал байлаа. Үнэн хэрэгтээ Харри эцгийнхээ энэ шившлэгийг Снеггэд хэрэглэж байхыг харсан бөгөөд Рон, Гермиона хоёрт гүн ухааны цүнхээлд хийсэн аялалынхаа тухай яриагүй байлаа. Гэтэл түүнд нэг гайхамшигтай санаа төрлөө. Хэрвээ энэ эрлзийз хунтайж гэдэг нь ...?

- Магадгүй аав чинь түүнийг ашиглаж байсан байж болох юм, Харри. Гэхдээ тэр үүнийг хэрэглэдэг цорын ганц хүн биш. Хэрвээ чи мартсан бол бид үүнийг хэрэглэж байгаа бүлэг хүмүүсийг харсан. Хүмүүсийг агаарт дүүжлээд

... юу ч хийж чадахгүй болгосон байсан.

Харри түүн рүү ширлээ. Тэр квиддичийн дэлхийн аваргын тэмцээн дээр Үхэл залгигчид ийм үйлдэл гаргаж байсныг санажээ. Рон түүнд туслахаар яарав.

- Энэ чинь шал өөр хэрэг. Тэд шившлэгийг буруу тал руу нь хэрэглэсэн байна.

Харин Харри түүний аав хоёр зүгээр тоглож байсан. Чамд хунтайж таалагддаггүйн учир гэвэл Гермиона гэж Рон нэмэрлээд түүн рүү зайдсаар зааж,

- Тэр чамаас уусмалын хичээлдээ илүү гэдэгт байгаа юм гэлээ.

- Энэ үүнд ямар ч хамаагүй! гээд Гермионагийн хацар улайлаа.

- Би зүгээр л үйлчлэлийг нь мэдэхгүй үл мэдэгдэх шившлэг хэрэглэх нь хариуцлагагүй хэрэг гэж бодож байна. Тэгээд ч та хоёр үргэлж хунтайжын тухай ярилцах юм. Би ийм тэнэг нэр хэрэглэдэг хүн өөдтэй биш гэдэгт мөрийцсөн ч бэлхэн байна!

- Чи юуны тухай яриад байна? Хэрвээ тэр Үхэл залгигч байсан бол эрлийз гэдгээрээ бахархах байсан гэж үү?

Харри үгээ хэлж дуусаагүй байхдаа эцэг нь цэвэр цусны шидтэн байсан гэдгийг санасан ч энэ бодлоо дараа тунгаахаар үлдэн хөөлөө ...

- Бүх Үхэл залгигчид цэвэр цусных байж чадахгүй. Би тэдний ихэнхи нь эрлийз хэдий ч үүнийгээ нуудаг байх гэж бодож байна. Тэд маглуудаас гаралтай шидтэнг үзэн яддаг болохоор жишээлбэл Рон та хоёрыг эгнээндээ баяртайгаар авах байсан.

- Би энэ дэлхий дээр яагаад ч Үхэл залгигч болохгүй! гэж Рон уурсаад сэрээгээрээ Гермiona руу зангахад зайдасны үлдэгдэл нисэн Эрни Макмилланы толгой руу онолоо. Манай гэр бүлийхэн бүгдээрээ цэвэр цуснаас урвагчид! Энэ бол тэдний хувьд магл гаралтай гэдгээс муу зүйл!

- Харин тэд надад хайртай болох юм шиг санагдаж байна гэж Харри даажигнан хэлээд,

- Хэрвээ тэд намайг дуусгахыг оролддоггүй бол сайн найзууд болох байлаа гэв. Рон инээмсэглэхэд, Гермiona хүртэл инээд алдлаа. Тэгтэл Жинни ирэв.

- Хөөе, Харри надад үүнийг чамд дамжуул гэж хэллээ.

Энэ нь Харрийн нэрийг бичсэн танил налуу бичигтэй хуйлаастай цаас байлаа.

- Баярлалаа, Жинни ... энэ Дамблдорын дараагийн хичээл байна! гэж Харри Рон, Гермiona хоёрт мэдэгдээд цаасыг тэнийлгэн түргэн уншлаа.

- Даваа гаригийн үдэш гэнээ! гээд түүний сэтгэл санаа ер бусын хөгжилтэй боллоо. Бидэнтэй Хогсмид явах уу, Жинни?

- Би Динтэй явна. Магадгүй тэнд уулзаж болох л юм гээд гараа даллан цааш явлаа.

Үүдний царсан хаалган дээр Филч зогсоод хүмүүсийн Хогсмид явах зөвшөөрлийг шалгаж байв. Өнөөдөр энэ үйл явц ердийнхөөс илүү удаан үргэлжилсний учир гэвэл Филч гарч буй хүн бүрийг нууц зүйл илрүүлэгчээр шалгав.

- Хэрвээ хэн нэгэн сургуулиас хар урлагын зүйл авч гарахыг хүссэн бол ямар ялгаа байна? Хамгийн гол нь дотогш авч орохгүй бол гэдэгтээ байгаа юм биш үү! гээд Рон илрүүлэгчийг болгоомжлон харлаа.

Тэр өөрийн ээлжиндээ илрүүлэгчид хэдэн удаа ширүүн үрүүлэн үрчийгээд гудамжинд гарахад цас бороо холилдон орж байлаа.

Хогсмидийн зугаалга таагүй болов. Харри нүүрээ ороолтонд нүдээ хүртэл шигтгэсэн ч үлдсэн хэсэг нь бээрч мэдээ алдлаа. Сурагчид тосгон хүрэх зам дээгүүр өрөвдөх сэтгэлгүй салхинд бөхийн гүйлдэж байв. Харри хэдэн ч удаа дулаахан аятай амралтын өрөөндөө үлдээгүйдээ харамсаад эцэст нь Хогсмидэд хүрэхэд шидэт тоглоомын «Зонко» дэлгүүрийн самбар хаалттай болохыг илрүүлэв. Харри энэ хувь заяаны тэмдгийг Хогсмидэд хөгжилдэх боломжгүй болгон хүлээж авлаа. Рон зузаан бээлийгээрээ «Амтат ван»-гийн зүг дохиход аз болоход онгорхой байлаа. Харри, Гермiona хоёр Роны араас оров.

- Бурханд баярлалаа гэж Рон чихрийн анхилам үнэртэй дулаахан өрөөнд ороод дагжин хэллээ.

- Харри, хүү минь! гэх чанга танил хоолой тэдний ард сонсогдов.



- Өө, үгүй ээ гэж Харри бувтналаа.

Гурвуулаа эргэж хараад профессор Слизнорт том арьсан малгай, үстэй захтай дээл өмсөөд гартаа том хайрцагтай хэвжүүлсэн хан боргоцой барьсныг харлаа. Тэр дэлгүүрийн дөрөвний нэг хэсгээс багагүй зайг эзэлж байв.

- Харри чи хэдийн гурван удаа миний нөхөрсөг зоогийг алгаслаа! гэж Слизнорт элэгсгээр цээж рүү нь ёворч хэлээд,

- Тэгж болохгүй, хүү минь! Би бүр чамайг шийтгэхийг хүсч байна шүү!

Хатагтай Грэйнджерт миний үдэшлэг таалагдсан байх тийм үү? гэв.

- Тиймээ, тэд үнэхээр ... гэж Гермiona цөхрөнгүй хэлэв.

- Харин та яагаад хамт ирсэнгүй вэ, Харри? хэмээн Слизнорт шаардангуй асуулаа.

- Би квиддичийн бэлтгэлтэй байсан, профессор.

Тэр үнэн хэрэгтээ Слизнортын урилгыг хүлээн аваад бэлтгэлийн цагийг тааруулсан юм. Энэ арга нь Рон ганцаар үлдэхгүй болж тэд Жиннигийн хамтаар Гермiona хэрхэн Маклагген, Забини нартай байгаа талаар төсөөлөн инээлдсэн билээ.

- Таныг эхний тэмцээнд хожихын тулд бэлтгэл хийх ёстойг ойлгож байна! Гэхдээ заримдаа амрах хэрэгтэй байдаг юм. Даваа гаригийн үдэшлэгийн хувьд та ийм цаг агаартай байхад бэлтгэл хийх боломжгүй болохоор ...

- Чадахгүй нь, профессор. Би ... надад ... энэ үдэш профессор Дамблдортой уулзах ёстой.

- Ахиад л аз таарсангүй! гэж Слизнорт жүжигчилсэн байртай дуу алдаад,

- Гэхдээ ... чи надаас үүрд бултаад байх боломжгүй шүү, Харри гэв.

Ингээд хаан хүн шиг даллаад дэлгүүрээс гарахдаа Ронд лангуун дахь багц жоомноос илүү анхаарал хандуулсангүй.

- Итгэмээргүй юм чи ахиад л мултарчихлаа! гэж Гермiona толгой сэгсрэн хэллээ. Үнэн хэрэгтээ тэнд муугүй байсан ... заримдаа бүр ч сонирхолтой гээд Роны царайг харснаа,

- Хөөх, хараач энэ чихэртэй үзэг байна ... хэдэн цагийн турш бичиж болдог гэлээ.

Гермiona сэдвийг өөрчилсөн явдалд Харри талархаад шинэ нэмэлт том чихрэн үзэг рүү сонирхон харах үед Гермiona тэднээс хаашаа явахыг хүсч байгааг асуухад Рон мөрөө хавчлаа.

- «Гурван шүүр» рүү явъя. Тэнд дулаахан гэж Харри санал болгов.

Тэд ахиад л ороолтоороо нүүрээ хучин амтатны дэлгүүрээс гарлаа. «Амтат ван»-гийн чихрэн дулааны дараа салхи хэрцгийгээр нүүр нүдгүй ороолгож байв. Гудамжинд хүмүүс цөөхөн байлаа. Хэн ч ярихаар зогсохгүй зөвхөн зорьсон газраа хүрэхээр гүйлдэх аж. «Гурван шүүр»-ийн гадаа хоёр эрэгтэй хүн зогсож байлаа. Нэг нь өндөр

туранхай бөгөөд Харри бороонд угаагдсан нүдний шилэн дороосоо Хогсмидын өөр нэг баар болох «Гахайн толгой»-н эзнийг танилаа. Андуудыг ойртоход үйлчлэгч жанчны захаа битүү товчлоод цааш явахад намхан хөрш нь гартаа юм бариад үлдэв. Тэднийг түүнд хүрэхэд ердөө хэдхэн алхамын зай үлдээд байтал Харри гэнэтхэн хэн болохыг нь танилаа.

- Наземникус!

Намхан майга хөлтэй, урт шаргал үстэй хүн цочсондоо гартаа байсан хуучин чемоданаа алдахад тархийн унаад газраар нэг хуучин зүйлс худалддаг дэлгүүрийн үзмэрийн цонхонд байдаг шиг янз бүрийн зүйл тархав.

- Аан, Харри сайн уу гэж Наземникус Флетчер итгэлгүйхэн хэлээд,

- За, чамайг саатуулахыг хүсэхгүй байна гэв.

Тэр түргэн явахыг хүссэн мэт бөхийн газар байсан эд зүйлээ чемодандаа цуглуулан хийлээ.

- Чи энэ зүйлийг зарах гэж байсан юм уу? гэж Харри Наземникус хэрхэн бохир эд зүйлс цуглуулахыг хараад асуулаа.

- Өө, амьдрахын тулд юм хийх хэрэгтэй биз дээ! Алив нааш нь! Рон бөхийн газраас мөнгөлөг цом аваад,

- Хүлээгээрэй. Би үүнийг нэг л харсан юм байна ... гэж удаанаар хэлэв.

- Баярлалаа! гээд Наземникус цомыг Роны гараас булаан авч чемодандаа хийлээ.

- За, дараа уулзацгаая ... Ёо!

Харри Наземникусыг баарны хананд шахав. Нэг гараараа хоолойноос нь бариад нөгөө гараараа саваагаа гаргалаа.

- Харри! гэж Гермиона дуу алдав.

- Чи энэ цомыг Сириусын гэрээс хулгайлсан. Түүн дээр Блэкийн гэр бүлийн сүлд байна гээд Харри Наземникустай бараг хамраа нийлүүлэх шахахад хуучин тамхи, спиртийн таагүй үнэр ханхлав.

- Би ... үгүй ... яаж дээ ...? гэж Наземникус амьсгаадаад хүрэн улаан болжээ.

- Чи түүнийг үхсэн шөнө очиж гэрийг нь дээрэмдээ юу? гэж Харри зандарлаа.

- Үгүй ... би ...

- Надад өг!

- Харри, хэрэггүй! гэж Гермиона хашгирахад Наземникус хэдийн хөхөрч эхэлжээ.

Ямар нэг зүйл чанга тасхийгээд Харрийн гар Наземникусын хоолойноос тавигдлаа. Тэр амьсгаадан хахаж цацалсаар чемоданаа аваад тас хийн үл мэдэгдэх зүгт шилжлээ.

Харри чанга хараагаад Наземникус хаашаа алга болсныг мэдэхийн тулд байрандаа эргэлдэв.

- Буцаад ир, хулгайч минь!

- Ашиггүй дээ, Харри.

Тэдний өмнө Тонкс зогсож байлаа. Түүний саарал үс цас болжээ.

- Наземникус одоо хэдийн Лондонд байгаа. Хашгирах хэрэггүй.

- Тэр Сириусын эд зүйлийг хулгайлсан! Хулгайлсан, ойлгож байна уу!

- Тиймээ, тийм гэхдээ яагаад үүний төлөө хүйтэнд зогсох хэрэгтэй гэж хэмээн

Тонкс энэ мэдээ санааг нь огт зовоогоогүй аятай хэллээ.

Тэр тэднийг «Гурван шүүр»-ийн үүдэнд хүргэж өгөв. Босго дөнгөж давангуут Харри ахин тэссэнгүй,

- Тэр Сириусын юмыг хулгайлсан! гэв.

- Би бүгдийг ойлгож байна, Харри. Зөвхөн битгий хашгир гуйя, хүмүүс биднийг хараад байна гэж Гермiona шивнээд,

- Явж суу. Би чамд уух юм авчирья гэв.

Хэдэн хормын дараа тэр ширээнд эргэж ирэхдээ гурван шилэн аягатай цөцгийний шар айраг авчрав. Харри уур хилэнд автсан хэвээр байлаа.

- Бүлэг үнэхээр Наземникусыг хянаж чаддаггүй гэж үү? хэмээн найзууддаа уурсан шивнээд,

- Тэр штабын байрны бүх зүйлийг хулгайлахаас өмнө зогсоох ямар нэг зүйл хийхгүй юм байх даа? гэв.

- Чшш! гэж Гермiona цөхрөн гуйгаад хэн нэгэн сонссон эсэхийг шалган ийш тийшээ харлаа.

Зэргэлдээх ширээний хоёр шидтэн Харрийн зүг сонирхон харахад, холгүйхэн баганы дэргэд Забини уйдсан янзтай сууж байв.

- Харри би чиний оронд байсан бол бас л уурлах байсан. Би чиний зүйлийг хулгайлсан гэдгийг ойлгож байна ...

Харри цөцгийний шар айрганд хахаж цацлаа. Тэр Гриммогийн арван хоёрдугаар байшин түүнд харьяалагдах болсон гэдгийг мартсан байв.

- Тиймээ, энэ миний эд зүйл! Тэр намайг хараад баярлаагүй явдалд гайхах юм алга! За яахав, би Дамблдорд очоод заавал юу болсныг хэлэх болно. Тэр л ганц Наземникусыг айлгах хүн.

- Сайхан бодол байна гэж Гермiona дэмжээд Харригт тайвширсан явдалд баяртай боллоо.

- Рон чи юугаа тэгтлээ хараа вэ?

- Юу ч биш гэж Рон түргэн хэлээд лангуунаас хараагаа холдуулсан ч Харри түүний мухлагийн эзэн болох дур булаам хатагтай Розмертагийн харцыг барихыг оролдож байсныг мэдэж байв.

- Би галт шарз болохгүй гэж мэдэж байна хэмээн Гермiona егөөдөнгүй хэллээ. Рон тохуурхалыг үл тоомсорлоод цөцгийний шар айргаа чимээгүйхэн уулаа. Харри Сириусын гэр бүлийн мөнгөн эдлэлүүдээ тэвчиж чаддаггүй байсан талаар бодов. Гермiona хуруугаараа ширээ бөмбөрдөнгөө баарны лангуу руу харав.

Харриг лонхон дахь сүүлчийн дусал шар айргаа ууж амжтал Гермiona,

- За өнөөдрийн хувьд хангалттай байх. Сургууль руугаа буцах уу? гэв.

Тэд хоёул толгой дохилоо. Зугаалга хөгжилтэй бус болсоны дээр цаг агаар улам дорджээ. Тэд ахин жанчаа товчлон, ороолтоо ороогоод, бээлийгээ өмсөв. Энэ агшинд Кэти Белл найз охиныхоо хамт баарнаас гарлаа. Гурван найз бас гарч охидын араас төв гудамжинд гарав. Харри Жиннигийн тухай саналаа. Тэр түүнтэй тааралдсангүй. Тэр эргэлзээгүй Диний хамт хатагтай Паддифутын кафед аз жаргалтай хосуудын дунд сууж байгаа байх. Харри хөмсгөө өргөөд хүйтэн салхитай бороо угтахад толгойгоо бөхийлгөн цааш явлаа.

Хэсэг хугацааны дараа Кэти Белл болон найз охиных нь хоолой салхиар дамжин дуулдав. Харри нүдээ анивчаад бороон дахь тодорхойгүй дүрс рүү харав. Охид Кэтигийн гартаа барьсан зүйлийн талаар маргалдаж байлаа.

- Энэ чамд хамаагүй, Лианна! гэх Кэтигийн үг Харрид сонсогдов.

Тэд булан эргэхэд нойтон цас улам лавсаж Харрийн нүдний шилэнд тогтов. Тэр бээлийтэй гараараа арчихаар өргөх агшинд Лианна Кэтигээс хуйлаасыг авах оролдлого хийв. Кэти өөр лүүгээ буцаан татахад хайрцаг газар уналаа.

Тэр агшинд Кэти агаарт гуа жавхлантайгаар хөөрөөд нисэхийг хүссэн мэт гараа дэлгэв. Энэ нь ямар нэг хачирхалтай хэвийн бус аймшигтай зүйл байлаа ... Салхи Кэтигийн үсийг хүчтэй хийсгэхэд нүд нь аниатай царайд нь ямар ч төрх илэрсэнгүй. Харри, Рон, Гермiona, Лианна нар байрандаа хөшөөд түүнийг нүд салгалгүй харав.

Газраас зургаан футын өндөрт хөөрсөн хойноо Кэти гэнэтхэн аймшигтай хашгирлаа. Нүд нь нээгдэж харж байсан ч тэсэхийн аргагүй өвдөлт мэдэрсэн нь тодорхой. Тэр хашгирахаа больсонгүйд Лианна бас хашгирч Кэтигийн шагайнаас зууран доошоо буулгахыг хичээв. Харри, Рон, Гермiona нар түүнд туслахаар ухасхийв. Тэд Кэтигийн хөлөөс зэрэг татахад газар уналаа. Харри, Рон хоёр түүнийг амжин тэвэрч авахад тогтоон барихын аргагүй атиралдан мурилзав. Тэд түүнийг газар буулгалаа. Тэр үргэлжлүүлэн хашгирч хэнийг ч танихгүй байлаа.

Харри эргэн тойрноо харахад хэн ч байсангүй.

- Хаашаа ч битгий яваарай! Би явж тусламж дуудъя! гэж тэр улин исгэрэх салхин дундуур орилов.

Тэр сургуулийн зүг гүйлээ. Харри хэзээ ч ингэж байгаа хүн хараагүй болохоор Кэтид юу тохиолдсоныг төсөөлсөнгүй. Замын эргэлтэн дээр аварга том баавгайн дүрстэй тааралдаад арын хөлийг нь мөргөв.

- Хагрид! гэж Харри амьсгаадан хэлээд унахдаа орооцолдсон бургасан хашаанаасаа салав.

- Харри! гэж Хагрид баяртай дуу алдав. Тэр өтгөн сэгсгэр минжний арьсан дээл өмсөөд хөмсгөнд нь нойтон цас тогтжээ.

- Би дөнгөж сая Гроххтой уулзаад явж байна, тэр хичнээн их ухаалаг болсныг чи төсөөлөхгүй дээ ...

- Хагрид тэнд нэг охин шархадсан эсвэл хараагдсан эсэхийг нь мэдэхгүй байгаа ч ...

- Юу гэнээ? гээд Хагрид хүчтэй салхинд Харрийн үгийг сайн сонсохын тулд бөхийв.

- Хэн нэгэн хараасан! гэж Харри хашгирав.

- Хараасан гэнээ? Хэнийг? Роныг уу? Гермionaг уу?

- Үгүй! Кэти Белл! Тэнд ...

Тэднийг хамтдаа зам рүү гүйн очиход атиралдан орилж хашгирах Кэтиг тойроод багахан бүлэг үүссэн байв. Рон, Гермiona хоёр Лианнаг тайвшируулахыг оролдоно.

- Алив холдоцгоо! Надад харах боломж өг! гэж Хагрид хашгирав.

- Түүнд ямар нэг зүйл тохиолдсон ... би юу гэдгийг нь мэдэхгүй байна ... гэж Лианна нулимс асгаруулав.

Хагрид агшин зуур Кэти руу харснаа үг хэлэлгүй бөхийн гар дээрээ тэврээд шилтгээн рүү гүйлээ. Хэдэн хормын дараа Кэтигийн чих дөржрөм хашгиралт алслан холдож зөвхөн салхины улиан үлдэв.

Гермiona уйлж байгаа Кэтигийн найз руу гүйж очоод тэвэрлээ.

- Чи Лианна байх, тийм үү? Охин толгой дохилоо.

- Энэ гэнэтхэн болсон юм уу эсвэл ... ?

- Энэ хайрцаг задрахад болсон гэж Лианна цурхираад газар хэвтэх шалба норсон хүрэн цаастай хайрцаг руу заав.

Цаас урагдаж цоорхойгоор нь ногоон зүйл цухуйжээ. Рон хайрцагт хүрэхээр бөхийсөн ч Харри гараас нь барьж арагш холдуулав.

- Бүү хүр!

Харри доош суулаа. Урагдсан цаасан дотроос бадмаараг хүзүүний зүүлт цухуйж байлаа.

- Би үүнийг урьд нь харж байсан юм байна гэж Харри чимэглэлийг анхааралтай харж хэлээд,

- Зуун жилийн өмнө «Горбин ба Бэркс» мухлагын лангуунд байсан. Үүн дээр хараалтай гэж бичсэн байсан. Кэти лав түүнд хүрсэн байх гээд Лианна руу толгойгоо эргүүлэн,

- Тэр үүнийг хаанаас авсан юм бэ? гэлээ.

- Ийм учраас л бид маргасан юм! Тэр «Гурван шүүр»-ийн жорлон руу ороод гартаа цаасан хайрцагтай эргэн ирэхдээ Хогвартсын хэн нэгний гэнэтийн бэлэг байх гэж гэсэн ... Тэр маш хачирхалтай ярьсан ... Бурхан минь, үгүй ээ тэр лав Имперуус шидийн нөлөөн дор байсан байх, би мэдсэнгүй!

Лианна чичирснээ ахин цурхирлаа. Гермiona мөрийг нь халамжлангуй илэв.

- Лианна, тэр үүнийг хэн өгсөнийг хэлээгүй юу?

- Үгүй ... хэлэхийг хүсээгүй ... харин би түүнийг тэнэг амьтан сургууль руу аваачих хэрэггүй гэж хэлсэн ч намайг сонсохыг хүсээгүй ... тэгээд би үүнийг булаах гэтэл ... тэгээд ... тэгээд ...

Лианнагийн яриа өрөвдөлтэй орилолт болж хувирав.

- Бид сургууль руу явсан нь дээр байх гэж Лианнаг тэвэрч байсан Гермiona хэлээд,

- Түүний хэр байгааг мэдье. Явцгаая ... гэлээ.

Харри тэнэгэлзсэнээ ороолтоо тайлан Роны дуу алдахыг тоолгүй нямбайлан зүүлтийг ороогоод газраас өргөлөө.

- Бид үүнийг хатагтай Помфрид үзүүлэх хэрэгтэй байх.

Ингээд Роны хамт Гермiona, Лианна хоёрын араас явахдаа бодлогоширонгоо шилтгээний хаалганд хүрэх үед тэсч чадалгүй яриа эхлүүлэв.

- Малфой энэ зүүлтний тухай мэдэж байсан. Тэр «Горбин ба Бэркс» мухлагын лангуунд дөрвөн жилийн өмнө байсан юм. Би Малфой болон түүний ааваас нуугдаж байхдаа яаж ширтэж байхыг нь харсан. Тэр биднийг дагадаг өдөр худалдаж авсан байх! Тэр энэ зүүлтийн тухай санаад тийшээ очсон байх!

- М-мэдэхгүй, Харри гэж Рон итгэлгүйхэн хэлээд,

- «Горбин ба Бэркст» олон л хүмүүс ордог шүү дээ ... тэгээд ч охин Кэти түүнийг охидын жорлонгоос авсан гэж хэлээ биз дээ? гэв.

- Тэр Кэтиг жорлонгоос эргэж ирсэн гэсэн болохоос биш түүнд шууд өгсөн гээгүй ...

- МакГонагалл! гэж Рон анхааруулан дуу алдав.

Харри дээшээ харлаа. Тэгтэл ч үнэхээр чулуун шатаар профессор МакГонагалл нойтон цасыг үл тоомсорлон чулуун гишгүүр уруудан бууж ирлээ.

- Хагрид та дөрвийг Кэти Беллд тохиолдсон явдлыг харсан гэлээ ... бүгд дээшээ миний өрөө лүү орцгоо. Таны гарт юу байгаа юм бэ, Поттер?

- Энэ түүний хүрсэн зүйл гэж Харри хариулав.

- Бурхан минь! гэж профессор МакГонагалл айн дуу алдаад Харригаас зүүлтийг авч түгшин харлаа.

- Үгүй, үгүй Филч тэд надтай хамт яваа юм! гэж Филчийг Үүдний танхимд илрүүлэгчтэй угтан ухасхийхэд яаран хэлэв.

- Энэ зүүлтийг профессор Снеггэд аваачиж түргэн аваачиж өг. Гэхдээ битгий хүрээрэй! Ямар ч тохиолдолд ороолтыг бүү задлаарай!

Харри болон үлдсэн хүмүүс профессор МакГонагллыг даган шатаар өгслөө. Цонхны цаана нойтон цас хялмаалан ханан зууханд гал асаж байсан ч өрөөнд сэрүүн байлаа. Профессор МакГонагалл хаалга хаагаад бичгийн ширээний ард сууж Харри, Рон, Гермиона болон уйлж байгаа Лианна нар луу харлаа.

- Тэгэхээр юу болоо вэ?

Түгдрэн нулимсаа залгилан байж Лианна Кэти хэрхэн «Гурван шүүр»-ийн жорлон руу ороод ямар ч тэмдэглэгээгүй хайрцагтай эргэж ирэхдээ биеэ хачирхалтай авч явж байсан бөгөөд тэд үл мэдэгдэх зүйлийн талаар маргалдан булаацалдаад цаас урагдсаныг ярилаа. Тэгснээ Лианна ахин нулимс асгаруулан юу ч нэмж хэлэх боломжгүй болов.

- За сайн байна эмнэлгийн хэсэгт очоод хатагтай Помфригоос тайвшируулах ямар нэг зүйл өгөхийг гуй, Лианна гэж профессор МакГонагалл аяархан хэлэв.

Лианнаг явмагц профессор Макгонагалл Харри, Рон, Гермиона нар луу эргэлээ.

- Кэти зүүлтэнд хүрсний дараа юу болсон бэ?

- Тэр агаарт хөөрсөн гэж Харри Рон, Гермиона хоёрыг ямар нэг зүйл хэлж амжихаас урьтан хэлээд,

- Дараа нь газар унаад хашгирч эхэлсэн. Уучлаарай профессор би профессор Дамблдортой ярьж болох уу? гэв.

- Захирал сургууль дээр даваа гариг хүртэл ирэхгүй гэж профессор

МакГонагалл түүний гуйлтанд гайхширан хэллээ.

- Ирэхгүй гэнээ? хэмээн Харри уурсан давтлаа.

- Тиймээ, Поттер ирэхгүй! гэж профессор МакГонагалл ширүүн хэлээд,

- Гэхдээ та мэдээж аймшигтай үйл явдлын шалтгааны талаарх зүйл хэлэх гэж байгаа бол надад үүнийгээ хэлж болох юм! гэв.

Харри агшин зуур чимээгүй болоод шийдэх эсэхээ мэдсэнгүй. Профессор МакГонагллтай яриа өрнүүлэх нь хэцүү байлаа. Хэдийгээр Дамблдор олон талаар түүнээс аймшигтай ч бусдын онол ухаангүй байсан ч хүндэтгэлтэй ханддаг юм. Гэхдээ амьдрал үхлийн шалтгаан болоод байхад ийм зүйлд санаа зовж байх цаг байсангүй.

- Би Драко Малфой зүүлтийг Кэтид өгсөн гэж бодож байна, профессор.

Түүний дэргэд зогсож байсан Рон ичингүйрэн хамраа үрэхэд, нөгөө талд нь зогсож байсан Гермиона Харригаас холдохыг хүссэн мэт хөлөө сольж гишгэлэв.

- Энэ чинь их ноцтой буруутгал байна, Поттер гээд профессор МакГонагалл хэсэг чимээгүй байснаа,

- Таньд баримт нь байгаа юм уу? гэлээ.

- Үгүй гэхдээ ... гээд тэр Малфойг хэрхэн дагалдан «Горбин ба Бэркс» мухлаг руу ороход Горбинтой хийсэн яриаг нь сонссон тухайгаа хэллээ.

Түүнийг чимээгүй болох үед профессор МакГонагалл бодлогоширсон төрхтэй болов.

- Малфой «Горбин ба Бэркс» мухлагт ямар нэг зүйл засуулахыг хүссэн юм уу?

- Үгүй, профессор тэр зөвхөн Горбиныг яаж засахыг хэлэхийг хүссэн. Түүнд өөрт нь байгаагүй. Гэхдээ энэ нь гол биш. Хамгийн гол нь тэр ямар нэг зүйл худалдаж авсан. Би үүнийг зүүлт байх гэж бодож байна ...

- Чи Малфойг дэлгүүрээс гарахад гарт нь ийм хайрцаг байхыг харсан юм уу?

- Үгүй, профессор тэр Горбиныг дэлгүүртээ хадгалж байхыг ...

- Гэхдээ Харри гэж Гермиона түүний яриаг таслаад,

- Горбин Малфойг тэр зүйлийг өөртөө авч явахыг хүсэхэд үгүй гэж хэлсэн шүү дээ ... гэв.

- Өөрөө хүрэхийг хүсээгүй л байхгүй юу! гэж Харри ууртай хэлэв.

- Тэр би энэ зүйлийг яаж авч явах юм бэ? гэж тодорхой хэлсэн хэмээн

Гермиона сануулав.

- Тэр гудамжаар зүүлттэй явж байвал тэнэг харагдах нь тодорхой гэж Рон оролцов.

- Өө, Рон гэж Гермиона тэвчээргүйхэн дуу алдаад,

- Тэр боолттой байсан болохоор хүрэх хэрэг байхгүй. Тэгээд ч жанчин дороо нуугаад явж байхад хэн ч анзаарахгүй! Би түүнийг Горбинтой илүү чимээ шуугиан овор хэмжээ ихтэй гудамжаар ажиглагдахгүй авч явж болохооргүй зүйлийн талаар ярьсан байх гэж бодож байна. Тэгээд ч гэж Харрийн үг хэлэхийн урьд дуугаа өндөрсгөөд,

- Би Горбинаас зүүлтний тухай асуусаныг санаж байна уу? Түүний Малфойд юу хадгалж байгааг мэдэхийн тулд. Гэсэн ч Горбин надад үнийг нь хэлэхдээ зүүлт зарагдсан гэж хэлээгүй... гэв.

- Мэдээж тэр чамд хэлэхгүй. Чамд юу хэрэгтэй байгааг шууд тааварласан юм чинь. Тэгээд ч Малфойд зүүлтийн араас хэн нэгнийг илгээж ...

- Хангалттай гэж профессор МакГонагалл Гермионаг эсэргүүцэхээр ам нээхэд хэлэв.



- Поттер би таныг хэлсэн үгийг үнэлж байгаа ч бид ноён Малфойг зүүлт худалдаж байсан дэлгүүр лүү орсны төлөө буруутгаж болохгүй. Учир нь зүүлтийг өөр хүн худалдан авсан байж болно. Тэнд мэдээж олон хүмүүс орсон нь тодорхой ...

- Би тэгж хэлсэн биз дээ гэж Рон бувтнав.

- ... ямар ч тохиолдолд бид энэ жил аюулгүй байдлыг хүчтэй нэмэгдүүлсэн болохоор зүүлтийг сургууль руу мэдэгдэхгүй оруулж чадна гэдэгт итгэхгүй байна ...

- Гэхдээ ...

- ... бас ноён Малфой өнөөдөр Хогсмидэд байгаагүй гэж профессор

МакГонагалл хэлэв. Харри амаа ангайн харлаа.

- Та хаанаас мэдээ вэ, профессор?

- Яагаад гэвэл тэр надаас шийтгэлтэй байсан юм. Тэр хоёр ч удаа хувиргалын хичээлийн гэрийн даалгавар хийгээгүй. Нэг үгээр хэлэхэд надад сэжиглэлээ хэлсэн явдалд, баярлалаа Поттер гээд хаалга руу алхаж,

- Би одоо эмнэлэг руу явж Кэти Беллийн хэр байгааг мэдэх хэрэгтэй байна.

Өдрийг сайхан өнгөрүүлээрэй гэлээ.

Тэр хаалга нээлээ. Гурвуул чимээгүйхэн хонгил руу гарав.

Харри тэр хоёрыг МакГонагаллын талд орсон явдалд уурлаж байсан ч болсон явдлын тухай хэлэлцэхэд дуугүй байж чадсангүй.

- Та нар зүүлтийг Кэти хэнд өгөх ёстой байсан гэж бодож байна? хэмээн Рон шатаар Гриффиндорын амралтын өрөө рүү өгсөхөд хэлэв.

- Хэн мэдэх юм. Ямар ч байлаа гэсэн тэр шидээр аврагдсан. Нэг ч хүн хайрцагыг зүүлтэнд хүрэхгүй онгойлгож чадахгүй гэж Гермиона хэлэв.

- Би хэнд илгээх нь бага гэж бодож байна. Дамблдор. Үхэл залгигчид түүнээс салахдаа баяртай байх болно. Тэдний номер нэг бай юм чинь. Эсвэл Слизнорт ч юм уу. Дамблдор Волан-де-Морт түүнийг талдаа оруулахыг маш их хүсч байгаа гэсэн болохоор ийшээ ажиллахаар ирсэнд сэтгэл дундуур байгаа гэсэн. Эсвэл ...

- Эсвэл чамд гэж Гермиона түгшин хэлэв.

- Байж боломгүй юм. Тэгвэл намайг Кэтигийн араас баарнаас гарахад эргээд өгөхгүй яасан юм? Филч бүгдийг үүдэнд шалгаж байгаа болохоор Хогвартсаас хол хийсэн нь дээр биз дээ. Малфой яагаад түүнийг шилтгээнд оруул гэснийг ойлгох юм алга?

- Харри, Малфой Хогсмидэд байгаагүй! гэж Гермиона уурсан хэлээд хөлөө дэвслэв.

- Тэгвэл түүнд хамсаатан байж. Крэбб, Гойл ч юмуу ... Эсвэл өөр ямар нэгэн Үхэл залгигч байсан байж болох юм. Малфой Крэбб, Гойл хоёртой болохоор өөрөө

...

Рон, Гермиона хоёр бие бие рүүгээ «түүнтэй маргаад хэрэггүй» гэсэн байртай харлаа.

- Лабардан! гэж Гермиона тарган хатагтай хөргийн өмнө очиход шийдэмгий хэллээ.

Хөрөг эргэн Гриффиндорын амралтын өрөөнд орох гарц нээгдэв. Энд дүүрэн нойтон хувцасны чийг ханхлахыг бодвол олон сурагчид таагүй цаг агаарын улмаас Хогсмидээс эрт ирсэн бололтой. Гэхдээ айсан яриа хөөрөө сонсогдохгүй байгаагаас үзэгдэхэд Кэтид тохиолдсон явдлыг хэн ч мэдээгүй бололтой.

- Бодоод үзэх юм бол нэг их ухаалаг биш дайралт байлаа гээд Рон ердийнхөөрөө суудаг газар болох нэгдүгээр дамжааныхан суусан галын дэргэдэх сандал руу явж,

- Хараал шилтгээн дотор үйлчилэхгүй. Хэтэрхий найдваргүй арга гэлээ.

- Чиний зөв. Энэ бол тийм ч сайн бодсон арга биш юм гэж Гермиона зөвшөөрөхөд Рон хөлөөрөө сандал өшиглөн зангаж нэгдүгээр дамжааныхныг суудлаас нь босголоо.

- Гэхдээ Малфой дэлхий дээрх аугаа их сэтгэгчийн нэг байгаа биз дээ? гэж

Харри асуулаа.

Рон, Гермиона хоёр юу ч хэлсэнгүй.

## БҮЛЭГ 13: РЕДДЛИЙН НУУЦ

Дараагийн өдөр нь Кэтиг гэгээн Мунгогийн эмнэлэгт аваачив. Энэ үеэс л эхлэн түүний хараал туссан талаарх мэдээ сургууль даяар тархсан ч болсон үйл явдлыг хэн ч тодорхой мэдсэнгүй. Зөвхөн Харри, Рон, Гермиона, Лианна нар л мэдэж байлаа.

- Малфой бас мэдэж байгаа гэж Харри Рон, Гермиона хоёрт шинэ дүлий цагдаад хэлж байгаа аятай «Малфой бол Үхэл залгигч» гэсэн өөрийн онолоо давтлаа.

Харри Дамблдор даваа гаригийн үдэш эргэн ирж амжихгүй гэж эмээж байсан ч энэ тухай үг цухуйлгалгүй захирлын өрөөний хаалгыг найман цагаас цохиж орох зөвшөөрөл гуйлаа. Дамблдор ширээнийхээ ард ер бусын зүдэрсэн төрхтэй суугаад байж гар нь улам харлаж түлэгдсэн хэдий ч инээмсэглэн Харриг суухыг зангав. Гүн ухааны цүнхээл ширээн дээр нь тавиастай адарт мөнгөлөг тусгал нь ойн эргэлдэнэ.

- Намайг байхгүйд та нарт хангалттай үйл явдал болж. Миний ойлгож байгаагаар Кэтид чиний нүдэн дээр золгүй тохиолдол тохиолдсон юм байна.

- Тиймээ, ноёнтоон. Тэр хэр байгаа бол?

- Бие нь хүндхэн байгаа ч аз таарсан гэж хэлж болно. Тэр зүүлтэнд арьсаараа ялимгүй шүргэсэн бололтой. Бээлийд нь маш жижигхэн цоорхой байж. Хэрвээ тэр зүүлтийг зүүх юмуу бээлийгүй гараар авсан бол агшин зуур үхэх байсан. Аз болоход профессор Снегг хараалыг түргэн зогсоосон ...

- Яагаад тэр гэж? Харри түргэн асуугаад,

- Яагаад хатагтай Помфри биш? гэв.

- Ямар эрээ цээргүй юм! гэх аяархан дуу Сириусын өвөг эцэг Финеас Найжелус Блэкийн хөргөөс гарч толгойгоо өргөснөө,

- Намайг Хогвартсын захирал байх үед сурагчдад өөрсдийнхөө эргэлзлийн талаар асуулт тавихыг зөвшөөрдөггүй байсан юм гэлээ.

- Баярлалаа, Финеас гэж Дамблдор түүнийг зогсоов.

- Харри, профессор Снегг хар урлагийн талаар хатагтай Помфригоос илүү их мэдлэгтэй. Намайг эмнэлэгийн жигүүрт очиход түүнийг бүрэн эдгэрнэ гэх найдлага байсан.

- Харин та амралтын өдрүүдээр хаана байсан юм бэ, ноёнтоон? гэж Харри хайрамжгүй ширүүн асуугаад Финеас Найжелус шүднийхээ завсраар исгэрэхийг сонслоо.

- Би энэ тухай одоо ярихыг хүсэхгүй байна. Гэхдээ цаг нь болохоор чамд ярих болно гэж Дамблдор хэлэв.

- Ярьж өгнө гэнээ? хэмээн Харри гайхан давтлаа.

- Тийм гэж бодож байна гээд Дамблдор жанчныхаа дотор талаас ээлжит хуруу шилтэй мөнгөлөг дурсамж гаргаж ирээд бөглөөг нь саваагаараа нээв.

- Ноёнтоон би Хогсмидэд Наземниукстай уулзсан ... гэж Харри шийдвэргүйхэн эхлэв.

- Өө тийм л дээ, би Наземникус чиний залгамжилсан зүйлд хүндэтгэлгүй хандсан тухай сонссон гээд Дамблдор хөмсөг зангидан,

- Та нарын «Гурван шүүр»-т болсон ярианы дараа тэр надаас зайлсхийж байгааг бодвол уулзахаас эмээж байгаа бололтой. Гэхдээ цаашид түүнийг Сириусын зүйлийг зөөхгүй гэдэгт итгэлтэй байж болно гэв.

- Тэр бохир хагас цустан Блэкийн үе дамжсан зүйлийг хулгайлсан хэрэг үү? гэж Финеас Найжелус дэлбэрээд хөргөөсөө ууртай алхан гарч эргэлзээгүй Гриммогийн арван хоёр дугаар байшин дахь хөрөг рүүгээ зочлохоор явлаа.

- Профессор гэж Харри түр чимээгүй байсныхаа дараа хэлээд,

- Профессор МакГонагалл таньд миний Кэтигийн золгүй тохиолдлын талаарх бодлыг хэлсэн үү? Драко Малфойн тухай? гэв.

- Тиймээ, тэр надад чиний сэжиглэлийн тухай ярьсан.

- Харин тэгээд та ... ?

- Би Кэтид тохиолдсон явдалтай холбоотой бүхнийг нарийвчлан шалгаж байгаа. Гэхдээ одоо Харри бид хичээлд анхаарал хандуулах ёстой.

Харри үл ялиг эгдүүцэхээ мэдэрлээ. Хэрвээ энэ хичээл тийм чухал юм бол яагаад нэг хоёрдугаар хичээлийн хооронд тийм их завсарлага авсан юм бол? Гэсэн ч тэр Малфойн тухай ярилгүй Дамблдор хэрхэн дурсамжыг урт хуруугаараа бариад гүн ухааны цүнхээ рүү болгоомжтой сэгсрэхийг харлаа.

- Чи мэдээж өнгөрсөн удаад лорд Волан-де-Мортын өнгөрсөн үеийн тухай үзэсгэлэнтэй магл Том Редлл шидтэн эхнэр Меропагаа орхиж Бага-Хэнглтон дахь гэр бүлийн байшинд эргэн ирсэн тухай сонссон. Меропа Лондонд ганцаар үлджээ. Тэр хүүхдээ буюу лорд Волан-де-Мортыг төрөхийг хүлээж байсан байна.

- Та түүнийг Лондонд байсан гэдгийг хаанаас мэдэж байгаа юм бэ, ноёнтоон?

- Учир нь Карактак Бэрк энэ үйл явдлын цорын ганц гэрч болсон юм.

Хачирхалтай тохиолдлоор тэр зүүлтийг худалдан авсан дэлгүүрийн эзэн байжээ.

Дамблдор гүн ухааны цүнхээлийг зайлахад шингэн удаанаар хуйлран эргэлдэж жижигхэн хөгшин хүний дүрс мөнгөлөг хий үзэгдэл адил удаанаар гарч ирлээ. Түүний үс бараг нүдээ халхлах шахам духаа бүрхжээ.

- Тиймээ бид үүнийг ер бусын нөхцөл байдалд олж авсан. Түүнийг олон жилийн өмнө зул сарын үеэр залуухан шидтэн авчирсан юм. Энэ ч их эртний хэрэг дээ ... Тэр мөнгө хэрэгтэй гэж хэлэхэд энэ нь илэрхий байсан. Маш их элэгдсэн ноорхой хувцастай байсан ... Тэр хүүхдээ хүлээж байна гэж хэлээд зүүлтийг Слизеринээс залгамжилсан гэсэн. Бид нар үргэлж ийм төрлийн түүх сонсдог юм. «Өө, энэ бол Мерлинээс өвлөгдөж ирсэн хайртай аяга нь» гээд л.

Гэхдээ би зүүлтэн дээр үнэхээр Слизериний тэмдэг байгааг хараад хэдэн энгийн шившлэгээр шалган жинхэнэ гэдэгт нь түргэн итгэсэн юм. Энэ зүйл мэдээж үнэлэхийн аргагүй байлаа. Эмэгтэй түүнийг хичнээн үнэтэй болохыг төсөөлөхгүй биз. Арван галлеон өгөхөд баяртай авсан. Бидний хийж байсан хамгийн шилдэг наймаа байлаа!

Дамблдор суулгыг огцом сэгсрэхэд Карактак Бэрк ахин хуйлран эргэлдэж буй мөнгөлөг дурсамжын гүн рүү живлээ.

- Тэр түүнд ердөө арван галлеон өгсөн юм уу? гэж Харри зэвүүцэн асуув.
- Карактак Бэрк хэзээ ч өгөөмөр байгаагүй. Тэгэхээр бид Меропагийн хүүхэд төрөхийн урьд Лондонд ганцаар үлдээд мөнгө хэрэгтэй болсны улмаас түүнд байсан цорын ганц үнэт зүйл болох эцэг Марволоогоос үе дамжин ирсэн зүүлтийг зарсныг мэдлээ.
- Гэхдээ тэр илбэдэж чадна биз дээ! Тэр өөртөө хоол хүнс болон бусад хэрэгтэй зүйлсийг илбэдэн гаргаж чадах байсан! гэж Харри тэвчээргүйхэн хэлэв.
- Магадгүй чадах байсан. Гэхдээ энэ бол ахин нэг таавар бөгөөд хэрвээ би алдаагүй бол нөхөр нь түүнийг хаясны дараа Меропа ид шид хэрэглэхээ больжээ. Би түүнийг шидтэн байхыг хүсэхээ больсон гэж бодож байна. Эсвэл хайр цөхрөл түүний шидийн хүчийг барсан ч байж болох юм. Энэ тохиолддог. Гэхдээ ямар ч тохиолдолд Меропа шидэт саваагаа өөрийнхөө амьдралыг аврахын төлөө ч хэрэглээгүй гэдгийг чи харлаа.
- Тэр хүүгийнхээ төлөө ч амьд үлдэхийг хүсээгүй гэж үү? Дамблдор хөмсгөө өргөлөө.
- Чи лорд Волан-де-Мортын төлөө харамсаж байна уу?
- Үгүй гэж Харри түргэн хэлээд,
- Гэхдээ түүнд сонголт байсан биз дээ? Миний ээжийнхээс өөр ... гэв.
- Чиний ээжид ч гэсэн сонголт байсан гэж Дамблдор аяархан хэлээд,
- Тиймээ, Меропа Реддл хүүдээ хэрэгтэй байгаагаа үл харгалзан үхэхийг эрхэмлэсэн юм. Гэхдээ түүнийг ширүүнээр шүүх хэрэггүй, Харри. Тэр удаан хугацаанд зовж шаналсан бөгөөд хэзээ ч чиний ээж шиг зориг зүрхтэй байгаагүй. Харин одоо босоод нааш ир дээ ... гэв.
- Бид хаашаа явах юм бэ? гээд Харри босож Дамблдорын бичгийн ширээ рүү очлоо.
- Энэ удаад бид миний дурсамж руу орно. Би чамайг тэндээс хангалттай зүйлийг мэдэх байх гэж бодож байна. Чиний дараа, Харри.

Харри гүн ухааны цүнхээл рүү бөхийж хүйтэн мөнгөлөг шингэнд нүүрээ дүрээд ахин харанхуйд уналаа ... Хэдэн хормын дараа хөл дээрээ хатуу газар зогсоод нүдээ нээвэл Дамблдорын хамт хуучин загварын хөл үймээнтэй Лондонгийн гудамжинд зогсож байлаа.

- Харин энэ би байна гэж Дамблдор хөгжилтэй хэлээд урагшаа заахад өндөр дүрс зам хөндлөн гарч сүү зөөдөг морин тэрэгний урдуур өнгөрлөө.

Залуу Дамблдор урт шаргал үс мөн адил сахалтай байв. Тэр тэдний талын гудамж руу гараад замаар явахад хажуугаар нь өнгөрсөн хүмүүс өмссөн этгээд хийцтэй тансар хүрмийг нь сонирхон харлаа.

- Сайхан хүрэм байна, эрхэмээ гэж Харри тэсгэлгүй хэлэхэд Дамблдор инээвхийлээд өөрийгөө дагалаа.

Тэд залуу Дамблдороос хоцрохгүйг хичээн явж төмөр хаалгаар ороод баргар барилгыг хүрээлсэн өндөр хашаанд хүрлээ. Залуу Дамблдор довжоогоор өгсөж хаалга цохив. Хормын дараа нээгдэхэд хормогч өмссөн бохир охин зогсож байлаа.

- Өдрийн мэнд. Би хатагтай Коултай уулзахаар тохирсон юмсан. Хэрвээ эндүүрээгүй бол тэр эндхийн эрхлэгч байх аа?

- Өө, гэж эмэгтэй Дамблдорын өмссөн жигтэй хувцсанд гайхширч хэлээд,

- Хм ... жаахан хүлээгээрэй ... Хатагтай Коул! гэж мөрөн дээгүүрээ хандан хашгирав.

Түүний ард алсад хэн нэгэн хариу хашгирав. Эмэгтэй Дамблдор руу эргэлээ.

- Орно уу, тэр одоо таныг хүлээж байна.

Дамблдор хар цагаан хавтанцартай шалан дээгүүр явахад эндхийн байдал ядуу дорой ч гэсэн бүх зүйл өөгүй цэвэрхэн байв. Харри Дамблдорын хамт орлоо. Тэдний ард хаалга хаагдаж амжаагүй байтал үүдний өрөөнд түгшсэн шинжтэй туранхай эмэгтэй яаран ирэв. Түүний ширүүн царай сэтгэл зовохын зэрэгцээ өрөвдөх сэтгэлгүй өнгө тодролоо. Тэр явах зуураа өөр нэг хормогчтой эмэгтэйд үг хэлэв.

- ... йод аваад дээшээ Марта, Билли Стаббсын хамт оч. Эрик Уоллигийн шарх орны цагаан даавуундаа шүүрсэн байсан ...! гээд нүдний харц нь Дамблдор дээр тусмагц хөшсөн юм шиг зогсож анааш урдуур нь өнгөрсөн аятай гайхан мэлрэв.

Өдрийн мэнд гэж Дамблдор мэндлээд гараа сунгахад хатагтай Коул түүнийг амаа ангайн ширтлээ.

- Миний нэрийг Альбус Дамблдор гэдэг. Би уулзахыг хүссэн тухайгаа захидал илгээхэд та эелдэгээр намайг өнөөдөр ирэхийг урьсан юмсан.

Хатагтай Коул нүдээ цавчлаа. Тэр харваас Дамблдорыг хий юм үзэгдээгүй гэж шийдсэн бололтой сулхан хоолойгоор,

- Аан, тийм л дээ. Тийм тохиолдол ... тийм тохиолдол байсан ... та миний өрөөнд орсон нь дээр байх гэв.

Тэр Дамблдорыг зочны ч биш албаны ч биш жижигхэн өрөөнд дагуулж оров. Эндхийн бүх зүйл ядуу дорой агаад үүдний өрөөний адил тавилга хэрэгсэл нь элэгдэж хуучирчээ. Тэр Дамблдорыг яйжгий сандалд суухыг санал болгоод түгшсээр янз бүрийн цаас овоолсон бичгийн ширээний ард суулаа.

- Би таньд захиандаа Том Реддлийн ирээдүйн тухай ярилцахыг хүсч байгаа талаараа бичсэн гэж Дамблдор хэлэв.
- Та түүний хамаатан уу? гэж хатагтай Коул асуулаа.
- Үгүй, би багш. Би Томыг манай сургуульд сурахыг санал болгох гэсэн юм.
- Юу гэдэг сургууль юм?
- Түүнийг Хогвартс гэж нэрлэдэг.
- Та яагаад Томыг сонирхож байгаа юм?
- Бид түүнд манайд сурах боломж байгаа гэж үзэж байгаа.
- Түүнд тэтгэлэг олдоно гэж хэлэх гээ юу? Тэр яаж чадах юм бэ? Тэр хэзээ ч хаашаа ч орж чадахгүй.
- Гэхдээ түүнийг төрмөгц манай сургуульд бүртгэж авсан.
- Хэн түүнийг бүртгүүлсэн юм? Эцэг эх нь үү?

Хатагтай Коул эргэлзээгүй хатуу ширүүн эмэгтэй байлаа. Дамблдор ч бас тэгж бодов бололтой халааснаасаа шидэт саваагаа чимээгүйхэн гаргаж ирээд ширээн дээр байгаа цэвэр цаас руу дохилоо.

- Энэ гээд Дамблдор саваагаа далласанаа цаасыг хатагтай Коулд өглөө. Одоо таньд бүх зүйл ойлгомжтой болно гэж бодож байна.

Хатагтай Коул цаас руу харав. Түүний нүд эргэлдсэнээ агшин зуур ахин байрандаа оров.

- Харваас бүх зүйл хэвийн бололтой гээд Дамблдорт цаасыг буцаан өглөө. Тэгснээ түүний харц хормын өмнө энд байгаагүй жин дарстай лонх хоёр шилэн аяган дээр тусаж,
- Э-э ... магадгүй таньд аяга уух юм санал болгож болох уу? гэв.
- Маш их баярлалаа гээд Дамблдор таатай инээмсэглэв.

Төдхөн хатагтай Коул жин дарс уухын хувьд шинэхэн хүн биш гэдэг нь тодорхой болов. Тэр дарсыг шилэн аяга руу өгөөмөр тонгойлгоод өөрийнхийгөө ганцхан балгалтаар дуусгалаа. Тэгээд ичиж зоволгүй уруулаа амталмагц Дамблдор руу анх удаагаа инээмсэглэв.

- Та надад Том Реддлын тухай ярьж өгөхгүй юу? Тэр энд асрамжын газар төрсөн байх аа?
- Яг тийм гээд хатагтай Коул өөртөө ахин дарс дүүргэж,
- Би тэгэхэд ажилд ороод удаагүй байсан болохоор энэ тухай сайн санаж байна.

Шинэ жилийн өмнөх аймшигтай хүйтэн орой цас орж байлаа. Хар дарсан шөнө байсан даа. Тэгтэл надаас арай эгчмэд охин довжоо өгсөн ирэхдээ хөл

дээрээ арай ядан тогтож байсан. Тэр эхнийх нь ч биш сүүлчийнх нь ч биш байлаа. Бид түүнийг оруулаад цагийн дараа төрж хүүхэд гаргасан юм. Тэгээд цагийн дараа үхсэн дээ.

Хатагтай Коул сэтгэл хөдөлсөн янзтай толгой дохиод дарснаасаа ахин балгалаа.

- Тэр үхэхийнхээ өмнө ямар нэг зүйл хэлсэн үү? Жишээлбэл хүүхдийнхээ эцгийн тухай ч юм уу?

Хатагтай Коул дарсны аагинд сэтгэл хангалуун болж ирээд,

- Хэлсэн шиг санагдаж байна. Би түүний «тэр аавтайгаа төстэй болно гэж найдаж байна» гэснийг санаж байна. Үнэнийг хэлэхэд түүний найдсан нь зүйтэй байсан юм яагаад гэвэл тэр өөрөө царай муутай байсан юм. Харин дараа нь түүнд эцгийг нь хүндэтгэж Том Марвало гэсэн нэр өгөөрэй гэсэн. Хачирхалтай нэр байгаа биз тийм үү? Бид түүнийг циркээс ирсэн юм болов уу гэж бодсон. Харин тэр хүүгийн овгийг Реддл гэж хэлсэн. Тэгээд л өнгөрсөн дөө ахиж нэг ч үг хэлээгүй.

- Бид түүнийг гуйсан ёсоор нэрлэсэн. Хөөрхий амьтанд харваас энэ их чухал байсан юм. Гэхдээ Том Марвалог ямар ч Реддл асууж ирээгүй болохоор асрах газар үлдээд одоо хүртэл энд байгаа.

Хатагтай Коул сэтгэл самуурсан байдалтай ахин нэг хийж авлаа. Түүний шанаанд хоёр ягаан толбо гарч иржээ. Тэгснээ,

- Хачирхалтай хүү байгаа юм гэв.

- Тиймээ. Би ч гэсэн тэгж бодож байна гэж Дамблдор хэлэв.

- Бага байхдаа ч хачирхалтай байсан. Бараг хэзээ ч уйлдаггүй байсныг мэдэх үү. Харин өсөж том болоод ... этгээд болсон.

- Ямар утгаар тэр вэ?

- Тэр ...

Тэгээд хатагтай Коул түгдэрснээ бүүдгэртсэн Дамблдор руу дарсан дээгүүр харлаа.

- Түүнд танай сургуульд байр байгаа гэж бодож байна уу?

- Энэ ч тодорхой.

- Бас юу ч хэлсэн өөрчлөгдөхгүй гэж хэлсэн үү?

- Өөрчлөгдөхгүй гэж Дамблдор батлав.

- Ямар ч тохиолдолд түүнийг аваачих уу?

- Ямар ч тохиолдолд.

Тэр нүдээ хяламхийн итгэх эсэхээ бодож буй бололтой. Тэгснээ тэгсэн нь дээр гэж бодов бололтой гэнэтхэн,

- Тэр бусад хүүхдүүдийг айлгадаг гэлээ.

- Та тэднийг дээрэлхдэг гэж хэлэхийг хүсээ юу? Айлгадаг гэнээ?



- Тиймээ тэр тэгдэг. Түүнийг барьж байхад маш хэцүү. Янз бүрийн тохиолдол байсан ... Тийм ч сайнгүй гэж хатагтай Коул хөмсөг зангидан хэлэв.

Дамблдор түүнээс энэ талаар асуусангүй ч Харри түүний сонирхож байгааг харлаа. Тэр ахин балгаад хацар нь улайж,

- Билли Стаббс туулайтай байсан ... Том мэдээж үүнийг хийгээгүй гэж хэлсэн ч түүнийг байшингийн нуруунаас яаж өлгөснийг би төсөөлөхгүй байна ... Туулай мэдээж өөрөө өлгөгдөхгүй биз дээ? гэв.

- Тийм байх гэж Дамблдор аяархан хэлэв.

- Ямар аргаар хийсэн нь ухаанд ч хүрэхгүй юм. Би ганцхан зүйлийг л мэдэж байна өмнө нь Билли тэр хоёр маргалдсан байсан бас гээд хатагтай Коул ахин дарс балгахдаа эрүү рүүгээ гоожуулчихлаа,

- Бид зун зугаалахад ... тэднийг гадагш гаргахад ... та ойлгож байгаа биз дээ жилд нэг удаа хөдөө юмуу тэнгисийн эрэг рүү зугаалдаг юм ... Тэгэхэд Эми Бенсон, Деннис Бишоп хоёр нэг л биш болчихсон байсан. Бид түүнээс асуухад Том Реддлтэй хадан дээр очсон гэсэн. Тэр зөвхөн орчин тойрноо үзсэн гэж ам алдсан ч тэнд ямар нэг зүйл болсон гэдэгт би итгэлтэй байгаа! Энэ мэтчилэн янз бүрийн хачирхалтай явдал болдог юм ...

Тэр ахин Дамблдор руу харахад хацар нь улайсан ч харц нь тодхон байлаа.

- Би түүнийг эндээс явбал тийм ч олон хүн санана гэж бодохгүй байна.

- Та бид түүнийг байнга авч чадахгүй гэдгийг ойлгосон байх гэж найдаж байна? Тэр энд зун болгон эргэн ирж байх юм.

- За яахав, үүнд чинь баярлалаа. Энэ ч зэвтэй шилээгүүрээр цохьсоноос дээр байна шүү гээд хатагтай Коул үл мэдэг зогисуулав. Түүнийг босоход Харри лонхны гуравны хоёрыг уусан хэр нь хөл дээрээ тогтож байгаа явдалд биширлээ.

- Би таныг түүнтэй уулзахыг хүсч байна гэж ойлголоо?

- Маш их гээд Дамблдор бас бослоо.

Хатагтай Коул өрөөнөөс гараад чулуун шатаар өгсөх зуураа хүмүүжигч хүүхдүүд дэргэдүүр нь өнгөрөхөд сануулга заавар өгч байлаа. Асрамжын газрын хүүхдүүд ижилхэн саарал хүрэм өмсдөг ажээ. Тэд энэ уйтгартай газар өссөнөө үл харгалзан сэргэлэн ухаалаг харагдана.

- Ирлээ гээд хатагтай Коул шатны хоёр дахь талбай дээр урт хонгилын эхний хаалганы өмнө зогсов. Тэр хаалга цохилоо.

- Том чам дээр зочин ирлээ. Энэ бол ноён Дамбертон ... өршөөнө үү, Дандербор. Тэр чамд хэлэхээр ... ер нь бол тэр өөрөө чамд хэлэх байх.

Харри хоёр Дамблдорын хамт өрөөнд ороход хатагтай Коул хаалга хаалаа. Энэ нь хуучин хувцасны шүүгээ төмөр орноос ондоо тавилгагүй жижигхэн өрөө байв. Орон дээр саарал хувцастай хүү өвдгөө нугалан суугаад гартаа ном барьжээ.

Том Реддлын царайд Мраксын гэр бүлийн ямар ч шинж тэмдэг байсангүй. Метропагийн үхэхийн өмнө хүсэж байснаар хүү царайлаг эцгийнхээ хуулбар байлаа. Арван нэгэн настай гэхэд өндөр хар үстэй, цонхигор царайтай аж. Тэр Дамблдорын жигтэй төрхийг хараад цэгнэн нүдээ нарийсгалаа. Хормын турш чимээгүй болов.

- Сайн уу, Том? гээд Дамблдор гараа сунган урагш алхлаа.

Хүү тээнэглэсэнээ гар барив. Дамблдор орны хажууд модон сандал дөхүүлэн суухад эмнэлэгт өвчтөн дээр ирсэн зочин шиг харагдав.

- Би профессор Дамблдор.

- Профессор гэнээ? хэмээн Реддл давтан асуугаад түгшсэн янзтай болж,

- Энэ чинь эмч гэсэн үг үү? Та яах гэж ирээ вэ? Тэр таныг намайг үзүүлэхээр уриа юу? гэв.

Тэр хатагтай Коулын саяхан алга болсон хаалганы зүг дохив.

- Үгүй, үгүй гээд Дамблдор инээмсэглэв.

- Би таньд итгэхгүй байна. Тэр намайг үзэхийг хүссэн үү? Үнэнийг хэл!

Тэр сүүлчийн хоёр үгээ захирангуй хэлсэн учир Харри бараг цочирдлоо. Энэ нь яг л түүний хар мянган удаа өгч байсан тушаал шиг сонсогдлоо. Дамблдор эелдэгээр үргэлжлүүлэн инээмсэглэхэд Реддлийн нүд томров. Хэдэн секундэн дараа Реддл Дамблдор руу ууртай ширтэхээ болиод болгоомжлон харлаа.

- Та хэн бэ?

- Би хэдийн хэлсэн. Намайг профессор Дамблдор гэдэг. Хогвартс гэдэг сургуульд ажилладаг юм. Би ийшээ чамайг манай сургуульд орохыг санал болгох гэж ирсэн. Хэрвээ явах дуртай байвал чиний шинэ сургууль чинь.

Реддлийн хариу үйлдэл санаанд оромгүй байлаа. Тэр орноосоо үсрэн босоод Дамблдор руу хилэгнэн ширтэв.

- Та намайг мэхэлж чадахгүй! Та галзуугийн эмнэлэгээс ирсэн, тийм үү?

Профессор гэл үү, өө тэгэлгүй яахав дээ ... Би хаашаа ч явахгүй ойлгомжтой юу? Энэ хөгшин муурыг өөрийг нь аваачих хэрэгтэй! Би Эми Бенсон, Деннис Бишоп хоёрт хэзээ ч юу ч хийгээгүй. Тэднээс асуувал өөрсдөө таньд хэлэх болно!

- Би галзуугийн эмнэлэгээс ирээгүй гэж Дамблдор тэвчээртэй хэлээд,

- Би багш. Хэрвээ чи тайвшираад суувал Хогвартсын тухай ярьж өгье. Хэн ч тэнд чамайг өөрөө хүсэхгүй бол сургахгүй ... гэв.

- Оролдоод үз л дээ! гэж Реддл уруулаа үрчийлгэв.

- Хогвартс бол гэж Дамблдор Реддлийн сүүлийн үгийг сонсоогүй аятай үргэлжлүүлээд,

- Онцгой авъяастай хүүхдүүдийн сургууль юм ... гэлээ.

- Би галзуу биш!

- Би чамайг галзуу биш гэдгийг мэдэж байна. Хогвартс бол галзуу хүүхдүүдийн сургууль биш. Энэ бол ид шидийн сургууль.

Нам гүм болов. Реддл байрандаа хөшжээ. Түүний царай ямар ч хувиралгүй байлаа. Тэр урагшаа Дамблдор руу хараад худал хэлсэн эсэхийг нь ойлгохыг хичээв.

- Ид шидийн гэнээ? хэмээн шивнэн давтлаа.

- Яг тийм гэж Дамблдор хэлэв.

- Энэ шид гэдгээр чинь ... би юу хийж чадах юм бэ?

- Чи юу хийж чаддаг гэж?

- Янз бүр гээд Реддлийн амьсгаа давхцав. Тэр сэтгэл хөөрсөндөө хүзүүнээсээ дээш царай нь улайлаа.

- Эд зүйлсийг хүрэхгүй хөдөлгөж чадна. Амьд амьтныг ч гэсэн сургалгүйгээр.

Хэрвээ хэн нэгэн намайг уурлуулвал түүнд муу зүйл хийж чадна. Хүсвэл хүмүүсийг өвтгөж чадна.

Түүний хөл чичирлээ. Тэр орон дээрээ ахин суугаад гар луугаа ширтэн толгойгоо унжуулав.

- Би өөр гэдгээ мэднэ гэж чичирсэн гарандаа хандан хэлээд,

- Би онцгой гэдгээ мэднэ. Үргэлж өөртөө ямар нэг юм байгаа гэдгийг мэддэг байсан гэв.

- Чиний бүрэн зөв гээд Дамблдр инээмсэглэлгүй Реддл рүү анхааралтай харлаа.

- Чи бол шидтэн.

Реддл толгойгоо өргөлөө. Түүний царай өөрчлөгдөв. Одоо хязгааргүй баяр хөөр түүний царайг нь сайхан харагдуулахын оронд эсрэгээрээ зэрлэг араатных шиг болгов.

- Та ч гэсэн шидтэн үү?

- Тиймээ.

- Үүнийгээ батал! гэж Реддл «Үнэнийг хэл» гэж хэлсэнтэйгээ адил захирангуй өнгөөр давтлаа.

Дамблдор хөмсгөө өргөв.

- Хэрвээ чи Хогварстад элсэхийг зөвшөөрч байгаа бол ...

- Мэдээж, зөвшөөрч байна!

- Тэгвэл чи надтай «профессор» юмуу «ноёнтоон» гэж хандах ёстой.

Энэ богинохон нэг агшины турш Реддлийн царай хэрцгий болсноо санаанд оромгүй эелдэг дуугаар,

- Намайг уучлаарай, ноёнтоон. Би профессор таныг надад юм үзүүлэхгүй юу гэж хэлэх гэсэн юм ...? гэв.

Харри Дамблдор татгалзана гэдэгт итгэлтэй байлаа. Реддл Хогвартсад үзэх хангалттай цаг байгаа тэгээд ч тэд маглууд дүүрэн байшинд байгаа болохоор болгоомжтой байх ёстой байлаа. Гэхдээ түүний гайхлыг төрүүлэн Дамблдор халааснаасаа шидэт саваа гаргаж ирээд хуучин шүүгээ рүү чиглүүлэн хайхрамжгүй зангав.

Шүүгээ шатлаа.

Реддл хөл дээрээ үсрэн босов. Харри түүний бүх зүйл шүүгээн дотор байсан учир цочирдож уурласандаа дуу алдсаныг буруутгаж чадсангүй. Тэрбээр Дамблдор руу эргэх агшинд дөл унтарч шүүгээ огт хүрээгүй мэт болов.

Реддл шүүгээ рүү ширтсэнээ дараа нь Дамблдор руу харахад шуналтай харц нь шидэт саваан дээр тусав.

- Би хэзээ иймийг авах юм бэ?

- Хүссэн үедээ ... минийхээр бол чиний шүүгээн дотроос ямар нэг зүйл гарах гэж оролдож байх шиг байна.

Тэгтэл үнэхээр шүүгээн дотор сулхан таржигнах чимээ сонсогдов. Анхны удаагаа

Реддлийн царайд айдас тодорлоо.

- Хаалгыг нь онгойлго гэж Дамблдор хэлэв.

Реддл тээнэгэлзсэнээ өрөөн дундуур явж шүүгээний хаалгыг онгойлголоо. Элэгдсэн хэдэн хүрмийн дээрх хамгийн дээд тавиур дээр жижигхэн цаасан хайрцаг байлаа. Тэр дотор нь хулгана хийсэн мэт чичирэх аж.

- Түүнийг гарга.

Реддл болгоомжлон чичирсэн хайрцагыг авлаа.

- Түүн дотор чамд хамааралгүй ямар нэг зүйл байна уу? Реддл Дамблдор уруу удтал тооцоолон харснаа,

- Тиймээ, ноёнтоон гэж эцэст нь юу ч илэрхийлэхгүй хоолойгоор хэлэв.

- Онгойлго гэж Дамблдор хэлэв.

Реддл тагийг сөхөөд харалгүйгээр хайрцагыг ор луу сэгсэрлээ. Харри ямар нэг гайхамшигтай юм харахыг хүлээсэн авч хамгийн жирийн зүйлс болох йо-йо тоглоом, мөнгөн хуруувч, өнгөө алдсан аман хуур гарлаа. Тэдгээр зүйлс хайрцагнаас гараад хөдлөхөө больж хөдөлгөөнгүй хэвтэв.

- Чи тэднийг эздэд нь эргүүлж өгөөд уучлал гуй гэж Дамблдор тайван хэлээд шидэт саваагаа хантаазныхаа халаасанд хийлээ.

- Чамайг үүнийг хийсэн эсэхийг би мэдэх болно. Бас анхааруулахад Хогвартсад хулгайчыг тэвчиж чаддаггүй юм.

Реддл огтхон ч ичсэнгүй Дамблдор руу хүйтнээр харсаар байлаа. Эцэст нь өнгөгүй хоолойгоор,

- Тиймээ, ноёнтоон гэлээ.

- Хогвартсад зөвхөн шид хэрэглэхэд сурдаггүй түүнийг хяналтанд байлгаж сурдаг юм. Чамайг санамсаргүй тэгсэн гэдэгт итгэлтэй байгаа ч манай сургуульд ийм аргаар авъяасаа гаргаж болохгүй. Чи ид шид хэрэглэж чаддаг анхны хүн биш. Чамайг ингэсний төлөө ид шидийн яам Хогвартсаас хөөж ч болно. Тиймээ, тэнд яам байдаг юм дүрэм зөрчигсдийг хатуу шийтгэдэг. Шидтэн болж манай ертөнцөд алхан орж буй хүн бүр хуулийг сахих үүрэгтэй.

- Тиймээ, ноёнтоон гэж Реддл давтлаа.

Түүний юу бодож байгааг тааварлах араггүй байв. Тэр царайдаа юу ч илэрхийлэлгүй хулгайлсан зүйлсээ хайрцагт буцаан хийлээ. Үүнийгээ дуусгаад Дамблдор руу эргэж шуудхан,

- Надад мөнгө байхгүй гэв.

- Үүний учрыг амархан олж болно гээд Дамблдор халааснаасаа арьсан хүүдийтэй мөнгө гаргаж ирэв.

- Хогвартсад өөрсдөө сурах бичиг болон дүрэмт хувцас худалдаж авч чадахгүй сурагчдад зориулсан албан ёсны хуримтлал байдаг юм. Чи магадгүй шившлэгийн ном болон бусад зүйлсийг хуучныг худалдаж авах ...

- Шившлэгийн ном хаана зардаг юм бэ? гэж Реддл яриаг нь таслан асуулаа.

Тэр хүнд хүүдийтэй мөнгийг талархалгүй аваад алтыг цэгнэн харав.

- Тахир гудамжинд. Би чамд бүхнийг олоход туслах ...

- Та надтай хамт явах юм уу? гэж Реддл харцаа өргөн асуулаа.

- Эргэлзээгүй хэрвээ чи ...

- Хэрэггүй. Би бүх зүйлээ өөрөө хийж дассан болохоор Лондон руу ганцаар явах болно. Харин энэ Тахир гудамжыг хаанаас олох вэ ... ноёнтоон? гэж нэмэрлээд Дамблдор руу харав.

Харри Дамблдорыг Реддлтэй хамт явахаар зүтгэх байх гэж бодсон ч алджээ. Дамблдор Реддлд чухал шаардлагатай зүйлсийн жагсаалттай дугтуй өгөөд асрамжын газраас «Цоорхой тогоо»-нд хүрэх замыг зааж дараа нь,

- Чи маглуудын харж чадахгүй баарыг харах юм. Шидтэн бус хүмүүс түүнийг харж чадахгүй. Үйлчлэгч Томыг асуугаарай. Энэ нэрийг тогтооход хялбархан чамтай адилхан учир ...

Реддл салж өгдөггүй яршигтай ялааг хөөх мэт уурсан агзасхийлээ.

- Чамд Том гэсэн нэр таалагддаггүй юм уу?

- Хэтэрхий олон Том гэж Реддл бувтналаа. Тэгснээ гэнэтхэн асуулт асуух хүслээ дарж ядан,

- Миний эцэг бас шидтэн байсан уу? Надад түүнийг бас Том Реддл гэдэг гэж хэлсэн гэв.

- Харамсалтай нь би үүнийг мэдэхгүй гэж айж байна хэмээн Дамблдор аяархан хэлэв.

- Миний ээж шидтэн байж чадахгүй. Тэр үхсэн гэж Реддл Дамблдороос илүү өөртөө хандан хэлээд,

- Тэгэхээр тэр байх ёстой. Ингэхэд би хэрэгтэй бүх зүйлийг худалдан авсны дараа Хогвартс руу яаж явах вэ? гэв.

- Дугтуйнд бүх зүйлийг нарийвчлан бичсэн хоёр дахь цаас байгаа. Чи Кингс Кросс буудлаас есөн сарын нэгэнд явна. Тэнд бас галт тэрэгний тасалбар байгаа.

Реддл толгой дохив. Дамблдор босож ахин гараа сунгалаа. Реддл түүнийг бариад,

- Би могойн хэлээр ярьж чаддаг. Би үүнийг гадуур аялах үедээ мэдсэн юм. Тэд өөрсдөө над руу гулган ирээд исгэрэн ярьдаг. Энэ шидтэнгүүдийн хувьд ердийн зүйл үү? гэв.

Харри түүнийг хамгийн хачирхалтай авьяасаа сэтгэгдэл төрүүлэхийн тулд сүүлд хэлснийг ойлголоо.

- Үгүй ердийн бус гэж Дамблдор хэсэг дуугүй байсны дараа хэлээд,

- Гэхдээ энэ тохиолддог юм гэв.

Тэр хайхрамжгүй хэлсэн ч Реддлийн царай руу сонирхон харлаа. Тэд хормын турш бие биеэ ширтэн зогсов. Дараа нь гараа тавиад Дамблдор хаалгаар гарлаа.

- Баяртай Том Хогвартсад уулзацгаая.

- Би үүнийг хангалттай гэж бодож байна хэмээн Харрийн хажууд зогсож байсан буурал үстэй Дамблдор хэлэв.

Дараагийн агшинд тэр Харрийн хамт дээш харанхуйд хөөрч өнөөгийн өрөөнд газардав.

- Суу гэж Дамблдор Харрийн дэргэд буугаад хэлэв.

Тэр харсан зүйлдээ бүрэн автсан болохоор хүлцэнгүй дагалдав.

- Та түүнийг шидтэн гэж хэлэхэд надаас хурдан итгэлээ шүү. Би эхлээд Хагридад итгээгүй.

- Тиймээ, Реддл түүнийг онцгой гэж хэлсэн хэнд ч итгэхэд бэлэн байсан юм.

- Харин та тэгэхэд мэдсэн үү?

- Миний өмнө бүх цаг үеийн хамгийн аюултай хар шидтэн байна гэж үү? Үгүй ээ, би түүнийг том болтол ойлгоогүй. Гэхдээ тэр эргэлзээгүй миний анхаарлыг татсан. Би Хогвартсад эргэж ирээд түүнийг найз нөхөдгүй ганцаараа байхыг ажигласан.

- Чи түүний авьяас тийм залуу шидтэн гэхэд гайхалтай хүчтэй хөгжсөнийг сонссон. Сонирхолтой нь гэвэл илүү аюултай тал руугаа. Тэр хэдийн өөрийн боломжоо хянаж ухамсартайгаар ашиглан сурсан байсан. Бас чи түүнийг ихэнхи

залуу шидтэнгүүд шиг замбараагүй хэрэглэдэггүй болохыг харлаа шүү дээ. Тэр хэдийн шидийг эргэн тойрныхоо эсрэг хэрэглэн сурч түүний тусламжтай хүмүүсийг айлган, шийтгэж, хянаж байсан. Дүүжлүүлсэн жижигхэн туулайны болон охид хөвгүүдийн түүхийн хувьд тэр хад руу хуурч авчирчээ ... хэрвээ би хүсвэл хүмүүсийг өвтгөж чадна.

- Бас тэр могойн хэл ойлгодог гэж Харри хэлэв.

- Тиймээ, үнэхээр тийм. Энэ ховор тохиолдох авьяас түүнийг хар урлагтай холбож байсан ч бид сайхан сэтгэлтэй шидтэнгүүдийн хувьд бас могойн хэл мэддэг тохиолдол гардагийг мэднэ. Үнэн хэрэгтээ түүний могойтой ярьдаг авьяасаас илүү хэрцгий, нууцлаг, эзэрхэг байдал нь миний сэтгэлийг зовоож байсан юм.

- Цаг хугацаа үргэлж биднийг мэхэлдэг гээд Дамблдор цонхны цаадахь харанхуй тэнгэр рүү зааснаа,

- Гэхдээ биднийг салахаас өмнө би чиний анхаарлыг саяын харсан үйл явдлын тодорхой агшинд чиглүүлэхийг хүсч байна. Тэд бидний дараагийн хичээлтэй шууд холбоотой юм гэлээ.

- Нэгдүгээрт чи Реддл «Том» гэсэн нэрийг нь хэлэхэд хэрхэн хүлээж авч байгааг харсан байх.

Харри толгой дохив.

- Тэр өөрийн жигшил зэвүүцлээ ойр дотныхоо хүмүүст үзүүлдэг нь түүний хувьд ердийн зүйл юм. Тэр үед л бусдаас өөр, ялгаатай алдартай болохыг хүсэж байсан хэрэг. Чи түүнийг энэ ярианаас хойш ердөө хэдэн жилийн дараа өөрийн нэрнээсээ үүрд татгалзаж Волан-де-Морт гэдэг нэрэн дор нуугдах болсныг мэдэж байгаа.

- Чамайг Том Реддлийн биеэ даасан, хаалттай, найз нөхөдгүй талыг ажигласан байх гэж бодож байна. Түүнд тусламж хэрэггүй, Тахир гудамжин дахь аялалд нь дагалдагч хэрэггүй байсан. Тэр ганцаараа хийхийг эрхэмлэж байсан. Насанд хүрсэн Волан-де-Морт яг иймээрээ үлдсэн. Олон Үхэл залгигч нар түүний итгэлийг олон ойртож түүнийг ойлгож байна гэж боддог. Тэд гүнзгий төөрөлдөж байгаа юм. Лорд Волан-де-Мортод хэзээ ч найз байгаагүй. Би түүнд найзууд хэрэггүй гэж бодож байна.

- Ингээд хамгийн сүүлд ... Харри чамайг нойрмоглохгүй анхааралтай сонсоно гэж найдаж байна. Том Реддл хүүхэд байхдаа олз цуглуулах дуртай байсан. Чи түүнийг хулгайлсан зүйлсээ өрөөндөө хайрцагт нуусан байхыг харсан. Тэр

хохирогч нараасаа жижигхэн бэлэг дурсгал ч гэж хэлж болмоор зүйлийг авдаг зуршилтай байсан. Энэ алаг шаазгай шиг онцгой авирыг санаж аваарай. Тэр бидэнд цаашид их чухал байх болно ...

- Харин одоо явж унтах цаг чинь болж.

Харри бослоо. Тэр өрөөнөөс гарах замдаа замдаа өнгөрсөн удаа Марвалогийн бөгж байсан ширээ рүү харав. Бөгж тэнд байсангүй.

- За, Харри? гэж Дамблдор түүний зогсохыг хараад хэлэв.
- Бөгж алга болчихож гээд Харри эргэн тойрноо харлаа.
- Гэхдээ би таньд аман хуур юмуу өөр ямар нэг зүйл байгаа гэж бодож байна ... Дамблдор инээмсэглээд түүн рүү шилнийхээ цаанаас харлаа.
- Маш ажигч байна, Харри гэвч аман хуур бол ердийн аман хуур шүү дээ. Тэр энэ нууцлаг үгийнхээ дараа гараа зангахад Харри явах болсноо ойлголоо.



## БҮЛЭГ 14: ФЕЛИКС ФЕЛИЦИС

Маргааш өглөө нь Харрийн эхний хичээл ургамал судлал байлаа. Тэр өглөөний цайн дээр Рон, Гермиона хоёрт Дамблдортой хийсэн өчигдөрийн хичээлийн тухай ярьсангүй, хүн сонсохоос эмээлээ. Харин дараа нь хүлэмж рүү явах замдаа бүгдийг ярив. Амралтын өдрийн турш шуурсан салхи эцэст нь нам гүм болоод нууцлаг манан суунаглаж хэрэгтэй хүлэмжээ олоход саад болов.

- Хөөх Хэцүү нэрт хүүхэд байхдаа ямар байж вэ гэдгийг мэдэх ямар аймшигтай хэрэг вэ! гэж Рон аяархан хэлэв. Гурван найз булцуутай хожуул тойроод хамгаалалтын бээлийгээ өмслөө. Гэхдээ Дамблдор яагаад чамд янз бүрийн зүйл үзүүлж байгаа нь ойлгомжгүй юм. Энэ бүхэн их сонирхолтой ч цаашид ямар хэрэгтэй юм бол?

- Мэдэхгүй гээд Харри амны хамгаалалт зүүлээ. Тэр энэ хичээл их чухал бөгөөд намайг амьд үлдэхэд туслана гэсэн.

- Харин минийхээр бол маш сонирхолтой байна гэж Гермиона дуу алдаад,

- Волан-де-Мортын тухай ихийг мэдэх нь зүйтэй шүү дээ. Чи тэгээд түүний сул талыг олов уу? гэв.

- Өнгөрсөн удаагийн Слизнортын үдэш ямар болсон бэ? гэж Харри түүнээс амны зузаан хамгаалалтынхаа цаанаас асуулаа.

- Өө, маш хөгжилтэй болсон гээд Гермиона хамгаалалтын бээлийгээ өмслөө.

- Тэр ердийнхөөрөө алдартай сурагчдынхаа тухай ярьж, Маклаггеныг сайн холбоотойн төлөө долигонон, биднийг янз бүрийн амттанаар зочилж, Гвеног Жонсыг танилцуулсан.

- Гвеног Жонс гэнээ? «Холихедский Гарпий» багийн ахмад уу? гээд Роны нүд хамгаалалтын шилэн дороо томорлоо.

- Яг тийм гэж Гермиона батлаад,

- Надад тэр жаахан ихэрхэг санагдсан ... гэв.

- Алив яриагаа больцгоо! гэж тэдний дэргэд ирсэн профессор Стебль ширүүн хэллээ. Бүгд ажилдаа орсон байхад та нар хоцорч байна шүү. Невилл хэдийн анхны буурцагаа хураагаад байна!

Найзууд эргэн тойрноо харлаа. Тэгтэл ч үнэхээр Невиллийн уруул язарч нүүрэндээ хэд маажуулсан бөгөөд гартаа таагүй лугших зүржийн хэмжээтэй ногоон зүйл барьжээ.

- Ойлголоо, профессор одоохон эхэллээ! гэж Рон хэлснээ түүнийг эргэмэгц нам дуугаар,

- Харри, бид Дүлийрүүлэх шившлэг ашиглах хэрэгтэй байх гэв.

- Үгүй, хэрэггүй! гэж Гермиона эрлийз хунтайжын зохиосон шившлэгийг ашиглахад үргэлж аймшигтай уурсадагаараа хэлээд,

- За болно, ярьж боллоо. Ажилдаа оръё гэв.

Тэр Рон, Харри руу цөхрөнгүй хараад гурвуул гүнзгий санаа алдсанаа тахир хожуул руу дайралтанд оров.

Хожуул даруй амь орж өргөстэй урт мөчирнүүд гарч ирснээ агаар исгэрүүлгэн оролгов. Нэг үзүүр нь Гермionaгийн үснээс зуурахад Рон түүнийг хайчаар хайчилав. Харри амжилттайгаар хоёр мөчир барьж аваад хооронд нь зангидлаа. Тэмтрүүл шиг мөчрүүдийн дундаас нүхний амсар нээгдэв. Гермiona тийшээ зоригтойгоор гараа шургуулахад амсар нь хаагдан тохойг нь хавчлаа. Харри, Рон хоёр бүх хүчээ гарган мөчрийг угзрахад нүхний ам ахин нээгдэж тэр гараа гарган авахдаа хуруундаа Невиллийн адил буурцаг барин гарч ирлээ. Өргөстэй мөчир ахин хожуулийн дотогш орж гэмгүйхэн өмхөрсөн тайрдас болов.

- Юу гэдгийг нь мэдэх үү? Хэрвээ надад хувийн цэцэрлэг байх юм бол хэзээ ч ийм зүйл тарихгүй гээд Рон хамгаалалтын шилээ аваад духныхаа хөлсийг арчлаа.

- Алив тавгаа нааш нь өг гэж лугшсан буурцаг гартаа барьсан Гермiona гуйлаа.

Харри тавгаа өгөхөд жигшсэн байртай буурцгыг хаяв.

- Ёсорхох хэрэггүй шүү! Шинэхэн дээр нь шүүсийг нь шахах хамгийн сайн байдаг юм! гэж хүлэмжний нөгөө өнцгөөс профессор Стебль хашгирав.

- Тэгээд ч гээд Гермiona сарнисан яриагаа эргэн үргэлжлүүлэв.

- Слизнорт зул сарын үдэшлэг зохиох гэж байгаа. Харри энэ удаад чамд ямар ч бултах боломж байхгүй. Тэр надаас чиний хуваарийг өгөхийг гуйгаад үдэшлэгтээ заавал ирэхээр болгосон.

Харри дуу алдан ёолов. Рон энэ агшинд буурцгыг тавган дээр бяц шахахын тулд хоёр гараараа дараад хорсолтойгоор,

- Ахиад л Слизнортын хайртай сурагчдын бас нэг үдэшлэг үү? гэв.

- Тиймээ зөвхөн Слизнейн кулбын гишүүдэд гэж Гермiona хэллээ.

Буурцаг Роны гаран дороос мултараад дээшээ хөөрч хүлэмжийн шилэн дээвэр цохиод профессор Стеблийн хуучин нөхөөстэй малгайг дэлсэн уналаа. Харри түүний араас ухасхийн эргүүлэн авч ирэхэд Гермionaгийн,

- Сонсооч би Слизнейн клуб гэсэн нэр бодож олоогүй гэх дуулдав ...

- Слизнейн клуб гэж Рон давтаад уруулаа үрчийлгэн Малфой шиг шоолонгуй инээд алдав.

- Шал дэмий юм. Чамд үдэшлэг таалагдана байх гэж найдна. Чи тэнд Маклагненыг яагаад уургалж болохгүй гэж тэгвэл Слизнорт та хоёрыг Слизнейн хаан хатнаар зарлах байх ...

- Бидэнд өөрсөдтэйгээ зочин урихыг зөвшөөрсөн гээд Гермionaгийн хацар улайлаа. Би чамаас асуухыг хүссэн ч хэрвээ энэ чамд тийм тэнэг байгаа бол төвөг удахыг хүсэхгүй байна!

Харри гэнэтхэн өргөст хэмх арай хол нисээгүйд харамслаа тэгсэн бол одоо энэ хоёртой сууж байхгүй байсан. Тэдэнд анхаарал хандуулахгүйг хичээн тавган дээр үсчих буурцгыг бариад бүх хүчээ гарган дарахдаа аль болох их чимээ шуугиан гаргасан ч өмнөхийн адил үг бүрийг нь сонсож байв.

- Чи намайг урихыг хүсээ юу? гэж Рон шал өөр хоолойгоор асуулаа.
- Тиймээ! гэж Гермиона уурсан хариулаад,
- Гэхдээ чи намайг Маклаггеныг уургалахыг хүсч байгаа бол ч ... гэв.

Нам гүм болов. Харри өргөст хэмхээ бяцхан хүрзний тусламжтай шүүсийг нь шахахыг оролдлоо.

- Үгүй, би үүнийг хүсэхгүй байна гэж Рон аяархан хэлэв. Харри өргөст хэмхээ алдаад тавгийг хагартал цохьчихлоо.

- Репаро гэж тэр яаран хэлээд саваагаа хэлтэрхий руу чиглүүлэхэд хагархай нийлж таваг ахин бүтэн болов. Чанга тасхийх чимээ Рон, Гермиона хоёрт түүний дэргэд нь сууж байгааг сануулсан бололтой. Гермиона сандарсандаа

«Дэлхий дээрх иддэг жимс ургамал» лавлах эргүүлж шүүс бэлтгэх арга хайв. Рон ичингүйрсэн ч сэтгэл хангалуун байлаа.

- Нааш нь өг, Харри гэж Гермиона яаран хэлээд,
- Энд хэлэхдээ түүнийг хурц зүйлийн тусламжтай цоолох хэрэгтэй гэсэн байна гэв ...

Харри түүнд тавагтай буурцгыг өгөөд Роны хамт хамгаалалтын шилээ зүүж хожуул руу очив. «Үнэнийг хэлэхэд үүнд гайхах зүйл алга» гэж Харри бодоод өргөст тэмтрүүл боомилохыг оролдоход тэмцэлдэв. Түүнд эрт орой хэдий энэ тохиолдох ёстой байсан юм шиг мэдрэмж төрөв. Тэр үүнд яаж хандахаа өөрөө ч мэдэхгүй байлаа. Чжоу тэр хоёр бие ярихаа больсноос хойш бие биеэ харахад амаргүй байв. Хэрвээ Рон, Гермиона хоёр дурлалын роман үүсгээд дараа нь маргалдвал яана? Тэгвэл тэдний нөхөрлөл тэсэх үү? Тэр гуравдугаар дамжаандаа Рон, Гермионатай ярихаа болиод Харри бүх хүчээ гарган эвлэрүүлэхийг оролдсоноо санав. Харин одоо тэр үеийнх шиг маргалдвал яах вэ? Билл, Флер хоёр шиг байвал тэр тэдний дэргэд илүүдэх болов уу?

- Аанхан баригдав уу! гэж Рон орилоод нүхэн дундаас хоёр дахь буурцагыг гарган авлаа.

Гермиона энэ үед эхний буурцгыг онгойлгон тавганд өт шиг мушгиралдсан ногоон булцуутай зүйл дүүргэв.

Слизнортын үдэшлэг хичээлийн төгсгөл хүртэл дурсагдсангүй. Дараагийн хэдэн өдрийн турш Харри хоёр найзаа анхааралтай ажиглахад Рон, Гермиона хоёр ердийнхөөрөө бие биетэйгээ эелдэг харьцаж байлаа. Харри тэднийг Слизнортын бүүдгэр өрөөнд үдэшлэг дээр цөцгийтэй шар айрагны үйлчлэл дор яахыг харах үлдлээ гэж бодов. Одоо түүнд санаа зовох өөр зүйл байлаа.

Кэти Белл гэгээн Мунгогийн эмнэлэгт хэвтсэн хэвээр болохоор Гриффиндорын баг есөн сарыг дуустал нэг ангуучгүй сургуулилт хийн өнгөрүүлэв. Харри Кэтиг орлох хүнийг хайлгүй Слизеринтэй хийх тэмцээний өмнө эргээд ирнэ гэж найдсан ч улирлын анхны тэмцээн ойртон ирэхэд эцэст нь Кэти тоглоомд ирэхгүй гэсэн бодолтойгоо эвлэрлээ.

Харри ахин нэг сорилт явуулахыг хүссэнгүй. Тэр хүндхэн зүрхтэй (квиддичтэй ямар ч холбоогүй) хувиргалын хичээлийн дараа Дин Томастай үлдлээ. Анги хоосорч зөвхөн Гермионагийн гаргасан хэдэн шаргал шувууд адарт жиргэн эргэлдэнэ.

- Чи ангуучаар тоглох боломжыг сонирхохгүй биз?
- Юу гэнээ? Тиймээ, тэгэлгүй яахав! гэж Дин догдлон дуугарлаа.

Харри түүний мөрөн дээгүүр Симус Финниган гашуун төрхтэйгээр сурах бичигээ цүнхэндээ хийхийг харлаа. Харри Динийг тоглолтонд урьсан нь Симуст таалагдахгүй гэдгийг мэдэж байв. Гэхдээ өөр өнцгөөс бол энэ нь багт ашигтай байлаа. Дин сорилтон дээр Симусээс сайн нисч байсан юм.

- Тэгвэл тоглоно гэж бод. Бэлтгэл өнөөдөр долоогоос эхлэнэ.
- Ойлголоо. Ура, Харри! Хөөх, явж Жиннид хэлье байз!

Тэр өрөөнөөс гүйн гараад Харри, Симус хоёрыг үлдээв. Амаргүй агшин байж Гермионагийн шувуудын нэг Симусын толгой руу мөргөчихлөө.

Зөвхөн Симус Кэтигийн орлон тоглогчын сонголтонд бухимдсан хүн байсангүй. Гриффиндорын амралтын өрөөнд олон хүүхдүүд Харри багтаа нэг ангийхнаасаа хоёр хүүхэд авсанд дургүйцэн гүнгэлдэж байв. Түүнд үүнээс ч долоон дор зүйл сонсож байсан болохоор иймэрхүү ярианд сэтгэл зовсонгүй. Слизеринтэй хийх тэмцээнд хожих хэрэгтэй байлаа. Хэрвээ Гриффиндор ялвал тэд шүүмжлэлээ мартан ямар сайхан баг бүрдсэнийг мэдэх болно. Хэрвээ тэд хожигдвол ... тэгвэл бүр ч муу юм сонсох болно гэж бодоод ярвайлаа ...

Тэр үдэш Харри сонголтондоо харамсах шалтгаан байсангүй. Дин Жинни, Демелза хоёртой сайхан хамтран ажиллаж байлаа. Довтлогч Пикс, Кут хоёр бэлтгэл бүр дээр улам сайжирч байв. Цорын ганц асуудал Рон үлдлээ.

Харри эхэндээ Рон жигд бус тоглодгийг мэдэж байсан ч тэр сэтгэл нь хүчтэй донсолсны улмаас өөртөө итгэлгүй болжээ. Золгүй нь гэвэл улирлын анхны тэмцээний өмнө түүний өмнөх бүх айдас хямрал эргэн ирсэн байлаа. Тэр эхлээд зургаан бөмбөг алдсаны ихэнхийг Жинни оруулав. Түүний тоглолтын арга барил улам бүр муудсаар эцэст нь Демелза Робинсын нүүр рүү нударгаараа цохьчихлоо.

- Би санаандгүй уучлаарай, Демелза жинхэнээсээ уучлаарай! Би зүгээр л ... гэж Рон түүнийг цус дуслуулан тахирлан эргэлдсээр газардахад хэлэв.
- Усан тэнэг гэж Жинни ууртай хэлээд Демельзагийн хажууд газардан язарсан уруулыг нь харлаа.
- Чи түүний ямар байгааг хараач!

- Би одоохон засчихъя гээд Харри охидын хажууд газардаад шидэт саваагаа Демельзагийн нүүр лүү чиглүүлж,

- Эпискеи! гэлээ. Тэгээд ч Жинни чи Роныг усан тэнэг гэж нэрлэхээ боль, чи ямар багийн ахлагч биш!

- Чи их завгүй байсан болохоор хэн нэгэн түүнийг тэнэг гэдгийг нь хэлэх ёстой биз дээ ...

Харри инээдээ арайхийн барьж тэслээ.

- Бүгд шүүрэндээ үргэлжлүүлье!

Ерөнхийдөө амжилтгүй бэлтгэл болсон ч Харри тэмцээн ойртож байхад зөв бодлого баримталсан нь дээр гэж үзжээ.

- Бүгд сайн ажиллаа! Бид Слизеринчүүдийг тэгшилээд өгнө гэж бодож байна! гэж багийнхандаа урамтай хэлээд үр дүнд нь баяртай тоглогчидтой хувцас солих өрөөнд орлоо.

- Би шуудайтай лууны шивх шиг тоглолоо гэж Рон Жинниг хаалга хаамагц хөндий хоолойгоор хэлэв.

- Ерөөсөө ч тийм биш гэж Харри хатуу хэлээд,

- Чи миний сорилтон дээр харсан хамгийн сайн хаалгач байсан. Чиний ганц асуудал бол сэтгэл хөдлөл юм гэв.

Тэр сургууль хүрэх замын турш Роныг тасралтгүй ятган зоригжуулж хоёр давхарт гарлаа. Рон үл ялиг хөгжив. Харри ердийнхөөрөө Гриффиндорын цамхаг руу гардаг нууц хонгил болох зургыг түлхэхэд өмнө нь Дин, Жинни хоёр наалдсан аятай тэврэлдэн зогсоод үнсэлдэж байв.

Харрийн дотор ямар нэг том хайрстай зүйл хөрвөн сарвуугаараа маажлах шиг болов. Толгой руу нь халуун цус хөөрөхөд бүх бодол нь сарниж зөвхөн Диныг цэлцгий болтол шивших зэрлэг хүсэл төрөв. Гэнэтийн ассан хүсэлтэйгээ тэмцэлдэж байтал алсад Роны хоолой сонсогдон,

- Хөөе! гэлээ.

Дин, Жинни хоёр огло үсрэн холдоод эргэн тойрноо харав.

- Яасан бэ? гэж Жинни асуулаа.

- Би дүүгээ залуутай бүгдийн өмнө үнсэлдэж зогсохыг хүсэхгүй байна!

- Чамайг ирээгүй байхад хонгил хоосон байсан биз дээ!

Дин ичингүйрсэн байртай харагдав. Тэр Харри руу хулчгардуухан инээмсэглэлээ. Харри хариу инээмсэглэсэнгүй дотор нь шинэхэн төрсөн мангас архиран түүнийг даруйхан багаас хөөх хүсэл төрөв.

- Э-э ... явъя, Жинни. Алив амралтын өрөөндөө эргэж очъё гэж Дин бувтналаа.

- Чи явж бай! Харин би хайрт ахдаа хэлэх хэдэн найрсаг үг байна!

Дин хэрүүлээс бултах боломж олдсонд баярлан явлаа.

- Тэгэхээр гэж Жинни хэлээд урт шаргал үсээ хойш чулуудаж Рон уруу уурсан харснаа,
- Алив энэ бүхний учрыг олоодохъё. Чамд миний хэнтэй уулзаж юу хийх нь хамаагүй, Рон ... гэв.
- Үгүй, хамаатай! гээд Рон түүнээс дутуугүй уурласан байлаа.
- Намайг сургууль даяар дүүгийн минь тухай яриаг сонсоосой гэж хүсээд байгаа юм уу?
- Хэн? Хэн юм хэл? гэж Жинни шидэт саваагаа гарган орилов.
- Тэр ерөөсөө тэгж хэлэхийг хүсээгүй, Жинни гэж Харри өөрийн мэдэлгүй хэлсэн ч дотор нь байгаа мангас Роны үгийг урамшуулан архирлаа.
- Үгүй, хүссэн! гээд тэр Харри руу нүдээ гялалзуулан,
- Учир нь тэр амьдралдаа нагац эгч Мюриэлээс ондоо хэнтэй хэзээ ч үнсэлдэж байгаагүй ...
- Амаа тат! гэж улаан хүрэнтсэн Рон орилов.
- Үгүй, чимээгүй болохгүй! гэж Жинни уурсан хашгирлаа.
- Би чамайг Флегми рүү хацар дээрээ үнсүүлнэ гэж найдан яаж гөлөрдөгийг чинь харсан өрөвдөлтэй амьтан минь! Хэрвээ чи өөрөө үнсэлдэж чадахгүй бол бусдыг үүнийг хийж байгаад санаа зовох хэрэггүй!

Рон ч гэсэн шидэт саваагаа гаргахад Харри түргэхэн дундуур нь оров.

- Чи юуны тухай ярьж байгаагаа мэдэхгүй байна! гэж Рон орилоод Харрийн алдалсан гарын доогуур Жинни рүү чиглүүлэхийг хичээлээ.
- Хэрвээ би үүнийг хүмүүсийн нүдэн дээр хийгээгүй бол ... Жинни чанга хөхрөөд Харриг холдуулахаар түлхлээ.
- Чи хэнтэй үнсэлддэг юм, Гахайтайгаа юу? Эсвэл дэрэн дороо нагац эгч Мюриэлийн зургийг хадгалдаг юм биш биз?
- Чи муу ...

Харрийн зүүн гаран доогуур шаргал гэрэл гялсхийн өнгөрөөд Жиннигээс инчийн зайтай зөрөв. Харри Роныг хананд шахлаа.

- Сонсооч, битгий тэнэг ...
- Харри Чжоу Чангтай үнсэлдсэн! гэж уйлах шахсан Жинни хашгирав. Харин Гермiona Виктор Крамтай үнсэлдсэн! Чи ганцаараа хэнтэй ч үнсэлдээгүй. Учир нь чи арван хоёр настай хүүхэд шиг бие авч явдаг учраас!

Тэр үүнийхээ дараа цааш явлаа. Харри Роныг тавихад царайны өнгө нь хүн алахад бэлэн болоод байв. Тэд хүндхэн амьсгаадан зогсоход булангаас Филчийн муур хатагтай Норрис гарч ирлээ. Түүнийг ирэлт уур амьсгалыг өөрчлөв.

- Эндээс зайл гэж Харри хэлэхэд булангаас сургуулийн харуулийн хөлийн чимээ сонсогдож эхэлжээ.

Рон, Харри хоёр шатаар гүйж долоон давхарт гарлаа.

- Замаас холд! гэж Рон жижиг хүүхдийг зандрав.

Охин айсандаа үсрээд мэлхийний түрстэй шилээ унагачихлаа.

Харри шилний хагарах чимээг дөнгөж сонсоод хүүхдүүдийн дунд ормогц толгой нь эргэн үймэрч аянганд цохиулсантай адил мэдрэмж төрөв. «Энэ бүхэн Роны дүүгээс болж байна гэж тэр өөртөө хэлэв. Надад түүний Динтай үнсэлдэхийг харах нь таалагдахгүй байна. Яагаад гэвэл тэр Роны дүү учраас ...»

Тэгтэл урд нь хүсээгүй дүр зураг харагдав. Энэ удаад хоосон хонгилд Дин биш тэр өөрөө Жиннитэй үнсэлдэж байлаа ... цээжинд байгаа мангас архирлаа ... Тэрбээр цааш нь Рон хэрхэн нууц гарцыг сөхөн гарч ирээд шидэт саваагаа түүн рүү чиглүүлж «урвагч» ... эсвэл «найз хэмээгч» гэх мэтийн үг хашгирч байна хэмээн төсөөлөв.

- Чи Гермionaг Крамтай үнэхээр үнсэлдсэн гэж бодож байна уу? гэж Рон тарган хатагтай руу хүрч байхдаа гэнэтхэн асуулаа.

Харри гэмшингүй давхийгээд сэхээ ороход ямар ч Жинни байхгүй ганцаараа байлаа.

- Юу? Аан ... ээ ... гэж будилан хэллээ. Үнэн хэрэгтээ «тийм» гэж хэлэх ёстой байсан ч Харри үүнийг хэлэхийг хүссэнгүй. Гэхдээ Рон өөрөө түүний царайнаас тааварлав бололтой.

- Лабардан гэж баргар царайлан хэлээд тарган хатагтайн хөргөн нүхээр амралтын өрөө рүү шурган орлоо.

Тэд Жинни, Гермiona нарын тухай дурссангүй. Үнэндээ бол юу ч ярилцалгүй орондоо чимээгүйхэн ороод өөрсдийн бодолдоо умбалаа.

Харри удтал нойргүй хэвтэн хөшиг ширтэнгээ өөртөө Жинниг ахын сэтгэлээр хайрлаж байна гэж итгүүлэхийг хичээв. Тэр зунжингаа нэг гэрт ах дүү хоёр шиг амьдран, квиддич тоглож, Роныг даажигнан, Билл Флегми хоёрыг шоолон инээлдэж байсан. Тэр зуун жилийн өмнөөс Жиннигийн тухай мэднэ ... тэр түүнийг хамгаалахыг хүссэн байх ... түүнтэй үнсэлдсэн Диныг хэдэн хэсэг болгон тас татаад ... Үүнийг л ахын сэтгэл зөвшөөрөхгүй ...

Рон чанга хурхирлаа.

«Тэр Роны дүү. Роны дүү. Энэ бол хориотой бүс» гэж Харри өөртөө хатуу хэлэв. Тэр энэ дэлхий дээр Ронтой үерхэх нөхөрлөлдөө аюул учруулахыг хүссэнгүй. Харри нударгаараа дэрээ цохилон аятайхан болгоод Жиннигийн тухай бодолгүй унтахыг бүх хүчээ гарган хичээлээ.

Маргааш өглөө нь Харри удаан үргэлжилсэн зүүдний дараа сэрэхэд Рон түүнийг квиддичийн цохиур барин элдэж байсан тул Жинни, Дин хоёрыг үл тоомсорлож байгаа жинхэнэ Ронор баяртайгаар сольсон ч тэр бас Гермionaг тоолгүй их зантай

хайхрамжгүй харьцаж байсан тул цаадах нь юу болсныг мэдэлгүй ихэд гомдлоо. Рон тэр өдөр туйлын өөнтөгч эмзэг байж хүмүүстэй ямар нэгэн соплохвост аятай хандаж байлаа. Харри өдрийн турш Рон, Гермiona хоёрыг найрамдуулах амжилтгүй оролдого хийв. Эцэст нь сэтгэлээр унасан Гермiona охидын унтлагын өрөө рүү ороход, Рон хөвгүүдийн унтлагын өрөө орох замдаа хэдэн нэгдүгээр дамжааныхныг өөдөөс нь ширтсэний төлөө хараав.

Харри дараагийн өдөр Рон сэтгэл санаа огтхон ч дээрдээгүй байсанд ихэд харамсжээ. Муу нь гэвэл үүнтэй зэрэгцэн түүний хаалгачын чадвар муудаж үүндээ уурсан тэмцээний өмнөх бямба гаригийн сүүлчийн бэлтгэл дээр нэг ч бөмбөг барьж чадалгүй Демельза Ронбисыг уйлтал чанга загнан орилжээ.

- Алив амаа татаад түүнийг тайван орхи! гэж гартаа хүнд цохиур барьсан Пикс түүн рүү хашгирлаа.

- Хангалттай! гэж Харри орилов.

Тэр Жинни Рон руу хорсон ширтэхийг хараад сарьсан багваахайн хараалын сайхан хийдгийг нь санаад муу юм болгохгүйн тулд дунд нь хөөрөн буулаа.

- Пикс блажеруудаа хайрцагт хий. Демельза тайвшир даа чи өнөөдөр гайхамшигтай тоглосон. Рон ... гээд бусад тоглогчдыг цааш холдохыг хүлээснээ,

- Чи миний сайн найз. Гэхдээ хэрвээ чи биеэ ингэж авч явах юм бол багаас хөөхөөс өөр арга алга гэв.

Агшин зуур Рон түүнийг цохих гэж байгаа юм шиг санагдсан ч бүр ч дор юм боллоо. Рон шүүрэн дээрээ суугаад,

- Би өөрөө гарна. Би авъяасгүй хаалгач гэв.

- Чи ямар ч авъяасгүй биш хаашаа ч явахгүй! гэж Харри ууртай хашгираад

Роны жанчны захнаас зуурлаа.

- Чи хэвийн байх үедээ хамгийн хүнд бөмбөгийг барьж авдаг болохоор чиний мэдрэлд чинь асуудал байгаа юм!

- Намайг солиотой гэж хэлэх гээ юу?

- Тийм шүү, магадгүй л юм!

Тэд бие биеэ уурсан хараад дараа нь Рон толгойгоо найдлагагүй сэгсэрлээ.

- Би чамд өөр хаалгач эрэх цаг байхгүйг мэдэх болохоор маргааш тоглох болно.

Хэрвээ хожигдвол энэ ч тодорхой би багаас гарна.

Харри түүнд юу ч хэлсэн өөрчлөгдсөнгүй. Тэр хоолон дээр Роны итгэлтэй байдлыг сэргээхийг хичээсэн ч ааш муутай баргар байлаа. Харри амралтын өрөөнд үдэш ятгах ахин нэг оролдлого хийж хэрвээ Рон тэднийг орхивол бүх багаараа сүйрнэ гэж ухуулсан ч үнэндээ буланд сууж байсан багийнхан нь Роны тухай ярьж байгаа бололтой ууртай харцаар ширвэж байлаа. Эцэст нь Харри ахин Роныг өдөн спортын



уур хилэнг хөдөлгөхийг оролдсон ч энэ бас үйлчилсэнгүй. Рон унтлагын өрөө рүүгээ гунигтай буцав.

Харри удтал унталгүй харанхуйд хэвтэв. Тэр маргаашийн тэмцээнд хожигдохыг хүссэнгүй. Энэ бол түүний ахмад болсон анхны тэмцээн учраас Драко Малфойг квиддич дээр хожихыг хатуу шийдлээ. Хэрвээ Рон сүүлчийн хэдэн бэлтгэл шиг тоглох юм бол тэдэнд ялах боломж маш бага үлдэнэ ...

Хэрвээ ямар нэг аргаар Роныг сэргээдэг бол ... түүнийг талбай дээр сүүлчийн боломжоо ашиглан тоглоход хүргэдэг бол ... түүний хувьд жинхэнэ амжилттай өдөр байхаар ...

Тэгтэл Харри сэхээ оров. Хариулт гэнэтхэн гялсхийн орж ирлээ.

Маргааш нь өглөөний цайн дээр ердийнхөөрөө тэмцээний өдрийн уур амьсгал ноёрхож Гриффиндорын багаас хэн нэгэн Их танхимд орж ирэхэд Слизеринчүүд чанга шүгэлдэн элэглэж байв. Харри адар руу араад цэлмэг тэнгэр харсан нь сайны тэмдэг байлаа.

Гриффиндорын ширээнд сууж байсан алтлаг улаан хувцастай хүүхдүүд Харри, Рон хоёрыг нөхөрсгөөр хашгиран угтав. Харри нүүр дүүрэн инээмсэглээд гараа даллахад, Рон нүүрээ ярвайлгаад толгой сэгсрэв.

- Тэсээрэй Рон! Би чамайг сайн тоглоно гэдгийг мэдэж байна! гэж Лаванда хашгирав.

Рон үүнийг авч хэлэлцсэнгүй.

- Цай? Кофе? Хулууны шүүс уух уу? гэж Харри түүнд санал болгов.

- Хамаагүй гэж Рон баргар хэлээд шарсан талх хазлаа.

Хэдэн хормын дараа Роны муу зан авирын улмаас тэдэнтэй өглөөний цайн дээр хамт суухгүй байсан Гермиона ширээ рүү дөхөн ирж зогслоо.

- Сэтгэл санаа ямар байна хөвгүүд ээ? гэж Роны шилэн хүзүү рүү болгоомжтой харан сониучирхав.

- Маш сайн гээд Харри Ронд аягатай хулууны шүүс дөхүүлж өглөө.

- Май аваарай, Рон. Уу.

Рон аягыг өргөн урууландаа хүргэтэл Гермиона гэнэтхэн,

- Битгий уу, Рон! гэлээ. Харри, Рон хоёр түүн рүү харлаа.

- Яагаад үгүй гэж? хэмээн Рон асуув.

Гермиона Харри руу нүдэндээ итгэхгүй байгаа мэт харав.

- Чи аяганд ямар нэг зүйл нэмсэн!

- Чи юу хэлсэн бэ? гэж Харри асуулаа.

- Сонссоныг чинь хэллээ! Би чамайг Рон уух юманд ямар нэг зүйл нэмэхийг харсан. Шил нь одоо чиний гарт байна!

- Чамайг юуны тухай яриад байгааг ойлгохгүй байна гээд Харри түргэхэн шилээ халаасандаа хийлээ.

- Рон би чамд анхааруулсан шүү, битгий уу! гэж Гермиона түгшин давтахад Рон аягатайгаа аваад ганц балгалтаар хоослов.

- Намайг захирахаа больж үз, Гермиона!

Гермиона тэдэн рүү мэгдэн харав. Тэгснээ Харрийн чих рүү бөхийн,

- Чамайг ийм зүйл хийсний чинь төлөө хөөх хэрэгтэй! Би чамайг хэзээ ч ингэнэ гэж бодсонгүй, Харри! гэв.

- Хэн үүнийг хэлж байна гэж тэр хариу шивнэв.

- Саяхан Конфундус шившлэг илгээсэн хүн үү?

Гермиона уурсан цааш явлаа. Харри түүний араас харахдаа өчүүхэн ч харамссангүй. Гермиона хэзээ ч квиддич хичнээн чухал болохыг ойлгож байгаагүй. Тэгээд уруулаа тамшаалж байгаа Рон руу харж,

- Явах цаг боллоо! гэж инээмсэглэн хэлэв.

Тэд цантсан ногоо хөлийн дор шажигнуулсаар цэнгэлдэх хүрээлэн рүү явлаа.

- Өнөөдөр амжилттай цаг агаартай байгаа биз тийм үү? гэж Харри хэлэв.

- Аанхан гэж Рон хариуллаа. Тэр дотор нь муухайрсан юм шиг цонхийжээ.

Жинни, Демельза хоёр хэдийн дүрэмт хувцсаа өмсөөд хувцас солих өрөөнд хүлээж байлаа.

- Өнөөдрийн нөхцөл сайхан байна гэж Жинни Рон руу харалгүй хэлээд,

- Юу болсныг таа даа? Слизериний ангууч Вейзи өчигдөрийн бэлтгэл дээр блажераар толгой руугаа цохиулан тоглож чадахгүй болжээ! Бас өөр илүү дээр зүйл гэвэл Малфой өвдсөн байна!

- Юу? гээд Харри түүн рүү огцом эргэн ширтлээ.

- Өвдсөн гэнээ? Тэр яагаа вэ?

- Мэдэх юм алга гэхдээ бидний хувьд сайн хэрэг гэж Жинни хөөрөн хэлээд,

- Түүний оронд Харпер тоглож байгаа. Тэр манай дамжаанд сурдаг дүүрчихсэн тэнэг амьтан байгаа юм гэв.

Харри инээмсэглээд толгойгоо улаан жанчинд шургуулахдаа зөвхөн квиддичийн тухай бодсонгүй. Малфой нэг удаа гэмтлээс болж тоглож чадахгүй гэж зүтгэн тэмцээнийг цуцлуулж Слизеринчүүдэд сайхан боломж өгсөн. Харин одоо яагаад орлогч авахыг зөвшөөрсөн юм бол? Үнэхээр өвдсөн юм болов уу эсвэл мэхэлж байгаа юм уу?

- Хачирхалтай байгаа биз, тийм үү? Малфой тоглохгүй гэдэг нь? гэж Харри

Роноос аяархан асуулаа.

- Би үүнийг аз таарсан гэж хэлэх байна гээд Рон үл мэдэгхэн сэргэлээ.
- Бас Вейзи байхгүй тэр тэдний хамгийн сайн оноо оруулагч нь байсан юм. Би найдаагүй ... Хөөе! гээд тэр гэнэтхэн бээлийгээ өмсөж байснаа хөшин Харри руу нүдээ бүлтийлгэн ширтлээ.
- Яасан?
- Би ... чи гээд Рон дуугаа намсган айхах гайхах зэрэгцсэн харагдав.
- Миний уусан ... хулууны шүүс ... чи үгүй ... байж боломгүй юм? Харри үүнд хөмсгөө өргөөд зөвхөн,
- Бид таван хормын дараа гарлаа чи гутлаа өмссөн нь дээр байх гэлээ.

Тэднийг талбай руу гарахад үзэгчдийн суудлаас чих дөжрөм чимээ нүргэлж эсрэг багийн хөгжөөн дэмжигчид шүгэлдэв. Цэнгэлдэх хүрээлэнгийн нэг хагас нь алтлаг улаан хувцастай, нөгөө хэсэг нь мөнгөлөг ногоон хувцастай байлаа. Олонхи Пуффендуйчууд болон Когтевранчууд өөр багийг дэмжиж байлаа. Орилж хашгирах алга таших чимээн дундаас Харри Полумна Лавгудын арслангийн төрхтэй танил малгайн архиралтыг сонсов.

Харри тэмцээний шүүгч хатагтай Нугарагч руу очив. Тэр талбай дээр зогсоод хайрцагнаас бөмбөгийг гаргахаар зэхэж байлаа.

- Ахмадууд гар барьцгаа гэж тэр хэлэхэд Харрийн хурууг Слизериний шинэ ахмад Урхартын хүчирхэг гар шажигнатал базлаа.
- Бүгд шүүрэндээ! Шүгэл ... гурав ... хоёр ... нэг ...

Шүгэл дуугарлаа. Харри болон бусад тоглогчид хөлдүү газар хүчтэй түлхэн агаарт хөөрлөө.

Харри цэнгэлдэх хүрээлэн дээгүүр тойрог нисэн снитчийг хараачилангаа Харпер алсад эргэлдэхийг харлаа. Гэнэтхэн дасал болоогүй тайлбарлагчийн хоолой сонсогдов.

- За ингээд тоглоом эхэллээ. Би Поттер энэ жил бүгдийг гайхшируулсан баг цуглуулсан гэж бодож байна. Олон хүмүүс Рональд Уизли өнгөрсөн улирлын жигд бус тоглолтын улмаас багт орохгүй гэж бодож байсан ч ахмадтай хувийн нөхөрлөл ойрын холбоотой байсан явдал нь тусалжээ ...

Слизериний үзэгчдийн хагас нь энэ үгийг шоолон хашгиран хүлээн авч алга ташив. Харри хүзүүгээ эргүүлээд тайлбарлагчийн тавцан руу харахыг хичээв. Тэнд өндөр туранхай цайвар үстэй хамартай хүү дээшээ харан зогсоод шидэт чанга яригчаар ярьж байлаа. Харри Пуффендуйн тоглогч Захария Смитийг танилаа.

- За ингээд Слизеринчүүдийн эхний дайралт эхэллээ, Урхарт талбай дээгүүр нисэж байна ...

Харрийн дотор палхийлээ.

- Уизли бөмбөгийг барилаа. Түүнд хааяа нэг аз таардаг юм ...

- Энэ ч тодорхой, Смит гэж Харри бувтнаад инээмсэглэн ангуучдын дунд шумбан орж снитч хаа нэг тийш гялалзахыг харлаа.

Хагас цагийн дараа Гриффиндор тоглоомыг жар тэгээр тэргүүлж эхлэв. Рон хэдэн удаа маш сайхан барилт хийн заримдаа бөмбөгөнд хурууны үзүүрээр хүрч, Жинни Гриффиндорын зургаан бөмбөгийн дөрвийг цагаригт оруулжээ. Үүний дараа Захария ах дүү Уизлиг багт зөвхөн Поттертой нөхөрлөдөгийн төлөө оруулсан эсэхийг чанга асуухаа болиод оронд нь Пикс, Пут хоёр луу чиглэлээ.

- Мэдээж Кут хамгийн сайн довтлогчийн хувьд тохиромжтой тоглогч биш тэд илүү булчинлаг байдаг болохоор ...

- Түүн рүү блажер илгээ! гэж Харри Кутад хашгираад дэргэдүүр нь нисэн өнгөрөхөд тэр инээмсэглэн ээлжит блажераа Харпер луу чиглүүлэв. Харри блажер цохьсон байгаа онох бөглүү цохилтыг сэтгэл ханамжтай сонслоо.

Гриффиндорынхон өнөөдөр нэг ч алдаа хийсэнгүй гэж бодож болохоор байлаа. Тэд ахин дахин эсрэг талын цагаригт оноо оруулж Рон хялбархнаар хүч гаралгүй бөмбөгийг барин авч байв. Тэр одоо инээмсэглэж эхлэн цугласан хүмүүс сайн барилт болгонд нь урамшуулан дуртай хуучин дуу болох «Рональд Уизли манай хаан» дууг дуулахад агаарт хөгжим удирдаж буй дүр үзүүлэв.

- Түүний хувьд онцгой өдөр болохыг төсөөлж байна гэх егөөдөнгүй хоолой сонсогдоод Харпер түүнийг хүчтэй мөргөөд Харри золтой л шүүрнээсээ унасангүй. Чиний найз чинь цэвэр цуснаасаа урвагч ...

Хатагтай Нугарагч энэ агшинд өөр зүг рүү харж байсан болохоор Гриффиндорчуудын хөгжөөн дэмжигчдийн уурсан хашгиралт дунд Харпер хэдийн алга болохыг ажигласангүй. Мөр нь янгинахад Харри түүний араас хариуг нь өгөх хүсэлдээ автан элдлээ.

- Минийхээр бол Слизериний багийн Харпер снитчийг харсан бололтой!

Тиймээ тэр гарцаагүй Поттерын чадаагүй зүйлийг харж! гэж Захария Смит шидэт чанга яригчаараа хэлэв.

«Смит ч дүүрсэн тэнэг амьтан юм даа» гэж Харри бодов. Түүний Харпертай мөргөлдсөнийг анзаарсангүй гэж үү? Гэвч дараагийн агшинд газар дэлхий хөрвөх шиг болов. Смитийн зөв Харрийн буруу байлаа. Харпер санамсаргүй дээшээ хөөрсөнгүй тэр Харрийн ажиглаагүй зүйлийг олж харжээ. Тэдний дээр цэнхэр тэнгэрт снитч хурдтай нисч байв.

Харри хурдаа нэмлээ. Салхи чихнийх нь хажуугаар исгэрэн өнгөрч тайлбарлагч Смитийн дуу, үзэгчдийн орилоон хадна. Хэрвээ Харпер түрүүлж барих юм бол Гриффиндор хожигдох болно ... одоо Харперт снитчийг барихад хэдхэн фут зай үлдэж гараа сунгажээ ...

- Хөөе, Харпер! гэж Харри цөхрөн орилов.

- Малфойг чамайг орондоо тоглуулахын тулд хэдийг төлсөн бэ?

Тэр юу хатгаад ингэж хэлснээ өөрөө ч мэдсэнгүй. Гэсэн ч Харпер агаарт тооромслоход снитч хурууных нь завсраар мултарч Харри урагш ухасхийн жижигхэн жигүүртэй бөмбөгийг барьж авлаа.

- Зүйтэй! гэж Харри орилоод эргэлт хийн синтчийг барьсан гараа өргөн газардав. Үзэгчид юу болсныг ойлгосон бололтой тоглоом дууссаны тэмдэг болох эцсийн шүгэлтэй хамт нүргэлүүлэв.

- Жинни чи хаачих нь вэ? гэж Харри багийнхны тэврэлтэн дундаа хашгирлаа.

Гэсэн ч Жинни дэргэдүүр нисэн өнгөрөөд тасхийх чимээ гарган тайлбарлагчын тавцанг мөргөлөө. Үзэгчдийн хашгиралт, Гриффиндорын багийн инээдэм дунд Захария Смит хугарсан самбар дор хэвтэж байв. Харри Жинни хэрхэн уурласан МакГонагаллд,

- Уучлаарай профессор, тоормослохоо мартчихаж гэж тайлбарлаж байхыг сонслоо.

Харри инээд алдан бусад тоглогчдоос чөлөөлөгдөөд Жинниг чанга тэвэрснээ түргэхэн тавилаа. Тэр түүний нүд рүү харахгүйг хичээн баярлаж хөөрсөн Роны мөрөн дээр алгадлаа. Гриффиндорын багийнхан талбайгаас гарахад хөгжөөн дэмжигчид нь гараа зангидан даллаж хашгирч байлаа.

Хувцас солих өрөөний уур амьсгал хөөр баяслаар дүүрэв.

- Амралтын өрөөнд баяр тэмдэглэнэ. Симус надад хэлсэн! гэж Дин орилоод,

- Явъя Жинни, Демельза! гэв.

Рон, Харри хоёр бусдын ард саатав. Тэднийг явахаар гарах үед хувцас солих өрөөнд Гермiona орж ирлээ. Тэр Гриффиндорын ороолтоо угз татан аваад сэтгэлээр унасан хэдий ч шийдэмгий төрхтэй байлаа.

- Харри би чамтай ярих хэрэгтэй байна гээд гүнзгий амьсгал авснаа,

- Чи яаж үүнийг чадав аа. Слизнорт үүнийг хууль бус гэж хэлэхийг сонсоо биз дээ гэв.

- Чи тэгээд биднийг яах юм? гэж Рон шаардангуй сонирхов.

- Та хоёр юуны тухай яриад байгаа юм? гэж Харри хэлэхдээ инээж байгаагаа харуулахгүйн тулд жанчаа толгой дээгүүрээ нөмөрлөө.

- Чи юуны тухай ярьж байгааг сайн мэдэж байгаа! гэж Гермiona хашгираад,

- Чи Роны шүүсэнд аз авчирдаг уусмал нэмсэн! Феликс Фелицисс! гэв.

- Үгүй, нэмээгүй гээд Харри тэдэн рүү эргэж зогслоо.

- Үгүй, чи нэмсэн Харри ийм учраас бүх зүйл гайхамшигтай бүтэж Слизериний хоёр тоглогч өвдөн, Рон бүх бөмбөгийг барьж авсан!

- Би тийшээ юу ч нэмээгүй! гээд Харри нүүр дүүрэн инээмсэглэв. Тэр халааснаасаа Гермionaгийн өглөө харсан лонхыг гаргаж ирлээ. Сав дүүрэн алтлаг шингэнтэй байсан бөгөөд лац нь чанга таглаатай хэвээр байлаа.

- Би Ронд тэгсэн гэж бодуулахыг хүссэн учраас хуурсан юм гээд түүн рүү харлаа.

- Чи бүх бөмбөгийг амжилтандаа итгэлтэй байсан учир барьж авлаа. Харин үнэн хэрэгтээ өөрөө бүгдийг хийсэн!

Харри уусмалаа ахин халаасандаа далд хийв.

- Үнэн хэрэгтээ би жирийн хулууны шүүс уусан болж байна уу? гэж мэгдсэн

Рон асуугаад,

- Гэхдээ сайхан цаг агаарыг яах вэ ... бас Вейза тоглож чадахгүй болсон байдаг ... чи үнэхээр надад азын уусмал өгөөгүй юм уу? гэв.

Харри толгой сэгсэрлээ. Рон түүн рүү алмайран харснаа дараа нь Гермиона руу эргэж хоолойг нь дуурайн элэглэж,

- Чи Роны шүүсэнд Феликс Фелицис нэмсэн учраас тэр бүх бөмбөгийг барьж авлаа гэнэ шүү! Харж байна уу! Би гадны тусламжгүйгээр бөмбөг барьж чадна гэдгийг! гэв.

- Би чамайг чадахгүй гэж хэлээгүй ... Рон гэхдээ чи түүнийг уусан гэж бодсон биз дээ!

Гэсэн ч Рон хэдийн шүүрээ мөрөн дээрээ тавиад хаалга руу явжээ.

- Э-э ... гэж Харри гэнэтийн нам гүмийг эвдэн хэлэв. Тэр ийм үр дүнг хүлээгээгүй билээ.

- За тэгээд, баяр луу явцгаах уу?

- Чи яв! гээд Гермиона нулимсаа арчлаа.

- Би одоо Роныг харахаас дотор муухайрч байна. Би ахиад юу буруу хийснээ ойлгохгүй байна.

Ингээд тэр хувцас солих өрөөнөөс бас үсрэн гарлаа.

Харри шилтгээн руу удаанаар явлаа. Хүүхдүүд түүнд баяр хүргэж байсан ч сэтгэлээр унахаа мэдэрлээ. Тэр Роныг тэмцэнд хожвол Гермионатай шуудхан найрамдана гэдэгт итгэлтэй байсан. Тэр Гермионад Крамтай үнсэлдсэндээ буруутай болохыг яаж тайлбарлахаа мэдсэнгүй. Энэ ч их дээр үед болсон хэрэг дээ.

Харри Гермионаг амралтын өрөөнд харсангүй. Түүнийг орох үед баяр ид үргэлжилж байв. Түүнийг хашгиралт алга ташилтын давалгаа угтав. Удалгүй Харри баяр хүргэж буй Грфифиндорчуудын дунд орлоо. Тэр Роныг эрж олохыг хүссэн авч эхлээд өнөөдрийн тоглолтын тухай дүн шинжилгээ хийхийг хүссэн ах дүү Криви болон

сормуусаа дэвэн чанга инээлдэх бүлэг охидоос салах хэрэгтэй болов. Эцэст нь Слизнортын зул сарын үдэшлэгт хамт явахыг хүссэн Ромильда Вейнээс арайхийн мултрад уух юмтай ширээ рүү очих замдаа Жиннитэй тулгарлаа. Түүний мөрөн дээр үстэй бөмбөлөг Арнольд суугаад хөл дор нь Живоглот найдангуй мяулж байв.

- Роныг хайж байна уу? Тэр байна жигшүүртэй хоёр нүүртэн гээд Жинни хорон инээмсэглэлээ.

Харри түүний заасан зүг рүү харлаа. Буланд Рон, Лаванда Браун хоёр зогсож байв. Тэд маш чанга тэврэлдсэн учир хэнийх нь гар хаа байгаа гэдгийг хэлэхэд бэрхтэй ажээ.

- Тэр түүнийг идэхийг хүсч байгаа юм шиг харагдаж байгаа биз тийм үү? Түүнд арга барилаа сайжруулсан нь дээр бололтой. Өнөөдөр сайхан тоглолоо, Харри.

Тэр гаран дээр нь алгадлаа. Харрийн дотор нэг юм хөрвөсөн ч тэр хэдийн ширээ рүү очиж цөцгийний шар айраг авлаа. Живоглот түүний араас дагаж шар нүдээ Арнольдоос салгасангүй.

Харри Раноос эргээд орчин тойрноо харахдаа хөргөн нүх хаагдахыг ажиглав. Түүнд нүхээр ямар нэгэн өтгөн хүрэн үс зурсхийх шиг санагджээ.

Харри урагш ухасхийн Ромильда Вейнээс зайлсхийгээд тарган хатагтайн хөргийг онгойлгов. Хонгилд хэн ч байсангүй.

- Гермiona?

Тэр түүнийг эхний түгжээгүй ангиас олов. Гермiona багшийн ширээн дээр ганцаар суугаад толгой дээгүүр нь илбэдэн гаргасан бололтой шаргал шувууд дугуйран эргэлдэж байв. Харри түүнийг ийм агшинд ч гэсэн шившлэг хийж байгаад биширлээ.

- Аан, сайн уу Харри гэж тэр сулхан хоолойгоор хэлээд,

- Би жаахан сургуулилахаар шийдсэн гэв.

- Аан ... тийм л дээ ... тэд ... э-э ... маш сайн байна гэж Харри хэлэв.

Тэр юу хэлэхээ төсөөлсөнгүй. Амралтын өрөөнд хэтэрхий чимээ шуугиан ихтэй байсан учраас Роныг ажиглаагүй явсан байх гэж найдлаа. Тэгтэл Гермiona,

- Рон тэнд хөгжилтэй байх шиг санагдсан гэв.

- Э-э ... тийм үү?

- Хараагүй дүр бүү эсгэ. Тэр нуугдах гэж нэг их хичээгээгүй биз дээ ...

Тэдний ард хаалга чанга нээгдлээ. Харрийн айдсыг хүргэн ангид Рон орж ирэхдээ инээд алдан Лавандагийн гараас чиржээ.

- Өө, гээд тэр Харри, Гермiona хоёрыг харан зогсов.

- Ёо-ёо! гээд Лаванда инээсээр ангиас үсрэн гарлаа. Хаалга түүний ард хаагдав.

Эвгүйцэм нам гүм болов. Гермiona Рон руу харлаа. Рон түүний харцнаас зайлсхийсэн ч зоригтой дүр эсгэн эв хавгүйхнээр,

- Сайн уу, Харри! Би чамайг хаачсан юм бол гэж бодлоо гэв.

Гермiona ширээнээс гулган буув. Сүрэг алтлаг шувууд толгой дээгүүр нь өдтэй нарны системийн загвар шиг хачирхалтай дугуйран эргэлдэнэ.

- Чи Лавандаг хонгилд хүлээлгэж болохгүй. Тэр чамайг гарч ирэхгүй байгаад гайхаж байгаа байх.

Тэр хаалга руу удаанаар явлаа. Харри Рон руу харахад ийм хялбархан салсан явдалд баяртай харагдав.

- Оппуньо! гэх хашгиралт хаалганы дэргэдээс сонсогдов.

Харри даруйхан эргээд Гермиона хэрцгий төрхтэй Рон руу саваагаа чиглүүлэхийг харлаа. Алтлаг шувууд түүний зүг суман мөндөр шиг шаагин буув. Рон хашгираад нүүрээ гараараа дарахад шувууд түүнийг тоншиж хумсаараа хүрч чадах газар болгондоо маажив.

- Холдуулаач! гэж Рон орилов.

Гермиона түүнийг сүүлчийн удаа жигшүүртэй харцаар ширвээд үүд нээн алга болов. Хаалга хаагдахын урд Харрид уйлах чимээ сонсогдох шиг санагджээ.



## БҮЛЭГ 15: ҮЛ ЭВДЭГДЭХ АМЛАЛТ

Ахиад л хөлдүү цонхны цаана цасан ширхэг хаялж зул сар түргэн ойртов. Хагрид үргэлжид байдаг шигээ ганцаараа арван хоёр зул сарын гацуур авчирч Их танхимыг чимэглэн, шатны бариулыг мөнгөлөг цаасаар хучин, рыцарын хоосон дуулганд мөнхийн лаа асааж, хонгилд омела цэцгийн эгнээ өлгөлөө. Харриг омелагийн дэргэдүүр санамсаргүй өнгөрөх болгонд сүрэг охид тойрон бүслэн авахыг оролдох аж. Гэхдээ аз болоход олон тооны давтагдсан шөнийн аялалаараа бүх нууц хонгил нууцыг гарцыг мэдэх болсон тул хичээлээс хичээл рүү ямар ч хүндрэлгүй нуугдан явж байлаа.

Өмнө нь Рон энэхүү тойруу аялалд атаархах байсан бол одоо хөгжилтэйгээр инээд алдаж байв. Харрид шинэ зоригтой наргианч Рон хэдэн долоо хоногийн турш тэвчиж байсан баргар төрхтэйгээ бодвол илүү их таалагдаж байсан ч энэ сайжрал түүнд үнэтэй олджээ. Нэгдүгээрт Харри одоо Лаванда Брауны байнга байдагт эвлэрэх хэрэгтэй болж, хоёрдугаарт гэвэл ахин хоёр сайн найз нь хоорондоо ярихаа больсон байлаа.

Рон гарандаа Гермионагийн шувууны дайралтаас үлдсэн уруулсан шархтай үлдээд гомдолтой өнгөөр ярилаа.

- Түүнд харамсах юм байхгүй. Тэр Крамтай үнсэлдсэн. Харин одоо намайг хэн нэгэнтэй үнсэлдэхийг хүсч байгааг харж байгаа. Бид чинь эрх чөлөөтэй оронд амьдарч байна шүү дээ. Би ямар ч муу зүйл хийгээгүй.

Харри хариулсангүй маргаашийн шившлэгийн хичээлд уншихыг тушаасан «Утгын эрэлд» гэсэн номд төвлөрлөө. Тэр Рон, Гермиона хоёртой хоёулантай нь найз үлдэхээр хатуу шийдээд ихэнхи цагт ам нээхгүй өнгөрүүлж байв.

- Би Гермионад юу ч амлаагүй. Би зул сарын Слизнортын үдэшлэгт хамт явах байсан ч гэхдээ тэр хэлэхдээ ... зөвхөн нөхөрлөлийн үүднээс гэж хэлсэн ... би чинь чөлөөтэй хүн ...

Харри хуудас эргүүлэхдээ Роны харцыг мэдэрлээ. Роны хоолой тодорхойгүй бувтналт болон хувираад галын тас нясхийх дуунаас арай ядан сонсогдох хэдий ч Харри танил үг болох «Крам», «харамсах юмгүй» гэсэн үгийг гэж ялган сонслоо.

Гермиона маш шахуу хуваарьтай байсан тул Харритай зөвхөн үдэш ярих боломжтой байж Рон тэр үед Лавандтай тэврэлдэж байсан учир түүнийг юу хийж байгааг анзаарсангүй. Гермиона Роныг байгаа үед амралтын өрөөнд орохоос татгалзаж байсан учраас Харри түүнтэй ихэнхидээ номын санд тааралдаж шивнэлдэн ярилцаж байлаа.

- Түүний хэнтэй үнсэлдэх нь дурын хэрэг гэж Гермиона номын санч хатагтай

Пинс номын тавиурын ардуур гэтэн өнгөрөхөд хэлээд,

- Энэ намайг зовоохгүй байна гэв.

Тэр үзгээ аваад цэг хүчтэй тавихдаа цаас нэвт хатгачихлаа. Харри чимээгүй болов. Тэр хоолой нь ийм хэрэглээнээс болж мөдхөн гарахаа дуу гарахаа болих байх даа

гэж бодлоо. Тэгээд доош уусмалын хичээлийн ном руугаа бөхийн Либациусын мөнхийн ундааны мөрөн доор бичсэн эрлийз ханхүүгийн үнэтэй нэмэлтийн учрыг олохыг хичээв.

- Ер нь ингэхэд чи ч гэсэн болгоомжтой байх хэрэгтэй гэж Гермiona хэсэг зуур дуугүй байсныхаа дараа хэлэв.

- Сүүлчийн удаа хэлье гэж Харри дөчин таван минут чимээгүй байсны улмаас сөөсөн хоолойгоор шивнээд,

- Би энэ номыг эргүүлж өгөхгүй. Би эрлийз хунтайжаас Снегг, профессор Слизнорт хоёрыг нийлүүлснээс ч илүү их юм сурсан гэв.

- Би чиний тэнэг хунтайжын тухай яриагүй байна гээд Гермiona ном л түүнийг гомдоосон юм шиг таагүй харж,

- Би ийшээ ирэхийн өмнө эмэгтэйчүүдийн жорлонд ороход арваад охин түүний дотор Ромильда Вейн зогсоод чамд яаж хайрын ундаа өгөх вэ гэж ярилцаж байна лээ. Бүгд чамтай Слизнортын үдэшлэг рүү хамт явахыг мөрөөдөж байгаа болохоор Фред, Жорж хоёроос хайрын ундаа худалдаж авсан байсан. Харамсалтай нь гэвэл тэр маш түргэн үйлчилдэг юм даа ...

- Чи яагаад тэднээс хурааж аваагүй юм бэ? гэж Харри уурслаа.

Гермонагийн дүрэм журам баримталдаг хэнээ гэнэтхэн өөрчлөгдсөн нь итгэмээргүй санагдлаа.

- Тэд түүнийгээ жорлонд авч ороогүй гэж Гермiona зэвүүцэнгүй хариулав.

- Тэд зөвхөн яаж хэрэглэх талаараа л ярьж байсан. Эрлийз хунтайж хүртэл арван хоёр өөр хайрын шингэн үйлчлэлийг зогсоох арга арга олж чадахгүй байх шүү. Чамд зөвлөхөд хэн нэгнийг урь тэгвэл бусад нь ойлгоод зогсох болно. Энэ маргааш орой болохоор тэд бүр шийдсэн байгаа.

- Би хэнийг ч урихыг хүсэхгүй байна гэж Харри бувтнаад Жиннигийн тухай бодохгүй байхыг хичээлээ. Тэр түүний зүүдэнд байнга орж байгаа учир ... Роныг легилменций эзэмшээгүй явдалд баяртай байлаа.

- Ер нь болгоомжтой байж Ромилда Вейн юу ч өгсөн битгий уугаарай.

Минийхээр бол тэр ноцтойгоор хандаж байгаа шүү гэж Гермiona баргар төгсгөв.

Тэр урт хуйлаастай цаас дэлгээд шидэт тооны ухааны зохион бичлэгээ үргэлжлүүлэн үзгээрээ сараачиж эхлэв. Харри түүн рүү харахдаа өөр зүйлийн тухай бодлоо.

- Сонсооч би Филчийг «Уизлийн шидэт эдлэлүүд» дэлгүүрийн бараа таваарыг хориглосон гэж бодсон юмсан?

- Хэн Филчийг хоригийг авч хэлцэх юм? гээд Гермiona зохион бичлэгээсээ хөндийрсөнгүй.

- Гэхдээ би бас шуудангийн уулийг шалгаж байгаа гэж бодож байна. Энэ охид яаж хайрын ундаагаа сургуульд оруулж ирсэн юм бол?

- Фред, Жорж хоёр тэдэнд ханиалгын уусмал болон үнэртэй усны дор хийж явуулсан. Энэ нь тэдний уулийн шуудангийн захиалгын нэг хэсэг нь.

- Чамайг энэ бүхний учрыг сайн мэдэж байгааг чинь харж байна. Гермiona түүн рүү уурсан харснаа,

- Энэ чинь зун тэдний Жинни бид хоёр үзүүлсэн уусмалын тайлбар дээр бичээстэй байсан гэж хүйтнээр хэлээд,

- Чинийхээр бол би хүмүүсийн уусмалыг шалгаж ... муу зүйл байгаа эсэхийг нь үзэж байх болж байна уу ... гэв.

- За яахав гэж Харри түргэн хэлээд,

- Хэргийн учир гэвэл Филчийг мангууруулж болно гэдэгт байгаа юм. Охид сургуульд хориотой эд зүйлийг далдлан оруулж байна! Тэгвэл Малфой яагаад зүүлт оруулж ирж чадахгүй гэж? гэв.

- Өө, Харри минь ... зөвхөн битгий эхэлж үзээрэй дээ!

- Үгүй ээ сонсооч яагаад үгүй гэж? хэмээн Харри шаардлаа.

- Чи ойлго. Илрүүлэгч хараал, нууцалсан шидийг илрүүлдэг ойлгомжтой юу?

Тэднийг хэрэглэсэн хар урлагийн болон хар талын зүйлсийг илрүүлдэг юм. Тэр ийм хүчирхэг хараал шингээсэн ямар ч зүүлт байсан илрүүлэх байсан. Гэхдээ тэд ямар нэг буруу үйлчилгээтэй лонхны хувьд үйлчилэхгүй. Ер нь бол хайрын ундаа хар шидийнх биш тэд аюулгүй.

- Чамд ярихад амархан л байгаа даа гэж Харри бувтнаад Ромильда Вейний тухай бодлоо.

- Филч тийм ч сайн биш шидтэн биш болохоор ханиалгын уусмал дор юу байгааг төсөөлөөгүй байх. Тэгээд ч би түүнийг нэг уусмалаас нөгөөг нь ялгаж чадна гэдэгт эргэлзэж байна ...

Гермиона үгээ дуусгалгүй чимээгүй боллоо. Харри харанхуй тавиурын цаана хэн нэгэн явах чимээ сонсов. Тэд хөшин хүлээтэл тавиурын араас хатагтай Пинсийн махчин шувуу шиг царай цухуйгаад гартаа барьсан лааны гэрэл хөнхөр хацар, цаас шиг цонхигор арьс, урт махигар хамрыг нь таагүйхэн гэрэлтүүлэв.

- Номын сан хаасан. Номоо байранд нь тавихаа бүү мартаарай ... энэ чинь одоо юу вэ? Чи ном гэмтээсэн юм уу, хүү минь?

- Энэ номын сангийх биш, минийх! гээд Харри ширээн дээрээс номоо авахад тэр ясан сарвуугаараа шүүрэн авлаа.

- Ямар муухай юм бэ! Бүдүүлэг зан! Доромжлол! гэж тэр хашгирав.

- Зөвхөн хэдхэн бичээс! гэж Харри цагаатгаад сурах бичгээ хуруунаас нь угз татан авлаа.

Хатагтай Пинс түүн рүү одоохон булааж авах гэж байгаа аятай харлаа. Гермiona яаран юмаа цүнхлээд Харрийн гараас чирэн гарах хаалга руу зүглэв.

- Болгоомжтой байхгүй бол тэр чиний номын санд орохыг хориглож мэднэ!

Яах гэж энэ тэнэг номыг авчирсан юм бэ?

- Гермiona хэрвээ түүнд галзуу авир байгаа бол би буруугүй! Эсвэл тэр Филчийн тухай чиний хэлснийг сонссон юм болов уу? Надад үргэлж тэдний хооронд юм байх шиг санагддаг байсан ...

- Ха-ха!

Харри, Гермiona хоёр хоосон хонгилоор амралтын өрөөнд хүрэхдээ Филч, хатагтай Пинс хоёрын нууцлаг дурлалын тухай ярилцлаа.

- Зул сарын бөмбөлөг! гэж Харри тарган хатагтайн баярын шинэ нууц үгийг хэллээ.

- Чамд ч гэсэн зул сарын мэнд хүргэе! гээд тарган хатагтай инээд алдаад нээгдэн тэднийг оруулав.

- Сайн уу, Харри! гэж Ромильда Вейн Харриг хөргөн нүхээр дөнгөж ормогц хэлээд,

- Халуун ус уух уу? гэв.

Гермiona түүн рүү «би чамд хэлсэн биз дээ?» гэсэн байртай харав.

- Үгүй баярлалаа. Би тийм ч их дуртай биш гэж Харри түргэн хэлэв.

- Тэгвэл үүнийг ав гээд Ромильда түүнд хайрцагтай чихэр сунгав.

- Шоколадан тогоо дотроо галт шарзаар дүүрэн. Эмээ надад явуулсан ч би дургүй л дээ.

- Өө ... их баярлалаа гээд Харри өөр үг бодож олж чадсангүй. Э-э ... би одоохон явах хэрэгтэй ...

Тэр үгээ дуусгалгүй Гермionaгийн араас гүйлээ.

- Би чамд хэлсэн биз дээ. Хэн нэгнийг урих хүртэл чинь тэд чамаас салахгүй ... Тэгтэл түүний царай гэнэтхэн Рон, Лаванда хоёр нэг сандал дээр тэврэлдэн суухыг хараад хоосон болов.

- Тавтай нойрсоорой, Харри гээд хэдийгээр ердөө долоон цаг болж байсан ч охидын унтлагын өрөө рүү өөр нэг ч үг хэлэлгүй орлоо.

Харри унтахаар явахдаа Слизнортын үдэшлэг болоход ердөө ганц өдөр үлдсэн бөгөөд дараа нь Роны хамт Үүрэнд очих тухайгаа бодлогоширов. Одоо түүнд Рон, Гермiona хоёрыг амралт эхэлтэл эвлэрүүлэх нь боломжгүй санагдаж салахынхаа өмнө ямар нэг юм бодох байх гэж найдав ...

Маргааш өдөр нь Харрийн найдлага тэдэнтэй хувиргалын хичээлд суусныхаа дараа бөхөв. Тэдэнд хүнийг хувиргах тухай итгэмээргүй хүнд сэдэв орж толины өмнө

сургуулилан хөмсөгнийхөө өнгийг өөрчлөх ёстой байлаа. Рон эхний оролдлогоороо сахалтай болсонд Гермиона шоолон инээлээ. Рон уурсан хариуд нь түүнийг хэрхэн профессор МакГонагаллын асуултанд хариулахаар гар өргөх өнгөлзөх болгоныг дуурайж элэглэхэд Лаванда, Парвати хоёр баясан инээж Гермиона золтой л уйлсангүй. Тэр ангиас хонх жингэнэнгүүт үсрэн гарахдаа ширээн дээр юмныхаа хагасыг орхичихлоо. Харри одоо түүнд Ронноос илүү Гермиона хэрэгтэй гэж бодоод юмыг нь цуглуулан хайхаар яваад эцэст нь эмэгтэйчүүдийн жорлонгоос нуруун дээр нь аргадан илэх Полумна Лавгудтай хамт гарч ирэхийг харлаа.

- Өө, сайн уу, Харри. Чиний нэг хөмсөг чинь шаргал болсныг мэдэж байна уу? гэж Полумна хэлэв.

- Сайн уу, Полумна. Гермиона чи ангид юмаа мартчихаж ... Тэр түүнд сурах бичгийг нь өглөө.

- Өө, тийм л дээ гээд Гермиона номоо авч эргэхдээ түргэхэн харандааны саваар нүдээ арчлаа.

- Баярлалаа, Харри. Би явсан нь дээр байх ...

Түүнийг яаран явахад Харри тайвшируулах үг хэлж амжсангүй үнэндээ юу ч бодож олж чадсангүй.

- Тэр жаахан сэтгэлээр уначихаж. Би эхлээд тэнд уйланхай Миртл байгаа юм болов уу гэж бодсон ч Гермиона байсан. Тэр Рон Уизлийн тухай ямар нэг зүйл ярьсан ...

- Тиймээ тэд маргалдсан гэж Харри хэлэв. Тэд хамтдаа хонгилоор явлаа.

- Тэр заримдаа их инээдтэй зүйлийн талаар ярьдаг тийм үү? Гэхдээ заримдаа жаахан хэрцгий байдаг. Би үүнийг өнгөрсөн жил ажигласан.

- Тиймээ, магадгүй л юм гэж Харри хэлэв. Полумна үргэлжид байдаг шигээ таагүй үнэнийг хэлдэг авъяастай билээ. Харри хэзээ ч ийм хүнтэй таарч байсангүй.

- Чи хэр байна даа? Хагас жилийг сайхан өнгөрүүлэв үү?

- Тиймээ, муугүй. ДА-гүй жаахан уйтгартай байлаа. Гэхдээ Жинни надтай сайн харьцаатай байдаг юм. Тэр саяхан хоёр хүүг хувиргалын хичээл дээр намайг хагас ухаантай гэж нэрлэхийг зөвшөөрөөгүй ...

- Чи надтай Слизнортын үдэшлэгт явахыг хүсч байна уу?

Энэ үг Харрийн амнаас зогсоож амжихаас өмнө гараад гэнэтхэн өөрийнхөө хоолойг нөгөө өнцгөөс сонслоо.

Полумна түүн рүү гайхан харлаа.

- Слизнортын үдэшлэг гэнээ? Чамтай юу?

- Аанхан. Биднийг зочин авчирахыг зөвшөөрхөн болохоор би чамайг хүсвэл ... гэхдээ би ... гээд санаагаа тодруулахын тулд,

- Зөвхөн найз нөхдийн хувьд гэж ойлгож байгаа биз дээ. Хэрвээ чи хүсэхгүй байгаа бол ... гэв.

Тэр хэдийн зөвшөөрөхгүй байгаасай гэж найдаж эхэлжээ.

- Үгүй дээ, надад чамтай найзын зүгээс явах нь их аятайхан байна! гэж Полумна Харрийн нэг ч удаа харж байгаагүй аз жаргалтай инээмсэглэн хэлэв.

- Хэн ч намайг найзын хувьд үдэшлэгт урьж байгаагүй! Чи энэ үдэшлэгт зориулан хөмсгөө будсан юм уу? Би бас тэгэх үү?

- Энэ эндүүрэл болсон юм. Би явж Гермionaг засахыг гуйхаас. Зам найман цагаас үүдний танхимд уулзая гэлээ.

- Аанхан! гэх дуу дээр нь сонсогдоход хоёул цочлоо. Тэд Пивзийн дор ярьж буйгаа ажигласангүй. Тэр толгойгоо уруу харуулан бүрхүүлээс зүүгдээд хорон инээмсэглэж байв.

- Потти Солиотыг үдэшлэгт урилаа! Потти Солиотод хайртай болж! Потти Солиото-о-о-о-д ха-а-а-а-а-айртай болж! гэж тэр цааш эргэлдэн хөөрөөд хашгирлаа.

- Потти Солиотод хайртай болж!

- Чиний хувийн амьдралд хэн ч оролцдоггүй нь ямар таатай юм гэж Харри хэлэв.

Тэгтэл ч үнэхээр түүнийг эргэн харж амжаагүй байтал сургууль даяар Харри Поттер Полумна Лавгудыг Слизнортын үдэшлэгт урьсан нь тодорхой болов.

- Чи өөр хэнийг ч урьж болох байсан! Хэнийг ч! Харин чи хагас ухаантай Лавгудыг сонголоо? гэж Рон оройн хоолон дээр үл итгэн дуу алдав.

- Түүнийг битгий тэгж нэрлэ, Рон! гэж Харрийн ард найзуудтайгаа зогсож байсан Жинни огцом хэлээд,

- Харин чи түүнийг урьсан чинь их сайн байна, Харри. Тэр их жаргалтай байгаа гэв.

Ингэж хэлээд тэрбээр цааш явж Дины сууж байгаа газар очлоо. Харри Жинни Полумнаг урьсанд баяртай байгаад баярлахыг оролдсон ч энэ нь бүтсэнгүй. Гермiona ширээний төгсгөлд ганцаараа суугаад тавган дээрх сэрээгээрээ оролдож байлаа. Харри Рон түүний зүг сэмхэн харж байхыг ажиглав.

- Чи уучлал гуйх хэрэгтэй байх гэж Харри хэлэв.

- Түүнийг над руу сүрэг шувууд дайруулсны төлөө юу? гэж Рон бувтналаа.

- Чи яах гэж түүнийг дуурайн элэглэсэн юм?

- Тэгвэл тэр миний сахлыг шоолж инээсэн!

- Би ч гэсэн инээсэн. Амьдралдаа хэзээ ч тийм тэнэг зүйл харж байсангүй.

Гэвч Рон сонссонгүй бололтой ширээнд Лаванда, Парвати хоёр ойртон ирлээ. Харри Рон хоёрын дундуур Лаванда шургалан түүний хүзүүгээр тэврэн авлаа.

- Сайн уу, Харри гэж Парвати хэлэв.

Түүнд ч гэсэн амаргүй байлаа. Дэргэд нь найз нь өөр хүнтэй байхад хийх зүйл юу байх билээ.

- Сайн уу. Юу байна даа? Чи Хогвартсад үлдэх үү? Би эцэг эх чинь чамайг авахыг хүссэн гэж сонссон.

- Би тэдэнтэй яриад зохицуулсан. Кэтигийн түүх тэднийг айлгасан ч үнэндээ айх зүйл юу ч байгаагүй ... Өө, сайн уу, Гермiona!

Парвати хүчлэн инээмсэглээд Гермiona руу хувиргалын хичээл дээр шоолон инээсэндээ гэмшсэн байртай харагдав. Тэгтэл Гермiona хариу зальжин инээмсэглэхийг Харри харлаа. Охид заримдаа маш хачирхалтай байх юм даа ...

- Сайн уу, Парвати! гэж Гермiona Рон, Лаванда хоёрыг үл ойшоон хэлээд,

- Чи өнөөдөр Слизнортын үдэшлэгт очих уу? гэв.

- Хэн ч намайг уриагүй гэж Парвати гашуудалтай хэлэв.

- Гэхдээ би явахыг хүсч байна. Тэнд гайхамшигтай байх даа ... харин чи явах уу?

- Тиймээ, би Кормактай найман цагаас уулзахаар тохирсон, бид ...

Энэ үг угаагуурын бөглөрөл арилгаж байгаа бүлүүр шиг сонсогдож Рон Лавандагын тэврэлтээс мултарлаа. Гермiona юу ч харж сонсоогүй дүр эсгэв.

- ... бид хоёр хамтдаа үдэшлэгт явах гэж байгаа юм.

- Кормак гэнээ? Кормак Маклагген уу? гэж Парвати асуув.

- Яг тийм гэж Гермiona хэлээд,

- Бараг л ... Гриффиндорын хаалгач болчихоогүй хэмээн «бараг» гэсэн үгээ тодотгон хэлэв.

- Чи одоо түүнтэй уулздаг болоо юу? гэж Парвати хомхойрон сониучирхав.

- Өө тийм л дээ, чи мэдээгүй байгаа юм уу? гээд тэр Гермionaгийн бус инээд алдав.

- Үгүй! гээд Парвати тийм мэдээнд нүдээ томруулснаа,

- Чамайг квиддичийн тоглогчдод дуртайг харж байна! Эхлээд Крам, одоо Маклагген ... гэв.

- Би квиддичийн сайн тоглогчдод дуртай гэж Гермiona инээмсэглэн засаад,

- За баяртай! Явж үдэшлэгт бэлтгэх хэрэгтэй байна ... гэв.

Тэр явчихлаа. Лаванда, Парвати хоёр даруйхан Маклаггены талаар сонссон гайхалтай сонинг шивнэлдэж эхлэхэд Рон хачирхалтай хоосон харцтай суугаад юу ч хэлсэнгүй. Харри чимээгүйхэн охидын өшөө авах арга гэж бодлоо.

Оройн найман цагаас үүдний танхимд буугаад Харри дасал болоогүй дүр зураг харлаа. Үүдний танхимд дүүрэн охид зогсоод түүнийг Полумна руу очихыг гомдонгуй ширтэж байв. Тэр гялтагнасан мөнгөлөг даашинз өмссөн нь үзэгчдийн инээдийг хүргэсэн ч өөр өнцгөөс бол аятайхан харагдаж байлаа. Харри ямар атугай түүнийг өнөөдөр луувантай ээмэг, цөцгийн шар айрагны бөглөөтэй зүүлт болон солонгорсон нүдний шилээ зүүгээгүйд баяртай байлаа.

- Сайн уу. Явах уу?
- Өө, тэгэлгүй яахав! Харин үдэшлэг хаана болох юм? гэж Полумна баяртай хэлэв.
- Слизнортын ангид гээд Харри түүнийг хөтлөн гантиг шатаар дагуулан явахад ард нь шивнэлдсэн үзэгчид үлдэв.
- Үдэшлэгт цус сорогч ирнэ гэж сонссон уу?
- Руфус Скримжер уу?
- Юу? гэж Харри гайхан асуулаа. Чи ид шидийн яамны сайдыг хэлж байна байна уу?
- Тиймээ, тэр цус сорогч гэж Полумна энгийнээр хэлээд,
- Аав энэ тухай Скримжер Корнелиус Фажын суудлыг залгамжлан авахад урт нийтлэл бичсэн. Гэхдээ ид шидийн яамнаас энэ тухай хэвлэхийг хориглосон л доо. Харваас тэд үнэнийг мэдэгдэхийг хүсээгүй бололтой! гэв.

Харри хариулсангүй ч Руфус Скримжер цус сорогч гэдэгт итгэхэд бэрх байсан ч тэр эртнээс Полумна эцгийнхээ этгээд үзэмжийн тухай ярьдагт дассан байсан юм. Тэднийг Слизнортын өрөөнд ойртон ирэхэд инээд яриа хөөр, хөгжмийн чимээ чангарав.

Слизнорт ямар нэг шидийн төрөл ашиглан өрөөгөө ердийн багшийн өрөөнөөс илүү том болгожээ. Хана адарт маргад ногоон, улаан хүрэн алтан хөшиг унжуулсан нь том цацар дотор байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлнэ. Өрөөнд дүүрэн хүн байсан тул бүгчим халуун байж адрын голоос өлгөсөн алтлаг дэнлүүний улаан гэрэлд жинхэнэ шидэт дагинас хурц гэрэл татуулан нисэж байлаа. Алсын буланд ямар нэг хөгжмийн зэмсгээр чанга хөгжимдөн дуулах нь мандолин юм шиг сонсогдов. Хэдэн гүнзгий яриа өрнүүлж буй ахимаг насны шидтэний толгой дээгүүр утаан үүл суунаглана. Гэрийн үйлчлэгч нар хөлийн доогуур часхийн гүйлдэж хүнд мөнгөлөг тавиуртай хоол зөөх нь өөрөө явдаг жижигхэн ширээ шиг харагдаж байлаа.

- Харри, хүү минь! гэж Слизнорт Харри, Полумна хоёрыг хаалгаар ормогц дуу алдаад,
- Орцгоо, орцгоо би та нарыг олон хүнтэй танилцуулахыг хүсч байна! гэв.



Слизнорт шовгор оройтой хилэн цацагтай малгай мөн тийм эдээр хийсэн хүрэм өмсчээ. Тэр Харрийн гарыг хаа нэг тийш хамт шилжих гэж байгаа юм шиг чанга атгаад зочдын гүнд оруулав. Харри Полумнагийн гараас барин араасаа чирлээ.

- Харри, танилц энэ бол урьд нь миний сурагч байсан Элдред Уорпл «Цусан ах дүүс. Цус сорогчдын дунд өнгөрүүлсэн амьдрал» нэртэй номын зохиогч бас түүний найз Сангвини.

Уорпл гэдэг жижигхэн булиа бие нүдний шилтэй хүн Харри руу урам зоригтой гар сунгаад сэгсрэхэд өндөр, туранхай, нүднийхээ доогуур хар хүрээтэй цус сорогч Сангвини үл мэдэг толгой дохив. Түүний байдал уйдсан янзтай байлаа. Дэргэд нь хөхрөлдсөн охид ойртон зогсоход сониучирхан харлаа.

- Харри Поттер, би баяртай байна, маш баяртай байна! гэж Уорпл Харрийн нүүрийг ойроос ширтэн хэлээд,

- Би профессор Слизнорттой «Харри Поттерын намтар хаана байна бид түүнийг хүлээгээд байгаа шүү» гэсэн сэдвийн тухай ярьж байлаа? гэв.

- Э-э ... хүлээж байсан гэнээ?

- Юутай даруухан билээ! Яг л Горацийн хэлсэн шиг юм! гэж Уорпл дуу алдсанаа, Гэхдээ, чухалчлан хэлэхэд гээд хоолой нь гэнэтхэн ажил хэрэгч өнгөтэй болж,

- Би үүнийг өөрийн биеэр бичихдээ баяртай байх болно. Хүмүүс таны тухай ихийг мэдэхийг хүсч байна, хонгор хүү минь зүгээр л ангаж цангаж байна! Хэрвээ та надад хэдэн сурвалжлага өгөхийг зөвшөөрвөл дөрөв таван цагийн дараа шуугиан тарьж бид номоо сарын дараа дуусах юм. Энэ бүхэн таны зүгээс маш бага чармайлт шаардах болно гэдгийг би итгүүлэн хэлэх байна ... Сангвини байрандаа үлд! гэж Уорпл гэнэтхэн ширүүн зандрахад цус сорогч өлсгөлөн нүдээ гялалзуулсаар ойролцоох охид руу дөхөн очсон байлаа.

- Май бялуу ав! гээд Уорпл дэргэдүүр өнгөрсөн үйлчлэгчийн тавиуртай бялуунаас Сангвинигийн гар дээр тавиад ахин Харри руу эргэж,

- Хонгор хүү минь, та багахан алт төлөх юм бол юу болохыг төсөөлж чадахгүй дээ гэв.

- Би үүнийг сонирхохгүй байна гэж Харри шийдэмгий хэлээд,

- Уучлаарай би таньдаг хүнээ харлаа ... гэв.

Тэр Полумнаг цугласан хүмүүсийн дундуур дагуулсаар өтгөн хүрэн үс цухалзаад алга болсон «Эмгэн шулмас» хамтлагийн гишүүдийн зүг явлаа.

- Гермiona! Гермiona!

- Харри! Бурханы авралаар чи ирлээ! Сайн уу, Полумна!

- Чи яагаа вэ? гэж Харри асуухад Гермiona саяхан чөтгөрийн ургамлын савраас мултарсан мэт сэгсийсэн төрхтэй байлаа.

- Өө, арайхийж мултарлаа ... би Кормакаас гэж хэлэх гэсэн юм гэж Харригийн асуунгуй харцны хариуд хэлээд,
- Омелын дор гэв.
- Чи түүнийг урих хэрэггүй байсан юм гэж Харри хэлэв.
- Би Роныг тэр л уурлуулах байх гэж бодсон юм. Эхлээд Захария Смитыг урих гэснээ дараа нь ...
- Чи Смитыг урихыг хүссэн гэнээ? хэмээн Харри зэвүүцэн асуулаа.
- Тиймээ, хүссэн ч сонгосон хойноо харамссан. Маклагтены дэргэд Грохх жинхэнэ женгельмен. Эндээс холдоцооё аягүй бол бид харагдаж магадгүй тэр өндөр болохоор ...

Гурвуулаа өрөөний нөгөө өнцөг руу очих замдаа хэтэрхий оройтсон хойноо хананы дэргэд профессор Трелони ганцаар зогсож байхыг ажиглажээ.

- Сайн байна уу гэж Полумна эелдэгээр хэлэв.
- Оройн мэнд, хонгор минь гээд профессор Трелони Полумна руу төвлөрөн харахад Харри ахин дарсны үнэрийг мэдрэв.
- Таныг хичээл дээрээ удтал харсангүй ...
- Энэ жил бидэнд Флоренц орж байгаа.
- Аан тийм л дээ гээд профессор Трелони согтуу уурсан хөхөрч,
- Эсвэл бөгтөр морь гэх юмуу би түүнийг тэгж нэрлэж байгаа. Намайг сургуульд эргэж ирмэгц профессор Дамблдор энэ мориноос ангижрах хэрэгтэй байсан юм? Гэтэл үгүй ... биднийг ангиудыг хуваасан ... нэг үгээр хэлэхэд энэ бол доромжлол! Тиймээ та нар мэднэ дээ ... гэв.

Профессор Трелони халамцуу байсан тул Харриг таньсангүй. Тэр Флоренцыг уурсан харааж гарахад Харри Гермиона руу бөхийгөөд аяархан,

- Алив нэг зүйл тайлбарлаадах. Чи Ронд хаалгачын сорилтонд хожиход тусалсанаа хэлэх гэж байна уу? гэв.

Гермиона хөмсгөө өргөлөө.

- Чи үнэхээр намайг тэгж доошоо орно гэж бодож байна уу? Харри түүн рүү харлаа.
- Гермиона хэрвээ чи үдэшлэгт Маклаггентай явж чадаж байгаа бол ...
- Энэ бол өөр хэрэг. Би Ронд хаалгачын сорилтын талаар юу ч хэлэхгүй гэж тэр бардам хэллээ.
- Сайн байна гээд Харрийн санаа амарлаа. Хэрвээ тэр ахиад сэтгэлээр уначихвал бид дараагийн тэмцээнд хожигдох болно ...
- Квиддич! гэж Гермиона уурсан дуу алдлаа. Та нар үүнээс өөр юу ч сонирхдоггүй юм уу? Кормак надаас нэг ч асуулт асуулгүй «Тиймэрхүү зуун

бөмбөгийг Кормак Маклагген хааж чадах байсан» гэж эцэс төгсгөлгүй давтсан ... Өө ээж минь, тэр наашаа ирж байна!

Тэр шилжсэн юм шиг түргэн алга болж хөхрөлдөж буй шидтэнгүүдийн дундуур чихэн алга болов.

- Гермionaг харав уу? гэж Маклагген хормын дараа цугласан хүмүүсийн дундуур зүтгэлэн ирээд асуулаа.

- Харамсалтай нь үгүй гэж Харри хэлээд Полумна руу түргэн эргэлээ.

- Харри Поттер! гэж профессор Трелони чичирсэн хоолойгоор хэллээ. Тэр түүний байгааг сая л ажиглажээ.

- Сайн байна уу гэж Харри урамгүйхэн мэндлэв.

- Хүндэт хүү минь! Хичнээн их цуу яриа! Хичнээн их хов жив дэгдэж байна!

Сонгогдсон! Би үүнийг эртнээс мэдэж байсан юм ... чамд гай зовлон тохиолдоно гэдгийг мэдэж байсан, Харри ... Гэхдээ та яагаад мэргэ төлгийн хичээлийг үргэлжлүүлсэнгүй вэ? Таньд энэ нь олон хүмүүсийг бодвол хамгийн чухал юм шиг санагдах юм!

- Ай даа, Сивилл бид бүгд л өөрсдийн хичээлээ хамгийн чухал гэж боддог! гэх чанга хоолой пролфессор Трелонигийн нөгөө талаас гараад царай нь улайсан Слизнорт нэг гартаа хундагатай дарс, нөгөө гартаа бялуутай гарч ирлээ.

- Гэхдээ би хэзээ ч уусмалын хичээлд ийм авъяастай сурагчтай учирна гэж бодож байсангүй! гээд Слизнорт Харриг улайсан нүдээрээ энхрийлэн харж,

- Яг л эх шигээ! Миний багшлах хугацаанд ийм авъяастай сурагч хэдхэн тохиолдож байсан. Би таньд хэлсэн дээ Сивилл, тэр ч байтугай Северус хүртэл ...

Тэгээд Харрийн айдсыг хүргэн Слизнорт хаа нэгтгээгээс Снеггийг чирж авчрав.

- Нуугдахаа болиод бидэнтэй нэгдээч, Северус! гэж тэр баясгалантай уулга алдаад,

- Би сая Харригийн уусмалын гайхалтай авъяасын тухай ярьж байлаа! Та Харрид таван жилийн турш багшилсан болохоор үүнд үнэмших байх! гэв.

Слизнортын гар мөрөн дээгүүр нь тэвэрсэнд хавханд орсон Снегг унжуу хамраа доошлуулан Харри руу нүдээ нарийсган харлаа.

- Хөгжилтэй нь надад хэзээ ч Поттерд ямар нэг юм сургасан гэсэн сэтгэгдэл төрөөгүй юмсан.

- Энэ чинь төрөлхийн авъяас байгаа юм! Тэр миний хамгийн эхний хичээл дээр яасныг харсан ч болоосой! Амьд үхлийн ундаа ... өөр нэг ч сурагч тийм гайхалтай үр дүнг анхны оролдлогоороо гаргаж байгаагүй юм даа. Би таныг ч гэсэн тэгж бодож байна, Северус ...

- Тийм гэж үү? хэмээн Северус аяархан хэлээд Харри руу үргэлжлүүлэн харлаа.

Тэгтэл түүнд Снегг хаанаас ийм уусмалын хичээлийн гялалзсан авъяас гарч ирснийг мөрдөн шалгах вий гэсэн бодол төрөв.

- Таныг ямар хичээлээр үргэлжүүлэн суралцаж байгааг хэлээч, Харри? гэж Слизнорт асуулаа.
- Хар урлагаас хамгаалах хичээл, шившлэг, хувиргал, ургамал судлал ...
- Товчхон хэлэхэд мракоборец болоход шаардлагатай бүхэн гээд Снегг үл мэдэг мушийлаа.
- Тиймээ, би үүнийг л хүсч байгаа гэж Харри хэлэв.
- Та агуу мракоборец болно! гэж Слизнорт нүргэлүүлэв.
- Би чамайг мракоборец болж хэрэггүй байх гэж бодож байна, Харри гэж Полумна гэнэтхэн ярианд оролцов. Бүгд түүн рүү харлаа.
- Мракоборецууд ялзарсан хуйвалдаанд оролцдог болохыг хүн бүр мэднэ гэж бодож байна. Тэд ид шидийн яамны дотор хар урлагыг хөгжүүлэхэд тусалдаг.

Харри инээд алдаад ууж байсан ундаандаа хахаж цацчихлаа. Үнэнийг хэлэхэд Полумнаг ийш нь авчирсандаа энэ агшинд баяртай байв! Цомтойгоо цацлуулан ханиалган инээснээ гэнэтхэн сэтгэл санаа нь дээрдэх зүйл харлаа. Драко Малфойн чихнээс Аргус Филч бариад зогсож байв.

- Профессор Слизнорт гэж Филч сөөнгөтөөд эрүү нь чичигнэн шийтгэл хүлээлгэх гал бүлтгэр нүдэнд нь гялсхийж,
- Би энэ сурагчыг нэг давхарын дээр хонгилд барилаа. Тэр таны үдэшлэгт уригдаад бага зэрэг хоцорсон гэж баталж байна. Та түүнийг уриа юу? гэв.

Сэтгэлээр унасан Малфой Филчийн гараас мултараад,

- За яахав, намайг уриагүй! Би урилгагүй ирэхийг хүссэн юм. Та сэтгэл хангалуун байна уу? гэж ууртай хэлэв.
- Үгүй, сэтгэл хангалуун биш байна! гээд Филч хачирхалтай баяр хөөр царайдаа тодруулж,
- Чи асуудалд орсон байна! Захирал шөнийн цагаар хонгилд гарахыг хориглосон биз дээ? гэв.
- Бүгд хэвийн, Аргус бүх зүйл хэвийн гээд Слизнорт гараа савчин,
- Одоо зул сар болж байгаа болохоор баярт ирэхийг хүсэх нь гэмт хэрэг биш.

Зөвхөн энэ удаа шийтгэлийг мартаж үз. Үлдэж болно, Драко гэлээ.

Филчийн царай урам хугарсан гонсойсон ч Харри Малфой руу хараад яагаад золгүй харагдаж байгааг нь гайхлаа. Бас яагаад Снегг Малфой руу ийм их ууртай магадгүй айдас дүүрэн харж байгаа юм бол?

Гэхдээ Харри сэтгэгдлийнхээ учрыг олж амжихаас урьтаж Филч цааш хөлөө чирсээр бувтнан явлаа. Малфой Слизнортод талархан инээмсэглэхэд Снеггийн царай ахин ойлгомжгүй болов.

- Зүгээр дээ, зүгээр гэж Слизнорт Малфойн талархалд савчаад,
- Эцсийн эцэст би өвөөг чинь таньдаг байсан юм... гэв.
- Тэр таны тухай үргэлж хүндэтгэлтэй ярьдаг байсан, ноёнтоон гэж Малфой яаран хариулаад,
- Танаас илүү уусмалын сайн мастерыг мэдэхгүй гэж хэлсэн гэв.

Харри Малфой руу нүд салгалгүй ширтлээ. Тэрбээр багшид долигносон явдалд нь гайхсангүй энэ бол Снеггийн хичээлийн хэтэрхий танил дүр зураг байлаа. Гэхдээ гайхсаны учир гэвэл Малфой өвдсөн юм шиг харагдах аж. Харри түүнийг эртнээс ойроос хараагүй болохоор одоо л нүдэн дор нь хар сүүдэр татаж арьсны өнгө нь саарал болсныг харав.

- Би таньтай ярих хэрэгтэй байна, Драко гэж Снегт гэнэтхэн хэлэв.
- Яалаа гэж дээ, Северус гээд Слизнорт зогьсуулснаа,
- Одоо зул сар болж байгаа болохоор хэтэрхий ширүүн байх хэрэггүй ... гэлээ.
- Би түүнийг тэнхимийн эрхлэгч болохоор ширүүн бус харьцах эсэхээ өөрөө шийднэ. Намайг дага, Малфой.

Тэд өрөөнөөс гарлаа. Снегт түрүүлж явахад Малфой араас нь дургүйхэн дагав. Харри хормын турш тээнэгэлзэн зогссоноо Полумнад,

- Би түргэн ... угаалгын өрөө ороод ирье гэв.
- Сайн байна гэж тэр хөгжилтэй хэлээд Харриг хүмүүсийн дундуур яаран шургалахад харваас энэ тухай сонирхож байгаа бололтой профессор Трелонитой хуйвалдааны тухай яриагаа сэргээв.

Хонгилд хэн ч байсангүй. Тэр халааснаасаа үл үзэгдэх цуваа гарган нөмөрлөө. Малфой, Снегт хоёр үзэгдсэнгүй. Харриг хонгилоор гүйхэд хөлийн чимээ нь Слизнортын өрөөнөөс дуулдаж буй хөгжим, чанга ярианд дарагдав. Магадгүй Снегт Малфойг газар дорхи өрөөндөө аваачсан юм болов уу? Эсвэл Слизеринчүүдийн амралтын өрөөнд аваачсан хэрэг үү? Юутай ч гэсэн Харри хаалга болгонд чихээ наан гүйж байснаа сүүлчийн ангийн цоожны нүхээс хоолой сонсогдохыг сонсоод ихэд баярлав.

- Алдаа гаргаж болохгүй тэгвэл Драко таныг сургуулиас хөөх болно ...
- Би яагаа ч үгүй ойлгомжтой юу?
- Би таныг үнэн хэлсэн гэж найдаж байгаа ч энэ бүхэн чинь болхи бүдүүлэг тэнэг хэрэг юм. Таныг хэдийн сэжиглэж эхэлсэн.
- Хэн намайг сэжиглэх юм? гэж Малфой ууртай хэлээд,

- Сүүлчийн удаа хэлье, би үүнийг хийгээгүй ойлгов уу? Тэр Белл гэдэг охинд дайсан байсан эсэхийг хэн мэдэх юм бэ ... Над руу ингэж харах хэрэггүй шүү! Би таныг юу хийж байгааг мэднэ. Би тэнэг биш наадах чинь бүтэхгүй! Би таньд саад болж чадна!

Нам гүм болсноо дараа нь Снегг аяархан,

- Аанхан ... нагац эгч Беллатриса чинь чамайг окклюменцийд сургасныг харж байна. Чи ямар бодлоо эзнээсээ нуухыг хүсээ вэ? Драко? гэлээ.

- Би түүнээс юу ч нуугаагүй. Би зөвхөн таныг бусдын хэрэгт оролцохыг хүсэхгүй байна!

Харри чихээ цоожны нүхэнд чанга наалаа. Малфой Снеггтэй яагаад ингэж хандаж байгаа юм бол тэр үргэлж түүнтэй хүндэтгэлтэй харилцдаг байсан ...

- Тэгвэл яагаад та надаас хичээлийн жилийн эхнээс зугтсан юм бэ? Миний оролцооноос айгаа биз дээ?

- Тэгвэл та намайг хичээлийн дараа үлдээ л дээ! Дамблдорт ховло! гэж Малфой шоолонгуй хэлэв.

Ахин нэг нам гүм болов. Тэгснээ Снегг,

- Та намайг ийм зүйл хийхгүй гэдгийг сайн мэдэж байгаа гэв.

- Тэгвэл намайг өрөөнөөс гаргаадах!

- Намайг сонс гэж Снегг маш аяархан хэлсэн учир Харри бүх хүчээ гарган чихээ цоожны нүхэнд наалаа.

- Би таньд туслахыг хичээж байна. Би ээжид чинь хамгаална гэсэн амлалт өгсөн. Би үл эвдэгдэх амлалт өгсөн, Драко ...

- Тэгвэл таньд түүнийгээ эвдэх хэрэг гарч дээ учир нь надад таны хамгаалалт хэрэггүй! Надад энэ даалгавар оногдсон учраас би өөрөө хийх болно. Тэгээд ч надад төлөвлөгөө байгаа, жаахан л бодох юм бол бүтэх гээд байна!

- Ямар төлөвлөгөө?

- Энэ таны хэрэг биш!

- Хэрвээ чи надад ярих юм бол би тусалж ...

- Баярлалаа надад хэдийн хэрэгтэй бүх тусламж байгаа! Би ганцаараа биш!

- Ямар ч тохиолдолд та өнөөдөрийнх шиг тэнэг алхам хийж хонгилоор хараа хяналтгүй ганцаар тэнүүчилэх юм бол энэ чинь наад захын алдаа ...

- Би Крэбб, Гойл хоёрыг өөртөө авмаар байна. Хэрвээ та тэднийг хичээлийн дараа шийтгэж үлдээхгүй бол!

- Аяархан ярь! гэж Снегг Малфой зандарлаа,

- Хэрвээ таны найз Крэбб, Гойл хоёр энэ жил хар урлагаас хамгаалах хичээлийн С.И.Ш өгсөн бол тэд цаашид илүү анхааралтай байх хэрэгтэй ...

- Энэ чинь хэнд хэрэгтэй юм бэ? Хар урлагаас хамгаалах гэдэг чинь хуурамч зүйл биз дээ? Бидэнд хар урлагаас хамгаалах хэрэгтэй юм бэ!

- Энэ хуурамч зүйл таны амжилтанд хэрэгтэй, Драко! Таныхаар бол би энэ бүх жилүүдэд хуурамч дүр үзүүлээгүй байх нь уу? Харин одоо намайг сонс! Та биеэ болгоомжтой авч явахгүй шөнийн цагаар хонгилоор тэнүүчилэн баригдаж Крэбб, Гойл мэтийн туслагчидтай ...

- Зөвхөн тэд ч биш! Миний талд өөр илүү дээр хүмүүс байгаа!

- Тэгвэл надад тэдний тухай хэл би ...

- Таны юу хэлэх гэж байгааг мэдэж байна! Миний гавъяаг хулгайлахыг хүсээ юу!

Ахин чимээгүй болсноо Снеггийн хүйтэн хоолой,

- Та яг хүүхэд шиг ярьж байна байна. Би эцэг чинь баривчлагдан хоригдсоны улмаас сэтгэлээр унаж байгааг чинь ойлгож байгаа ч ... гэлээ.

Харри агшин зуур хаалганаас холдов. Тэр хаалга руу ирэх Малфойн чимээг сонсоод хажуу тийш болж амжих агшинд саван нээгдлээ. Малфой хонгил рүү түргэн гарч Слизнортын нээлттэй хаалгыг өнгөрөөд булангаар далд оров.

Харри бараг амьсгалахгүй хөшөөд хөдөлж зүрхэлсэнгүй. Снег ангиас удаанаар гарч ирснээ ойлгомжгүй царайтай үдэшлэгт эргэн орлоо. Харри шалан дээр үл үзэгдэх цуван дор суун үлдээд тархи нь хурдтай ажиллав.

## БҮЛЭГ 16: МАШ ХҮЙТЭН ЗУЛ САР

- Тэгэхээр Снегг түүнд туслахыг санал болгосон юм уу? Тэр үнэхээр түүнд туслахыг санал болгосон гэж үү?

- Ахиж нэг удаа асуух юм бол энэ байцаагаар цохьлоо шүү ...

- Би зүгээр л шалгахыг хүссэн юм! гэж Рон хэлэв.

Тэд хоёул Үүрний гал зууханд суугаад хатагтай Уизлийн өгсөн уул овоо шиг их байцааг арилгаж байв. Цонхны цаана цасан ширхэг алгуур хаялана.

- Тиймээ, Снегг түүнд туслахыг санал болгосон! Тэр Малфойн ээжид түүнийг хамгаалахаар үл эвдэгдэх амлалт ч гэлүү өгсөн гэсэн ...

- Үл эвдэгдэх амлалт гэнээ? хэмээн Рон мэгдэн асуугаад,

- Үгүй дээ, тэр чадахгүй ... Чи итгэлтэй байна уу? гэв.

- Тиймээ итгэлтэй байна. Энэ чинь тэгээд юу гэж байгаа юм?

- Үл эвдэгдэх амлалтыг эвдэх боломжгүй.

- Хачирхалтай нь би үүнийг хэдийн ойлгосон. Эвдвэл юу болох юм бэ?

- Тэр үхнэ. Намайг таван настай байхад Фред, Жорж хоёр тийм амлалт авахыг оролдсон юм. Би үүнийг хийхээр Фредийн гараас бариад байтал аав ороод ирсэн. Тэр арай л ухаан солиороогүй гээд Роны нүд энэ дурсамжинд гялалзсанаа,

- Би тэгэхэд цорын ганц удаа аавыг ээжээс илүү уурлахыг харсан юм байна.

Фред тэр өдрөөс хойш зүүн талын өгзөг нь нөгөөтэйгээ хэзээ ч адилгүй болсон гэж бодож байгаа.

- За, Фредийн зүүн талын өгзөгөөр тоглох ч яах вэ ...

- Өршөөгөөрэй? гэх Фредийн хоолой сонсогдоод гал зууханд ихрүүд орж ирлээ.

- Хөөх, Жорж чи тэднийг юу хийж байгааг хар даа. Тэд хутга ашиглаж байна гэж бодоод үз дээ.

- Би хэдхэн сарын дараа арван долоо хүрнэ. Тэгвэл шидийн тусламжтай үүнийг хийж чаддаг болно! гэж Рон бувтнав.

- Гэхдээ энэ хооронд бид энэ үзэгдлийг зөв хийж байгаа эсэхийг цэнгэн харж болох нь! гээд Жорж гал зуухны ширээн дээр хөлөө тавин суулаа.

- Энэ бүхэн чамаас болсон! Намайг арван долоон нас хүрэхийг хүлээж л байгаарай ... гэж Рон уурсан орилохдоо эрхий хуруугаа эсгэчихлээ.

- Чамайг тэр үед биднийг урьд өмнө мэдэгдээгүй байсан шидийн чадвараараа гайхшируулна гэдэгт итгэлтэй байна гээд Фред эвшээлээ.



- Ингэхэд урьд өмнө мэдэгдээгүй шидийн чадвар гэснээс, Рональд! Жинни чи болон залуу хатагтайн чинь тухай ярьж байхыг сонслоо ... хэрвээ буруу сонсоогүй бол ... Лаванда Браун гэлүү?

Рон улайгаад таагүйхэн байцаа арилгахаар эргэв.

- Энэ чиний хэрэг биш!

- Ямар хатуу хариулт вэ. Чамайг ийм хүчтэй үг хаанаас олсныг төсөөлж ч чадахгүй нь. Үгүй дээ, бид зөвхөн ганц л зүйлийг мэдэхийг хүсч байна ... энэ бүхэн яаж болсон юм бэ?

- Юу болсон гэж?

- Тэр осолд юмуу өөр зүйлд болсон юмуу?

- Юу гэнээ?

- Золгүй нь гэвэл хөөрхий амьтан тархины гэмтэлтэй юм байна. Хөөе, болгоомжтой!

Хатагтай Уизли гал зууханд орж ирээд Роныг Фред рүү байцааны хутга барин дайрч цаадах нь саваагаа хөнгөн даллаад цаасан онгоц болгон хувиргахыг харлаа.

- Рон! Чи ахиж миний нүдэнд хутга далайж харагдах юм бол! гэж тэр уурсан орилов.

- Тэгэхгүй ээжээ. Ахиж харахгүй гэж Рон шивнэн нэмэрлээд байцаандаа эргэж оров.

- Фред, Жорж надад их харамсалтай байна, хонгорууд минь. Гэхдээ Римус шөнө ирэх болохоор Билл танай өрөөнд шахалдах болох нь.

- Зүгээр дээ гэж Жорж хэлэв.

- Чарли ирээгүй нь яамай. Тэгсэн бол Харри, Рон хоёр дээврийн хонгилд унтах байсан даа. Флер, Жинни хоёр өрөөгөө хуваадаггүй л юм бол ...

- ... үүнийг л Жинни зул сараар хүлээж байгаа гэж Фред бувтнав.

- ... тэгвэл бүгд ая тухаа олох болно. Охид орон дээр унтах ёстой гэж хатагтай

Уизли итгэлгүйхэн төгсгөв.

- Ингэхэд Перси бидэнд үзэшгүй муухай царайгаа үзүүлэхгүй юм байх даа? гэж

Фред асуухад хатагтай Уизли хаалга руу эргээд,

- Үгүй, тэр яаманд завгүй байгааг нь би мэдэж байна гэв.

- Эсвэл тэр дэлхийн дээрх хамгийн том усан тэнэг. За болно, Жорж явцгаая гэж Фред хатагтай Уизлиг гал зуухнаас гарсан хойно хэлэв.

- Та хоёр хаачих гэж байгаа юм бэ? Бидэнд байцаа арилгахад туслахгүй юм уу?

Та хоёр саваагаа зангахад л бид түүнээс сална шүү дээ! гэж Рон хэлэв.

- Үгүй биднийг ийм алхам хийнэ гэж бодохгүй хэрэггүй. Байцааг савааны тусламжгүй арилгах нь хэцүүхэн зан авиртай хүнийг маглууд болон сангасваагын амьдрал ямар хүнд болохыг ойлгоход тусалдаг юм даа гэж Фред чухалчлан хэллээ.

- Хэрвээ чи хүмүүсийг өөртөө туслахыг хүсч байгаа бол Рон гэж Жорж нэмэрлээд түүн рүү цаасан онгоц нисгэж,

- Тэдэн рүү хутга барин ухасхийх хэрэггүй байдаг юм. Эн миний зөвөлгөө шүү. Биднийг тосгонд байх үед бичиг хэргийн дэлгүүрт ажилладаг хөөрхөн охин миний нэрийн хуудсыг гайхамшигтай гаргасан ... бараг л шидийн гэмээр ... гэв.

- Гахайнууд. Тэдэнд хийхэд ердөө арван секунд орох байтал тэгвэл бид бас явж болох байлаа гэж Рон ах дүү хоёрыг цастай хашаанд гарахад баргар царайлан хэлэв.

- Би л биш шүү. Би Дамблдор гэрээс холдохгүй гээд амалчихсан гэж Харри хэллээ.

- Аан тийм л дээ гээд Рон хэдэн байцаа цэвэрлэсэнээ,

- Чи Дамблдор Снегг, Малфой хоёрын яриаг сонссон тухайгаа хэлэх гэж байна уу? гэв.

- Тэгэлгүй яахав. Дамблдор тэднийг зогсоож чадах жагсаалтын эхний хүн болохоор би бүгдийг хэлнэ. Бас эцэгтэй чинь ярина.

- Чи Малфойн үнэн хэрэгтээ юу хийж байгааг сонсоогүй нь харамсалтай.

- Би яаж сонсож чадах байсан юм бэ? Тэр Снеггэд хүртэл энэ тухай хэлэхээс татгалзсан.

Хормын турш хоёул чимээгүй байснаа дараа нь Рон,

- Чи тэдний юу хэлэхийг мэдэж байна уу? Аав, Дамблдор болон бусад нь гэх мэт? Тэд Снегг Малфойд жинхэнээсээ туслах гээгүй харин юу хийх гэж байгааг нь тодруулахаар оролдож байсан гэнэ дээ.

- Тэд түүнийг сонсоогүй. Хэн ч Снегг хүртэл тийм сайн дүр үзүүлж чадахгүй.

- Тийм шүү ... би зүгээр хэлсэн юм.

- Гэхдээ чи миний зөв гэж бодож байгаа биз дээ? гээд Харри түүн рүү хөмсөг зангидан эргэлээ.

- Тэгэлгүй яахав! гэж Рон яаран хэлээд,

- Үнэхээр тэгж бодож байна! Гэхдээ бүгд Снегг бүлэгт тусалж байгаа гэдэгт итгэлтэй байгаа биз дээ? гэв.

Харри чимээгүй байлаа. Тэр тийм баталгаанаас татгалзахад хэцүү болохыг ойлгож байсан бөгөөд шинэ баталгааны эсрэг Гермionaгийн юу хэлэх байсан тухай бодлогоширов. «Харри, тэр Малфойд туслахыг санал болгосон дүр үзүүлж юу хийж байгааг нь хэлүүлэх гэсэн нь илэрхий байна шүү дээ.»

Энэ төсөөлөлдөө Гермионагийн эсрэг хэлэх үг байсангүй. Түүнийг Слизнортын үдэшлэг дээр буцаж ирэхэд уур хилэнд автсан Маклаггентай тааралдсан бөгөөд дараа нь амралтын өрөөнд эргэж очиход Гермиона хэдийн унтахаар хэвтсэн байлаа. Харин маргааш өглөө нь Үүр лүү явахдаа зөвхөн зул сарын мэнд хүргэж амжаад амралтын дараа чухал мэдээ дуулгахаар амласан билээ. Гэвч энэ үед Рон, Лаванда хоёр ард нь үгэн бус салах ёс гүйцэтгэж байсан болохоор Гермиона түүний яриаг сонссон эсэхэд итгэлгүй байлаа..

Юутай ч гэсэн Малфой үнэхээр ямар нэг зүйл хийж Снегг түүнийг нь мэдэж байна гэдгийг Гермиона хүртэл үгүйсгэж чадахгүй ... Тэр үед Харри «би та нарт юу гэж хэллээ?» гэж Ронд олон удаа хэлсэн үгээ давтах болно.

Ноён Уизли ид шидийн яаманд зул сарын баярын үдэш хүртэл ажил дээрээ саатаж байсан болохоор Харри түүнтэй ярилцаж чадсангүй. Энэ үдэш Уизличууд зочдынхоо хамтаар сууж байсныг Жинни цаасан цэцгээр чимэглэсэн нь хүн бүр хөлөөсөө толгой хүртлээ хучигдсан мэт санагдана. Түүнчлэн зөвхөн Фред, Жорж, Харри, Рон нар зул сарын гацуурын орой дээр байгаа сахиусан тэнгэр үнэн хэрэгтээ Фредийн зул сарын оройн хоолны луувангаар дэгээдэн барьж авсан цэцэрлэгийн анахай болохыг мэдэж байв. Тэр одоо хөдөлдөггүй шидээр хөшөөд алтлаг өнгөөр будуулан нуруундаа далавчтай жижигхэн бүжгийн хувцас өмсөж тэдэн рүү ууртай харж байсан нь Харрийн амьдралдаа харсан төмс шиг толгой, үстэй хөлтэй хамгийн догшин сахиусан тэнгэр байлаа.

Бүгд том модон радионоос хангинах хатагтай Уизлийн дуртай дуучин болох Селестина Уорлокын зул сарын баярын тоглолтын нэвтрүүлгийг чагнаж байв. Флерд Селестина уйтгартай санагдсан бололтой буланд чанга ярихад хатагтай Уизли муухай харснаа шидэт саваагаа дуу тохируулагч руу чиглүүлэн дууг нь чангалахад хоолой улам чанга сонсогдлоо. Дагшаа хөгжимтэй «Халуун хүчтэй хайраар дүүрэн тогоо минь» гэсэн дуу явахад Фред, Жорж хоёр Жинниг дэлбэрдэг зургаар тоглохыг ширтэнэ. Рон нууцгайхан Флер, Билл хоёр руу харлаа. Энэ үед улам турж хувцас нь элэгдэж ноорсон Римус Люпин зуухны өмнө суугаад Селестинагийн дууг сонсолгүй гал ширтэж байв.

Өө, алив тогоо минь хутгагдаарай Хэрвээ чи бүгдийг зөв хийсэн бол Чамайг энэ үдэш дулаахан болгох Халуун хүчтэй хайр дурлал буцлана

- Бид энэ дууны аянд арван найман настай байхдаа бүжиглэж байж билээ! Санаж байна уу, Артур? гэж хатагтай Уизли хэлээд нулимсаа арчив.
- М-м-м? гэж зүрж хальсалж байсан ноён Уизли толгой дохиод,
- Аан тийм л дээ ... гайхамшигтай аялгуу байсан ... гэлээ. Тэр дэргэдээ суугаа Харри руу харлаа.
- Биднийг уучлаарай гээд Селестинагийн хоолой сонсогдож буй радионы зүг толгой дохисноо,
- Удахгүй дуусах байх гэлээ.

- Зүгээр дээ. Та ид шидийн яаманд их ажилтай байв уу? гээд Харри инээмсэглэлээ.

- Маш их. Бид сүүлчийн сар гурван хүнийг баривчилсан ч тэдний нэг нь ч жинхэнэ Үхэл залгигч гэдэгт эргэлзэж байна. Гэхдээ энэ тухай хүнд бүү яриарай, Харри гэж яаран нэмэрлээд гэнэтхэн сэргэлээ.

- Тэд одоо хүртэл Стэн Шанпайкыг хорьсон хэвээр байгаа гэж үү?

- Тийм гэж айж байна. Би Дамблдор Скримжертэй уулзан Стэнийг суллах талаар ярилцсаныг мэднэ ... Бүгд түүнийг Үхэл залгигч гэдэг нь энэ зүрж шиг гэдгийг мэдэж байгаа ... Гэхдээ ямар нэг зүйл хийсэн харагдахын тулд

«гурван эндүүрсэн баривчлалт суллагдсан» гэдгээс «гурван баривчлалт» гэдэг нь дээр сонсогдож байгаа. Гэхдээ ахин хэлэхэд энэ бүхэн нууц зүйл л дээ ...

- Би хэнд ч хэлэхгүй гэж Харри амлав.

Тэр хормын турш ярих эсэхдээ тээнэгэлзсэнээ бодлоо цэгцлэх агшинд Селестина Уорлок «Чи миний зүрхийг эзэмдсэн» гэж дуулж байлаа.

- Ноён Уизли та миний сургууль явахын өмнө буудал дээрх яриаг санаж байна уу?

- Би бүгдийг шалгасан, Харри. Малфойн гэрт нэгжлэг хийсэн. Тэгээд нэг ч эвдэрсэн эсвэл бүтэн зүйл олдоогүй.

- Тийм ээ, би мэднэ. Би энэ тухай «Зөнч» сонингоос уншсан ... гэхдээ арай өөр илүү чухал зүйлийн талаар ярих гэсэн юм ...

Ингээд тэр ноён Уизлид Снегг, Малфой хоёрын ярианаас сонссон зүйлийнхээ тухай ярилаа. Харри яриандаа Люпин толгойгоо тэдний зүг эргүүлж үг бүрийг нь сонсохыг ажиглав. Түүнийг яриагаа дуусгамагц нам гүм болж зөвхөн Слестинагийн,

Өө, хөөрхий зүрх чи минь хаана байна?

Намайгаа удтал орхилоо гэж дуулах сонсогдоно.

- Энэ санаагаа мартсан чинь дээр Харри. Снегг зөвхөн дүр үзүүлж байгаа юм гэж ноён Уизли хэлэв.

- Малфойн төлөвлөгөөг биелүүлэхэд туслахаар санал болгож уу? Тиймээ би таныг ингэж хэлнэ гэдгийг мэдэж байсан юм. Гэхдээ бид үүнийг хаанаас мэдэх юм бэ?

- Энэ бол бидний хэрэг биш гэж Люпин гэнэтхэн хэлэв. Тэр ханан зуухнаас эргээд ноён Уизли болон Харри руу харлаа.

- Энэ бол Дамблдорын хэрэг. Дамблдор Северуст итгэдэг. Энэ л бидэнд хангалттай.

- Гэхдээ Дамблдор Снеггийн тухад алдсан бол яана гэж Харри эсэргүүцэв.

- Энэ тухай олон удаа ярьсан. Бүх зүйл чи Дамблдорын бодолд итгэж байгаа эсэхэд байгаа юм. Би итгэдэг учраас Снеггэд итгэж байна.

- Гэхдээ Дамблдор алдсан байж болно биз дээ. Тэр өөрөө ч тэгж ярьж байсан гэж Харри зөрүүдлээд,

- Харин та гээд Люпин руу ширтэж,

- Үнэнийг хэлэхэд таньд Снегг таалагддаг гэж үү? гэв.

- Би түүнийг надад таалагддаг эсэхийг хэлж чадахгүй. Үгүй ээ, үгүй Харри би үнэнийг ярьж байна гэж Харрийн шүүмжлэнгүй төрхийг харж хэлээд,

- Бид түүнтэй хэзээ ч найз нөхөд байгаагүй. Бүх зүйл Жеймс, Сириус, Севериус нарын хооронд болсон үйл явдлаас хэтэрхий олон гашуун дурсамж үлдсэнд байгаа юм. Тэгээд ч би Хогвартсад багшилж байхдаа Севериус надад сар бүр хүч чонын эсрэг уусмал гайхамшигтай бэлтгэж өгсний ачаар арван тавны сар гарахад зовж шаналахгүй байснаа санаж байна.

- Гэхдээ тэр санамсаргүй мэтээр таныг хүч чоно гэж хэлээд сургуулийг орхиулахад хүргэсэн биз дээ! гэж Харри ууртай дуу алдав.

Люпин мөрөө хавчлаа.

- Тэгсэн ч гэсэн энэ тухай хэзээ нэгэн цагт задрах л байсан. Бид хоёул түүний миний суудалд тэмүүлж байгааг мэдэж байсан болохоор Северус надад хүн чонын эсрэг уусмалаараа томоохон хор учруулж чадах байсан. Харин тэр намайг эрүүл үлдээсэн. Ийм болохоор би түүнд талархдаг юм.

- Магадгүй тэр Дамблдорыг байхад уусмалд ямар нэг зүйл хийж зүрхлээгүй биз! гэж Харри эсэргүүцэв.

- Чи түүнийг үзэн ядахыг хүсч байна, Харри гэж Люпин сулхан инээмсгэлэн хэлээд,

- Би чамайг ойлгож байна. Би чамайг Жеймс болон, загалмайлан эцэг Сириусээс энэ бүхнийг өвлөж авсныг харж байна. Чи Дамблдорд энэ бүх бодлоо Артур бид хоёрт ярьсаны адил хэлэхдээ бодлыг чинь хуваалцана гэж бүү бодоорой. Бас чиний яриа түүнийг гайхуулна гэж хүлээх хэрэггүй. Северус Дракогоос Дамблдорын тушаалын дагуу асуусан байх бүрэн боломжтой.

Чи түүний хэсгийг нь цуулсан ч

Тэр эргээд ирлээ энэ бол аз жаргал

Селестина дуугаа удаан өндөр хоолойгоор төгсөхөд радионоос чанга алга ташилт сонсогдон хатагтай Уизли урам зоригтой нэгдлээ.

- Дууссан уу? Бурханд баярлалаа, энэ ч а'мшигтай байлаа ... гэж Флер чанга хэлэв.

- Шөнийн аяга юм уух уу? Өндөгтэй коктейл хэн уухыг хүсч байна? гэж ноён Уизли чанга асуугаад босов.

- Та сүүлийн үед юу хийж байсан бэ? гэж Харри Люпинээс асуухад ноён Уизли коктейл хундгалж бүгд аваад хоорондоо хөөрөлдөж эхлэв.

- Газар дор байсан. Нэг үгээр хэлбэл. Ийм учраас би чамд захиа бичээгүй юм, Харри. Чамд бичих нь өөрийгөө барьж өгөх байлаа.

- Та юуны тухай яриад байна?

- Би өөрийнхөө төрлийнхөн дунд байсан юм. Хүн чононуудын дунд гэж Люпин Харрийн ойлгоогүй харцыг харан хэлээд,

- Тэд бараг бүгдээрээ Волан-де-Мортын талд орсон. Дамблдор намайг тагнуул хийлгэхийг хүсээд би ... бэлэн байсан болохоор.

Түүний хоолой гашуун болоход үүнийгээ ажигласан бололтой инээмсэлээд дулаан өнгөөр үргэлжүүлэв.

- Би үүнд гомдоллохгүй ажил хэрэг чухал байсан тэгээд ч надаас өөр хэн үүнийг дээр хийж чадах юм бэ? Гэхдээ тэдний итгэлийг олоход хэцүү байлаа. Би шидтэнгүүдийн дунд амьдрахыг оролдож байсан болохоор ойлгож байгаа биз дээ. Харин тэд хүмүүсийн дундаас хөөгдөж тусгаар амьдарч заримдаа хооллохын тулд ... алдаг юм.

- Гэхдээ тэдэнд яагаад Волан-де-Морт таалагдсан юм бэ?

- Тэд түүний захиргаан дор илүү дээр амьдрал хүлээж байгаа гэж бодож байгаа. Тэдний дунд Сивый байгаа болохоор энэ тухай маргахад хэцүү л дээ ...

- Сивый гэж хэн юм бэ?

- Чи түүний тухай сонсоогүй юу? гээд Люпины өвдгөн дээрээ тавьсан хуруу чичирлээ.

- Фенрир Сивый хүн чонын дундаас хамгийн хэцгий нь юм. Тэр өөрийн амьдралдаа аль болох олон хүмүүсийг хазаж маажиж хувирган их хэмжээний хүч чоно цуглуулаад шидтэнгүүдийг дийлэх зорилготой юм. Волан-де-Морт түүнд эргэн үйлчилсэн тохиолдолд олон тооны золиос амласан байгаа. Сивый хүүхдүүдэд дуртай ... «Тэднийг залуу байхад нь хазвал эцэг эхээс нь хөндийрүүлэн жирийн шидтэний амьдралыг үзэн ядаж өснө» гэж хэлдэг юм. Волан-де-Морт хүмүүсийг айлгахын тулд Сивыйг тэдний хүү болон охид руу тавина гэж сүрдүүлж энэ нь шаардлагатай үр дүнд хүрч байгаа.

Люпин чимээгүй болсноо дараа нь,

- Сивый намайг хазсан гэлээ.

- Юу? гэж Харри гайхан асуулаа.

- Та хүүхэд байхад чинь ... гэж хэлэхийг хүсээ юу?

- Тиймээ. Миний эцэг түүнийг доромжилсон юм. Би удаан хугацааны турш хүн чоно намайг дайрахаар дагаж байгаа гэж таамаглаагүй. Би тэр үед хүн чоно болон хувирсан үед юу болдогийг мэддэг байсан. Үнэндээ Сивыйд энэ бүхэн хамаагүй байсан. Тэр арван тавны сар гараад удаагүй байхад золиос руугаа түргэн цохилт

өгөхийн тулд гэтсэн. Бүгдийг урьдчилан төлөвлөсөн байсан. Энэ амьтныг Волан-де-Морт ашиглан хүн чононуудыг удирдаж байгаа юм.

Сивыйг эсэргүүцэхэд хэцүү тэр хүн чононуудаас цус шаардаж жирийн хүмүүсийг эгнээндээ элсүүлэхийг хүсч байгаа.

- Гэхдээ та хэвийн биз дээ! Зүгээр л таньд ... хүнд байдаг гэж Харри дуу алдав. Люпин хөхөрлөө.

- Чи заримдаа надад Жеймсийг их санагдуулах юм! Тэр надтай хамт байхдаа надад багахан асуудал байгаа гэж хэлдэг байсан. Олон хүмүүст би гэртээ муу хүмүүжсэн гэсэн сэтгэгдэл төрсөн байх.

Тэр ноён Уизлийн аяга өндөгтэй коктейлийг уугаад талархан арай хөгжилтэй болоход Харри сэтгэл нь хөөрөхөө мэдэрлээ. Эцгийнх нь тухай дурсамж түүнд Люпинээс асуух ёстой зүйлийг сануулав.

- Та эрлийз хунтайж гэж нэрлэдэг хүний тухай сонсоогүй биз?

- Эрлийз гэнээ ... ?

- Эрлийз хунтайж гээд Харри Люпины царай луу анхааралтай харж таньсаны ямар нэг шинж тэмдгийг хүлээлээ.

- Шидтэнгүүдийн дунд хунтайж байхгүй гээд Люпин инээмсэглэн,

- Чи өөртөө ийм цол бодож олсон юм биш биз дээ? Надад бол сонгогдсон гэдэг чинь хангалттай санагдаж байна гэв.

- Надад энэ ямар ч хамаагүй! гэж Харри уурслаа.

- Эрлийз хунтайж бол Хогвартсад сурч байсан шидтэн надад зөвхөн уусмалын хичээлийн хуучин сурах бичиг нь оногдсон юм. Тэр номоороо дүүрэн зохиосон шившлэгүүдээ бичсэн байсан байсан. Тэдний нэг бол Левикорпус ...

- Аан тийм л дээ, намайг Хогвартсад сурч байх үед энэ шившлэг их өргөн дэлгэр байсан юм. Намайг тавдугаар дамжаанд байхад хэдэн сарын турш хэн ч агаарт шагайнаасаа өлгөгдөхгүйгээр хэдэн алхам хийж чаддаггүй байсныг санаж байна.

- Аав бас түүнийг ашиглаж байсан. Би гүн ухааны цүнхээлд Снеггийг хэрхэн өлгөхийг харсан.

Харри үүнийг аль болох хайхрамжгүй хэлэхийг хичээсэн авч бүтэлтэй болсон гэдэгт итгэлгүй байлаа. Люпин ойлгосон янзтай инээмсэглэв.

- Тиймээ тэр үүнийг хэрэглэдэг ганц хүн биш. Би энэ шившлэг их тархсан байсан тухай ярьж байна ... Чи ч гэсэн гэнэтхэн хүчтэй дэлгэрснээ дараа нь мартагддаг явдлын тухай мэднэ.

- Гэхдээ надад түүнийг зохиосон хүн сургуульд сурдаг байсан гэж санагдсан юмсан.

- Заавал тийм байх албагүй. Шившлэг түгээмэл тархсан бол хэн ч хэрэглэж болно.

Тэр Харрийн царай руу харснаа аяархан,

- Жеймс цэвэр цусны шидтэн байсан, Харри. Чамд итгүүлэн хэлэхэд тэр хэзээ ч хунтайж гэж дуудуулахыг гуйж байгаагүй гэв.

Харри хайхрамжгүй гараа даллаад,

- Энэ Сириус юм болов уу? Эсвэл та юу? гэв.

- Ямар ч тохиолдолд биш.

- Би зүгээр л тэгж бодсон юм ... гээд Харри гал руу ширтлээ. Ер нь бол хунтайж миний уусмалын хичээлд их тусалсан.

- Энэ ном хэр хуучин бэ, Харри?

- Мэдэхгүй шалгаагүй.

- Шалгавал энэ нь чамд хунтайж Хогвартсад хэзээ сурч байсныг тодруулахад тус болох байх.

Энэ үед Флер Селестинаг дуурайхыг хичээн «халуун хүчтэй хайр дурлалаар дүүрэн тогоо» гэж дуулахад бүгд хатагтай Уизлийн нүүрэнд ор луугаа явах болсны дохио илрэхийг харлаа. Харри, Роны хамт ор нь хүлээж байгаа дээврийн өрөө рүү өгслөө.

Рон даруйхан унтаж Харри чемоданаасаа уусмалын хичээлийн номоо гаргаж ирлээ. Тэр хуудсыг эргүүлж хайгаад эцэст нь хамгийн эхний нүүрэн дээр хэвлэгдсэн он сарыг харлаа. Ном тавиас доошгүй жил болсон аж. Эцэг нь ч найзууд нь ч тэр Хогварстад тавин жилийн өмнө сурч байгаагүй. Сэтгэлээр унасан Харри номыг чемодан руугаа буцаан хийгээд гэрэл унтрааж орондоо хөрвөөн хүн чоно болон Снегг, Стэн Шанпайк түүнчлэн эрлийз хунтайжын тухай бодоод эцэст нь амьтдын сүүдэр хүүхдүүийг орилуулан хазаж байгаа тухай түгшүүртэй зүүдэнд автлаа ...

- Тэр тоглосон байлгүй дээ ...

Харри цочин сэрээд шилээ зүүхэд жижигхэн цонхны цаана цас лавсан орж Рон орон дээрээ суугаад зузаан алтан гинжийг харж байв.

- Энэ юу вэ? гэж Харри сониучирхав.

- Лавандагийн бэлэг гэж Рон зэвүүцэн хэлээд,

- Тэр үнэхээр намайг үүнийг зүүгээд явна гэж бодсон юм байх даа ... гэв.

Харри бэлгийг ойртон хараад инээд алдав. Том алтан гинжин дээр алтан үсгээр «Хайрт минь» гэж бичжээ.

- Аятайхан л юм байна. Ганган ч гэж болох юм. Чи үүнийгээ Фред, Жорж хоёртой уулзахын өмнө зүүсэн нь дээр байх шүү.

- Хэрвээ чи тэдэнд хэлэх л юм бол гэж Рон зүүлтийг дэрэн доогуураа шургуулан,



- Би ... би ... би гэв.
- Үлдсэн амьдралынхаа туршид надтай ярихгүй юу? гэж Харри инээвхийлээд,
- Боль доо чи намайг ингэхгүй гэдгийг мэдэж байгаа биз дээ гэв.
- Түүний толгойд надад хаанаас ийм зүйл таалагдана гэж ордог байна? гэж Рон хоосон газар луу ширтэн дуу алдав.
- Санах гээд үзье л дээ. Магадгүй чи түүнээс хүзүүн дээрээ хайрт минь гэсэн бичиг зүүгээд явахыг гуйсан ч юм билүү?
- За боль доо ... бид тийм ч олон зүйл ярилцаагүй. Ихэнхидээ ...
- Үнсэлдсэн гэж Харри хэлэв.
- Ер нь бол тийм л дээ гээд Рон тээнэгэлзсэнээ,
- Гермiona үнэхээр Маклаггентай уулзаж байгаа болов уу? гэв.
- Мэдэхгүй. Тэд Слизнортын үдэшлэгт хамт очсон ч тийм ч сайн болоогүй байх гэж бодож байна.

Рон үл ялиг хөгжин бэлэг рүүгээ гар сунгав.

Харрийн бэлгэн дунд хатагтай Уизлийн нэхсэн цээжин дээрээ том алтан снитчтэй цамц, «Уизлийн бүх төрлийн шидэт эдлэл» дэлгүүрээс ихрүүдийн илгээсэн том цаасан хайрцаг болон «Кикимерийн эзэнд» гэж хаягласан хөгц үнэртсэн чийгтэй хайрцаг байлаа.

Харри түүн рүү гайхан харлаа.

- Чи үүнийг нээвэл аюулгүй гэж бодож байна уу?
- Ямар ч аюулгүй. Манай бүх шууданг ид шидийн яамнаас шалгаж байгаа гэж Рон хэлсэн ч илгээмж рүү сэжигтэй хяламхийв.
- Харин би Кикимерт ямар нэг зүйл бэлэглэнэ гэж бодсонгүй. Хүмүүс зул сарын баяраар гэрийн үйлчлэгчдээ ямар бэлэг өгдөг юм бол? гээд Харри илгээмжийг болгоомжтой авлаа.
- Гермiona ямар нэг зүйл бэлэглэх байсан. Гэхдээ өөрийгөө зовоохын урьд дотор нь юу байгааг нь харсан нь дээр байх.

Хормын дараа Харри чанга хашгираад үсрэн холдоход хайрцагт дүүрэн авгалдай хэвтэж байлаа.

- Гайхамшигтай гэж Рон инээд алдан хэлээд,
- Маш их тунгаан бодсон бэлэг байна гэв.
- Чиний зүүлтгнээс дээр гээд Харри хэлэхэд Рон чимээгүй боллоо.

Зул сарын ширээнд Флерээс бусад хүн бүр шинэ цамцтай суухад (хатагтай Уизли түүнд хүч зарлагадахыг хүсээгүй бололтой) хатагтай Уизли алтан хүзүүний зүүлт зүүгээд, ододыг санагдуулам алмааз гялалзах цэнхэр шидтэнгийн малгай өмсчээ.

- Үүнийг надад Фред, Жорж хоёр бэлэглэсэн юм! Гайхамшигтай байгаа биз дээ?

- Харж байна уу ээжээ бид таньд оймсыг минь угаасны төлөө хичнээн их талархаж байгааг гээд Жорж агаарт гараа савчин,

- Гэхдээ үгэнд цадахгүй биз дээ, Римус? гэв.

- Харри чиний үсэн дээр өт байна гэж Жинни хөгжилтэй хэлээд ширээн дээгүүр бөхийн толгой дээрээс нь Кикимерийн бэлэгний үлдэгдлийг арилгахад Харрийн хүзүүгээр өттэй ямар ч хамаагүй жирсхийлээ.

- ‘Мар ‘ймшигтай юм! гэж Флер цочирдсон дүр үзүүлэн хэлэв.

- Үнэхээр тийм гэж үү? Сүмс авах уу, Флер? гэж Рон хэллээ.

Тэр түүнд туслахаар яарсандаа болоод сүмстэй савыг цохин унагахад Билл саваагаа даллаад сүмсийг байранд нь удаашруулан буулгав.

- Чи яг л Тонкс шиг байх юм гэж Флер Ронд хэлээд Биллийг талархан үнслээ.

- Тэр ч гэсэн үргэлж юм цохиж байдаг ...

- Би өнөөдөр Тонксыг урьсан гэж хатагтай Уизли мэдэгдээд Флерийн ууртай харцан дор ширээнд лууван тавьж,

- Гэхдээ тэр ирэхгүй гэсэн. Чи түүнтэй сүүлийн үед ярилцсан уу, Римус? гэв.

- Үгүй би түүнтэй бараг уулзаагүй. Гэхдээ Тонкс аль нэг хамаатныдаа зочилж байгаа байх гэж Люпин хэлэв.

- Хм-м. Магадгүй л юм. Гэхдээ үнэн хэрэгтээ тэр надад зул сарыг ганцаараа өнгөрүүлэхээр шийдсэн юм шиг санагдах юм гэж хатагтай Уизли хэлэв.

Тэр Люпин рүү Тонксын оронд Флер бэр нь болсонд буруутай юм шиг уурсан харлаа. Харри Биллд цацагт хяруул сэрээдэн өгөх Флер рүү харснаа хатагтай Уизлийн урт удааны тэмцэлд хожигдсон тухай бодлоо. Энэ яриа түүнд Тонкстой холбоотой зүйл сануулахад Люпинээс асуухаар шийдлээ. Тэр Патронусын тухай бүгдийг мэддэг билээ.

- Тонксын Патронус өөрчлөгдсөн байсан. Снег тэгж хэлсэн. Би юу болсныг нь мэдэхгүй юм. Яагаад Патронус өөрчлөгдсөн юм бол?

Люпин чимээгүй болсноо цацагт хяруул зажлангаа яаралгүйхэн,

- Заримдаа энэ тохиолддог юм ... хүчтэй сэтгэлийн хямралаас болоод ... гэв.

- Тэр том дөрвөн хөлтэй юм шиг харагдсан гэж Харри эхэлснээ гэнэтхэн нэг бодол орж ирэхэд дуугаа намсгаад,

- Хүлээгээрй ... энэ ...?

- Артур! Артур, Перси тэнд байна! гэж хатагтай Уизли гэнэтхэн уулга алдав.

Тэр сандлаасаа үсрэн босоод гараараа цээжээ даран гал зуухны цонхоор шагайлаа.

- Юу?

Ноён Уизли эргэн тойрноо харлаа. Бүгд агшин цонхны зүг эргэхэд Жинни сайн харахын тулд бослоо. Гадаа цастай хашаанд Перси Уизли орж ирэхэд эвэр хүрээтэй шил нь нарны гэрэл гялбав. Тэр ганцаараа биш байлаа.

- Артур, тэр ... тэр сайд байна!

Тэгтэл ч үнэхээр Персигийн араас үл мэдэг доголсоор «Өдөр тутмын зөнч» сонинд гарсан дэл шиг үстэй, цасанд цоохорлогдсон хар дээлтэй хүн явж байв. Хэн нэгэн үг хэлж амжихаас урьтаж ноён ба хатагтай Уизли мэгдсэн харц солилцоход үүдний хаалга нээгдэн гал зуухны босгоор Перси орж ирлээ.

Таагүй нам гүм болов. Тэгтэл Перси,

- Зул сарын мэнд, ээжээ гэв.

- Өө, Перси минь! гээд хатагтай Уизли хүү рүүгээ ухасхийн цээжиндээ наалаа.

Руфус Скримжер үүдний босгон дээр хөшөөд таяг руугаа бөхийн энэхүү сэтгэл хөдлөм үйл явдлыг инээмсэглэн харав.

- Төвөг удсан явдалд уучлаарай гэж тэр баясан гийсэн хатагтай Уизли нулимсаа арчихыг харан хэлээд,

- Перси бид хоёр ойрхон ажлаар явж байгаад тэр тэсэлгүй та нартай уулзахыг хүссэн юм гэв.

Гэвч Перси үлдсэн гэр бүлийнхэнтэйгээ мэндлэх ямар ч хүсэлгүй байлаа. Тэр зогсоод бүгдийн толгой дээгүүр ширтэв. Ноён Уизли, Фред, Жорж нар түүн рүү хүйтнээр харлаа.

- Өршөөгөөрэй, сайдаа орооч суугтун! гээд хатагтай Уизли малгайгаа заслаа.

- Зүсэм цацагт хяруул юмуу бялуу идэх үү ... би одоохон ...

- Үгүй дээ, үгүй Молли хонгор минь баярлалаа гэж Скримжер хэлээд,

- Би та нарт саад болохыг хүсэхгүй байна. Хэрвээ Перси та нартай уулзахыг хүсээгүйсэн бол би энд байхгүй байлаа гэв.

- Өө, Перси минь! гэж хатагтай Уизли нулимс асгаруулан хэлээд хүүгээ үнсэхээр ухасхийв.

- ... Бидэнд ердөө таван хором байгаа болохоор Персид садаа болохгүйн тулд гадаа хашаанд зугаалахыг би илүүд үзэж байна. Үгүй, үгүй намайг зочлох хэрэггүй дээ! Хэрвээ хэн нэгэн надад энэ сайхан цэцэрлэгийг үзүүлэхийг зөвшөөрвөл ... Аан энэ залуу хүн та хооллож дууссан бололтой яагаад надтай хамт гарч болохгүй гэж?

Уур амьсгал мэдэгдэхүйц өөрчлөгдөв. Бүгд Скримжер болон Харрийн зүг харлаа. Скримжерийн Харриг танихгүй байх оролдлого хэнийг ч хуурч чадсангүй бололтой түүнд сайдыг дагалдах хүндэтгэл оногдоход Жинни, Фред, Жорж нарын таваг бас хоосон байлаа.

- Тэгэлгүй яахав гэж Харри нам гүмийг эвдэн хэлэв.

Тэр бүгдийг ойлгож байлаа. Скримжер Перси гэр бүлийнхэнтэйгээ уулзахыг хүссэн гэж харагдуулахыг хүссэн ч үнэн хэрэгтээ Харритай нүүр тулан уулзах хэрэгтэй байж.

- Бүх зүйл зүгээр дээ гэж тэр сандлаас босож байгаа Люпины дэргэдүүр өнгөрөхдөө хэлээд,

- Бүх зүйл хэвийн гэж ноён Уизли үг хэлэхээр ам нээхийг хараад давтлаа.

- Гайхалтай! гээд Скримжер Харриг өнгөрүүлэхийн тулд хажуу тийш болов.

- Бид цэцэрлэгээр жаахан зугаалаад дараа нь Перси бид хоёр явах болно. Цааш нь баяраа үргэлжлүүлнэ үү, та нараас гуйя!

Харри Уизлийнхны өтгөн өвстэй цасанд хучигдсан цэцэрлэгт гарахад Скримжер үл ялиг доголлон хажууд нь явлаа. Харри түүний саяхан мракоборецуудын хэлтсийг толгойлж байсныг мэдэх болохоор эрэмгий төрхтэй Скримжер Фаж болон түүний бүрх малгайтай огт адилгүй байлаа.

- Сэтгэл татам юм гэж Скримжер цасанд хучигдсан цэцэрлэгийг харан хэлээд,

- Маш сэтгэл татам юм гэв.

Харри чимээгүй байлаа. Тэр Скримжер түүнийг харж байгааг мэдэж байв.

- Би чамтай маш эртнээс танилцахыг хүссэн. Чи үүнийг мэдэх үү?

- Үгүй гэж Харри үнэнээ хэллээ.

- Тиймээ тийм, маш эртнээс. Гэвч Дамблдор таныг хамгаалж байсан. Ер нь бол та болсон үйл явдлын дараа юу бодож байна ... Ялангуяа ид шидийн яамнд болсон үйл явдлын дараа ...

Тэр чимээгүй болоод Харрийн үг хэлэхийг хүлээсэн авч юм хэлсэнгүйд ахин ярьж эхлэв.

- Би таньтай эртнээс уулзах боломжыг хайсан ч Дамблдор ... түүнийг ойлгож болох юм ... надад тийм боломж өгөөгүй.

Харри чимээгүйхэн цааш ярихыг нь хүлээлээ.

- Таны тухай хаа сайгүй цуу яриа дэгдэж байна! Мэдээж бид энэ энэ түүх гуйвуулагдсаныг мэдэж байгаа ... зөгнөлийн тухай ... таны сонгогдсон тухай гээд л ...

«Одоо л бид Скримжерийн ирсэн жинхэнэ шалтгаанд хүрлээ» гэж Харри бодов.

- Би Дамблдор таньтай энэ тухай ярьсан байх гэж бодож байна.

Харри худал хэлэх эсэхээ хянамгай бодлоо. Тэр Фредийн барьж аваад зул сарын гацуурын оройд бүжигчний хувцас өмсгөөд өлгөсөн анахайн цэцгийн мандалд гарсан жижигхэн хөлийн мөрийг харлаа. Эцэст нь үнэнийг хэлэхээр шийдэв ... үнэндээ жаахан л.

- Тиймээ бид энэ тухай ярилцсан.

- Ярьсан гэнээ хэмээн Скримжер давтлаа.

Харри нүднийхээ булангаар сайд түүн рүү нүдээ анивчин харснаа хөлдүү бутны дороос толгойгоо цухуйлгаж буй анахайг сонирхсон дүр эсгэхийг харлаа.

- Тэгээд Дамблдор таньд юу хэлээ вэ, Харри?

- Өршөөгөөрэй энэ бидний хоорондох хэрэг.

Тэр Скримжертэй адил аль болох нөхөрсөг ярихыг хичээхэд тэр ч гэсэн адил өнгөөр,

- Тэгэлгүй яахав энэ бол итгэлцлийн асуудал ... би үүнийг задруулахыг хүсэхгүй байна ... үгүй ээ, үгүй ... гэхдээ ямар ч тохиолдолд таньд сонгогдсон эсэх нь тийм чухал байгаа юм уу?

Харри энэ үгийн талаар бодлогошироод хэдэн секундтэй дараа,

- Би таны юун тухай яриад байгааг ойлгохгүй байна, сайдаа гэлээ.

- Тэгэхээр энэ таны хувьд маш чухал ажил гэж Скримжер инээвхийлэн хэлээд,

- Бүхэл шидтэнгүүдийн ертөнц ... Энэ таньд ойлгомжтой биш байна гэж үү?

Хүмүүс юунд итгэх нь маш чухал юм.

Харри юун тухай болохыг нь тааварлаж байсан ч Скримжерт ярихад нь туслахыг хүссэнгүй. Бутан дороос анахай гарч ирээд үндэсний цас малтан өт гаргаж ирэхэд Харри түүн рүү ширтлээ.

- Ойлгож байна уу, шидтэнгүүд таныг сонгогдсон гэж итгэж байна. Тэд таныг жинхэнэ баатар гэж бодож байгаа ч мэдээж таны сонгогдсон эсэх чухал биш! Та хичнээн удаа Хэцүү нэртэй нүүр тулгарсан билээ? Ямар ч гэсэн гээд хариулт хүлээснээ цааш үргэлжлүүлэн,

- Та олон хүний хувьд итгэл найдварын бэлэг тэмдэг болоод байна, Харри.

Зөвхөн шидтэнгүүдэд Хэцүү нэртийг устгах тавилантай гэсэн бодол төрүүлэх юм бол хүмүүсийн сэтгэлийг сэргээх болно. Бас би ... таныг ид шидийн яамтай хамтран ажиллах нь бүх төрлийн тусламж авахад хэрэг болно гэж үзэж байна гэв.

Анахай өтийг зулгаалаа. Тэр түүнийгээ хөлдүү газраас сугалахын тулд бүх хүчээ гарган татав. Харри удтал чимээгүй байсан тул Скримжер эцэст нь анахайгаас харцаа салгаж,

- Хөгжилтэй хүмүүс байгаа биз тийм үү? Та надад хариулах уу, Харри? гэв.

- Би таныг надаас юу хүсч байгааг ойлгохгүй байна гэж Харри удаанаар хэлээд,

- Ид шидийн яамтай хамтран ажиллах гэдэг чинь ... юу гэж байгаа юм? гэлээ.

- Өө, энэ таньд итгүүлэн хэлэхэд өчүүхэн ч төвөг удахгүй. Хэрвээ та жишээлбэл ид шидийн яамаар үе үе шагайж байвал энэ нь хэрэгтэй сэтгэгдэл төрүүлэх болно. Мэдээж таньд миний залгамжлагч болох мракборецуудын хэлтсийг удирддаг Гавейн Робадрстай ярилцах сайхан боломж бүрдэнэ. Долорес Амбриж надад таныг мракборец болохыг мөрөөддөг гэж хэлсэн. Энэ ч амархан зохицуулж болох зүйл л дээ ...

Харри уур хилэнд автлаа. Долорес Амбриж одоо хүртэл ид шидийн яаманд ажилласаар байгаа хэрэг үү?

- Ийм учраас л би танд ид шидийн яаманд ажилд орохыг хүсч байгаа гэсэн сэтгэгдэл төрсөн хэрэг байх нь ээ?

- Бүгд таныг манай ажилд оролцож байгааг мэдэхдээ баяртай байх болно хэмээн Скримжер Харриг түргэн ойлгосон явдалд санаа амран хэлээд,

- Та ойлгож байна уу, «Сонгогдсон» ... энэ нь хүмүүст найдлага төрүүлэх болно гэлээ.

- Хэрвээ би ид шидийн яамны үйл ажиллагаанд оролцож эхэлвэл ... хүмүүс намайг үйл ажиллагааг нь дэмжиж байгаа гэж бодохгүй байх.

Скримжер хөмсгөө зангидсанаа

- Үгүй ээ ийм учраас л бид ...

- Үгүй би үүнийг бүтнэ байх гэж бодохгүй байна гэж Харри таатай инээмсэглэн хэлээд,

- Надад яамны хийж байгаа зарим зүйлс таалагддаггүй. Жишээлбэл Стэн Шанпайкыг баривчилсан явдал гэлээ.

Хэдэн хормын турш Скримжер чимээгүй байснаа царайны хувирал нь агшин зуур өөрчлөгдөв.

- Би таныг ойлгохыг хүлээгээгүй байна гэж уур хилэнгээ арайхийн нууж хэлээд,

- Цаг үе аюултай болж шаардлагатай арга хэмжээ авахыг шаардаж байна. Гэтэл та ердөө арван зургаан настай ...

- Дамблдор арван зургаан настай хүнээс ахмад хэр нь Стэнийг Азкабанд илгээх хэрэггүй гэж бодож байгаа юм гэж Харри яриаг нь таслаад,

- Та Стэнийг золигт гаргах ямаа болгож харин намайг аз жаргалын сахиус болгохыг оролдож байна гэв.

Тэд удтал бие бие рүүгээ хүйтнээр харлаа. Эцэст нь Скримжер ямар ч дулаахан өнгөгүйгээр,

- Ойлгомжтой. Та баатар болохыг хүсэж байгаа ч Дамблдор яамнаас холхон байхыг эрхэмлэж байгаа байх нь гэв.

- Намайг ашиглаасай гэж би хүсэхгүй байна.

- Таныг ид шидийн яаманд ашиглагдах үүрэгтэй гэж хэлэх багагүй хүмүүс олдоно.

- Мэдээж бусад хүн тэгж хэлж байсан ч таны үүрэг бол шоронд хорихоосоо өмнө жинхэнэ Үхэл залгигч эсэхийг нь шалгах явдал гээд Харрийн уур улам нэмэгдлээ.

- Та яг л Барти Крауч шиг аашилж байна. Та болон таны хүмүүс хэзээ ч ажлаа зөв хийхэд суралцаагүй. Фаж ч гэсэн хамар дор нь хүмүүсийг алж байхад бүх зүйл сайхан гэсэн дүр үзүүлж буруу хүмүүсийг хорьж байсан. Харин та сонгогдсон хүний төлөө ажиллаж байна!

- Та сонгогдсон юм биш биз дээ?

- Минийхээр бол та энэ чухал биш гэж хэлсэн санагдаж байна гэж Харри гашуунаар инээмсэглэн хэлээд,

- Ямар ч тохиолдолд гэв.

- Би тэгж хэлээгүй. Энэ бол зохимжгүй үйл явдал гэж Скримжер түргэхэн хэллээ.

- Үгүй ээ энэ бол үнэн. Ганц л үнэн зүйлийг та надад хэлсэн. Таньд миний амьд үхсэн эсэх хамаагүй гэхдээ бүгдийг Волан-де-Морттой хийх дайнд ялна гэж итгүүлэх ёстой. Би мартаагүй байна, сайдаа ...

Тэр баруун гараа сунгалаа. Хүйтэн гар дээр Долорес Амбрижийн Харрийн арьсан дээр хүчээр бичсэн «би худал хэлэхгүй» гэсэн сорви сийлэгдсэн байлаа.

- Би бүгдэд Волан-де-Морт эргэж ирсэн гэж хэлэхэд хамгаалалтыг минь яаран нэмэгдүүлснийг санахгүй байна. Өнгөрсөн жил ид шидийн яам надтай тийм ч нөхөрсөг байгаагүй.

Тэд чимээгүй болоод хөлдүү газар зогслоо. Анахай эцэст нь өтийг сугалж аваад бутны доогуур чирэн оров.

- Дамблдор юу хийгээд байгаа юм? Тэр Хогвартсаас гадна хаашаа алга болоод байгаа юм бэ? гэж Скримжер сонирхлоо нуулгүй асуулаа.

- Мэдэх юм алга гэж Харри хэлэв.

- Мэдэх байсан ч хэлэхгүй тийм үү?

- Үгүй, хэлэхгүй гэж Харри батлав.

- Тэгвэл би үүнийг мэдэхийг хичээх болно.

- Ородоод үз л дээ. Гэхдээ таныг Фажаас илүү ухаалаг хийсэн алдааг нь давтахгүй байх гэж бодож байна. Тэр Хогвартсын хэрэгт хөндлөнгөөс оролцохыг оролдсон юм. Та түүнийг сайдаа больсон байхад Дамблдор захирал хэвээр үлдсэнийг ажигласан байх. Би таны оронд байсан бол түүнд хүрэхгүй байсан даа.

Удтал чимээгүй болов.

- Тэгэхээр тэр тань дээр маш сайн ажилласан гэдэг нь надад ойлгомжтой боллоо гэж Скримжер эцэст нь хэлээд Харри хүйтнээр ширтэн,

- Та бүрэн Дамблдорын хүн болж тийм үү, Харри? гэв.

- Тийм шүү. Энэ тухай ярилцсанд баяртай байна.

Ингээд тэрбээр сайд руу нуруугаа харуулан байшин руу явлаа.

## БҮЛЭГ 17: СУЛХАН ДУРСАМЖ

Шинэ жил гарснаас хойш хэдэн өдрийн дараа Харри, Рон, Жинни нар Хогвартс руу буцахаар гал зууханд цуглав. Ид шидийн яамнаас сурагчдыг сургууль руу аюулгүй түргэн буцаахын тулд нисдэг даринь сараалжыг нэг чиглэлийн холбоотой болгожээ. Ноён Уизли, Фред, Жорж, Билл, Флер нар ажилдаа явсан учир тэдэнтэй зөвхөн хатагтай Уизли салах ёс гүйцэтгэлээ. Салахын өмнөх агшинд хатагтай Уизли нулимс асгаруулсан ч бүгдэд түүний Персиг зул сараар гэртээ ирээд явснаас хойш уйлах зүйл юу ч үгүй байхад уйлдаг зуршилтай болсон нь илэрхий байлаа.

- Битгий уйл ээжээ гэж Жинни мөр лүү нь нулимс асгаруулж байгаа хатагтай Уизлийн нурууг илэн хэлээд,
- Бүх зүйл сайхан болно ... гэлээ.
- Тиймээ, тийм бидэнд санаа зовох хэрэггүй гэж Рон ээжийгээ хацар дээр нь нойгтноор үнсэхэд нэмэрлээд,
- Персид ч гэсэн. Тэр усан тэнэг болохоор болохоор түүнгүй байсан нь хамаагүй дээр байгаа биз? гэв.

Хатагтай Уизли Харрийг тэврээд улам хүчтэй гэнгэнүүлэв.

- Надад болгоомжтой байна гэж амал ... Асуудалд орооцолдохгүй гэж ...
- Би үргэлж болгоомжой байдаг, хатагтай Уизли. Та намайг тайван чимээгүй амьдралд дуртай гэдгийг мэднэ биз дээ гэж Харри хэлэв.

Хатагтай Уизли инээмсэглээд алхам холдлоо.

- За яахав ухаалаг байгаарай. Та нар бүгдээрээ шүү ...

Харри маргад ногоон дөл рүү алхан ороод «Хогвартс!» гэж хашгирлаа. Тэрбээр дөл нөмрөн авахын урьд гал зууханд байгаа хатагтай Уизлийн нулимстай царайг сүүлчийн удаа харснаа дараа нь түргэн эргэлдэхэд нүдний өмнө бусад шидтэнгүүдийн гал зуухны өрөө зурсхийн өнгөрч хараанаас алга болоод эцэст нь эргэлт удааширч профессор МакГонагаллын өрөөний ханан зууханд хөл дээрээ хатуу газар буулаа. Харриг зуухнаас гарах үед тэр өмнөө хэвтэж байсан цааснаас харцаа холдуулав.

- Оройн мэнд, Поттер. Хивсэн дээр их хөө болгочихгүйг хичээгээрэй дээ.
- Ойлголоо, профессор.

Харриг хамар дээрх нүдний шилээ засаад үсээ илэх үед ханан зууханд Рон эргэлдэн орж ирлээ. Харин дараа нь Жинни ирээд гурвуул МакГонагаллын өрөөг орхин Гриффиндорын цамхаг руу явлаа. Харри хонгилоор явахдаа цонхоор харав. Нар хэдийн доошлон гадаа гүнзгий цас Уизлийн цэцэрлэг шиг хунгарлан тогтжээ. Харри алсад Хагридын дүрс овоохойныхоо өмнө Клювокрылыг тэжээж байхыг харлаа.

- Зул сарын бөмбөлөг гэж Рон тарган хатагтайд хүрэх үед итгэлтэй хэлэв. Ердийнхөөсөө цонхийсон хатагтай түүний чанга хоолойд ярвайлаа.



- Үгүй.
- Үгүй гэдэг чинь юу гэж байгаа юм?
- Нууц үг өөрчлөгдсөн. Тэгээд бас битгий хашгир гуйж байна гэж тарган хатагтай хэлэв.
- Гэхдээ бидний хэн ч энд байгаагүй болохоор хаанаас ...
- Харри! Жинни!

Тэдэн рүү хүйтэнд улайсан Гермiona малгай бээлийтэй ирлээ.

- Би хэдийн хоёр цагийн өмнө эргэж ирсэн. Сая Хагрид Клю ... Махаон дээр зочлохоор очсон юм гэж амьсгаадан хэлээд,
- Зул сарыг сайхан өнгөрүүлэв үү? гэлээ.
- Тийм шүү, хичнээн их зүйл болсон гээч. Руфус Скрим ... гэж Рон хэлэв.
- Надад чамд хэлэх зүйл байна, Харри гэж Гермiona түүнийг үл ойшоон дуугарснаа,
- Өө, хүлээгээрэй ... нууц үг. Цээрлэлт гэв.
- Яг тийм гэж тарган хатагтай сулхан хоолойгоор хэлээд эргэж хөргөн нүх нээгдлээ.
- Тэр яагаа вэ? гэж Харри асуулаа.
- Харваас зул сараа хэтрүүлсэн бололтой гэж Гермiona нүдээ эргэлдүүлэн хэлээд түрүүлж сурагчдаар дүүрсэн зочны өрөөнд орлоо. Тэр найз Виолеттайгаа замдаа тааралдсан бүх дарсыг уугаад шившлэгийн хонгилд согтуу гэлэнтэй явж байсан.

Тэр халааснаасаа Дамблдорын бичгийн хэвтэй хуйлаастай цаас гаргалаа.

- Сайн байна гээд Харри түргэн нээж үзэхэд Дамблдорын дараагийн хичээл маргааш орой байлаа.
- Надад түүнд хэлэх зүйл олон байна ... бас чамд ч гэсэн. Алив сууцгаая ...

Тэгтэл «Бон-Бон!» гэж хашгирах чанга дуу сонсогдоод хаа нэгтээгээс Лаванда Браун ухасхийн Роныг тэвэрлээ. Үүнийг харсан хэдэн хүүхдүүд инээд алдахад Гермiona чанга хөхөрснөө,

- Тэнд сул ширээн байна ... Чи бидэнтэй суух уу, Жинни? гэв.
- Үгүй, баярлалаа би Динтэй уулзана гээд амалчихсан гэж Жинни хэлэхэд Харри түүний хоолойд ямар ч урам зориг байхгүй болохыг ажиглав. Рон, Лаванда хоёрыг босоо тэврэлттэй нь орхиод Харри, Гермionaгийн хамтаар ширээ рүү очлоо.
- Зул сарыг хэр өнгөрүүлэв?
- Муугүй гээд тэр мөрөө хавчлаа. Ямар ч онцгой зүйл байхгүй. Харин Бон-Боны хувьд яасан бэ?

- Одоохон ярья. Сонсооч Гермiona чa чадахгүй ...?
  - Үгүй, чадахгүй. Гуйсны ч хэрэггүй гэж тэр хатуу татгалзав.
  - Би чамайг ... чи ойлгож байгаа биз дээ зул сарын дараа ...
  - Энэ бол тарган хатагтай таван зуун жил торхонд хадгалсан дарс ууснаас болохоос би биш, Харри. Чи тэгээд надад ямар чухал мэдээ хэлэхийг хүсээ вэ?
- Тэр эдгээр хормын турш Рон, Харри хоёр Малфой, Снеггээс сонссон яриагаа хэлээгүй явдалд уурсан сонслоо. Түүнийг яриагаа дуусгах үед Гермiona чимээгүйхэн бодлогоширсноо,
- Чи тэгж бодож байна уу? гэв.
  - ... тэр тусламж санал болгосноороо Малфойг хуурах гэсэн гэж үү?
  - Ер нь бол тийм л дээ.
  - Роны эцэг, Люпин хоёр бас тэгж бодож байгаа юм гэж Харри дургүйхэн хэлээд,
  - Гэхдээ тэдний яриа хөөрөөнөөс үзэхэд Малфой ямар нэг зүйл хийхээр төлөвлөснийг үгүйсгэхгүй биз дээ гэв.
  - Үгүй, чадахгүй.
  - Тэгвэл тэр үнэхээр миний хэлсэн шиг Волан-де-Мортын тушаалыг биелүүлж байна!
  - Хм-м-м ... тэдний нэг яриандаа Волан-де-Мортын нэрийг дурссан юм уу? Харри хөмсөг зангидаад бүгдийг эргэн санахыг хичээлээ.
  - Би итгэлгүй байгаа ч ... Снегг эргэлзээгүй «чиний эзэн» гэсэн. Чинийхээр бол энэ өөр хэн байж болно гэж?
  - Мэдэхгүй. Магадгүй эцэг нь юм болов уу? гээд Гермiona уруулаа хазлав.
- Тэр өрөөний нөгөө өнцөг рүү бодолд автан харахдаа Роныг гижигдэж буй Лавандаг анзаарсангүй.
- Люпин хэр байна?
  - Тийм ч сайн биш гээд Харри түүний хүн чонын дунд биелүүлсэн хүнд бэрх даалгаварын тухай ярилаа.
  - Чи Фенрир Сивый гэсэн нэр сонсож байсан уу?
  - Тийм шүү, сонсож байсан! гэж Гермiona эмээнгүй дуу алдаад,
  - Чи ч гэсэн сонссон, Харри! гэв.
  - Ид шидийн түүхийн хичээл дээр үү? Чи намайг ховорхон сонсодог гэдгийг мэднэ биз дээ ...

- Үгүй, үгүй ид шидийн түүх дээр дээр биш. Малфой түүний нэрийг барин Горбиныг сүрдүүлсэн! Догшин гудамжинд санаж байна уу? Тэр Сивый гэр бүлийнх нь эртний найз бөгөөд Горбиныг амжилт гаргах хүртэл шалгаж байх болно гэсэн!

Харри амаа ангайн түүн рүү харлаа.

- Бүр мартчихаж! Энэ чинь Малфой Үхэл залгигч гэдгийг баталж байгаа биз дээ. Өөрөөр бол тэр яаж Сивыйтэй холбогдон тушаал өгч чадах юм бэ?

- Тиймээ, их сэжигтэй байна. Хэрвээ зөвхөн ... гэж Гермiona шивнэн хэлэв.

- Боль доо чи үүнийг өөрөөр тайлбарлаж чадахгүй! гэж Харри уурсан хэллээ.

- Гэхдээ ... түүний үг ердөө хоосон сүрдүүлэг байсан бол яана.

- Чи итгэмээргүй гэдгээ мэдэх үү гэж Харри толгой сэгсрэн хэлээд,

- За яахав дараа хэнийх нь зөв байсныг дараа харъя ... Чамд ид шидийн яамны адил хэлсэн үгэндээ уучлал гуйх цаг ирнэ дээ, Гермiona. Аан тийм л дээ, би Руфус Скримжертэй маргалдаад ...

Тэд үдшийн үлдсэн хэсгийг ид шидийн яамны сайдыг зүхэж өнгөрүүлэхэд Гермiona Роны адил ид шидийн яам өнгөрсөн жил учруулсан гэмийнхээ дараа тусламж гуйх нь ичгүүртэй зүйл гэж бодож байлаа.

Маргааш өглөө нь улирлын анхны өдөр зургадугаар дамжааныханд гэнэтийн бэлэг болж хэн нэгэн шөнө амралтын өрөөний зарлалын самбар дээр том хуудас наажээ.

## ШИЛЖИХ ХИЧЭЭЛ

Хэрвээ та арван долоон нас хүрсэн буюу найман сарын гучин нэгнээс өмнө хүрэх гэж байгаа бол ид шидийн яамны зааварлагч хөтлөн явуулах арван хоёр долоо хоногийн шилжих хичээлд оролцох эрхтэй болно.

Оролцох хүсэлтэй хүн гарын үсгээ үлдээнэ үү. Хөлс: 12 галлеон.

Харри, Рон хоёр жагсаалтанд нэрээ бичихээр самбарын өмнө цугласан хүүхдүүдтэй нэгдлээ. Рон үзэг авч нэрээ Гермionaгийн нэрэн доор гарын үсгээ тавихад араас нь Лаванда нүдийг нь хаагаад,

- Хэн гэдгийг нь таагаач, Бон-Бон! гэв.

Харри эргээд Гермionaгийн явахыг харж араас нь нэгдэхдээ Роныг Лавандатай орхих ямар ч хүсэл байсангүй авч түүний гайхлыг төрүүлэн Рон тэднийг хөргөн нүхээр шууд гүйцлээ. Түүний чих улайж царай нь ууртай байв. Гермiona үг хэлэлгүй алхаагаа түргэсгэн Невиллтэй цуг явлаа.

- Тэгэхээр шилжих нь маш хөгжилтэй байх, тийм үү? гэж Рон болж буй үйл явдалд нийцэхгүй өнгөөр хэлэв.

- Мэдэхгүй. Магадгүй үүнийг өөрөө хийж үзэхэд арай дээр мэдрэмж төрөх биз.

Намайг Дамблдор өөртэйгээ авч явах үед ямар ч таатай сэтгэгдэл төрөөгүй.

- Тийм дээ, би чиний шилжсэн гэдгийг мартчихаж ... Миний хувьд анхны шалгалт болох гэж байна гээд Роны царайд сэтгэл зовсон өнгө тодров.

- Фред, Жорж хоёрынх бас анхны удаа бүтэлтэй болсон.
- Гэхдээ Чарли унасан биз дээ?
- Тийм шүү, гэхдээ Чарли надаас хамаагүй биерхүү гээд Рон гараа горилл сармагчин шиг болгон алдалж үзүүлэв.
- Бид хэзээ жинхэнэ шалгалтаа өгөх юм бол?
- Арван долоо хүрэх үедээ. Надад зөвхөн гурван сар хүртэл хүлээх үлдлээ!
- Гэхдээ шилтгээний нутагт дэвсгэрт хориотой болохоор чи шилжиж чадахгүй.
- Энэ хамаатай гэж үү? Хүн бүр намайг хүссэн үедээ шилжиж чадна гэдгийг мэдэх юм чинь.

Рон шилжих хичээлд санаа зовсон цорын ганц хүн байсангүй. Өдөржин энэ тухай хичээлийн эргэн тойронд яриа хөөрөө дэгдэж бүгд алга болоод хүссэн газраа гарч ирэх тухай ярилцав.

- Янзтай, бид үүнийг чаддаг болох нь гээд Симус хуруугаа цагариглан алга болохыг дүрслэн үзүүлээд,
- Миний үеэл Фергюс намайг зөвхөн уурлуулахын тулд үүнийг хийдэг байсан юм. Гэхдээ зүгээр дээ, тэр намайг хүлээж л байг. Би түүнд ахиж боломж өгөхгүй юм чинь!

Аз жаргалтай ирээдүйн дүр зурагт тэр хөөрсөндөө шившлэгийн хичээл дээр усан оргилуур болгох ёстой байсан цэвэр ус руу саваагаа хэтэрхий урамтай даллахад адар цохин олгойдоод профессор Флитвикийн нүүр лүү шүршлээ.

- Харри хэдийн шилжиж үзсэн гэж Рон профессор Флтивик ганцхан даллан хувцсаа хатгаад Симусыг хэдэн удаа «Би шидтэн болохоос шидэт саваатай сармагчин биш» гэж бичүүлсний дараа хэллээ.
- Ээ ... Нэг хүн түүнийг өөртэйгээ аваад шилжсэн юм. Хос шилжилт гэж мэднэ биз дээ.
- Хөөх! гэж Симус шивнээд Дин, Невилл нарын хамт Харри руу бөхийн шилжихэд юу мэдэрдэг талаар сонслоо.

Зургадугаар дамжааныхан тэр үдэш Харриг асуултаар булаав. Түүнийг шилжихэд хэрхэн эвгүй байдаг тухай ярих үед тэдэнд эмээхээсээ бишрэх сэтгэл төрсөн бололтой. Харри найман цаг болоход арван минут дутуу байх үе хүртэл асуултанд хариулсаар Дамблдорын хичээл рүү явахын тулд номын санд сурах бичгээ мартсан тул буцах хэрэгтэй байна гэж хэлэх хэрэг гарчээ.

Дамблдорын өрөөний бүх дэнлүү асаж өмнөх захирлын хөргүүд жаазандаа аяархан хурхиран, гүн ухааны цүнхээл бэлхэн ширээн дээр тавиаастай байлаа. Дамблдорын алгаа суулгын ирмэг дээр тавихад баруун нь урьдын адил хар байсан хэвээр байв. Тэр хэзээ ч эдгэрэхгүй юм шиг санагдахад Харри зуу дахь удаагаа яагаад гэмтсэнийг нь гайхширсан ч асуусангүй. Дамблдор үүнийг цаг нь болохоор мэдэх болно гэж

хэлсэн тул өөр сэдвээр ярихыг хүслээ. Гэхдээ түүнийг Снегг, Малфой хоёрын тухай ямар нэг зүйл ярьж амжихаас урьтаж Дамблдор,

- Би чамайг зул сараар яамны сайдтай уулзсан гэж сонслоо? гэв.
- Тиймээ. Тэгээд ч тэр надаас тийм ч баяртай үлдээгүй.
- Үгүй ээ гэж Дамблдор санаа алдаад,
- Ер нь бол тэр надад таагүй байгаа юм. Харин бид тэмцлээ үргэлжлүүлэхийн тулд таагүй зүйл сонсох ёстой байдаг.

Харри инээмсэглэв.

- Тэр намайг шидтэнгүүдийн ертөнцөд ид шидийн яам ажлаа сайн хийж байгааг үзүүлэхийг хүссэн.

Дамблдор инээмсэглэв.

- Ер нь бол энэ Фажын санаа байгаа юм. Тэр сайд байх сүүлчийн өдрүүдээ эрх мэдлээсээ цөхрөн зууралдаж чамтай уулзахыг оролдон өөрийг нь дэмжинэ гэж найдаж байсан.

- Фаж өнгөрсөн жил хийсэн энэ бүхнийхээ дараа юу? Амбрижын дараа юу? гэж Харри уурсан асуулаа.

- Би Корнелиуст ямар ч боломж байхгүй гэж хэлсэн ч энэ санаа түүнийг огцорсны дараа бөхөөгүй бололтой. Хэдхэн цагийн дараа Скримжер түүний байрыг эзлээд надтай уулзах үедээ чамтай яриулахыг шаардсан.

- Тийм учраас л та хоёр маргалдаа юу! Би энэ тухай «Өдөр тутмын зөнч» сонингоос уншсан.

- «Зөнч» сонин заримдаа үнэнийг хэлдэг юм. Тиймээ бид үүнээс болж маргалдсан. Харваас Руфус чамайг буланд шахах боломж олсон бололтой.

- Тэр намайг Дамблдорын бүрэн дүүрэн хүн гэж буруутгасан.
- Ямар бүдүүлэг хэрэг вэ.
- Харин би түүнд яг тийм гэж хэлсэн.

Дамблдор юм хэлэх гэснээ чимээгүй боллоо. Харрийн ард галт шувуу Фоукс аяархан уянгалан дуугарав. Харри гэнэтхэн Дамблдорын цэнхэр нүдэнд нулимс цийлэгнэхийг хараад ичсэндээ яаран харц буруулав. Гэвч ярьж эхлэх үедээ түүний хоолой хатуу дуулдаж байлаа.

- Би их яарч байна, Харри.
- Скримжер таныг Хогвартсаас хаачаад байгааг мэдэхийг хүссэн гэж Харри өвдөгнөөсөө харцаа холдуулалгүй хэллээ.
- Тиймээ, тэр энэ тухай мэдэхийг маш их хүсч байгаа гэж Дамблдор хөгжилтэй хэлэхэд Харри дээшээ харж болно гэж шийдлээ.

- Тэр намайг мөрдөхийг хичээж байгаа юм. Энэ ч хөгжилтэй шүү. Тэр миний араас Долишыг тавьсан. Энэ бол эелдэг бус хэрэг л дээ. Би түүнийг нэг удаа хөшөөж байсан болохоор одоо үүнийгээ хоёр дахь удаа хийхэд хүрсэндээ ихэд харамссан шүү.

- Тэгэхээр тэд таны хаашаа алга болж байгааг мэдэхгүй байх нь ээ? гэж Харри асуугаад ой ухаанд нь энэ нууцыг тайлах найдлага зурхийсэн ч Дамблдор инээмсэглээд нүдний шилэн дээгүүрээ ширтэв.

- Үгүй, мэдэхгүй тиймээ энэ тухай мэдэх цаг чинь болоогүй. Одоо ажилдаа орсон нь дээр байх хэрвээ чи өөр зүйл ярихыг хүсээгүй бол ...

- Хүсч байна, эрхэм ээ. Энэ бол Малфой, Снегг хоёрт хамаатай зүйл.

- Профессор Снегг гээч, Харри.

- Тиймээ, эрхэмээ. Би тэдний яриаг профессор Слизнортын үдэшлэг дээр сонссон ... Үнэнийг хэлэхэд би араас нь дагасан юм ...

Харрийн түүхээ ярихыг Дамблдор амгалан царайтай сонсож байлаа. Түүнийг яриагаа дуусгахад хэдэн секунд дуугүй байснаа,

- Энэ тухай хэлсэнд баярлалаа, Харри. Гэхдээ үүнийг толгойноосоо гаргаж хаяхыг зөвлөж байна. Би үүнд чухал юм байна гэж бодохгүй байна гэлээ.

- Чухал юм байхгүй гэнээ? хэмээн Харри чихэндээ үл итгэн асуугаад,

- Профессор та ойлгохгүй байна ... гэв.

- Тиймээ, Харри би ховорхон тохиолдох сэтгэлгээний чадвараар чиний надад хэлсэн бүх зүйлийг ойлгосон гэж Дамблдор хөнгөхөн даажигнан хэлээд,

- Чи намайг илүү их зүйл ойлгохыг хүсэж байгаа байх. Давтаж хэлье, чамайг надад итгэдэгт баяртай байдаг ч түгшээх зүйл юу ч болоогүй гэдгийг хэлье гэв.

Харри чимээгүй суугаад Дамблдор руу ширтлээ. Юу болоод байна? Дамблдор үнэхээр Снеггэд Малфойн бодлыг мэдэхийг тушаасан юм болов уу? Тэгвэл Харрийн ярьсан бүхнийг Снеггээс мэдсэн юм байх даа? Эсвэл Харрийн хэлсэн зүйл сэтгэлийг нь зовоож байсан ч тэгээгүй мэт дүр эсгэж байгаа биш биз?

- Ноёнтоон та түүнд урьдын адил итгэсээр байгаа хэрэг үү? ... гэж Харри хэлэхдээ аль болох тайван дуугарахыг хичээв.

- Надад энэ асуултанд хариулах тэвчээр хангалттай болсон гэж Дамблдор хэлсэн ч хоолойд нь тэсч ядсан өнгө сонсогдсонгүй. Тэгээд ч миний хариулт урьдын адил хэвээр үлдэнэ.

- Үгүй ер! гэх Финеас Найжелусын егөөдөнгүй дуу гарсан ч Дамблдор түүнд анхаарал хандуулсангүй.

- Харин одоо Харри бид ажилдаа орох хэрэгтэй байна. Би чамтай энэ үдэш их чухал зүйлийн талаар ярилцах гэсэн юм.

Харри будилж гүйцжээ. Тэр яагаад Малфойн эсрэг буруутгалын сэдвийг өөрчилж байгаа юм бол? Дамблдор түүний бодлыг уншсан бололтой толгой сэгсэрлээ.

- Ай, Харри минь заримдаа ийм тохиолдол сайн найзуудын хооронд хүртэл тохиолддог юм! Хүн бүр өөрийнх нь хэлж байгаа зүйл илүү чухал гэдэгтээ итгэлтэй байдаг!

- Би таныг чухал биш юм хэлсэн гэж бодоогүй, эрхэмээ.

- Тэгвэл чиний зөв учир нь тийм биш юм. Би чамд өнөөдөр хоёр дурсамж үзүүлэхийг хүсч байна. Би тэднийг хүндхэн олсон бөгөөд хоёр дахь нь миний бодлоор бусдаас илүү чухал байгаа юм.

Харри мэдээллийг нь няцаасан явдалд уурласан хэвээр байсан тул юу ч хэлсэнгүй.

- Тэгэхээр бид өнөөдөр уулзсаны учир нь гэвэл Том Реддлийн түүхийг үргэлжлүүлэн ярих гэсэн юм. Өнгөрсөн хичээл дээр бид түүнийг Хогвартст элсэхийн өмнө орхисон билээ. Чи Реддл шидтэн гэдгээ дуулаад хэрхэн сэтгэл нь хөөрөн надтай хамт Тахир гудамжинд очихоос татгалзсан болон би түүнд сургуульд хулгай хийж болохгүй гэж анхааруулсныг санаж байгаа.

- Сургуулийн хичээлийн шинэ жил эхлэхэд Том Реддл хуучин жанчтай чимээгүй хүү ирээд бусад нэгдүгээр дамжааныхантай хамт хуваарлигдахаа хүлээн зогсож байсан. Хуваарилагч бүрх Реддлийн толгойд дөнгөж хүрмэгц Слизеринд хуваарилсан юм гээд Дамблдор харласан гараараа тавиур дээр хөдөлгөөнгүй байгаа малгай руу заалаа.

- Реддл маш түргэн энэ тэнхимийг үндэслэгч могойн хэлээр ярьж чаддаг байсныг мэджээ. Магадгүй тэр үдшээ ч байж болно. Энэ мэдээ түүнийг хүчтэй догдлуулж өөртөө эрэмших сэтгэлийг нь нэмэгдүүлсэн байна.

- Хэдийгээр тэр Слизериний нэг ангийхнаа айлгах юмуу сэтгэгдэл төрүүлэхийн тулд амралтын өрөөнд могойн хэлээр ярьж байсан ч багш нар энэ тухай юу ч мэддэггүй байлаа. Тэр гадна өнгөндөө ямар ч биеэ тоосон түргэмгий зан үзүүлсэнгүй. Багш нар энэхүү ер бусын авъяаслаг үзэсгэлэнтэй өнчин хүүг ирсэн анхны өдрөөс анхаарал халамж тавьсан юм. Тэр эелдэг тайвнаар мэдлэг хүсч байлаа. Бараг бүх хүнд тэр таатай сэтгэгдэл төрүүлсэн.

- Харин та тэдэнд асрамжын газар ямар байсныг нь хэлээгүй юу?

- Үгүй хэлээгүй. Тэр гэмшлийн ямар ч тэмдэг үзүүлээгүй ч өмнөх үйлдэлдээ харамсан амьдралаа цэвэр цаас шиг шинээр эхлэхийг хатуу шийдсэн байж болох юм. Би түүнд тийм боломж өгөхөөр шийдсэн билээ.

Дамблдор чимээгүй болсноо үг хэлэхээр ам нээсэн Харри руу асуунгуй харлаа. Тэр Дамблдор үргэлж хүмүүст итгэл хүлээх гавьяагүй гэдэг олон тооны баримтыг үл харгалзан итгэдэг болохыг мэднэ. Тэгтэл Харри нэг зүйл саналаа.

- Гэхдээ та түүнд жинхэнээсээ итгээгүй биз дээ, эрхэмээ? Тэр надад тэгж хэлсэн ... Реддл тэмдэглэлийн дэвтрээс гарч ирээд «Дамблдор би хэзээ ч бусад сурагчдын адил таалагдаж байгаагүй» гэсэн.

- Бид миний түүнд итгэж болох эсэх тухай яриагүй. Би хэдийн шинж тэмдэг ажигласан болохоор түүнээс нүд салгахгүй байхаар шийдсэн. Тэгээд ч нүд салгаагүй. Эхэндээ миний ажиглалт олон зүйлийг өгөөгүй. Реддл үнэн төрхийг нь илрүүлж болно гэдгийг ойлгож байсан учраас надтай болгоомжтой харьцаж нэг их зүйл яриагүй. Тэр цаашид ч олон зүйл ярихгүйг хичээсэн авч сэтгэл хөдөлсөн хоромдоо ам нээсэн мөчийг буцаах боломжгүй байсан. Яг л хатагтай Коулын хэлсэн шиг. Ерөнхийдөө түүнд надад орооцолдохгүй байх ухаан хангалттай байсан юм.

- Тэр ангиас анги дэвшин сурахдаа өөрийгөө тойруулан үнэнч найз нөхдөө цуглуулсан. Би тэднийг тэгж дуудаж байгааг учир нь илүү тохиромжтой үг олохгүйдээ ч биш Реддл тэдний хэнтэй ч онцгой холбоогүй байсанд оршиж байгаа юм. Эдгээр сурагчдыг ямар нэг баргар зүйл ноёлож байв. Тэдгээр нь олон янзын байсан бөгөөд сул дорой хамгаалалт хэрэгтэй хөвгүүд, цэвэр цус алдар гавьяанд дурлагчид, хүмүүсийг хүчээр бөхийлгөх дуртай гэх мэтчилэн илүү хэрцгий болгон сургаж болох хүмүүс багтаж байлаа. Өөрөөр хэлвэл тэдний дундаас Хогвартсын анхны Үхэл залгигчид төрсөн билээ.

- Реддл тэднийг буруу зүйл хийлгэлгүй хатуу гараар барьж байсан бөгөөд долоон жилийн дотор багагүй үйл явдал болсны хамгийн ноцтой нь нууц өрөөг нээж үр дүнд нь нэг охин үхсэн юм. Чи үүнд Хагридыг буруутгаж шийтгэснийг мэднэ.

- Би Реддлийн Хогвартсед суралцаж байх үеэс тийм ч олон дурсамж цуглуулж чадаагүй гээд Дамблдор харласан алгаараа гүн ухааны цүнхээлийг илж,

- Түүний тухай багахан зүйл мэдэх хэсэг нь ярихад бэлэн байсан авч хэтэрхий айсандаа болоод хэлэхээс татгалзсан. Би түүнийг Хогвартсыг орхисны дараа хичээнгүй чармайлт гарган ул мөрийг нь хайж ярьж болох хүмүүсийг олон, хуучин бичиг баримт ухаж, магл болон шидтэнгүүдээс асуусан гэв.

- Би түүнтэй хийсэн ярианаас Реддл төрөл төрөгсдөө дэмжиж байсныг мэднэ.

Тиймээ Реддл асрамжын газар өссөн болохоор хаанаас ирснээ мэдэх гэж оролдох нь ойлгомжтой. Тэр Том Реддлийн ул мөрийг анхааралтай эрж алдрын танхим, сургуулийн ахлагч байсан хүмүүсийн жагсаалт тэр ч байтугай ид шидийн түүхийн номонд хүртэл хайсан. Эцэст нь түүнд эцэг нь Хогвартсад хэзээ ч сурч байгаагүй гэсэн бодолтойгоо эвлэрэх хэрэг гарчээ. Бодвол тэр үедэс өөрийнхөө нэрээс үүрд татгалзан лорд Волан-де-Морт нэрийг бодон олж үзэн яддаг байсан эхийнхээ талыг судалж эхэлсэн байна. Хэрвээ чи санаж байгаа бол тэр ээжийгээ сул дорой хүний үхлээр ичгүүртэй нас барсан учраас шидтэн биш гэж бодож байсан.

- Реддл зөвхөн цорын ганц Марвало гэсэн нэр олж чаджээ. Тэр асрамжын газрын эрхлэгч ээжийнх нь эцгийг тэгж хэлснийг мэдэх байлаа. Удаан хугацааны няхуур эрэл хайгуулын үр дүнд эртний шидтэнгүүдийн удам угсааны номноос Слизериний хамаатан болохоо мэдсэн байна. Арван зургаан насныхаа зун тэр амралтаараа үргэлж ирдэг байсан асрамжын газрыг орхиж өөрийн хамаатан болох Мраксуудыг хайхаар явсан байна. Харин одоо, Харри чи босоод ир дээ ...

Дамблдор өндийхөд Харри түүний гарт хуйларсан цагаан шингэнээр дүүрэн болор хуруу шил байхыг харлаа.



- Надад үүнийг цуглуулах маш ховор аз тохиолдсон юм гээд Дамблдор гялалзсан шингэнийг гүн ухааны цүнхээл рүү хийж,

- Чи үүнийг харах үедээ ойлгох болно. За эхлэх үү? гэлээ.

Харри чулуун суулга руу ойртон нүүрээ дурсамжийн гадаргууд дүрэхэд танил мэдрэмж хаман авч хоосонд унаснаа харанхуйд бохир чулуун шалан дээр буулаа.

Түүнд хаана байгаагаа мэдэхийн тулд хэдэн агшин шаардсан ч тэр үед Дамблдор дэргэд нь газардав. Мраксын гэр ер бусын бохир заваан байж Харри амьдралдаа ийм газар харсангүй. Адар аалзны шүлсээр дүүрч, шалан дээр битүү хөө тортог тогтон, ширээн дээр угаагүй аяга таваг дүүрэн овоорчээ. Цорын ганц гэрэл гарч байгаа зүйл ам хамар нь ялгагдахааргүй үс сахал ургасан хүний хөлд байлаа. Ханан зуухны хажуугийн сандалд суугаа хүнийг хараад Харрид агшин зуур үхсэн гэсэн мэдрэмж төрөв. Тэгтэл хэн нэгэн хаалга чанга цохиход тэр цочин сэрээд баруун гартаа шидэт саваа, зүүн гартаа хутга барилаа.

Хаалга чахран онгойлоо. Үүдэн дээр хуучин загварын дэнүү барьсан өсвөр насны хүү зогсож байсныг Харри шууд танилаа. Өндөр цонхигор царай хар үстэй царайлаг залуу Волан-де-Морт байв.

Волан-де-Мортын харц удаанаар доошилсноо сандал дээр сууж байгаа хүн дээр тогтов. Хэсэг хугацааны турш тэд бие биенээ ширтэн харлаа. Дараа нь эрэгтэй хүн шалан дээр байсан хоосон лонхнуудыг харжигнуулан гуйвлан босов.

- Чи! Чи! гэж тэр хашгирав.

Тэрбээр хутга, шидэт саваагаа даллан Реддл руу ухасхийлээ.

- Зогс!

Реддл энэ үгийг могойн хэлээр хэллээ. Эрэгтэй ширээний дэргэд гулган зогсоход шалан дээр сав суулга тачигнан унав. Тэд удтал бие биенээ бодлогоширон харлаа. Эцэст нь нам гүмийг эзэн эвдэж,

- Чи түүгээр ярьж чаддаг юм уу? гэв.

- Тиймээ, би түүгээр ярьдаг гэж Реддл хэлээд өрөөнд орж хаалга хаалаа.

Харри Реддл айсан дүр үзүүлсэнгүйд багагүй бишрэх сэтгэл төрөв. Түүний царайд дургүйцэж урам хугарсан өнгө тодорлоо.

- Марвало хаана байна?

- Үхсэн. Олон жилийн өмнө үхсэн. Харин чи хэн гээч вэ?

Реддл хөмсгөө зангидлаа.

- Тэгвэл чи хэн болж байна?

- Морфин өөр хэн байдаг юм?

- Марвалогийн хүү юу?

- Мэдээж хүү нь гэдэг нь тодорхой харин ...

Морфин Реддлийг сайн харахын тулд бохир үсээ холдуулахад Харри түүний баруун гарт Марвалогийн хар чулуун бөгж байхыг харлаа.

- Харин чи маглаас ирсэн. Чи тэр маглтай адилхан юм гэж Морфин шивнэлээ.
- Ямар магл? гэж Реддл огцом асуув.
- Миний дүүд таалагддаг байсан магл. Тэр замын хажуугийн том байшинд амьдардаг юм гээд Морфин гэнэтхэн шал руу нулимснаа,
- Чи түүнтэй их адилхан юм байна. Реддлтэй. Зөвхөн тэр чамаас ахмад юм байна ... гэв.

Морфин согтуу мэт үл ялиг ганхсанаа ширээний ирмэгээс зуурав.

- Тэр эргээд ирсэн.

Волан-де-Морт Морфин руу харснаа юу чадахыг нь цэгнэж байгаа бололтой. Дараа нь Морфин руу ойртон,

- Реддл эргээд ирсэн хэрэг үү? гэв.
- Аанхан, тэр түүнийг бузар гэрлэлтийнхээ дараа хаяад ирсэн гээд Морфин ахин нулимлаа.
- Харин тэр зугтахынхаа өмнө биднийг дээрэмдсэн! Зүүлт хаа байна аан, Слизериний зүүлт хаа байна?

Волан-де-Морт хариулсангүй. Морфин уурсаж эхлэн хутгаа даллан хашгирлаа.

- Биднийг тэр завхай хүүхэн шившиг болгосон! Чи наашаа ирж асуулт асуудаг хэн юм? Бүх зүйл хэдийн дууссан ... бүгд дууссан.

Тэр цааш харснаа найгахад Волан-де-Морт урагш алхав. Тэгтэл ер бусын харанхуй болж Волан-де-Мортын дэнлүү болон Морфины лаа унтраад бүх зүйл бөхлөө ...

Дамблдорын хуруу Харрийн гарнаас атгаад хоёул хөөрөн ахин одоо цагтаа буцан ирлээ. Харрид бүүдгэр харанхуйн дараа Дамблдорын өрөөний алтлаг лааны гэрэл нүд гялбам санагдав.

- Ингээд л болоо юу? Яагаад харанхуй болсон бэ? Юу болсон юм?
- Яагаад гэвэл үүнээс цаашиг нь Морфин санахгүй байгаа юм гээд Дамблдор Харриг сандалд суухыг зангалаа.
- Тэр маргааш өглөө нь сэрээд шалан дээр ганцаар хэвтэж байгаагаа мэдсэн.

Харин Марвалогийн бөгж алга болсон байсан.

- Энэ үед Бага-Хэнглтоны тосгоны гудамжаар үйлчлэгч эмэгтэй гүйж том байшингийн зочны өрөөнд гурван үхдэл хэвтэж байна гэж хашгирч байлаа. Том Реддл болон түүний эцэг эх гурав.

- Маглууд юу ч ойлгоогүй. Авада Кедаврагийн шид ямар ч ул мөр үлдээдэггүй болохоор тэд одоо хүртэл Реддлийнхнийг юунаас болж үхсэнийг мэдэхгүй байгаа ... Гэвч нөгөө өнцгөөс ид шидийн яам аллагыг шидтэн үйлдсэн гэдгийг даруй ойлгосон.

Тэд магл үзэн ядсан хэргээр яллагдаж жирийн хүн рүү дайрсныхаа төлөө шоронд хоригдсон хүн тосгоны гадаа Реддлийн байшингаас холгүйхэн суудгийг мэдэж байв.

- Иймээс ид шидийн яам Морфиныг баривчилсан байна. Түүнд үнэнийг хэлүүлэгч уусмал өгч легилменцийг хэрэглэх хэрэг байсангүй. Тэр шуудхан бардмаар аллагад буруутай гэдгээ хүлээн зөвшөөрч энэ гэмт хэрэгт буруутай гэдгээ мэдэгдсэн байна. Тэр маглыг алсандаа баяртай байгаа бөгөөд ийм боломжыг олон жилийн турш хүлээсэн гэдгээ хэлжээ. Морфины шидэт саваагаар Реддлчүүдийг алсан гэдэг нь ойлгомжтой байлаа. Тэр эсэргүүцэж тэмцэлгүй Азкабанд суужээ. Түүнийг ердөө ганц л зүйл болох эцгийнхээ бөгжийг алдсан явдал зовоож байсан байна. «Тэр намайг ална даа. Тэр намайг бөгжийг алдсаны төлөө алдна даа» гэж Морфин шоронд ахин дахин давтдаг байж. Түүнээс өөр зүйл хэзээ ч хэлээгүй байна. Морфин амьдралынхаа сүүлчийн өдрийг хүртэл Азкабанад Марвалогийн удмын сүүлчийн зүйлийг алдсандаа харамсан суугаад дөрвөн хананы дунд золгүйгээр нас эцэслэн оршуулга нь шоронд явагдсан байна.

- Тэгэхээр Волан-де-Морт Морфины савааг ашигласан хэрэг үү? гэж Харри асуугаад сандлаасаа бослоо.

- Яг зөв. Бидэнд үүнийг батлах дурсамж байхгүй хэдий ч үнэхээр тэгсэн гэдэгт итгэлтэй байна. Волан-де-Морт нагац ахаа шившлэгээр хөшөөгөөд шидэт савааг нь авч тосгоны хажуу дахь том байшин руу очжээ. Тэнд эхийг нь хаясан маглыг эцэг эхийнх нь хамт алаад Реддлийн удмын сүүлчийн төлөөлөгчдийг устган эцэгтэйгээ уулзахыг хүсээгүй байна. Дараа нь Мраксын овоохойд эргэж ирээд ярвигтай шидийн тусламжтай түүний ой ухаанд хуурамч дурсамж суулган савааг ухаангүй хэвтэх эзнийх нь дэргэд хаяад эртний бөгжийг халааслан алга болжээ.

- Тэгээд Морфин хэзээ ч буруугүй гэдгээ ойлгож байгаагүй хэрэг үү?

- Хэзээ ч гэж Дамблдор батлаад,

- Тэр миний хэлсэнчлэн бардмаар хэргээ хүлээсэн юм.

- Гэхдээ энэ бүх хугацаанд түүний оюун ухаанд жинхэнэ дурсамж хадгалагдсаар байсан хэрэг үү!

- Яг тийм, би түүнээс гарган авахыг тулд хүнд хэцүү легилменцийн шившлэг хэрэглэсэн. Морфин хэдийн хэргээ хүлээсэн учир түүний ой ухааны нэгжиж үзэх санаа хэний ч толгойд ороогүй байна. Гэсэн ч би түүний амьдралын сүүлчийн долоо хоногт уулзах аз тохиосон бөгөөд тэр үед Волан-де-Мортын өнгөрсөн үеийн тухай аль болох олон зүйл мэдэхийг хүсч байсан билээ. Би түүнээс жинхэнэ дурсамжыг хүндхэн гаргаж аваад Азкабанаас чөлөөлөхийг оролдсон. Гэвч яам шийдвэр гаргахаас урьтаж Морфин үхсэн юм.

- Гэхдээ ид шидийн яам яагаад энэ бүхнийг Волан-де-Морт хийсэн гэдгийг тааварлаагүй юм бэ? Тэр тэгэхэд насанд хүрээгүй байсан биз дээ? Би яамныхан насанд хүрээгүй шидтэний шид хэрэглэх эрхийг хянаж байдаг гэж бодсон юмсан! гэж Харри уурсан хэллээ.

- Чиний зөв, тэд шидийн үйлчлэлийг илрүүлж чадах хэдий ч хэн хийсэн болохыг нь мэдэхгүй. Иймээс ид шидийн яамнаас чамайг левитацийн шид ашигласан гэж буруутгасныг санаж байгаа биз дээ ...

- Добби гэж энэ шударга бус буруутгал дотроос нь зовоож байсан Харри уурсан бувтналаа.

- Хэрвээ насанд хүрээгүй хүүхэд шидтэний гэрт ид шид ашиглавал яам энэ тухай мэдэх үү?

- Хэн жинхэнэ шид хэрэглэсэн гэдгийг тодруулж чадахгүй гэж Дамблдор Харрийн эгдүүцсэн царайг хараад үл мэдэг инээмсэглэн хэлэв. Гэхдээ тэд шидтэн эцэг эхчүүдийг хүүхдүүдээ гэртээ хянаж чадна гэж найддаг юм.

- Юун дэмий үг вэ! Морфинд юу болсныг хараач! гэж Харри уурсан хэллээ.

- Тиймээ үүнийг зөвшөөрч байна. Ямар ч байсан Морфин хийгээгүй аллагынхаа төлөө буруутгагдан тийм үхлийг хүртэх ёсгүй байсан. Цаг оройтсон хэдий ч би чамайг явахаас өмнө өөр нэг дурсамж харахыг хүсэж байна ...

Дамблдор халааснаасаа өөр нэг хуруу шил гаргаж ирэхэд Харри энэ дурсамж бүгдээс илүү чухал олдоход хэцүү байсан гэдгийг саналаа. Харри шилэн дэх бодис гүн ухааны цүнхээл руу дургүйхэн живэхийг хараад магадгүй энэ муу дурсамж юм болов уу? гэж бодлоо.

- Энэ тийм ч их цаг авахгүй гэж Дамблдор хуруу шилийг хоослоод хэлээд,

- Чамайг ухаарч амжихаас өмнө бид эргэж ирсэн байх болно. За ахин нэг удаа гүн ухааны цүнхээлд шумбах уу ... гэв.

Харри ахин мөнгөлөг гадаргуу руу ороод энэ удаад дэргэд нь газардсан хүнээ шууд танилаа.

Энэ бол залуу Гораций Слизнорт байлаа. Харри түүний халзан толгойг тойрсон өтгөн гялалзсан цайвар үсэнд дассан болохоор битүү үстэй байхад нь үл мэдэг балмагдсан ч профессорын зулай дээр нь галлеон шиг гялалзсан дугуй байхыг харлаа. Слизнортын сахал тийм ч өтгөн биш цайвар байв. Тэр Харрийн мэдэх Слизнорт шиг махлаг биетэй алтан товчтой хилэн хантаазныхаа цаанаас том гүзээтэй хүн байсангүй. Богино хөлөө дэрэн дээр тавин түшлэгтэй өндөр сандалд суугаад нэг гартаа дарстай шилэн аяга, нөгөө гартаа хайрцаг чихэртэй хан боргоцой барьжээ.

Дамблдор дэргэд нь ирэхэд Харри эргэн тойрноо хараад Слизнортын өрөөнд байгаа болохоо ойлгов. Өрөөний эзнийг тойроод арваад өсвөр насны хүү арай намхан суудалд суужээ. Харри Реддлийг шууд танив. Тэр бусад хөвгүүдээс үзэсгэлэнтэй илүү амирлангуй харагдах агаад баруун гараа сандлын түшлэг дээр тавьжээ. Харри гэнэтхэн түүнийг Марвологийн хар чулуутай алтан бөгж зүүснийг танилаа. Реддл хэдийн эцгээ алсан бололтой.

- Ноёнтоон, профессор Вилкост тэтгэвэртээ гарч байгаа гэсэн үнэн үү? гэж Реддл асуулаа.

- Том, Том би энэ тухай мэдэх байсан ч та нарт хэлэхгүй байсан гэж Слизнорт зэмлэнгүй чихэртэй хуруугаа гозойлгон хэлээд,

- Би чамайг багш нарын хагас нь мэдэхгүй мэдээллийг хаанаас авсан болохыг мэдэхгүй юм гэв.

Реддл инээмсэглэхэд бусад хөвгүүд инээд алдан түнийг бахадсан харцаар харав.

- Таны ер бусын авъяас хэнтэй яаж харьцахаа мэдэх юмаа ... Ингэхэд хана боргоцойнд чинь баярлалаа таны зөв, би үүнд дуртай.

Хөвгүүдийн нэг ахин инээхэд ер бусын хачирхалтай зүйл болов. Өрөөнд гэнэтхэн өтгөн цагаан манан суунаглан Харри дэргэдээ зогсож байгаа Дамблдороос ондоо хэний ч царайг ялгаж чадааргүй болов. Дараа нь манангаас Слизнортын чанга хоолой ялгарч,

- Чи буруу замаар явж байна, хүү минь. Миний үгийг санаж яваарай гэв.

Манан гэнэтхэн гарч ирсэн шигээ арилахад хэн ч ер бусын зүйл болсон тухай үг цухуйлгасангүй. Харри Слизнортын ширээний ард байсан жижигхэн алтан цагийг харахад арван нэг болж байв.

- Бурхан минь ийм оройтсон гэж үү? хэмээн Слизнорт гайхшираад,

- Та нар явсан нь дээр байх, хөвгүүд минь тэгэхгүй бол таагүй явдалд орооцолдох болно. Лестрейнж би таныг маргааш өглөө зохион бичлэгээ өгөхгүй бол хичээлийн дараа үлдээхэд хүргэнэ шүү. Энэ ч гэсэн таньд хамаатай Эйвери.

Хөвгүүд өрөөг орхин гарахад Слизнорт сандал дээрээ суугаад ширээн дээр байсан хоосон шилэн аягыг авлаа. Реддл явахыг яарсангүй. Харри түүнийг Слизнорттой үлдэхийг хүссэн мэт зориуд хөдөлж ядахыг харав.

- Яарсан нь дээр шүү, Том гэж Слизнорт түүний байгааг харж хэлээд,

- Та ч гэсэн унтах ёстой цагаас гадуур явах ёсгүй. Ингэхэд та чинь ахлагч биз дээ ... гэв.

- Ноёнтоон, би танаас юм асуух гэсэн юм.

- Тэгвэл асуу хүү минь, асуугтун ...

- Ноёнтоон би таныг крестражын тухай мэдэх байх гэж бодлоо?

Ингээд үйл явдал ахин давтагдаж өрөө өтгөн манангаар дүүрэн Харри дэргэдээ зогсоод инээмсэглэж буй Дамблдороос ондоо хүн харч чадахгүй болов. Тэгтэл ахин Слизнортын хоолойг сонсогдов.

- Би крестражын тухай юу ч мэдэхгүй. Мэдэх байсан ч таньд хэлэхгүй! Харин одоо эндээс даруйхан гарч үз. Би таныг энэ тухай ярихыг чинь ахиж сонсохыг хүсэхгүй байна!

- Ингээд болно. Буцах цаг боллоо гэж Дамблдор тайван хэлэв.

Дараагийн агшинд Харрийн хөл шалан дээр газардаад ахин Дамблдорын ширээний урдах хивсэн дээр зогсож байлаа.

- Ингээд л болоо юу? гэж мэгдэн тэр асуув.

Дамблдор үүнийг бүгдээс чухал дурсамж гэж хэлсэн ч Харри онцгой зүйл юу ч олж харсангүй. Үнэндээ манан байсан хэдий ч хачирхалтай зүйл юу ч бололгүй Реддл тавьсан асуултынхаа хариуг авч чадсангүй.

- Чи энэ дурсамж бага зэрэг засагдсан гэдгийг ажигласан байх гэж Дамблдор ширээнийхээ ард суугаад хэлэв.

- Засагдсан гэнээ? хэмээн Харри сандал дээр суун давтлаа.

- Ямар ч эргэлзээгүй гэж Дамблдор батлаад,

- Профессор Слизнорт надад дурсамжаа өгөхийн өмнө ажиллаж амжсан юм гэв.

- Гэхдээ яах гэж?

- Би түүнд энэ дурсамжаас ичих шалтгаан байсан гэж бодож байна. Тэр дурсамжаа өөрчлөх замаар илүү гэрэлтэй талаа үлдээн хүсээгүй хэсгээ надад харуулахааргүй болгожээ. Жинхэнэ дурсамжаа өөрчлөн үзүүлнэ гэдэг бүдүүлэг хэрэг болохыг чи ажигласан байх.

- Ийм учраас би чам анх удаагаа гэрийн даалгавар өгөх гэж байна, Харри. Чи профессор Слизнортой ярьж бүтэн дурсамжаа үзүүлэхийг ятгах ёстой. Тэр нь эргэлзээгүй бидний хувьд хамгийн чухал шийдвэрлэх хэсэг байх юм.

Харри Дамблдор руу харлаа.

- Гэхдээ уучлаарай, эрхэмээ гэж аль болох хүндэтгэсэн өнгөөр дуугарахыг хичээгээд,

- Яагаад би гэж? Та легилменцийг ашиглах юмуу ... эсвэл үнэнийг хэлүүлэгч уусмал өгч ... гэв.

- Профессор Слизнорт туйлын авъяаслаг шидтэн болохоор эдгээр боломжуудыг бүгдийг нь урьдчилан харсан байгаа. Бас золгүй Морфин Мраксыг бодвол түүний авъяасын багагүй хэсгийг окклменций эзэлдэг юм. Хэрвээ би профессорыг дурсамжаа үзүүлэхийг албадаад үнэнийг хэлүүлэгч уусмал үйлчилвэл их гайхахад хүрэх байна.

- Үгүй ээ, ийм аргаар профессор Слизнортыг үнэнийг хүчээр хэлүүлэх оролдлого хийх нь тэнэг хэрэг. Би түүнийг Хогвартсыг орхихыг хүсэхгүй байгаа. Гэсэн ч түүнд бид бүгдийн адил сул тал байгаа учир чи ганцаараа түүнийг хамгаалалтыг нэвтэрч чадна гэдэгт итгэлтэй байна, Харри. Энэ нь бидний хувьд хичнээн чухал болохыг жинхэнэ дурсамжыг хараад мэдэх болно ... Ингээд чамд амжилт хүсье ... тавтай нойрсоорой ...

Харри гэнэтийн саналд балмагдан сандлаас түргэхэн бослоо.

- Тавтай нойрсоорой, эрхэм ээ.

Тэр ардаа хаалга хаагдаж амжихаас урьтаж Финеас Найжелусын хоолойг сонслоо.

- Та яагаад энэ хүүг өөрөөсөө дээр гэж бодож байгааг чинь би ойлгохгүй байна, Дамблдор?

- Харин би таныг ойлгоно гэж хүлээгээгүй, Финеас гэж Дамблдр хариулахад Фоукс ахин нэг удаа уянгалсан дуу гаргалаа.

## БҮЛЭГ 18: ТӨРСӨН ӨДРИЙН ГЭНЭТИЙН БЭЛЭГ

Дараагийн өдөр нь Харри Дамблдор өгсөн даалгаварын тухай Рон, Гермиона хоёрт ярилаа. Үнэндээ Гермиона Роны байхад дургүйцсэн хэвээр зэвүүцэнгүй ширвэж байсан болохоор тус тусад нь ярихад хүрчээ.

Рон Слизнортын хувьд Харрид ямар ч хүндрэл учрахгүй гэдэгт итгэлтэй байлаа.

- Тэр чамд хайртай гэж өглөөний цайн дээр шарсан өндөг сэрээдэн савчин хэлээд,

- Чамд ямар нэгэн зүйлээр татгалзаж чадна гэж үү. Уусмалын жижигхэн хунтайждаа л биш шүү. Зүгээр л өнөөдөр хичээлийн дараа очоод асуултаа асуу.

Гермиона үүнийг баргар хүлээн авлаа.

- Хэрвээ Дамблдор хүртэл түүнээс гарган авч чадаагүй бол Слизнорт үнэнийг нуухаар шийдсэн нь гарцаагүй гэж тэр сургуулийн цастай хоосон хашаанд зогсч байхдаа хэлээд,

- Крестраж ... крестраж ... ийм зүйлийн тухай нэг ч удаа сонсож байсангүй ... гэлээ.

- Сонсож байсангүй гэнээ?

Харрийн урам хугарлаа. Тэр Гермиона л зөвхөн крестраж гэдэг нь юу болохыг тайлбарлаж өгнө гэдэгт итгэлтэй байсан юм.

- Магадгүй хар шидийн онцгой зүйл байж болох юм. Түүнээс яах гэж Воланде-Мортод шаардагдах билээ? Үүнийг хялбар бүтнэ гэж бүү бод, Харри. Слизнорттой ярилцахдаа болгоомжтой байж аргаа сайтар төлөвлөх хэрэгтэй

...

- Рон намайг зөвхөн уусмалын хичээлийн дараа үлдэхэд болно гэж бодож байгаа юм ...

- Өө, хэрвээ Бон-Бон тэгж бодож байгаа бол зөвлөгөөг нь дагасан чинь дээр гэж Гермиона агшин зуур уурсан хэлээд,

- Эцсийн эцэст Бон-Бон алдаж байсан удаа ер нь бий билүү? гэв

- Гермиона чи ...

- Үгүй! гэж тэр ууртай хэлээд Харриг ганцаар орхин цас туучин явлаа.

Сүүлийн үед Харри, Рон хоёр уусмалын хичээл дээр тухгүй сууж Гермионаг ширээ хуваалцахыг харж байсан билээ. Харин өнөөдөр тэрбээр тэднийг үл тоомсорлон тогоогоо ширээний өнцөг рүү Эрнид ойртуулан тавилаа.

- Чи юугаараа буруутаа вэ? гэж Рон Гермионагийн ихэмсэг төрхийг харан шивнэн асуулаа.



Гэвч Харриг хариулж амжихаас урьд Слизнорт ангид орж ирэн бүгдийг нам гүм болгов.

- Сууцгаа, сууцгаа! Ингээд түргэлээрэй өнөөдөр бидэнд ажил их байна!

Голпалоттагийн гурав дахь хууль ... Хэн надад хэлэх вэ? Аан, мэдээж хатагтай Гермиона!

Гермиона аймшигтай хурдтайгаар дуржигнуулав.

- Голпалоттагийн-гурав-дахь-хууль-гэдэг-нь-хорны-эсрэг-найрлагатай-уусмалтай-тэнцүү-хэмжээгээр-хольсон-салангид-найрлагатай-эсрэг- үйлчилгээтэй-уусмалыг-хэлнэ.

- Яг тийм! гэж Слизнорт баясан хэлээд,

- Гриффиндорт арван оноо өглөө! Ингээд бид Голпалоттагийн гурав дахь хуулийг үнэн гэдгийг батлахын тулд ... гэв.

Харри үнэнийг хэлэхэд Голпалоттагийн гурав дахь хуулийн тухай Слизнортын үгнээс юу ч ойлгосонгүй. Түүнчлэн Гермионагаас өөр хэн ч Слизнортын цаашдын үгийг ойлгосонгүй бололтой.

- ... энэ аргын тусламжтай уусмалын зөв орцыг танин тогтоох явдал бөгөөд бидний анхны даалгавар бол эдгээр хорны эсрэг орцуудаас нэмэлт найрлагатайг хайн олж алхимийн аргаар бодисуудыг хувиргах явдал юм ...

Рон Харрийн дэргэд амаа ангайн шинэ сурах бичгээ гөлрөн сууна. Тэр Гермионагийн тусламжид найдалгүй асуудлыг шийдэхэд дасал болоогүй байлаа.

- Ингээд хүн бүр миний ширээн дээрээс хуруу шил ав. Хичээлийн эцэст бэлтгэсэн хорны эсрэг уусмалаа шилэнд хийгээрэй. Амжилт хүсье, хамгаалалтын бээлийгээ өмсөхөө бүү мартаарай!

Гермиона сандлаасаа үсрэн босож багшийн ширээ рүү очих замын хагаст анги яарах цаг болсныг ойлгоод Харри, Рон, Эрни гурав ширээндээ эргэж ирэхэд тэр хэдийн орцоо тогоондоо хийн дор нь гал асаж байлаа.

- Харамсалтай нь Харри өнөөдөр хунтайж чамд юугаар ч тус болж чадахгүй гэж тэр хөгжилтэй хэлээд,

- Чи үүнийг зарчмын холбоотой гэдгийг ойлгох ёстой! Ямар ч мэхлэх арга байхгүй! гэлээ.

Уурсан Харри Слизнортын ширээн дээрээс авсан тод ягаан өнгийн уусмалынхаа бөглөөг аваад тогоондоо хийж гал асаав. Ингээд цаашид юу хийх талаар ямар ч төсөөлөл байсангүй. Тэр Рон руу хяламхийн харахад Харрийн хийсэн бүгдийг давтаж амжаад одоо хийх ажилгүй зогсож байлаа.

- Чи хунтайж энэ талаар ямар ч үг хэлээгүй гэдэгт итгэлтэй байна уу? гэж Рон шивнэн асуулаа.

Харри үнэнч сурах бичгээ гаргаж ирээд хорны эсрэг уусмалын гарчгыг нээлээ. Гермионагийн хэлсэнчлэн Голпалоттагийн гурав дахь хуулийн тухай энд байсан ч

хунтайж нэг ч зурвас үлдээсэнгүй. Харваас хунтайж Гермionaгийн адил энэ хуулийг ямар ч хүндрэлгүй ойлгож болно гэж үзсэн бололтой.

- Хоосон байна гэж Харри баргар мэдэгдэв.

Гермиона хэдийн урам зоригтойгоор тогоон дээгүүр даллаж байлаа. Харамсалтай нь түүний шившлэгийг Харри, Рон хоёр давтаж чадсангүй. Тэр үгэн бус шившлэгийг эзэмшсэн учир чанга хэлэх хэрэггүй болсон байв. Эрни Макмиллан тогоо руугаа өнгийн «Спесиалис Ревелио!» гэж бувтналаа. Энэ нь сэтгэгдэл төрүүлэм сонсогдоход Харри, Рон хоёр мөн адил хийхээр яарлаа.

Харрид уусмалын мастерын алдар хүнд нь бүгдийн нүдэн дээр нуран унаж байгааг ойлгоход таван хором шаардагдав. Слизнорт газар доорх хонгил дундуур явж тогоо руу нь найдангуй шагайгаад хамар луу нь өмхий өндгөөр утсан мэт яаран явлаа. Гермionaгийн царайд Харрийн уусмалын хичээл бүр дээр тодордог байсан сэтгэл хангалуун инээмсэглэл тодров. Тэр одоо нууцлаг аргаар бэлтгэсэн уусмалаа арван янзын хуруу шилэнд хийж байлаа. Энэхүү таагүй дүр зургийг харахгүйн тулд Харри эрлийз хунтайжын сурах бичиг рүү тонгойн хэдэн хуудас эргүүлэв.

Тэгтэл эсрэг уусмалын урт жагсаалтан дор сараачсан үг гараад ирлээ.

Зүгээр л хоолой руу нь безоар хийхэд болно.

Харри агшин зуур энэ үгийг харлаа. Тэр хаа нэг дээр үед безоар чулууны тухай сонсож байсан юм. Снег түүний тухай уусмалын эхний хичээл дээр дурьдаж байсан билүү? «Безоар бол үхрийн цөснөөс гаргаж авдаг чулуу бөгөөд хорны эсрэг уусмалд ашигладаг.»

Голпалоттагийн хуулинд хариулаагүйн асуудал үүнд байж. Тэдний багш Снег хэвээр байсан бол Харри үүнийг хийж зүрхлэхгүй байсан авч одоо сэтгэл шулууджээ. Тэр яаран орцны шүүгээ руу очиж дотроос нь ганц эвэртийн эвэр болон хатсан эмийн ургамлын цаадах хайрцагнаас «безоар» гэж бичсэн зүйлийг оллоо.

Харри хайрцгийг онгойлгох агшинд Слизнорт,

- Анхаараарай хоёр минут үлдлээ! гэв.

Хайрцагт арваад үрчийсэн хүрэн зүйл хэвтэж байсан нь жинхэнэ чулуу гэхээсээ хатсан ямааны бөөр шиг харагдав. Харри нэгийг нь аваад яаран тогоо руугаа эргэлээ.

- Цаг боллоо ... Зогс! гэж Слизнорт хөгжилтэй дуу алдав.

- За юу болсныг харцгаая! Блейз та намайг юугаар баярлуулах гэж байна?

Слизнорт удаанаар анги дундуур явж өөр хоорондоо ялгаатай уусмалуудыг харж байв. Даалгаварыг хэн ч дуустал нь хийж чадсангүй. Гермiona урдаа байсан шилэндээ уусмал хийхээс урьтаж Слизнорт түүн рүү очлоо. Рон амьсгалахгүйг хичээн зогсоход тогооноос нь ялзарсан үнэр утаж байв. Харри гартаа безоар атгаад хүлээж зогслоо.

Тэдний ширээ рүү Слизнорт хамгийн сүүлд ойртож ирлээ. Тэр Эрнигийн уусмалыг үнэрлэн ярвайгаад, Ронх руу эргэснээ яаран үсрэн холдохдоо үл мэдэг огиулав.

- За, Харри надад юу үзүүлэх гэж байна? Харри гартаа атгасан безоарыг сунган үзүүлэв.

Слизнорт чулуу руу арван секунд орчим харав. Харрид агшин зуур тэр хашгирах гэж байгаа юм шиг санагдсан ч толгойгоо гэдийлгээд хөхөрлөө.

- Та бүдүүлэг байна шүү! гээд тэр безоарыг авч ангид үзүүлэхээр өргөлөө.

- Өө, та яг л эх шигээ юм ... үүнийг буруутгах юм алга ... безоар бол эргэлзээгүй энэ бүх уусмалын эсрэг үйлчилгээтэй!

Нүүр нь хөлөрч хамар нь хөө болсон Гермiona улайлаа. Түүний дутуу бэлтгэсэн бэлтгэсэн тавин хоёр янзын орц агуулсан эсрэг уусмал үс рүү нь үсчин хөөсрөн буцлахад Харри руу эргэлээ.

- Чи шууд өөрөө безоарыг бодож олоо юу, Харри? гэж шүдний завсар сийгүүлэн асуув.

- Үүнд уусмалын онцгой мэдрэмж хэрэгтэй! гэж Слизнорт Харриг хариу хэлж амжихаас өмнө хэлэв. Түүний ээж нь тийм байсан юм. Лили уусмалыг зөнгөөрөө мэдэрдэг байсан болохоор Харри эргэлзээгүй түүнээс залгамжилжээ ... Тиймээ Харри таны гарт безоар байгаа бол энэ асуудлыг шийдэх болно ... Тэр энэ дэлхий дээр туслаж чадахгүй тохиолдол ховорхон гардаг юм ...

Ангид Гермionaгаас илүү уурласан цорын ганц хүн гэвэл Малфой байлаа. Харри түүнийг дотор нь муухайрсан муур шиг тонгойсныг баяртайгаар хараад сурах бичгээ автал хонх дуугарлаа.

- Хичээл дууслаа! Тиймээ, Гриффиндорт ичгүүргүй авирынх нь төлөө арван оноо өглөө!

Ингээд тэр үргэлжлүүлэн инээсээр ширээ рүүгээ явав.

Харри алгуурлснаа яаралгүйхэн юмнуудаа цүнхлэв. Рон, Гермiona хоёр уурссандаа болоод түүнд амжилт хүсэлгүй явжээ. Эцэст нь ангид зөвхөн Слизнортын хамт үлдэв.

- Алив ээ, Харри та дараагийн хичээлдээ хоцрох нь байна шүү гэж Слизнорт эелдэгээр хэлээд лууны ширэн цүнхнийхээ алтан горхийг шархийлгэв.

- Ноёнтоон би танаас юм асуух гэсэн юм гэж Харри эхлэхдээ Волан-де-Морт бас ингэж хэлснийг саналаа.

- Тэгвэл асуу, хүү минь асуугтун.

- Ноэнтон би таныг крестражын тухай ... мэдэх байх гэж бодлоо? Слизнорт хөшсөнөө дугуй царай нь цайрав. Тэр уруулаа долоосноо сөөнгөтөн,

- Та юу хэлсэн бэ? гэлээ.

- Би таныг крестаржын тухай мэдэх болов уу гэж асуусан, ноёнтоон. Ойлгож байна уу ...

- Дамблдор таныг явуулжээ гэж Слизнорт шивнэв.

Түүний хоолойны өнгө бүрэн өөрчлөгдлөө. Ямар ч эелдэг өнгө үлдсэнгүй зөвхөн цочирдол айдас байв. Тэр халааснаасаа нусын алчуур гаргаж ирээд духаа арчлаа.

- Дамбдор таньд ... тэр дурсамжыг үзүүлсэн байна. Алив? Үзүүлсэн үү?
- Тиймээ гэж Харри агшин зуур худал хэлэх хэрэггүй гэж шийдээд хэллээ.
- Тиймээ, тэгэлгүй яахав гэж Слизнорт аяархан давтаад цонхийсон нүүрээ арчиж,
- Тэгэлгүй яахав ... хэрвээ та түүнийг үзсэн бол крестражын тухай юу ч мэдэхгүй гэдгийг минь харсан байх, Харри. Юу ч мэдэхгүй шүү ... юу ч ... гэж хүчлэн давтлаа.

Тэр лууны ширэн цүнхээ аваад алчуураа халаасандаа хийж газар дорхи өрөөний хаалгаар гарлаа.

- Ноёнтоон би зүгээр л таныг жаахан санаж магадгүй гэж бодсон юм хэмээн Харри араас нь цөхрөн хашгирлаа.
- Санах гэнээ? Тэгэхээр та алдаж байна. Алдаж байна! Тэр сүүлчийн үгээ хэлмэгц хаалга тасхийтэл хаалаа.

Харри амжилтгүй ярианыхаа тухай хэлэхэд Рон, Гермиона хоёрын хэн нь ч өрөвдсөнгүй. Гермиона Харри зүй ёсоор ажиллаагүй ялсан явдалд уурссан хэвээр байв. Рон ч гэсэн Харри безоарын тухай хэлээгүй явдалд зэвүүцсэн байлаа.

- Хэрвээ бид хоёр үүнийг хоёулаа хийсэн бол тэнэг харагдах байсан! Би дараа нь түүнээс Волан-де-Мортын тухай асуух хэрэг байсан биз дээ. Боль доо биеэ барьж сурах цаг чинь болж! гэж Роныг нэрийг сонсоод хэрхэн үрчийхийг хараад унтууцан хэллээ.

Амжилтгүй оролдлого болон найзууддаа уурссан Харри дараагийн хэдэн өдрийг Слизнортын тухай бодож өнгөрүүлэв. Ингээд Слизнортыг крестражын тухай яриаг мартаж хүртэл асуухгүй байхаар шийдлээ. Энэ нь түүнийг хуурамч тайвшируулсан аюулгүй мэдрэмж төрүүлж байгаад дараа нь дайралт хийсэн нь хамаагүй дээр байлаа.

Харри Слизнортоос ахин ямар ч асуулт асуугаагүй болохоор уусмалын багш ердийн найрсаг төрхөндөө орсноос үзвэл таагүй сэдвийг толгойноосоо арчин хаясан бололтой. Харри түүнийг үдэшлэгт урихыг хүлээж квиддичийн бэлтгэлтэй байсан ч очихоор шийдсэн байлаа. Гэвч урилга ирсэнгүй. Харри Гермиона, Жинни нараас асуухад тэдний хэн ч урилга аваагүй байлаа. Харри Слизнорт бүгдийг мартсандаа биш харин түүнд асуулт асуух боломж өгөхгүйн тулд ингэсэн гэдгийг тааварлажээ.

Энэ үед Хогвартсын номын санд Гермионагийн ой ухаанд багтамгүй зүйл болж байв. Тэр үүнд цочирдсондоо болоод тэр ч байтугай Харрийн илбэт безоарт уурсаж байснаа мартжээ.

- Би крестражын тухай нэг ч тайлбар олсонгүй! Нэг ч шүү! Би бүр хамгийн аймшигтай номнууд байдаг хориотой хэсэгт хайсан ч юу ч байгаагүй. Зөвхөн нэг

номд цухас дурдсан байхыг оллоо ... «Крестраж шидийн бүтээлд байдаг хэдий ч бид түүний тухай ярихгүй, ямар ч заавар өгөхгүй ...» Тэгвэл яагаад энэ тухай дурьдсан юм бол? гэж тэвчээргүйхэн хэлснээ номоо тас хийтэл хаахад хий үзэгдэл шиг чарлав.

- Амаа тат! гэж тэр зандраад цүнхэндээ буцааж хийлээ.

Хоёр сар гарахад сургуулийн эргэн тойрны цас хайлж хүйтэн чийглэг боллоо. Саарал ягаан үүлс шилтгээний дээгүүр хөшиглөн үргэлжид хүйтэн бороо орсны улмаас зүлэг нил шавар шавхай болжээ. Үр дүнд нь зургадугаар дамжааныхан шилжих эхний хичээл болох бямба гаригийн өглөө гадаа биш Их танхимын дотор цуглалаа.

Харри, Гермiona хоёрыг Их танхим руу явж ороход (Рон Лавандатай хамт явжээ) ширээнүүд байхгүй болсон байлаа. Бороо цонхны шил тачигнуулан нүдэж шидэт адар уйтгартай хуйлраад тэнхимийн эрхлэгч нар болох профессор МакГонагалл, Снегг, Флитвик, Стебль нар болон Харрийн тааварласнаар ид шидийн яамнаас илгээсэн зааварлагч тэдний эгнээний урд зогслоо. Зааварлагч хачирхалтай өнгөгүй тунгалаг сормуус, шингэн үстэй ганц хүчтэй салхилахад хийсээд явчихмаар туниа муутай ажээ.

- Өглөөний мэнд гэж яамны шидтэн эмэгтэй хэлэхэд тэнхимийн эрхлэгчид цугларсан сурагчдыг чимээгүй болголоо.

- Намайг Уилки Двукрест гэдэг. Яамнаас намайг та нарт арван хоёр долоо хоногийн турш шилжих хичээл заахаар явууллаа. Энэ нь та нарыг шилжих шалгалтанд бэлдэхэд тус болно гэж найдна ...

- Малфой чимээгүй анхааралтай бай! гэж профессор МакГонагалл зандрав.

Бүгд эргэн харлаа. Малфой уурсан хүрэгтээ шивнэн маргалдаж байсан Крэббээс алхам холдлоо. Харри Снегг рүү түргэхэн хараад зөвхөн Малфойн хүмүүжилгүйд биш МакГонагалл тэнхимийн сурагчид нь үг хэлсэн явдалд уурсан байхыг харлаа.

- ... үүний дараа та нарын олонхи чинь шалгалт өгөхөд бэлэн болно. Түүнчлэн та бүгд Хогвартсын нутаг дэвсгэрт шилжих боломжгүй гэдгийг мэдэх билээ. Иймээс та нарын сургуулилтанд зориулан сургуулийн захирал шившлэгийг Их танхимд нэг цаг алга болгож байгаа юм. Анхааруулан хэлэхэд энэ хананаас гадна шилжихийг оролдох нь ухаалаг бус хэрэг гэдгийг сануулах байна. Харин одоо та бүгдийг урдаа таван фут сул зай үлдээгээд байраа эзлэхийг гуйя.

Бөөн хөл үймээн үүсч сурагчид өрсөлдөн байраа эзлэхдээ бие биенээ түлхэж зай тавьж өгөхийг чангаар шаардаж байлаа. Тэнхэмийн эрхлэгчид сурагчдын маргааныг болиулан байранд нь зогсоов.

- Чи хаачих нь вэ, Харри? гэж Гермiona шаардангуй асуув.

Харри хариулсангүй. Тэр түргэхэн цугласан хүүхдүүдийн дундуур шургалан хэдэн Когтевранчуудыг байрыг нь эзлүүлэн зогсоохыг оролдох профессор Флитвик болон, Пуффендуйчуудыг цэгцэлж байсан профессор Стеблийг өнгөрөөд эцэст нь Эрни Макмилланаас зайлсхийн бүгдийн хойно Крэббтэй маргаанаа үргэлжлүүлж байсан Малфойн ард зогслоо.

- Би хэр удахыг нь мэдэхгүй байна, ойлгов уу? Үүнд миний бодсоноос ч илүү цаг орох болно гэж Малфой ардаа байгаа Харриг ажиглалгүй хашгирлаа.

Крэбб ам нээсэн авч Малфой түүний юу хэлэх гэж байгааг тааварласан бололтой.

- Сонсооч Крэбб миний юу хийж байгаа нь чиний ухаан хүрэх ажил биш. Гойл та хоёр зүгээр л тушаал биелүүлээд харуулд зогсож бай!

- Хэрвээ би найзуудаа харуулд зогсоохыг хүсвэл юу хийх гэж байгаагаа тайлбарладаг гэж Харри Малфойд сонсуулахын тулд чанга хэлэв.

Малфой огцом эргээд гар нь шидэт саваа руугаа явсан ч эрхлэгчид «Чимээгүй!» гэж хашгиран нам гүм болголоо. Малфой дургүйхэн эргэж харав.

- Баярлалаа. Одоо ингээд ... гэж Двукрест хэлэв.

Тэр шидэт саваагаа даллахад сурагчдын өмнө хуучин загварын модон цагариг гарч ирэв.

- Хамгийн чухал нь шилжихэд шаардлагатай гурван зүйлийг санах явдал юм!

Зорилготой, Шургуу, Хянамгай байх! Анхны алхам бол ухаан бодлоо зорьсон газартаа төвлөрүүлэх явдал юм. Энэ тохиолдолд цагаригийн дотор тал болно. Одоо төвлөрөөд үз дээ.

Хүн бүр эргэн тойрноо хяламхийн хөршүүд нь цагариг дотроо байгаа эсэхийг шалгаад яаран хэлснийг нь хийлээ. Харри тоостой шалан дээрх тойроогоор хязгаарлагдсан зайд бодлоо төвлөрүүлэхийг хичээсэн авч бүтсэнгүй. Тэр Малфойд яагаад харуул шаардагдсаныг үргэлжлүүлэн тааварласаар байсан тул энэ нь бүтэшгүй зүйл байлаа.

- Хоёр дахь алхам бол хүрэх гэж байгаа газраа бодолдоо төсөөлөн шийдэмгий төвлөр! Ингээд түүнийг ухаан бодол биенийхээ хэсэг бүрт шингээ!

Харри нууцхан эргэн тойрноо харлаа. Зүүн талд нь байсан Эрни Макмиллан цагаригийнхаа төв рүү квоффлын хэмжээтэй өндөг гаргах гэж байгаа юм төвлөрөхөд царай нь улайлаа. Харри инээд алдаад яаран цагариг руугаа харлаа.

- Гурав дахь алхам бол зөвхөн миний тушаалыг биелүүлнэ шүү ... байрандаа эргээд хоосон ахуйг мэдэрч яаралгүйхэн хянамгай хөдөл! Ингээд миний тушаалаар эхлэе ... нэг ...

Харри эргэн тойрноо ахин харахад олонхи сурагчдын царайд шилжихийг ийм хурдан гуйсан явдалд айдас тодорч харагдлаа.

- Хоёр ...

Харри ахин бүх бодлоо цуглуулан цагаригтаа төвлөрөхийг хичээсэн ч хэдийн гурван зарчмыг мартжээ.

- Гурав!

Харри байрандаа эргээд тэнцвэр алдан золтой л унасангүй. Танхим даяар сурагчид зүг бүр тийш эргэлдлээ. Невилл ар нуруугаараа хэвтэж байсан бол, Эрни Макмиллан

эсрэгээрээ цагаригийн дотор газардаад Дин Томас руу харахад урдаас нь инээд алдаж байлаа.

- Зүгээр дээ, зүгээр гэж Двукрест үүнээс өөр юу ч хүлээгээгүй бололтой хөндий хэлээд,

- Цагаригаас гарч байраа эргэн эзлэнэ үү ... гэв.

Хоёр дахь оролдлого эхнийхээсээ дээргүй болов. Гурав дахь ч гэсэн. Дөрөв дэх удаад нь сонирхолтой зүйл боллоо. Зовж шаналсан аймшигтай хашгиралт гарахад бүгд айдаст автан харвал Пуффендуйн Сьюзен Боунс цагаригийнхаа төвд ганхаад зүүн хөл нь таван алхамын зайд байрандаа хэвтэж байв.

Эрхлэгчид Сьюзен руу ухасхийн чанга тасхийх чимээ гараад агаарт хүрэн утаа суунаглаж сарних үед бүгд цурхиран уйлах Сьюзены хөл эргэн бий болоод өөрөө үхтлээ айсан байхыг харлаа.

- Ийм тохиолдлыг хуваагдал юмуу биеийн хэсгийн салалт гэдэг юм хэмээн

Уилки Двукрест хайхрамжгүй хэлээд,

- Хангалттай шийдэмгий бус үед ийм явдал тохиолддог. Та нар зогсолтгүй шийдэмгий байж зорьсон газар луугаа яаралгүйхэн хөдлөх хэрэгтэй ... Ингээд гэв.

Двукрест урагш алхаад гараа сунган байран дээрээ эргэлдэн жанчаа хуйлруулан алга болсноо танхимын нөгөө өнцөгт ханын дэргэд гарч ирлээ.

- Гурван зарчмаа сана. Ингээд ахин нэг оролдож үзье ... нэг ... хоёр ... гурав ... Ганцхан цагийндараа Сьюзений хуваагдсан явдал бүх хичээлийн хамгийн

сонирхолтой үйл явдал болжээ. Двукрест үүнд урам хугарсангүй. Яаран жанчныхаа хоолойг товчлох зуураа,

- Дараагийн бямба гариг хүртэл баяртай. Ингээд битгий мартаарай Зорилготой, Шургуу, Хянамгай байдал гэлээ.

Тэр саваагаа даллан цагаригийг алган болгоод профессор МакГонагаллын хамт гарч одов. Зургадугаар дамжааныхан үүдний танхим руу явлаа.

- Чи ямар шуу байв даа? гэж Рон яаран Харрийн зүг ирээд асуув. Би сүүлчийн оролдлогоороо ямар нэг зүйл мэдрэх шиг болсон ... хөл бадайраад л.

- Магадгүй чиний гутал багадсан байлгүй дээ, Бон-Бон гэх хоолой тэдний ард гараад сэтгэл Гермiona хангалуун инээмсэглэн дэргэдүүр нь өнгөрлөө.

- Харин би юу ч мэдрээгүй гэж Харри түүнд хэлээд,

- Гэхдээ энэ намайг зовоохгүй байна ... гэв.

- Зовоохгүй байна гэдэг чинь юу гэж байгаа юм? Чи шилжиж сурахыг хүсэхгүй байгаа юм уу? гэж Рон гайхширан асуув.

- Үнэндээ миний сэтгэлийг татахгүй байна. Би нисэхийг эрхэмлэдэг гэж Харри хэлээд Малфойг хайн эргэж харснаа үүдний танхимд алхаагаа хурдасгалаа.

- Сонсооч, түргэлээрэй надад шалгах хэрэгтэй юм байна ...

Тэвдсэн Рон гүйх шахам Харриг Гриффиндорын цамхаг руу дагалаа. Дөрвөн давхарт тэднийг Пивз саатуулав. Тэр хаалгыг гацаасан болохоор Харри, Роныг эргэхийг гуйгаад танил товчилсон замдаа орж таван хормын дараа хөргөн нүхээр шургалав.

- Чи надад юу хийх гэж байгаагаа хэлэх үү үгүй юу? гэж Рон үл мэдэг амьсгаадан асуув.

- Ийшээ явъя гээд Харри амралтын өрөөг өнгөрөн шатаар өгсөөд хөвгүүдийн унтлагын өрөөнд орлоо.

Түүний найдсанаар өрөө хоосон байв. Түүнийг чемоданаа онгойлгон онгичиж эхлэхэд Рон тэвчээргүйхэн ширтэж байлаа.

- Харри ...

- Малфой Крэбб, Гойл хоёрыг харуулаар ашиглаж байна. Тэр сая үүнээс болж Крэббтэй маргалдсан. Харин би мэдэхийг хүсэж байна ... аанхан!

Тэр эрсэн зүйл болох эвхсэн дөрвөлжин хоосон цаасыг олж нээгээд шидэт саваагаа хүргэн тогшлоо.

- Зөвхөн дүрсгүйтэнэ гэдгээ баясгалантайгаар тангараглаж байна ...

Тэгтэл цаасан дээр даруйхан Тэнүүлчний газрын зураг гарч ирлээ. Энд шилтгээний бүх давхарт явж байгаа хүн бүр жижигхэн нэр бүхий хар цэгээр тэмдэглэн харагдах ажээ.

- Малфойг хайхад туслаач гэж Харри гуйлаа.

Тэр газрын зургийг орон дээрээ дэлгээд Роны хамт бөхийн хэрэгтэй цэгээ хайлаа.

- Энэ байна! гэж хормын дараа Рон хэлэв.

- Тэр Слизериний амралын өрөөнд байна ... Түүнтэй Паркинсон, Забини, Крэбб, Гойл нар байна ...

Харри газрын зураг руу хараад урам хугарлаа.

- За яахав би үүнээс хойш түүнийг байнга харж байх болно. Тэгээд түүнийг Крэбб, Гойл хоёрыг хаана харуул болгон нуугдаж байгааг нь мэдмэгц үл үзэгдэх цув өмсөөд ...

Тэр Невилл шатсан даавууны үнэр ханхлуулсаар унтлагын өрөөнд орж ирээд чемоданаа нээхэд чимээгүй боллоо.

Харри Малфойг барихыг хичнээн их хүссэн ч сүүлийн хоёр долоо хоногт аз нэг ч удаа инээмсэглэсэнгүй. Түүнийг газрын зураг руу харах үед заримдаа жорлонд юмуу эсвэл хичээл хооронд байж нэг ч удаа сэжигтэй газар байж харагдсангүй. Тэр Крэбб, Гойл хоёрыг тусдаа шилтгээний эргэн тойронд яван заримдаа хоосон хонгилд хөдөлгөөнгүй зогсохыг харсан авч тэр үед Малфой тэдэнд ойртохгүй байрлалыг нь газрын зураг дээр тодорхойлохын аргагүй болж байлаа. Энэ нь ихэд нууцлаг байв. Хамгийн том таавар гэвэл Харри Малфойг шилтгээний нутаг дэвсгэрт байхгүй байна



гэж бодсон ч аюулгүй байдлын хүч нэмэгдүүлсэн хамгаалалтын дараа яаж ингээд байгааг нь төсөөлж чадсангүй. Зөвхөн Малфойг зуугаад цэг дундаас алга болохыг харж байлаа. Тэгтэл салж хагацашгүй Малфой, Крэбб, Гойл гурав салангид явж байсан хэдий ч энэ нь хүмүүсийг насанд хүрэхэд тохиолддог зүйл байлаа. «Рон, Гермиона хоёр үүний баталгаа байна» гэж Харри гунигтай бодов.

Гурван сар ойртоход цаг агаар тийм ч чийглэг биш салхитай боллоо. Бүгдийн эгдүүцлийг хүргэн амралтын өрөөний зарлалын самбар дээр Хогсмид явах дараагийн аялал цуцлагдсан тухай мэдээ гарчээ. Ялангуяа Рон үүнд уурслаа.

- Энэ чинь миний төрсөн өдөр шүү дээ! Би ямар их хүлээсэн гээч! гэж тэр дуу алдав.

- Тийм ч том гэнэтийн бэлэг биш байна. Ялангуяа Кэтид тохиолдсон явдлын дараа гэж Харри хэлэв.

Тэр гэгээн Мунгогийн эмнэлэгээс эргэн ирээгүй байлаа. Түүнчлэн «Өдөр тутмын зөнч» сонинд хэдэн шинэ алга бололтыг зарласны тоонд Хогварсад сурч байгаа сурагчдын хэдэн хамаатнууд орлоо.

- Ердөө энэ тэнэг шилжих хичээлийг хүлээх үлдлээ! Хөгжилтэй ч төрсөн өдөр болно доо ...

Шилжихийн хувьд гэвэл хэдийн гурван хичээл өнгөрөөд хэдэн сурагчид хуваагдсан байв. Олонхи нь гурван зарчимд бүрэн хандаагүйн улмаас сэтгэлээр гонсойсон Уилки Двукрест зарим хүнд нэр хоч оноож эелдэгээр «Шивхэн толгойт» гэж байлаа.

- Төрсөн өдрийн мэнд хүргэе, Рон! гэж Харри Симус, Дин хоёр өглөөний цайндаа явахаар унтлагын өрөөнөөс чимээ шуугиантай гарч тэднийг сэрээхэд хэлэв.

- Май бэлгээ ав.

Тэр Роны орон дээр шөнө гэрийн үйлчлэгч л тавьсан бололтой багахан овоолттой бэлгийн хажууд өөрийнхийгөө тавилаа.

- Гайхалтай! гэж Рон нойрмог бувтнав.

Түүнийг бэлгийн гаднах цаасыг задалж эхлэхэд Харри орноосоо босоод чемоданаа онгичин Тэнүүлчний газрын зургийг хайж эхлэв. Тэр чемоданыхаа талыг хоослон байж оймсон дороос олоход дэргэд нь аз авчирдаг Феликс Фелицис хэвтэж байв.

- Зүйтэй гэж Харри бувтнаад газрын зурагтайгаа ор луугаа эргэн саваагаараа тогшоод аяархан,

- Зөвхөн дүрсгүйтнэ гэдгээ баясгалантайгаар тангараглаж байна гэв.

- Сайн байна! гэж Рон хашгираад Харрийн бэлэглэсэн хаалгачын бээлийгээр даллав.

- Зүгээр дээ гэж Харри хэлээд Слизериний унтлагын өрөөнд Малфойг хайлаа.

- Хөөх ... би түүнийг орондоо байхгүй гэж бодсонгүй шүү ...

Рон хариулсангүй. Тэр бэлгээ задлаад үе үе баяртай дуу алдан хэтэрхий завгүй байлаа.

- Энэ жил их олзтой байна! гэж мэдэгдээд хачирхалтай дүрс тэмдэг бүхий жижигхэн хөдөлдөг ододтой алтан цаг зүүж,

- Харж байна уу, үүнийг ээж аав хоёр бэлэглэж. Хөөх жилийн дараа бас насанд хүрэх гэж байдаг ... гэв.

- Янзтай гэж Харри бувтнаад цаг руу түргэн харсаа ахин газрын зураг руу тонгойлоо. Ингэхэд Малфой хаана байгаа юм бол? Их танхимд Слизериний ширээнд нэг ангийхан дундаа алга байлаа ... Снеггийн ойролцоо бас байхгүй байв ... Жорлонд ч эмнэлэгт ч байсангүй ...

- Нэгийг авах уу? гээд Рон түүнд хайрцагтай шоколадан тогоо сунгав.

- Үгүй ээ, баярлалаа гээд Харри газрын зургаасаа харцаа салган,

- Малфой ахиад л алга болчихож! гэв.

- Тэр хаачаад байгаа юм бол? гээд Рон амандаа хоёр дахь шоколадан тогоогоо хийснээ орноосоо хувцаслахаар өндийв. Алив ээ, хэрвээ чи яарахгүй бол хоосон гэдэстэй шилжих нь байна ... хэдийгээр надад энэ нь дээр байгаа ч гэсэн.

Рон цаасан хайрцагтай чихэр рүү бодлогоширон харснаа мөрөө хавчаад амандаа гурав дахиа хийв.

Харри шидэт саваагаараа газрын зургыг тогшин хэдийгээр энэ худал байсан ч «дүрсгүйтэж ханалаа» гээд бодлогоширон хувцаслаж эхлэв. Малфойн алга бололтыг юу гэж тайлбарлах вэ. Тэр үүнд тайлбар бодож олж чадахааргүй байлаа. Хамгийн сайн арга бол Малфойг үл үзэгдэх цувтай мөрдөх явдал байсан ч хичээл, квиддичийн бэлтгэл, гэрийн даалгавар, шилжилт гээд бүтэн өдөр сургууль дотор дагах боломжгүй байсан учир түүний алга бололт ажиглагдахгүй үлдэж байлаа.

- Бэлэн үү? гэж Роноос асуулаа.

Харри унтлагын өрөөний хаалга хүрэх замын хагасыг туулсан хойно гэнэтхэн Рон байрнаасаа хөдлөлгүй орны багана налаад бороонд угаагдсан цонх руу ширтэн нүүрэнд нь хачирхалтай хувирал тодорсныг харав.

- Рон! Өглөөний цайндаа явъя!

- Би өлсөөгүй. Харри нүдээ томрууллаа.

- Чи үнэхээр тэгж хэлсэн үү?

- За яахав явъя. Гэхдээ би нэг их хүсэхгүй байна гээд Рон санаа алдав. Харри түүнийг сэжигтэйгээр харлаа.

- Тэгэлгүй яахав, чи сая хагас хайрцаг шоколадан тогоо идсэн юм чинь.

- Үүндээ биш. Чи ... ойлгохгүй байна гээд Рон ахин санаа алдлаа.

- Юу үнэн гэвэл энэ үнэн гээд Харри хаалга руу эргэлээ.

- Харри! гэж Рон гэнэтхэн дуудав.
  - Юу?
  - Харри, би үүнийг тэвчихгүй нь!
  - Юу тэвчихгүй гэж? хэмээн Харри жинхэнээсээ түгшин асуулаа. Рон дотор нь муухайрсан юм шиг цонхийн цайсан харагдав.
  - Би үргэлж түүний тухай бодоод байна! гэж тэр сөөнгөтөн хэлэв.
- Харри амаа ангайлаа. Тэр ийм зүйл сонсоно гэж хүлээгээгүй билээ. Тэд найзууд хэдий ч хэрвээ Рон Лавандаг Лав-Лав гэж нэрлэж эхэлвэл зогсоох хэрэгтэй.
- Энэ яагаад чамайг өглөө цайнд ороход саад болно гэж? хэмээн Харри сониучирхан асуулаа.
  - Би түүнийг миний байгааг тааварлахгүй байна гэж бодож байна гээд Рон цөхрөн гараа савчив.
  - Юу тааварлахгүй гэж? Чи түүнтэй үргэлж үнсэлдэж байсан биз дээ? гэж Харри үл итгэн асуулаа. Рон нүдээ цавчлаа.
  - Чи хэний тухай яриад байна?
  - Харин чи хэний тухай ярьсан юм?
  - Ромильда Вейний тухай гэж Рон аяархан хэлэхэд царай нь нарны туяанд гийлээ.
- Тэд бие бие рүүгээ бараг бүтэн хормын турш харснаа Харри,
- Энэ чинь тоглоом уу? Чи тоглож байгаа биз дээ гэв.
  - Би бодохдоо ... Харри, би түүнд хайртай болсон юм шиг байна гэж Рон хүчлэн өгүүлэв.
  - За яахав гээд Харри Рон руу очиж гөлийсөн нүд, цонхигор царай луу нь харлаа.
  - За яахав ... ахин нэг давтаад хэл дээ ...
  - Би түүнд хайртай гэж Рон аяархан давтлаа.
  - Чи түүний хар үс гялалзсан торго шиг зөөлхөн болохыг харсан уу ... Харин нүд нь? Том хар нүд. Бас ...
  - Энэ бүхэн чинь их инээдтэй байна. Тоглохоо больж үз гэж Харри тэвчээргүйхэн хэлэв.
- Тэр гарахаар цааш эргээд хоёр алхаж амжаагүй байтал баруун чих рүү нь цохилт ирлээ. Тэр гуйвснаа эргэж харав. Рон нударга зангидаад царайд нь уур хилэн тодорч ахин дайрахад бэлэн байлаа.
- Харригийн үйлдэл зөнгөөрөө болж шидэт саваагаа халааснаасаа гаргахад толгойд нь Левикорпус! гэсэн шившлэг бодогдов.

Рон орилоод өсгийнөөсөө өргөгдөж агаарт толгойгоо уруугаа харуулан сарвалзахад жанч нь хөмөрлөө.

- Юуны төлөө? хэмээн Харри дэлбэрлээ.
  - Чи түүнийг доромжилсон, Харри! Чи энэ бүхэн инээдтэй байна гэж хэлсэн!
- гэж Рон хашгираад нүүр лүү нь цус буун хүрэн улаан боллоо.

- Ухаан солиормоор юм! гэж Харри бувтнав.

Тэгтэл түүний нүд Роны орон дээр хэвтэж байгаа онгорхой хайрцаг дээр тусав.

- Чи хаанаас шоколадтай тогоо аваа вэ?
- Надад төрсөн өдрөөр бэлэглэсэн! гэж Рон сөөнгөтөөд удаанаар эргэлдэн чөлөөлөгдөх оролдлого хийв. Би чамд нэгийг санал болгосон санаж байна уу?
- Чи хайрцагыг шалан дээрээс авсан уу?
- Тэгээд юу гэж зүгээр л орноос уначихсан юм. Намайг тавь!
- Тэр орноос унаагүй ойлгож байна уу? Энэ бол миний чихэр, би түүнийг чемоданаасаа Тэнүүлчний газрын зураг хайх гэж гаргасан юм. Надад үүнийг Ромильда Вейн зул сараар бэлэглэсэн. Тэр дотроо хайрын ундаатай!

Роны ухаанд ганц л үг оров бололтой.

- Ромильда гэнээ? Чи Ромильда гэж хэлсэн үү? Харри чи түүнтэй танил юм уу?
- Намайг танилцуулж болох уу?

Харри агаарт өлгөгдөн найдангуй ярьж байгаа Рон руу харснаа инээх хүслээ арай ядан барив. Түүнийг өвдөж буй чихтэй ойролцоо нэг хэсэг нь Роны хайрын уусмал үйлчилж дуусахаар нь буулгах хүсэл төрсөн авч ... гэтэл нөгөө талаас бол тэд найзууд болохоор Рон түүн рүү дайрсан ч гэлээ найзыгаа Ромильда Вейнд үүрд хайртай болгохыг хүссэнгүй.

- Сайн байна, би чамайг танилцуулъя. Одоо би чамайг доош буулгаад явцгаая, ойлгов уу?

Тэр Роныг шалан дээр унагахад инээмсэглэн хөл дээрээ үсрэн бослоо.

- Тэр Слизнортын өрөөнд байгаа гэж Харри итгэлтэй хэлээд хаалга руу түрүүлж явлаа.
- Ямар учраас? гэж Рон түгшин хэлээд түүнийг гүйцлээ.
- Тэр уусмалын хичээлийн нэмэлт даалгавар авсан.
- Тэгвэл түүнийг бидэнд хамт өгөхийг гуйж болох уу? гэж Рон тэсч ядан сониучирхав.
- Маш сайхан санаа байна гэж Харри зөвшөөрлөө.

Хөргөн нүхний дэргэд тэднийг Лаванда хүлээж байсан нь Харрийн урьдчилан тааварлаагүй зүйл болов.

- Бон-Бон хоцорч байна шүү! гээд тэр уруулаа цорвойлгосноо,
- Би чамд төрсөн өдрийн бэлэг авчирсан ... гэв.
- Намайг ганцаар орхиж үз. Харри намайг Ромильда Вейнтэй танилцуулахаар явж байгаа юм.

Ингээд өөр нэг ч үг хэлэлгүй түүнийг холдуулан түлхээд хөргөн нүхээр гарлаа. Харри царайдаа уучлал гуйсан өнгө тодруулахыг хичээхдээ тарган хатагтайн хөрөг тэдний ард хаагдахад Лавандагын гомдсон царайг санаад инээд алдав.

Түүнд Слизнорт өглөөний цайгаа ууж байх вий гэсэн түгшүүртэй бодол төрсөн ч хаалга нэг цохиход профессор нойрмог нүдтэй хамба хилэн халат, шөнийн малгайтай онгойлголоо.

- Харри, ямар эрт ирээ вэ ... Бямба гаригт би ердийнхөөсөө илүү унтдаг юм.
- Түгшээсэн явдалд уучлаарай, профессор гэж Харри шивнэн хэлэв. Рон тэр үед өлмий дээрээ зогсон Слизнортын өрөө рүү шагайхыг хичээлээ.
- Гэхдээ миний найз Рон алдаа гаргаад хайрын ундаа уучихсан. Та түүнд эсрэг үйлчлэлтэй уусмал өгч чадахгүйсэн болов уу? Би түүнийг хатагтай Помфри руу аваачих гэсэн ч «Уизлийн бүх төрлийн шидэт эдлэлүүд» дэлгүүрийн бараа сургуульд хориотой болохоор та ойлгож байгаа биз дээ ... таагүй асуултууд ...
- Би Харри таны уусмалын мэдлэг үүнийг найздаа бэлтгэн өгч чадна гэж бодож байна, тийм биш гэж үү? хэмээн Слизнорт асуулаа.
- Э-э гэж Харри хэлэхэд Рон хавирга руу нь нудран бодоход саад болов. Харж байна уу ноёнтоон, би хайрын ундааны эсрэг үйлчлэлтэй уусмалыг хэзээ ч бэлтгэж байгаагүй. Хэрвээ би түүнийг хийх юм бол Ронд таагүй явдал учруулж болзошгүй ...

Аз болоход Рон энэ агшинд,

- Тэр харагдахгүй байна, Харри ... нуугдсан юм болов уу? гэж дуу алдлаа.
- Энэ уусмалыг бэлтгэж байгаагүй гэнээ? хэмээн Слизнорт сонирхоод Рон руу мэргэжлийн үүднээс харж,
- Тэд их хүчтэй болохоор үйлчилгээ нь удаан хадгалагддагийг мэднэ биз дээ гэв.
- Энэ олон зүйлийг тайлбарлаж байна гэж Харри Слизнортын хөл доогуур шургалах гэсэн Ронтой тэмцлээ. Ингээд ямар ч атугай,
- Өнөөдөр түүний төрсөн өдөр, профессор гэж нэмэрлэв.
- Өө, гайхамшигтай тэгвэл орцгоо орцгоо. Хэрвээ миний цүнхэнд хэрэгтэй зүйл байвал эсрэг уусмалыг бэлтгэхэд ямар ч түвэггүй л дээ ...

Рон Слизнортын өрөөнд ороод ширээний хөл доогуур бөхийн шагайснаа тэнцвэр алдан Харрийн хүзүүгээр зуураад,

- Тэр харагдахгүй байна тийм үү? гэв.

- Тэр ирээгүй байна гээд Харри профессор орцыг онгойлгож хэдэн чимхийг болор хуруу шилд хийхийг харлаа.

- Сайн байна. Би ямар харагдаж байна?

- Маш сайхан гэж Слизнорт хэлээд Роны аягатай тунгалаг шингэнийг хутгаж,

- Харин одоо үүнийг уу. Энэ ханд түүнийг ирэхэд таньд тайван байхад туслах болно гэв.

- Сайн байна гэж Рон тэвчээргүйхэн бувтнаад эсрэг уусмалыг чимээтэй залгилав.

Харри, Слизнорт хоёр түүнийг ширтэв. Агшин зуур Рон тэдэн рүү зальжин инээмсэглэв. Дараа нь инээмсэглэл алгуур бөхөөд айдаст автсан царай болон өөрчлөгдөв.

- За яасан ахиад эрүүл ухаантай болов уу? гэж Харри инээмсэглэхэд Слизнорт хөхрөв.

- Их баярлалаа профессор.

- Ингэж хэлэх хэрэггүй дээ, хүү минь гэж Слизнорт хэлэхэд Рон сандалд лагхийн суулаа.

- Түүнийг жаахан сэргээх хэрэгтэй гэж Слизнорт үргэлжлүүлээд ширээн дээр шилэн аяга гаргаж тавилаа. Надад цөцгийний шар айраг, дарс бас сүүлчийн лонх царсан торхонд дарсан балын ундаа байна ... хм-м ... би түүнийг зул сараар Дамблдорд бэлэглэх гэж байсан юм ... за яахав гээд мөрөө хавчсанаа,

- Өгөөгүй болохоор гомдохгүй биз. Яагаад бид түүнийг ноён Уизлийн төрсөн өдрийн төлөө онгойлгож болохгүй гэж? Зүрх шархлуулсан хайрын төлөө ... гэв.

Тэр ахин инээд алдахад Харри бас инээмсэглэв. Үнэн дурсамжыг гарган авах гээд сүйрсэн анхны бүтэлгүй оролдлогынхоо дараа Харри түүнтэй бараг ганцаар үлдлээ. Хэрвээ профессорын өөдрөг сэтгэлийг дэмжвэл ... хэрвээ балын ундаа тэдэнд үйлчилвэл ...

- За чиний төлөө гээд Слизнорт түүнд болон Ронд аягатай ундаа өгөөд өөрийнхийгөө өндөрт өргөлөө.

- Ральфын төрсөн өдрийн төлөө ...

- Рон гэж Харри шивнэлээ.

Гэвч Рон хундаганы үгийг сонсолгүй аягатайг хэдийн уруулдаа хүргэжээ.

Ердөө агшины дараа зүрхэнд цохилт өгсөн явдал болж Харри ямар нэг аймшигтай зүйл болсныг ойлгоход Слизнорт үүнийг ажигласангүй.

- Таньд олон олон ...

- Рон!

Рон аягыг унагаад сандал руу буцаж унан хөл гар нь татвалзаж эхлэв. Амнаас нь хөөс гарч нүд нь бүлтийлээ.

- Профессор! Ямар нэг зүйл хийгээч! гэж Харри орилов.

Гэвч Слизнорт цочирдолд орсон бололтой. Рон татганасаар арьс нь хөхөрч эхлэлээ.

- Гэхдээ ... юу ... гэж Слизнорт уулга алдав.

Харри намхан ширээн дээгүүр харайгаад Слизнортын онгорхой орхисон орцон дундах хүүдийтэйг онгичиход ард нь Роны хэржигнэсэн амьсгаа сонсогдлоо. Эцэст нь эрсэн зүйл болох Слизнортын уусмалын хичээл дээр авчирсан үрчийсэн ямааны бөөрийг оллоо.

Тэр Рон руу яаран ухасхийгээд эрүүг нь хүчээр нээж ам руу нь безоарыг чихлээ. Роны чичирэлт намдан хүчтэй агаар амьсгалаад дараа нь бие нь суларч хөшлөө.

## БҮЛЭГ 19: ЭЛЬФ МӨРДӨГЧИД

- Роны төрсөн өдөр тийм ч сайн болсонгүй юу? гэж Фред асуулаа.

Хэдийн үдэш болоод эмнэлэгийн жигүүрт нам гүм оргиж цонхны хөшиг хаалттай дэнлүү ассан байв. Энд зөвхөн ганц ор эзэнтэй байсны дээр Рон хэвтэж Харри, Гермиона, Жинни гурав тойрон сууж байлаа. Тэд өдрийн турш гадаа хүлээн өрөө рүү хэн нэгэн орох юмуу гарах болгонд хаалгаар шагайхыг хичээж байсан юм. Хатагтай Помфри тэднийг ердөө оройн найман цагаас оруулжээ. Фред, Жорж хоёр арван хормын дараа ирэв.

- Тиймээ бид түүнд бэлгээ яаж гардуулахаа төсөөлөхгүй байна гэж Жорж баргар хэлээд Роны орны дэргэдэх шүүгээн дээр том боодолтой бэлэг тавилаа.

- Тэгээд ч бид энэ үйл явдлыг Роныг эрүүл байхад зураглан бүтээсэн юм гэж Фред зөвшөөрөв.

- Хогсмидод суугаад түүнд гэнэтийн бэлэг барих гээд хүлээж байлаа ... гэж Жорж үргэлжлүүлэв.

- Та нар Хогсмидэд байгаа юм уу? гэж Жинни тэдэн рүү харлаа.

- «Зонко»-г худалдаж авдаг юм уу гэж бодож байна гэж Фред баргар царайлан хэлээд,

- Хогсмидийн шидэт тоглоомын дэлгүүрийг мэднэ биз дээ ... Хэдийгээр энэ сайхан бодол ч гэсэн хэрвээ та нар амралтын өдрүүдээрээ очиж юм худалдаж авахгүй бол боломжгүй болно ... Гэхдээ одоо энэ хамаагүй л дээ! гэв.

Тэр сандлаа Харри руу дөхүүлэн суугаад Роны цонхигор царай руу харлаа.

- Энэ бүхэн яаж болсон юм бэ, Харри?

Харри түүнд Дамблдор, МакГонагалл, хатагтай Помфри, Гермиона, Жинни нарт ярьсан түүхээ бараг зуу дахь удаагаа ярилаа.

- Намайг түүний аманд безоар шургуулах үед амьсгаа нь дээрдэж Слизнорт тусламж дуудахаар гүйгээд МакГонагалл хатагтай Помфри хоёрын хамт ирж ийш нь шууд авчирсан юм. Тэд түүний бүх зүйл хэвийн гэсэн. Хатагтай Помфри Роныг дараа нь харамсах зүйл гаргуулахгүйн тулд ... энд ойролцоогоор долоо хоног байх болно гэсэн ...

- Чөтгөр гэж чи ямар азаар безоарын тухай санав аа гэж Жорж аяархан хэлэв.

- Аз болоход тэр тэнд байсан гээд Харри хэрвээ чулууг олоогүй бол юу тохиолдох байсныг бодохоос дотор зарсхийлээ.

Гермиона сонсдох төдий хамраа шуухитнуулав. Энэ өдрийн турш тэр ер бусын чимээгүй байлаа. Тэрбээр цонхийсон царайтай эмнэлэгт нисэн ирээд Харриг барин авч юу тохиолдсоныг хэлэхийг шаардсан ч Харри, Жинни хоёрын Роныг яагаад



хордуулсан тухай ярианд оролцоогүй бөгөөд тэднийг эцэст нь өрөөнд оруулан харахыг зөвшөөрөх хүртэл шүдээ зуун айсан янзтай зогсож байсан юм.

- Ээж аав хоёр мэдэж байгаа юу? гэж Фред Жиннигээс асуулаа.
  - Тэд цагийн өмнө ирээд Роныг хэдийн харсан. Одоо Дамблдорын өрөөнд сууж байгаа удахгүй ирнэ.
- Бүгд чимээгүй болоод зүүдэндээ бувтнаж буй Рон руу харлаа.
- Дарсанд хор байсан хэрэг үү? гэж Фред аяархан асуулаа.
  - Тиймээ гэж Харри даруй хэлэв. Тэр өөр зүйлийн талаар бодож чадахааргүй байсан тул ярианд ахин баяртайгаар оролцлоо.
  - Слизнорт түүнийг аягалаад ...
  - Тэр Роны аяганд чамд ажиглагдахгүйгээр ямар нэг зүйл хийж чадах байсан болов уу?
  - Чадах байсан. Гэхдээ Слизнортод Роныг хордуулах нь ямар хэрэгтэй гэж?
  - Мэдэх юм алга гэж Фред хөмсөг зангидан хэлээд,
  - Чи түүнийг эндүүрээд аяга сольсон гэж бодохгүй байна уу? Чамайг хордуулах гэсэн юм биш биз дээ? гэв.
  - Слизнорт Харриг хордуулж яах юм? гэж Жинни асуулаа.
  - Мэдэхгүй. Гэхдээ Харриг хордуулах шалтгаан байгаа биз дээ? Сонгогдсон энэ тэр гээд л.
  - Чи Слизнортыг Үхэл залгигч гэж бодож байгаа юм уу?
  - Байж болох л юм гэж Фред баргар хэлэв.
  - Өөрөөр түүнийг Импербус шившлэгийн дор удирдаж байсан байж болох юм гэж Жорж хэлэв.
  - Эсвэл тэр үүнд ямар ч буруугүй. Лонхонд байсан хор түүнийг өөрийг нь хордуулах гэсэн юм биш биз дээ гэж Жинни дуугарлаа.
  - Слизнортыг алах нь хэнд хэрэгтэй юм бэ?
  - Дамблдор Волан-де-Морт Слизнортыг өөрийн талдаа оруулахыг хүсч байгаа гэж бодож байгаа. Ийм учраас Слизнорт Хогвартс руу ирэхээс өмнө бүтэн жил нуугдсан хэрэг. Тэгээд ч ... гээд Харри Дамблдор Слизнортын дурсамжыг гарган авч чадахгүй байгаа тухай бодсоноо,
  - Магадгүй Волан-де-Морт түүнийг замаасаа зайлуулахыг хүссэний учир нь Слизнорт Дамблдор ашигтай байж болох юм гэлээ.
  - Гэхдээ чи Слизнорт лонхыг Дамблдортуул зул сараар бэлэглэх гэж байсан гэсэн биз дээ. Тэгэхээр хордуулагч Дамблдор руу чиглэсэн байна гэж Жинни хэлэв.
  - Тийм тохиолдолд хордуулагч Слизнортыг муу мэддэг юм байна гэж

Гермиона хэдэн цагийн дараа анх удаа амаа нээгээд,

- Ямар ч байсан түүнийг мэдэх хүн өөрөө амтлах боломжыг алдахгүй байсан гэдгийг сайн мэдэж байгаа гэв.

- Ер-ми-наа гэж Рон гэнэтхэн сөөнгөтөв.

Бүгд чимээгүй болоод түүн рүү түгшин харахад Рон учир нь олдохгүй үг бувтгаснаа хурхирлаа.

Өрөөний хаалга нээгдэж бүгдийг цочин харайтал Хагрид том алхлан орж ирлээ. Үс нь борооны дусалд цоохортож, баавгайн арьсан дээл өмсөөд гартаа нум сум барьжээ. Хагрид ардаа багахан дельфиний хэмжээтэй бохир мөр үлдээж байлаа.

- Өдөржингөө ойд байлаа! Арагогын бие муу байгаа болохоор би ном уншиж өгсөн юм. Дараа нь хооллодог юм уу гэж бодтол профессор Стебль надад Роны тухай хэллээ! Ингэхэд тэр хэр байна даа?

- Муугүй. Тэд бүх зүйл нь хэвийн гэсэн хэмээн Харри хэлэв.

- Нэгэн зэрэг зургаагаас илүү эргэлтийн хүн байж болохгүй! гэж өрөөнд яаран орж ирсэн хатагтай Помфри мэдэгдэв.

- Хагрид зургаа дахь нь гэж Жорж хэллээ.

- Аан ... тийм л дээ ... гээд хатагтай Помфри харваас Хагридын биеийн хэмжээг хэдэн хүнээр шууд тооцсон бололтой. Тэр мэгдсэнээ нуухын тулд шидэт саваагаа яаран гаргаж ирээд ойн сахиулын үлдээсэн бохир мөрийг арилгав

- Би үүнд итгэж чадахгүй нь ... Ерөөсөө ч итгэхгүй нь ... Та нар түүний хэвтэж байгааг нь хар даа ... Хэн түүнд ингэтлээ уурладаг байна? гэж Хагрид сөөнгөтөн хэлээд Рон руу толгойгоо сэгсрэн харлаа.

- Бид энэ тухай сая ярьж байлаа. Сайн мэдэхгүй байна гэж Харри хэлэв.

- Магадгүй хэн нэгэн Гриффиндорын квиддчийн багийн эсрэг шүд зуусан хэрэг биш биз? гэж Хагрид түгшин асуугаад,

- Эхлээд Кэти, дараа нь Рон... гэв.

- Бүх багийнхнийг хорлож чадах хүнийг төсөөлөхгүй нь гэж Жорж хэллээ.

- Хэрвээ Вуд байсан бол хэн үүнийг хийснийг мэдэх байсан даа. Тэр

Слизеринчүүдийг сайн мэддэг юм гэж Фред хэлэв.

- Би квиддич энэ дайралттай холбоотой гэдэгт итгэхгүй байна гэж Гермиона аяархан дуугарлаа.

- Энэ чинь юу гэж байгаа юм? гэж Фред асуулаа.

- Нэгдүгээрт хоёр үхлийн тохиолдол цэвэр санамсаргүй тохиолдлоор бүтсэнгүй. Хоёрдугаарт хор, зүүлт хэнийг алахаар зориулагдсан байсан нь тодорхойгүй байна. Мэдээж үүний ард хэн нэг маш аюултай хүн зогсож байгаа. Түүнд жинхэнэ золиосондоо хүрэхээс нааш хэдэн хүнийг дуусгах нь хамаагүй гэж Гермиона бодлогоширон хэлэв.

Хэн нэгэн энэ аймшигт мэдэгдэлд хариу хэлж амжихаас өмнө өрөөний хаалга нээгдэж ноён ба хатагтай Уизли яаравчлан орж ирлээ. Тэд түрүүний ирэлтээрээ Роны бие ямар байгааг харсан учир хатагтай Уизли Харри руу очин чанга гэвэрлээ.

- Дамблдор бидэнд чиний безоарын тусламжтай Роныг хэрхэн аварсан тухай ярилаа гэж нулимс дуслуулан хэлээд,

- Өө, Харри минь юу хэлэх вэ дээ? Чи Жинниг аварлаа ... Артурыг аварлаа ... харин одоо Роныг аварлаа ... гэв.

- Үгүй дээ, би тэгээгүй ... гэж Харри ичингүйрэн бувтнав.

- Хэрвээ бодоод үзвэл манай гэр бүлийн хагас нь чамтай амьдралаараа холбоотой гэж хатагтай Уизли цахиртсан хоолойгоор хэлээд,

- Би зөвхөн ганц л зүйлийг хэлж чадах байна. Рон чамтай «Хогвартс Экспресс» галт тэргэнд нэг тасалгаанд суусан нь бидний хувьд хамгийн азтай өдөр, Харри минь гэв.

Харри үүнд хариу хэлэх үг олж чадаагүй байтал хатагтай Помфри ахин орж ирээд Рон дээр зургаагаас илүүгүй эргэгч байхыг сануулахад ихэд баярлав. Харри, Гермiona хоёр шууд явахаар босоход Хагрид тэдэнтэй нэгдэн Роныг гэрийнхэнтэй нь үлдээлээ.

- Аймшигтай юм гээд ойн сахиул өтгөн сахал дороо бувтнаад тэдний хамт хонгилоор гантиг шат руу явж,

- Хичнээн их шинэ хамгаалалт тавьсан ч хүүхдүүд дайралтанд өртөж байна ... Дамблдор их түгшсэн байсан. Тэр энэ тухай чимээгүй байгаа ч би харж байна ... гэв.

- Чамд үүнийг хэн хийгээд байгаа талаар ямар нэг санаа байна уу, Хагрид? гэж Гермiona цөхрөн асуулаа.

- Санаа гэвэл түүнд зуугаараа бий. Гэхдээ тэр хэн энэ зүүлт, хордуулсан дарсыг илгээснийг мэдэхгүй байгаа. Намайг зовоож байгаа зүйл гэвэл гээд хоолойгоо намсан эргэн тойрноо харав (Харри ямар ч атугай адарт Пивз нуугдсан эсэхийг харлаа).

- Хэрвээ хүүхдүүдийг дайрч эхлэвэл Хогвартс удаан нээлттэй тогтож чадах уу? Ахиад л нууц өрөө шиг юм болно биз дээ? Цочирдол газар авч эцэг эхчүүд юу болсныг ойлгож амжихаас өмнө хүүхдээ сургуулиас гаргаж авах болно гэсэнээ чимээгүй болоход дэргэдүүр нь урт үстэй хатагтайн хий үзэгдэл өнгөрлөө.

- Энэ боломжтой гэж үү? хэмээн Гермiona түгшлээ.

- Чи өөрөө бүгдийг харж байгаа биз дээ гэж Хагрид гашуунаар хэлээд,

- Хогвартсад хүүхдээ илгээх үргэлж эрсдэлтэй байсан. Нэг газар өсвөр насны зуугаад шидтэнийг түгжихэд золгүй явдлаас өөр юу хүлээх юм. Гэвч тэднийг алах гэдэг бол өөр хэрэг. Өөр нэг гайхаж байгаа зүйл гэвэл Дамблдор Снеггэд уур ... гэв.

Хагрид байрандаа хөшсөнөө сахалтай нүүрэн дээр нь танил гэм буруутай өнгө тодров.

- Юу? Дамблдор Снеггэд уурласан хэрэг үү? гэж Харри түргэн асуулаа.
  - Би тэгж хэлээгүй гээд Хагрид айсан янзтай толгойгоо хөдөлгөж,
  - Хараач шөнө дунд болчихож би явах хэрэгтэй байна гэв.
  - Хагрид Дамблдор яагаад Снеггэд уурласан юм? гэж Харри чанга асуулаа.
  - Чш-ш-ш! гээд Хагрид тэднийг уурсан харж,
  - Тийм чанга орилох хэрэггүй, Харри. Чи намайг ажлаас хөөлгөхийг хүсээд байгаа юм уу? Чи одоо шидэт амьтны хичээлд явахаа больсон болохоор ...
  - Намайг буруугаа хүлээхийг хүсч байна уу? Тэгвэл юу ч бүтэхгүй гэж Харри хатуу хэлээд,
  - Снегг юу хийсэн юм? гэв.
  - Мэдэхгүй, Харри би тэдний яриаг бүгдийг нь сонсоогүй! Өчигдөр үдэш ойд явж байтал маргаж байгаа бололтой яриа сонссон юм. Би тэдний анхаарлыг татахыг хүсээгүй болохоор чимээгүй явах гэсэн ч тэд ... ер нь бол чихэнд дуулдаж байхад сонсохгүй байх аргагүй байлаа.
  - Тэгээд яасан? гэж Харри Хагрид гэмшингүй хөлөө сольбин гишгэхэд хэлэв.
  - Би зөвхөн Снегг Дамблдортой ... үүнийг хийхийг хүсэхгүй байна гэж хэлэхийг л сонссон ...
  - Юу хийнэ гэж?
  - Мэдэхгүй, Харри энэ нь яг л Снеггт зүтгэл гаргаагүй юм шиг сонсогдсон.
- Ямар ч гэсэн Дамблдор түүнд хийхийг зөвшөөрсөн гэдгийг нь ширүүн сануулсан. Маш хатуу шүү. Харин дараа нь Снеггийн удирдаж байгаа Слизерин тэнхимд ямар нэг ул мөр хайх тухай ярьсан. Тэгээд өөр хачирхалтай зүйл юу ч болоогүй! гэж Хагрид яаран нэмэрлэсэнээ Харри, Гермiona хоёр учиртай харц солилцохыг хармагц,
- Бусад эрхлэгчдийг ч гэсэн тэнхимдээ шалгах үүрэг өгсөн ... гэлээ.
  - Тиймээ гэхдээ тэдний хэн ч Дамблдортой маргалдаагүй биз дээ? гэж Харри хэлэв.
  - Хүлээгээрэй гээд Хагрид гартаа байсан нум сумаа тахийлгахад чанга тасхийх чимээ гараад хоёр хэсэг болон хуваагдав.
  - Би чиний Снеггийн тухай юу бодож байгааг мэдэж байна, Харри. Би чамайг түүний хэрэгт оролцоосой гэж хүсэхгүй байна.
  - Болгоомжтой! гэж Гермiona анхааруулав.

Тэднийг эргэж харах агшинд хананд Аргус Филчийн сүүдэр туссанаа араас нь өөрийн биеэр булан тойрон бөхийн гарч ирээд эрүүгээ баяртайгаар чичигнүүлэв.

- Аанхан! Цаг оройтсон байхад та нар унтаагүй болохоор хичээлийн дараа үлдэх шийтгэл хүлээх болж дээ!
- Үгүй дээ, Филч. Тэд надтай хамт явж байгаа гэж Хагрид хэлэв.
- Үүнд чинь тэгээд ямар ялгаа байгаа юм? гэж Филч сониучирхав.
- Чөтгөр гэж, би бол багш өөдгүй сангасваа минь! гэж Хагрид зандрав.

Жигшүүртэй исгэрэх чимээ сонсогдоод Филч уурсан хөөхөд хатагтай Норрис ирээд ясархаг шагайг нь шөргөөв.

- Эндээс явцгаа гэж Хагрид хэлэв.

Хоёр удаа гуйлгах хэрэг байсангүй Харри, Гермиона хоёр гүйн холдохдоо ардаа Хагрид, Филч хоёрын чанга маргалдах хоолойг сонслоо. Тэднийг Гриффиндорын цамхаг руу урдаас нь Пивз угтан ирээд баяртай хашгиран нисэж,

Хэрвээ хүмүүс маргалдаж байвал

Пивзийг дууд хоёр дахин нэмэгдүүлээд өгье гэв.

Тарган хатагтай хурхирч байсан болохоор сэрээсэн явдалд огтхон ч баярласангүй бөгөөд үглэн эргэхэд Гермиона, Харри хоёр чимээгүй хоосон амралтын өрөөнд орлоо. Ронд тохиолдсон явдлыг олон хүн мэдсэнгүй. Харрийн хувьд өнөөдөр байцаалт хангалтай болсон болохоор санаа амарлаа. Гермиона Харрид тавтай нойрсохыг хүсээд охидын унтлагын өрөө рүү явлаа. Тэр амралтын өрөөнд үлдээд ханан зуухны урд талын сандалд суун унтарч буй цог ширтэв.

Тэгэхээр Дамблдор Снеггтэй маргалдсан байна. Тэр Харрид юу ч хэлсэн бай, Снеггэд бүрэн итгэдэг гэж зүтгэлсэн ч бай түүнийг Слизеринчүүдийг мөрдөхөд хангалттай амжилт гаргаагүй явдалд уурлажээ ... эсвэл зөвхөн Малфойг юм болов уу?

Магадгүй Дамблдор Харриг ямар тэнэг зүйл хийх вий гэж болгоомжилсондоо бүгдийг гартаа авах гэсэн юм байгаа даа? Эсвэл Харриг хичээлээс нь хөндийрүүлэхийг хүсээгүй болохоор Слизнортын дурсамжыг олж өгөхийг хүссэн байх. Эсвэл арван зургаан настай хүүхэд багшдаа сэжиглэлээ хэлнэ гэж бодоогүй байж болох юм ...

- Аан чи юу, Поттер!

Харри цочирдон үсрэн босоод шидэт саваагаа бэлхэн барилаа. Тэр амралтын өрөөнд хэн ч байхгүй гэдэгт итгэлтэй байсан ч булангийн сандлаас том биетэй хүн босож ирэв. Ойртож ирэхэд нь харвал Маклагген байлаа.

- Би чиний ирэхийг хүлээж байлаа гэж Маклагген Харрийн савааг үл ойшоон хэлээд,
- Тэгээд унтчихаж. Сонсооч би өглөө Уизлиг эмнэлэг рүү аваачихыг харлаа.

Тэр харваас дараагийн долоо хоногийн тэмцээн хүртэл эдгэрэхгүй юм шиг санагдсан гэв.

Харрид түүний юун тухай ярьж байгааг ойлгоход хэдэн хором шаардагдав.

- Аан ... тийм л дээ ... квиддич гээд саваагаа жинснийхээ халаасанд хийж үсээ ядрангуй илээ.
- Тиймээ, тэр тоглож чадахгүй болсон.
- Тэгвэл би хаалгачаар тоглож болно биз дээ?
- Тиймээ, тэгж үз ...

Эцсийн эцэст сорилтон дээр Маклагген хоёр дугаар байранд орсон болохоор эсэргүүцэх хэрэггүй байлаа.

- Маш сайн байна. Тэгвэл бэлтгэл хэзээ эхлэх юм? гэж Маклагген баярлав.
- Юу? Аан ... маргааш орой.
- Сайн байна. Сонсооч, Поттер бидэнд өөр ярих зүйл байна. Надад бодсон зарим нэг төлөвлөгөө байгаа болохор чи тэднийг ашигтай болгож болох юм.
- За яахав гэж Харри урам зориггүй зөвшөөрөөд,
- Гэхдээ зөвхөн маргааш ярьж үзээрэй. Өнөөдөр намайг хичнээн их ядарсныг харж байна уу ... гэв.

Маргааш нь сургууль дээгүүр Роны хордсон тухай мэдээ тарсан ч Кэтийн дайралтын дараах шиг шуугиан дэгдсэнгүй. Бүгд энэ золгүй явдал уусмалын багшийн өрөөнд болсон болохоор эсрэг уусмалыг даруйхан өгч гэмтэлгүй өнгөрсөн гэж бодоцгоожээ. Үнэн хэрэгтээ Гриффиндорынхон Пуффендуйтай тоглох тэмцээнийг сонирхож олон хүн Пуффендуйн ангууч Захария Смитыг Слизеринтэй хийсэн эхний тэмцээн дээр хэлсэн тайлбарынх нь төлөө шийтгэхийг хүсч байлаа.

Гэхдээ Харри квиддичийг ердийнхөөсөө илүү бага сонирхож байлаа. Драко Малфойн тухай бодол толгойны өвчин болж хувиран боломж гарах бүрт Тэнүүлчний газрын зургийг харж шалгаж байсан авч ямар ч ер бусын газар илрүүлж чадсангүй. Ингээд Малфой тайлбарлаж боломжгүй аргаар газрын зурагнаас үргэлжлүүлэн алга болсон хэвээр байлаа.

Түүнчлэн квиддичийн бэлтгэл, гэрийн даалгавар болон хаашаа ч явсан салахгүй дагах Кормак Маклагген, Лаванда Браун нараас болоод энэ тааврыг тайлахад тийм ч олон цаг зарцуулж чадсангүй.

Тэр тэдний хэнд нь илүү уурлахаа мэдэхгүй байлаа. Маклагген үргэлж Роноос илүү хаалгач болохоо нотлон ярих бөгөөд Харри түүний жигд тоглолтыг хараад бас тэгж бодлоо. Гэсэн ч Маклагген бусад тоглогчдыг шүүмжлэн Харрид тоглолтын төлөвлөгөөний талаарх заавар өгч байсны улмаас нэг бус удаа багийн ахлагч хэн гэдгийг сануулах хэрэг гарчээ.

Харин Лаванда түүнтэй Роны тухай ярилцан Маклаггены квиддичийн тухай лекцээс дутуугүй залхааж байлаа. Эхэндээ Лаванда Роныг эмнэлэгт хэвтсэн гэдгийг хэн ч хэлээгүй явдалд ихэд уурласан авч (Би ямар ч гэсэн түүний найз охин шүү дээ!)

дараа нь Харриг үүнийх нь төлөө уучлахаар шийдээд Роны мэдрэмжийн тухай яриа өрнүүлж эхлэв.

- Сонсооч чи яагаад энэ бүхнээ Ронтой ярьж болдоггүй юм? гэж Харри түүний удаан байцаалтын тухай асуулаа.

- Намайг түүнтэй уулзахаар очих болгонд унтаж байдаг шүү дээ! гэж Лаванда уурсан хэллээ.

- Яасан гэнээ? хэмээн Харри гайхлаа. Түүнийг эмнэлэгт очих болгонд Рон хөгжилтэй сэргэлэн байж Дамблдор болон Снеггийн тухай сонирхон асууж Маклаггены талаар ярьж байдаг байсан юм.

- Гермiona Грейнджер түүн дээр очсон хэвээр байгаа юу? гэж Лаванда гэнэтхэн хэлэв.

- Минийхээр бол тийм. Тэгээд ч тэд найзууд юм чинь яагаад болохгүй гэж? хэмээн Харри амаргүйхэн хэллээ.

- Найзууд гэнээ, битгий инээд хүргээд бай! гэж Лаванда зэвүүцэн хэлээд,

- Тэр Роныг надтай уулзаж эхэлсэн долоо хоногоос хойш ярихаа больсон биз дээ! Харин одоо найрамдахаар шийдсэн гэдэг чинь сонирхолтой байна ... гэв.

- Чинийхээр бол хор бас сонирхолтой байх уу? Ямар ч байсан ... би явах ёстой уучлаарай ... Тэндээс Маклагген квиддичийн тухай ярилцахаар ирж байна гээд Харри яаран хажуу тийш ухасхийж товч замаар уусмалын хичээл рүү явахад аз болоход Лаванда, Маклагген хоёр түүний араас дагаж чадсангүй.

Пуффендуйтай тоглох тэмцээний өглөө Харри замаараа эмнэлэг орлоо. Хатагтай Помфри түүний сэтгэлийг донслохоос болгоомжилж тэмцээн харахыг явахаар зөвшөөрсөнгүйд Рон ихэд унтууцсан байв.

- Маклагген хэр байна даа? Тэр хэвийн хэмжээндээ орсон уу? гэж Рон энэ асуултыг хоёр удаа тавьсан болохоо мартан асуулаа.

- Би чамд хэлсэн биз дээ. Тэр дэлхийн хэмжээний тоглогч болохоор би түүнийг багтаа барьж чадахгүй нь. Тэр бусдад үргэлж элдвийн заавар зөвөлгөө өгч залхааж байгаа. Би түүнээс хэзээ салахаа хүлээж чадахгүй нь. Ингэхэд гээд Харри «Аянга»-аа босгосноо,

- Чи Лавандаг ирэхэд унтаж байгаа дүр үзүүлэхээ больж болохгүй юу? Тэр намайг бүр ухаан солиоруулах нь байна гэлээ.

- Өө, тиймээ тэгэлгүй яахав гэж Рон ичингүйрэн хэлэв.

- Түүнтэй уулзахыг хүсэхгүй байгаа бол энэ тухайгаа хэл гэж Харри зөвлөв.

- Тийм шүү ... гэхдээ энэ амаргүй байна гээд Рон чимээгүй болсноо,

- Гермiona тэмцээний өмнө ийшээ ирэхгүй юм болов уу? гэв.

- Үгүй тэр хэдийн Жиннитэй талбай руу явсан.

- Тийм л дээ гэж Рон барайн хэлээд,

- За амжилт хүсье. Маклаг ... бут цохигдоно гэж найдаж байна ... Смит гэх гэсэн юм л даа.

- Хичээе гээд Харри шүүрээ мөрөн дээрээ тавилаа.

- Баяртай тэмцээний дараа уулзая.

Тэр яаран хоосон хонгилд гарлаа. Бүгд цэнгэлдэх хүрээлэн рүү явсан бололтой нэг ч хүн байсангүй. Харри цонхны хажуугаар өнгөрөх зуураа ямар салхитай байгааг нь багцаалах гэж оролдтол анхаарал нь урдаа гарсан чимээнд татагдлаа. Малфой түүний зүг хоёр охин дагуулсаар ойртож ирэхэд хоёул барайн дургүйцсэн харагдав.

Харриг ажигламагц Малфой байрандаа хөшөөд хорон инээмсэглэснээ ахин урагшаа явлаа.

- Чи хаачиж байгаа юм? гэж Харри огцом асуув.

- Аан, Поттер хүлээж бай би чамд хамаатай зүйлийг хэлье! Чи яарсан чинь дээр байх шүү тэнд Сонгогдсон ахмад, Үргэлж ялагч хүү өөр юу ч билээ чамайг хүлээгээд байна.

Охидын нэг инээд алдав. Харри түүн рүү харахад улайлаа. Малфой Харриг түлхээд цааш явахад охин найзынхаа хамт араас нь дагаад гурвуул булан тойрон алга болов.

Харри хөшсөн юм шиг үлдээд араас нь харав. Уурласандаа орилохыг хүслээ! Тоглолт эхлэхэд хэдхэн хором үлдээд байхад Малфой хоосон сургууль дотор гэтэж явдаг. Түүнд Малфойн юу хийж байгааг илрүүлэх сайхан боломж ирлээ. Чимээгүй агшин урсан өнгөрөхөд Харри Малфойн алга болсон газраас нүд салгалгүй зогссоор байлаа ...

- Чи хаана байсан бэ? гэж Жинни Харриг хувцас солих өрөөнд гүйн ороход ууртай асуув. Бүх багаараа хэдийн хувцсаа сольж өмсөөд довтлогч Кут, Пикс хоёр цохиураараа тэвдэнгүй хөлөө цохилж байв.

- Малфойтой уулзсан юм гээд Харри толгойдоо улаан жанчаа углалаа.

- Юу гэнээ?

- Бүгдийг энд байхад түүнийг хоёр охинтой шилтгээнд юу хийж байгааг нь мэдэхийг хүссэн юм ...

- Энд болж байгаа үйл явдал чухал биз дээ?

- За, гарцгаая! гээд Харри «Аянга»-аа авч шилээ заслаа.

Ингээд өөр үг хэлэлгүй талбай руу гарахад чих дөжрөм хашгиралт угтав. Багахан салхитай байсан бөгөөд тэнгэр ховорхон үүлтэй үе үе нарны гэрэл гялбах аж.

- Найдваргүй нөхцөл! гэж Маклагген багт хандан хэлээд,

- Кут, Пикс та хоёр наран талаас нисвэл тэд ирж байгааг чинь харж чадахгүй шүү ... гэв.

- Багийн ахмад би байна, Маклагген тоглогчдыг сургахаа больж үз гэж Харри яриаг нь ууртай таслаад,



- Онооны цагаригтаа очсон чинь дээр байх! гэв. Маклаггеныг явмагц Харри довтлогчид руу эргээд,

- Наран талд нисэхийг хичээгээрэй гэж дургүйхэн хэлэв.

Харри Пуффендуйн багийн ахмадтай гар барилцаад хатагтай Нугарагчын шүглийн дуугаар газар түлхэн бусад тоглогчдоос өндөрт хөөрөөд талбайн эргэн тойронд снитчийг эрлээ. Хэрвээ снитчийг эрт барьж авбал шилтгээн рүү очин Тэнүүлчний газрын зураг дээр Малфойн юу хийж байгааг харах боломжтой болно ...

- Аан Пуффендуйн Смит квоффлыг авч явж байна гэх чанга мөрөөдөнгүй хоолой сонсогдов.

- Өнгөрсөн удаад түүнийг тайлбарлагч хийж байхад нь Жинни Уизли мөргөсөн билээ. Энэ нь түүний зүгээс санаатай юм шиг харагдсан. Смит Гриффиндорын эсрэг бүдүүлэг байсныхаа төлөө одоо харамсаж байгаа байх ... Өө хараач, Жинни түүнээс квоффлыг булааж авлаа тэр надад таалагддаг, маш сайн охин ...

Харри доошоо тайлбарлагчын тавцан руу харлаа. Хэний толгойд тэмцээнийг Полумна Лавгудаар тайлбарлуулах санаа ордог байна аа? Ийм өндрөөс ч эндүүрэх боломжгүй байв. Урт цайвар үс, шар айрагны бөглөөтэй зүүлт гээд л ... Дэргэд нь сууж байгаа профессор МакГонагалл түгшсэн шинжтэй байсан нь харваас энэ сонголтондоо харамсаж байгаа бололтой.

- ... гэхдээ одоо квоффлыг Жиннигээс Пуффендуйн том биетэй тоглогч авлаа, нэрийг нь санаж чадахгүй нь ... Быкинс ... үгүй, Бугайни ...

- Скоткинс! гэж профессор МакГонагалл чанга хэлэхэд үзэгчид нирхийтэл инээлдэв.

Харри эргэн тойрондоо снитч байгаагийн ямар ч шинж тэмдэг харсангүй. Хормын дараа Скоткинс оноо авлаа. Маклагген Жиннигийн квоффл алдсан явдлыг хашгиран шүүмжилж байсан болохоор үр дүнд нь том улаан бөмбөг баруун чихний дээгүүр нь өнгөрлөө.

- Маклагген өөрийн ажлаа хийгээд тоглогчдыг тайван орхи! гэж Харри дэлбэрээд хаалгачынхаа царай луу тулж очлоо.

- Харин чи надад жишээ үзүүлж байгаа юм уу! гэж улайж уурсан Маклагген хашгирав.

- Ингээд Харри Поттер хаалгачаа харааж байна гэж Полумна баяртайгаар хэлэхэд Пуффендуй болон Слизеринчүүдийн суудлаас хөхрөлдөөн сонсогдов.

- Гэхдээ энэ нь түүнд снитчийг барихад нь туслана гэж бодохгүй байгаа ч ухаалаг заль байж болох юм ...

Харри уурсан хараасаар байрандаа ирээд ахин талбай дээгүүр эргэлдэн тэнгэрт нүдээ бэлчээж жижигхэн алтан жигүүртэй бөмбөгийг хайлаа.

Жинни, Демельза хоёр тус бүрдээ оноо авахад улаан хувцастай хөгжөөн дэмжигчид хөөрөн нүргэлүүлэв. Дараа нь Скоткинс ахин нэг бөмбөг оруулахад оноо тэнцүү

болсон ч Полумна үүнийг ажигласангүй бололтой. Онооны байдал түүний сонирхлыг бага татаж үзэгчдийн анхаарлыг өөр илүү сонирхолтой зүйл болох үүлсийн ер бусын хэлбэр дүрсийн талаар ярих юмуу Захария Смит квоффлыг барьж чадалгүй алдах болгонд чадваргүй амьтан гэж байлаа.

- Оноо дал-дөч Пуффендуйд ашигтай байна! гэж Полумнагийн чанга яригчаар профессор МакГоанагалл тасхийв.

- Хэдийн тийм болчихсон уу? гэж Полумна гайхсанаа,

- Хөөх хараач! Гриффиндорын хаалгач довтлогчынхоо цохиурыг авчихлаа гэв.

Харри агаарт огцом эргэлээ. Тэгтэл үнэхээр Маклагген Пиксийн цохиурыг барин блажерыг яаж цохихыг үзүүлэхэд Скоткинс хэдийн ойртож иржээ.

- Түүнд цохиурыг нь буцааж өгөөд цагаригтаа буц! гэж Маклагген руу Харри уурсан орилоход блажерыг цохин өөр зүг лүү илгээлээ.

Гялсхийгээд дотор муухайран өвдөж ... гэрэл анивчихад ... алсад хашгирах сонсогдон ... гүнзгий хонгил руу унаж байгаа мэдрэмж төрөв ...

Дараагийн агшинд Харри дулаахан тухтай оронд хэвтээд харанхуй адарт дугуйрсан алтлаг гэрэл рүү харлаа. Тэр толгойгоо хүндхэн өргөлөө. Зүүн талд нь хэн нэг танил сэвхтэй шаргал үстэй хүн хэвтэж байв.

- Намайг харсанд чинь баяртай байна гэж Рон инээвхийлэв.

Харри нүдээ анивчаад эргэн тойрноо харлаа. Тэгэлгүй яахав тэр эмнэлэгт байв. Тэнгэр бараантаж хүрэнгэн улайжээ. Тэмцээн дуусаад хэдэн цаг болсон бололтой ... түүнчлэн Малфойг буланд шахах найдлага бөхжээ. Толгой нь ер бусын хүнд санагдахад Харри гараа өргөөд зузаан боолт мэдэрлээ.

- Юу болсон бэ?

- Тархи чинь хагарсан гэж хатагтай Помфри хариулаад түргэн ойртож ирээд дэрийг нь засав.

- Гэхдээ санаа зовох хэрэггүй дээ, би түргэн эмчилсэн учир ганц шөнө энд хоноход болно. Ойрын хэдэн цагийн турш хэтэрхий хүчилж болохгүй шүү.

- Би энд шөнөжингөө хэвтэхийг хүсэхгүй байна гэж Харри уурсан хэлээд хөнжлөө ярлаа.

- Би явж Маклаггеныг олоод алмаар байна.

- Энэ таныг хэт хүчилэхэд хүргэх болно гэж айж байна хэмээн хатагтай Помфри хариулаад Харриг шийдэмгий түлхэж хэвтүүлэн саваагаа сүрдүүлэн зангав.

- Та намайг гаргатад энд үлдэх болно, Поттер. Эсрэг тохиолдолд би сургуулийн захирлыг дуудах болно шүү.

Ингээд тэр түргэн алхаагаар өрөөнөөс гарахад Харри уурсан дэрэн дээрээ хэвтлээ.

- Биднийг хэдэн оноогоор хожигдсоныг мэдэхгүй биз? гэж тэр шүд зуун сонирхов.

- Мэдэлгүй яахав гэж Рон гэмшингүй хариулаад,
- Гурван зуун хорь-жар гэв.
- Гайхамшигтай гэж Харри дуу алдав.
- Жинхэнэ гайхамшиг! Маклагген хэрвээ миний гарт өртдөг л юм бол!
- Чи түүнд хүрэх гэсний хэрэггүй. Тэр чинь савдаг шиг биетэй. Хэрвээ би чиний оронд байсан бол түүн рүү хунтайжын хөлийн хумс ургуулах шившлэг илгээх байсан даа. Ер нь бол чамайг эндээс гарахын өмнө багийнхан түүнтэй учраа олчих байх, тэд их баяртай бус байгаа ...

Роны хоолойд муухан далдлагдсан хөөрсөн өнгө сонсогдоход Харри Маклаггены муу тоглосон явдал баярлуулж буйг нь ойлгов. Харри хэвтээд адарт эргэлдэх гэрэл ширтэн саяхан эмчлүүлсэн толгой нь өвдөөгүй ч хөндүүрлэх шиг санагдав.

- Би эндээс тайлбарлагчын хоолойг сонссон гэж Рон хөхрөн хэлээд,
- Полумнаг цаашид бүх тоглолтыг тайлбарлана гэж найдаж байна ... Чадваргүй амьтан энэ л хэрэгтэй байгаа юм! гэлээ.

Харри хэтэрхий уурласандаа болоод инээхтэй манатай байсан болохоор тургилахад Рон чимээгүй боллоо.

- Чамайг ухаангүй байхад ийшээ Жинни ирсэн гэж Рон хэсэг хугацааны дараа хэлэхэд Харри Жинни түүний ухаангүй биеийн өмнө хэрхэн цурхиран уйлж үүрдийн хайраа хүлээн зөвшөөрөхөд Рон түүнийг ерөөж байна гэж төсөөлөв.
- Тэр чамайг тэмцээн болохын өмнөхөн ирсэн гэж хэлсэн. Юу болсон юм бэ?

Чи эндээс эрт гарсан биз дээ.

- Аан ... гээд Харрийн ухаанд байсан дүр зураг бөхлөө.
- Би Малфойг хоёр охин дагуулан явж байгаатай тааралдахад хоёулаа түүнтэй явахыг хүсэхгүй байгаа юм шиг санагдсан. Бас тэр хоёр дахь удаагаа квиддичийн тэмцээнийг алгасаад байгаа биз дээ. Өнгөрсөн тэмцээнд бас байгаагүй санаж байна уу? гээд санаа алдсанаа,
- Тэмцээн сүйрэхийг мэдсэн бол түүнийг дагасан нь дээр байж дээ гэв.
- Дэмий юм бүү ярь! Чи тэмцээнийг зөвхөн Малфойг дагахын төлөө орхиж болохгүй, чи чинь ахлагч биз дээ! гэж Рон эсэргүүцэв.
- Би түүний юу бодож олсныг мэдэх хэрэгтэй байна. Тэгээд ч Снеггтэй ярьсан ярианых нь дараа зөвхөн миний төсөөлөл гэж бүү хэл ...

- Би хэзээ ч чиний төсөөлөл гэж хэлээгүй гээд Рон тохойн дээрээ өндийн ууртай ширтсэнээ,
- Чи Малфойтой бага орооцолдсон чинь дээр, Харри. Тэмцээнийг зөвхөн түүний араас мөрдөхийн тулд алгасна гэдэг чинь ... гэв.

- Би түүнийг газар дээр нь барихыг хүсч байна! Чи бодоод үл дээ, тэр яаж

Тэнүүлчний газрын зурагнаас алга болоод байгаа юм бол?

- Би хаанаас мэдэх юм! Хогсмид рүү ч юмуу ... гээд Рон эвшээлээ. Хоёул чимээгүй болоход Харри адарт эргэлдэх гэрэл харан бодлогоширов...

Мэдээж тэр Руфус Скримжерийн адил эрх мэдэлтэй байсан бол Малфойн араас мөрдүүлж чадах байсан ч золгүй нь гэвэл бүлэг мракоборецууд удирдлаган дор нь байсангүй ... Тэр ахин ДА зохион байгуулах эсэх талаар бодож үзсэн ч үүнд ганц асуудал байлаа. Бүгд хичээлээ алгасахын аргагүй шахуу хуваарьтай байв.

Роны орноос аяархан хурхиралт сонсогдов. Хатагтай Помфрийн өрөөнөөс зузаан халат өмсөх чимээ дуулдана. Харри унтаж байгаа дүр эсгэн хажуугаа эргээд түүнийг саваагаа даллан хөшиг хаах чимээ сонслоо. Дэнлүүнүүд бөхөхөд хатагтай Помфри өрөөндөө эргэж орлоо. Харри хаалга хаагдах чимээ сонсоод түүнийг унтахаар хэвтсэнийг ойлгов.

Энэ квиддичийн улмаас эмнэлэгт ирсэн гурав дахь тохиолдол болж байгаа тухай Харри бодлогоширов. Өнгөрсөн удаад талбай дээр Дементорууд гарч ирсний улмаас шүүрнээс унаад, түүнээс урьд профессор Туг үс гарынх нь бүх ясыг алга болгоход ... Харрийн амссан хамгийн их зовлонтой мөч байсан. Гарныхаа ясыг нэг шөнийн дотор ургуулахад хэрхэн өвдөж шаналж байснаа бодтол гэнэтхэн тааварлаагүй зочин ирснийг саналаа ...

Харри огцом босч суухад зүрх нь хүчтэй цохилж боолт нь хазайв. Тэр Мафойн араас яаж мөрдөх шийдвэрээ гаргалаа. Тэр яаж энэ тухай өмнө нь бодолгүй мартаж чадав аа?

Асуулт гэвэл түүнийг яаж дуудахад вэ гэдэгт байлаа. Юу хийх хэрэгтэй юм бол? Харри аяархан итгэлгүйхэн харанхуйд,

- Кикимер? гэлээ.

Тэгтэл чанга тасхийх чимээ гараад чимээгүй тасалгаанд дүүрэн часхийх чимээ дуулдав. Рон цочин сэрлээ.

- Юу болоод байна ...?

Хатагтай Помфри өрөөнөөсөө гараад ирэх вий гэж айсан Харри яаран хаалга руу нь шидэт саваагаа чиглүүлээд «Дүлийр!» гэлээ. Дараа нь орноос юу болсныг харахаар өндийв.

Өрөөний дунд шалан дээр нэг нь хүрэн өнгийн цамц хэдэн ноосон малгай давхарлан өмссөн, нөгөө нь нүхтэй бохир хуучин даавуу өмссөн хоёр гэрийн үйлчлэгч өнхрөлдөж байв. Ахин нэг чанга тасхийх чимээ гарч зууралдаж буй үйлчлэгч нарын дээгүүр хий үзэгдэл Пивз нислээ.

- Надаас нууж чадахгүй шүү, Потти! гэж тэр зэвүүцэнгүй хэлээд дороо болж байгаа тэмцэл рүү хуруугаа зааж,

- Чи энэ жижигхэн амьтдыг маргалдан бие биеэ хазаж цохиж байгааг харж байна уу? гэв.

- Кикимер Доббийн дэргэд Харри Поттерыг доромжилж болохгүй, Добби Кикимерийн амыг хамжих болно! гэж Добби чих дөжрөм жингэнүүлэв.

- ... өшиглө, мааж! гэж Пивз баяртай орилоод үйлчлэгч нарыг улам уурлуулахаар шохой чулуудаж,

- Чимхэж, нудар! гэлээ.

- Кикимер эзнийхээ тухай хүссэнээ хэлэх болно, өө тэгэлгүй яахав түүний эзэн бузар бохир цустны найз юм чинь, Кикимерийн хөөрхий эзэгтэй ингэж хэлэх байсан даа...

Үнэндээ Кикимерийн хөөрхий гэрийн эзэгтэй юу хэлснийг мэдэхээс өмнө Добби жижигхэн нударгаараа Кикимерийн ам руу цохиж хагас шүдийг нь үйрүүлэв. Харри, Рон хоёр орноосоо үсрэн буугаад үйлчлэгч нарыг салган бие биенээ өшиглөж цохихооргүй болгов. Пивз бүрхүүл тойрон эргэлдэж,

- Хуруугаа хамар луу нь чих, чих рүү нь хатга ... гэж хашгирлаа.

Харри Пивз рүү шидэт саваагаа чиглүүлээд «Ланглок!» гэлээ. Пивз хоолойгоо барьснаа өрөөнөөс нисэн гарахдаа ичгүүргүй хөдөлгөөн занган үзүүлсэн ч дуу гарсангүй хэл нь тагнайдаа цавуудан наалджээ.

- Муугүй шүү гэж Рон урамтай хэлээд Доббиг Кикимерт хүрэхээргүй сарвалзуулан өргөж,

- Энэ чинь одоо юу вэ хунтайжын бас нэг шившлэг үү? гэв.

- Тиймээ гээд Харри мурилзаж байгаа Кикимерийн нуруу болон үрчгэр гараас нь зуурлаа.

- Би та хоёрыг бие биетэйгээ зодолдохыг хориглож байна! Кикимер чи Доббитой зодолдож болохгүй. Добби би чамд тушаал өгч чадахгүйгээ ойлгож байгаа ч ...

- Добби чөлөөтэй үйлчлэгч хэдий ч Харри Поттерын хүссэн зүйлийг хийхийг эрхэмлэж байна! гэж Добби цамцаараа нулимсаа арчин хэллээ.

- Тэгвэл ч яахав гээд Харри, Роны хамт үйлчлэгч нарыг тавихад хоёул шалан дээр унасан ч үргэлжүүлэн зодолдсонгүй.

- Эзэн намайг дуудсан уу? гэж Кикимер сөөнгөтөөд бөхийн ёсолж Харриг зовж үхэхийг хүссэн харцаар шагнав.

- Дуудсан дуудсан гээд Харри хатагтай Помфрийн өрөө рүү харж дүлийрүүлэх шившлэг цуцлагдсан эсэхийг харахад ямар нэг чимээ шуугиан сонсогдсонгүй.

- Надад чамд өгөх даалгавар байна.

- Кикимер эзний хүссэн бүгдийг хийнэ гэж Кикимер мойног хөлийн хуруундаа хүртэл гүнзгий бөхийн ёслоод,

- Яагаад гэвэл Кикимерт сонголт байхгүй, гэхдээ Кикимерт ийм эзэнтэй гэхэд ичгүүртэй байна ... гэв.

- Добби Харри Поттерын хэлсэн бүгдийг хийнэ! гэж Добби одон бөмбөг шиг том нүдэндээ нуимс мэлтэрүүлэн хэлээд,

- Добби Харри Поттерт туслахыг хүндэтгэл гэж үзнэ! гэв.

- Ер нь бол та хоёр хоёулаа надад хэрэгтэй. Тэгэхээр ... та хоёр Драко Малфойг дагах хэрэгтэй байна.

Тэр Роны гайхширч унтууцсан царайд анхаарал хандуулалгүй,

- Би түүнийг хаашаа явж, хэнтэй уулзаж, юу хийж байгааг мэдэхийг хүсч байна. Би та хоёрыг түүнийг өдөр шөнөгүй мөрдөхийг хүсч байна.

- Ойлголоо, Харри Поттер! гэж Добби дуу алдаад том нүдээ баяртайгаар гялалзуулж,

- Хэрвээ Добби ингэж хийхгүй бол хамгийн өндөр цамхагаас үсрэнэ! гэв.

- Тэгэх хэрэггүй гэж Харри яаран итгүүлэв.

- Эзэн намайг залуу Малфойг дагахыг хүсч байгаа юм уу? Эзэн намайг хуучин эзэгтэйн цэвэр цусны зээг мөрдөхийг хүсч байгаа юм уу? гэж Кикимер сөөнгөтөв.

- Яг тийм гэж Харри хэлснээ энэ даалгавар хичнээн эрсдэл дагуулахыг ойлгоод,

- Чамд түүнд энэ тухай анхааруулахыг хориглож байна, Кикимер. Түүнд мэдэгдэх зүйл хийх юм уу, түүнтэй ярилцах эсвэл зурвас бичих болон ямар нэг аргаар холбогдохыг хориглож байна. Чи ойлгов уу? гэлээ.

Харри хариу хүлээхдээ Кикимер тушаалын сул талыг ашиглан мултрахыг завдаж байгаа юм шиг санагдав. Гэвч хормын дараа Кикимер Харрийн санааг гүнээ амраан ахин нэг удаа бөхийн ёслоод таагүйхэн,

- Эзэн бүгдийг урьдчилан боджээ, Кикимер хэдийгээр залуу Малфойд зүтгэхийг эрхэмлэж байгаа ч гэсэн эзний үгэнд захирагдах болно ... гэлээ.

- Тэгвэл тохиролцлоо. Надад мэдээллээ өгөхдөө эргэн тойрон хүмүүс байхгүй үед ирээрэй. Рон, Гермiona хоёр үүнд хамаагүй. Өөр хэнд ч юу хийж байгаагаа хэлж болохгүй. Зөвхөн Малфойн араас цавуудсан юм шиг дагахад болно.

## БҮЛЭГ 20: ЛОРД ВОЛАН-ДЕ-МОРТЫН ХҮСЭЛТ

Харри, Рон хоёр эмнэлэгийг даваа гаригийн өглөө орхилоо. Хатагтай Помфрийн сувилгааны ачаар тэд бүрэн эдгэрсэн бөгөөд хамгийн сайн нь гэвэл Рон, Гермиона хоёр ахин эвлэрсэн явдал байлаа. Гермиона тэднийг өглөөний цайнд хүргэж өгөөд Жинни, Дин хоёр маргалдсан тухай мэдээ дуулгахад Харрийн цээжинд нойрсож байсан мангас гэнэтхэн сэргэж найдангуй агаар шиншлэв.

- Тэд юунаас болж маргалдсан юм? гэж Харри гурвуул долоон давхарын балетын бүжиг бүжиглэж буй савдагнуудыг анхааралтай ширтэх жижигхэн охиныг эс тоовол хоосон хонгилоор явж байхдаа аль болох хайхрамжгүй асуулаа. Охин зургадугаар дамжааныхан ойртон ирэхийг хараад айсандаа шалан дээр хүнд зэс жинлүүр унагачихав.

- Зүгээр дээ, зүгээр! хэмээн Гермиона охинд туслахаар ухасхийгээд жинлүүр рүү шидэт саваагаа чиглүүлэн,

- Репаро гэв.

Охин түүнд талархалгүй араас нь дагуулан харж үлдэхэд Рон эргэж харснаа,

- Тэд жил ирэх тусам улам л жижигхэн болоод байх юм гэв.

- Тэр ч яахав гэж Харри тэвчээргүйхэн хэлээд,

- Жинни, Дин хоёр юунаас болж маргалдсан юм, Гермиона? гэв.

- Дин Маклагген чамайг блажераар цохиход инээсэн юм.

- Энэ үнэхээр инээдтэй байсан байх гэж Рон хэлэв.

- Ямар ч инээдтэй зүйл байгаагүй! гэж Гермиона дуу алдаад,

- Энэ аймшигтай байсан хэрвээ Кут, Пикс хоёр Харриг барьж аваагүй бол хүнд гэмтэх байсан байх!

- Гэхдээ Жинни яагаад үүнээс болж Динээс харьцаагаа тасалсан гэж хэмээн

Харри өмнөхийн адил хайхрамжгүй дуугарахыг хичээгээд,

- Эсвэл тэд хамтдаа байсан хэвээр байгаа юм уу гэв?

- Тиймээ тэгсэн ... Харин чи яагаад үүнийг сонирхоод байгаа юм? гээд

Гермиона Харри руу анхааралтай ширтлээ.

- Зүгээр л манай квиддчийн багт ахиад будлиан үүсэхийг хүсээгүй юм! гэж Харри яаран хэлсэн ч Гермиона түүнийг үргэлжлүүлэн сэжигтэй харсан хэвээр байсан учир ард нь «Харри!» гэж дуудах чимээ гарахад санаа амран эргэлээ.

- Сайн уу, Полумна.

- Би чамайг эмнэлэгт эргэхээр очсон ч тэд чамайг гарсан гэж хэлсэн гээд

Полумна цүнхээ ухлаа.

Тэр Роны гарт том ногоон сонгино, хортой мөөг шиг цоохорлогдсон зүйл бариулаад эцэст нь цүнхнээсээ бохирдсон цаас гаргаж Харрид сунгав.

- ... надад үүнийг чамд дамжуулахыг гуйсан юм.

Харри агшин зуур хуйлаастай цаасан дээр Дамблдорын ээлжит урилга байхыг танилаа.

- Өнөө орой байна гэж цаасыг нээсэн даруйдаа Рон, Гермiona хоёрт хэлэв.

- Чи сүүлчийн тэмцээнийг сайхан тайлбарласан шүү! гэж Рон Полумнаг юмнуудаа буцааж авахад магтав. Полумна итгэлгүйхэн инээмсэглэв.

- Тоглож байна уу? Бүд намайг аймшигтай байсан гэж хэлсэн.

- Үгүй дээ, би үнэнээсээ хэлж байна! Би тийм таатай сэтгэгдэл төрүүлж байсан тайлбарлагчыг санахгүй юм байна! Ингэхэд энэ юу вэ? гээд гартаа барьсан сонгинотой адил зүйл руу харлаа.

- Энэ бол үндэс. Хүсвэл наадхаа авч болно. Надад ахиад хэдэн ширхэг байгаа. Ингээд тэр үндсийг аяархан инээсэн Ронд үлдээгээд явлаа.

- Полумна надад улам таалагдаж байна шүү гэж тэр Их танхим руу явахдаа хэлээд,

- Би түүнийг жаахан галзуу гэдгийг мэдэх ч сайн ...

Тэр гэнэтхэн чимээгүй боллоо. Гантиг шатны хөлд Лаванда Браун ширүүн төрхтэй зогсож байв.

- Сайн уу гэж Рон бухимдангуй мэндлэв.

- Явъя гэж Харри Гермionад шивнээд алхаагаа хурдасгасан ч Лавандагийн,

- Чи яагаад өнөөдөр гарна гэдгээ хэлээгүй юм бэ? Бас тэр яагаад чамтай явж байгаа юм? гэхийг сонслоо.

Рон хагас цагийн дараа өглөөний цайнд барайн ирээд Лавандагийн хамт суусан ч хоорондоо нэг ч үг солилцсонгүй. Гермiona юу ч болоогүй мэт биеэ авч явж байсан ч Харри царайд нь хоёр удаа ойлгомжгүй инээмсэглэл тодрохыг харжээ. Энэ өдрийн турш Гермiona өөдрөг сэтгэлтэй байж үдэш Гриффиндорын амралтын өрөөнд Харрийн ургамал судлалын зохион бичлэгийг харж өглөө. Тэр сүүлийн үед Рон түүнээс хуулдагыг мэддэг байсан учир үүнийг хийхээ больсон байсан билээ.

- Их баярлалаа, Гермiona гээд Харри нуруун дээр нь алгадаж цагаа харахад бараг найм болж байлаа.

- Сонсооч, би одоохон Дамблдор руу гүйхгүй бол хоцрох нь байна.

Тэр хариулсангүй зөвхөн ядарсан байртай өгүүлбэрээ үргэлжлүүлэн бичлээ. Харри инээмсэглээд хөргөн нүхээр яаран гарч захирлын өрөө лүү явлаа. Эргүүлгэн шатны урдахь луу шоколадтай эклерийг сонсоод үсрэн холдоход Харри шат руу гарч дээшээ яваад хаалга цохиход найман цагийн харанга дуугарлаа.

- Ороорой гэж Дамблдор хэлэв.



Харри хаалга түлхэхээр гараа сунгатал дотроос нь хэн нэг нь нээлээ. Хаалган дээр профессор Трелони зогсож байв.

- Аанхан! гэж тэр Харри руу жүжигчилсэн байртай заан хашгираад зузаан шилнийхээ цаанаас нүдээ анивчин харснаа,
- Энэ таны намайг өрөөнөөсөө бүдүүлгээр хөөн гаргасны шалтгаан уу! гэв.
- Сивилла хонгор минь гэж Дамблдор уурсангуй хэлээд,
- Ийм учраас би таныг бүдүүлгээр хөөн гаргаагүй зөвхөн надад Харритай яриагаа үргэлжлүүлэх шалтгаан байгаа юм ... гэв.
- Маш сайн байна гэж профессор Трелони гомдонгуй хэлээд,
- Хэрвээ та хууль бус морио эндээс хөөхийг хүсэхгүй байгаа бол ... би сургуулиас явж авъяасыг минь илүү үнэлэх газар олсон нь дээр байх ... гэлээ.

Тэр Харрийн дэргэдүүр өнгөрөөд эргүүлгэн шатаар алга болон замынхаа хагаст бүдрэх чимээ сонсогдоход Харри алчууран дээрээ гишгэсэн болохыг тааварлав.

- Хаалгаа хаагаад сууж үз, Харри гэж Дамблдор ядрангуй хэлэв.

Харри ердийнхөөрөө Дамблдорын ширээний өмнө суухад тэдний хооронд ахин гүн ухааны цүнхээл тавиастай байж дэргэд нь хоёр жижигхэн болор шил дүүрэн дурсамж хуйларч байлаа.

- Профессор Трелони урьдын адил Флоренц сургуульд багшилж байгаад таагүй хэвээр байгаа хэрэг үү? гэж Харри асуулаа.
- Таагүй байгаа. Мэргэ төлөг ийм их асуудал болохыг би урьдчилан мэдсэн болохоор хэзээ ч энэ хичээлийг судалж байсангүй. Би Флоренцыг хөөгдсөн байхад ой руугаа буцахыг гуйж чадахгүй, Сивилли Трелониг сургуулиас явахыг хүсч чадахгүй. Тэр бидний дунд байсаар байгаад шилтгээний гадна ямар аюул хүлээж байгааг мэдэхгүй байгаа. Түүнчлэн чи болон Волан-де-Мортод хамааралтай зөгнөл хэлсэн гэдгээ мэдэхгүй.

Дамблдор хүндээр санаа алдсанаа дараа нь,

- Гэхдээ миний багш нарын асуудал чамд ямар ч хамаагүй, Харри. Бид илүү чухал сэдвээр ярилцах ёстой. Гэхдээ үүний урьд чи миний өнгөрсөн хичээл дээр өгсөн даалгаварыг биелүүлсэн үү? гэв.
- Аа ... гээд Харри чимээгүй боллоо. Шилжих хичээл, квиддич, Роны хордолт, тархиа хагалсан, Драко Малфойн юу хийж байгааг мэдэх гээд энэ бүхэнд автаад Дамблдорын Слизнортоос гаргаж авахыг гуйсан дурсамжын тухай бараг мартсан байлаа.
- Би энэ тухай профессор Слизнортоос уусмалын хичээлийн дараа асуусан ч гэхдээ тэр ... э-э ... татгалзсан.

Нам гүм болов.

- Ойлгомжтой гээд Дамблдор Харриг нүдний шилэн дээгүүр ширтэхэд Харрид рентгэн гэрэлд харуулж байгаа аятай мэдрэмж төрлөө.

- Чи тэгээд арай өөрөөр хийх гэж үзсэн үү? Бүх нөөц бололцоогоо ашиглахаар? Энэ дурсамжыг авахад бүх арга залиа зориулж?

- Гэхдээ ... гээд Харри юу хэлэхээ мэдсэнгүй. Слизнортын дурсамжийг гарган авах гэсэн цорын ганц оролдого нь гэнэтхэн маш ичмээр өрөвдөлтэй санагдлаа.

- Роныг эндүүрээд хайрын ундаа уудаг өдөр би түүнийг профессор Слизнорт руу аваачсан юм. Тэгэхэд профессор Слизнортыг сайхан зантай дээр нь асуух гэж бодсон ч ...

- Тэгээд энэ бүтэв үү? гэж Дамблдор яриаг нь таслан асуулаа.

- Ер нь бол үгүй ноётоон учир нь Рон хордоод ...

- Энэ мэдээж чамайг дурсамж гарган авах ямар ч оролдлогыг мартахад хүргэнэ.

Чиний хамгийн сайн найз аюулд ороод байхад би өөр юу ч хүлээх билээ дээ. Гэвч би ноён Уизлиг эдгэмэгц чамайг даалгавраа биелүүлэхэд эргэн орно гэж найдаж байлаа. Би чамд энэ дурсамж хичнээн чухал болохыг тодорхой ойлгуулсан санагдаж байна. Үнэн хэрэгтээ чамд яагаад ахин сануулж байгаагийн учир нь тэр үлдсэн бүх дурсамжаас илүү чухал шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд түүнгүйгээр бид цагаа хоосон үрсэн хэрэг болох юм.

Харри ичсэндээ бүх бие нь халуу оргив. Дамблдор дуугаа өндөрсгөөгүй, уурлаагүй хэдий ч хашгирсан бол дээр байлаа. Хөгшин шидтэний хүйтэн урам хугарал Харрид юунаас ч илүү дор санагдав.

- Ноёнтоон би хичээгээгүй гэдэгтээ байгаа юм биш ... гэж цөхрөн дуугараад,

- Зүгээр л надад өөр ... өөр ... гэв.

- Өөр зүйл ухаанд чинь байж. Би ойлгож байна гэж Дамблдор өгүүлбэрийг дуусгалаа.

Өрөөнд ахин чимээгүй болж эвгүйцсэн нам гүм болоход Харри Дамблдорын дэргэд живэх шиг санагдав. Нам гүмийг зөвхөн Дамблдорын толгой дээр байгаа Арманда Диппегийн хөрөгнөөс аяархан хурхирах дуу эвдэнэ. Харрид энэ өрөөнд анх орж ирсэн мөчөөсөө хойш жижгэрсэн юм шиг хачирхалтай мэдрэмж төрлөө. Тэр цаашид чимээгүй байж тэвчихгүй болоод,

- Профессор Дамблдор надад үнэхээр харамсалтай байна ... Би илүү их хүч гаргах ёстой байж ... Хэрвээ таны хувьд чухал биш байсан бол надаас гуйхгүй байсан гэдгийг ойлгож байна гэв.

- Энэ тухай хэлсэнд чинь баярлалаа, Харри. Гэхдээ би цаашид даалгавар чиний тэргүүний зорилго болно гэж ойлгож болох уу? Өнөө үдшээс эхлээд бидний цаашдын уулзалт Слизнортын дурсамжгүй бол утгагүй болох юм.

- Би түүнээс авахын тулд хичээх болно, эрхэмээ гэж Харри амлав.

- Энэ тухай цаашид ярих хэрэггүй болсон бололтой харин түүхээ зогссон газраас нь үргэлжлүүлье. Чи хаана гэдгийг нь санаж байна уу? гэж Дамблдор эелдэгээр хэлэв.

- Тиймээ, эрхэмээ. Волан-де-Морт өөрийнхөө эцэг, эмээ, өвөөгөө алж нагац ах Морфиноо хийсэн юм шиг сэжиглэгдэхээр болгосон. Дараа нь Хогвартст буцаж ирээд профессор Слизнортоос крестражын тухай асуусан.

- Маш сайн байна. Одоо чамайг миний анхны хичээл дээр хэлсэн тааварлах хэрэг гарна гэсэн тухай мартаагүй байх гэж найдна.

- Тиймээ, эрхэмээ.

- Одоог хүртэл би чамд Волан-де-Мортын арван долоо хүртэлх насны амьдралыг илүү найдвартай эх сурвалжаас дүгнэлт хийснээ үзүүлж байсан билээ.

Харри толгой дохилоо.

- Харин одоо Харри минь илүү харанхуй бүрхэг болно. Хэрвээ залуу Реддлд хамаатай гэрчүүдийг ольё гэвэл энэ нь хүнд хэцүү байсан ч Волан-де-Морт нэртэй хүний хувьд дурсамж байх нь бараг боломжгүй юм. Өөрөөр хэлбэл дэлхий дээр түүний Хогвартсыг орхисны дараах амьдралыг мэдэх нэг ч амьд хүн байгаа гэдэгт эргэлзэж байна. Гэсэн ч надад сүүлчийн хоёр дурсамж байгаа бөгөөд үүнийгээ чамтай хувцаалцахыг хүсэж байна гээд Дамблдор гүн ухааны цүнхээлийн дэргэд гялалзаж байгаа болор шил рүү заалаа.

- Харин дараа нь би чиний бодлыг баяртайгаар сонсож миний гаргасан дүгнэлттэй хэр нийцэхийг сонирхох болно.

Дамблдор түүнийг бодлыг өндрөөр үнэлж байгаа явдал нь Харриг крестражын тухай дурсамж олоогүйдээ улам ичихэд хүргэхэд түүний эхний хуруу шилийг өргөж гэрэлд шинжихийг хараад гэмшингүйхэн суудал дээрээ займчив.

- Чамайг бусдын бодолд нэвтрэхдээ ядраагүй байх гэж найдна. Эдгээр дурсамжууд хоёулаа онцгой сонирхолтой юм. Эхнийх нь Похлеб гэдэг нэртэй маш хөгшин гэрийн үйлчлэгчийн тухай. Гэхдээ бид Похлебыг харахаас урьтаж би чамд лорд Волан-де-Морт Хогвартсыг төгсөөд юу хийсэн тухай ярья.

- Тэр долдугаар дамжаагаа шалгалт тус бүрийг нь өндөр үнэлгээтэй төгссөн юм. Түүний нэг ангийхан нь Хогвартсыг төгсөөд ямар ажил хийх вэ гэдэгт толгойгоо зовоож байлаа. Том Реддл сургуулийн ахлагч, тэргүүний сурагч түүнчлэн Сургуульдаа онцгой гавьяа байгуулсны төлөө цом хүртсэн болохоор бүгд түүнээс ямар нэг онцгой зүйл хүлээж байлаа. Би тэдгээр багшийн тоонд байсан профессор Слизнорт түүнийг ид шидийн яаманд ажилд оруулахын тулд уулзалт зохион байгуулан ашигтай хүмүүстэй танилцуулахыг санал болгосныг мэднэ. Гэвч Реддл бүгдээс нь татгалзжээ. Дараа нь түүний тухай багш нарын олж мэдсэн зүйл гэвэл Волан-де-Морт «Горбин ба Бэркс» мухлагт ажилд орсон явдал байлаа.

- «Горбин ба Бэркс» гэнээ? хэмээн Харри мэгдэн асуулаа.

- «Горбин ба Бэркс»-т гэж Дамблдор тайвнаар давтаад,

- Би чамайг Похлебын дурсамжнаас түүнийг энэ дэлгүүрт яагаад татагдсаныг ойлгох болно гэж бодож байна. Гэхдээ энэ нь Волан-де-Мортын сонгосон анхны ажил биш юм (энэ тухай бараг хэн ч мэдэхгүй ч би тэр үед сургуулийн захирлын итгэдэг цөөн хүний тоонд ордог байсан юм). Эхлээд Волан-де-Морт профессор Диппетэд хандан Хогвартсад багшилахаар үлдэж болохгүй юу гэж асуужээ.

- Тэр энд үлдэхийг хүсээ юу? Яах гэж? хэмээн Харри улам гайхан асуулаа.

- Хэдийгээр тэр профессор Диппетэд хэлээгүй ч би түүнд хэд хэдэн шалтгаан байсан гэж бодож байна. Нэгдүгээрт хамгийн гол шалтгаан гэвэл Волан-де-Морт сургуультайгаа ямар ч хүнээс илүү холбоотой байсан. Хогвартсад түүний хамгийн аз жаргалтай жилүүд өнгөрч гэр нь болдог цорын ганц газар нь байлаа.

Харри энэ тухай дуулаад бага зэрэг эвгүйцэв. Түүнд ч гэсэн Хогвартсын тухайд ийм мэдрэмж төрдөг билээ.

- Хоёрдугаарт гэвэл манай шилтгээн эртний шидийн түшиг тулгуур юм. Волан-де-Морт түүний олон нууцын ихэнхийг тайлсан. Гэхдээ тэр шилтгээнд тайлагдаагүй нууцууд бас үлдсэн гэдгийг ойлгож байсан.

- Гуравдугаарт тэр багш болсноороо хүчирхэг эрх мэдэлтэй болж залуу шидтэнгүүдэд нөлөөлж чадах байсан. Магадгүй энэ санааг түүнд профессор Слизнорт төрүүлсэн байх. Түүнтэй сайн харилцаатай байснаар багш ямар эрх мэдэл ашиглаж болдогийг үзүүлжээ. Би Волан-де-Мортыг Хогвартсад өнгөрүүлсэн сүүлчийн өдрүүддээ хувийн армия бүрдүүлэн хүн элсүүлэх боломж олж харсан гэж бодож байна.

- Гэхдээ тэр энэ ажилд ороогүй биз дээ, эрхэмээ?

- Үгүй, ороогүй. Профессор Диппет түүнд арван найман нас гэдэг бол багшийн хувьд хэтэрхий залуу бөгөөд хэдэн жилийн дараа багшлах хүсэл нь хэвээр байвал ахин хүсэлт гаргаж болно гэж хэлсэн.

- Харин та үүнд яаж хандсан бэ, эрхэмээ? гэж Харри тээнэгэлзэн асуулаа.

- Маш их сэтгэл түгшсэн. Би Армандод түүнийг багшаар авахгүй байхыг зөвлөсөн юм. Хэдийгээр надад чамд хэлж байгаа шиг баталгаа байгаагүй ч профессор Диппет Волан-де-Мортыг маш их хайрлаж үнэнч шударга явдалд нь эргэлздэггүй байсан. Би зүгээр л лорд Волан-де-Мортыг сургуульд эргэж ирээд эрх мэдэлд хүрэх суудал өгөхийг хүсээгүй.

- Харин тэр ямар ажил хүсч байсан юм, эрхэмээ? Ямар хичээлд багшлахыг? Дамблдор хэлэхээс өмнө Харрид хариулт яагаад ч юм тодорхой байлаа.

- Хар урлагаас хамгаалах хичээл. Тэр үед энэ хичээлийг Хогвартсад бараг тавин жил ажилласан хөгшин хатагтай профессор Галатея Вилкост зааж байлаа. Ингээд Волан-де-Морт «Горбин ба Бэркс» мухлагт ороход бүх багш нар нэгэн дуугаар тийм дэлгүүрт ажиллах нь гялалзсан залуу шидтэнд тохирох газар биш гэцгээж байлаа. Гэвч Волан-де-Морт жирийн нэг худалдагч байсангүй. Эелдэг үзэсгэлэнтэй ухаантай тэрбээр төдхөн ажлаа гартаа авсан юм. Энэ

дэлгүүр ер бусын хүч агуулсан зүйлийг зардаг газар болохыг чи мэднэ. Волан-де-Мортыг илгээн хүмүүсийг ятгаж үнэт эдлэлийг нь худалдаж авахдаа хямдруулдаг байсан бөгөөд тэрбээр энэ ажлыг ер бусын авъяаслаг хийж байлаа.

- Эргэлзэх юм алга гэж Харри тэссэнгүй хэллээ.
- Яг тийм гэж Дамблдор сулхан инээмсэглээд,
- Харин одоо гэрийн үйлчлэгч Похлебийн зүтгэж байсан маш хөгшин баян шидтэн болох Хэпзиб Смитийн үгийг сонсох цаг болж гэв.

Дамблдор шидэт саваагаа даллахад шилний бөглөө мулт үсрэн хуйларсан дурсамж гүн ухааны цүнхээл рүү орохтой зэрэгцэн,

- Эхлээд чи, Харри гэв.

Харри босож чулуун суулга руу тонгойн долгиолж буй мөнгөлөг шингэнд нүүрээ хүргэлээ. Тэр харанхуй хоосонд унаснаа ямар нэг зочны өрөөнд газардахад урд нь сууж байсан ер бусын бүдүүн хөгшин хатагтай гоёмсог шаргал хиймэл үс тавиад гялалзсан ягаан цэцэгтэй даашинз өмссөн нь хайлж буй зайрмагтай бялуу шиг харагдав. Хатагтай жижигхэн үнэт чулуун шигтгээтэй толинд харж том ягаан улайсан хацартаа энгэсэг түрхэхэд Харрийн урьд харж байснаас хамгийн жижигхэн үйлчлэгч махлаг хөлд нь атлаасан шаахай өмсүүлж байв.

- Яараарай, Похлеб! гэж Хэпзиб захирангуй хэлээд,
- Тэр дөрвөн цагаас ирнэ гэсэн байтал ердөө хэдхэн минут үлдээд байна. Бас тэр хэзээ ч хоцорч байгаагүй! гэлээ.

Похлеб босоход хатагтай энгэсгээ цааш тавилаа. Үйлчлэгчийн толгойны орой Хэпзибийн сууж байгаа сандалд арай хүрэхээргүй намхан ажээ.

- Би ямар харагдаж байна? гэж Хэпзиб сониучирхаад царайгаа толинд янз бүрийн өнцгөөс харлаа.
- Дур булаам, хатагтай гэж Похлеб часхийв.

Харри Похлебийн харцнаас худал хэлсэн болохыг таамаглав. Учир Хэпзиб Смит түүний бодлоор огтхон ч дур булаам харагдахгүй байлаа.

Хаалганы хонх дуугарахад үйлчлэгч, эзэгтэй хоёул цочлоо.

- Түргэлээрэй түргэлээрэй, Похлеб тэр байна! гэж Хэпзиб хашгирлаа.

Үйлчлэгч овоолсон юмны дундуур гүйн өрөөнөөс гарахад зочин битүү чихсэн зүйл дундуур яаж орж ирэх нь ойлгомжгүй байв. Энд жижигхэн чийдсэн хайрцаг дүүрэн хийсэн шүүгээ, алтан хавтастай ном ярайтал өрсөн том шүүгээ болон тавиур дээгүүр дэлхийн бөмбөрцөг тавилж эргэн тойронд хүрэл саванд тарьсан олон тооны цэцэг ургамлууд байлаа. Нэг үгээр хэлбэл зочны өрөө эртний шидэт дэлгүүрийг санагдуулна.

Хормын дараа үйлчлэгч өндөр залуу хүн дагуулан орж ирэхэд Харри төвөггүйхэн Волан-де-Мортыг танив. Тэр энгийн хар костюм өмсөж үс нь сургуульд байхаасаа

илүү урт ургасан ч өмнөхөөсөө илүү сайхан харагдаж байлаа. Түүний битүү чихсэн эд зүйлсийн дундуур хялбархан орж ирэхийг нь үзвэл нэг бус удаа энд ирж байсан бололтой. Тэрбээр тонгойн Хэпзибын булцгар гарт уруулаа хүргэв.

- Би таньд цэцэг авчирсан гэж аяархан хэлээд хаа нэгтээгээс баглаа сарнай гаргалаа.

- Дүрсгүй хүү, тэгэх хэрэггүй байсан юм! гэж хөгшин Хэпзиб дуу алдсан ч Харри ойролцоох ширээн дээр хоосон ваар байхыг ажиглав.

- Та хөгшин хатагтайг уярааж байна шүү, Том ... Суугтун ... Ингэхэд Похлеб хааччихав? Аан ...

Үйлчлэгч зочны өрөөнд эргэн яаран орж ирэхдээ жижигхэн бялуутай тавиур авчран эзэгтэйнхнээ тохойны дэргэд тавилаа.

- Идээрэй, Том. Би таньд миний бялуу таалагддаг болохыг мэднэ. Та чинь яачихаа вэ? Цонхийчихоо юу даа. Таныг дэлгүүр чинь хэтэрхий их ажиллуулж байна гэж би бараг зуун удаа хэлсэн дээ ...

Волан-де-Морт инээмсэглэхэд Хэпзиб хариу инээмсэглээд,

- Тэгэхээр та ямар хэргийн учир зочилж ирэв дээ? гэж сормуусаа дэвэн асуув.

- Ноён Бэркс таньд албинуудын хийцийн дуулганы талаар ашигтай санал тавьж байгаа юм. Тэр үүнд таван зуун галлеон төлөх нь шударга хэрэг гэж бодож байгаа ...

- Үгүй үгүй, тийм хурдан биш шүү би таныг зөвхөн ийм зүйлийн төлөө ирсэн гэж бодохгүй байна! хэмээн Хэпзиб уруулаа цорвойлгов.

- Намайг түүний төлөө ийшээ ирэхийг тушаасан. Би ердөө хөөрхийлөлтэй туслагч болохоор юу хэлснийг нь хийх ёстой юм. Ноён Бэркс намайг асуухыг хүссэн л дээ ... гэж Волан-де-Морт аяархан хэлэв.

- Өө, ноён Бэркс бодож үзээ юу! гээд Хэпзиб жижигхэн гараа савчин,

- Би таньд ноён Бэрксийн хэзээ ч хараагүй зүйлийг үзүүлэх гэсэн юм! Та нууц хадгалж чадах уу, Том? Энэ тухай ноён Бэркст ярихгүй гэж амал. Хэрвээ тэр намайг таньд үзүүлсэн гэдгийг мэдэх юм бол амар заяа үзүүлэхгүй. Харин би түүнийг ноён Бэркст байтугай өөр хэнд ч худалдахгүй! Гэхдээ Том таны авъяас эдгээр зүйлсийн түүхийг нь мэдэх болохоор хэдэн галлеон хүрэхийг нь

... гэв.

- Би хатагтай Хэпзибын үзүүлэхийг хүссэн бүх зүйлийг харахдаа баяртай байх болно гэж Волан-де-Морт аяархан хэлэхэд Хэпзиб охин шиг хөхөрлөө.

- Одоохон Похлебийг ийш нь авчир гэж хэлье ... Похлеб, чи хаачив аа? Би ноён Реддлд үнэт эдлэлийг үзүүлэхийг хүсэж байна ... Хоёуланг нь аваад ирээрэй ...

- Болгооно уу, хатагтай гэж үйлчлэгч хэлэхэд Харри хоёр давхар ширэн хайрцаг өрөөн дундуур өөрөө явж буй мэт харагдсан ч сандлын хөлнөөс өндөргүй жижигхэн Похлеб толгой дээрээ өргөөд явж байгааг нь мэдэж байлаа.

- Одоо гэж Хэпзиб баяртай хэлээд үйлчлэгчээс хайрцагийг авч өвдгөн дээрээ тавиад дээд талынхыг нь онгойлгохоор зэхэв.

- Энэ таньд таалагдана гэж бодож байна, Том ... Өө, хэрвээ манай гэрийнхэн таньд үзүүлэхийг мэдсэн бол! Тэд зөвхөн үүнийг гартаа оруулах гэсэн ганц л зүйлийг боддог юм!

Хэпзиб хайрцагны тагыг нээлээ. Харри дотор нь юу байгааг харахаар урагш алхаад маш уран хийц бүхий хоёр бариултай жижигхэн алтан аяга байхыг харлаа.

- Та үүнийг юу гэдгийг мэдэх үү, Том? Аваад сайн хардаа! гэж Хэпзиб шивнэлээ.

Волан-де-Морт урт нарийхан хуруутай гараа сунгаад аяганы нэг бариулаас барьж торгон боолтноос нь авлаа. Харрид Волан-де-Мортын хар нүдэнд улаан оч гялсхийх шиг санагджээ. Залуугийн шунахай царай үзэсгэлэнтэй зочноосоо нүд салгалгүй ширтэж байсан Хэпзибийн биед хачирхалтай тусан харагдав.

- Дорго гэж Волан-де-Морт бувтнаад аяганы сийлбэрийг харж,

- Тэгэхээр энэ ...? гэв.

- Пенелопа Пуффендуйгийнх, та ухаантай хүү болохоор маш сайн мэдэж байна! гээд Хэпзиб хацрынх нь хонхорхойг чимхэхээр бөхийхөд бэлхүүсэвч нь чанга чажарлаа.

- Би таньд энэ тухай хэлээгүй билүү? Энэ зүйл манай гэр бүлд олон жилийн өмнөөс гараас гар дамжин хадгалагдсаар ирсэн юм. Сайхан байгаа биз тийм үү? Түүнд янз бүрийн хүч агуулагдаж байдаг гэсэн ч би үүнийг шалгаагүй ердөө өөртөө тайван чимээгүй хадгалж байдаг юм ...

Тэр аягыг Волан-де-Мортын урт хуруунаас буцаан авч хайрцаганд болгоомжтой хийлээ. Хатагтай хэтэрхий завгүй байсан болохоор аягыг авах үед залуу хүний царайд сүүдэр тусахыг анзаарсангүй.

- Тэгэхээр Похлеб хааччихав? Аан чи энд байна уу! Үүнийг авч бай гэж Хэпзиб баяртай хэлэв.

Үйлчлэгч дуулгавартай хайрцагтай аягыг авахад Хэпзиб өвдгөн дээрээ байсан өөр хайрцаг луу анхаарал хандуулав.

- Энэ зүйл таньд илүү таалагдана гэж бодож байна, Том. Сайн харахын тулд жаахан бөхий дөө ... Хэрвээ Бэркс миний түүнээс худалдаж авсан зүйл байгааг мэдсэн бол ахин энэ зүйлийг авахдаа баяртай байсан даа ...

Хатагтай угалзтай горхийг онгойлгон хайрцагны тагыг нээв. Дотор нь хүрэн улаан хамба хилэн дээр хүнд алтан зүүлт байлаа.

Энэ удаад Волан-де-Морт хайрцаг руу гараа урилгагүй сунган зүүлтийг аваад гэрэлд өргөн харлаа.

- Слизериний тэмдэг гэж аяархан хэлэхэд «С» үсэг ороосон могой гэрэл ойлгон гялалзав.

- Зүйтэй! гэж Хэпзиб баяртай дуу алдахад Волан-де-Морт зүүлтийг бахдан харлаа.

- Би түүнийг алдсанаас гар хөлөө өгсөн нь дээр ийм зүйл миний цуглуулганд л хадгалагдаж байх ёстой. Бэркс энэ зүүлтийг харваас хулгайлсан бололтой үнэ цэнийг нь мэдэхгүй ноорхой эмэгтэйгээс худалдаж авсныг мэдэх юм байна.

Энэ удаад эндүүрэхийн аргагүй болов. Хэпзибийн эдгээр үгийн дараа Волан-де-Мортын нүдэнд улаан оч гялсхийж зүүлтний гинжийг барьсан хурууны үе нь цайрлаа.

- Бэркс түүнд өчүүхэн мөнгө төлөөд надад худалдсан юм ... Сайхан эд байгаа биз, тийм үү? Ямар нэг шидийн хүч агуулаагүй хэдий ч би түүнийг зүгээр л тайван чимээгүй хадгалж байдаг юм ...

Хөгшин хатагтай зүүлт рүү гар сунгав. Агшин зуур Харрид Волан-де-Морт зүүлтийг өгөхийг хүсэхгүй байх шиг санагдсан ч хамба хилэн зөөлөвчин дээр нь буцааж тавилаа.

- За, тэгэхээр Том таньд таалагдсан гэж найдаж болох уу!

Тэр зочныхоо царай луу харахад Харри анх удаа тэнэг инээмсэглэл нь бөхөхийг харлаа.

- Таны бие зүгээр үү, хонгор минь?

- Өө, тэгэлгүй яахав. Тиймээ, миний бие маш сайн байна гэж Волан-де-Морт чимээгүй хэлэв.

- Харин надад санагдахдаа ... гэрэл гялбаад ... гэж Хэпзиб түгшин хэлэхэд Харри түүний Волан-де-Мортын нүдэн дэх улаан туяаг олж харсныг ойлгов.

- Похлеб тэднийг буцааж хийгээд түгж ... ердийн шившлэгээр ...

- Явах цаг боллоо, Харри гэж Дамблдор жижигхэн үйлчлэгч хайрцагыг авч зочны өрөөнөөс гарахад аяархан хэлээд хоёул дээшээ нисэж өрөөнд эргэн ирлээ.

- Хэпзиб Смит хоёр өдрийн дараа багахан үйл явдлын улмаас үхсэн гээд Дамблдор Харриг сандалд суухыг зангаж,

- Ид шидийн яамнаас гэрийн үйлчлэгч Похлебийг эзэгтэйдээ санамсаргүй хордуулсан како өгсөн гэж буруутгасан юм гэв.

- Үгүй ер! гэж Харри ууртай дуу алдав.

- Би чиний ухаанд юу байгааг ойлгож байна. Гарцаагүй энэ үхэл Реддлийнхний үхэлтэй олон талаараа төстэй. Хоёр тохиолдолд бурууг нь хэн нэгэн үүрч, хэн нэгэн үхлийн шалтгаан болох ой санамжыг арчин ...



- Похлеб хэргээ хүлээсэн үү?
- Тэр какао эзэгтэйдээ өгөх гэж байгаад чихэр биш үхлийн аюултай хор хийснээ санаж байгаа. Тэр үүнийг санаатайгаар биш хөгширч будилсны улмаас хийсэн хэрэг гэж боджээ.
- Волан-де-Морт түүний ой санамжыг яг Морфиных шиг өөрчилсөн хэрэг үү!
- Би ч гэсэн тэгж бодож байна. Тэгээд ч Морфины тохиолдлын адил яамнаас Похлебыг буруутгахад бэлэн байсан ...
- ... учир нь тэр гэрийн үйлчлэгч болохоор тэр үү гээд Харри Гермионагийн үйлчлэгч хамгаалах нийгэмлэгийг өрөвдөх сэтгэл төрөв.
- Яг тийм. Тэр хөгшин эзэгтэйнхээ уух юманд будилснаа хүлээсэн болохоор ид шидийн яамнаас хэн ч цааш нь шалгаж төвөг удсангүй. Яг л Морфины тохиолдлын адил би түүнээс цагийг нь олж ой санамжыг гарган авсан. Түүнд амьдрахад багахан хугацаа үлдээд байсан юм. Гэвч Волан-де-Морт аяга, зүүлтийг мэдэж байсан дурсамж юу ч баталж чадахгүй юм.
- Похлебыг шийтгэгдэх үед Хэпзибийн гэр бүл хоёр үнэт эрдэнэсээ алдсаныг илрүүлжээ. Бүрэн итгэх хүртлээ төрөл төрөгсөд нь Хэпзибийн үнэт эдлэлийн нууцыг тайлахад багагүй хугацаа зарцуулсан бөгөөд тэр цуглуулгаа атаархлаас сэргийлэн маш сайн хамгаалдаг байсан. Гэвч тэднийг аяга, зүүлт алга болсонд итгэлтэй болох хүртэл «Горбин ба Бэркс» мухлагын худалдагч залуу ажлаа орхин алга болжээ. Түүнийг хаачсаныг дэлгүүрийн эзэд мэдсэнгүй ч алга бололт нь бусдаас илүү гайхуулсангүй. Ингээд бараг хэн ч Том Реддлийн талаар удаан хугацааны турш харж сонсоогүй байна.
- Харин одоо Харри минь хэрвээ чи эсэргүүцэхгүй бол анхаарлыг чинь хэсэг зуур өөр түүхэнд хандуулах гэсэн юм. Волан-де-Морт ахин нэг аллага хийсэн. Хамгийн түрүүнд Реддлийнхнийг алсан эсэхийг мэдэхгүй ч тийм гэж бодож байна. Энэ удаад тэр өшөө хонзонгоос болж биш олзны төлөө алахыг харлаа. Тэр золгүй тэнэг хатагтайн үзүүлсэн үнэт хоёр зүйлийг эзэмшихийг хүсчээ. Ингээд яг л өнчин хүүхдийн асрах газар байхдаа нагац ах Морфины бөгжийг хулгайлаад нуугдсан шигээ Хэпзибийн аяга зүүлтийг авсан байна.
- Гэхдээ энэ чинь ухаангүй хэрэг байна шүү дээ. Эрсдэлд орон ажлаа хаян байж ... гэж Харри хөмсөг зангидан хэлэв.
- Чамд тийм байж болох ч Волан-де-Мортын хувьд ухаангүй хэрэг байгаагүй юм. Чи цаг нь ирэхээр эдгээр зүйлс түүний хувьд ямар утгатай болохыг ойлгоно гэж найдаж байгаа ч зүүлт түүнд залгамжлагдах нь хууль ёсны хэрэг бодсоныг төсөөлөхөд тийм ч хэцүү биш юм.
- Зүүлт мэдээж тийм байх. Гэхдээ аяга авах ямар хэрэгтэй байсан гэж?
- Аяга Хогвартсын үндэслэгчдийн нэгнээс залгамжлагдаж ирсэн. Волан-де-Морт сургуульд орох гэж зүтгэж байсан учир Хогвартсын түүхтэй холбоотой

зүйлийн дэргэдүүр өнгөрч чадахгүй байх гэж бодож байна. Үнэндээ өөр шалтгаан байсан ... Удахгүй чамд түүнийг үзүүлэх байх гэж найдъя.

- Харин одоо хамгийн сүүлчийн (ямар ч гэсэн чамайг профессор Слизнортын дурсамжыг авах хүртэл) дурсамжыг чамд үзүүлэх чухал шаардлагатай гэж бодож байна. Похлебын дурсамж арван жилээр таслагдсан бөгөөд бид эдгээр жилүүдэд лорд Волан-де-Морт юу хийж байсныг тааварлах төдий юм ...

Харри ахин суудлаасаа босоход Дамблдор гүн ухааны цүнхээл рүү сүүлчийн дурсамжыг хоослов.

- Энэ хэний дурсамж вэ? гэж Харри асуув.

- Миний.

Харри мөнгөлөг шингэнд умбаад саяхан орхисон өрөөндөө газардав. Энд Фоукс хонуур дээрээ зүүрмэглэж, ширээний ард сууж байсан Дамблдор дэргэд нь зогсож байгаатай маш төстэй байсан ч хоёр гар нь бүтэн гэмтээгүй агаад царай нь арай үрчлээ багатай байлаа. Зөвхөн ганц л зүйл ялгаатай байсан нь цонхны гаднах харанхуйд цас цэнхэртэн харагдана.

Залуу Дамблдор хэн нэгнийг хүлээж байгаа бололтой. Тэгтэл хэдэн хормын дараа хаалга цохиход «Ороорой» гэлээ.

Харри дуу алдав. Өрөөнд Волан-де-Морт орж ирлээ. Түүний царай ширүүн болж нүдний цагаан нь цусаар дүүрсэн ч хүүхэн хараа нь зураас (Харрийн мэдэх шиг) болон хувираагүй байлаа. Волан-де-Морт урт жанч өмссөн агаад мөрөн дээрээ гялалзаж байгаа цас шиг цонхигор царайтай аж.

Ширээний ард сууж байсан Дамблдор өчүүхэн ч гайхсаны шинж тэмдэг үзүүлсэнгүйг бодвол харваас айлчлал урдаас товлогдсон бололтой.

- Оройн мэнд, Том. Суухыг хүсэхгүйсэн болов уу? гэж Дамблдор амирлангуй хэлэв.

- Баярлалаа гээд Волан-де-Морт Дамблдорын заасан сандалд сууж,

- Би таныг сургуулийн захирал болсон гэж сонслоо. Зүй ёсны сонголт байна гэж урьдынхаас арай илүү өндөр хүйтэн хоолойгоор хэллээ.

- Чамайг дэмжиж байгаад баяртай байна. Дарс уухыг санал болгож болох уу? гэж Дамблдор инээмсэглэн хэлэв.

- Тэгвэл талархах байна. Би багагүй зам тууллаа.

Дамблдор босож гүн ухааны цүнхээл хадгалж байсан одоо дүүрэн лонхтой шилэн нүүртэй шүүгээ рүү очлоо. Тэрбээр Волан-де-Мортод цомтой дарс өгөөд өөртөө дүүргэж бичгийн ширээний ар дахь сандалд суулаа.

- За, Том ... таньд юугаар туслах вэ?

Волан-де-Морт шууд хариу хэлсэнгүй дарсаа балгав.

- Хэн ч намайг Том гэж дуудаггүй. Одоо би өөр нэрээр алдартай ...

- Би чиний алдартай нэрийг мэднэ гэж Дамблдор таатай инээмсэглэн хэлээд,
- Гэхдээ чи миний хувьд үргэлж Том Реддл хэвээр үлдэх болно гэж айж байна.

Хөгшин багшийн таагүй онцлог бол залуусыг хэзээ ч хаанаас эхэлснийг нь мартдаггүй явдал юм гэв.

Ингээд тэр аягатайгаа хундаганы үг хэлэх мэт өргөхөд Волан-де-Мортын царай ойлгогдохын аргагүй боллоо. Өрөөний уур амьсгал яльгүй өөрчлөгдөв. Дамблдор Волан-де-Мортын сонгосон нэрээ ашиглахаас татгалзсанаараа түүнийг албадах эрхийг өгөөгүй гэдгийг Харри ойлголоо.

- Би таныг удтал энд ажиллаж байгаа явдалд гайхаж байна. Би үргэлж тань шиг ийм шидтэн сургуулийг яагаад нэг ч удаа орхихыг хүсдэггүй юм бол гэж боддог байсан хэмээн Волан-де-Морт хэсэг дуугүй байсныхаа дараа хэлэв.

- Юу гэвэл над шиг ийм шидтэнд залуу оюун ухааныг хурцлан эртний эрдэм мэдлэгийг түгээх шиг чухал зүйл байдаггүй юм. Хэрвээ миний ой санамж өөрчлөгдөөгүй бол та ч гэсэн багшилахад татагдаж байсан байхаа гэж Дамблдор өмнөхийн адил инээмсэглэн хэлэв.

- Би зүгээр л ид шидийн яамнаас таньд сайдын суудлыг хоёр удаа санал болгоход татгалзсан явдлыг гайхаж байна ...

- Тийм саналын тухайд бол сүүлийнхтэйгээ гурван удаа. Гэвч сайдын ажилд би хэзээ ч татагдаж байгаагүй. Үүнийг бидний бас нэг төсөөтэй зүйл гэж бодож байна.

Волан-де-Морт инээмсэглэсэнгүй толгой бөхийлгөөд дарсаа шимлээ. Дамблдор өрөөний нам гүмийг эвдсэнгүй Волан-де-Мортын түрүүлж ярихыг хүлээлээ.

- Би эргээд ирлээ. Профессор Диппетийн хүлээж байснаас арай хожуу ... тэр намайг хүсэлт гаргахад хэтэрхий залуу байна гэсэн л дээ. Миний энд ирсний учир гэвэл таны зөвшөөрлийг авч шилтгээнд багшаар эргэн ирэх гэсэн юм. Та намайг энэ газраас явахын урьд олон зүйл хийснийг мэдэж байгаа. Би таны сурагчдад нэг ч шидтэний өгч байгаагүй зүйлийг үзүүлэх болно гэдгээ хэлэх байна.

Дамблдор хариулахаасаа өмнө Волан-де-Морт руу цомон дээгүүрээ ширтлээ.

- Тиймээ, би чамайг эндээс явахаас өмнө олон зүйл хийснийг мэднэ. Таны амжилтын тухай цуу яриа хуучин сургуульд чинь хүрсэн, Том. Хэрвээ тэдний хагас нь үнэн байсан бол би их гунигтай байхсан.

Волан-де-Мортын царай тоомсоргүй хэвээр үлдлээ.

- Алдар хүнд атаархлыг төрүүлдэг, атаархал өшөө хорслыг төрүүлдэг, өшөө хорсол худал хуурмагт хүрдэг. Та энэ тухай мэднэ биз дээ, Дамблдор.

- Та хийж байгаа зүйлээ алдар хүнд гэсэн үү? гэж Дамблдор аяархан асуулаа.

- Тэгэлгүй яахав гээд Волан-де-Мортын нүдэнд улаан оч дүрсхийж,

- Би туршилт хийж ... тэдний хэзээ ч хүрэхгүй шидийн хил хязгаарыг давж ... гэв.

- Зарим төрлийн шид гэж Дамблдор засаад,
- Зарим. Харин бусдынх нь хувьд үлдээж байгаа нь ... намайг уучлаарай ... харамсалтай бүдүүлэг хэрэг юм гэв.

Волан-де-Морт анх удаагаа инээмсэглэлээ. Энэ бол хүйтэн хорон инээмсэглэл байсан бөгөөд догшин харцанд нь заналхийлэл илрэв.

- Энэ ч эртний маргаан л даа. Гэхдээ ертөнцөд таны хайр янз бүрийн шидээс хүчтэй гэдэг алдартай тунхаглалыг дэмжиж байгаа нэг ч хүнийг би харахгүй байна, Дамблдор.

- Магадгүй та түүний баталгааг буруу газраа эрсэн байх боломжтой.

- Тийм тохиолдолд Хогвартсаас илүү газар хайж болно гэж үү? Та намайг эргэж ирэхийг зөвшөөрөх үү? Сурагчиддаа мэдлэгээ хуваалцахыг зөвшөөрөх үү? Би өөрийгөө болон бүх авъяасаа таны мэдэлд өгье. Таны зарц больё.

Дамблдор хөмсгөө өргөв.

- Хэн таны хэдийн зарц болон хувирсан бэ? Цуу ярианд итгэх юм бол ... тэд өөрсдийгөө Үхэл залгигчид гэж дууддаг байх аа?

Харри Волан-де-Морт Дамблдор энэ нэрийг мэднэ гэж хүлээгээгүй болохыг тод олж харлаа. Түүний нүдэнд ахин улаан оч гялсхийснээ хамраа сарталзуулав.

- Миний найзууд намайг эзгүйд тэгж байгаа байх гэдэгт итгэлтэй байна гэж агшины дараа хэлэв.

- Тэднийг найзууд гэж нэрлэдгийг чинь сонсоход баяртай байна. Надад тэд аялдан дагалдагч гэж сэтгэгдэл төрсөн юмсан.

- Та алдаж байна гэж Волан-де-Морт итгүүлэв.

- Хэрвээ би өнөө шөнө «Гахайн толгой» руу явж шагайвал бүлэг хүмүүс болох Нотт, Розье, Мальсибер, Долохов нар таныг эргэн ирэхийг хүлээж байгааг харж болох юм. Үнэндээ үнэнч найзууд чинь таныг багшийн суудалд хүрэх оролдлогод амжилт хүсэхээр ийм цастай шөнө урт зам сонгон авчээ!

Дамблдорын аялалын тухай мэдэж байгаа явдал Волан-де-Мортод бүхнээс илүү бага таалагдсан ч агшин зуур биеэ барилаа.

- Та үргэлж бүхнийг мэдэх юм, Дамблдор.

- Үгүй дээ, би ердөө эндхийн баарны эзэнтэй найз юм гэж Дамблдор яаран хариулаад хоосон аягаа ширээн дээр тавьж сандалдаа цэхлэн суулаа.

- Харин одоо, Том минь шударгаар ярилцъя. Та яагаад ийшээ ажил гуйхаар дагалдагч нартайгаа хамт ирсэн юм бэ? Бид хоёулаа таныг үүнийг хүсэхгүй байгаа гэдгийг мэдэж байгаа.

Волан-де-Морт хүйтнээр гайхширлаа.

- Хүсэхгүй байгаа гэнээ? Эсрэгээрээ би түүнийг маш их хүсэж байна, Дамблдор.

- Үгүй дээ, та Хогвартст эргэн ирж багшилахыг арван найман настайгаасаа илүү хүсээгүй. Ингэснээрээ та юунд хүрэх юм, Том? Та яагаад энэ тухай гуйсан юм бэ?

Волан-де-Морт жигшүүртэй инээвхийлэв.

- Хэрвээ та надад энэ ажлыг өгөхийг хүсэхгүй байгаа бол ...

- Мэдээж хүсэхгүй байна. Тэгээд ч таныг надаас ийм зүйл хүлээсэн гэж бодохгүй байна. Таньд ийшээ ирж гуйх ямар нэг зорилго байсан байх.

Волан-де-Морт бослоо. Тэр одоо Том Реддлтэй бүр төсгүй болж царайд нь уур хилэн хуралдав.

- Энэ таны сүүлчийн үг үү?

- Сүүлчийн гэж Дамблдор хариулаад мөн адил босов.

- Ийм нөхцөлд бидэнд олон зүйл ярих хэрэг алга.

- Ямар ч гэж Дамблдор зөвшөөрөөд царайд нь гашуудсан шинж тодорч,

- Би таныг гэмт хэргийг чинь шийтгэн айлгахын тулд шүүгээ шатааж байснаас хойш урт хугацаа өнгөрч, Том. Гэхдээ би тийм боломж олгохыг хүссэн, Том

... хүссэн ... гэв.

Агшин зуур Харри утгагүй анхааруулан хашгирах шахлаа. Тэр Волан-де-Мортын гар халаас руугаа шидэт саваа авахаар шургалсан гэдэгт итгэлтэй байв. Гэвч агшины дараа эргээд хаалга хаан алга болов

Харри Дамблдор ахин тохойноос нь барихыг мэдрээд хормын дараа хоёул бараг л адилхан газар зогсоход зөвхөн цонхны гадаа цас байсангүй бөгөөд Дамблдорын гар ахин хар болсон байлаа.

- Яагаад? Яагаад тэр эргэн ирсэн юм бэ? Та үүнийг тайлбарлаж чадах уу? гэж

Харри асуугаад Дамблдорыг ширтэв.

- Надад энэ талаар хэдэн санаа байгаа.

- Ямар санаа, эрхэмээ?

- Энэ тухай чамайг профессор Слизнортын дурсамжыг олж ирсэн хойно хэлье, Харри. Чамайг тэр дүр зургийн сүүлчийн хэсгийг авчирсан хойно тодорхой болно гэж найдаж байна ... хоёуланд маань.

Харри сониучирхсан хүсэлдээ шатсаар Дамблдор хаалга руу очоод онгойлгосон ч хөдөлсөнгүй.

- Тэр хар урлагаас хамгаалах хичээлд багшлахыг хүсч байсан гэж үү, ноёнтоон? Тэр тэгж хэлээгүй ...

- Мэдээж хамгаалах хичээлд багшлахыг хүсч байсан. Үүний баталгаа нь гэвэл бидний богинохон уулзалтаас үүссэн үр дагавар юм. Намайг лорд Волан-де-Мортод энэ суудлыг татгалзсанаас хойш одоог хүртэл хар урлагаас хамгаалах хичээлийн нэг ч багш жилээс илүү тэсэхгүй байгааг харж байгаа биз дээ.

## БҮЛЭГ 21: ТАЙЛАГДАШГҮЙ ӨРӨӨ

Дараагийн долоо хоногийн турш Харри Слизнортыг яаж ятган үнэн дурсамжыг нь гарган авах вэ гэдэг зүйлд тархиа зовоосон ч нэг ч гялалзсан санаа төрсөнгүйд сүүлийн үед дасал болсоноороо уусмалын хичээлийн сурах бичиг эргүүлэн хунтайж ямар нэг ашигтай зүйл бичиж үү гэж найдав.

- Чи тэндээс юу ч олохгүй гэж Гермiona түүнд бямба гаригийн үдэш хатуу хэллээ.

- Ахиад эхлэх хэрэггүй шүү, Гермiona. Хэрвээ хунтайж байгаагүй бол Рон бидний дэргэд сууж байхгүй байсан.

- Хэрвээ чи нэдүгээр дамжаандаа Снеггийн үгийг анхааралтай сонссон бол сууж байх байсан гэж Гермiona үл ойшоон хэлэв.

Харри түүнтэй маргахыг хүссэнгүй. Тэр зөвхөн (Сектумсемпра!) гэсэн шившлэгэн дор «дайсандаа» гэсэн нууцлаг үг сараачсаныг үзээд туршиж үзэх хүсэл төрсөн ч Гермionaгийн урд болохгүй байсан учир нууцхан хуудасны булан руу ширтэв.

Тэд амралтын өрөөнд ханан зуухны дэргэд суугаад зөвхөн зургадугаар дамжааныхан сэрүүн байлаа. Тэднийг оройн хоолноос эргэн ирэхэд зарлалын самбар дээр бүгдийн сэтгэл хөдөлгөсөн мэдээ гарч шилжих шалгалт авах өдөр цагийг товлосон байв. Арван долоо хүрсэн юмуу эсвэл шалгалтын өдөр болох дөрвөн сарын хорин нэгэнд хүрэх хүн Хогсмидэд (хүч нэмэгдүүлсэн хамгаалалтан дор) нэмэлт сургуулилт авч болох ажээ.

Рон мэдээг уншмагц сандралд орлоо. Шилжихэд сураагүй болохоор шалгалт болохоос айжээ. Гермiona хэдийн хоёр удаа шилжсэн болохор биеэ арай илүү итгэлтэй явж байв харин Харрийн хувьд арван долоо хүрэхэд ахиад дөрвөн сар үлдсэн болохоор шалгалтанд бэлтгэх эсэх нь хамаагүй байлаа.

- Тэгсэн ч чи шилжиж чадна! гэж Рон халаглан дуу алдаад.

- Дээр нь долоон сард төрсөн болохоор санаа зовох зүйл юу ч алга гэв.

- Би ердөө ганц удаа үүнийг хийсэн гэж Харри сануулав. Сүүлчийн хичээлийн үеэр тэр эцэст нь алга болоод цагаригийн дотор гарч ирсэн билээ.

Шилжихэд санаа зовсон чанга яриан дундуур Рон Харри, Гермiona хоёрын хэдийн дуусгасан Снеггийн хэцүү зохион бичлэгийг дуусгахаар зүтгэж байлаа. Харри бичгийн ажилдаа Снеггийн Дементортой тэмцэх аргыг үгүйсгэсэн болохоор хамгийн бага үнэлгээ авна гэдэгтээ эргэлзсэнгүй. Гэхдээ энэ түүнийг зовоосонгүй одоо хамгийн чухал зүйл Слизнортын дурсамж байв.

- Би хунтайж энэ удаад чамд юугаар ч тус болж чадахгүй гэж хэлсэн биз дээ, Харри! Хүнийг хүссэн юмаа хүчээр хийлгэх ганц л арга байдаг юм ... Империнус шившлэгээр удирдаж болох ч энэ нь хууль бус ... гэж Гермiona дуугаа өндөрсгөн хэлэв.

- Үүнд чинь баярлах эсэхээ мэдэхгүй л байна. Учир нь би өөр зүйл эрж байгаа юм. Дамблдор үнэнийг хэлүүлэгч үйлчилэхгүй гэж хэлсэн ч өөр шившлэг юмуу уусмал үйлчилж болох юм ...

- Чи буруу замаар яваад байна. Дамблдор зөвхөн чамайг л дурсамжыг гарган авч чадна гэдэгт итгэлтэй байсан. Харин энэ чинь чи Слизнортыг өөр хэнээс ч илүү ятгаж чадах хүн гэсэн үг. Энэ бол түүнд ямар нэг уусмал юмуу өөр зүйл хэрэглэнэ гэсэн үг биш ...

- «Түрэмгий» гэдгийг яаж зөв бичдэг юм бэ? гэж Рон үзгээ сэгсрэн цаасаа харж хэлээд,

- Ү-Р-Г биш биз дээ ... гэв.

- Үгүй, тийм биш гээд Гермиона Роны зохион бичлэгийг ойртуулан татсанаа,

- «Ууртай» ч гэсэн «О-Р-Т»-ээр эхэлдэггүй. Чи ингэхэд ямар үзгээр бичээд байгаа юм бэ? гэв.

- Фред, Жорж хоёрын алдаа шалгагч үзэг ... гэхдээ шившлэгний үйлчилэх хугацаа нь дууссан бололтой.

- Тийм байна гээд Гермиона хуруугаараа гарчгийг нь зааж,

- Яагаад гэвэл бидний хэн ч Дементортой тэмцэхдээ асуудаггүй, хоёрдугаарт гэвэл чи Рундил Уолзликийн нэрийг сольж гэв.

- Өө, үгүй ээ! Зөвхөн бүгдийг эхнээс нь бичнэ гэж бүү хэлээрэй дээ! гэж Рон дуу алдаад айдаст автан цаас руугаа харлаа.

- За яахав, би үүнийг засчихъя гээд Гермиона цаасыг өөр лүүгээ дөхүүлээд шидэт саваагаа гаргаж ирэв.

- Би чамд хайртай, Гермиона гээд Рон сандалдаа лагхийн сууж ядрангуй нүдээ арчлаа.

Гермиона ялимгүй улайснаа,

- Лавандад үүнийгээ бүү сонсгочихоорой доо ... гэлээ.

- Хичээж л байна ... тэгвэл магадгүй намайг хаях юм болов уу гэж Рон гартаа хандан хэлэв.

- Хэрвээ чи энэ бүхнийг дуусгахыг хүсч байгаа бол яагаад өөрөө хаяж болохгүй гэж? хэмээн Харри асуулаа.

- Чамд хэн нэгнийг хаяж байсан удаа байна уу? Чжоу та хоёр зүгээр л ...

- Зүгээр л салсан, чиний зөв гэж Харри хэлэв.

- Лаванда бид хоёр бас тэгвэл сайн байна гэж Рон гунигтай хэлээд Гермиона хэрхэн савааныхаа үзүүрийг буруу бичигдсэн үг бүрт хүргэн засахыг харлаа.

- Гэхдээ би бүгдийг дуусгахыг хүссэн ч гэсэн тэр надаас чанга зуураад тавихгүй байна. Яг л аварга том наймаалж гэсэн үг.

- Май гэж хорин минутын дараа Гермiona хэлээд Ронд ажлыг нь буцаан өглөө.
- Мянга дахин баярлалаа! Би чиний үзгээр бичиж болох уу? гэж Рон дуу алдав.

Харри эрлийз хунтайжын бичгээс ямар ч ашигтай зүйл олж илрүүлээгүй болохоор эргэн тойрноо харав. Симус саяхан Снеггийн зохион бичлэгийг дуусаад явж өрөөнд зөвхөн тэр гурав үлджээ. Цорын ганц чимээ гэвэл ханан зууханд дөл шажигнах болон Дементорын тухай сүүлчийн мөр бичиж буй Роны зээлэн авсан үзэг чахрах дуу гарна ... Харри эвшээн номоо хаатал ...

Тас.

Гермиона аяархан дуу алдахад, Рон саяхан дуусгасан бичгийн ажил руугаа бэх асгачихлаа.

- Кикимер! гэж Харри дуу алдав.

Гэрийн үйлчлэгч хөлийн тавхайгаа хүртэл гүнзгий бөхийн ёслоод,

- Эзэн залуу Малфойн юу хийж байгаа тухай мэдээлэл өгөхийг хүссэн учраас Кикимер ирлээ ... гэв.

Тас

Добби Кикимерийн дэргэд данхны зурагтай малгай нь хазайсан гарч ирлээ.

- Добби бас Харри Поттерд тусалсан! гээд Кикмимер руу уурсан харж,
- Кикимер Доббид Харри Поттер руу ирэхдээ мэдээллээ хамт өгнө гэсэн! гэлээ.
- Энэ чинь юу гэсэн үг юм? Юу болоод байна, Харри? гэж үйлчлэгчид гэнэтхэн гарч ирсэн явдалд цочирдсон Гермiona асуулаа.

Харри түүнд Кикимер Добби хоёроор Малфойг мөрдүүлж байгаа тухай хэлээгүй болохоор хариулахын өмнө тээнэгэлзлээ. Гэрийн үйлчлэгчид түүний хувьд үргэлж эмзэг сэдэв байдаг билээ.

- Би тэднээс Малфойг дагахыг гуйсан юм.
- Өдөр шөнөгүй гэж Кикимер сөөнгөтөв.
- Добби долоо хоногийн турш унтаагүй, Харри Поттер! гэж Добби бардам хэлээд үл мэдэг ганхахад Гермiona уурсан харлаа.
- Унтаагүй гэнээ, Добби? Гэхдээ Харри чи тэдэнд ингэж тушаасан гэдэгтэй ...
- Мэдээж тэгээгүй гэж Харри яаран хэлээд,
- Добби чи унтаж болно, за юу? Тэгээд та хоёр ямар нэг зүйл олов уу? гэж

Гермионагийн шинэ оролцооноос өмнө яаран асуулаа.

- Залуу Малфой цэвэр цусны язгууртан гаралдаа зохих ёсоор хүмүүстэй харьцаж байгаа. Тэр миний эзэгтэйн төрх байдлыг сануулж ... гэж Кикимер сөөнгөтөн дуржигнуулав.



- Драко Малфой муу хүү! Муу хүү гэж Добби уурсан хэлснээ малгайнахаа цацгыг чичрүүлэн гал руу үсрэх гэж байгаа аятай гүйлээ. Харри иймэрхүү зүйл хүлээж байсан болохоор үйлчлэгчийг замын дунд барин авч чанга тэвэрлээ. Хэдэн хормын турш Добби сарвалзсанаа намдав.

- Баярлалаа, Харри Поттер. Доббид өмнөх эзнийхээ тухай муу үг хэлэхэд хэцүү байх юмаа ...

Харри түүнийг тавилаа. Добби малгайгаа засаад Кикимерт хандан,

- Гэхдээ Кикимер Драко Малфой гэрийн үйлчлэгчид муу эзэн гэдгийг мэдэх ёстой! гэлээ.

- Тийм шүү чиний Малфойд хэр хайртай чинь бидэнд сонин биш байна. Тэр юу хийж байсныг түргээн хэлээдэх гэж Харри Кикимерт хэлэв.

Кикимер ахин нэг удаа бөхийн ёслоод ууртай харлаа.

- Залуу Малфой Их танхимд хоолож, цамхагийн унтлагын өрөөнд унтан, янз бүрийн хичээлд явж ...

- Добби чи ярьсан дээр байх гэж Харри Кикимерийн яриаг таслан хэлэв.

- Тэр ямар нэг газар байсан уу?

- Харри Поттер, ноёнтоон гээд Доббийн том нүд галын дөлд гялалзав.

- Добби Малфойг ямар нэг дүрэм зөрчиж бусдын нүднээс нуугдах гэснийг ажиглаагүй. Тэр ердийнхөөрөө долоон давхар руу явж олон сурагчдыг орохоосоо өмнө харуулд зогсоодог юм ...

- Шаардлагатай өрөө! гэж Харри дуу алдаад духаа номоороо чанга цохив. Рон, Гермиона хоёр түүн рүү нүдээ томруулан харлаа.

- Тийм учраас л тэр булгаад байж! Ийм болохоор л газрын зурагнаас алга болоод байж ... Хэрвээ бодоод үзвэл би Шаардлагатай өрөөг газрын зураг дээр хэзээ ч хараагүй юм байна!

- Магадгүй Тэнүүлчний газрын зураг өрөөний байгааг мэдэхгүй байх гэж Рон хэлэв.

- Энэ бол өрөөний шидийн нэг хэсэг гэж бодож байна гэж Гермиона хэллээ.

- Добби чи Малфой тэнд юу хийж байхыг харсан уу? гэж Харри тэвчээргүйхэн асуув.

- Үгүй, Харри Поттер энэ боломжгүй.

- Зүйтэй боломжгүй гэж Харри шуудхан зөвшөөрлөө.

- Гэхдээ Малфой өнгөрсөн жил тийшээ манай штабын байр руу орсон болохор би Шаардлагатай өрөөнд орж түүнийг хийж байгааг зүйлийг тагнах болно.

- Харин би тэгж бодохгүй байна, Харри. Малфой тэгэхэд Мариэттагийн ярианаас болоод биднийг Шаардлагатай өрөөг яаж ашиглаж байгааг сайн мэдэж байсан. Түүнд ДА-гийн өрөөнд орохын тулд тэгж гуйхад болох байсан.

Харин чи Малфойн юу хийж байгааг мэдэхгүй болохоор Шаардлагатай өрөөнд орохын тулд юу гуйхыг мэдэхгүй гэж Гермiona удаанаар хэлэв.

- Ямар нэг зүйл бодож олж болох юм. Чи сайн ажиллаа, Добби.
- Кикимер бас муугүй ажилласан гэж Гермiona нөхөрсөг хэлсэн ч Кикимер талархахын оронд цус хурсан нүдээрээ тааз руу ширтэн,
- Бохир цустан Кикимерт хандлаа. Кикимерт түүнийг сонсоогүй дүр үзүүлэх болно ... гэж сөөнгөтөв.
- Эндээс яв! гэж Харри зандрахад Кикимер сүүлчийн удаа бөхийн ёслоод шилжлээ.
- Харин чиний хувьд Добби явж унтсан чинь дээр байх.
- Баярлалаа, Харри Поттер ноёнтоон! гэж Добби баяртай хэлээд бас алга боллоо.
- За яасан муугүй биз? гэж үйлчлэгч нар өрөөг орхимогц Харри тэдэн рүү эргээд урам зоригтой дуу алдав.
- Бид Малфойн хаана нуугдаад байгааг мэддэг боллоо. Харин одоо түүнийг буланд шахах болно!
- Тиймээ гэж Рон гунигтай батлаад цаасан дээр асгарсан бэхийг цэвэрлэхийг оролдов. Гермiona Рonoос цаасыг авч саваагаа хүргэн бэхийг соруулснаа,
- Өөр олон сурагчдын хамт явж байсан гэдэг нь юу гэсэн үг вэ? Хэр олон хүмүүс байгаа юм бол? Чи түүнийг хийж байгаа ажилдаа бүлэг хүмүүс цуглуулж байгаа гэж бодож байна уу ... гэв.
- Тиймээ, энэ хачирхалтай юм. Би түүнийг Крэббтэй ярилцахыг сонссон. Түүний юу хийж байгаа нь Крэббэд хамаагүй гэсэн ... Харин одоо бүгдэд үүнийгээ хэлсэн юм байх даа гээд Харри чимээгүй болж гал ширтсэнээ,
- Бурхан минь, би ямар тэнэг юм бэ. Бүгд өдөр шиг тодорхой байж! Газар дорх хонгилд том торх байгаа ... Тэр хичээл дээр хэсгийг аваад тийшээ нь хийж чадах байсан ... гэв.
- Юу хийсэн гэж? хэмээн Рон асуув.
- Хувиргагч уусмал. Малфой Слизнортын эхний хичээл дээр бидэнд үзүүлсэн хувиргагч уусмалаас хулгайлан авсан байна. Тиймээс ямар ч олон сурагчид түүнийг хамгаалагүй ердөө Крэбб, Гойл хоёр байж ... Тиймээ, бүгдийн учир олдлоо! гээд Харри хөл дээрээ босон зуухны урд холхиж эхлэв.
- Хоёулаа юу хийлгэхийг даалгасныг хийх тэнэг болохоор Малфой тэдэнд төлөвлөгөөгөө хэлээгүй байна. Тэр хэн нэгэнд Шаардлагатай өрөөний гадна холхиж анхаарал татахгүйн тулд найзуудаа Хувиргагч уусмалаар хувирган өөр хүмүүс болгон харагдуулж байж ... Миний тэмцээний өдөр харсан хоёр охин ... ха! Крэбб, Гойл хоёр байж!

- Чи миний жинлүүрийг нь зассан жижигхэн охин гэж хэлэхийг хүсээ юу ... гэж Гермиона чимээгүйхэн хэлэв.

- Тэгэлгүй яахав! гэж Харри чанга хэлээд түүн рүү харж,

- Мэдээж шүү дээ! Малфой энэ үед өрөөний дотор суугаад тэр ... Хүлээгээрэй би юу ярьж байна аа? Тэр жинлүүрээ унагасан нь Малфойд гадны хүн энд байна гарч болохгүй гэсэн дохио байж! Бас мэлхийний түрс унагасан охин ч гэсэн! Яг тийм ... Бид дэргэдүүр нь маш олон өнгөрөхдөө юу ч ажиглаагүй байна!

- Тэгвэл тэр Крэбб, Гойл хоёрыг охид болгон хувиргаж байгаа юм уу? гэж Рон хөхөрлөө. Чөтгөр гэж ... Тэдний сүүлийн үед золгүй царайтай байгаад гайхах юм алга ... Хачирхалтай нь тэд яагаад багш нарт хэлээгүй юм бол ...

- Тэр хэрвээ Хар тамга үзүүлсэн бол тэгж чадахгүй биз дээ?

- Хм-м ... Хар тамга бид хараагүй гэж Гермиона шүүмжлэнгүй хэлээд Роны бичгийн ажлыг ямар нэг юм тохиолдохоос нь өмнө хуйллаа.

- Харах болно гэж Харри итгэлтэй хэлэв.

- Тиймээ тэгнэ гэж Гермиона зөвшөөрөөд босож,

- Гэхдээ Харри ... би чамайг Шаардлагатай өрөөнд орж дотор нь юу байгааг мэдэх боломжтой гэж бодохгүй байна. Бас чамайг Слизнортын дурсамжыг олох ёстойгоо мартсан гэж бодохгүй байна. Тавтай нойрсоорой гээд цүнхээ мөрөн дээгүүрээ үүрлээ.

Харри түүнийг таагүй харцаар дагуулан үлдэв. Гермионаг охидын унтлагын өрөө хаамагц Рон руу эргэлээ.

- Харин чи юу бодож байна?

- Би үйлчлэгч нар шиг шилжиж чаддаг бол ямар сайхан бэ гэж бодож байна гээд Рон Доббийн алга болсон газар луу харлаа. Тэгвэл шалгалт халаасанд байна л гэсэн үг.

Энэ шөнө Харри муу унтлаа. Тэр удтал нойргүй хэвтээд Малфойн Шаардлагатай өрөөнд юу хийж байгааг тааварлаж Гермиона юу гэж хэлсэн ч бай хэрвээ Малфой штабын байранд нэвтэрсэн бол түүнд ч гэсэн нэвтрэх боломж байгаа гэж бодлоо. Тэр юу хийж байж болох вэ? Нууц уулздаг газар юм уу? Нуугддаг юм болов уу? Агуулах уу? Засварын газар уу? Харри тархиа тасралтгүй ажилуулсаар эцэст нь унтмагц Малфой Слизнорт дараа нь Снегт болон хувирч байгаа тухай түгшүүртэй зүүд зүүдэллээ ...

Маргааш нь өглөөний цайн дээр сууж байхдаа хар урлагаас хамгаалах хичээлийн чөлөөт цаг дээр Шаардлагатай өрөөнд нэвтрэх оролдлого хийхээр шийдэв. Тэр Гермионад төлөвлөгөөгөө шивнэн ярихад санаатайгаар сонирхсонгүй тул хэрвээ түүнийг хүсвэл туслах байсан явдалд ихээхэн уурслаа.

- Сонсооч! гэж тэр нам дуугаар хэлээд түүнийг гартаа барьсан «Өдөр тутмын зөнч» сонинг дэлгэж ард нь нуугдахаас өмнө бөхийгөөд,

- Би Слизнортын тухай мартаагүй зүгээр л надад түүний ухаанд яаж нэвтрэх талаар ямар нэг санаа алга байхад яагаад Малфойн юу хийж байгааг мэдэхийг оролдож болохгүй гэж? гэв.

- Би чамд хэдийн Слизнортыг ятгах ёстой гэж хэлсэн. Асуудал түүнийг мэхлэх юмуу илбэдэхэд байгаа юм биш. Дамблдор өөрөө үүнийг агшин зуур хийж орхино. Шаардлагатай өрөөний эргэн тойронд холхиж байхын оронд гээд Харрийн гар дор байсан сонины эхний хуудсыг эргүүлээд,

- Слизнортыг олж сайн тал руу нь эргүүлэхийг оролдсон нь дээр дээ гэв.

- Хэн нэгэн танил хүн байна уу? гэж Рон асуулаа.

- Тиймээ! гээд Гермiona тэдний өглөөний хоолондоо хахахыг харснаа,

- Гэхдээ зүгээр дээ, тэр амьд байна ... Наземникус баривчлагдан Азкабанд оржээ! Ямар нэг дээрэмдэхийн тулд инфернал болон зүсээ хувиргасан байна. Бас найман өнцөгтэй нэг зүйл алга болж .... Өө, ямар аймшигтай юм бэ! Есөн настай хүү өвөө эмээгээ алах гэсний төлөө баривчлагджээ. Түүнийг Имперуус шившлэгийн нөлөөн дор байсан гэж бодож байгаа юм байна гэв.

Тэд өглөөний цайгаа чимээгүйхэн дуусгалаа. Гермiona эртний дүрс бичгийн хичээлдээ явахад, Рон амралтын өрөөнд үлдээд Дементорын тухай зохион бичлэгийнхээ дүгнэлтийг бичиж, Харри долоон давхарын эсрэг хананд байдаг Варнав Вздрюченный балет бүжиглэж байгаа савдгийн хөрөг рүү явлаа.

Харри хүнгүй хонгилд гараад үл үзэгдэх цуваа нөмөрч зорьсон газраа хүрэхэд хоосон байлаа. Харри Малфойн Шаардлагатай өрөөний дотор юмуу гадна байгаа эсэхэд итгэлтэй биш байсан ч эхний оролдлогод нь саад болохоор арван нэгэн настай охин болон хувирсан Крэбб юмуу Гойл байсангүй нь сайн хэрэг боллоо.

Тэр Шаардлагатай өрөөний үүдэн дээр очоод нүдээ анилаа. Өнгөрсөн жил амжилттай хийж байсан болохоор юу хийх ёстойгоо мэдэж байв. Төвлөрөөд «Надад Малфой энд юу хийж байгааг харах хэрэгтэй байна ... Надад Малфой энд юу хийж байгааг харах хэрэгтэй байна ... Надад Малфой энд юу хийж байгааг харах хэрэгтэй байна ...» гэж бодлоо.

Гурван удаа хаалганы дэргэдүүр өнгөрөөд зүрх түгшин цохилсоор нүдээ нээтэл урд нь хоосон хана байв.

Тэр урагш алхаад түлхэж үзэв. Чулуун хана нээгдсэнгүй.

- За яахав, би тэгж бодсон юмаа гэж Харри чанга хэллээ.

Тэр хормын турш бодлогошироод бүгдийг ахин эхэлж нүдээ анин төвлөрлөө.

«Надад Малфойн нууц зүйл хийж байгааг газрыг харах хэрэгтэй байна ... Надад Малфойн нууц зүйл хийж байгааг газрыг харах хэрэгтэй байна ... Надад Малфойн нууц зүйл хийж байгааг газрыг харах хэрэгтэй байна ...»

Гурван удаа урагш хойш яваад Харри найдангуй нүдээ нээлээ.

Хаалга байсангүй.

- Өө, боль доо. Би чамд тодорхой хэлсэн биз дээ ... гэж хананд уурсан хэллээ. Тэр ахин эхлэхээсээ өмнө хэдэн хормын турш бодлоо. «Надад Драко Малфойн байгаа газар хэрэгтэй байна ...»

Тэр холхиж дуусаад нүдээ шууд нээсэнгүй хаалга нээгдсэн байж болох чимээ чагналаа. Гэвч алсад шувуу нисэхээс өөр юу ч сонсогдсонгүй. Ингээд нүдээ нээлээ.

Хаалга байсангүй.

Харри хараахад хэн нэгэн хашгирлаа. Тэр эргэж хараад нэгдүгээр дамжааны сурагч хараалч хий үзэгдэл гэж бодсон бололтой булан тойрч далд орохыг хараад инээд алдав.

Харри боломжтой бүхий л хувилбарыг оролдож үзэн «Надад Драко Малфойн дотор юу хийж байгааг харах хэрэгтэй байна» гээд эцэст нь Гермionaгийн зөв болохыг хүлээн зөвшөөрөв. Шаардлагатай өрөө түүнд нээгдэхийг хүссэнгүй. Сэтгэлээр унаж уурссан тэрбээр хар урлагаас хамгаалах хичээлдээ явахдаа үл үзэгдэх цуваа цүнхэндээ хийлээ.

- Ахиад хоцорлоо, Поттер. Гриффиндороос арван оноо хаслаа гэж Снегг лааны гэрэлтэй өрөөнд яаран ороход хүйтнээр хэлэв.

Харри Снегг рүү уурсан хараад Роны дэргэд суулаа. Сурагчдын хагас нь сурах бичгээ гаргаж амжаагүй байхыг үзвэл тийм ч их хоцроогүй бололтой.

- Хичээл эхлэхээс өмнө Дементорын тухай бичгийн ажлыг хурааж авах болно гээд Снегг саваагаа хайхрамжгүй даллахад хорин таван хуйлаастай цаас хөөрөн ширээн дээр нь нямбай овоологдлоо.

- Бас та нарын өмнө нь бичсэн Имперуус шившлэгийн эсрэг яаж тэмцэх вэ гэсэн утгагүй зүйлээс дээр гэж найдаж байна. Харин одоо сурах бичгийнхээ хуудсыг онгойлго ... Яасан бэ, ноён Финниган?

- Ноёнтоон, хий үзэгдлийг инферналаас яаж ялгах вэ? Учир нь «Зөнч» сонинд инферналын тухай ...

- Энэ бол инфернал биш байсан гэж Снегг уйдсан хоолойгоор хэлэв.

- Гэхдээ ноёнтоон, тэнд хэлэхдээ ...

- Хэрвээ ноён Финниган та үнэхээр тэр нийтлэлийг уншсан бол инфернал гэж өөдгүй хулгайч Флетчер Наземникусыг нэрлэсэн болохыг мэдэх байсан.

- Би Снеггийг Наземникустай нэг тал гэж бодсон юмсан. Наземникусын баривчлагдсан явдал нь түүнийг сэтгэлээр унагах ... хэмээн Харри Рон, Гермiona хоёрт хандан бувтналаа.

- Харваас Поттер энэ сэдвээр бидэнд олон сонирхолтой зүйл ярьж өгч чадах юм шиг байна гээд Снегг гэнэтхэн ангийн ар тал руу заагаад хар нүд нь Харри дээр төвлөрч,

- Алив Поттероос асууя. Бид яаж хий үзэгдлийг инферналаас ялгах вэ гэв.

Анги даяараа түүн рүү харахад Харри Дамблдор Слизнортынд очсон шөнө юу гэж хэлснийг яаран саналаа.

- Э-э ... хий үзэгдэл нэвт гэрэлтдэг ...

- Гайхамшигтай гэж Снегг уруулаа мушийлган яриаг нь таслаад,

- Тийм шүү, бараг зургаан жилийн турш шидийн боловсрол олж авахад цаг гарздаагүй чинь харагдаж байна. Хий үзэгдэл гэрэлтдэг гэнэ шүү гэв.

Пэнси Паркинсон цангинатал хөхөрлөө. Өөр бас хэдэн сурагчид тэнэгдүү инээмсэглэл тодруулав. Харри цээж дүүрэн амьсгал аваад дотор нь шатаж байсан ч тайван үргэлжлүүлэв.

- Тиймээ хий үзэгдлүүд нэвт гэрэлтдэг харин инферналууд бол үхсэн бие юм.

Ийм учраас тэд хатуу ...

- Үүнийг бидэнд таван настай хүүхэд ч ярьж өгч чадна гэж Снегг шоолонгуй хэлээд,

- Инферналууд бол хар шидтэний буцаан амилуулсан хүүр юм. Үнэн хэрэгтээ тэд амьд биш ердөө хүүхэлдэй адил шидтэний тушаалыг биелүүлж байгаа. Харин хий үзэгдэлүүд бол газар дэлхийгээ үлдсэн хоргодон үлдсэн сүнс гэдгийг та нар хэдийн мэдэх байх ... Поттерын мэргэн ажигласан шиг тэд гэрэлтдэг.

- Гэхдээ Харри тэднийг ялгахад туслах ашигтай зүйл хэлсэн шүү дээ! Хэрвээ бид түүнтэй харанхуй гудамжинд тааралдвал тунгалаг эсвэл хатуу эсэхийг нь харах үлдлээ. Бид уучлаарай та санамсаргүй газар дэлхийдээ хоргодсон сүнс биш биз гэж асуухгүй биз дээ? гэж Рон хэлэв.

Ангид инээд хадсан ч Снегг дор нь чимээгүй болгов.

- Гриффиндороос арван оноо хаслаа. Рональд Уизли танаас би өөр ямар ч ухаалаг зүйл хүлээгээгүй. Та хатуу хүү болохоор хагас дюймийн зайд ч шилжиж чаддаггүй.

- Чимээгүй! Үгүй бол тэр чамайг хичээлийн дараа үлдээх шийтгэл онооно шүү! гэж Харриг уурсан амаа нээхэд Гермiona шивнээд гараас нь барьж авлаа.

- Харин одоо сурах бичгийнхээ хоёр зуун арван гуравдугаар хуудсыг нээж Круциатус шившлэгийн тухай эхний хоёр мөрийг унш гэж Снегг сэтгэл хангалуун инээмсэглэн хэлэв.

Хичээлийн турш Рон ер бусын чимээгүй сууж өнгөрлөө. Хонх дуугарахад Лаванда Харри, Рон хоёрыг барьж авахад, (Гермиона түүний ойртон ирэхийг хараад агаарт ууршсан юм шиг алга болжээ) Снеггийн шилжих тухайд доромжилсон явдалд Рон ихэд сэтгэлээр унасан тул түүнээс зугтахын тулд Харрийн хамт хөвгүүдийн жорлонд оров.

- Ер нь Снеггийн зөв биз дээ? гэж Рон хагарсан толинд өөрийгөө хараад хэллээ.

Би шалгалт өгч чадах эсэхээ мэдэхгүй байна. Миний шилжих гэж юу ч бүтэхгүй байх.

- Чи Хогсмидэд нэмэлтээр хичээл авч болно шүү дээ. Энэ тэнэг цагаригаас хамаагүй сонирхолтой байх болно ... Хэрвээ чи чадахгүй бол ... шалгалтаа хойшлуулаад ирэх жил надтай хамт орж болно ... Миртл энэ чинь эрэгтэйчүүдийн жорлон шүү дээ!

Тэдний ард байсан тасалгааны суултуураас хий үзэгдэл охин хөвөн гарч ирээд зузаан цагаан дугуй шилнийхээ цаанаас ширтсэнээ,

- Өө, та хоёр байсан юмуу гэж баргар хэлэв.

- Харин чи хэнийг харна гэж бодсон юм ? гэж Рон түүнийг толинд хараад асуулаа.

- Хэнийг ч биш гээд тэр эрүүн дээрх батгаа шахаж,

- Тэр надтай эргэж уулзахаар ирнэ гэсэн бас чи ч гэсэн над дээр ирнэ гэсэн ... гээд Харри руу зэвүүцэн харлаа.

- Би чамайг хэдэн сарын турш харсангүй. Би одоо хөвгүүдээс олон зүйл хүлээх хэрэггүй гэдгийг ойлгосон.

- Надад чи эмэгтэйчүүдийн жорлонд амьдардаг гэж санагдсан юмсан гэж Харри хэлэв.

- Тиймээ, амьдардаг гэж Миртл батлаад гомдонгуй мөрөө хавчиж,

- Гэхдээ энэ чинь өөр газар байж болохгүй гэсэн үг биз дээ. Би чамтай нэг удаа угаалгын өрөөнд уулзсаныг санаж байна уу? гэв.

- Саналгүй яахав!

- Харин би түүнд таалагдсан гэж бодож байна. Хэрвээ та хоёр эндээс гарахгүй бол тэр эргэж ирэхгүй байх. Бидэнд төстэй олон зүйл бий гэдгийг ... түүнийг мэдэрсэн гэдэгт итгэлтэй байна гээд Миртл найдангуй хаалга руу ширтлээ.

- Олон зүйл төстэй гэдэг чинь юу гэж байгаа юм? Энэ чинь тэр бас тахир хоолойд амьдардаг гэсэн үг үү? хэмээн Рон хөгжилтэй хэлэв.

- Үгүй! гэж Миртл хэлэхэд хоолой нь угаалгын өрөөнд чанга цуурайтлаа.

- Хүмүүс түүнтэй бүдүүлэг харьцдаг ч гэсэн их зөөлөн сэтгэлтэй, бас хэн ч түүнтэй ярьдаггүй ганцаардмал болохоор өөрийн мэдрэмжээ уйлж үзүүлэхээс ичдэггүй!

- Хөвгүүдийн хэн нэг энд уйлдаг хэрэг үү? Жижигхэн үү? гэж Харри сонирхов.

- Энэ чиний хэрэг биш! гээд Миртл жижигхэн нулимстай нүдээ инээж буй

Роноос салгалгүй,

- Би түүнд хоорондын нууцаа хэнд ч хэлэхгүй гээд амалчихсан гэв.

- Үхэн үхтлээ гэдэгт найдаж болох уу? Магадгүй усны хоолойд гээд Рон тургилав.

Миртл уурсан орь дуу тавиад суултуур руу шумбан шалаар нэг ус үсчүүлэв. Миртл Роны сэтгэл санааг өргөсөн бололтой.

- Чиний зөв. Би шалгалт өгөхөө шийдэхээс урьд Хогсמידэд бэлтгэл хийнэ гээд цүнхээ мөрөн дээр тавилаа.

Дараагийн амралтын өдөр Рон, Гермiona хоёр арван долоо хүрэхэд хоёр долоо хоног үлдсэн бусад зургадугаар дамжааныхантай нэгдэхээр явлаа. Харри тэднийг тосгон руу явахад бэлэн болсныг хараад атаархах сэтгэл төрөв. Энэ нь удаан хугацааны дараа цэлмэг тэнгэр гарсан хаврын сайхан өдөр байлаа. Гэвч Харри тэднийг байхгүйд ахин нэг удаа Шаардлагатай өрөөнд орох гэж үзэхээр шийджээ.

- Чи Слизнортын өрөөнд орж дурсамжыг авах гэж оролдвол дээрсэн гэж Гермiona түүнд үүдний танхимд сануулав.

- Би тэгэх гэж оролдоогүй гэж үү! хэмээн Харри уурласан нь цэвэр үнэн байлаа.

Сүүлчийн долоо хоног тэр уусмалын хичээлийн дараа үлдэн Слизнортыг буланд шахахыг оролдсон ч уусмалын профессор газар дорх хонгилоос ажиглагдамгүй түргэн гарч байсан учир нэг ч удаа барьж авч чадсангүй. Хоёр ч удаа Слизнортын өрөөний хаалгыг цохиход хариу өгөөгүй бөгөөд хуучин эгшигт хөгжим дуугарах нь сонсогджээ.

- Тэр надтай ярихыг хүсэхгүй байна, Гермiona! Тэр намайг ганцаарчилан үлдээх гэж байгааг мэдэж байгаа учир ингэх боломж өгөхгүй байна!

- Тэгвэл үргэлжлүүлэн оролдохоос өөр арга үлдсэн гэж үү?

Сурагчдын багахан дараалал Филч рүү сунан ойртоход ердийнхөөрөө илрүүлэгчээрээ хатган шалгаад хэдэн алхам урагшилахад Харри сонсохоос нь айгаад Гермionaд хариу хэлсэнгүй. Тэр Рон, Гермiona хоёрт амжилт хүсээд гантиг шатаар өгсөж Шаардлагатай өрөөнд орох гэж үзэхээр шийдлээ.

Үүдний хонгил ард үлдмэгц Харри цүнхнээсээ Тэнүүлчний газрын зураг болон үл үзэгдэх цуваа авлаа. Үл үзэгдэх болсныхоо дараа газрын зурган дээрээ тогшиж «Зөвхөн дүрсгүйтэнэ гэдэгдээ баясгалантайгаар тангараглаж байна» гээд анхааралтай харлаа.

Ням гаригийн өглөө бараг бүх сурагчид амралтын өрөөндөө байж Гриффиндорынхон болон Когтевранчууд өөр өөрсдийн цамхагтаа, Слизеринчүүд газар дорхи хонгилд харин Пуффендуйчууд гал зуухны ойролцоох хонгилд байлаа. Хэн нэг сэлгүүцэж яваа хүн номын санд юмуу хонгилд байлаа. Хэдэн хүн шилтгээний гадаа зугаалан долоон давхарт Грегори Гойл ганцаар байв. Газрын зураг дээр Шаардлагатай өрөөний ямар ч шинж тэмдэг байсангүй ч энэ нь Харриг зовоосонгүй. Хэрвээ Гойл гадаа нь харуулд зогсож байгаа бол газрын зураг дээр



харагдах эсэхээс үл хамааран өрөө онгорхой гэсэн үг. Харри дээшээ өгсөөд хэрэгтэй хонгилдоо хүрч удаанаар гэтэхэд Гермionaгийн хоёр долоо хоногийн өмнө эелдэгээр тусалсантай маш адилхан охин гартаа хүнд зэс жинлүүр бариад зогсож байлаа. Тэр түүний ард хүрээд тонгойж нам дуугаар,

- Сайн уу ... чи ямар хөөрхөн юм бэ! гэж шивнэлээ.

Гойл айсандаа часхийтэл орилоод жинлүүрээ унаган гүйн одоход эвдэрсэн жинлүүрийн дуу нүргэлэв. Харри хөхрөөд хоосон хана руу эргэж харахдаа дотор Драко Малфой хөшин зогсоод урилгагүй хэн нэгэн гадна байгаагаас эмээн гарч ирч чадахгүй байгаад эргэлзсэнгүй. Энэ нь Харрид таатай мэдрэмж төрүүлэхэд хүч ороод хананд ямар үг хандан хэлэхээ бодов.

Түүний найдлага удаан үргэлжилсэнгүй. Хагас цагийн дотор тэр Мафойг харахыг хүссэн бүхий л хувилбарыг оролдож үзсэн ч хаалга нээгдсэнгүй. Малфой түүнээс ердөө хэдхэн алхамын өмнө байтал юу хийж байгааг нь харах боломжгүйд Харри урам хугаран тэвчээр алдаад хана руу хөлөө өшиглөлөө.

- Ёо!

Түүнд хөлийн хуруугаа хугалах шиг санагдсанд нэг хөл дээрээ догонцтол үл үзэгдэх цув нь гулгаад уначихлаа.

- Харри?

Тэр нэг хөл дээрээ үсрэн эргэж харахдаа уначихлаа. Тэгээд Тонкс түүн рүү энэ хонгилоор зугаалах нь хамгийн ердийн хэрэг юм шиг ирэхийг хараад гайхав.

- Чи энд юу хийж байгаа юм бэ? гэж хөл дээрээ босоод асуув. Ер нь Тонкс яагаад түүнийг үргэлж шалан дээр хэвтэж байхад нь олдог юм бол?

- Дамблдортой уулзахаар ирсэн юм.

Харри түүнийг аймшигтай харагдаж байна гэж бодов. Турж эцэн саарал үс нь урт ургажээ.

- Түүний өрөө энд байдаггүй. Шилтгээний нөгөө өнцөгт лууны цаана байдаг ...

- Би мэднэ. Гэхдээ тэр тэнд байхгүй байсан. Ахиад л гадагш явсан бололтой.

- Явсан гэнээ? хэмээн Харри давтаад хөхөрсөн хөлөөрөө шалан дээр болгоомжтой гишгэж,

- Сонсооч, түүний хаачаад байгааг мэдэхгүй биз? гэв.

- Үгүй.

- Тэгвэл яагаад түүнтэй уулзахыг хүссэн юм?

- Энэ чухал биш гээд Тонкс жанчынхаа ханцуйг оролдов. Зүгээр л түүнийг юу болоод байгааг мэдэж магадгүй гэж бодсон юм ... Надад цуу яриа сонсогдоод

... хүмүүс гэмтэж байгаа.

- Тиймээ, би энэ тухай сонин дээр гарсныг мэднэ. Жаахан хүү өөрийнхөө алахыг оролдож ...

- Зөнч үргэлж цуу яриа гаргаж байдаг юм гэж Тонкс түүний яриаг сонсоогүй бололтой хэлээд,
- Чи сүүлийн үед бүлгийн хэн нэгнээс захиа авсан уу? гэв.
- Сириусээс өөр бүлгийн хэн ч надад захиа бичдэггүй ... Тэгтэл Тонксын нүдэнд нулимс дүүрлээ.
- Намайг уучлаарай ... Би ч гэсэн түүнийг санаад ... гэж Харри эв хавгүйхэн бувтнав.
- Юу? гэж Тонкс түүний үгийг бараг сонсолгүй асуугаад,
- За яахав ... дараа уулзая, Харри гэв.

Тэр огцом эргээд хонгилоор явахдаа Харриг ардаа орхилоо. Хормын дараа тэр шалан дээрээс үл үзэгдэх цуваа авч Шаардлагатай өрөөнд нэвтрэх оролдлогоо сэргээсэн ч нэмэр болсонгүй. Эцэст нь гэдэс өлсөхөд Рон, Гермиона хоёр удахгүй шилтгээнд хооллохоор ирэхийг санаад Малфойн хамрыг хэдэн цаг өрөөнөөс цухуйлгахгүй хүсэлтэй байсан ч арга буюу орхилоо.

Тэр Рон, Гермона хоёрыг Их танхимаас олоход хэдийн эрт ирээд хоолныхоо хагаст хүрээд байв.

- Минийх болсон! Бараг л гэж Харриг хараад Рон урам зоригтой хэлэв.
- Би хатагтай Паддифутын кафены хаалга руу шилжих ёстой байсан ч жаахан хэтрээд Писсаро руу орчихсон. Гэхдээ л байрнаасаа хөдөлсөн!
- Сайн байна. Харин чи Гермиона ямархуу байв?
- Тэр мэдээж хамгийн сайн байсан! Бид дараа нь «Гурван шүүр» лүү орж юм уухаар явахад Двукрест түүний тухай ярихыг чи сонссон болоосой! гэж Рон дуу алдлаа.
- Харин чи яасан бэ? Өдрийг Шаардлагатай өрөөний гадна өнгөрүүлэв үү? гэж Гермиона Роны яриаг тоолгүй асуулаа.
- Аанхан. Тэнд хэнтэй тааралдсаныг таа даа? Тонкс!
- Тонкс гэнээ? хэмээн Рон, Гермиона хоёр нэгэн зэрэг гайхан давтлаа.
- Тэр Дамблдортой уулзахаар ирсэн гэсэн ...
- Хэрвээ миний бодлыг мэдэхийг хүсвэл тэр жаахан сэтгэлээр унаж. Ид шидийн яаманд болсон явдлын дараа биеэ эзэмдэж чадахаа больсон бололтой гэж Рон Харрийг Тонксын талаарх яриагаа дуусгамагц хэлэв.
- Хачирхалтай юм гэж Гермиона хүчтэй сэтгэл түгшин хэлээд,
- Тэр сургуулийг хамгаалах ёстой байтал гэнэтхэн байраа орхиод Дамблдртой уулзахаар явна гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэв.
- Би ч гэсэн тэгж бодсон гэж Харри шийдвэргүйхэн хэлээд,

- Чамд тэр санагдахгүй байна уу ... ойлгож байна уу ... Сириуст хайртай байсан юм шиг? гэв.

Гермиона түүн рүү ширлээ.

- Чи хаанаас тэгж бодоо вэ?

- Мэдэхгүй. Зүгээр л би түүний тухай дурстал арай л уйлаагүй. Бас Патронус нь том дөрвөн хөлтэй болсон байдаг. Тэгээд би бодохдоо түүнд болоогүй байгаа гэж ...

- Энэ тухай чинь л би яриад байгаа юм. Тэр жаахан хачирхалтай байгаа. Өөрийгөө эзэмдэж чадахгүй. Тэгээд ч эмэгтэйчүүд амархан сэтгэлээр унадаг юм гэж ам дүүрэн нухсан төмс чихсэн Рон хэллээ.

- Би чамайг хагас цагийн дотор шулам, анагаагч, мимбулус миблетония гурвын шог ярианд инээх эмэгтэй олно гэдэгт эргэлзэж байна. Үүнд чинь хатагтай Розмерта ч инээхгүй байх гэж Гермиона хэлэв.

Рон хөмсгөө зангидлаа.

## БҮЛЭГ 22: ОРШУУЛГЫН ДАРАА

Шилтгээний том жижиг цамхагууд дээгүүр тэнгэр цэнхэртэх хэдий ч Харрийн сэтгэл санааг зун ойртож буй шинж тэмдэг өргөсөнгүй. Түүний Малфойн юу хийж буйг мэдэх гэсэн болон Слизнортыг ятган дурсамжыг нь авах оролдлогыг бүтэлгүйтжээ.

- Би чамд сүүлчийн удаа хэлье, Малфойн тухай март гэж Гермиона хатуу хэлэв. Тэд саяхан үдийн хоолондоо ороод шилтгээний гадаах хашаанд нарны гэрэлтэй буланд сууж байв. Гермиона, Рон хоёр гартаа ид шидийн яамнаас гаргасан «Шилжихэд гардаг түгээмэл алдаа болон түүнээс хэрхэн зайлсхийх вэ» гэсэн товхимол барьжээ. Тэд өнөөдөр оройн хоолны дараа шалгалт өгөх болохоор заавар сэтгэлийг нь тайвшируулсангүй. Тэгтэл булангийн цаанаас нэг охин гарч ирэхэд Рон Гермионагийн цаана нуугдахыг оролдов.

- Энэ Лаванда биш байна гэж Гермиона ядрангүй хэлэв.
- Аан сайн байна гээд Рон санаа амарлаа.
- Харри Поттер уу? Надад үүнийг чамд өгөхийг даалгалаа гэж охин хэлэв.
- Баярлалаа ...

Харри зүрх нь палхийн жижигхэн хуйлаастай цаасыг авлаа. Тэгээд охиныг дөнгөж сонсож чадахааргүй холдмогц,

- Дамблдор намайг дурсамж авахгүй бол ямар ч хичээл болохгүй гэсэн гэв.
- Магадгүй чиний амжилтыг сонирхох гэсэн юм болов уу? гэж Гермиона хэлэхэд Харри сэтгэлээр унан хуйлаасыг нээгээд Дамблдорын налуу бичгийн хэв биш харин жигд бус үсгээр сараачиж том нүүгэлтсэн толбоны улмаас учрыг нь олоход бэрхтэй болсон цаас байхыг харлаа.

Хүндэт Харри, Рон, Гермиона!

Өнгөрсөн шөнө Арагог үхлээ. Харри, Рон та хоёр түүнийг таних болохоор ямар гайхамшигтай гэдгийг нь мэднэ. Гермиона чамд ч гэсэн таалагдах байсныг мэдэж байна. Хэрвээ та нар өнөө орой сургуулиас гарч оршуулгад оролцвол надад их тус болох байна. Би түүний дуртай байсан үе нь болох харанхуйд оршуулах гэж байгаа. Би та нарт оройтох зөвшөөрөл байхгүй гэдгийг мэдэж байгаа ч жанчаа ашиглаж болох юм. Би үүнийг ганцаараа тэсч чадахгүй нь.

Хагрид

- Хараач гээд Харри зурвасыг Гермионад өглөө.
- Бурхан минь гэж Гермиона дуу алдаад түүн рүү түргэн харснаа Ронд дамжуулахад унших тусмаа улам үл итгэсэн янзтай болов.
- Тэр галзуурчихаж! гэж Рон уншиж дуусаад уурслаа. Тэр найздаа Харри бид хоёрыг идэхийг санал болгосон! Харин одоо тэгтэл биднийг аймшигтай үсэрхэг амьтны төлөө уйлахыг хүлээж байна!

- Зөвхөн энэ ч биш тэр шилтгээний хамгаалалт мянга дахин нэмэгдсэнийг хэр нь биднийг шөнө гарахыг гуйжээ. Хэрвээ биднийг барьдаггүй юмаа гэхэд томоохон асуудалд орох болно гэж Гермiona дэмжив.

- Өмнө нь бид түүнтэй уулзахаар шөнө очиж байсан гэж Харри хэлэв.

- Гэхдээ энэ чинь адил тохиолдол биш. Бид Хагридад туслахын тулд томоохон эрсдэлд орох болно гэхдээ эцсийн эцэст Арагог үхсэн шүү дээ. Энэ түүнийг аврах тухай ярьж байгаа юм биш ...

- Би тийшээ явах дургүй байна. Чи түүнтэй тааралдаж байгаагүй болохоор, үхсэн хойноо ч таалагдах зүйлээр бага амьтан гэдэгт итгээрэй, Гермiona гэж Рон дуугарлаа.

Харри ахин зурвасыг аваад бэхний нүүсэн толбыг харав. Цаасан дээр гарцаагүй нулимс дууссан байлаа.

- Харри чи түүн рүү явах гэж бодсоны ч хэрэггүй. Эрсдэлд орон сургуулийг орхих нь ухаангүй явдал.

Харри санаа алдлаа.

- Тиймээ, би мэднэ. Хагрид бидэнгүй Арагогыг оршуулчих биз.

- Тийм шүү гэж Гермiona санаа амран хэлээд,

- Сонсооч өнөөдөр бүгд шалгалттай болохоор уусмалын хичээл дээр бараг хүн байхгүй ... Ингэхэд чи ахин нэг удаа Слизнортыг ятгах гээд оролдоод үзвэл яасан юм! гэв.

- Чи тавин долоо дахь удаад нь аз тохионо гэж бодож байна уу? гэж Харри гашуунаар хэлэв.

- Аз! Энэ л байхгүй юу, Харри аз тохиох! гэж Рон гэнэтхэн дуу алдав.

- Чи юуны тухай яриад байна?

- Чамд аз авчирдаг уусмал бий шүү дээ.

- Рон, энэ чинь ... энэ чинь! гэж Гермiona мэгдэн хэлснээ,

- Тэгэлгүй яахав! Бид яагаад урьд нь энэ тухай бодож үзээгүй юм бол? гэлээ. Харри найзууд руугаа харлаа.

- Феликс Фелицис үү? Гэхдээ мэдэхгүй л байна ... би түүнийг өөр зүйлд хэрэглэх гээд хадгалж ...

- Юунд тэр вэ? гэж Рон шаардангуй сонирхов.

- Энэ хорвоо дээр дурсамжаас чухал юу байж болох вэ, Харри? гэж Гермiona асуулаа.

Харри хариулсангүй. Тэр жижигхэн лонхтой алтлаг уусмалыг тодорхойгүй төлөвлөгөө болох Жиннийг Динээс салгахад зориулан түүний шинэ найзтай болсон явдалд Рон баяртай байхаар хэрэглэхэд төсөөлж байлаа. Гэвч энэ бүхэн ой ухааных нь гүнд байсан учир үдэш унтаа сэрүүн хоёрын хооронд хэвтэх үед ...

- Харри? Чи энд байна уу? гэж Гермiona асуулаа.
  - Юу? Тиймээ, тэгэлгүй яахав. За яахав би өнөөдөр үдээс хойш Слизнорттой ярилцаж чадахгүй бол үдэш «Феликс Фелицисс»-ийг хэрэглэж ахин нэг удаа оролдлого хийе.
  - За тэгвэл шийдэгдэх шив дээ гэж Гермiona хэлээд өлмий дээрээ эргэлдэн,
  - Зорилготой ... шийдэмгий ... хянамгай гэж бувтналаа.
  - Үүнийгээ больж үз ... Дотор муухайрсан минь хангалттай ... түргэхэн надаас холд! гэж Рон гуйлаа.
  - Энэ Лаванда биш байна! гэж Гермiona хашаанд ахин хоёр охин гарч ирээд Рон агшин зуур түүний ард нуугдахад тэвчээргүйхэн хэлэв.
  - Янзтай гээд Рон Гермionaгийн мөрний цаанаас баяртайгаар цухуйж,
  - Чөтгөр гэж, тэд тийм ч их баяртай харагдахгүй байна, тийм үү? гэв.
  - Тэд бол эгч дүүс Монтгормерууд. Дүүдээ тохиолдсон явдлыг сонссон юм гэж Гермiona хэллээ.
  - Үнэнийг хэлэхэд би хэн нэгний хамаатанд тохиолдсон явдлаас болж бүр толгой эргэж гүйцлээ гэж Рон хэлэв.
  - Тэдний дүү руу хүн чоно дайрсан юм. Цуу яриагаар бол эх нь Үхэл залгигчдад туслахаас татгалзсан гэсэн. Ер нь бол хүү ердөө таван настай байсан болохоор аварч чадалгүй гэгээн Мунгогийн эмнэлэгт нас барсан гэсэн.
  - Үхсэн гэнээ? хэмээн Харри айдаст автан давтаад,
  - Гэхдээ хүн чоно алдаггүй өөрсдийнхөө нэг болгон хувиргадаг шүү дээ гэв.
  - Заримдаа алах үе байдаг юм. Би хүн чоно хэтэрхий улайрсан тохиолдолд тийм юм тохиолддогыг сонссон гэж Рон дасал болоогүй буурьтай өнгөөр хэлэв.
  - Хүн чоныг нь хэн гэсэн бэ? гэж Харри түргэн асуулаа.
  - Үүнийг Фенрир Сивый байсан гэж ярьцгааж байна.
  - Би мэдээд байсан юмаа. Хүүхдүүд рүү дайрах дуртай гаж донтон гэж Люпин түүнийг хэлсэн! хэмээн Харри уур хилэн автан хэллээ.
- Гермiona түүнийг ширүүн харцаар ажиглав.
- Харри чи дурсамжыг олох ёстой. Түүний тусламжтайгаар Волан-де-Мортыг зогсооно биз дээ? Тэгвэл энэ бүх аймшиг түүний хамт алга болно ...
- Шилтгээнд хонх дуугарахад айсан Рон, Гермiona хоёр үсрэн бослоо.
- Та хоёр чадна гэж Харри тэднийг үүднийг танхим руу орон шилжих шалгалт өгөх сурагчидтай нэгдэхэд хэлээд,
  - Амжилт хүсье! гэв.

- Чамд ч гэсэн! гээд Гермiona учиртай харахад Харри газар дорхи хонгил руу явлаа.

Уусмалын хичээл дээр ердөө Харри, Эрни болон Драко Малфой гэсэн гуравхан сурагч байлаа.

- Та нар шилжихэд хэтэрхий залуу хэрэг үү? Арван долоо хүрээгүй байгаа юм уу? гэж Слизнорт элэгсгээр хэлэв.

Бүгд толгой дохилоо.

- За бид нар цөөхүүлээ ч гэсэн хөгжилтэй байх болно. Ямар нэг хөгжилтэй юм чанацгаая гэж Слизнорт өөдрөг үргэлжлүүлэв.

- Гайхамшигтай санаа байна, ноёнтоон гэж Эрни алгаа үрэн хэлэв. Малфой инээмсэглэсэнгүй.

- Хөгжилтэй гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? гэж уурсангүй асуув.

- Намайг гайхуул гэж Слизнорт хэллээ.

Малфой таагүйхэн уусмалын хичээлийн сурах бичгээ нээв. Тэр бүхий л төрх байдлаараа хичээл хоосон цаг үрсэн явдал гэж бодож байгаа нь ойлгомжтой байлаа. Харри түүний зүг сурах бичгэн дээгүүрээ хараад Шаардлагатай өрөөнд байхгүйдээ харамсаж байна гэж бодлоо.

Түүний төсөөлөлөөс болоод ч тэрүү Малфой Тонксын адил турсан юм шиг санагдав. Арьс нь сүүлийн үед өдрийн гэрэл ховорхон үзсэнээс сааралдуу туяатай болжээ. Ямар ч сэтгэл хангалуун, хөөртэй, давилуун зан болон Хогвартс экспресс галт тэргэнд Волан-де-Мортын даалгаварын тухай ярихад байсан өөртөө итгэлтэй байдал ул мөргүй байлаа. Харрийн бодлоор энэ нь ганц л зүйлд байлаа. Даалгавар тааруухан биелэгдэж байгаа бололтой.

Энэ бодолдоо хөгжсөн Харри уусмалын хичээлийн сурах бичгийн эрлийз хунтайжын зассан Сэтгэл хөөргөдөг ундааны хуудсыг нээгээд хэрвээ түүнд таатай сэтгэгдэл төрүүлвэл дурсамжаа өгөхөөр ятгаж болно гэж бодлоо.

- За, гайхамшигтай гэж Слизнорт хагас цагийн дараа алгаа хавсраад Харрийн нарны гэрэлд туссан тогоо руу харлаа.

- Баяр хөөрийг би ойлгож байна? Харин юуны үнэр вэ? М-м-м ... та гааны үндэс нэмсэн биш биз? Хэв загварт баригдсан биш тэмдэглүүштэй зүйл байна, Харри ... Хүү минь энэ чиний толгойд хаанаас орсныг мэдэхгүй байгаа ч гайхамшигтай санаа байна ...

Харри эрлийз хунтайжын номыг хөлдөө тавьсан цүнх рүү түлхлээ.

- ... би таньд эхийн чинь авъяас байна гэж хэлсэн байхаа!

- Өө ... тиймээ, магадгүй л юм гэж Харри санаа амран хэлэв.

Эрни Харрийн тодорсон явдалд таагүйхэн сууж байв. Малфой Слизнорт түүний уусмалыг «боломжийн» гэж дүгнэсэнд гашуун төрхтэйгээр юмаа цүнхлэв.

Хонх дуугарахад Эрни, Малфой хоёр шууд явлаа.

- Ноёнтоон гэж Харри эхэлсэн ч Слизнорт түүнээс ондоо хэн ч үлдээгүйг хараад хаалганы зүг түргэн явлаа.

- Профессор ... Профессор, та миний уусмалыг ... гэж Харри араас нь цөхрөн хашгирав.

Гэвч Слизнорт ул мөргүй алга болжээ. Сэтгэлээр унасан Харри тогоогоо хоослоод цүнхэндээ хийн газар дорхи хонгилоос гарч Гриффиндорын амралтын өрөө рүү удаанаар өгслөө.

Рон, Гермиона хоёр түүнтэй зөвхөн орой л уулзав.

- Харри! Харри, би тэнцчихсэн! гэж Гермиона хөргөн нүхээр цухуйв уу үгүй юу хашгирлаа.

- Сайн байна! Харин Рон?

- Тэр ... Ер нь бол уначихсан гэж Гермиона шивнэхэд амралтын өрөөнд Рон баргар царайтай орж ирлээ.

- Үнэн хэрэгтээ түүнд аз тохиогоогүй шалгагч ардаа хөмсөгнийхөө хагасыг үлдээснийг нь анзаарчихсан юм ... Харин чи Слизнорттой юу болов доо?

- Баярлах зүйл юу ч алга гэж Харри Роныг ойртож ирэхэд бувтнаад,

- Чамд аз таараагүй ч найз минь зүгээр дээ дараагийн удаа өгч болно. Хамтдаа өгцгөөе гэлээ.

- Харж үзэж болох л байсан. Хөмсөгнийхөө талыг орхисон гэж бодоод үз дээ!

Ямар ялгаа байна! гэж Рон гунигтай хэлэхэд,

- Би түүний хатуу хандсан гэдгийг ойлгож байна хэмээн Гермиона тайвшируулахыг хичээлээ.

Оройн хоолны ихэнхи хэсгийг тэр гурав шилжих шалгалт авсан шалгагчыг харааж өнгөрүүлэхэд Рон яльгүй хөгжилтэй болов. Тэд Гриффиндорын амралтын өрөө рүү зүглэхдээ Слизнортын ой ухаанд хэрхэн нэвтрэх талаар ярилцлаа.

- Харри чи Феликс Фелицисийг ашиглах юм уу үгүй юм уу? гэж Рон шаардангуй асуулаа.

- Тэгсэн нь дээр бололтой. Гэхдээ надад бүгдээрээ шаардагдана гэж бодохгүй байна. Уусмал арван хоёр цаг үйлчилдэг болохоор ... зөвхөн ганц балга болох байх. Хоёр гурван цаг үүнд хангалттай.

- Үүний дараа чи өөрийгөө маш сайхнаар мэдэрнэ. Яг л юуг ч буруу хийж чадахгүй юм шиг гэж Рон хэлэв.

- Чи юуны тухай яриад байна? Нэг ч удаа үүнийг удаа хэрэглэж байгаагүй биз дээ! гэж Гермиона инээд алдав.

- Гэхдээ би үүнийг хэрэглэсэн гэж бодсон биз дээ? хэмээн Рон ойлгомжтой зүйл тайлбарлаж байгаа хүний маягтай хэллээ. Үүнд ямар ч ялгаа байхгүй байх.



Тэднийг ердөө хэдэн хормын өмнө Их танхимыг орхиход Слизнорт оройн хоолондоо орж ирж байсан бөгөөд удаан саатдагийг нь мэддэг учир гурвуулаа амралтын өрөөнд Харри Слизнортын өрөө рүү яваад эргэж ирэхийг нь хүлээх төлөвлөгөө зохиов. Нар хориотой ойн мододын оройг шүргэхэд тэд хэрэгтэй мөч боллоо гэж шийдээд Невилл, Дин, Симус нарыг амралтын өрөөнд байгаа эсэхийг шалгасан хойноо хөвгүүдийн унтлагын өрөөнд орлоо.

Харри чемоданаасаа боодол оймс дороос жижигхэн гялалзсан лонх гаргаж ирээд,

- За явцгаая гээд бяцхан лонхыг уруулдаа хүргэн балгалаа.
- Чи юу мэдэрч байна? гэж Гермiona шивнэв.

Харри шууд хариулсангүй. Түүний сэтгэл хөөрөн хязгааргүй боломжын мэдрэмж төрөхөд хорвоо дээр хийж чадахгүй зүйл юу ч байхгүй юм шиг санагдав ... Слизнортын дурсамжыг эзэмдэх нь боломжгүй биш ердийн зүйл мэт санагдах ажээ.

Харри хөл дээрээ үсрэн босоод итгэлтэйгээр инээмсэглэлээ.

- Гайхамшигтай. Зүгээр л гайхамшигтай. За ... би Хагрид руу явлаа.
  - Юу? хэмээн Рон, Гермiona хоёр мэгдсэн хоолойгоор зэрэг хашгирлаа.
  - Хүлээгээрэй, Харри чи Слизнорттой очиж уулзах ёстойгоо санаж байна уу?
- гэж Гермiona хэлэв.

- Үгүй. Би Хагрид руу очих ёстой энэ хамгийн дээр гэдгийг мэдэрч байна гэж Харри итгэлтэй хэллээ.

- Чи аварга том аалзны оршуулганд оролцохыг хамгийн дээр гэж байгаа юм уу? гэж Рон гайхширан асуулаа.

- Тийм л дээ. Би энэ шөнө тэнд очих ёстой гэдгээ мэдэрч байна гээд Харри үл үзэгдэх цуваа цүнхэндээ хийлээ.

- Үгүй гэж Рон, Гермiona хоёр зэрэг түгшин хэлэв.

- Сонсооч энэ үнэхээр Феликс Фелицис мөн үү? гэж Гермiona сэтгэл зовон хэлээд шилийг гэрэлд өргөн харснаа,

- Чамд арай өөр дүүрэн шингэнтэй лонх байсан юм биш биз ... гэв.

- Биеэ барих чадваргүй болгодог? гэж Рон санал болгоод Харри мөрөндөө хэрхэн цуваа нөмрөхийг харлаа.

Харри Гермiona, Рон хоёрыг улам түгшүүлэн хөхөрлөө.

- Надад итгэ, би юу хийхээ мэдэж байна. Ер нь бол Феликс мэдэж байна гээд хаалга руу итгэлтэй алхав.

Тэр үл үзэгдэх цуваа толгой дээгүүрээ нөмрөөд шат руу уруудахад Рон, Гермiona хоёр яаран араас нь дагалдав. Доошоо хүрсэн хойноо хаалга онгойлголоо.

- Чи түүнтэй юу хийж байгаа юм? гэж Лаванда Браун Харриг нэвт хараад хөвгүүдийн унтлагын өрөөнөөс гарч ирсэн Рон, Гермиона хоёр луу орилов. Харри амралтын өрөөний дундуур ухасхийхдээ Рон ямар нэг хэлхээ холбоогүй зүйл бувтнахыг сонслоо.

Хөргөн нүхэнд ойртоход урдаас нь Жинни, Дин хоёр ирэхийг хараад дундуур нь шурдхийн өнгөрөв. Ингэхдээ санамсаргүй Жинниг шүргэчихлээ.

- Битгий намайг түлхээд бай, Дин. Чи үргэлж намайг түлхэх юмаа гэж тэр уурсан хэлэв.

Харри Дины уцаарлангүй үгийг сонсохоос өмнө хөрөг агшин зуур хаагдав. Тэр том алхлан шилтгээний дундуур явлаа. Ямар ч гэтэх хэрэг байсангүй бөгөөд урдаас нь хэн ч тааралдсангүй явдалд Харри өчүүхэн ч гайхсангүй. Тэр өнөө үдэш Хогвартсын хамгийн азтай хүн байлаа.

Гэхдээ яагаад Хагрид руу явахаар шийдсэн талаар өчүүхэн ч төсөөлөл байсангүй. Бүгд яг л уусмал замыг нь хэдэн алхамын урд гийгүүлж байгаа мэт байлаа. Харри Слизнорттой хаана уулзахаа ойлгоогүй ч энэ зөв зам гэдэгт итгэлтэй байв. Үүдний хонгилд хүрээд Филч хаалга түгжихээ мартсан болохыг илрүүлэв. Харри түүнийг нээхэд ногооны үнэр ханхлан цэвэр агаар үнэртэж босгоор бүрэнхийд гарлаа.

Доод талын гишүүрт хүрэхэд Хагридынх руу ногооны талбайгаар дайрч явсан нь дээр гэж толгойд нь оров. Энэ нь ойрхон зам биш хэдий ч Харри үүнийг хийх ёстой гэдгээ мэдэж байв. Тэр шууд ногооны талбай руу чиглээд профессор Слизнорт, професср Стебльтэй ярилцаж байхыг хараад өчүүхэн ч гайхсангүй. Харри намхан чулуун хашааны ард зогсоод хоёр профессорын яриаг сонслоо.

- Надад зориулж цаг гаргасан явдалд баярлалаа, Помона. Ихэнхи зохиогчид тэднийг үдшийн бүрэнхийд цуглуулах нь үр дүнтэй гэсэн байдаг юм хэмээн Слизнорт эелдэгээр хэлэв.

- Өө, би ч гэсэн тэднийг зөвшөөрч байна. Таньд энэ хангалттай юу?

- Хангалттай, хангалттай гэж Слизнорт хэлэхэд Харри түүний атга дүүрэн навч барьсаныг нь ажиглалаа.

- Гуравдугаар дамжааныханд зориулан хэдэн навч нөөцлөх хэрэгтэй байна ...

Таньд сайхан үдшийг хүсье, маш их баярлалаа!

Профессор Стебль хүлэмжийн харанхуй цэцэрлэг рүү явахад Слизнорт Харрийн харагдахгүй зогсож буй зүг рүү чиглэв.

Харри агшин зуур түүнд үзэгдэх шийдвэр гаргаад үл үзэгдэх цуваа тайллаа.

- Үдшийн мэнд, профессор.

- Мерлиний сахлаар тангараглая, та намайг цочоочихлоо! гээд Слизнорт дороо хөшин зогссоноо,

- Та яаж шилтгээнээс гараа вэ? гэлээ.

- Филч хаалга түгжихээ мартсан байсангэж Харри хөгжилтэй хэлээд

Слизнортын барайхыг сэтгэл ханамжтай харлаа.

- Би түүнийг талаар гомдол бичнэ. Энэ эрхэм бидний аюулгүй байдлаас илүү хогийн савыг сонирхож байх шиг санагддаг юм ... Гэхдээ та энд юу хийж байгаа юм бэ, Харри?

- Ноёнтоон Хагридад тохиолдсон явдлаас болоод гэж Харри хэлээд үнэнийг хэлсэн дээр гэдийг мэдэж,

- Тэр их сэтгэлээр унаад байгаа. Гэхдээ профессор та хэнд ч хэлэхгүй биз? Би түүнд таагүй явдал тохиолдуулахыг хүсэхгүй байна л даа гэв.

Слизнортын царайд сониучирхсан төрх илрэв.

- Би хэнд ч ч хэлэхгүй гэж амлая. Тэгээд ч Дамблдор Хагридад бүрэн дүүрэн итгэдгийг мэддэг болохоор ямар ч аймаар зүйл хийхгүй гэж бодож байна.

- Түүнд ойд амьдардаг аварга том аалз байсан юм ... Аалз ярьж чаддаг байсан л даа тэгээд ...

- Би ойд Акрмантул байгаа гэж тухай цуу яриа сонссон гэж Слизнорт аяархан хэлээд харанхуй мододын зүг эргэн харснаа,

- Энэ үнэн үү? гэв.

- Тиймээ. Гэхдээ энэ аалз Арагог Хагридын тэжээсэн анхын аалз бөгөөд өнгөрсөн шөнө үхсэн болохоор их гашуудаж байгаа. Тэр оршуулганд хамт оролцохыг хүсээд би очихоор амалсан юм.

- Ямар уярмаар юм гэж Слизнорт бодлогоширон хэлээд том усархаг нүд нь алсад ойн сахиулын овоохойн гялалзах гэрэл дээр төвлөрч,

- Акрмантулын хор их үнэтэй ... ялангуяа үхсэн хойноо ч сайн хэвээр байдаг ... Мэдээж би Хагридыг илүү сэтгэлээр унагахыг хүсээгүй ч ... ямар нэг аргаар олж авдаг бол ... Миний бодлоор амьд Акрмантулын хорыг олох нь боломжгүй хэрэг л дээ ...

Слизнорт Харригаас илүү өөртэйгээ ярьж буй бололтой.

- Хэрвээ тэр хэнд ч хүртэхгүй үрэгдвэл аймшигтай гарз болно ... пинт нь зуун галлеон хүрэх боломжтой ... ний нуугүй хэлэхэд миний цалин хангалттай биш

...

Одоо л Харри юу хийх ёстойгоо тодорхой ойлголоо.

- Ер нь та хүсвэл надтай хамт явж болно шүү, профессор. Хагридад их таатай санагдах болно. Арагогыг үдэж гаргах хэрэгтэйг ойлгож байгаа биз дээ?

- Тэгэлгүй яахав гэж Слизнорт зөвшөөрөөд нүдээ урам зоригтой гялалзуулан,

- Тэнд уулзацгаая, Харри. Би хөөрхий амьтны төлөө уух хоёр лонх юм аваад очно ... мэдээж эрүүл энхийн төлөө биш л дээ ... Ямар ч гэсэн оршуулгын дараа салах ёс гүйцэтгэх хэрэгтэй биз дээ. Харин одоо би зангиагаа солихоос ийм үйл явдалд хэтэрхий тод байна гэв.

Тэр шилтгээн рүү яаран зүглэхэд Харри сэтгэл хангалуун Хагридынх руу явлаа.

- Ороорой гэж Хагрид хаалга нээн урдаа үл үзэгдэх цувтай зогсож байгаа Харриг хараад сөөнгөтөв.

- Рон, Гермiona хоёр ирж чадсангүй. Гэхдээ уучлалт гуйсан.

- Зүгээр дээ ... энэ чухал биш ... чи энд байгаа хойно, Харри ...

Хагрид чанга цурхирлаа. Тэр ханцуйдаа гутал өнгөлдөг хар даавуу шигалчуур уяж нүд нь улайн хавджээ. Харри түүнийг тайвшируулахаар хүрч чадах газар болох тохойг нь илэв.

- Бид түүнийг хаана ойршуулах юм бэ? Ойд уу?

- Үгүй дээ гээд Хагрид нулимсаа ханцуйгаараа арчиж,

- Түүнийг үхсэний дараа бусад аалзнууд намайг үүрэндээ ойртуулахгүй байгаа.

Тэд намайг зөвхөн түүний тушаалаар идэхгүй байсан байж! Чи үүнийг төсөөлж байна уу, Харри? гэв.

Үнэндээ бол «тийм» гэж хэлэх байлаа. Харри Роны хамт Акрмантултай нүүр тулгарах үедээ Арагог л зөвхөн Хагридыг идүүлэхэд саад болж байдаг гэдгийг тодорхой ойлгосон билээ.

- Урьд нь хэзээ ч ойд ийм байсангүй! гээд Хагрид толгойгоо сэгсэрч,

- Арагогийн биеийг тэндээс гаргах амаргүй байлаа ... тэд ердийнхөөрөө үхсэнээ иддэг болохоор ... Гэхдээ би түүнийг сайхан оршуулж ... зүй ёсоор нь үдэхийг хүссэн юм гэв.

Тэр ахин нулимс асгаруулахад Харри тохойг нь илж (уусмал ингэж хэлэх нь зүйтэй гэж заалаа),

- Хагрид би наашаа ирэх замдаа профессор Слизнорттой тааралдлаа гэв.

- Чи таагүй явдалд ороогүй биз дээ? Чамд орой болсон хойно шилтгээнээс гарах хориотой байдаг болохоор энэ миний буруу байх болно гэж Хагрид халамжлангүй харж асуув.

- Үгүй дээ тэр намайг ийшээ ирж байгааг сонсоод наашаа ирж Арагогыг сүүлчийн замд үдэхэд хүндэтгэл үзүүлэхийг хүссэн. Тэр зохимжтой хувцаслаж ... бас Арагогийн төлөө уух хэдэн шил дарс авчирна гэсэн.

- Юу гэнээ? хэмээн мэгдсэн Хагрид гайхлаа.

- Тэр ямар сайн хүн бэ. Би урьд нь Гораций Слизнорттой нэг их ярилцаж байсангүй ... Тэр хөгшин Арагогыг үдэхээр ирэхийг хүссэн гэнээ? Тиймээ түүнд таалагдах болно, Арагог ...

Харри хувьдаа Арагогт Слизнорт хангалттай хүрэлцэхүйц хоол болохоор илүү таалагдах байсандаа гэж бодоод овоохойн арын цонх руу очтол аймшиг төрөм үзэгдэл болох аварга том үхсэн аалз дээшээ харан атиралдан хэвтэхийг харлаа.

- Бид түүний энд оршуулах уу? Хагрид. Ногооны талбайд уу?
- Хулууны талбайн цаахан талд. Би хэдийн булшны нүх малтсан байгаа ... Түүний тухай хэдэн найрсаг үг хэлж хэдэн үг ... жаргалтай дурсамж гээд ойлгож байгаа биз дээ ...

Түүний хоолой чичирснээ бөхлөө. Хаалга цохиход Хагрид эргэн нээхдээ том нусны алчуурт нусаа нийлээ. Босгоор Слизнорт яаран орж ирэхдээ гартаа хэдэн лонх барьж бараан өнгийн зангиа зүүжээ.

- Хагрид таньд хүнд гарз тохиолдсон явдалд миний гүн эмгэнэлийг хүлээн авна уу гэж тэр гашуудсан хоолойгоор хэлэв.
- Таны зүгээс ямар эелдэг хэрэг вэ. Маш их баярлалаа. Бас Харриг шийтгээгүй явдалд баярлалаа.
- Миний толгойд тийм зүйл ороогүй гэж Слизнорт түүнийг итгүүлээд,
- Гашуудалтай шөнө байна, гашуудалтай шөнө ... ингэхэд золгүй амьтан хаа байна? гэлээ.
- Тэнд. За эхэлцгээх үү? гэж Хагрид чичирсэн хоолойгоор хэлэв.

Гурвуулаа ногооны талбай руу гарлаа. Сарны цайвар туяа мододын мөчрийг гэрэлтүүлж Хагридын овоохойны цонхноос тусах гэрэл шинэхэн ухсан овгор шорооны хажууд хэвтэх Арагогын бие дээр тусна.

- Гайхамшигтай үзэгдэл байна гэж Слизнорт аалзны толгой руу ойртоод хэлэв. Найман цагаан сүүн нүд тэнгэр лүү гөлийж, хөдөлгөөнгүй хоёр том хазуур сарны гэрэлд гялтагнана. Слизнорт том үстэй толгойг нь харахыг хүссэн мэт бөхийхөд Харри шил жингэнэх чимээ сонслоо.

- Түүний гадаад үзэсгэлэнг хүн бүр үнэлээд байдаггүй юм. Би таныг Арагог шиг амьтныг сонирхдог гэж мэдсэнгүй, Гораций гэж Слизнортын ард зогсож байсан Хагрид хэлээд нүднийхээ нулимсыг арчлаа.

- Сонирхдог гэнээ? Хүндэт Хагрид минь би тэдний биширдэг гээд Слизнорт алхам ухарлаа. Харри жанчин дор лонх гялсхийн орохыг харсан ч Хагрид нүдээ арчиж байсан болохоор юу ч ажигласангүй.

- За оршуулгаа эхлэх үү?

Хагрид толгой дохиод урагш алхав. Тэр аварга том аалзыг гараараа өргөөд шуухитнасаар харанхуй нүх рүү өнхрүүлэв. Аалз нүхний ёроолд аймшигтай тас няс хийн унахад тэр ахин нулимс асгаруулав.

- Тиймээ таньд одоо амаргүй байгааг мэдэж байна гээд Слизнорт Хагридын тохойг Харри шиг түшин,
- Та намайг хэдэн үг хэлэхийг зөвшөөрөх үү? гэв.

«Тэр Арагогоос дээд зэргийн сайн хор авсан бололтой» гэж Харри бодлоо. Слизнорт сэтгэл хангалуун инээмсэглээд нүхний ирмэгт дөхөн зогсож удаан бөгөөд сэтгэгдэл төрүүлэм хоолойгоор,

- Арахнидын хаан Арагог минь баяртай! Чамайг мэдэх хүн бүр үнэнч удаан нөхөрлөлийг чинь мартахгүй! Чиний бие өмхөрсөн ч сүнс чинь амьд хэвээр төрөлх ойдоо аалзныхаа торонд эргэлдэнэ. Чиний олон нүдтэй үр удам чинь хөгжиж цэцэглэн, чамтай нөхөрлөж байсан хүмүүс энэ гарзыг туулахад тулж түшин тайтгаруулах болно гэв.

- Энэ ... энэ сайхан боллоо! гээд Хагрид овоолсон бордоон дээр суугаад улам хүчтэй цурхирлаа.

- Тийшээ гээд Слизнорт шидэт саваагаа даллахад овоолсон том шороо агаарт хөөрөн аалзны үхсэн бие дээ бөглүү чимээ гарган буугаад гөлгөр толгод боллоо.

- Дотогш орж юм ууцгаая. Нөгөө талаас нь түш, Харри ... Ингээд ... Явъя, Хагрид ... та сайн байлаа ...

Тэд Хагридын ширээг тойрон суулаа. Оршуулгын үеэр сагсанд нуугдаж байсан Соёт тэдэн рүү дөхөн ирээд аяархан самардаж хүнд толгойгоо ердийнхөөрөө Харрийн өвдөг дээр тавилаа. Слизнорт нэг лонхтой дарсаа задлангаа,

- Би түүний бүгдийнх нь хорыг шалгасан гэж Харрид хэлээд эхний лонхтойг Хагридын хувин шиг аяганд дүүргэн өглөө.

- Таны хөөрхий найз Рупертэд тохиолдсон явдлын дараа би үйлчлэгчээр лонхтой бүрээ амсуулдаг болсон.

Харри Гермiona энэ тухай сонсох юм бол яахыг төсөөлөөд хэзээ ч хэлэхгүй байхаар шийдлээ.

- Үүнийг чамд, Харри ... харин энэ минийх гээд Слизнорт хоёр дахь лонх дарсаа хоёр аяганд хуваан хийгээд аягатайгаа өргөж,

- За, Арагогын төлөө гэв.

- Арагогын төлөө гэж Хагрид, Харри хоёр зэрэг давтлаа.

Слизнорт, Хагрид хоёр аягатайгаа том балгав. Харри өмнөхийн адил Феликс Фелицсийн нөлөөн дор ууж болохгүйгээ мэдэж байсан тул балгасан дүр эсгээд аягатайг ширээн дээр тавилаа.

- Би түүнийг өндөг байхад нь авснаа санаж байна. Ямар жижигхэн байсан гээч.

Хав шиг хэмжээтэй байсан.

- Ямар хөөрхөн юм бэ гэж Слизнорт хэлэв.

- Түүнийг сургуульд аваачиж хонгилд ...

Хагридын царай гэнэт барайхад Харри яагаад гэдгийг нь мэдэж байв. Том Реддл Хагридыг нууц өрөөг онгойлгосон юм шиг зохион байгуулан буруутгаад сургуулиас

хөөлгөсөн билээ. Гэвч Слизнорт Хагридыг сонсоогүй бололтой адраас өлгөөтэй олон тооны зэс сав суулга дунд байх нүд гялбам урт цагаан үсийг харлаа.

- Энэ санамсаргүй ганц эвэртийн үс биш биз, Хагрид?
- Тийм л дээ. Сүүлнээс нь унаад ойн бутанд өлгөгдсөн байсан юм гэж Хагрид хайхрамжгүй хэлэв.
- Хонгор найз минь та тэдний ямар үнэ хүрэхийг мэдэх үү?
- Би тэднээр амьтан барьдаг уяа хийдэг гээд Хагрид мөрөө хавчив. Маш хүчтэй болохоор ... сайн болдог юм.

Слизнорт ахин нэг удаа аягатайгаасаа том балгаад овоохойг анхааралтай нэгжин харахад Харри царсан торхтой балын ундаа, хэвжүүлсэн хан боргоцой, хамба хилэн хүрэм болгож хувиргахаар зүйл хайж байгааг нь ойлгож байлаа. Дараа нь тэр Хагридын аягыг өөрийнхтэйгээ дүүргээд ойд ямар амьтан амьдардаг тухай ярилцлаа. Хагрид уух юмны нөлөөн дор нойтон нүдээ арчихаа болиод Слизнортын сонирхсон асуултанд баяртайгаар хариулж лукотрусын тухай урт яриа дэлгэв.

Тэгтэл Феликс Фелицис Харриг дотроос нь нударч Слизнортын уух юм дуусч байгааг харууллаа. Одоо хүртэл Харри нэг ч удаа Эргэн дүүргэх шидийг чанга хэлэлгүй ашиглаж үзээгүй болохоор өнөөдөр бүтнэ гэж бодоогүй ч инээмсэглэн шидэт саваагаа хоосон лонх руу чиглүүлээд дарсаар дүүргэхэд бие биендээ хууль бусаар лууны өндөг оруулах тухай ярилцаж байсан Слизнорт, Хагрид хоёр ажигласангүй.

Цагийн дараа Хагрид, Слизнорт хоёр Хогвартсын төлөө, Дамблдорын төлөө ... үйлчлэгчийн хийсэн дарсны төлөө гээд олон тооны хундага өргөлөө.

- Харри Поттерын төлөө! гэж Хагрид хүнгэнүүлээд хувин шиг аяганыхаа дөрөвний нэг дүүрэн байсан дарсыг цалгиулан сахал руугаа асгачихлаа.
- Зүйтэй! гэж хэл нь ээдэрсэн Слизнорт дуу алдаад,
- Парри Оттерын төлөө, сонгогдсон хүүгийн төлөө ... тэгээд аягатайгаа хоосоллоо.

Хагрид ахин нулимс мэлтэлзүүлж Слизнортод ганц эвэртийн бүтэн сүүлээ өгөхөд авч халаасандаа далд хийгээд,

- Нөхөрлөлийн төлөө! Өгөөмөр сэтгэлийн төлөө! Арван галлеон хүрэх үсний төлөө! гэв.

Удалгүй Хагрид Слизнорттой мөр мөрөө түшин суугаад Одо нэртэй үхсэн шидтэний тухай гунигтай дуу удаанаар аялав.

- Ай даа тэд залуудаа үхсэн нь сайн байна гээд Хагрид гэнэтхэн ширээ дэрлээд нүд нь сөлийлээ. Слизнорт тэр хооронд дуулсаар байлаа.
- Миний аав ... тиймээ чиний ээж аав хоёр ч гэсэн, Харри.

Хагридын нүдэнд ахин нулимс цийлэгнэхэд Харрийн гараас бариад сэгсэрлээ.

- Миний мэдэх хамгийн сайн шидтэнгүүд байлаа тийм залуудаа ... би хэзээ ч мэдсэнгүй ... аймшигтай юм ... аймшигтай ...

Слизнорт гүнгэнэв.

Одо баатар гэртээ харьжээ Тэнд хүүхэд насаа өнгөрүүлжээ Малгай нь дэргэд нь хэвтэнэ

Саваа нь хугарчээ уйтгартай байлаа

- Аймшигтай гэж Хагрид бувтнаад сэгсгэр толгойгоо гаран дээрээ тавьж агшин зуур унтаад чанга хурхирлаа.

- Өршөөгөөрэй. Гэхдээ би уянгын дууг тэсдэггүй юм.

- Хагрид таны дууны тухай яриагүй. Тэр миний эцэг эхийн үхлийн тухай ярьсан гэж Харри аяархан хэлэв.

- Өө гээд Слизнорт хэрхэрснээ,

- Аан, тийм л дээ. Энэ үнэхээр аймшигтай байсан. Аймшигтай ... аймшигтай ... гэснээ өөр хэлэх үг олдсонгүй бололтой аягаа дүүргэснээ,

- Та энэ тухай санадаггүй байх тийм үү, Харри? гэж эв хавгүйхэн сонирхов.

- Үгүй. Тэднийг нас барахад би ердөө ойтой байсан гээд Харри чанга хурхирч байгаа Хагрид руу харснаа,

- Гэвч би энэ талаар багагүй мэддэг юм. Аав эхэлж үхсэн. Та үүнийг мэдэх үү? гэв.

- Үгүй гэж Слизнорт чимээгүйхэн хэлэв.

- Тиймээ ... Волан-де-Морт түүнийг алаад дараа нь ээж рүү очсон.

Слизнорт бүх бие нь чичирснээ айдаст автсан харцаа Харригаас салгаж чадсангүй.

- Тэр ээжид замаасаа холдохыг тушаасан гэж Харри өрөвдөх сэтгэлгүй үргэлжлүүлэв.

- Тэр өөрөө надад түүнийг үхэх хэрэггүй байсан гэж хэлсэн. Түүнд зөвхөн би хэрэгтэй байж. Ээж зугтаж аварагдаж болох байлаа.

- Ай, бурхан минь. Тэр ... тэр чадах байж ... ямар аймшигтай юм бэ ...

- Тиймээ, аймшигтай гээд Харри хоолойгоо бараг шивнэх шахам болов.

- Тэгээд ээж байрнаасаа хөдөлсөнгүй. Аав намайг үхэхийг хүсээгүй болохоор хэдийн үхсэн байсан. Ээж Волан-де-Мортоос гуйсан ч ... хариуд нь ердөө хөхөрсөн ...

- Хангалттай! гэж Слизнорт гэнэтхэн дуу алдаад чичирсэн гараа өргөв.

- Хонгор хүү минь, хангалттай. Би хөгшин хүн ... би сонсох хэрэггүй ... сонсохыг хүсэхгүй байна ...

- Би мартчихаж. Та түүнд хайртай байсан биз дээ? гэж Харри Феликс



Филицисийн нөлөөн дор худал хэлэв.

- Хайртай байсан гэнээ? хэмээн Слизнорт асуугаад нүдэнд нь нулимс дүүрч,
- Би түүн шиг хайрлаж болох хүнийг төсөөлөхгүй юм байна. Маш зоригтой, хөгжилтэй ... энэ аймшигтай байсан ...
- Тэгвэл хүүд нь тусалж болохгүй гэж үү. Тэр миний төлөө амиа өгсөн байхад та дурсамжаа хүртэл өгөхийг хүсэхгүй байна гэж үү.

Овоохойг Хагридын чанга хурхиралт дүүргэв. Харри Слизнортын нулимстай нүд рүү харц салгахгүй харахад уусмалын багш тэнхэлгүй болоод харц буруулав.

- Битгий тэгж ярь. Энэ тийм биш ... Хэрвээ энэ таньд туслах бол тэгэлгүй яахав ... гэвч энэ ямар ч хувь заяаг өөрчилж чадахгүй ...
- Чадна гэж Харри тод чанга хэлэв.
- Дамблдорт мэдээлэл хэрэгтэй. Надад мэдээлэл хэрэгтэй.

Тэр аюулгүй байдалд байгаагаа сайн мэдэж байлаа. Феликс түүнд Слизнорт өглөө яриагаа огт санахгүй гэдгийг сануулж байв. Харри урагш яльгүй бөхийгөөд Слизнортын нүд рүү цоо ширтэв.

- Би сонгогдсон. Би түүнийг алах ёстой. Надад таны дурсамж хэрэгтэй байна. Слизнорт хүчтэй цонхийгоод духан дээр нь хөлс гялалзав.
- Та сонгогдсон гэж үү?
- Тэгэлгүй яахав гэж Харри тайван хэлэв.
- Гэвч ... хүндэт хүү минь ... та их зүйл гуйж байна ... та надаас устгахад туслахыг гуйж байгаа ч ...
- Та Лили Эвансын алуурчингаас салахыг хүсэхгүй байна уу?
- Харри, Харри, мэдээж би хүсч байгаа ч ...
- Та түүнийг тусалсныг чинь мэднэ гэж айж байна уу? Слизнорт хариулсангүй ч үхтлээ айсан харагдав.
- Миний ээж шиг зоригтай бай, профессор ...

Слизнорт махлаг гараа өргөөд чичирсэн хуруугаараа уруулаа дарахад агшин зуур том хүүхэд адил болов.

- Надад бахархах зүйл алга. Би ... энэ дурсамжыг үзүүлэхээс ичиж байна. Би тэр өдөр аймшигтай хор учруулсан санагдаж байна ...
- Та надад дурсамжаа өгсөнөө хийсэн бүх зүйлээ цагаатгах болно. Энэ маш зоригтой хүнлэг алхам байх болно.

Хагрид нойрондоо агзасхийснээ ахин хурхирлаа. Слизнорт, Харри хоёр бие биенээ лааны дөлд ширтлээ. Удтал чимээгүй болоход Феликс Фелицис Харрид үүнийг таслалгүй хүлээх хэрэгтэйг санууллаа.

Дараа нь Слизнорт маш удаанаар халааснаасаа шидэт саваа гаргаж ирлээ. Тэгээд нөгөө гараараа жанчнаасаа жижигхэн хоосон шил гаргаж ирэв. Тэр Харри руу харсаар савааны үзүүрийг чамархайдаа хүргээд татахад дотроос нь урт мөнгөлөг дурсамж үзүүр даган сунан гарч ирэв. Утас сунан сунасаар саваанаас зүүгдэн гялалзав. Слизнорт түүнийг шилэнд хийхэд эргэлдсэнээ хий шиг хуйлрав. Тэр чичирсэн гараараа шилийг ширээн дээгүүр Харри руу түлхэв.

- Их баярлалаа, профессор.

- Та сайн хүү гээд профессор Слизнортын том хацар дээгүүр нулимс урсан сахал руу нь оров.

- Таны нүд ... Би зөвхөн үүнийг хараад миний тухай хэтэрхий муугаар бодохгүй байхыг гуйя.

Ингээд профессор бас толгойгоо гаран дээрээ тавиад гүнзгий амьсгал аван унтлаа.

## БҮЛЭГ 23: КРЕСТРАЖУУД

Харри шилтгээн рүү буцахдаа «Феликс Фелицис»-ийн үйлчлэл гарч эхэлж байгааг мэдрэв. Үүдний хаалга түгжээгүй хэвээр байсан ч гурван давхарт Пивзтэй тулгараад арай ядан товч зам руу бултаж амжлаа. Хөргөн нүхэнд хүрээд үл үзэгдэх цуваа тайлахдаа тарган хатагтай ааш муутай байхыг хараад өчүүхэн ч гайхсангүй.

- Одоо чинийхээр бол цаг хэд болж болж байгаа хэрэг вэ?
- Надад үнэхээр харамсалтай байна ... нэг чухал юманд явах шаардлага гарсан юм ...
- Шөнө дунд нууц үг солигдсон болохоор хонгилд унтах хэрэгтэй болж дээ, ойлгов уу?
- Та тоглож байгаа байлгүй дээ! Хэн шөнө дунд нууц үг солино гэж?
- Хэрвээ энэ чамд таалагдахгүй байгаа бол явж захиралтай ярилц. Тэр аюулгүй байдлыг чангатгасан.
- Гайхалтай гэж Харри гашуунаар хэлээд нүцгэн шал руу харж,
- Маш гайхалтай. Хэрвээ Дамблдор энд байгаа бол би түүн дээр очиж хүссэн зүйлийг нь биелүүлсэнээ ... гэв.
- Тэр энд байгаа. Профессор Дамблдор сургуульд цагийн өмнө эргэж ирсэн гэх хоолой ард нь сонсогдов.

Бараг толгойгүй Ник Харрийн зүг толгойгоо том захан дээрээ санжигнуулан хөвөн ирлээ.

- Би энэ тухай цус бароноос сонссон. Тэр Дамблдорын ирэхийг харсан гэсэн. Тэгээд түүнийг ядарсан явдалд их баяртай байсан гэж Ник хэллээ.
- Тэр одоо хаана байгаа юм бэ? гэж Харри асуугаад зүрх нь баяртай цохилохыг мэдрэв.
- Тэр одон орны цамхаг дээр дуртай ажил болох гинжээ хангинуулан гасалж байгаа ...
- Үгүй дээ, цуст барон бишээ ... Дамблдор!
- Аан, өрөөндөө байгаа. Барон түүнийг хэлэхдээ ямар нэг ажил дуусгах ёстой гэсэн ...
- Тиймээ ёстой гэж Харри хэлээд цээжинд нь Дамблдор амжилтынхаа тухай хэлэх баяртай хүсэл төрөв. Тэр эргээд гүйхдээ араас нь тарган хатагтайн хашгирахыг тоосонгүй.
- Эргээд ир! За яахав, би худал хэлсэн юм! Зүгээр л намайг сэрээсэн явдалд уурлаад! Нууц үг өмнөхийн адил «туузан хорхой!»

Гэвч Харри хэдийн хонгилоор нисээд хэдэн хормын дараа Дамблдорын луунд

«шоколадтай эклер» гэж хэлэхэд үсрэн холдож эргүүлгэн шатанд хүрэх зам нээгдлээ.

- Ороорой гэж түүнийг хаалга цохиход Дамблдор ядрангуй хэлэв.

Харри хаалга түлхлээ. Түүний өмнө Дамблдорын өрөө үргэлжид байдаг шигээ байх агаад зөвхөн цонхны цаана харанхуй тэнгэрт одод түгсэн байлаа.

- Бурхан минь, Харри! Ийм оройтсон хойно юугаар туслах билээ? гэж Дамблдор гайхлаа.

- Ноёнтоон ... би түүнийг олсон! Слизнортын дурсамжыг авсан!

Харри шилэн саваа гаргаад Дамблдорд үзүүлэв. Агшин зуур захирал мэгдсэн царайтай болов. Тэгснээ царайд нь нүүр дүүрэн инээмсэглэл тодорлоо.

- Ямар гайхамшигтай мэдээ вэ, Харри! Маш сайн байна! Би чамайг чадна гэдгийг чинь мэдэж байсан юм!

Дамблдор харваас цаг оройтсоныг мартав бололтой ширээгээ яаран тойроод гэмтсэн гараараа Слизнортын дурсамжыг авч гүн ухааны цүнхээлтэй шүүгээ руу очлоо.

- Харин одоо гээд тэр чулуун суулгыг ширээн дээр тавиад шилтэй шингэнээ хоосолж,

- Эцэст нь бидний харах цаг боллоо. Түргэлээрэй, Харри! гэв.

Харри дуулгавартай гүн ухааны цүнхээл рүү бөхийгөөд хөлөн дороос нь шал хөндийрэхийг мэдэрлээ. Тэр ахин харанхуй нэвтлэн нисэж олон жилийн өмнөх Гораций Слизнортын өрөөнд газардав.

Тэнд ихэд залуужсан өтгөн гялалзсан цайвар үс, сахалтай Слизнорт ахин тухтай түшлэгтэй өндөр сандалд суугаад хөл нь хилэн дэр дээр тавиад байж нэг гартаа дарстай аяга, нөгөө гартаа хайрцаг хэвжүүлсэн хан боргоцой барьжээ. Түүнийг тойроод арваад хөвгүүд байсны дотор хуруундаа Марвологийн хар чулуутай алтан бөгж зүүсэн Том Реддл байлаа.

Дамблдор Харрийн дэргэд газар дахь үед Реддл,

- Ноёнтоон, профессор Вилкост тэтгэвэртээ гарч байгаа гэсэн үнэн үү? гэв.

- Том минь, Том минь би энэ тухай мэдэх байсан ч чамд хэлэхгүй байсан гэж

Слизнорт зэмлэнгүй чихэртэй хуруугаа гозойлгон хэлээд нүд ирмэж,

- Би чамайг багш нарын тэн хагас нь мэдэхгүй мэдээллийг хаанаас авсан болохыг чинь мэдэхгүй юм гэв.

Реддл инээмсэглэхэд үлдсэн хөвгүүд инээд алдан түүнийг бахадсан харцаар ажиглав.

- Таны ер бусын авъяас хэнтэй яаж харьцахаа мэдэх юмаа ... Ингэхэд хан боргоцойнд чинь баярлалаа таны зөв, би үүнд дуртай.

Хэдэн хөвгүүд ахин инээд алдлаа.

- Итгэлтэйгээр хэлэхэд та хорин жилийн дараа яамны сайдын суудалд хүрэх байх шүү. Арван таван жилийн дараа хэрвээ хан боргоцой илгээсэн хэвээр байвал надад ид шидийн яаманд томоохон холбоо бий болох юм.

Том Реддл инээвхийлэхэд бусад хөвгүүд чанга хөхрөлдөв. Харрид тэр бусдаасаа хамгийн ахмад нь биш ч бүгд түүнийг удирдагч гэж бодож байх шиг санагдав.

- Улс төрийн зүтгэлтэн болно гэж бодохгүй байна, ноёнтоон. Миний гарал үүсэл тийм чухал ажилд тохирохгүй гэж Реддл инээд намдахад хэлэв.

Хоёр хүү сэтгэл хангалуун инээвхийлэн харц солилцлоо.

- Утгагүй юм. Таньд алдартай шидтэнгийн гэр бүлээс гаралтай авъяас байгаа гэдэг нь тодорхой байна шүү дээ. Үгүй дээ, та цаашаа явах болно, Том минь би сурагчдынхаа тухайд хэзээ ч алдаж байгаагүй юм шүү.

Слизнортын ширээн дээр байсан алтан цаг арван нэгэн цагийг заан жингэнэлээ.

- Бурхан минь ийм оройтсон гэж үү? гэж Слизнорт гайхан дуу алдаад,

- Та нар явсан нь дээр байх, хөвгүүд минь тэгэхгүй бол таагүй явдалд орооцолдох болно. Лестрейнж би таныг маргааш өглөө зохион бичлэгээ өгөхгүй бол хичээлийн дараа үлдээхэд хүргэнэ шүү. Энэ ч гэсэн таньд хамаатай Эйвери гэв.

Хөвгүүд өрөөг орхин гарахад Слизнорт сандлаасаа босоод ширээн дээр байсан хоосон шилэн аягыг авлаа. Ард нь чимээ гарахад эргэн харвал өрөөний дунд Том Реддл зогсож байв.

- Яарсан нь дээр шүү, Том. Та ч гэсэн унтах ёстой цагаас гадуур явах ёсгүй.

Ингэхэд та чинь ахлагч биз дээ ...

- Ноёнтоон, би танаас юм асуух гэсэн юм.

- Тэгвэл асуу хүү минь, асуугтун ...

- Ноёнтоон, би таныг крестражын тухай мэдэх байх гэж бодлоо? Слизнорт бүдүүн хуруундаа аягаа атгасан хэвээр алмайран харлаа.

- Хар урлагаас хамгаалах хичээл дээр бие даасан ажил хийх гээ юу?

Гэвч Харри Слизнорт үүнийг сургуулийн ажилтай ямар ч хамаагүй гэдгийг мэдэж байгаад мөрийцөхөд бэлэн байлаа.

- Яг ч тийм бишээ, ноёнтоон. Би энэ сэдвээр зарим зүйл уншсан ч сайн ойлгосонгүй.

- Таньд Хогвартсын номон дундаас крестражын тухай уншихын тулд ихээхэн хүч чармайлт хэрэгтэй дээ, Том. Энэ бол хар шидийн, жинхэнэ хар шидийн зүйл байгаа юм.

- Гэхдээ та түүний тухай мэдэж байгаа биз дээ? Тань шиг шидтэн ...

Өршөөгөөрэй та энэ тухай надад ярьж чадахгүй биз ... Би хэн нэгэн энэ тухай ярьж чадах бол таныг л байх гэж бодлоо ... Тэгээд асуухаар шийдсэн юм.

«Тэр үүнийг маш сайн гүйцэтгэлээ» гэж Харри бодов. Эргэлзэж тээнэгэлзсэн өнгө хайхрамжгүй байдал үгүй байлаа. Харваас энэ мэдээлэл Реддлд маш их хэрэгтэй нь илэрхий байсан тул Слизнорттой ярилцахаар хэдэн долоо хоногийн өмнөөс бэлдсэн бололтой.

- Юу гэвэл гээд Слизнорт түүний зүг харалгүй хэвжүүлсэн хан боргоцойны хайрцагны дээдэх туузаар оролдонгоо,

- Мэдээж би таны зан байдлаас үзэхэд үүний тухай ярихад хэнд ч гэм болохгүй байх гэж бодож байна. Нэг үгээр хэлбэл крестраж гэдэг нь хүний сүнснийхээ хэсгийг нуусан биет зүйл юм гэв.

- Гэхдээ би үүнийг яаж хийхийг ойлгохгүй байгаа юм, ноёнтоон. Түүний хоолой хянамгай байсан ч Харри сэтгэл догдлолыг нь мэдэрлээ.

- Та сүнсээ хуваагаад биеэсээ гадуур бодит зүйлд нуулаа гэж бодъё. Үүний дараа хэн нэгэн таны бие рүү дайрч тэр ч байтугай устгасан ч үхэх боломжгүй. Таны сүнсний хэсэг газар дэлхийтэйгээ холбоотой үлдээд ямар ч аюулд учрахгүй. Гэхдээ нэг тиймэрхүү хэлбэрт орно л доо ...

Слизнортын царай үрчийхэд Харри бараг хоёр жилийн өмнө сонссон үгээ саналаа.

«Би биеэсээ гарч сүнс гэхээсээ илүү хий үзэгдэл шиг болсон ч ... амьд хэвээр үлдсэн».

- Үүнийг цөөхөн хүмүүс хүсдэг юм, Том. Маш цөөхөн шүү. Тэд үхлийг илүү эрхэмлэдэг юм.

Реддлийн аль болох ихийг мэдэх гэсэн хүсэл харцанд нь илрэхэд шуналаа нууж чадахаа болилоо.

- Сүнсээ яаж хуваах вэ?

- Юу гэвэл та сүнс бүрэн бүтэн байх ёстой гэдгийг ойлгож байгаа байх.

Түүнийг хүчээр хуваах нь байгалийн эсрэг зүйл юм.

- Гэхдээ түүнийг яаж хийх юм бэ?

- Хорсол хилэн ... дээд зэргийн хорсол хилэн. Аллага хийх. Аллага сүнсийг зэрэмдэглэдэг. Крестраж бүтээхээр бодсон шидтэн үүнийг ашиглан сүнсээ салгадаг юм ...

- Салгах гэнээ? Яаж?

- Энэ шившлэгийг надаас битгий асуу, би мэдэхгүй! гээд Слизнорт толгойгоо шумуул хөөж байгаа хөгшин заан аятай сэгсрээд,

- Би үүнийг хийсэн хүнтэй төстэй байна уу? Алуурчин шиг харагдаад байна уу? гэв.

- Үгүй, ноёнтоон мэдээж үгүй. Өршөөгөөрэй би таныг гомдоохыг хүсээгүй гэж Реддл яаран хэлэв.

- Та юу ярина вэ юуны чинь гомдол. Иймэрхүү зүйлийн тухай цөөхөн хүн сонирхдог юм ... Шидтэнгүүд үргэлж шидийн энэ талд татагддаг байсан гэж Слизнорт баргар хэлэв.

- Тиймээ, ноёнтоон. Гэхдээ би нэг л зүйлийг ойлгохгүй байна ... Надад нэгээс илүү крестраж үүсгэх нь сонирхолтой байна л даа? Сүнснийг хэд хэдэн хэсэгт хувааж болох уу? Жишээлбэл илүү хүчирхэг шидийн тоо болох долоод хуваавал ямар вэ?

- Мерлиний сахлаар андгайлъя, Том! Долоо гэнэ шүү! Үнэндээ ганц хүнийг ч тийм зүйлийн төлөө алж болно гэж үү. Тиймээ дурын тохиолдолд ... сүнсээ хоёр хэсэг хуваах гэдэг нь муу зүйл байтал ... түүнийг долоо хуваана гэдэг чинь!

Тэгснээ Слизнорт Реддл рүү хэзээ ч харж байгаагүйгээрээ түгшин харахад Харри түүний энэ ярианд оролцсоноо харамсаж байгаа болохыг нь ойлголоо.

- Мэдээж бидний яриа ердөө таамнал төдий юм. Цэвэр сургалтын ...

- Тэгэлгүй яахав, ноёнтоон гэж Реддл яаран хэлэв.

- Гэхдээ ямар ч гэсэн Том бидний яриаг нууц болгон хадгалаарай. Хүмүүс бидний энэ тухай ярилцсаныг мэдвэл таагүй байх болно. Ойлгож байна уу, Хогвартсад энэ сэдэв хориотой байдаг юм. Ялангуяа Дамблдор энэ тухай мэдэх юм бол ...

- Би энэ тухай хэлэхгүй хэнд ч хэлэхгүй, ноёнтоон гэж Реддл амлаад өрөөг орхиход Харри түүний царайд шидтэн болохоо анх удаа мэдсэн үеийнх шиг ухаангүй баяр хөөр тодрохыг зэрвэс харлаа.

- Баярлалаа, Харри. Бид явах болж гэж Дамблдор аяархан хэлэв.

Харриг өрөөний шалан дээр газардахад Дамблдор хэдийн ширээндээ суужээ. Харри бас суугаад түүний ярихыг хүлээлээ.

- Би маш эртнээс энэ дурсамжыг олж авах найдлага тавьсан юм. Тэр миний онол болон хийж байгаа зүйл зөв гэдгийг батлан бидний өмнө ямар урт зам хүлээж байгааг үзүүлэх байлаа ...

Харри гэнэтхэн хананд өлгөөтэй өмнөх захирлын хөргүүд унталгүй тэдний яриаг анхааралтай сонсож байгаа болохыг харав. Махлаг биетэй улаан хамартай шидтэн чихэндээ сонсголын бүрээ барьсан байлаа.

- За, Харри чамайг бидний сонссон зүйлийн учрыг ойлгосон гэдэгт итгэлтэй байна. Чамтай адил насанд хүрэхэд хэдхэн сар дутуу байхдаа Том Реддл бүх хүчээ гарган үхэшгүй мөнх болох замыг эрж байсан.

- Та үүнийг бүтсэн гэж бодож байна уу, эрхэмээ? Тэр крестраж бүтээсэн болов уу? Ийм учраас намайг дайрсныхаа дараа үхээгүй юм уу? Түүний сүнсний нэг хэсэг аюулгүй газар байгаа юм уу?

- Энэ нь ганцаас илүү байх боломжтой. Чи Волан-де-Мортын үхлээс зугтахын тулд олон удаа аллага хийн сүнсээ хуваахад бэлэн байж ганцаас илүү крестраж үүсгэх талаар Горацийн бодлыг онцгойлон сонирхож байгааг сонссон. Үүнийг тэр

ямар ч номон дээрээс олж чадахгүй байсан. Миний мэдэж байгаагаар Волан-де-Мортоос өөр ямар ч шидтэн сүнсээ хоёроос илүү хувааж байсан түүхгүй гээд Дамблдор чимээгүй болж бодлоо цэгцлэн эрэгцүүлснээ,

- Дөрвөн жилийн өмнө би Волан-де-Мортын сүнсээ хуваасан гэдгийг жинхэнэ баталгаа болох зүйлийг авсан гэв.

- Хаана? Яаж? гэж Харри асуулаа.

- Надад түүнийг чи өгсөн, Харри. Нууц өрөөг яаж онгойлгох тухай заавар бичсэн Реддлийн тэмдэглэлийн дэвтэр.

- Би ойлгосонгүй, эрхэмээ.

- Хэдийгээр би Реддлийг тэмдэглийн дэвтрээс гарч ирэхийг хараагүй ч чи миний хэзээ ч хараагүй зүйлийг минь зураглан үзүүлсэн. Энгийн дурсамж өөрөө бодож чадна гэж үү? Дурсамж охины амьдралыг сорж гар дороо байлгаж чадах байсан уу? Үгүй дэвтэрт үүнээс илүү муу ёрын зүйл болох сүнсний хэсэг байсанд итгэлтэй байна. Өдрийн тэмдэглэл крестраж байсан. Гэхдээ эндээс олон асуулт хариултын хамт урган гарч байна. Намайг юунаас илүү түгшүүлсэн зүйл гэвэл тэмдэглэл хамгаалах хэрэгсэл болсон байлаа.

- Тэгсэн ч гэсэн би ойлгохгүй байна.

- Тэр крестражын үүргийг биелүүлж байж. Нэг үгээр хэлбэл сүнсний хэсэг дотор нь аюулгүй нуугдаад эзнээ үхлээс хамгаалж байсан. Тэгээд ч Реддл сүнсний нэг хэсгийг шингээсэн тэмдэглийн дэвтэрийг уншуулан хэн нэгний биеийг эзэмдэхийг хүссэн эргэлзээгүй юм. Тэгвэл ахин Слизериний мангас сул тавигдах байсан.

- Тэр зүгээр л хийсэн ажлаа үрэгдэхийг хүсээгүй байна. Бүгдэд тухайн үедээ баталж чадаагүй ч Слизериний загамжлагч гэдгээ үзүүлэхийг хүссэн байна.

- Яг зөв гээд Дамблдор толгой дохилов.

- Гэхдээ чи ойлгосонгүй, Харри. Хэрвээ тэр тэмдэглэлийн дэвтрийг ирээдүйн Хогвартсын хүмүүжүүлэгчдээ дамжуулахыг хүссэн бол үнэт сүнснийхээ хэсгийг нууснаар маш хайхрамжгүй хандсан байна. Профессор Слизнортын тайлбарласанчлан крестраж хүний биеийн хэсгийг агуулж байгаа болохоор хэн нэгний хөлд хаях нь устгагдах эрсдэлтэй байсан. Тэгээд ч ийм явдал болж сүнсний хэсэг үрэгдсэн бөгөөд чи үүнд гар бие оролцсон билээ.

- Волан-де-Мортын крестраждаа хайнга хандсан явдал нь надад үүнийг төсөөлөхөд тус болсон юм. Тэр илүү их крестраж зохиохоор төлөвлөж байжээ. Би үүнд итгэхийг хүсээгүй ч өөр тайлбар олж хараагүй юм.

- Дараа нь хоёр жилийн дараа чи шөнө надад Волан-де-Мортыг эргэн төрж Үхэл залгигчдаа олон зүйлийг тайлбарласныг ярьсан. «Би цааш нь үхэшгүй мөнх болох бусад аргыг хайсан» Би үүнийг Үхэл залгигчид ойлгоогүй байх

гэж бодож байна. Тэр өөрийнхөө ямар ч шидтэний хэзээ ч эзэмдэж байгаагүй зүйл болох крестражын тухай, олон тооны крестражын тухай ярьж байсан, Харри. Эдгээр



жилүүдэд лорд Волан-де-Морт хүний төрхөө алдаж хувирсан болоход нь зөвхөн ганц л тайлбар байна. Түүний сүнс өшөө хорсолд зэрэмдэглэгджээ.

- Тэр өөрийгөө алах боломжгүй болгохын тулд өөр хүмүүсийг алж байсан юм уу? Хэрвээ түүнд үхэшгүй мөнхийн болох тийм их хэрэгтэй байсан юм бол яагаад гүн ухааны чулууг бүтээх юмуу хулгайлаагүй юм бол?

- Бид түүнийг таван жилийн өмнө ийм зүйл хийхээр оролдсоныг мэднэ. Гэвч үүнд хэд хэдэн шалтгаан байгаа гэж бодож байна. Гүн ухааны чулуунд лорд Волан-де-Морт крестражаас бага татагдаж байсан.

- Амьдруулагч ундаа үнэхээр амьдралыг сунгах хэдий ч үхэшгүй мөнх байхын тулд ундааг үргэлж хэрэглэх ёстой. Энэ нь Волан-де-Мортыг бүрэн хараат байдалд оруулж түүнийг барагдах юмуу муудсан үед нь хэн нэгэн чулууг хулгайлсан бол бусад хүн шиг үхэх байсан. Ийм учраас түүний ганцаараа ажиллахыг эрхэмлэдэг болохыг сана. Түүнд ундаанаас хамааралтай байхыг төсөөлөхөд тэвчишгүй санагдсан. Мэдээж энэ нь аймшигтай хагас амьдралаас зугтаахад туслах юм бол тэр чам руу дайрсныхаа дараа ахин биедээ орохын тулд уухад бэлэн байсан. Харин цаашид ахин крестражад найдах хэвээр байсан гэдэгт итгэлтэй байна. Харин тэр хүний биед орж л байвал юуг ч оролдож үзэхэд бэлэн байсан. Ойлгож байна уу, тэр хэдийн үхэшгүй мөнх болсон байсан ... эсвэл мөнх болоход ойрхон байсан.

- Харин одоо Харри минь, чиний авсан дурсамжыг ашиглан бид урьд өмнө хэний ч хийж байгаагүй зүйл болох лорд Волан-де-Мортыг устгах нууцад ойртож ирлээ. Чи түүнийг сонссон, Харри. «Сүнсээ илүү хүчирхэг шидийн тоо болох долоо хуваавал яасан юм. Долоо бол хүчирхэг шидэт тоо». Тиймээ, энэ санаа түүнд үнэхээр сүнсээ долоон хэсэг болгон хуваах бодлыг төрүүлсэн.

- Тэгвэл тэр долоон крестраж бүтээсэн хэрэг үү? гэж Харри айдаст автан асуухад ханан дахь зарим хөргүүд цочирдож уурссандаа дуу алдав. Тэгвэл тэднийгээ дэлхийн хаа нэгтээ үзэгдэхгүй болгон нуусан байх ...

- Би чамайг өмнөө байгаа даалгаварын хэмжээг ойлгож байгаад баяртай байна.

Гэхдээ долоо биш зургаа юм. Долоо дахь сүнсний хэсэг нь түүний зохиосон биед байгаа. Энэ нь түүнийг олон жилийн турш хөөгдөн хий үзэгдлийн байдалтай тэнүүчилэн амьдарч байхад нь хамт байсан бөгөөд түүнгүй бол оршин тогтнохгүй байлаа. Түүнийг алахыг хүссэн хүн энэ долоон хэсгийг биед нь хадгалагдаж байгаагийн хамт устгах ёстой юм.

- За яахав зургаа болог гэж Харри бас л цөхрөн хэлээд,

- Гэхдээ бид тэднийг яаж олох вэ? гэлээ.

- Чи тэдний нэгийг хэдийн устгасан гэдгээ мартаад байна. Харин би өөр нэгийг нь устгасан.

- Устгасан гэнээ? хэмээн Харри дуу алдав.

- Тиймээ, устгасан гээд Дамблдор харлаж түлэгдсэн гараа өргөлөө.

- Бөгж, Харри. Марвологийн бөгж. Тэр аймшигтай шидээр харагдсан байсан.

Намайг хүнд шархдан Хогвартс руу ирэхэд профессор Снегг хүлээн авсан юм. Гэхдээ одоо энэ тухай ярих боломжгүй. Тэгээд ч миний хатсан гар Волан-де-Мортын долоон сүнсний хэсэг болох нэгээр нь хэтэрхий өндөр үнээр олдсон юм. Бөгж зөвхөн крестраж байгаагүй.

- Гэхдээ та түүнийг хаанаас олсон юм бэ?

- Чиний мэдэж байгаачилан би олон жилийн турш багагүй хүч гарздан байж Волан-де-Мортын өнгөрсөн амьдралын тухай мэдсэн. Би түүнийг байж болох олон газраар явсан. Мраксын байшингаас үлдэгдлээс энэ бөгжийг олсон юм. Харваас Волан-де-Морт сүнснийхээ нэг хэсгийг дотор нь шингээгээд зүүхийг хүсээгүй бололтой. Тэр түүнийг маш хүчирхэг шившлэгээр хамгаалан өвөг эцгийнхээ амьдарч байсан оромжинд нуухдаа эрт орой хэзээ нэгэн цагт намайг балгас руу очиж шидийн нууцын тэмдэгийг харна гэж таамаглаагүй байх.

- Гэхдээ баярлах зүйл болоогүй л байна. Чи тэмдэглэлийн дэвтрийг устгасан, би бөгжийг устгасан болохоор хэрвээ бидний долоо хэсэг сүнсний онол үнэн бол цаана нь дөрвөн крестраж үлдлээ.

- Тэд ямар ч хэлбэртэй байж болно биз дээ? Хуучин консервны лааз юмуу, хоосон уусмалын шил гээд л ...

- Чи энгийн нүдэнд өртөхгүй зүйл болох зөөвөрлөгчийн тухай яриад байна, Харри. Лорд Волан-де-Морт үнэт сүнсээ хадгалахаар консервны лааз юмуу хоосон шилийг сонгоно гэж үү? Чи миний үзүүлсэн зүйлийг мартсан бололтой. Лорд Волан-де-Морт олз цуглуулах дуртай байсан бөгөөд хүчирхэг ид шидийн түүхтэй зүйлсийг эрхэмлэдэг юм. Түүний бардам зан өөрийгөө илүүд үзэх хүсэл нь ид шидийн түүхэнд мөнхлөх хүслийг дагуулдаг. Энэ бүхэн нь надад Волан-де-Морт крестражаа болгохоор илүү хүндэтгэлтэй зүйлсийг сонгоно гэсэн бодлыг төрүүлсэн.

- Тэмдэглэлийн дэвтэр онцгой байгаагүй.

- Тэмдэглэлийн дэвтэр чиний хэлснээр Слизериний залгамжлагч гэдгийн баталгаа учир Волан-де-Морт түүнд томоохон ач холбогдол өгдөг байж.

- Тэгвэл бусад крестражын тухайд яах вэ? Та тэднийг ямар хэлбэртэй болохыг мэдэх үү?

- Би зөвхөн тааварлах төдий юм. Миний өмнө хэлсэн шалтгааны улмаас Лорд Волан-де-Морт сүр жавхлантай зүйлийг эрж байсан. Ийм учраас би түүний өнгөрсөн үе рүү буцан эргэн тойронд нь алга болсон шидийн эд өлгийн зүйлсийг хайж байгаа.

- Зүүлт! Пуффендуйн аяга! гэж Харри чанга хэлэв.

- Тиймээ гээд Дамблдор инээмсэглэн,

- Тэд гурав, дөрөв дэх крестраж гэдэг нь тодорхой. Хэрвээ үнэхээр зургааг хийсэн гэж үзвэл үлдсэн хоёрыг нь би аз туршин Пуффендуй болон

Слизернтэй холбоотой зүйлийг олж авсан болохоор Гриффиндор болон Когтеврантай холбоотой зүйл байх гэж таамаглаж байна. Хогвартсын дөрвөн залгамжлагчдаас өвлөгдсөн дөрвөн зүйл байх ёстой гэж таамаглаж байна. Түүнийг

Когтевраны ямар нэг зүйл хулгайлсан гэдгийг хэлж чадахгүй ч Гриффиндорын цорын ганц дурсгал бүрэн бүтэн байгаа гэдэгт итгэлтэй байж болно.

Ингээд Дамблдор харласан хуруугаараа арын ханандаа өлгөсөн бадмаараг шигтээтэй сэлэм рүү заалаа.

- Та түүнийг ийм учраас Хогвартс руу ирэхийг хүссэн гэж бодож байна уу?

Өөр үндэслэгчийн ямар нэг зүйлийг олохоор?

- Би үнэхээр тэгж бодсон. Гэвч харамсалтай нь би түүнд сургуульд хайх ямар ч боломж өгөөгүй юм. Иймээс дөрвөн залгамжлагчын үнэтэй зүйлийг эзэмших төлөвлөгөө бүтсэнгүй ... магадгүй гурав дахийг нь олсон байж болох ч ... бид үүнийг хайх болно.

- Гэхдээ тэр Когтевраны ямар нэг зүйлийг юмуу Грффиндорынхыг авлаа гэхэд зургаа дахь крестраж үлдэнэ биз дээ. Эсвэл тэр өөр зүйл олсон юм болов уу?

- Тэгж бодохгүй байна. Надад тэр зургаа дахь крестражыг өөртэйгээ хамт байлгаж байгаа юм шиг санагдсан. Ингэхэд чи Нагайна нэртэй могойн тухайд юу хэлэх гэж байна?

- Могой гэнээ? Амьд амьтныг крестражаар ашиглаж болох юм уу? гэж Харри мэгдэн асуулаа.

- Энэ тийм ч ухаалаг бус хэрэг л дээ. Сүнснийхээ нэг хэсгийг амьтанд итгэн даатгана гэдэг маш эрсдэлтэй зүйл юм. Хэрвээ миний тооцоо зөв бол Волан-де-Морт сүүлчийн крестражаа хийх зорилготой эцэг эхийн чинь гэрт чамайг алахаар очсон.

- Харваас нөөц крестраж зохиохоор түүний хувьд онцгой ач холбогдол өгч байсан зүйлийг сонгосон бололтой. Харин чи эргэлзээгүй тийм байсан. Тэр чамайг алснаараа зөгнөлийн хэлсэн гай зовлонгоос зайлсхийх болно гэдэгт итгэсэн. Тэр өөрийгөө ялагдашгүй гэдэгт итгэсэн. Ийм ураас би түүнийг сүүлчийн крестражаа чамайг алсны дараа зохиох гэж байсан гэдэгт итгэлтэй байна.

- Ингээд амжилт олоогүй болохыг нь бид мэднэ. Олон жилийн дараа тэр Нагайнаг ашиглан хөшин маглыг алах үед толгойд нь сүүлчийн крестражаа бүтээх бодол төрсөн байх. Могой бол Слизериний бэлэг тэмдэг бөгөөд лорд Волан-де-Мортын нууцлаг байдлыг нэмэгдүүлэх байлаа. Тэр түүнтэй маш хүчтэй холбоотой байж ер бусын чадвар болох могойн хэлээрээ хяналтандаа байлгаж байдаг юм.

- Сайн байна тэгвэл өдрийн тэмдэглэл байхгүй, бөгж ч гэсэн байхгүй. Аяга, зүүлт могой болон Когтевран юмуу Гриффиндороос залгамжлагдсан зүйл бүтэн хэвээр байгаа байх нь ээ?

- Гайхалтай товч дүгнэлт байна гэж Дамблдор толгойгоо бөхийлгөн хэлэв.

- Тэгвэл та өмнөхийн адил тэднийг эрсээр байгаа хэрэг үү? Ийм учраас сургуулийг орхин явж байсан юм уу?

- Зүйтэй. Би тэднийг маш эртнээс хайж байгаа. Ингээд нэгийг нь олоход ойрхон байгаа гэж бодож байна. Ямар нэг шинж тэмдэг харсан.

- Хэрвээ та крестажыг олвол би хамт явж устгахад тусалж болох уу? гэж Харри түргэн хэлэв.

Дамблдор түүн рүү маш анхааралтай харснаа,

- Тиймээ, тэгж бодож байна гэлээ.

- Үнэн үү? гэж Харри сэтгэлийн гүндээ гайхан асуулаа.

- Тийм л дээ. Минийхээр бол чи үүнийг хүртэх гавъяатай гэж Дамблдор сулхан инээмсэглэн хэлэв.

Харри зүрхээ хүчтэй цохилохыг мэдрэв. Болгоомжтой байдал болон хамгаалалтын тухай үг дурсаагүй нь сайн хэрэг байлаа. Хананд өлгөөтэй байсан захирлын хөргүүдэд Дамблдорын шийдвэр сэтгэгдэл төрүүлсэн бололтой зарим нэг нь толгой сэгсрэхэд, Финеас Найжелус тургилав.

- Ингэхэд Волан-де-Морт крестражыг нь устгахыг мэдэх үү, эрхэм ээ? Тэр үүнийг мэдрэх үү? гэж Харри хөргүүдийг үл ойшоон асуулаа.

- Их сонирхолтой асуулт байна. Би үгүй гэж бодож байна. Волан-де-Морт хорсол хилэнд автаад энэ чухал зүйлээс тасран бидэн шиг мэдрэмжгүй болсон. Магадгүй үхлийн босгон дээр тэднийгээ алдсан ч байж болох юм ... Жишээлбэл түүний Люциус Малфойд итгэн өгсөн тэмдэглэлийн дэвтэр устгагдсан гэдгийг мэдэхгүй. Волан-де-Морт тэмдэглэлийн дэвтэр устгагдсан гэдгийг мэдвэл аймшигтай уурлах нь гарцаагүй.

- Гэхдээ би түүнийг Люциус Малфойд дэвтрийг Хогвартст аваачихыг тушаасан гэж бодсон юмсан?

- Тиймээ олон жилийн өмнө бусад крестражуудаа үүсгэх чадвартай байх үедээ тушаасан. Люциус Малфой Волан-де-Мортын шууд тушаалыг хүлээж байсан ч дэвтрээ өгсний дараа алга болсон учраас аваагүй байна. Гэхдээ тэр Люциусын эзнээсээ айдагийг мэддэг болохоор крестражад ямар нэг юм хийж зүрхлэлгүй бусдын адил болгоомжтой хамгаална гэж бодсон байх. Харин Люциус тэмдэглэлийн дэвтэр үнэн хэрэгтээ юу агуулж байгааг мэдсэнгүй. Миний ойлгож байгаагаар Волан-де-Морт түүнд өдрийн тэмдэглэлийн тусламжтай нууц өрөөг ахин нээж болно гэж хэлжээ. Люциус гартаа эзнийхээ сүнсний хэсгийг барьж байгаага мэдсэн бол эргэлзээгүй дэвтэрт хүндэтгэлтэй хандах байсан. Харин тэр эртний даалгаварыг өөрийн тусын тулд ашиглажээ. Дэвтрийг Артур Уизлийн охинд өгөхөөр төлөвлөөд нэр хүндийг нь гутаан нэгэн зэрэг намайг Хогвартсаас хөөлгөхөөр боджээ. Хөөрхий Люциус ... Волан-де-Морт крестражаар нь өргөл барьсанд ямар их уурлах байсныг мэдвэл өнгөрсөн жил яаманд болсон явдлын дараа шоронд

аюулгүй сууж байгаадаа сэтгэлийн гүндээ баярлах байсанд би нэг их гайхахааргүй байна.

Харри хэсэг чимээгүй болсноо дараа нь,

- Хэрвээ бүх крестражыг устгавал Волан-де-Морт алж болох уу? гэв.
- Тийм гэж бодож байна. Крестаржуудгүй бол тэр ердийн зэрэмдэг сүнс болно. Гэхдээ үүнийг бүү март түүний сүнс засч болохооргүй гэмтсэн ч Волан-де-Мортын таринд шидийн хүч хөндөгдөөгүй үлдсэн. Ийм учраас түүнийг алах хүчтэй шидтэн өөрийнх нь адил шидийн ховор хүчийг эзэмдсэн байх хэрэгтэй.
- Гэхдээ надад ер бусын чадвар хүч байхгүй гэж Харри өөрийн мэдэлгүй хэлэв.
- Байгаа. Чи Волан-де-Мортод хэзээ ч байгаагүй хүчийг эзэмдсэн. Чи чадна ... гэж Дамблдор хатуу хэлэв.
- Тиймээ, би мэднэ! Би хайрлаж чадна! гээд Харри цааш нь арайхийн «Том амжилт шүү» гэж хэлчихэлгүй тэслээ.
- Тиймээ, Харри чи хайрлах хүчтэй. Хэрвээ чамд тохиолдсон бүхнийг санах аваас агуу хүч шаардагдана. Чи ер бусын гэдгээ ойлгоход хэтэрхий залуу байна, Харри.
- Зөгнөлд «Хар лорд хүчийг нь мэдэхгүй» гэж гардаг нь ердөө хайр байсан юм уу?
- Тиймээ хайр. Гэхдээ зөгнөлд зөвхөн Волан-де-Мортод холбогдолтой зүйл хэлснийг бүү март. Би чамд энэ тухай өнгөрсөн хичээлийн жилийн эцэст хэлсэн. Волан-де-Морт чамайг цорын ганц аюул учруулж чадах хүн гэж бодсон учир өөрөө үүнийг хийсэн.
- Гэхдээ тэр ердөө хувиргах ...
- Үгүй, тийм биш! гэж Дамблдор тэвчээргүйхэн яриаг нь таслаад Харри руу харласан хуруугаараа зааж,
- Чи зөгнөлд хэтэрхий ач холбогдол өгөөд байна! гэв.
- Гэхдээ та зөгнөлийн тухайд хэлэхдээ ...
- Хэрвээ Волан-де-Морт зөгнөлийн тухай хэзээ ч сонсоогүй бол биелэгдэхгүй байсан гэж үү? Ямар нэг зүйл болох байсан уу? Мэдээж үгүй! Чи Зөгнөлийн танхимд байгаа зөгнөл бүр биелэгддэг гэж бодож байна уу?
- Гэхдээ та надад өнгөрсөн жил бидний нэг нь нөгөөгөө алахаас нааш ...
- Харри, Харри минь үүний учир нь зөвхөн Волан-де-Морт профессор Трелонигийн үгийг сонсоод ноцтой алдаа гаргасанд байгаа юм! Хэрвээ Волан-де-Морт чиний эцгийг алаагүй бол чамд өс хонзон авах хүсэл төрөх байсан уу? Мэдээж үгүй! Хэрвээ чиний ээж чамайг аврахын төлөө үхээгүй шидийн хамгаалалт өгөөгүй бол тэр хүчгүй болох байсан уу? Мэдээж үгүй, Харри! Чи ойлгохгүй байна уу? Волан-де-Морт хамгийн муу дайснаа бүх харгис явдлынхаа хамт өөрөө бүтээсэн. Чи хүмүүсийг дарлаж айлгах нь ямар байдаг талаар төсөөлж байна уу? Тэд эрт орой хэзээ нэгэн цагт ихэнхи нь хохирогч болсон хойноо түүний эсрэг босон хариу цохилт өгөх байсан! Волан-де-Морт ч гэсэн ялгаагүй! Тэр үргэлж болгоомжтой байж дуудлага хаанаас ирэхийг хардаг

байж. Тэгээд зөгнөлийн тухай сонсмогц шүүрч аваад үр дүнд нь өөрийгөө дуусгах дайснаа төрүүлээд зогсохгүй түүнд үхлийн зэвсэг гардуулсан.

- Гэхдээ ...

- Чи үүнийг ойлгох нь маш чухал, Харри! гээд Дамблдор сандлаасаа босон жанчаа шар шурхийлгэн урагш хойш холхиж эхлэв. Харри түүнийг хэзээ ч ийм сэтгэл донсолсон байхыг үзэж байсангүй.

- Чамайг алахыг оролдсоноороо Волан-де-Морт миний урд сууж байгаа гайхалтай хүнийг бий болгосон. Өөрөө түүнд тэмцэх зэвсгийг өгсөн! Энэ бол Волан-де-Мортын буруу. Тэр чамайг бодолдоо нэвтрэх боломж олгож, тэр ч байтугай могойн хэлээр ярьдаг тушаалыг нь ойлгон өөрийнхөө ертөнцийн гүнд нэвтрэх онцгой эрх ямба олгосон. Гэсэн хэдий ч чи хар урлагт нэг ч удаа татагдан түүний дагалдагч нарын нэг болохыг хүсээгүй.

- Мэдээж би тэгэхгүй. Тэр миний эцэг эхийг алсан шүү дээ гэж Харри уурсан хашгирлаа.

- Товчхон хэлэхэд чамайг хайрын хүч хамгаалсан! Энэ цорын ганц хамгаалалт чамайг Волан-де-Мортын адил эрх мэдэлд шунахаас хамгаалсан!. Энэ бүх сорилт зовлон шаналалын дараа чиний зүрх арван нэгэн настай үедээ толинд үнэт зүйлээ харж байсан үеийнх шигээ цэвэр ариун үлдэж Волан-де-Морт шиг үхэшгүй мөнх рүү ч биш баян болоход ч тэмүүлээгүй. Харри чи хорвоо дээр хичнээн цөөхөн шидтэн энэ толинд тийм зүйл хардаг гэж бодож байна? Волан-де-Морт энэ тухай тэр үед төсөөлөх ёстой байсан ч тэгээгүй!

- Гэхдээ тэр одоо үүнийг мэднэ. Волан-де-Морт чиний ухаанд нэвтрэн орох үедээ эзэмдэж үхтэл нь зовоож чадахгүй гэдгээ ид шидийн яаманд мэдсэн. Гэхдээ би түүнийг учрыг нь ойлгосон гэж бодохгүй байна. Түүнчлэн тэр сүнсээ зэрэмдэглэхээр хэт яараад хиргүй тунгалаг сүнс ямар хүч эзэмддэг талаар нэг ч удаа бодож үзээгүй юм.

- Гэхдээ ноёнтоон энэ бүхэн адил биш гэж үү? Би түүнийг алах ёстой эсвэл ...

- Ёстой гэнээ? Мэдээж, чи тэгэх ёстой! Зөгнөлд тэгж хэлсэнд байгаа ч юм биш.

Учир нь чи ингэхгүйгээр хэзээ ч тайван байж чадахгүй! Бид хоёул үүнийг мэднэ! Чамаас гуйж хормын турш хэзээ ч зөгнөлийг сонсоогүй гэж төсөөлөөд үз дээ! Волан-де-Мортын тухайд ямар мэдрэмж төрж байна? Бод!

Харри нааш цааш алхаж байгаа Дамблдор уу харснаа бодлогширов. Тэр эцэг, эх, Сириусын болон Седрик Диггориин тухай бодлоо. Түүнчлэн Волан-де-Мортын гарт аймшигтайгаар амь үрэгдсэн бүх танил хүний тухай бодлоо. Тэгтэл цээжинд нь галын дөл асав.

- Би түүнийг дуусгахыг хүсч байна. Тэгээд үүнийг өөрөө хийх болно.

- Тэгэлгүй яахав. Чи зөгнөл заавал үүнийг хийх ёстой гэж хэлээгүй болохыг ойлгов уу! Гэхдээ зөгнөлд лорд Волан-де-Морт чамайг өөртэйгээ эн тэнцүү болгоно гэсэн ... Өөрөөр хэлбэл чи зөгнөлөөс чөлөөлөгдөн өөрөө замаа сонгон авч байна!

Харин Волан-де-Морт зөгнөлийг баримталсаар үлдэж өмнөхийн адил чиний араас ануучилах болно ...

- Бидний нэг нь нөгөөгөө алах хүртэл гэж Харри дэмжив.

Ингээд тэр эцэст нь Дамблдорын юу хэлэхийг хичээгээд байгааг ойлголоо. Ялгаа нь гэвэл өөрийгөө үхэлтэй нүүр тулгарах ёстой талбайгаас чирж гаргаад толгойгоо өндөрт өргөж энэ талбай руу орох явдал юм. Зарим хүмүүс үүнийг жижиг зүйл гэж үзэж болох ч Дамблдор мэдэж байгаа гэж Харри бодоод бахархах сэтгэл төрөв. Би ч гэсэн үүний ялгааг мэднэ.

## БҮЛЭГ 24: СЕКТУСЕМПРА

Хүнд шөнийн дараа эцэж ядарсан ч баярлаж хөөрсөн Харри маргааш өглөө нь шившлэгийн хичээл дээр Рон, Гермиона хоёрт (ойр сууж байсан хүмүүст Дүлийрүүлэх шившлэг илгээж байгаад) юу болсон тухайгаа бүгдийг ярьжээ. Түүний Слизнортын дурсамжыг авхаалжтай салган авсан явдал андуудад нь хүчтэй сэтгэгдэл төрүүлж, Дамблдор Волан-де-Мортын крестражыг устгахдаа өөртэйгээ хамт авч явна гэж амалсанд амаа ангайжээ.

- Үгүй ерөө! гэж Рон Харриг яриагаа дуусгамагц дуу алдаад шидэт саваагаа адар руу чиглүүлснээ мартан өөрийн мэдэлгүй даллаж,

- Хөөх! Чи үнэхээр Дамблдортой хамт явах юм уу? Бас устгахад нь оролцоно гэнээ? ... Үгүй ер! гэв.

- Рон чи цас оруулаад байна гэж Гермиона дуу алдаад бугуйнаас нь барьж адар өөд чиглэсэн савааг холдуулахад том цагаан цасан ширхэг дээрээс хаялав. Харри хөрш ширээний ард Лаванда Браун улаан нүдтэй зогсоод Роны гарыг буулгаж буй Гермиона луу ууртай харж буйг ажиглав.

- Аан тийм л дээ. Уучлаарай ... гээд Рон өөрийнхөө мөр лүү гайхширан харснаа,

- Хараач аймшигтай хагтсан юм шиг болчихож гэв.

Тэрбээр Гермионагийн мөрөн дээр байсан хэдэн цасан ширхэгийг гүвлээ. Лаванда нулимс цэлэлзүүлэв. Рон даруйхан буруутай өнгөөр түүнээс эргээд,

- Бид хоёр салсан. Өнгөрсөн шөнө. Тэр намайг Гермионатай унтлагын өрөөнөөс гарч ирэхийг харчихсан. Мэдээж чамайг хараагүй болохоор биднийг тэнд хоёулхнаа байсан гэж бодсон гэж шивнэлээ.

- Чи бүх зүйл дууссанд гашуудахгүй байгаа биз дээ?

- Үгүй. Мэдээж түүнийг над руу орилоход таатай зүйл бага байсан ч эцэст нь бидний хоорондох бүх зүйл дууссан гэдгийг өөрөө тайлбарлах хэрэг гарсангүй.

- Хулчгар амьтан гэж Гермиона сэтгэл хангалуун хэлээд,

- Өчигдөр дурлалт хосын муу өдөр байсан бололтой. Жинни, Дин хоёр бас салсан гэв.

Гермиона үүнийг хэлээд Харри руу хачирхалтай ойлгосон харцаар харсанд дотор нь гэнэтхэн хоосорлоо. Тэр царайгаа тайван байлгахыг хичээгээд аль болох хайхрамжгүй өнгөөр,

- Яагаад тэр вэ? гэв.

- Өө, шал тэнэг зүйл болсон ... Жинни Дин түүнийг үргэлж хөргөн нүхээр өөрөө гарч чадахгүй юм шиг түлхдэг гэсэн. Гэхдээ тэд эртнээс л маргалдаж эхэлсэн дээ.

Харри ангийн нөгөө талд сууж байгаа Дин руу харахад ихээхэн золгүй төрхтэй байв.



- Мэдээж энэ чамд жаахан төвөгтэй байдал үүсгэх байх даа?
- Чи юуны тухай яриад байна? гэж Харри түргэн асуулаа.
- Квиддичийн багийн чинь тухай. Жинни, Динтэй ярихаа больсон болохоор ...
- Аан тийм л дээ.
- Флитвик гэж Рон болгоомжлуулан шивнэв.

Тэдэн рүү жижигхэн шившлэгийн багш зэмлэнгүй ойртон ирэхэд зөвхөн Гермiona л цагаан цууг дарс болгон хувиргаад байлаа. Түүний өмнөх шилэн аяганд дүүрэн бараан улаан шингэн байсан бол, Рон, Харри хоёрынх хүрэн хэвээр байв.

- Тэгэхээр хөвгүүд минь, яриагаа багасгаж ажлаа ихэсгэж үз. Алив ахин нэг удаа оролдоод үз дээ, би харж байя гэж профессор Флитвик таагүйхэн хэлэв.

Хоёул шидэт саваагаа өргөөд шилэн аяга руу чиглүүлэн төвлөрөхөд Харрийн цагаан цуу мөс болон хувирсан бол, Роны аягатай дэлбэрлээ.

- Тийм л дээ ... гэрийн даалгаварт сургуулилаарай гээд профессор Флитвик ширээн дороос гарч ирээд малгайныхаа орой дээрээс шилний хэлтэрхийг сэгсрэн хэллээ.

Энэ өдөр шившлэгийн хичээлийн дараа чөлөөт цаг байсан тул бүгд амралтын өрөө рүү зүглэв. Рон эцэст нь Лавандагаас салсан болохоор сэтгэл нь өндөр байж, Гермiona ч гэсэн хөгжилтэй байсан тул «сайхан өдөр байна» гэлээ. Тэдний хэн ч Харрийн толгойд явагдаж байгаа тэмцлийг ажигласангүй.

Тэр Роны дүү.

Гэхдээ тэр Диныг хаясан! Тэгсэн ч гэсэн Роны дүү. Харин би түүний сайн найз! Үүнээс дор юу байхав.

Хэрвээ би эхлээд түүнтэй ярилцвал ...

Тэр чиний дух руу цохино.

Хэрвээ энэ надад хамаагүй байвал яах вэ?

Тэр чиний сайн найз!

Харри хэрхэн хөргөн нүхээр орж нарны гэрэлтэй амралтын өрөөнд орсноо анзаараагүй ч долдугаар дамжааны хэдэн охид зогсож буйг хальт харлаа. Тэгтэл Гермiona,

- Кэти! Чи эргээд ирчихсэн үү! Бие чинь зүгээр үү? хашгирав.

Харри эргэн харахад үнэхээр Кэти Белл эрүүл саруул баярлаж хөөрсөн найзуудаараа хүрээлүүлэн зогсож байлаа.

- Маш сайн! гэж Кэти баяртай дуу алдаад,
- Тэд намайг гэгээн Мунгогийн эмнэлэгээс даваа гаригт гаргасан ч эцэг эхтэйгээ хэдэн өдрийг өнгөрүүлээд өнөө өглөө ийшээ ирлээ. Харри, Лианна дөнгөж сая надад Маклагген сүүлчийн тэмцээн дээр яасан тухай ярилаа ... гэв.

- Тийм шүү одоо чи эргээд ирсэн болохоор, Роны бэлтгэл ч сайн байгаа. Бидэнд Когтевраныг ялаад цомыг хожих боломж байна. Сонсооч, Кэти ...

Тэр түүнд асуулт тавих гэж яарсандаа болоод Жиннигийн тухай хүртэл мартжээ. Кэтийн найз хувиргалын хичээлээс хоцорсон бололтой яаран юмаа цүнхэлхэд Харри дуугаа намсгаад,

- Зүүлт ... чи түүнийг хэн өгснийг санаж байна уу? гэв.

- Үгүй гээд Кэти гашуудангуй толгой сэгсэрлээ.

- Надаас энэ тухай бүгд асуусан ч би юу ч санахгүй байгаа. Хамгийн сүүлд «Гурван шүүр»-ийн эмэгтэйчүүдийн жорлонд орсоноо л санаж байна.

- Гэхдээ чи үнэхээр жорлонд орсон биз дээ? гэж Гермiona асуулаа.

- Би хаалга түлхсэнээ л санаж байна. Тэр үед түүний ард зогсож байсан хүн намайг Империиус шившлэгээр удирдсан байх. Харин үүний дараа сүүлчийн хоёр долоо хоногийг тооцохгүй бол хоосон ой ухаантай гэгээн Мунгогийн эмнэлэгт хэвтсэн. Сонсооч би гүйхгүй бол МакГонагалл хичээлийн анхны өдөр мөр бичүүлэх нь байна.

Тэр цүнхэндээ сурах бичгээ хийгээд яаран найзынхаа араас гарлаа. Харри, Рон, Гермiona гурав цонхны дэргэдэх ширээн дээр суугаад Кэтийн ярьсан зүйлийн талаар бодлогоширов.

- Зүүлтийг Кэтид эмэгтэйчүүдийн жорлон руу орж чадах эмэгтэй хүн юмуу охин өгсөн байх ёстой гэж Гермiona хэлэв.

- Эсвэл эмэгтэй хүн юмуу охины дүрд хувирсан хэн нэгэн. Хогвартсад тогоо дүүрэн Хувиргагч уусмал байгаа гэдгийг бүү март. Тэгээд ч бид түүнийг хэн хулгайлаад ашиглаж байгаа болохыг мэднэ ... гэж Харри дуугарлаа.

Түүний толгойд Крэбб, Гойл хоёрын хувирч болох охидын бүтэн жагсаалт төсөөлөгдөв.

- Би ахин нэг балга Феликс уугаад Шаардлагатай өрөөнд нэвтрэх гэж оролдоод үздэг юм билүү.

- Тэгвэл чи түүнийг хоосон гарздах болно гэж Гермiona хатуу хэлээд «Шидтэний цагаан толгой» сурах бичгээ цүнхнээсээ гарган тавьж,

- Аз зөвхөн чамд өрөөнд хүрэхэд хангалттай, Харри. Слизнортын хувьд бол өөр явдал байсан. Чи түүнийг үргэлж ятгахыг оролдож жаахан л хичээх юм бол болох байсан. Харин хүчирхэг шившлэгэнд ямар ч аз тус болохгүй. Тэгсэн

дор уусмалыг гарздахгүй байсан нь дээр! Тэгээд ч аз чинь Дамблдортой хамт явахад хэрэг болж болох юм ... гэж шивнэх шахам хэлэв.

- Бид түүнийг өөрсдөө бэлтгэж болдоггүй юм уу? гэж Рон Гермionaг үл тоомсорлон Харригаас асуулаа. Тийм зүйлийг нөөц байлгахад илүүдэхгүй. Чи номноосоо хараад л ...

Харри цүнхнээсээ уусмалын хичээлийн сурах бичиг гаргаад «Феликс Фелицис»-ийг эрж оллоо.

- Чөтгөр гэж найрлага нь маш ярвигтай юм байна! Тэгээд ч бэлтгэхэд хагас жилийн хугацаа орох юм байна гэж орцны жагсаалтыг гүйлгэн хараад хэлэв.

- Мөнхийн түүх гэж Рон бувтнав.

Харри сурах бичгээ хаахдаа хуудасны булан дээр бичсэн «дайсандаа» гэсэн тэмдэглэгээтэй Сектусемпра шившлэгийг харлаа. Энэ түүний нүдэнд хэдэн долоо хоногийн өмнө өртсөн билээ. Гэвч одоо хүртэл хийж үзээгүйн учир нь хамгийн гол нь Гермionaгийн дэргэд шалгаж үзэхийг хүсээгүй юм. Гэхдээ Маклагненыг хараагүй байхад араас нь хэрэглэн туршин үздэг юм билүү гэж бодсон билээ.

Кэти Белл эргэн ирсэнд баярлаагүй цорын ганц хүн гэвэл түүний орлон тоглогч Дин Томас байлаа. Харри түүнийг нөөц тоглогч болсон тухай мэдэгдэхэд Дин мөрөө хавчаад холдсоноо Симустэй нурууных нь ард уурсан чанга шивнэлдэх нь сонсогджээ.

Дараагийн хоёр долоо хоногт квиддичийн бэлтгэл гайхамшигтай сайхан явагдаж Харрийн ой ухаанд ийм зүйл байсангүй. Тоглогчид Маклагненаас салсандаа баярлаж, Кэтийн эргэн ирсэнд сэтгэл хангалуун байсан болохоор урьд урьдынхаас илүү сайн нисэж байлаа.

Жинни Динээс салсандаа огтхон ч сэтгэлээр унаагүй бөгөөд харин ч эсрэгээрээ багийнхаа сэтгэл санаа нь боллоо. Жинни тоглогчдыг хөгжөөж Рон квоффл ирэхэд сэтгэл түгшсэндээ хэрхэн цагаригийн өмнө хөөрснийг үзүүлэх юмуу эсвэл Харри Маклаггенд ууртай заавар өгч байсныг дуурайдаг байлаа. Харри бусдын хамт инээнгээ Жиннигийн нүд рүү гэмгүй харж чадах болсондоо баяртай байв. Тэр бэлтгэл дээр снитчийг бариагүй ч хоёр удаа блажерт цохиулжээ.

Толгойд нь «Жинни юу Рон уу?» гэсэн бугшсан тэмцэл явагдсан хэвээр байх аж. Заримдаа Рон өмнөхийн адил Лавандатай хэвээрээ байсан бол Жиннигийн зөвшөөрлийг гуйхад татгалзахгүй байсан шиг санагдана. Гэхдээ дүүгээ Динтэй үнсэлдэж байхыг хараад Роны царай ямар болсныг санамагц итгэл эвдэгчээр дуудах болно гэдэгт итгэлтэй байлаа.

Гэвч Харри Жиннитэй бэлтгэлийн дараа хамт инээлдэн шилтгээнд буцахаас өөр зүйл хийж чадсангүй. Хэдийгээр түүнийг ухамсар нь зовоож байсан ч гэлээ ямар аргаар ганцаарчлан үлдэх талаар бодлогоширч байв. Хэрвээ Слизнорт ахин үдэшлэг зохиосон бол Рон тийшээ явахгүй болохоор туйлын зохимжтой хэрэг байх байлаа. Харамсалтай нь Слизнорт тэгсэнгүй. Нэг юмуу хоёр удаа Харри Гермionaгаас тусламж гуйдаг юмуу гэж бодсоноо сэтгэл хангалуун царайг нь хараад чадсангүй.

Түүнд Гермiona Жинни рүү хэрхэн харж байгааг нь ажигласан юм шиг санагдаж эсвэл даажигнан инээхийг хүссэндээ зориуд тийм царай гаргаж байгаа юм шиг бодогдов. Энэ бүх түгшүүр зовнилийн дундаас Жиннийг түрүүлж урихгүй бол өөр хэн нэгэн урьтчих вий гэсэн бодол илүү зовоож байлаа.

Анхилам үнэртэй таван сар чимээгүйхэн өнгөрөхөд Харриг Жиннитэй уулзах болгонд Рон дэргэд нь торж байлаа. Харри хэзээ түүнд аз тохиохыг хүлээсээр Рон гэнэтхэн сайн найз нь дүүтэйгээ нийлсэнд жаргалтай байх ч юм билүү. Ойлгож тэднийг хэдэн хором хамт үлдээх ч юм билүү хэмээн найдав. Гэвч улирлын сүүлчийн тэмцээний ойртоход энэ найдлага биелсэнгүй. Тэр үргэлж Харритай тоглолтын төвөлөгөө ярьж өөр зүйлийн талаар ер бодсонгүй.

Гэхдээ зөвхөн Рон ийм байсангүй. Гриффиндор Когтевраны эсрэг тэмцээн сургуулийн аварга хэн болохыг шийдэх учир бүгд онцгойлон сонирхож байлаа. Хэрвээ Гриффиндор Когтевраныг гурван зуун оноогоор хожвол аварга болно. Түүнчлэн арай бага оноо авч Когтевран түрүүлвэл хоёрдугаар байранд орох болно. Түүнчлэн зуун оноогоор хожигдвол гуравдугаар байранд Пуффендуйн дараа орох бөгөөд ахин зуун оноогоор хожигдвол дөрөвдүгээр байранд орж хоёр зуун жилийн турш түүнийг Гриффиндорын ахмад байх үед хамгийн доод байр эзэлснийг хэн ч мартахагүй байх болно.

Шийдвэрлэх тэмцээний өмнө ердийнхөөрөө эсрэг тэнхимийн сурагчид уулзах болгондоо хүчтэй сөргөлдөж байлаа. Тоглогчдын хэн нэгэн хонгилд тааралдвал бүлгээрээ сүрдүүлэх юмуу дэргэдүүр нь өнгөрөх үед таагүй дуу чанга шоолон дуулах аж. Тоглогчдын сонголт цөөхөн болохоор анхаарал татаж байгаадаа чухал байдалтайгаар хичээлээс хичээлийн хооронд жорлонд нуугдаж байсан учир тэдэнтэй ховорхон тааралдаж байв. Харрийн ой ухаанд тоглоомын амжилт Жиннигийн талаарх бүтэлгүй төлөвлөгөөтэй зайлшгүй холбоотой байлаа. Хэрвээ Гриффиндор гурван зуун оноогор хожвол хөөрсөн чимээ шуугиан түүнд «Феликс Фелицис»-ээс дутуугүй боломж өгөх болно.

Энэ бүх түгшүүр дунд өөр нэг чухал даалгавар болох Малфойн Шаардлагатай өрөөнд юу хийж буйг мэдэх оролдлогоо мартсангүй. Тэр Тэнүүлчний зургийг үргэлжлүүлэн харж байсан ч Малфой ховорхон үзэгдсэнийг бодвол өмнөхийн адил өрөөнд ихээхэн цаг өнгөрүүлж буй бололтой. Харри түүнийг Шаардлагатай өрөөнд байхад нь орох нэвтрэх багахан найдлага агуулж дэргэдүүр нь өнгөрөх болгондоо оролдох хэдий ч харамсалтай нь түүний гуйлтанд өрөөний хаалга нээгдсэнгүй.

Когтеврантай тоглох тэмцээний өмнөх өдөр Роны гэдэс ахиад л өвдөж ойролцоох жорлон руу гүйгээд, Гермiona профессор Вектортой сүүлчийн бичгийн ажил дээр хийсэн алдааныхаа тухай ярилцах гээд явсан учир Харри хоолноос гараад ганцаар амралтын өрөө рүү явлаа. Тэр дадал болсон замаараа долоон давхарт гараад Тэнүүлчний газрын зургийг харлаа. Анхны агшинд Малфой олдсонгүйд гарцаагүй Шаардлагатай өрөөнд байгаа байх гэж бодтол түүний нэртэй жижигхэн цэг нэг давхарын дор эрэгтэйчүүдийн жорлонд Крэбб, Гойл хоёртой биш уйланхай Миртлгтэй байхыг олов.

Харри үнэмшилгүй энэ хоёр хосыг хараад агшин зуур зогссоноо цааш явахдаа өмнөө байсан рыцарын дуулгыг мөргөчихлөө. Чанга чахрах чимээ анхаарлыг нь сарниулахад Филчийг ирэхээс өмнө яаран холдоод гантиг шатаар нэг давхар уруудан ойролцоох хонгилоор явлаа. Жорлонд хүрээд чихээ хаалганд наахад юу ч сонсогдсонгүйд хаалгыг чимээгүйхэн нээв.

Түүн рүү Драко Малфой нуруугаа харуулан зогсоод угаагуур руу бөхийн цайвар үстэй толгойгоо барьсан байв.

- Хэрэггүй ... хэрэггүй ... надад чамайг юу зовоогоод байгааг хэлээч ... би чамд туслая гэх Миртлийн дуу бүхээгээс сонсогдов.

- Хэн ч надад тусалж чадахгүй ... би үүнийг хийж чадахгүй нь ... чадахгүй ... бүтэхгүй нь ... хэрвээ түргэн биелүүлэхгүй бол ... тэр намайг ална гэж хэлсэн гээд Малфойн бүх бие чичирлээ.

Харри Малфойн жинхэнээсээ уйлж буйг ойлгоод цочирдон байрандаа хөшихөд түүний цайвар хацрыг нь даган нулимс урсаад бохир угаагуур руу дуслав. Малфой амьсгаадан нулимс асгаруулснаа агзасхийгээд харцаа өргөж хагарсан толинд ардаа байгаа Харриг харлаа.

Малфой огцом эргээд шидэт саваагаа даллахад Харри зөнгөөрөө хамгаалав. Түүний шившлэг дэргэдүүр нь хэдхэн дюймийн зайтай нисэн өнгөрөөд хананд байсан дэнлүү хагалав. Харри хажуу тийш ухасхийгээд «Левикорпус!» гэж бодон саваагаа далласан ч тэр шившлэгийг хааж саваагаа өргөөд өөр нэгэн шид илгээв.

- Үгүй! Үгүй! хүлээгээрэй! Зогс! Зогсооч! гэж уйланхай Миртл жорлон цуурайтуулан хашгирав.

Харрийн нурууны ард тар нярхийн хогийн сав дэлбэрэхэд Хөл хөшөөх шившлэг илгээсэн ч Малфойн чихний дэргэдүүр өнгөрөөд уйланхай Миртлын сууж байсан суултуурыг хагалав. Миртл чанга хашгирахад эргэн тойрон усанд автагдаж Харри хальтарч унахад Малфой царайгаа мурийлган,

- Круци ... гэж хашгирлаа.

- Сектусемпра! гэж Харри шалан дээрээс орилоод саваагаа даллалаа.

Малфойн нүүр болон цээжнээс үл үзэгдэх илдээр цавчсан мэт цус асгарав. Тэр арагш найгаснаа усанд автсан шалан дээр пидхийтэл унаад гартаа байсан саваагаа унагалаа.

- Үгүй ... гэж Харри амьсгаадав.

Тэр гулгаж хальтигсаар хөл дээрээ босоод Малфой руу ухасхийхэд царай нь улаан болж цагаан алгаараа цусанд будагдсан цээжээ маажлав.

- Үгүй ... би ...

Харри юу хэлж байгаагаа өөрөө ч мэдсэнгүй өвдөглөн унаад цус асгаруулж буй

Малфойг сэгсэрлээ.

Уйланхай Миртл чих дөжрөм орилов.

- Алуурчин! Жорлонд аллага гарлаа! Алуурчин!

Үүдний хаалга тасхийн нээгдэхэд Харри айдаст автан эргэж харвал цонхийн цайсан Снегг орж ирлээ. Тэр Харриг бүдүүлгээр хажуу тийш түлхээд өвдөг дээрээ сөгдөн шидэт саваагаа гаргаж ирээд гүнзгий шархан дээгүүр явуулж ямар нэгэн аялгуу шиг

шившлэг бувтналаа. Цус урсах нь намдаж эхлэхэд Снегг Малфойн нүүрэн дээр даллан шившлэгийг давтав. Шарх нүдэн дээр аньж эхэллээ.

Харри айдаст автан Снегг рүү хараад цустай усанд нэвт норсон болохоо анзаарав. Хаа нэгтээ дээр уйланхай Миртл цурхирана. Снегг эсрэг шившлэгийг гурав дахь удаагаа хийгээд Малфойг өргөн хөл дээр нь босгов.

- Та эмнэлэгт очих хэрэгтэй. Зарим төрлийн шархнуудыг даруйхан эмчлэхгүй бол хүндэрдэг юм. Явцгаая.

Тэр Малфойг дэмжин угаалгын өрөөн дундуур явснаа хаалга хүрээд зогсож хүйтэн ууртай хоолойгоор,

- Харин та, Поттер ... намайг энд хүлээж байгаарай гэлээ.

Харрийн толгойд үүнийг зөрчих санаа орсонгүй. Тэр удаанаар босоод чичирэн дороо байгаа нойтон шал руу харлаа. Дор нь хүрэн улаан цэцэг шиг цусны толбо хөвж байв. Түүнд үргэлжлүүлэн уйлсаар байгаа уйланхай Миртлийг чимээгүй болгох тэнхэл ч байсангүй.

Снегг арван хормын дараа эргэж ирэв. Тэр жорлонд орж ирээд хаалга хаалаа.

- Эндээс яв гэж Миртлд тушаахад агшин зуур суултуур руу шумбан орж ардаа нам гүм үлдээв.

- Би юу болохыг мэдээгүй гэж Харри хэлэхэд хоолой нь хүйтэн усаар дүүрсэн жорлонд цуурайтав.

- Би шившлэг яаж үйлчилдэгийг мэдээгүй. Гэвч Снегг түүний үгийг үл тоомсорлов.

- Би таныг дутуу үнэлсэн бололтой, Поттер. Таныг хар шид мэддэг гэж хэн бодох билээ? Хэн таньд энэ шившлэгийг сургасан бэ?

- Би ... хаа нэгтээгээс уншсан юм.

- Хаанаас?

- Энэ ... номын сангийн ном байсан. Нэрийг нь санахгүй байна.

- Худалч! гэж Снегг хэлэхэд Харрийн хоолой хатлаа. Тэр Снегг түүний хэзээ ч ийм зүйл хийгээгүй болохыг нь мэдэж байгааг ойлгож байв ...

Жорлонд нам гүм болов. Харри толгойноосоо бүх бодлоо авч хаяхыг хичээн эрлийз хунтайжын уусмалын сурах бичгийг санахгүй байх цөхөрсөн оролдлого хийв.

Дараа нь усанд автаж хэмхэрсэн угаалгын өрөөний дунд зогсож байгаа Снегг руу харлаа. Тэр айхгүй байхыг хичээсэн авч ...

- Надад цүнхээ аваад ир. Бас бүх сурах бичгээ. Бүгдийг нь шүү. Ийшээ аваад ир. Даруйхан! гэж Снегг тайвнаар шаардав.

Маргах нь ухаангүй хэрэг байлаа. Харри үүд рүү эргээд ус үсчүүлэн жорлонгоос үсрэн гарлаа. Хонгилд гарсан даруйдаа Гриффиндорын цамхаг руу гүйв. Замд

тааралдсан хүмүүс түүнийг цустай усанд шалба норсон байдлыг нь гайхан харцгаана. Харри дэргэдүүр нь асуултанд хариулалгүй өнгөрөв.

Тэр дуртай гэрийн тэжээмэл амьтан нь гэнэтхэн догшин араатан болж хувирсан мэт гайхан мэгджээ. Хунтайж номдоо тийм шившлэгийг юу бодож оруулсан юм бол? Хэрвээ Снегт түүнийг харвал юу болох вэ? Слизнортод түүнийг ямар аргаар жилийн турш уусмалын хичээл дээр амжилт гаргаж байсныг хэлэх байхдаа гэж бодтол дотор нь гал шатлаа. Хичнээн их зүйл заасан номоо хураалган устгуулах хэрэг үү? Ном түүний найз шиг байсан биз дээ? Харри үүнийг чадахгүй ... чадахгүй ...

- Чи хаана байсан бэ? Яагаад норчихсон юм? Энэ юун цус вэ? ... гээд Рон шатны дээр зогсоод Харри руу гайхан харлаа.

- Надад чиний ном хэрэгтэй байна. Уусмалын хичээлийн сурах бичиг чинь.

Түргэлээрэй ... нааш нь өг ... гэж амьсгаадан хэллээ.

- Хунтайжынх яасан юм ...

- Дараа тайлбарлая!

Рон цүнхнээсээ уусмалын хичээлийн сурах бичгээ гаргаж Харрид өгөхөд амралтын өрөөн дундуур гүйлээ. Тэр цүнхээ авмагц оройн хоолоо дуусгаад эргэн ирж буй сурагчдын гайхсан харцыг тоолгүй ахин хөргөн нүхээр гарч долоон давхар руу гүйв.

Бүжиглэж буй савдагтай хөргийн өмнө гулган зогсоод нүдээ анин урагш хойш холхилоо.

«Надад номоо нуух газар хэрэгтэй байна ... Надад номоо нуух газар хэрэгтэй байна ... Надад номоо нуух газар хэрэгтэй байна ...»

Гурван удаа нүцгэн хананы дэргэдүүр өнгөрөөд нүдээ нээж Шаардлагатай өрөөний хаалгыг харлаа. Харри түүнийг нээгээд өрөөнд нисэн орж хаав.

Тэгтэл гайхсандаа хөшлөө. Түүнийг угаалгын өрөөнд хүлээж байгаатай холбоотой яарч сандарсан айдас нь харсан зүйлдээ бишрэхгүй байж чадсангүй. Тэр том цогчин дуганы хэмжээтэй өрөөнд зогсоод өндөр цонхноос цацрах туяа Хогвартсын олон олон эзэмшигчдийн юмаа нуусан цамхаг шиг сүндэрлэсэн ханан хотыг гийгүүлэв. Энд амжилтгүй болсон шидийн оролдлогоо нуухаар чирч авчирсан юмуу эсвэл гэрийн үйлчлэгч авчирсан бололтой эвдэрхий тавилга хэрэгслийн овоолгын зугаалж болмоор өргөн гудамж үүсчээ. Энд эргэлзээгүй хориотой болон хулгайлсан мянга мянган ном болон сараачмал бичгүүд байлаа. Түүнчлэн далавчтай харвагч, хаздаг нисдэг таваг байсан нь өөр бусад хориотой зүйлсийн овоолгын дундуур намуухан хөөрөн байв. Бас өтгөрсөн уусмалтай шил, малгай, үнэт чимэглэл, жанч, лууны өндөгний хальсыг санагдуулам зүйл, гялалзсан шингэн бүхий бөглөөтэй лонх, хэдэн хэдэн зэвэнд идэгдсэн илд, цусны толботой хүнд сүх байлаа.

Харри яаран нууц эрдэнэсийн олон гудмын нэг рүү очив. Тэр том чихмэл савдгийн дэргэдүүр баруун тийшээ эргээд жаахан гүйж зүүн тийшээ эргээд эцэст нь өнгөрсөн жил Монтегю толгойгоо шургуулдаг эвдэрсэн алга болдог шүүгээний дэргэдэх хоолны шүүгээний өмнө зогслоо. Харри чахарсан хаалганы нэгийг нь ойнгойлгоход

удаан хугацааны өмнө хэн нэгэн ашигласан бололтой тортой таван хөлтэй үхсэн амьтны араг яс байв. Тэр эрлийз хунтайжын номыг торны ард шургуулаад хаалаа. Агшин зуур овоолсон зүйлсийг гүйлгэн хараад зүрх нь хүндээр цохилон. Тэр энэ шүүгээг ахин хаягдал дундаас олох боломжтой болов уу? Харри баримжаа авахын тулд ойролцоох хайрцаган дээр байгаа толгойдоо тоостой хуучин хиймэл үс, өнгөө алдсан титэм угласан ямар нэг шидтэний цээж баримал руу харлаа. Дараа нь хурдтайгаар овоолсон зүйлсийн дундуур буцаж гүйгээд хонгилд үсрэн гарч хаалга хаалаа.

Тэгээд нэг давхарын дор байгаа жорлон руу гүйнгээ цүнхэндээ Роны сурах бичгийг хийлээ. Хормын дараа Снеггийн урд зогсоод чимээгүйхэн цүнхээ сунгав. Харри түүнийг өгөөд амьсгаадан цээжээр нь хатгуулахад хүлээн зогслоо.

Снегг номнуудыг нэг нэгээр нь шалгаж үзэв. Эцэст нь цүнхэнд хамгийн сүүлчийн ном болох уусмалын хичээлийн сурах бичиг үлдэхэд маш анхааралтай судаллаа.

- Энэ таны уусмалын хичээлийн сурах бичиг үү, Поттер?
- Тиймээ.
- Та үүнд үнэхээр итгэлтэй байна уу?
- Тиймээ гэж Харри батлав.
- Та түүнийг «Флориш Блоттс» дэлгүүрээс худалдан авсан уу?
- Тиймээ гэж Харри хатуу давтав.
- Тэгвэл яагаад дотор талын хавтсан дээр нь «Рундил Уизлик» гэсэн нэр байгаа юм бэ?

Харрийн зүрх палхийлээ.

- Намайг ингэж хочилдог юм.
- Хоч гэнээ хэмээн Снегг давтав.
- Аанхан, найзууд минь тэгж дууддаг юм гэж Харри батлав.
- Хоч гэдэг танил үг байна гэж Снегг хэлэв.

Түүний хүйтэн хар нүд ахин Харри руу цоо ширтэхэд урдаас нь харахгүйг хичээв.

«Оюун ухаанаа хоосол ... оюун ухаанаа хоосол ...» Гэвч тэр хэзээ ч үүнийг жинхэнээсээ хийхэд суралцаж байсангүй.

- Миний юу бодож байгааг мэдэх үү, Поттер? Би таныг худалч хууран мэхлэгч учир улирлын төгсгөл хүртэл бямба гариг бүр над дээр ирэх шийтгэл хүртэх гавъяатай гэж бодож байна. Та энэ талаар юу гэж бодож байна, Поттер?

- Би ... би таныг зөвшөөрөхгүй байна, ноёнтоон гээд Харри өмнөхийн адил Снеггийн нүд рүү харсангүй.

- За, сайн байна шийтгэлийн дараа юу гэж бодохыг чинь харцгаая. Бямба гаригт өглөөний арван цагт шүү, Поттер. Миний өрөөнд.



- Гэхдээ, ноёнтоон ... Квиддич ... улирлын сүүлчийн тэмцээн ... гээд Харри цөхрөн түүн рүү харлаа.

- Арван цагаас гэж Снегг шивнээд шар шүдээ ярзайлган инээмсэглээд,

- Хөөрхий Гриффиндор! Энэ жил дөрөвдүгээр байр эзлэнэ байх гэж айж байна гэв.

Ингээд тэрбээр өөр үг хэлэлгүй жорлонгоос гарлаа. Харри хагарсан толинд харахад Роны амьдралдаа үзэж байгаагүй дотор нь муухайрсан байв.

- Би чамд хэлсэн биз дээ гэж Гермiona цагийн дараа амралтын өрөөнд хэлэв.

- Больж үз, Гермiona гэж Рон ууртай хэллээ.

Харри оройн хоолонд явсангүй, хооллох дур ч байсангүй. Тэр дөнгөж саяхан Рон, Гермiona, Жинни нарт болсон үйл явдлын талаар ярьж дуусаад байлаа. Мэдээ түргэн тарсны учир нь уйланхай Миртл шилтгээний бүх жорлонгоор хүн бүрт ярьжээ. Пэнси Паркинсон хэдийн Малфойг эмнэлэгт эргээд Харрийн нэр хүндийг гутаахаар чадахаараа хичээж, Снегг болсон явдлын тухай бүх багш нарт ярьжээ. Харри амралтын өрөөнөөс профессор МакГонагаллд юу болсныг тайлбарлахын тулд нэг удаа гарсан бөгөөд таагүй арван таван хормыг тэвчин өнгөрүүлсэн ч аз болоход сургуулиас хөөсөнгүй, Снеггийн улирлын төгсгөл хүртэл бямба гаригийн шийтгэлийг үнэн зүрхнээсээ дэмжлээ.

- Би чиний хунтайжид ямар нэг буруу зүйл байна гэж хэлсэн биз дээ. Тийм биш гэж үү? хэмээн Гермiona зөрүүдлэн давтав.

- Үгүй ээ, тийм биш гэж Харри эсэргүүцлээ.

Түүнд Гермionaгийн лекцийг сонсолгүйгээр муу зүйл хангалттай байв. Бямба гаригт тоглож чадахгүй болсноо хэлэхэд багийнхаа тоглогчдын царайг ямар болохыг харсан нь хамгийн муу шийтгэл байлаа. Одоо Жиннигийн харцыг мэдэрч байсан ч уурлаж эсвэл урам хугарсан эсэхийг нь харахаас эмээлээ. Тэр саяхан түүнд бямба гаригт баригчаар тоглох болсон тухай болон түүнчлэн Дин багт эргэн ирж ангуучийн байрыг эзлэх болсныг хэлжээ. Магадгүй тэд ялвал Жинни, Дин хоёр баярласандаа тэмцээний төгсгөлд эвлэрэх боломжтой. Энэ бодол Харриг хүйтэн чинжаал шиг хайрав ...

- Харри чи яаж урьдын адил номоо хамгаалж чадаж байна аа ...

- Номны талаар улиглахаа больж үз! Хунтайж зөвхөн түүнийг хуулан бичсэн байсан юм тэгээд л тэр! Энэ чинь хэн нэгэнд хэрэглэхийг зөвлөсөн хэрэг биш! Бид түүний эсрэг хүн хэрэглэсэнийг тэмдэглэсэн ч юмуу гэдгийг хаанаас мэдэх юм!

- Би үүнд чинь итгэхгүй байна. Чи зүгээр л цагаатгаж байна ...

- Би хийсэн зүйлээ цагаатгаагүй! Би олон арван шийтгэл авсандаа ч биш үүнийг хийсэндээ харамсаж байна. Чи намайг ийм шившлэгийг Малфойн эсрэг хүртэл хэрэглэхгүй гэдгийг сайн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд ч хунтайжыг

буруутгахаа больж үз, тэр ямар «оролдож үз, маш сайн» гэж бичсэн хэрэг биш. Тэр зүгээр л ажигласнаа бичсэнээс өөр зүйлгүй ...

- Чи номоо буцааж авна гэж хэлэх гэж байна уу?
- Номоо авах гэнээ? Тиймээ авна. Сонсож бай хунтайжгүй бол би хэзээ ч «Феликс Фелицис»-ийг авахгүй байсан. Хэзээ ч Роныг хороос аврахыг мэдэхгүй байсан. Бас хэзээ ч ...
- Чи уусмалын хичээлийн гялалзсан нэр хүндийнхээ тухай мартаад байна гэж Гермиона хорон нэмэрлэв.
- Тайвширч үз дээ, Гермиона! гэж Жинни хэлэхэд Харри гайхсандаа талархахаа мэдэрч дээшээ харлаа.
- Харваас Малфой уучлашгүй шившлэг хэрэглэх гэж байсан болохоор Харрид хэрэглэх зүйл байсан нь сайн хэрэг.
- Мэдээж би Харриг хөшөөх шившлэгэд өртөөгүйд баяртай байна! гэж Гермиона дуу алдаад,
- Гэхдээ Сектусемпра шившлэгийг сайн гэж нэрлэж болохгүй, Жинни түүний ямар байдалд орсныг хар л даа! Тэгээд ч тэмцээнд та нарын ялах боломжид ...
- Ёо, зөвхөн квиддичийг ойлгодог дүр л бүү үзүүлээрэй гэж Жинни тасхийгээд,
- Чи зөвхөн өөрөөсөө л ич! гэв.

Харри, Рон хоёр түүн рүү нүдээ томруулан харлаа. Гермиона, Жинни хоёр үргэлж сайхан харьцаатай байдаг хэдий ч одоо хоёр талд энгэртээ гараа зөрүүлэн ууртай сууцгааж байв. Рон Харри руу бухимдангуй харснаа ширээн дээр байсан номыг авч ард нь нуугдав. Харри ч гэсэн тэгж бодсон авч үдшийн турш тэдний хэн ч үг хэлсэнгүйд гэнэтхэн хөгжилтэй болов.

Гэвч хөгжилтэй байдал удтал үргэлжилсэнгүй. Маргааш өдөр нь Гриффиндорын ахмад нь улирлын сүүлчийн тэмцээний өмнө золгүйгээр хасагдсан явдалд Слизеринчүүдийн доог тохууг тэвчих хэрэгтэй боллоо. Бямба гаригийн өглөө Харри Гермионад талбай дээр Рон, Жинни болон бусад тоглогчдын хамт гарах боломжыг бүх «Феликс Фелицис»-ээ баяртай солих байснаа хэллээ. Гадагшаа нарны гэрэлд гарахаар явж буй дэмждэг багийнхаа ороолт зүүсэн бөөн сурагчдын дундуур зөрөх нь тэвчимгүй хэрэг байсан бөгөөд газар дорхи хонгилын чулуун шатаар уруудахад алсад хүүхдүүдийн дуу намдсан ч тайлбарлагч баяртай хашгирч байгааг мэдэж байв.

- Аан, Поттер гэж Снегг Харриг хаалга тогшин танил таагүй өрөөнд ороход хэлэв.

Өрөөнд үргэлжид байдаг шигээ бүүдгэр гэрэлтэй байх агаад ханын дагуу өрсөн янз бүрийн өнгөтэй уусмалд үхсэн амьтад хөвнө. Өөр илүү муу ёрын зүйл гэвэл аалзны торонд бүрхэгдсэн олон тооны хайрцаг ширээн дээр байх нь түүний хийх ёстой ажил боллоотой.

- Ноён Филч эртнээс хуучин бичиг баримтуудаа цэгцлэхэд тусламж авахыг хүссэн юм. Энд Хогварстын дүрэм зөрчигсөд болон оноосон шийтгэлийнх нь нэрс байгаа. Бэх нь бүдгэрсэн болон хулгана мэрсэн хэсгийг нь гэмт хэрэг шийтгэлийнх нь хамт хуулж бичээд цагаан толгойн дараалаар цэгцэлж хайрцагт хийгээрэй. Шид ашиглах хориотой.

- Ойлголоо, профессор гэж Харри сүүлчийн үгээ чадахаараа зэвүүн хэллээ.

- Би таныг эхэлж болно гэж бодож байна хэмээн Снегг уруулаа ёжтой мушийлган үргэлжлүүлээд,

- Нэг хайрцагт мянга хоёр зуугаас мянга таван зуун ширхэг байгаа. Та тэдний дунд зарим танил нэртэй тааралдах болохор ажил чинь илүү сонирхолтой байх болно. Хараач энэ байна ... гэв.

Тэр дээд талын хайрцганаас хуудас авч чанга уншлаа.

- «Жеймс Поттер болон Сириус Блэк. Хууль бус шид Бертрам Обридын эсрэг хэрэглэсний улмаас баривчлагдсан. Обригийн толгой хэвийн хэмжээнээс хоёр дахин хөөсөн. Давхар шийтгэл» гэж уншаад хөхөрч,

- Тэд биднийг орхисон ч томоохон амжилт нь үлдсэнд таатай байна гэв.

Харри танил уур хилэнг мэдэрлээ. Тэрбээр юу ч хэлэхгүйн тулд хэлээ хазаад хайрцагны ард суун нэгийг нь татлаа.

Ийм ашиггүй уйтгартай ажил Харри урьд өмнө үзэж байсангүй (Снегг л бодож олсноос гарцаагүй). Тэр эцгийнхээ болон Сириусын нэрийг олох болгонд сэтгэл нь догдлох бөгөөд тэдний бага сага ялгаатай хэргүүд дээр үе үе Римус Люпин болон Питер Петтигрю нар нэгдэж байлаа. Тэр боломжтой бүх шийтгэлийг хуулан бичих зуураа гадаа юу болж байгааг тааварлан сууж байлаа. Тэмцээн хэдийн эхэлж Жинни Чжоугын эсрэг баригчаар тоглож байх ёстой ...

Харри ахин дахин хананд өлгөсөн том цаг руу харахад зүү ердийнхөөс хоёр дахин удаан хөдөлж байгаа юм шиг санагдав. Магадгүй Снегг түүнийг удаашруулах шидээр илбэдсэн юм болов уу? Тэр энд ердөө хагас цаг суусан байж боломжгүй юм

... цаг ... хагас цаг ...

Харрийн гэдэс хүржигнэх үед цагийн зүү арван хоёр хагасыг зааж байв. Снегг даалгаварыг нь биелүүлж байх үед үг хэлсэнгүй бөгөөд эцэст нь нэг цаг арван минут болоход дээшээ харлаа.

- Би үүнийг хангалттай гэж бодож байна. Байранд нь буцааж тавиарай.

Дараагийн бямба гаригт арван цагаас үргэлжлүүлнэ шүү гэж хүйтнээр хэлэв.

- Тиймээ, ноёнтоон.

Харри үрчийсэн цааснуудыг хайрцагт буцаан чихээд түүнийг бодлоо өөрчилөхөөс өмнө яаран хаалга руу явж чулуун шатаар гүйн гарахдаа талбай дээр ямар нэг чимээ шуугиан сонсохыг хичээсэн ч юу ч сонсогдсонгүй. Тэмцээн дууссан бололтой.

Тэр дүүрэн хүнтэй их танхимын дэргэд удаашраад гантиг шатаар өгслөө. Гриффиндор хожиж хожигдсон ч бай багийнхан нь амралтын өрөөндөө суугаад ердийнхөөрөө баярлах юмуу гашуудаж байгаа нь лавтай.

- Юу байна? гэж тэр тарган хатагтайгаас сониучирхаад юу болсныг таахыг оролдов.

Түүний царайны хувирлаас тарган хатагтай тааварласан бололтой,

- Өөрөө хараарай гэлээ. Түүнийг нээгдэхэд Харри орлоо.

Тэгтэл хөөрсөн дуу нүргэлэв. Харри амралтын өрөөнд байсан хүмүүс хашгирахыг алмайран хартал хэдэн гар дотогш нь чирэн оруулав.

- Бид ялсан! Ялсан! Дөрвөн зуун тав, зуун дөчөөр! Бид ялсан! гэж Рон урд нь орилоод мөнгөлөг цомоор даллав.

Харри эргэн тойрноо харахад Жинни баярлаж хөөрсөн царайтай гүйн ирээд тэвэрлээ. Ингээд тэр юу ч бодож амжилгүй, тэдэн рүү тавин хүн ширтэж байгаа гэдгийг ч ойлголгүй түүнийг үнсчихлээ.

Удаан үргэлжилсэн мөчийн дараа (магадгүй хагас цаг) тэд хоёр тийш салав. Амралтын өрөөнд нам гүм болов. Хэн нэгэн шүгэлдэж, хаа нэгтээгээс хийрхэн инээд алдах дуулдлаа. Харри Жиннигийн толгой дээгүүр хартал Дин Томас чичирсэн гартаа аяга барин зогсч байлаа. Гермiona баясан инээмсэглэхэд Харри Роныг хайлаа. Эцэст нь түүнийг олоход гартаа цомоо атган зогсоод царсан бороохойгоор толгой руугаа дэлсүүлчихсэн юм шиг байв. Тэд агшин зуур бие бие рүүгээ харахад Рон үл мэдэг толгой дохилоо.

Харрийн цээжинд байсан амьтан ёслол төгөлдөр архирахад Жинни рүү харж инээмсэглээд чимээгүйхэн хөргөн нүхээр гарахыг дохилоо. Хоёулаа удтал шилтгээнээр зугаалахад өнгөрсөн тэмцээний тухай ярихад цаг хангалттай байлаа.

## БҮЛЭГ 25: ҮЗМЭРЧИЙГ СОНССОН НЬ

Харри Поттер Жинни Уизлитэй уулзаж эхэлж байгаа яриа хүмүүсийн дунд тархан гайхуулсаны ихэнхи нь охид байлаа. Тэгсэн ч Харри сүүлчийн хэдэн долоо хоногт цуу ярианд жаргалтай байв. Эцсийн эцэст чамайг удаан хугацааны турш хар шидийн аймшигтай үйл явдалд холбоотой гэж ярьж байсны хувьд энэ нь таатай өөрчлөлт байлаа.

- Чи хүмүүсийн цуу ярианы тухай юу гэж бодож байна гэж Жинни амралтын өрөөнд Харрийн хөлийг түшин суугаад «Өдөр тутмын зөнч» сонин уншиж байхдаа хэлэв. Долоо хоногт Дементорын гурван дайралт гарсан байна. Бас Ромильда Вейн надаас нэг асуулт асуусан. Чиний цээжин дээр үнэхээр гиппогрифын шивээс байдаг юм уу гэж.

Рон, Гермиона хоёр инээд алдав. Харри тэдний зүг рүү харсангүй.

- Чи тэгээд юу гэж хэлсэн бэ?
- Чамд Унгарын эвэр сүүлт байдаг гэж хэлсэн. Маш эрч хүчтэй гээд Жинни яаралгүйхэн сонингоо эргүүлэв.
- Баярлалаа. Харин Роныг юу гэж хэлсэн бэ? гээд Харри инээмсэглэв.
- Үстэй бөмбөлөг. Гэхдээ хаана байгааг нь хэлээгүй.

Рон таагүй хөмсөг зангидахад Гермиона писхийтэл инээд алдав.

- Та хоёр болгоомжтой л байгаарай гээд Рон тэднийг хуруугаараа сүрдүүлэн зангаж,
- Хэрвээ би чамд зөвшөөрвөл ... гэв.
- Чиний зөвшөөрөл гэнээ? хэмээн Жинни тохуурхан асуугаад,
- Одоог хүртэл надад чиний зөвшөөрөл шаардагдаж байсан хэрэг үү? Ингэхэд чи Харриг Майкл, Дин хоёроос дээр гэж хэлсэн биз дээ гэв.
- Хэлсэн л дээ гэж Рон дургүйхэн зөвшөөрөөд,
- Гэхдээ энэ чинь бүгдийн нүдэн дээр тэврэлдэн үнсэлдэж эхлэнэ гэсэн үг биш гэв.
- Чи ч жигшүүртэй хоёр нүүртэн юм даа! Лаванда та хоёр шилтгээн даяар хос могой загас шиг тэврэлдээд байснаа юу гэж хэлэх гэж байна? гэж Жинни шаардлаа.

Гэвч зургаан сар эхлэхэд Харри, Жинни хоёр бие биетэйгээ байх нь цөөрсөн учир Роны тэвчээр шалгагдах явдал болсонгүй. Жиннигийн С.И.Ш-ийн шалгалт ойртож байсан тул шөнө орой болтол номын ард суух хэрэг гарч байлаа. Нэг тийм үдэш Жинниг номын сан явсан хойгуур Харри амралтын өрөөний цонхны дэргэд ширээн дээр суугаад ургамал судлалын зохион бичлэгээ дуусгангаа Жиннитэй үдийн хоолны дараа нууран дээр цагаа сайхан өнгөрүүлсэн тухай санаж суулаа. Гермиона түүн рүү өчүүхэн ч таатай зүйл илтгээгүй өнгөөр шийдэмгий харав.

- Бид ярилцах хэрэгтэй байна, Харри.
- Юуны тухай? гэж тэр сэжигтэй асуулаа. Саяхны үдэш Гермiona түүнийг Жиннигийн шалгалтанд бэлтгэх явдлыг нь сатааруулж байна гэж хэлсэн билээ.
- Эрлийз хунтайж гэдэг нэрний тухай.
- Ахиад л биш шүү гэж Харри дуу алдан ёолоод,
- Чи хэзээ үүнийгээ болих юм бэ? гэв.

Тэр Шаардлагатай өрөө лүү номныхоо араас явахыг зүрхэлсэнгүй бөгөөд уусмалын хичээл дээр онцгой амжилт гаргахаа больжээ (Слизнорт үүнийг өөдрөгөөр Харрийн дурлалдаа шатсанаар тайлбарлажээ). Харри Снегг хунтайжын номыг гартаа оруулах найдлагаа алдаагүй гэдэгт итгэлтэй байсан тул болгоомжтой байхаар шийдсэн байлаа.

- Намайг сонстол чинь гэж тэр хатуу хэлээд,
- Одоо би хэн тийм хар шидийн шившлэг зохион бүтээх дуртай болохыг тайлбарлах гэж оролдож байна ... гэв.
- Түүнд тийм сонирхол байхгүй ...
- Түүнд гэнээ? Тэр гэдэг чинь хэн юм?
- Сонсооч бид энэ тухай ярилцсан гэж Харри уурлаад,
- Хунтайж Гермiona, Хунтайж! гэв.
- Зүйтэй! гээд Гермionaгийн хацар дээр хэдийн улаан толбо гарч эхэлжээ. Тэр халааснаасаа хуучин сонин гаргаж Харрийн урд талын ширээн дээр тасхийтэл тавив.
- Үүнийг хар! Зургийг нь хараач!

Харри хуудсыг өргөн хуучирч шарласан амьд зураг руу харахад Рон мөн адил тонгойлоо. Зурган дээр арван тав орчим настай ясархаг охин байв. Тийм ч хөөрхөн биш өтгөн хөмсөг, гонзгой зэвхий царайтай ажээ. Зурганы дор «Эйлин Принц, Хогвартсын чулуун тоглоомын багийн ахлагч» гэж бичжээ.

- Тэгээд? гэж Харри асуугаад зурганы доод талын сургууль хоорондын уйтгартай тэмцээний товч мэдээг гүйлгэн харлаа.
- Түүнийг Эйлин Принц гэж дууддаг. Принц, Харри.

Тэд бие бие лүүгээ харахад Харри эцэст нь Гермionaгийн юу хэлэхийг оролдож байгааг ойлгов. Тэр инээд алдлаа.

- Яагаад ч биш.
- Юу гэнээ?
- Чи түүнийг эрлийз гэж бодож байна уу? Өө, алив л дээ.
- Яагаад үгүй гэж? Харри, шидтэний ертөнцөд жинхэнэ хунтайж байхгүй! Энэ бол хэн нэгний хоч ч биш жинхэнэ нэр байвал яах юм? Үгүй ээ, чи сонс! Хэрвээ

түүний эцэг шидтэн байгаад «Принц» гэсэн овогтой байсан бол эх нь маглаас гаралтай болохоор «эрлийз Принц!» гэдэг нэртэй болно.

- Тиймээ, маш ухаалаг байна, Гермiona ...
- Гэхдээ байж болно биз дээ! Магадгүй тэр «эрлийз Принц» гэдэг нэрээрээ бахархдаг ч байж болох юм!
- Сонс, Гермiona би үүнийг охин биш гэдгийг мэдэж байна. Зүгээр л мэдэж байна!
- Чи үнэндээ охидын ухаанд ийм зүйл орохгүй гэж бодож байна хэмээн Гермiona ууртай мэдэгдэв.
- Сонирхолтой нь би чиний дэргэд таван жил сурсан хэр нь охидод хангалттай ухаан байдаггүй гэж хаанаас хэлэх болж байна? Энэ түүний бичгээс л мэдэгдэж байна. Би зүгээр л хунтайжыг эр хүн гэдгийг мэдэрч байна. Энэ охин түүнтэй ямар ч хамаагүй. Ингэхэд чи түүнийг хаанаас авсан юм бэ?

Гермонагийн хариулт бүрэн урьдаас төлөвлөсөн байлаа.

- Номын сангаас. Тэнд хуучин «Зөнч» сонины дугаарууд байсан. За, би Эйлин Принцийн тухай арай ихийг мэдэхээр явлаа. Тэгээд мэдэх ч болно.
  - За, тэгвэл зугаацаж үз гэж Харри уурсан хэлэв.
  - Энэ ч тодорхой. Нэгдүгээрт би заавал хуучин уусмалын хичээлийн аваргуудыг харах болно гэж тэр хөргөн нүхээр гарахдаа хэллээ.
- Харри түүний араас хэсэг зуур уурсан харснаа харанхуй тэнгэр лүү харан бодлогоширов.

- Тэр зүгээр л чамайг уусмалын хичээлд давсанд эвлэрч чадахгүй байгаа юм гэж Рон «Ид шидэт мянган ургамал мөөг» ном руугаа бөхийгөөд хэлэв.
- Чи намайг номыг эргүүлэн авахыг хүссэнээрээ бас галзуурсан гэж бодож байна уу?
- Мэдээж үгүй. Хунтайж бол агуу. Тэгээд ч түүний безоарын тухай хэлсэн үг байгаагүй бол ... гээд Рон хоолой руугаа учиртай зааснаа,
- Би чамтай энд яриад сууж байхгүй байсан. Гэхдээ чиний Малфойд ашигласан шидийн хувьд тийм гэж бодохгүй байна гэв.
- Би ч гэсэн хэмээн Харри яаран хэлэв.
- Гэхдээ тэр эдгэрсэн биз дээ? Нүд цавчиж амжаагүй байхад эдгэрсэн.
- Тийм шүү. Үүнд Снеггэд талархах байна гэж Харри зөвшөөрөв.
- Чи ахиад л энэ хагас сайнд түүн рүү очих уу?
- Дараа дараагийнханд нь ч гэсэн. Тэр намайг улирлын эцэс хүртэл бүх хайрцагтайг янзалж чадахгүй бол ирэх хичээлийн жил ахин учрах болно гэсэн.

Снеггийн өрөөнд байх шийтгэл өмнөхийн адил маш залхуутай байсан бөгөөд Жиннитэй өнгөрүүлэх ихэнхи цагаа алдаж байв. Үнэндээ сүүлийн өдөр Снегт үүнийг ойлгосон эсэхийг тааварлаагүй ч урьд урьдынхаас ихээр саатуулсны улмаас Харри сайхан цаг агаарт өнгөрүүлэх бүх зүйлээ алджээ.

Харриг энэ гашуудалтай бодлоос нь гартаа хуйлаастай цаас барьсан Жимми Пиксийн ирэлт салгав.

- Баярлалаа, Жимми ... Хөөх энэ Дамблдорос байна! гэж Харри хөөрөн хэлээд цаасыг дэлгэж харлаа.

- Тэр намайг даруйхан өрөөндөө ирэхийг хүсчээ! Тэд бие бие рүүгээ ширтлээ.

- Чөтгөр гэж ... Чи тэгж бодож байна уу ... тэр олсон юм болов уу гэж Рон шивнэв.

- Явж харсан нь дээр биш үү? гээд Харри хөл дээрээ үсрэн бослоо.

Түүнийг амралтын өрөөнөөс яаран гарч долоон давхарын хонгилоор явахад Пивзээс өөр хэн ч байсангүй бөгөөд урдаас нь шохойгоор чулуудан хөхрөөд Харрийн илгээсэн хамгаалах шившлэгээс бултав. Пивзийг алга болмогц хонгилд нам гүм болж бүх сурагчид амралтын өрөөндөө цуглахад ердөө арван таван хором үлджээ.

Харрид гэнэтхэн хашгиралт цохих чимээ дуулдав. Тэр зогсоод сонслоо.

- Та нар ... яаж ... зүрхэлж байна аа ... ааа!

Энэ чимээ ойролцоох хонгилоос гарахад Харри шидэт саваагаа бэлхэн бариад ухасхийн булан тойроод харвал профессор Трелони шалан дээр толгойгоо тоо тоомшгүй олон зүүлтээрээ хучаад тэрийн хэвтэж дэргэд нь хэдэн лонх дарс байсны нэг нь хагарсан байлаа.

- Профессор ...

Харри яаран профессорыг босоход нь туслав. Хэдэн гялалзсан зүүлт түүний нүдний шилэнд нь орооцолджээ. Профессор Трелони чанга ханиалгаад алгаараа үсээ илэн Харрийн гараас атган бослоо.

- Юу болоо вэ, профессор?

- Маш сонирхолтой асуулт байна! Би ойр хавиар зугаалан зэрвэс харсан муу зөн совингийнхоо талаар бодлогоширч байтал ...

Гэвч Харри үүнд анхаарал хандуулсангүй. Тэр гэнэтхэн баруун талд нь бүжиглэж байгаа савдгуудын зурагтай хөрөг, зүүн талд нь нүцгэн хана байхыг харлаа.

- Профессор та Шаардлагатай өрөөнд орох гэж оролдоо юу?

- ... зөн совин батлагдаад ... Юу? Тэр гэнэтхэн харц буруулав.

- Шаардлагатай өрөө гэж Харри давтаад,

- Та түүн рүү орохыг оролдоо юу? гэв.

- Би ... сурагчид тэгж нэрлэдгийг мэдсэнгүй ...



- Бүгд биш л дээ. Гэхдээ юу болсон юм бэ? Та хашгирсан ... Надад өвдсөн юм шиг санагдсан юмсан.

- Би ... э-э ... гээд профессор Трелони алчуураа болгоомжтой засаад Харри руу том нүдээрээ ширтсэнээ,

- Би ... Шаардлагатай өрөөнд хэдэн ... м-м хувийн эд зүйлээ хадгалах гэсэн юм ... гэв.

Ингээд тэр араас нь ямар нэг таагүй үг бувтналаа.

- Ойлгож байна гээд Харри дарсны лонх руу харснаа,

- Гэхдээ тэднийгээ нуухаар орж чадсангүй юу? гэв.

Түүнд энэ хачирхалтай санагдав. Эцсийн эцэст тэр эрлийз хунтайжын номыг нуухыг хүсэхэд өрөө онгойсон шүү дээ.

- Үгүй, би орсон гээд профессор Трелони хана руу ууртай харж,

- Гэхдээ тэнд хэн нэгэн байсан гэв.

- Хэн нэгэн гэнээ ...? Хэн? Өрөөнд хэн байсан юм? гэж Харри шаардав.

- Хэн гэнээ? Мэдэх юм алга гэж профессор Трелони Харрийн шаардангуй дуунд балмагдан хэлээд,

- Би Шаардлагатай өрөөнд ороод хоолой сонссон ... урьд нь олон жилийн турш нуухаар ... ашиглаж байхад хэзээ ч ийм явдал тохиолдож байсангүй гэв.

- Хоолой гэнээ? Тэр юу гэж хэлсэн бэ?

- Юу хэлснийг нь мэдэхгүй байна. Энэ ... баяртай хашгиралт байсан.

- Баяртай гэнээ?

- Хөөрсөн гэж профессор толгой дохин батлав. Харри түүн рүү ширтлээ.

- Тэр эрэгтэй хүн байсан уу эмэгтэй хүн байсан уу?

- Би эрэгтэй байсан гэж хэлсэн биз дээ.

- Тэр баяртай сонсогдож байсан юм уу?

- Аз жаргалтай гэж профессор Трелони инээвхийлэв.

- Ямар нэг баяр тэмдэглэж байгаа юм шиг үү?

- Маш төстэй байна.

- Харин дараа нь ...?

- Харин дараа нь би «Энд хэн байна?» гэж хашгирсан.

- Та асуулгүйгээр үүнийг мэдэж чадсангүй гэж үү? хэмээн Харри урам хугаран асуулаа.

- Дотоод мэлмий минь орчлон ертөнцийн гаднах баяр хөөрийг сонсдог юм гэж профессор Трелони сүр жавхлантай мэдэгдээд алчуураа илж олон тооны зүүлтээ заслаа.

- Ойлгомжтой гэж Харри яаран хэллээ. Тэр профессор Трелонигийн дотоод мэлмийн тухай олон удаа сонсож байсан билээ.

- Тэгээд таньд хоолой хариулав уу?

- Үгүй, хариулаагүй. Эргэн тойрон гэнэтхэн харанхуй болоод би дараагийн агшинд Шаардлагатай өрөөнөөс толгойгоороо нисэн гарч байгаа болохоо мэдсэн!

- Тэгээд хэнийг ч харж чадсангүй юу? гэж Харри тэссэнгүй асуулаа.

- Үгүй, чадаагүй би тэнд харанхуй байсан гэж хэлсэн биз дээ яг л ... гээд чимээгүй болсноо Харри руу сэжигтэй харлаа.

- Би таныг энэ тухай профессор Дамблдорт хэлсэн нь дээр гэж бодож байна.

Тэр Малфойн баярлаж байгааг мэдэх хэрэгтэй ... би таныг Шаардлагатай өрөөнөөс гаргасан хүнийг гэж хэлэх гэсэн юм л даа.

Түүний гайхлыг төрүүлэн профессор Трелони энэ саналыг сонсмогц ихэмсгээр цэхлэн зогслоо.

- Сургуулийн захирал надад цөөн ирж байх талаар үг цухуйлгасан. Харин би өөрийгөө үнэлэхгүй байгаа хүнтэй харьцаж дасаагүй. Хэрвээ Дамблдор урьдын адил миний хэзрийн анхааруулгыг үл тоомсорлосон хэвээр байвал ...

Тэр гэнэтхэн ясархаг хуруугаараа Харрийн бугуйнаас зуурснаа,

- Намайг дахин дахин холих болгонд гээд жүжигчилсэн байртай алчууран дороосоо хөзөр гаргаж ирээд,

- Аянгат цамхаг. Золгүй явдал. Гай зовлон. Бүгд улам ойртож байна ... гэж шивнэлээ.

- Ойлгомжтой. Тэгсэн ч гэсэн та энэ тухай Дамблдорт хэлэх хэрэгтэй. Дуу хоолой болон харанхуй болоод Шаардлагатай өрөөнөөс хөөж гаргасан тухай

...

- Та тэгж бодож байна уу? гээд профессор Трелони Харри руу харан бодлогоширов.

- Би яг одоо түүн рүү явж байна. Бид хоёр уулзах ёстой юм. Ингэхэд хамтдаа явж болно шүү.

- Өө, ийм тохиолдолд бол ... гэж профессор Трелони инээмсэглээд бөхийн шалан дээрээс лонхнуудаа авч ойролцоо байсан том цэнхэр вааранд хүчээр чихлээ.

- Таныг миний ангид байсныг санаж байна, Харри. Та мэргэ төлөгт хэзээ ч онцгой амжилт гаргаж байгаагүй ... гэхдээ гайхалтай биет байсан ...

Харри хариу хэлсэнгүй. Тэр профессор Трелонигийн хэдийн тасралтгүй үхлийг зөгнөдөг биет байсан билээ.

- Би тэр хөгшин морийг ... өршөөгөөрэй хүн морь гэх гэсэн юм ... хэзрийн мэргийн тухай юу ч мэдэхгүй гэж айж байна. Би түүнээс жинхэнэ зөгнөгч шиг золгүй явдлын чичирхийлэлийг алсаас мэдэрдэг үү гэж асуусан. Гэхдээ тэр надаас инээдтэй зүйл олсон бололтой. Тиймээ, инээдтэй!

Түүний хоолой хийрхэх шахам болоход Харри ард хагарсан дарсны үнэр хүчтэй ханхлахыг мэдрэв.

- Магадгүй энэ морь л намайг агуу өвөг эцгийнхээ авъяасыг өвлөөгүй гэсэн яриа гаргасан байх боломжтой. Ийм цуу яриа атаархал намайг олон жилийн өмнөөс дагаж байгаа юм. Би тэдэнд юу хариулдагыг мэдэх үү, Харри? Дамблдор намайг энэ агуу сургуульд багшилахаар урихдаа эдгээр жилүүдэд итгээгүй хэрэг байх нь уу? Би түүнд өөрийгөө баталж үзүүлээгүй гэж үү?

Харри сонсдох төдий зүйл бувтналаа.

- Дамблдортой анх уулзсан тухайгаа сайн санаж байна. Би түүнд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн шүү, маш гүнзгий ... Би тэгэхэд «Гахайн толгойд» буудаллаад гэхдээ таньд тэгж зөвлөхөөргүй байна ... ор нь бясаатай юм билээ, хүү минь ... гэвч хөлс нь хямд байсан шүү. Дамблдор намайг буудлын өрөөнд эелдэгээр урьсан. Тэр надаас асуулт асуусан юм ... Эхэндээ надад мэргэ төлөгт тэр талархалтай ханддаггүй санагдсаныг нуух юун. Гэтэл надад тэр өдөр бараг юу ч идээгүй юм шиг хачирхалтай мэдрэмж төрсөн юм ... тэгээд дараа нь ...

Эдгээр мөчид Харри профессор Трелониг маш анхааралтай сонсож байсан болохоор Волан-де-Морт тэр хоёрт хамаатай зөгнөлийг хэлсэн өдрийн тухай ярьж байгааг ойлголоо.

- ... дараа нь бидний яриаг Северус Снегг бүдүүлгээр тасалсан.

- Юу?

- Тиймээ, хаалганы цаана чимээ шуугиан сонсогдоод нээгдэхэд болхи үйлчлэгч Снеггийн хамт зогсож байсан. Снегг шат андуурсан тухай ямар нэг зүйл бувтнасан ч надад тэр Дамблдор бид хоёрын яриаг сонсож байгаад баригдсан нь ойлгомжтой байсан. Харж байна уу тэр өөрөө энэ ажлыг авахыг хүсч байсан болохоор эргэлзээгүй тийм аргаар ашигтай мэдээлэл авна найдсан байж! Үүний дараа Дамблдор намайг дуртайгаар ажилд авсан. Би түүнийг хүнд хэцүү эрс тэс байдалд даруу төлөв маяг авъяасыг минь залуу хүн

цоожны нүхээр сонсоход бэлэн байгаа явдалд гайхсан гэж бодохгүй байж чадаагүй шүү ... Харри, хонгор минь!

Тэр саяхан Харриг дэргэдээ байхгүй болохыг ойлгоод эргэн харлаа. Тэр байрандаа хөшөөд арван алхамын зайд үлджээ.

- Харри? гэж тэр итгэлгүйхэн давтлаа.

Магадгүй түүний царай хувхай цайснаас ч болсон уу профессор Трелони сэтгэл зовж айсан байртай харагдав. Харри сонссон зүйлдээ цочирдон шалнаас ургасан аятай зогслоо.

Энэ бол Снегг зөгнөлийг сонссон хэрэг байж! Снегг зөгнөлийн тухай Волан-де-Мортод мэдэгдсэн байж! Снегг Питер Петтигрюгийн хамтаар Волан-де-Мортыг Лили, Жеймс болон тэдний хүүг ангуучилахаар явуулсан байж!

Үүнээс цааш Харрид бүх юм хамаагүй болов.

- Харри? гэж профессор Трелони давтаад,
- Харри бид хамтдаа захирал руу явж байгаа гэж бодсон юмсан гэв.
- Эндээ үлд гэж Харри хөшсөн уруулаараа хэллээ.
- Гэхдээ, хонгор минь ... Би түүнд Шаардлагатай өрөнөд дайралтанд өртсөн тухайгаа хэлэхийг хүсч байна ...
- Эндээ үлд! гэж Харри ууртай давтлаа.

Тэр айсан профессор Трелонигийн дэргэдүүр гүйн өнгөрөөд Дамблдорын луу зогсож буй булан руу эргэв. Харри түүнд нууц үгийг хашгираад эргүүлгэн шат руу нисэн гарч гурван гишгүүр алгасан өнгөрөв. Энэ удаад Дамблдорын хаалгыг цохьсонгүй балбахад тайван хоолой «Ороорой» гэх нь сонсогдоод дотогш орлоо.

Галт шувуу Фоуксын хурц хар нүдэнд цонхоор тусах жаргаж буй нарны алтлаг гэрэл туяарна. Дамблдор цонхны дэргэд гадагш харан зогсоод гартаа урт аян замын хар жанч барьжээ.

- За, Харри минь би чамайг өөртэйгээ авч явахаар амалсан.

Агшин зуур Харри юу болоод байгааг ойлгосонгүй. Трелонигийн ярьсан зүйл толгойд нь байсан бүхнийг хөөн гаргаад тархи нь маш удаан ажиллаж байлаа.

- Өөртэйгээ ... авч явах гэнээ ...?
- Мэдээж чамайг хүсч байвал.
- Хэрвээ би ...

Тэгтэл Харри ийшээ тэсч ядан гүйн ирсэн шалтгаанаа саналаа.

- Та түүнийг олоо юу? Крестражыг олсон хэрэг үү?
- Тийм гэж бодож байна.

Уур хилэн эгдүүцэлтэй, цочирдол гайхширал тэмцээд Харри хэдэн хормын турш нэг ч үг хэлж чадсангүй.

- Айдас бол зүй ёсны зүйл гэж Дамблдор хэлэв.
- Би айгаагүй! гэж Харри тэр даруй хэлсэн нь туйлын үнэн байлаа. Тэр одоо айдсыг ер мэдэрсэнгүй.
- Ямар крестражыг нь олоо вэ? Хаана байгаа юм?

- Ямрыг нь мэдэхгүй байгаа ч могойн тухай мартаж болно. Би ганц л зүйлд итгэлтэй байна. Крестраж эндээс олон милийн зайтай тэнгисийн эргийн хадан хясаанд нуугаастай байгаа. Би түүнийг маш эртнээс эрж байсан юм. Энэ бол Том Реддлийн асрах газрын зугаалгаар хоёр хүүхдийг үхтэл нь айлгадаг газар болохыг санаж байна уу?

- Тиймээ. Тэр ямар хамгаалалттай юм?

- Мэдэхгүй. Гэхдээ магадгүй тийшээ буруу аргаар орж магадгүй гэсэн таавар надад байгаа гээд Дамблдор тээнэгэлзсэнээ,

- Харри би чамайг өөртэйгээ авч явахаар амалсан ч энэ бүхэн аюултай байж болно гэдгийг анхааруулах ёстой гэв.

- Би таньтай хамт явна гэж Харри түүнд яриа дуусгах боломж өгөлгүй хэлэв.

Сүүлчийн хэдэн хормын турш Снеггэд буцалж байсан уур хилэн үүнээс арав дахин эрсдэлтэй аюултай зүйлд бөхлөө. Харваас энэ нь түүний царайд илэрсэн бололтой Дамблдор цонхноос холдоод Харри руу ойртон ширтэхэд мөнгөлөг хөмсгөн дээгүүр нь хөнгөхөн үрчлээ үүсэв.

- Чамд юу тохиолдоо вэ?

- Юу ч биш гэж Харри яаран худал хэлэв.

- Яагаад сэтгэлээр унасан юм?

- Би сэтгэлээр унаагүй.

- Харри чи хэзээ ч сайн окклюменцист байгаагүй ... Сүүлчийн үг Харрийн уур хилэнг гал шиг асаав.

- Снегг! гэж тэр хүчтэй орилоход ард нь Фоукс аяархан дуугарлаа.

- Снеггээс болж надад ийм зүйл тохиолдсон байна! Тэр хаалганы цаана нуугдан сонсож байгаад Волан-де-Мортод зөгнөлийн тухай хэлсэн байна! Трелони надад сая бүхнийг хэллээ!

Дамблдорын царайны хувирал өөрчлөгдсөнгүй ч жаргаж буй нарны цусан улаан гэрэлд цонхийлоо. Хөгшин шидтэн удтал чимээгүй болоод юу ч хэлсэнгүй.

- Чи энэ тухай хэзээ мэдсэн бэ? гэж эцэст нь асуув.

- Дөнгөж сая! гэж Харри хэлээд хашгирах хүслээ арайхийн тэссэн ч биеэ барьж чадсангүй.

- Та Волан-де-Мортыг миний эцэг эх рүү явуулсан хүнийг сургуульд багшилахыг зөвшөөрсөн!

Тэр Дамблдорын нэг ч булчин хөдөлсөнгүйд хүндээр амьсгаадсан өрөөн дотуур нэг гараараа нөгөөгөө хүчлэн барьж холхилоо. Харри түүнийг профессор Снеггэд итгэдэг хичнээн хөгшин тэнэг болох тухай орилон хэлэхийг хүссэн ч бас крестражыг устгахад хамт явахыг хүсч байсан болохоор уур хилэнгээ барьж чадахгүй бол энд үлдэхээс айлаа ...

- Харри намайг сонс гэж Дамблдор аяархан хэлэв.

Холхихоо болих нь хашгиралтаа барихаас дутуугүй хүнд байлаа. Харри байрандаа хөшөөд уруулаа хазлан Дамблдорын үрчгэр царай руу харав.

- Профессор Снегг аймшигтай ...

- Надад түүнийг алдаа гаргасан гэж бүү ярь, ноёнтоон! Тэр хаалганы цаана сонсож байсан!

- Надад яриагаа дуусгах боломж олгооч гээд Дамблдор Харрийн толгой дохихыг хүлээгээд үргэлжүүлэн,

- Профессор Снегг аймшигтай алдаа гаргасан. Тэр профессор Трелонигийн зөгнөлийн эхний хэсгийг сонсох үедээ Волан-де-Мортод зүтгэж байсан юм. Тэгээд сонссон даруйдаа эзэндээ хамаатай зүйлийг хэлэхээр яарсан. Гэхдээ Северус Волан-де-Морт ямар хүүгийн араас агнаж эхлэхийг мэдээгүй, мэдэх ч боломжгүй байсан. Эзэн нь эрсэнээ хөнөөх үед ... энэ түүний сайн танил хүмүүс болох чиний эцэг эх чинь байсан юм ... гэв.

Харри хөгжилтэй бус инээмсэглэв.

- Тэр эцгийг минь Сириус шиг үзэн яддаг байсан! Та эрт орой хэзээ нэгэн цагт Снеггийн үзэн ядсан хүмүүс үхэж төгсгөл болдог гэдгийг ажигласангүй юу?

- Тэгж хэлж болохгүй, Харри. Чи профессор Снегг Волан-де-Мортод зөгнөлийн тухай хэлсэндээ ямар их гэмшсэнийг төсөөлөх ч үгүй. Энэ түүний амьдралын хамгийн харамсалтай мөч байсан болохоор үүний улмаас эргэж ирсэн гэдэгт итгэлтэй байна.

- Гэхдээ тэр маш сайн окклюменцист биз дээ, ноёнтоон? гэж Харри чичирсэн хоолойгоор асуулаа.

- Иймээс Волан-де-Морт одоог хүртэл Снеггийг талд нь байгаад итгэлтэй биш биз дээ? Профессор ... та түүнийг өөрийнхөө талд байгаа гэдэгт яаж итгэж чадаж байна аа?

Дамблдор хормын турш чимээгүй болон ой ухаандаа ямар нэг шийдвэр гаргаж байгаа бололтой. Эцэст нь,

- Би итгэлтэй байна. Би Северус Снеггэд бүрэн итгэдэг гэлээ.

Харрид хэсэг хугацааны турш гүнзгий амьсгалан тайвширахыг хичээв. Гэвч бүтсэнгүй.

- Харин би итгэдэггүй! Энэ агшинд тэр хамар дор чинь Драко Малфойтой ямар нэг зүйл хийж байхад та урьдын адил ...

- Бид энэ тухай ярилцсан, Харри. Тэгээд ч би өөрийн бодлоо хэлсэн гэж Дамблдор ширүүн өнгөөр хэллээ.

- Та өнөөдөр сургуулийг орхиж байгаа болохоор Снегг, Малфой хоёр шийдвэр гаргана гэдэгт мөрийцсөн ч бэлхэн байна ...

- Юунд? Чи тэднийг юу хийж байгаа сэжиглэж байгаа юм? хэмээн Дамблдор хөмсгөө өргөлөө.

- Би ... тэд ямар нэг зүйл бодсон! гээд Харри нударгаа зангидаж,

- Профессор Трелони саяхан Шаардлагатай өрөөнд лонхтой дарсаа нуухаар ороод Малфойн баяр тэмдэглэж байгаа юм шиг хөөрөн хашгирахыг сонссон байна! Тэр тэнд ямар нэг аюултай зүйл засахыг оролдож байсан бол миний бодлоор энэ нь бүтсэн байхад харин та сургуулийг орхиж ...

- Хангалттай гэж Дамблдр маш тайван хэлэхэд Харри чимээгүй боллоо. Тэр эцэст нь үл үзэгдэх шугамыг зөрчсөнөө мэдлээ.

- Чи намайг сургуулийг орхисноороо хамгаалалтгүй үлдээж байсан гэж бодож байгаа юм уу? Огтхон ч тийм биш. Энэ шөнө намайг явсан хойно энд нэмэлт хамгаалалт ирнэ. Чамаас гуйя, Харри намайг сурагчдынхаа аюулгүй байдалд хариуцлагагүй ханддаг гэж бүү бод.

- Би тэгээгүй ... гэж Харри ичингүйрэн бувтнасан ч Дамблдор үргэлжлүүлэх боломж өгсөнгүй.

- Тэгээд ч би энэ сэдвээр ярилцахыг хүсэхгүй байна.

Харри үг сөргөх гэснээ хэтэрхий цаашлан Дамблдортой хамт явах боломжоо алдсан байх гэж айтал тэр гэнэтхэн,

- Чи тэгээд өнөө шөнө надтай явахыг хүсч байна уу? гэлээ.

- Тиймээ гэж Харри агшин зуур хариулав.

- Маш сайн байна. Тэгвэл сонсож бай гээд Дамблдор цэхлэн зогсож,

- Би чамайг нэг болзолтойгоор авч явах болно. Чи миний ямар ч тушаалыг асуулт тавилгүй шууд биелүүлэх үү? гэв.

- Тэгэлгүй яахав.

- Харри, чи миний хэлсэн үгийг эцсийг нь хүртэл бодоод үз. Би чамд «үгүй», «нуугд» эсвэл «хойшоогоо буц» гэж тушаавал биелүүлэхээр ам өгөх үү?

- Би ... тэгэлгүй яахав.

- Хэрвээ би чамд нуугдахыг тушаавал үүнийг хийх үү?

- Тиймээ.

- Хэрвээ чамайг зугтахыг?

- Тиймээ.

- Хэрвээ чамд намайг орхин өөрийгөө авар гэж хэлвэл?

- Би ...

- Харри?

Тэд бие биенээ ширтлээ.

- Тиймээ, ноёнтоон.
- Маш сайн байна. Тийм тохиолдолд явж үл үзэгдэх цуваа аваад таван хормын дараа үүдний танхимд уулзацгаая.

Дамблдор цонх руу эргэхэд нар тэнгэрийн хаяанд бадмаараг шиг улайран жаргаж байв. Харри өрөөнөөс түргэн гарч эргүүлгэн шат уруудахад толгойд нь гэнэтхэн нэг санаа төрөв. Тэр юу хийх ёстойгоо мэдэж байлаа.

Түүнийг амралтын өрөөнд эргэн очиход Рон, Гермиона хоёр сууж байв.

- Дамблдор юу хүсээ вэ? гэж Гермиона даруйхан асууснаа,
- Харри чи зүгээр үү? гэж санаа зовон нэмэрлэв.
- Зүгээр гээд дэргэдүүр нь гүйн өнгөрч унтлагын өрөө рүү нисэн ороод чемоданаа онгойлгон хуйлаастай хос оймс болон Тэнүүлчний газрын зургаа авлаа. Дараа нь шатаар уруудан амралтын өрөөнд орж мэгдсэн Рон, Гермиона хоёрын дэргэд зогсоод,
- Надад хугацаа бага байна. Дамблдор намайг үл үзэгдэх цуваа авчиргахыг хүлээж байгаа. Сонсооч ... гэж хүндээр амьсгаадан хэлэв.

Тэр хаачих болсон тухайгаа түргэхэн ярилаа. Гермиона айн дуу алдаж, Рон яаран асуулт асуухад яриагаа зогсоосонгүй.

- Та нар энэ юу болохыг ойлгож байгаа биз дээ? гэж тэр яриагаа дуусган хэлээд,
- Дамблдор өнөө шөнө энд байхгүй болохоор Малфой ахин оролдлого хийнэ. Үгүй ээ, сонсоцгоо! гэж Рон, Гермиона хоёр яриаг нь таслахыг оролдоход ууртай хэлээд,

Би Малфой Шаардлагатай өрөөнд баярлаж байгаад итгэлтэй байна. Үүнийг ав гээд Гермионад Тэнүүлчний газрын зургаа сунгаж,

- Та нар түүнээс гадна Снегтийг бас мөрдөх хэрэгтэй. ДА-гийн гишүүдээс туслагч аваарай. Гермиона бидний хоорондоо холбоотой галлеон ажилласан хэвээр байгаа биз дээ? Дамблдор сургуульд нэмэлт хамгаалалт үлдээсэн гэж хэлсэн ч Снегг яаж давахаа мэднэ ... тэгээд ч тэр та нарын харахыг хүлээгээд суухгүй шүү гэв.

- Харри ... гэж Гермиона айдас дүүрэн нүдтэй хэллээ.
- Надад маргалдаж байх цаг байхгүй гэж Харри түүний яриаг таслаад,
- Үүнийг ав гэж Ронд оймс сунгав.
- Баярлалаа. Гэхдээ оймс надад ямар хэрэгтэй юм бэ?
- Чамд дотор нь байгаа зүйл болох «Феликс Фелицис» хэрэгтэй. Жиннитэй дундаа хувааж хэрэглээрэй. Бас миний өмнөөс баяртай гэж хэлээрэй. Би явахгүй бол, Дамблдор хүлээж байгаа ...
- Үгүй! хэмээн Гермиона Рон оймсноос алтлаг уусмалыг гарган авч бишрэн харахад дуу алдаад,



- Бидэнд хэрэггүй, чи үүнийг ав. Чамайг юутай тулгарахыг хэн мэдэх юм бэ? гэв.

- Дамблдортой байх болохоор миний хувьд бүх зүйл хэвийн. Би зөвхөн та нарыг сайн гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй байна ... Тэгээд ч над руу битгий ингэж битгий хар, Гермiona. За, дараа уулзацгаая.

Ингэж хэлээд тэрбээр яаран хөргөн нүхээр гарч Үүдний танхим руу явлаа.

Дамблдор түүнийг царсан хаалганы дэргэд зогсоод хүлээж байв. Тэр Харрийн амьсгаадсаар үүдэнд ирэхэд эргэж харлаа.

- Жанчаа өмссөн чинь дээр байх гээд Харриг нөмрөхийг хүлээснээ,

- Маш сайн байна. За явцгаах уу? гэлээ.

Дамблдор чулуун гишгүүр уруудаж эхлэхэд дээл нь зуны салхинд үл мэдэг намирна. Харри үл үзэгдэх цуван дор араас нь яаран дагаснаа,

- Таныг явахыг хүмүүс хараад юу гэх бол? гээд Малфой, Снегг хоёрын тухай бодлоо.

- Хогсмидэд юм уухаар явж байна гэж хэлэх байх. Би заримдаа Розмерта дээр очих юмуу эсвэл «Гахайн толгой»-д ... шагайдаг юм. Хэрвээ чи жинхэнэ зорилгоо нуухыг хүсвэл энэ хамгийн сайн арга даа.

Тэд бүрэнхийд замаар явлаа. Агаарт шинэхэн ногоо, нуурын ус, Хагридын овоохойноос суунаглах утааны үнэр ханхална. Тэднийг гаднаас харахад эрсдэлтэй аюултай ажил хийхээр яваа гэхэд итгэхэд бэрх байлаа.

- Профессор бид шилжих үү? гэж Харри хаалгаар гарахын урд аяархан асуулаа.

- Тиймээ. Ингэхэд чи чадна биз дээ?

- Чадна гэхдээ надад зөвшөөрөл байхгүй.

Үнэндээ Харри ингэсэн нь дээр гэж бодож байв. Тэгэхгүй бол олон миль замыг яаж туулах юм билээ?

- Энэ чухал биш. Би чамд ахин нэг удаа туслана гэж Дамблдор хэлэв.

Хоёул хаалгаар гарч бүрэнхийд Хогсмид хүрэх хоосон замаар явлаа. Тэднийг төв гудамжинд хүрэх үед түргэн харанхуй болж шөнө боллоо. Ойролцоох дэлгүүрийн цонхнуудад гэрэл анивчих бөгөөд тэднийг «Гурван шүүр»-т ойртох үед чанга хашгиралт сонсогдов.

- ... эндээс гар! гэж хатагтай Розмерта нэг шидтэнг хаалгаар түлхэн гаргаад орилов.

- Өө, сайн уу, Альбус ... зугаалахад оройтсон үе байна.

- Оройн мэнд, Розмерта оройн мэнд ... намайг «Гахайн толгой» руу явж байгаад гомдохгүй биз дээ ... зүгээр л өнөө шөнө тэнд чимээгүй шуугиан багатай байгаа юм л даа.

Хормын дараа тэд зэргэлдээх гудамж руу эргэхэд «Гахайн толгой»-ны хаяг салхигүй хэдий ч хөнгөхөн чохарч байв. «Гурван шүүр»-ээс ялгаатай энд хоосон байлаа.

- Заавал орох шаардлагагүй. Гол нь хэн ч биднийг явахыг харахгүй ... одоо миний гараас барь, Харри. Тийм чанга атгах хэрэггүй дээ, би чамайг чиглүүлэх хэрэгтэй. За гурав хүртэл тооллоо шүү нэг ... хоёр ... гурав.

Харри эргэлээ. Ингээд агшин зуур мохоо хаймар хоолойнд хавчигдах мэт санагдаж амьсгалж чадахгүй болон бүх бие нь тэвчихийн аргагүй агшсанаа үл үзэгдэх тууз онгойх мэт болж харанхуйд сэрүүн давсархаг салхитай газар зогсож байлаа.

## БҮЛЭГ 26: АГУЙ

Харрид давсны үнэр ханхлан давалгаа сонсогдож чийгтэй сэвшээ салхи үсийг нь илбэхэд сарны гэрэл дэх тэнгисийн мандал болон одод түгсэн тэнгэр үзэгдэв. Тэр өндөр харанхуй хадан дээр зогсоод нь дор нь хөөс бургилж байв. Харри эргэн харахад ард нь нүүргүй огцом хясаа сүндэрлэнэ. Тэд хясааны өмнө хэсгээс хэлтэрч унасан бололтой нүсэр том хэдэн үхэр чулууны нэг дээр зогсож байв. Энд баргар ширүүн тэнгис хад үргэлжлэн ямар ч мод, өвс ногоо, элс байхгүй ажээ.

- Чи юу хэлмээр байна? гэж Дамблдор хэлэхэд Харрид түүний бодлыг асууж буй явдал нь хөдөө хээр энгийнээр зугаалж буй мэт санагдав.

- Тэд асрах газрын хүүхдүүдийг ийшээ авчирдаг гэж үү? гээд Харри нэг өдрийн зугаалгыг муухан төсөөлөв.

- Яг ч ийшээ биш. Тэнд дээр эрэг хүрэх замд тосгон байгаа. Миний ойлгож байгаагаар тийш нь асрах газрын өнчин хүүхдүүдийг тэнгисийн цэвэр агаар амьсгалуулан давалгаа харуулахаар авчирдаг. Гэхдээ энд Том Реддл болон залуухан хохирогч нараас нь ондоо хүн байсан гэж бодохгүй байна. Маглууд тийм ч сайн уулчин биш болохоор хэн ч энэ хясаа руу хүрч чадахгүй. Түүнчлэн завь ч ойртох боломжгүй эндхийн ус дэндүү аюултай. Би Реддлийг ийшээ шидийн олс гарган бууж ирсэн байх гэж төсөөлж байна. Тэгэхдээ өөртэйгээ хоёр хүүхдийг айлган зугаацахаар авчиржээ. Зөвхөн уруудах нь л хүүхдүүдийг үхтэл нь айлгахад хангалттай.

Харри дээшээ түүний харцыг дагуулан эрэг рүү хараад хамаг бие нь агзасхийлээ.

- Мэдээж түүний эцсийн зорилго ... бас биднийх ... жаахан цаашаа байгаа. Явцгаая.

Дамблдор хадны ирмэг рүү зангаад усан дундаас цухуйсан шовх оройтой арзгар үхэр чулуун дундуур явж хясаанд ойртлоо. Уруудах осолтой байсан бөгөөд хатсан гар нь удаан хөдлөн саад болж байлаа. Тэнгисийн усан дахь хадны доод хэсэг гулгамтгай болжээ. Харри хүйтэн давстай ус нүүрийг нь шавхуурдахыг мэдрэв.

- Люмос гэж Дамблдор цохионы нүүрэн талын үхэр чулуунд хүрээд хэллээ.

Мянга мянган алтлаг гэрэл хэдэн футын дор байх харанхуй усанд туяаран ойгоод хар хадан ханыг бас гийгүүлэв.

- Харж байна уу? гэж Дамблдор аяархан асуугаад шидэт саваагаа өндөрт өргөхөд Харри хясааны цаванд хуйларч буй харанхуй усыг харав.

- Чи жаахан норвол эсэргүүцэхгүй биз дээ?

- Үгүй.

- Тэгвэл үл үзэгдэх цуваа тайл ... одоо энд хэрэггүй болсон ... бид шумбах болно.

Дамблдор гэнэтхэн залуу хүн шиг шаламгай хөдлөн үхэр чулуун дээрээс гулгаад усанд пүлхийн орж харанхуй ангал руу шидэт саваагаа шүдэндээ зуун сэллээ. Харри жанчаа тайлан халаасандаа хийгээд араас нь дагалдав.

Ус мөс шиг хүйтэн байлаа. Харрийн хувцас норж хүндэрэн усны ёроол руу чангаав. Тэр замаг давсны үнэр дүүрэн агаарт гүнзгий амьсгал аваад цохионы гүн рүү ойртож буй гялалзсан гэрлийн дагуу сэллээ.

Төдхөн ан цав харанхуй хонгил болон өргөсөхөд Харри түрлэгний усаар дүүрснийг ойлголоо. Хонгилын гулгамтгай хана нэг нэгнээсээ гурван футын өндөр агаад Дамблдорын савааны гэрэлд нойтон давирхай адил гялалзана. Удалгүй хонгил зүүн тийш эргэхэд Харри цохионы гүн рүү сунасныг харлаа. Тэр Дамблдорын араас үргэлжлүүлэн сэлэхдээ бээрсэн хуруугаараа арзгар нойтон чулуунаас зуурч байлаа.

Тэгтэл урд нь Дамблдор мөнгөлөг үс, хар дээлээ гялалзуулан уснаас гарч ирэх нь үзэгдэв. Харри тэнд хүрэхэд хөл дор нь том хаднаас бүтсэн гишгүүр байлаа. Тэр уснаас нойтон хувцастай мөлхөн гараад өгсөхдөө хүйтэн агаарт дагжтал чичирлээ.

Дамблдор агуйн дунд зогсоод саваагаа өндөрт өргөн удаанаар эргээд эргэн тойрны хана адрьг шинжин харлаа.

- Тиймээ энэ газар мөн байна.
- Та хаанаас мэдэж байгаа юм? гэж Харри шивнэн асуув.
- Энд ид шид болсон байна гэж Дамблдор энгийн өгүүлэв.

Харри чөмгөндөө хүртэл даарсандаа ч юмуу эсвэл ид шид болсон гэдгийг сонссондоо ч тэр юмуу чичирлээ. Тэр Дамблдорыг үргэлжлүүлэн харахад байрандаа эргэлдэн Харрийн харж чадахгүй зүйлийг анхааралтай хайж байлаа.

- Энэ бол ердийн үүдний танхим гэж тэр хоёр хормын дараа хэлэв.
- Бид дотогшоо нэвтрэх хэрэгтэй байна ... Одоо бидний зам дээр байгалийн бус лорд Волан-де-Мортын босгосон саад байна.

Дамблдор агуйн хананд ойртоод харласан хурууны үзүүрээр илэн ойлгогдохгүй хэлээр үг бувтналаа. Тэрбээр хоёр ч удаа агуйг тойрч хуруугаа нэг газар урагш хойш гүйлгэж үзсэний эцэст алгаа хананд наан зогслоо.

- Энд. Бид үүгээр орох ёстой. Хонгил үүгээр нууцлагдсан байна.

Харри Дамблдорын яаж мэдсэнийг асуусангүй. Тэр хэзээ ч шидтэн ингэж хүрч харж ажиллахыг харж байсангүй.

Дамблдор алхам ухраад шидэт саваагаа хад руу чиглүүлэв. Агшин зуур нуман хаалганы дүрс тодорч нүд гялбам хурц цагаан гэрэл цацрахад хана тасхийлээ.

- Б-б-болсон уу! гэж Харри шүдээ тачигнуулан хэлсэн ч энэ үг уруулыг нь давж амжихаас өмнө дүрс алга болж хана урьдын адил нүцгэн хэвээр үлдэв. Дамблдор эргэж харлаа.

- Уучлаарай Харри, би мартчихаж гээд тэр Харри руу саваагаараа зангахад хувцас нь агшин зуур ханан зуухны өмнө өлгөсөн юм шиг хуурай дулаахан боллоо.

- Баярлалаа гэж Харри талархсан ч Дамблдор хэдийн хана руу эргэн анхаарлаа хандуулжээ.

Тэр ахин шид хэрэглэх гэж хичээсэнгүй зүгээр л зогсоод дээр нь ер бусын сонирхолтой зүйл бичээстэй мэт ширтэв. Харри бас зогсоод анхаарлыг нь сатааруулахыг хүссэнгүй болохоор хөдөлсөнгүй.

Хоёр хормын дараа Дамблдор аяархан,

- Байж боломгүй юм. Ямар бүдүүлэг хэрэг вэ гэлээ.

- Та юуны тухай ярьсан бэ, профессор?

- Бид орохын тулд хөлс төлөх хэрэгтэй гэж бодож байна гээд Дамблдор эрүүл гараараа жанчныхаа дороос Харрийн уусмалын орц зүсэхдээ ашигладаг шиг богино мөнгөн хутга гаргаж ирлээ.

- Төлөх гэнээ? Та хаалганд ямар нэг зүйл өгөх гээ юу?

- Тиймээ. Хэрвээ би эндүүрээгүй бол цус.

- Цус гэнээ?

- Би бүдүүлэг хэрэг гэж хэлсэндээ хэмээн Дамблдор Волан-де-Морт түүнээс ийм түвшин хүлээсэн явдалд зэвүүцсэн янзтай урам хугаран хэллээ.

- Гэхдээ та хэрвээ түүнгүйгээр орвол ... гээд Харри хангалттай өвдөж байсан туршлагатай болохоор дахин давтахыг хүссэнгүй.

- Заримдаа үүнээс зайлсхийх аргагүй байдаг юм гээд Дамблдор гэмтсэн гараа өргөн жанчныхаа ханцуйг сэгсэрлээ.

- Профессор! гэж Харри эсэргүүцээд хутга өргөсөн Дамблдор руу ухасхийлээ.

- Алив би үүнийг хийе, би ...

Тэр яагаад ингэж хэлэхийг хүссэнээ өөөрөө ч мэдсэнгүй. Магадгүй залуу эрүүл болохоороо тэр юм болов уу?

Гэвч Дамблдор ердөө инээмсэглэв. Мөнгө гялсхийхэд улаан цус оргилон хадны нүүрэнд гялалзсан бараан дуслууд цацагдав.

- Чи их сайхан сэтгэлтэй юм, Харри гээд Дамблдор савааныхаа үзүүрийг гүн зүссэн шархандаа хүргэхэд агшин зуур Снегг Малфойныхыг эмчилсэн шиг эдгэрэв.

- Гэвч чиний цус минийхээс илүү үнэтэй. Өө, манай заль бүтсэн бололтой!

Хананд ахин гялалзсан мөнгөлөг нуман хаалганы дүрс бий болсон ч энэ удаад алга болсонгүй. Цусанд будагдсан чулууд алга болоод оронд нь нэвтэршгүй харанхуй гарц үлджээ.

- Би түрүүлж орёе гээд Дамблдор нуман хаалгаар ороход Харри араас нь дагахдаа саваагаа яаран гаргаж гэрэлтүүлэв.

Аймшигтай үзэгдэл тэднийг угтлаа. Тэд харанхуй том нуурын эрэг дээр зогсож байсан бөгөөд Харри нөгөө эргийг нь харж чадсангүй. Агуй маш өндөр учир адар нь

нүдэнд үзэгдэхээргүй ажээ. Алсад нуурын дунд бололтой ногоон гэрэл манантан суунаглах нь хөдөлгөөнгүй усанд ойн тусаж байлаа. Зөвхөн энэ ногоовтор гэрэл болон хоёр саваанаас гарсан гэрэл баргар гаранхуйг гийгүүлэх хэдий ч Харрийн бодсон шиг хол туссангүй. Энэ бол жирийн биш түнэр харанхуй байлаа.

- Бид явах хэрэгтэй. Болгоомжтой байж усанд битгий хүрээрэй. Надад ойрхон байгаарай гэж Дамблдор аяархан хэлэв.

Түүнийг нуурын эрэг хөвөөлөн явахад Харри араас нь дагалаа. Тэдний алхаа нуурыг хүрээлсэн давчуу чулуун цагариг дээгүүр цуурайтана. Тэд явсаар байсан ч эргэн тойрон өөрчлөгдсөнгүй. Агуйн арсгар чулуун хана нэг зүгт төгсгөлгүй үргэлжилж толигор шилэн харанхуйн дунд нууцлаг ногоон гэрэл ассаар байлаа. Энэ газрын нам гүм Харриг дарамтлан бухимдлыг нь хүргэв.

- Профессор та крестраж энд байгаа гэж бодож байна уу? гэж эцэст нь асуулаа.

- Өө тийм л дээ. Би түүнд итгэлтэй байна. Асуудал гэвэл яаж түүнд хүрэх вэ гэдэгт л байна.

- Бид болохгүй ... бид зүгээр л Татдаг шидийг ашиглаж болохгүй юм уу? гэж Харри сониучирхав. Тэр үүнийг тэнэг асуулт болохыг нь мэдэж байсан ч эндээс түргэхэн явахын тулд юу ч хийхэд бэлэн байлаа.

- Болох л юм. Чи яагаад оролдож үзэж болохгүй гэж? хэмээн Дамблдор гэнэтхэн зогсоход Харри арай мөргөсөнгүй.

- Би юу? Өө ... за яахав гээд Харри ийм зүйл хүлээгээгүй ч хоолой засан ханиалгаад саваагаа даллан,

- Акцио крестраж! гэж чанга хэлэв.

Дэлбэрэх адил нүргэлэх чимээ гараад хорин футын зайтай харанхуй усанд ямар нэг том цагаан юм үсэрснээ Харрийн ялгаж амжихаас урьд алга болохдоо нуурын толигор гадаргуу дээр том загас адил цалгилуулсан мөр үлдээв. Харри айдаст автан нуруугаараа хана налаад Дамблдор руу харахад зүрх нь хүчтэй цохилон.

- Энэ юу байсан бэ?

- Биднийг крестраж авахад саад болоход бэлэн зүйл гэж бодож байна.

Харри ус руу харлаа. Нуурын гадаргуу ахин гялалзсан хар шил болон хувираад долгио алга болсон ч зүрх нь хүчтэй цохилсон хэвээр байв.

- Та үнэхээр тэгсэн гэж бодож байна уу, ноёнтоон?

- Хэрвээ бид хэтэрхий илт крестражыг зэмдэх оролдлого хийвэл ямар нэг зүйл болно гэж бодож байна. Ер нь бол бидний юу хийж байгааг тайлбарлах муугүй санаа л даа, Харри.

- Гэхдээ бид энэ юу байсныг мэдсэнгүй гээд Харри муу ёрын толигор ус руу нүд салгахгүй харлаа.

- Энэ амьтан гэж чи хэлэхийг хүсээ юу. Би түүнийг ганц байсан гэдэгт маш их эргэлзэж байна. За, цаашаа явах уу?

- Профессор!
- За, Харри?
- Та биднийг нуурын усанд орно гэж бодож байна уу?
- Орох гэнээ? Зөвхөн бидэнд аз таараагүй үед л.
- Та крестраж ёроолд нь байгаа гэж бодохгүй байна уу?
- Өө, үгүй дээ ... Би крестражыг нуурын дунд байгаа гэж бодож байна гээд

Дамблдор бүүдгэр ногоон гэрэл рүү заалаа.

- Тэгэхээр түүнд хүрэхийн тулд бид нуурыг гатлах ёстой юу?
- Тиймээ, тийм гэж бодож байна.

Харри чимээгүй боллоо. Түүний санаанд усны бүх төрлийн мангасууд болох аварга могой, чөтгөр болон лусын дагина оров.

- Аанхан гээд Дамблдор ахин зогссонд энэ удаад Харри түүнийг мөргөөд ус руу унах шахан ганхахад Дамблдор эрүүл гараараа мөрнөөс нь бариад өөр лүүгээ татлаа.

- Чамайг анхааруулаагүй явдалд уучлаарай, Харри. Нуруугаараа хана налаад зогсож бай. Би хэрэгтэй газраа олчих шиг боллоо.

Харри Дамблдорын юу ярьсаныг ойлгосонгүй. Харанхуй эрэг бусадтайгаа адилхан байсан ч Дамблдор ямар нэг онцгой зүйл илрүүлсэн бололтой. Тэр гараа чулуун хана руу биш харин агаарт үл үзэгдэх зүйл барих гэж байгаа мэт өргөв.

- Өө! гэж жаахан хүлээснээ баяртай хашгирлаа.

Түүний гарт ямар нэг юм байсан ч Харри ялгаж чадсангүй. Дамблдор усанд ойртлоо. Харри түүний угалзтай шаахай нь чулууны үзүүрийн ирмэгт хүрэхийг түгшин харав. Тэр гараа атгасан хэвээр нөгөө гараараа шидэт саваагаа өргөөд үзүүрээр нь тогшлоо.

Хоосон агаарт агшин зуур бүдүүн ногоорсон зэс гинж бий болоод усны ёроолоос Дамблдорын гарт татагдав. Дамблдор гинжийг тогшиход хурууны завсраар нь могой адил гулган ороогдож газар гинж хангинан унах чимээ цуурайтаад ямар нэг зүйл харанхуй усны гүнээс татан гаргаж ирлээ. Харри усны мандлаас жижигхэн завины хошуу гарч ирэхийг хараад гинжний адил ногоон гэрэл цацруулахыг хараад айсан ч тэдний зогсож байсан эрэгт тулан ирээд зогсов.

- Та түүний тэнд байгааг яаж мэдсэн юм бэ? гэж Харри гайхширан асуулаа.
- Ид шид үргэлж мөр үлдээдэг юм. Заримдаа маш өвөрмөц ул мөр. Би Том Реддлийг сургаж байсан болохоор хэв маягийг нь мэднэ гэж Дамблдор завь эрэг зөөлхөн мөргөхөд хэлэв.
- Энэ ... завиар хөвөхөд аюулгүй болов уу?
- Аюулгүй гэж бодож байна. Волан-де-Морт гэнэтхэн ирэх юмуу крестражаа авахыг хүсвэл усны дор байгаа амьтдын анхаарлыг таталгүй нуурыг хөндлөн туулах хэрэг гарна.

- Хэрвээ бид Волан-де-Мортын завиар хөвбөл энэ амьтад юу ч хийж чадахгүй юу?

- Магадгүй эрт орой нэг цагт биднийг лорд Волан-де-Морт биш гэдгийг ойлгох учир үүнтэй эвлэрэх хэрэг гарах байх. Одоохондоо бидэнд ямар ч аюул учрахгүй. Тэд биднийг завь руу гарахыг зөвшөөрнө.

- Гэхдээ яагаад зөвшөөрч байгаа юм бэ? гэж Харри асуулаа. Түүнд харанхуй усанд завиар хөвж эрэг хараанаас далд ороход уснаас тэмтрүүл цухуйж буй дүр зураг төсөөлөгдөв.

- Волан-де-Морт ухаалагаар агуу шидтэнээс өөр хүн завийг олж чадахгүйгээр бодсон. Би түүнийг хэн нэгэн завийг олоход (хэдийгээр энэ зүгээс харахад итгэмээргүй ч гэсэн) эрсдэлд ороход бэлэн байсны учир нь урд нь зөвхөн өөрөө л нэвтрэх чадвартай бусад саад хүлээж байгаа гэдгийг мэдэж байсанд гэж бодож байна. Бид удахгүй түүний зөв гэдгийг харах болно.

Харри завь руу харлаа. Тэр үнэхээр маш жижигхэн байв.

- Завь хоёр хүнд зориулагдаагүй бололтой. Тэр биднийг хоёуланг нь даах болов уу? Бид хэтэрхий хүнддэх юм биш үү?

Дамблдор инээд алдав.

- Волан-де-Морт жинд санаа тавьж чадахгүй. Гэхдээ нуурыг гатлах шидийн хүчтэй тэнцүү байх ёстой. Би завины шид дээр нь зөвхөн нэг шидтэн хөвөх боломж олгоно гэж бодож байна.

- Тэгвэл ...?

- Би чамайг тооцоогүй, Харри. Чи насанд хүрээгүй бүрэн боловсролтой болоогүй. Волан-де-Морт хэзээ ч ямар нэг арван зургаан нас хүрээгүй шидтэн энэ газар ирнэ гэж бодоогүй байх. Тэгэхээр чиний шидийн хүч минийхтэй харьцуулахад ажиглагдахгүй.

Энэ үг Харрийн сэтгэл санааны байдлыг өргөсөнгүйд Дамблдор үүнийг ойлгосон бололтой,

- Волан-де-Мортын алдаа, Харри. Волан-де-Мортын алдаа ... Эртнээс залуучуудыг тэнэгээр дутуу үнэлдэг байсан юм ... энэ удаад чи түрүүлж ор, болгоомжтой байж усанд хүрэхгүйг хичээгээрэй гэв.

Дамблдор хажуу тийш холдоход Харри завинд болгоомжтой оров. Дамблдор араас нь ороод гинжийг газар орооцолдуулан тавилаа. Хоёул байхад тухгүй байсан бөгөөд Харри өвдгөө завины ирмэгээс ёрдойлгон суухад завь эргээс холдон хөвж эхэллээ. Энд зөвхөн завины хошуу ус зүсэн шажигнахаас ондоо чимээгүй бөгөөд үл үзэгдэх олсоор татуулж байгаа мэт алсад гэрлийн зүг хурдална. Удалгүй агуйн хана алга болж давалгаа байхгүйг эс тооцвол завь тэнгист хөвж байгаа мэт болов.

Харри харанхуй усанд савааны гэрлийнх нь алтлаг тусгал гялтагнахыг харлаа. Завины хошуу хар толь шиг толигор усыг хага яран хөвнө ...



Тэгтэл ямар нэг гантиг шиг цагаан зүйл хэдхэн дюймийн дор сэлэн өнгөрлөө.

- Профессор! гэж тэр айн дуу алдахад чимээгүй харанхуйд чанга цуурайтав.
- Яасан, Харри?
- Би усанд гар харах шиг боллоо ... хүний гар!
- Үүнд эргэлзэх хэрэггүй гэж Дамблдор тайван хэлэв. Харри гар алга болсон хэсэг рүү харахад дотор нь муухайрав.
- Энэ амьтан уснаас үсрэн гарсан юм болов уу ...?

Харрийн асуултанд Дамблдор хариулж амжихаас урьтаж савааны гэрэлд усны гадарга дээр энэ удаад үхсэн хүн нүүрээрээ дээш харан хэвтээд хөвөн өнгөрлөө. Түүний нүд аалзны шүлсэнд бүрхэгдсэн мэт цайж, үс болон хувцас нь утаа шиг намирч байлаа.

- Тэнд үхдэл байна! гэж Харри өөрийн биш хоолойгоор дуу алдав.
- Тиймээ, гэхдээ бидэнд одоохондоо санаа зовох зүйл байхгүй.
- Одоохондоо гэнээ? хэмээн Харри давтаад Дамблдор руу харцаа уснаас холдуулан харав.
- Тэд бидний дор тайван хөвөхөө болих хүртэл. Эдгээр биенээс харанхуй адил айх хэрэггүй, Харри. Үхэлтэй харанхуйд тулгарана гэдэг бидний үл мэдэх зүйлээс айдагаас илүүгүй.

Энэ удаад Харри маргахыг хүссэнгүй болохоор юу ч хэлсэнгүй гэвч эргэн тойрон үхдлүүд хөвж буй гэхээс аймшигтай санагдаж аюулгүй гэдэгт нь итгэмээргүй санагдлаа.

- Гэхдээ тэдний нэг уснаас үсэрсэн гэж тэр хоолойгоо Дамблдорынх шиг тайван болгохыг хичээн хэлээд,
- Намайг Татдаг шидээр крестражыг авахыг оролдох үед бие нуураас үсэрсэн гэв.
- Тиймээ. Биднийг крестражыг эзэмдэхийг оролдох үед тэднийг ийм найрамдалтайбайхаа болино гэдэгт эргэлзэхгүй байна. Гэвч хүйтэн харанхуйд байдаг олон амьтаны адил тэд гэрэл дулаанаас айдаг болохоор бид түүнийг тусламж болгон ашиглаж болох юм. Гал, Харри гэж түүний гайхсаныг хараад инээмсэглэн нэмж хэлэв.

- Аан ... тийм л дээ гээд Харри завины чиглэн хөвж буй ногоон гэрэл рүү эргэн харлаа. Тэр айгаагүй юм шиг дүр үзүүлж чадсангүй. Аварга том нууранд дүүрэн үхэгсэд хөвж байна ... Тэр профессор Трелонитой уулзан, Рон, Гермиона хоёрт «Феликс Фелицис»-ийг өгснөөс хойш олон цаг өнгөрсөн юм шиг санагдана. Тэгснээ гэнэтхэн тэдэнтэй салах ёс гүйцэтгээгүйдээ харамслаа

... Жиннитэй ахин уулзахгүй бол яана ...

- Бараг ирчихлээ гэж Дамблдор хөгжилтэй хэлэв.

Тэгтэл ч үнэхээр ногоовтор гэрэл урган томорсоор хэдэн хормын дараа завь ямар нэг юмыг зөөлөн мөргөн зогсоход Харри эхэндээ юу ч харсангүй ч саваагаа өргөөд нуурын дундах жижигхэн чулуун арал дээр хүрснийг харлаа.

- Усанд битгий хүрээрэй гэж Харриг завинаас буухад хөгшин шидтэн ахин анхааруулав.

Арал Дамблдорын өрөөнөөс томгүй бөгөөд уудам харанхуйн дундах жижигхэн чулуун зайд ногоон гэрлээс ондоо юу ч байсангүй тэр ойртох тусам илүү хурц болж байлаа. Харри нүдээ анивчаад урдаа ямар нэг төрлийн дэнлүү байна гэж бодсон ч дараа нь гэрэл багахан тавцан дээр байгаа гүн ухааны цүнхээлийг санагдуулам чулуун аяганаас гарч байхыг харлаа.

Дамблдор түүнийг зүглэхэд Харри араас нь дагав. Тэд хоёул зэрэгцэн зогсоод аяга руу харлаа. Түүн дотор маргад ногоон өнгийн шингэн дүүрэн байсан бөгөөд түүнээс гэрэл гарч байв.

- Энэ юу вэ? гэж Харри аяархан асуув.

- Сайн мэдэхгүй байна. Гэхдээ таагүй үхдлийн цус биз.

Дамблдор харласан гарынхаа ханцуйг шуугаад түлэгдсэн хуруугаа ногоон шингэн рүү сунгалаа.

- Хэрэггүй, ноёнтоон бүү хүр ...!

- Би хүрч чадахгүй гэж Дамблдор сулхан инээмсэглэн хэлээд,

- Харж байна уу? Миний хуруу хүрэхгүй байгааг. Өөрөө оролдоод үз гэв.

Гайхсан Харри гараа аяга руу сунган ногоон шингэнд хүрэхийг оролдлоо. Тэгтэл үл үзэгдэх саадтай тулгарсан мэт болж хичнээн чармайсан ч хуруу нь хатуу уян агаараас ондоо юутай ч тулгарсангүй.

- Хажуу тийшээ холдож бай даа, Харри гэж Дамблдор хэлэв.

Тэр шидэт саваагаа огцом даллаад чимээгүйхэн бувтнахад шингэний гадаргуу улам тод болсноос өөр юу ч болсонгүй. Дамблдорыг ажиллаж байх үед Харри чимээгүй байсан ч саваагаа буулгах үед нь ярьж болно гэж үзээд,

- Ноёнтоон та крестражыг дотор нь байгаа гэж бодож байна уу? гэв.

- Тийм л дээ гээд Дамблдор бөхийн аягыг харахад Харри толигор шингэний гадаргууд царайны тусгалыг нь харлаа. Гэхдээ түүнд яаж хүрэх вэ? Уусмал гар хүрэхээр алга болдог шившлэгтэй болохоор ойртуулахгүй, хувирдаг шидтэй болохоор хутгаж асгаж соруулж болохгүй.

Тэгснээ Дамблдор шидэт саваагаа өргөөд агаарт эргэлдүүлэн болор цом гаргаж ирэв.

- Энэ шингэнийг ууж дуусгах л үлдлээ.

- Юу? Үгүй ээ! гэж Харри дуу алдлаа.

- Би тэгэх ёстой гэж бодож байна. Зөвхөн ууж байж аягыг хоослон ёроолд нь юу байгааг харж чадна.

- Гэхдээ хэрвээ ... тэр таныг алчихвал яах вэ?

- Үүнийг тэгж бодсон гэдэгт эргэлзэж байна. Лорд Волан-де-Морт энэ арал дээр хүрсэн хүнийг алахаар хүн биш.

Харри чихэндээ итгэсэнгүй. Энэ бүхэн Дамблдорын бүхнийг зөвхөн сайн талаас нь хардаг ухаангүй шийдэмгий байдал уу?

- Ноёнтоон гээд Харри хоолойгоо тайван байлгахыг хичээн,

- Ноёнтоон, энэ чинь Волан-де-морт биднийг ... гэв.

- Өршөөгөөрэй, Харри. Тэр хүнийг энэ аралд хүрсэн хүнийг даруйхан алах хүн биш гэж Дамблдор засаад,

- Тэр түүнийг одоо хүртэл амьд үлдээхийг хүссэний учир нь саадыг даван ийшээ ирэх боломж олгож хамгийн гол нь аягыг суллахыг хүсчээ. Волан-де-Морт крестражаа өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй гэдэгт итгэлтэй байсан гэдгийг бүү март гэв.

Харри амаа нээсэн ч Дамблдор гараа өргөн чимээгүй болгоод хөмсөг загидан маргад ногоон шингэн рүү харж бодлогоширлоо.

- Тиймээ эргэлзээгүй гэж эцэст нь хэлээд,

- Энэ уусмалын үйлчлэл намайг крестражад хүрэхэд саад болох ёстой. Тэр намайг мэдээ алдуулж, яах гэж ийшээ ирснийг мартуулж, өвтгөж эсвэл ямар нэг аргаар ухаан хүчгүй болгоно. Хэрвээ энэ бүхэн болвол Харри чи намайг цаашид уулгах талаар санаа тавиарай. Тэр ч байтугай эсэргүүцсэн ч гэлээ шингэнийг ам руу цутгаж өгөх ёстой. Чи ойлгов уу? гэлээ.

Тэдний харц тулгарахад ногоон өнгийн гэрэлд хоёулангийнх нь царай хачирхалтай цонхигор харагдав. Харри нэг ч үг хэлж чадсангүй. Тиймээ тэр үүний төлөө ийшээ ирсэн байх нь ... Дамблдорыг тэсвэрлэшгүй өвтгөж хүчээр уусмал уулгахын тулд байх нь?

- Чи намайг өөртэйгээ ямар болзлоор авч явсныг санаж байна уу?

Харри тээнэгэлзсэнээ аяганы гэрэлд ногоон болж хувирсан цэнхэр нүд рүү харлаа.

- Гэхдээ хэрвээ ...?

- Чи ямар ч тушаалыг бишлүүлнэ гэж ам өгснөө санаж байна уу?

- Тиймээ, гэхдээ ...

- Бас би чамд энэ газар аюултай байж болно гэж анхааруулсан биз дээ?

- Тиймээ, гэвч ...

- Тийм тохиолдолд чи миний тушаалыг биелүүлнэ гээд Дамблдор ханцуйгаа сэгсрэн хоосон хундагыг өргөлөө.

- Гэхдээ би яагаад таны оронд энэ уусмалыг ууж болдоггүй юм бэ? гэж Харри цөхрөн асуулаа.

- Яагаад гэвэл би илүү хөгшин, илүү ухаалаг, илүү үнэ цэнэ багатай. Чи намайг бүх хүчээ гарган үргэлжлүүлэн уулгана гэж ам өгөх үү, Харри?

- Аа ...

- Өгөх үү эсвэл өгөхгүй юу?

- Гэхдээ ...

- Амал, Харри!

- Би ... за яахав, гэхдээ ...

Гэвч Дамблдор цаашдын татгалзлыг сонсолгүй болор цомыг шингэнд дүрлээ. Харри агшин зуур цом шингэнд хүрэхгүй байх гэж найдсан ч дүүргээд уруулдаа хүргэв.

- Чиний эрүүл энхийн төлөө, Харри.

Ингээд тэрбээр цомыг хоослов. Харри түүнийг аяганы ирмэгээс харласан хуруугаараа чанга зуурахыг айдаст автан харлаа.

- Профессор? Таны бие зүгээр үү? гэж хоосон цомыг буулгахад түгшин асуув. Дамблдор нүдээ аниатай толгойгоо сэгсрэв. «Өвдөж эхлээгүй юм болов уу?» гэж

Харри бодлоо. Дамблдор нүдээ нээлгүй цомыг аяганд дүрээд ахин дүүргэж хоослов.

Чимээгүйхэн гурван удаа цом дүүрэн шингэн уулаа. Дараа нь дөрөв дэх цомны хагасыг уугаад аяга руу ганхав. Нүд нь аниастай хэвээр амьсгал нь хүнд болжээ.

- Профессор Дамблдор! Та намайг сонсож байна уу? гэж Харри хүчилсэн хоолойгоор дуудлаа.

Дамблдор хариулсангүй. Царай нь татвалзан аймшигийн зүүдэнд автсан хүнийх шиг болжээ. Түүний цом атгасан хуруу сулрахад шингэн асгарав. Харри гараа сунгаад болор цомыг барьж авлаа.

- Профессор та намайг сонсож байна уу? гэж тэр чанга давтахад агуйгаар дүүрэн цуурайтав.

Хөгшин шидтэн амьсгаадан ярихад (Харри түүний ингэж айсан байхыг үзээгүй учир хоолойг нь таньсангүй),

- Би хүсэхгүй байна ... намайг битгий албадаач ... гэв.

Харри танил махигар хамар, нүдний шилтэй цонхигор царай луу хараад юу хийхээ мэдсэнгүй.

- ... чадахгүй нь ... зогсоохыг хүсэж байна гэж Дамблдор өрөвдөлтэйгээр ёолов.

- Та ... та зогсож болохгүй, Профессор. Та үргэлжүүлэн уух ёстой, санаж байна уу? Та надад ингэж хэлсэн. Энэ ...

Тэр өөрийгөө болон хийж буй ажлаа үзэн ядсаар дүүрэн цомыг Дамблдорын уруулд хүргэн тонгойлгоход үлдэгдэлийг нь залгилаад,

- Үгүй ... би хүсэхгүй байна ... хүсэхгүй байна ... намайг орхи гэж Харри цомыг ахин дүүргэхэд гуйлаа.

- Бүх зүйл сайхан болно, Профессор гээд Харрийн гар чичирлээ.
- Бүгд сайн, би энд байна ...
- Больж үз, больж үз гэж тэр ёолов.
- Тиймээ ... тийм, одоохон энэ бүхэн зогсох болно гэж Харри худал хэлээд цомтой шингэнийг Дамблдорын ам руу уулгав.

Дамблдор хашгирахад чимээ үхлийн харанхуй усан дээгүүр хадан том агуй дотор чанга цуурайтав.

- Үгүй, үгүй, үгүй ... үгүй ... чадахгүй ... намайг битгий шах, би хүсэхгүй байна ...

- Бүх зүйл сайхан болно, Профессор! гэж Харри чанга давтаад гар нь чичрэхэд зураа дахь цомыг арайхийн дүүргэлээ. Аяганы тал нь хэдийн хоосорчээ.

- Таньд юу ч тохиолдохгүй, та аюулгүй байдалд байна, энэ зөвхөн таньд ингэж санагдаж байгаа юм ... жинхэнэ биш гэдгийг тангараглая ... алив үүнийг уучих ...

Ингээд Дамблдор дуулгавартайгаар Харри хорны эсрэг үйлчилгээтэй уусмал өгч буй аятай цомыг хоослоод өвдөг дээрээ унан бүх бие нь чичирлээ.

- Энэ бүхэнд би буруутай! гэж тэр цурхиран хэлээд,
- Чамаас гуйя больж үз, би ойлголоо, миний буруу байж, гуйж байна больж үз би хэзээ ч, хэзээ ч ахин ... гэв.
- Энэ үүнийг зогсоох болно, Профессор гэж Харри чичирсэн хоолойгоор хэлээд Дамблдорын ам руу долоо дахь цомыг цутгалаа.

Дамблдор үл үзэгдэх алуурчид тойрон зогссон мэт дальдчиж Харрийг чичирсэн гараараа ахин цом дүүргэхэд гараа савчаад,

- Түүнийг битгий зовоо, битгий зовоо, гуйя, гуйя үүнд зөвхөн би буруутай, оронд нь намайг зовоо ... гэж ёолов.
- Үүнийг уучих, уучих, тэгвэл та дээрдэх болно гэж Харри цөхрөн гуйлаа.

Дамблдор ахин үгэнд нь орон амаа нээхдээ нүдээ чанга аниад хөлөөсөө толгойгоо хүртэл чичирлээ.

Гэвч уусмалыг уугаад урагш унаж гараараа чулуу нүдэн хашгирахад Харри ес дэх цомыг дүүргэлээ.

- Гуйж байна, гуйж байна, гуйж байна, үгүй ээ ... зөвхөн энэ л биш шүү, энэ л биш, би өөр юу ч байсан хийнэ ...
- Зүгээр л уучих, Профессор, зүгээр л уучих ...

Дамблдор цомтойг цангаж үхэх гэж байгаа хүүхэд шиг залгилмагц дотор нь гал асаж байгаа мэт орилов.

- Хэрэггүй, гуйж байна, хэрэггүй ...

Харри арав дахь удаагаа цомыг дүүргэхдээ болор аяганы ёроол шүргэх чимээ сонслоо.

- Бид бараг дуусаад байна, Профессор. Үүнийг уучих, уучих ...

Тэр Дамблдорын мөрнөөс түшихэд ахин цомыг хоослов. Харри агшин зуур уусмал дүүргэхээр үсрэн боссон ч Дамблдор зовж шаналсандаа улам чанга хашгирлаа.

- Би үхэхийг хүсч байна! Үхэхийг хүсч байна! Үүнийгээ зогсоо, зогсоогооч, би үхэхийг хүсч байна!

- Уучих, Профессор. Үүнийг уучих ... Дамблдор ууснаа сүүлчийн балгыг залгимагц,

- Намайг ал! гэж орилов.

- Энэ ... сүүлчийнх! гэж Харри амьсгаадан хэлээд,

- Түүнийг уучих ... тэгвэл бүх зүйл дуусна ... бүх зүйл дуусна! гэв.

Дамблдор цомтойг эцсийнх нь дуслыг дуустал уугаад аймшигтай татвалзан доошоо харан өнхөрлөө.

- Үгүй! гэж Харри хашгирав.

Тэр ахин цомоо дүүргэхээр боссон ч аягаа дотор нь унагаад дэргэд нь өвдөглөн унаж дээш харуулав. Дамблдорын шил хэлтийж, амаа ангайгаад нүдээ аньсан байлаа.

- Үгүй! гэж Харри давтаад түүний мөрнөөс сэгсрэв.

- Үгүй, та үхэхгүй, та энэ хор биш гэж хэлсэн, сэргэ л дээ, сэргэ! Сэргэ! гэж хашгираад саваагаа цээж рүү нь чиглүүлэхэд улаан гэрэл гялсхийсэн ч юу ч болсонгүй.

- Сэргэ! Гуйж байна, эрхэмээ!

Дамблдорын зовхи чичирэхэд Харрийн зүрх ёгхийлээ.

- Ноёнтоон, та ...

- Ус гэж Дамблдор сөөнгөтөв.

- Ус гэнээ хэмээн Харри санаа алдаад,

- Тийм л дээ ... гэлээ.

Тэр босож аяган дотроос цомоо авахдаа дэргэд нь алтан гинж хэвтэж байгааг харлаа.

- Агуаменти! гэж тэр хашгираад саваагаа цом руу чиглүүлэв.

Цом цэвэр усаар дүүрэв. Харри өвдгөн дээрээ унаад Дамблдорын толгойг өргөж уруулд нь хүргэтэл хоосон байлаа. Дамблдор ёолон амьсгаадаж эхлэв.

- Гэхдээ би хийсэн шүү дээ ... хүлээгээрэй ... Агуаменти! гэж Харри ахин хашгираад саваагаа цом руу чиглүүлэв. Цомонд ахинд цэвэр ус дүүрсэн ч Дамблдорын уруулд хүргэмэгц ахин алга болов.

- Ноёнтоон, би хичээж байна, хичээж байна! гэж Харри цөхрөн хашгирсан ч түүнийг сонсож байгаа гэдэгт итгэлтэй биш байлаа. Тэр хажуулдан унаад сөөнгөтөн амьсгалж зовж шаналсандаа атиралдлаа.

- Агуаменти! Агуаменти! Агуаменти!

Цом дүүрсэн ч ахин хоосров. Дамблдорын амьсгал суларлаа. Харри сандралд автсанаа гэнэтхэн ус олох цорын арга төрлөө. Тэр Волан-де-Мортын ингэж төлөвлөсөн гэдгийг ойлгож байлаа ...

Тэр арлын ирмэг үү ухасхийн цомоо нууранд дүрээд хүйтэн усаар дүүргэтэл хаашаа ч алга болсонгүй.

- Ноёнтоон ... энэ! гэж Харри хашгираад Дамблдор дээр яаран эргэж ирээд цомоо нүүрний урд нь эв хавгүйхэн барилаа.

Тэр үүнээс өөр зүйл чадахааргүй байсан ч гэнэтхэн сул гарнаас нь хүйт даасан гулгамтгай нарийхан цагаан гар зуурч хэн нэгэн удаанаар арагш нь татахыг мэдрэв. Нуурын гадаргуу толигор байхаа больж хөөсрөхөд эргэн тойрон хаа сайгүй цагаан толгой гар цухуйн хөнхийсөн нүдтэй эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдүүд арал руу ойртоход үхэгсдийн арми харанхуй уснаас гарч ирлээ.

- Петрификус Тоталус! гэж Харри хашгираад саваагаа гөлгөр нойтон чулуун дээр байгаа гараас нь зуурсан инфернал руу чиглүүлэв.

Инфернал түүнийг тавьж үс руу цүлхийн унав. Харри арайхийн хөл дээрээ өндийхөд шинэ инферналууд арал руу хэдийн ойртон ирээд хүйтэн хоосон нүдээ салгахгүй ширтсээр ясархаг хуруугаараа гөлгөр чулуунаас зуурч авирлаа.

- Петрификус Тоталус! гэж ахин Харри ахин орилоод саваагаа даллахад арлаас зургаа долоон инфернал унасан ч улам олон авирч ирлээ.

- Отсолбеней! Инкарцеро!

Ахин хэдэн инфернал гуйвлан нэг хоёр нь олсоор ороогдон уналаа. Харри үргэлжлүүлэн саваагаа савчин орилоод,

- Сектусемпра! Сектусемпра! гэлээ.

Шившлэг Харрийн урд байсан инферналын шалба норсон хүйтэн арьс руу онож гүнзгий шарх үүссэн ч цус гарсангүй. Мэдрэмжгүй инферналууд зүг бүрээс нь үрчгэр гараа сунган ойртов. Харри араас нь туранхай хүйтэн үхэл шиг гар тэврэхийг мэдрээд чулуунд бүдрэн унахад инферналууд түүнийг өргөн удаанаар ус руу чирж эхлэв. Харри аврагдах зам үгүй болсныг ойлголоо. Тэр живж үхэн ахин нэг Волан-де-Мортын зэрэмдэг сүнсний үхлийн харуул болно ...

Тэгтэл харанхуйд алтлаг улаан дөл ярсхийн галт цагариг арлыг тойрон хүрээлэхэд Харриг чанга барьж байсан инферналууд гуйвлан удаашраад дөл рүү алхаж чадсангүй. Харри үхдлүүдийг унагаад гулгаж хальтичсаар дээшээ босож шидэт саваагаа өргөөд эргэн тойрноо харлаа.

Дамблдор ахин босч зогсжээ. Тэр инферналууд шиг цонхийн цайсан байсан ч хамаагүй өндөр байсан бөгөөд нүдэнд нь галын оч гялалзаж байв. Тэр саваагаа бамбар адил өндөрт өргөхөд үзүүрээс нь галт бугуйл шиг дөл гарч хуйлран арлын эргэн тойронд дулаахан болов.

Инферналууд өөр хоорондоо сохроор мөргөлдөн галаас аврагдах газар эрэн зугтав. Дамблдор чулуун аяганаас зүүлтийг аваад жанчныхаа дотор халаасанд шургуулав.

Тэр үг хэлэлгүй Харриг араасаа дага гэж дохилоо. Дөлнөөс айсан инферналууд олз нь арлыг орхисныг мэдсэнгүй. Дамблдор Харриг завинд суулгахад галт цагариг тэдний хамт хөдөлж арлын захад цугларсан инферналууд баяртайгаар харанхуй усанд гулган оров.

Харри дагжтал чичирэхэд Дамблдор завинд орж чадалгүй галт цагаригаа барихын тулд найгалаа. Харри түүний гараас бариад суухад туслав. Хоёул завинд аюулгүй суугаад харанхуй усан дээгүүр арлыг орхин буцах замдаа ороход галт цагариг тойрон эргэлдэж байлаа. Инферналууд завины доод талын уснаас цухуйсангүй.

- Ноёнтоон гэж Харри амьсгаадан хэлээд,
- Ноёнтоон би мартчихаж ... галын тухай ... тэд над руу ирэхэд сандраад ... гэв.
- Энэ ч ойлгомжтой гэж Дамблдор бувтнав. Харри түүний хоолой цаашаа орсныг түгшин сонслоо.

Тэднийг эрэгт ойртон ирэхэд завь бөглүү чимээ гарган хошуугаараа чулуу мөргөөд Харри үсрэн бууж Дамблдор туслахын тулд түргэн эргэж харав. Дамблдор эрэг дээр гармагц саваа нь гараас нь унаад галт цагариг агшин зуур алга болсон ч инферналууд уснаасаа цухуйж зүрхэлсэнгүй. Жижигхэн завь гинжээ хяхтнуулсаар удалгүй нуурын усанд далд оров. Дамблдор санаа алдсанаа агуйн ханыг наллаа.

- Би суларчээ ...
- Санаа зовох хэрэггүй дээ, ноёнтоон гэж Харри хэлээд эцэж ядран цонхийсон царайг нь харан,
- Санаа зовох хэрэггүй би таныг эндээс гаргах болно ... ноёнтоон ... Намайг түшээрэй, эрхэмээ ... гэв.

Харри Дамблдорын эрүүл гарыг мөрөн дээгүүрээ давуулаад дагуулан нуур тойрон явахдаа хамаг хүндийн жинг нь авлаа.

- Хамгаалалт байсан ... эцсийн эцэст ... муугүй бодсон гэж Дамблдор сонсдох төдий бувтнав.
- Түүнийг хэн ч ганцаараа давахгүй ... Чи сайн тэмцлээ, Харри маш сайн ...
- Одоо ярихгүй хэрэггүй гэж Харри Дамблдорын хоолой хөл шигээ сулрахад нь хэлээд,
- Хүчээ гамна, ноёнтоон ... Бид удахгүй эндээс явна ... гэв.
- Гарц ахин хаалтай ... миний хутга ...



- Тэр шаардагдахгүй, би гараа чулуунд зүсчихье гэж Харри хатуу хэлээд,
- Та зөвхөн хаана гэдгийг нь хэлчих ... гэв.
- Энд ...

Харри бугуйгаа чулуунд зүсээд хананд хүргэхэд нуман хаалга агшин зуур нээгдэв. Тэд агуйн гадагш харахад Харри Дамблдор хүйтэн тэнгисийн усаар дүүрсэн ангал дундуур явахад туслав.

- Бүх зүйл сайхан болно, эрхэмээ гэж Харри ахин дахин давтахад Дамблдор чимээгүй болж хоолой нь улам суларлаа.
- Бид бараг хүрээд байна ... Би хоёулангаа аваад шилжиж чадна ... Санаа зовох хэрэггүй ...
- Би санаа зовоогүй, Харри гэж Дамблдор мөс шиг хүйтэн усыг үл тоон арай чанга хоолойгоор хэлээд,
- Чи дэргэд байна гэв.

## БҮЛЭГ 27: АЯНГАТ ЦАМХАГ

Тэднийг ахин одот тэнгэрийн дор гармагц Харри Дамблдор ойлролцоох үхэр чулууны орой дээр гарахад туслав. Норж чичирсэн Харри Дамблдоргыг дэмнэн байж бүх хүчээ гарган эцсийн бай болох Хогсмид руу төвлөрлөө. Тэр нүдээ анин Дамблдоргын гараас чанга бариад урагш алхтал танил аймшигтай агших мэдрэмж төрөв.

Тэр нүдээ нээхээсээ өмнө бүх зүйл бүтсэнийг ойлгов. Давсны үнэр, тэнгисийн салхи алга болсон болж хоёул чичирч газар ус дуслуулсаар Хогсмидын харанхуй төв гудамжны дунд зогсож байлаа. Аймшигтай нэг мөчийн туршид Харрид ойлролцоох дэлгүүрийн хажуугаас инфернал гарч ирэх шиг санагдсан ч нүдээ анивчаад харвал ойр хавьд ямар ч хөдөлгөөн байсангүй бөгөөд зөвхөн гудамжинд цөөн хэдэн дэнлүү асаж дээд талын зарим цонхны гэрэл асаастай байлаа.

- Бид чадлаа, Профессор! Бид чадлаа! Бид крестражыг авлаа! гэж Харри шивнэтэл гэнэтхэн цээж нь янгинан өвдөхийг мэдэрлээ.

Дамблдор түүн рүү гуйвлаа. Агшин зуур Харри туршлагагүй шилжилт тэнцвэрийг нь алдуулж гэж бодсон ч гудамжны дэнлүүний гэрэлд түүний царай хэзээ ч байгаагүйгээрээ цонхийн цайсныг харлаа.

- Таны бие зүгээр үү, эрхэм ээ?

- Дээрдэж байна. Энэ уусмал ... маш эрүүл бус ундаа байна ... гэж Дамблдор сулхан хэлэв.

Ингээд Харрийн айдсыг хүргэн газар суулаа.

- Ноёнтоон ... бүх зүйл хэвийн ноёнтоон, та эдгэрнэ санаа зовох хэрэггүй ...

Тэр эргэн тойрноо цөхрөн тусламж эрэн харсан ч хэн ч үзэгдсэнгүйд Дамблдоргыг ямар нэгэн яаралтай аргаар эмнэлэгт хүргэх талаар бодлоо.

- Та сургуульд очих хэрэгтэй, эрхэм ээ ... хатагтай Помфри ...

- Үгүй ээ. Надад профессор Снегг хэрэгтэй ... үнэндээ тэгж бодохгүй байна ... би цаашаа хол явж чадна ...

- Тэгэлгүй яахав, эрхэмээ сонсооч ... Би хаалга цохин таныг амрааж болох байшин олоод хатагтай ...

- Северус. Надад Северус хэрэгтэй гэж Дамблдор тодхон хэлэв.

- За сайн байна Снегг ... гэхдээ би таныг түр орхих хэрэгтэй байна ...

Гэхдээ түүнийг алхам хийж амжихаас урьтаж хэн нэгэн гүйж ирэх чимээ гарлаа. Түүний зүрх хүчтэй цохилоод эргэн харвал хатагтай Розмерта харанхуй гудамжаар ноосон гэрийн шаахай, лууны хатгамал бүхий халаттай яаран ирлээ.

- Би унтлагын өрөөний хөшгөө татаж байгаад гэнэтхэн та нарын шилжин ирэхийг харлаа! Бурханы авралаар, бурханы авралаар надад ямар байгааг төсөөлж ч чадахгүй нь ... Альбус юу тохиолдоо вэ?

Тэр амьсгаа нь давхцан зогсоод Дамблдор руу том харлаа.

- Тэр шархдсан. Хатагтай Розмерта би сургууль руу тусламж дуудахаар гүйхдээ түүнийг «Гурван шүүр»-т үлдээж болох уу?

- Та тийшээ ганцаараа явж болохгүй! Ойлгохгүй байна уу ... ажиглаагүй юм уу?

- Хэрвээ та түүнийг нөгөө талаас нь түшвэл бид дотогш нь оруулж болох юм ... гэж Харри хатагтай Розмертаг сонсолгүй үргэлжлүүлэв.

- Юу болсон юм бэ? Юу болоо вэ, Розмерта? гэж Дамблдор гэнэтхэн асуув.

- Ха ... Хар тамга, Альбус.

Ингээд тэр Хогвартсын дээрх тэнгэр лүү заахад Харри энэ үгэнд айдаст автан эргэж харлаа ...

Хар тамга сургуулийн дээрх тэнгэрт хөөрч байлаа. Үхэл идэгчдийн байшинд орсны тэмдэг болгох юмуу ... хэн нэгнийг алсны тэмдэг болгон үлдээдэг могойн хэл бүхий гялалзсан ногоон гавал ...

- Тэр хэзээ гарсан? гэж Дамблдор асуугаад Харрийн мөрийг өвдтөл базан бослоо.

- Минийхээр бол хэдэн хормын өмнө. Намайг муураа гаргах үед тамга байгаагүй ...

- Бид шилтгээн рүү даруйхан буцах хэрэгтэй гээд Дамблдор үл мэдэг гуйвсан ч толгой нь сайн ажиллаж байгаа бололтой. Розмерта бидэнд шүүр хэрэгтэй ...

- Надад баарны ард хоёр ширхэг байгаа гэж хатагтай Розмерта айсан байртай хэлээд,

- Хүсвэл би тэдэн рүү гүйгээд ... гэв.

- Үгүй, Харри чадна.

Харри шидэт саваагаа түргэн өргөлөө.

- Акцио Розмертагийн шүүр.

Агшины дараа чанга тас хийх чимээ сонсогдон баарны хаалга нээгдсэнээ хоёр шүүр гудамжинд нисэн гарч ирээд Харрийн дэргэд хөвөн зогслоо.

- Розмерта, энэ тухай ид шидийн яаманд мэдэгдээрэй гээд Дамблдор ойролцоох шүүрний нэг дээр суулаа. Хогвартстын хэнд ч муу юм тохиолдоогүй байх ... Харри үл үзэгдэх цуваа өмс.

Харри халааснаасаа цуваа гаргаж нөмрөөд бас шүүрэн дээр суулаа. Хатагтай Розмерта хэдийн баар луу гүйжээ. Харри, Дамблдор хоёр огцом газар түлхээд агаарт хөөрлөө. Тэднийг шилтгээн рүү чиглэхэд Харри нүднийхээ булангаар Дамблдорыг

харж унавал дэмжихэд бэлэн байсан авч Хар тамга шидтэнг сэргээсэн бололтой шүүрэн дээрээ бөхийн тамга руу нүд салгалгүй харж нисэхэд урт мөнгөлөг үс сахал нь шөнийн агаарт намиран хийсэв. Харри бас гавал руу хартал дотор нь айдас хуралдан уушги зүрхийг нь шахах шиг болж толгойд түгшүүртэй бодол эргэлдэв.

Тэд хэр удсан бол? Рон, Гермиона, Жинни нар аз авчирдаг шингэнийг уусан болов уу? Хэрвээ Хар тамга сургуулийн дээр хөөрч байгаа бол тэдний хэн нэг үхсэн юм биш байгаа даа ... эсвэл Невилл, Полумна болон ДА-гийн бусад гишүүд юм уу? Хэрвээ тийм байвал ... тэр тэднийг аюулгүй унтлагын өрөөгөө орхин хонгилд эргүүл хийхийг хэлсэн ... Тэр ахин хэн нэг найзынхаа үхэлд хариуцлага хүлээх юм биш биз дээ?

Тэд харанхуйд түрүүхэн тосгон руу явсан зам дээгүүр нисэхдээ Харри шөнийн исгэрэх салхинд Дамблдор үл мэдэх хэлээр юм бувтнахыг сонслоо. Тэгтэл шүүр нь сургуулийн ханыг даван орохдоо чичирэхэд Дамблдор шилтгээнд түргэн орохын тулд хамгаалалтын шившлэгийг тайлсан болохыг ойлгов. Хар тамга хамгийн өндөр одон орны цамхагийн дээр гялалзаж байлаа. Энэ нь тэнд хэн нэгэн үхсэний тэмдэг юм болов уу?

Дамблдор хэдийн цамхагийн ирмэгтэй хана руу нисэн ороод шүүрнээсээ буулаа. Харри дэргэд нь газардаад ийш тийшээ харав.

Дотор хоосон байлаа. Шилтгээн рүү ордог эргүүлгэн шатны хаалга хаалттай байсан бөгөөд ямар ч тэмцлийн ул мөр болон үхсэн бие байсангүй.

- Энэ юу гэсэн үг вэ? гээд Харри дээрээ хөөрч байгаа могойн хэлтэй ногоон гавал руу харлаа.

- Энэ жинхэнэ тамга мөн үү? Эсвэл хэн нэгэн үнэхээр ... Профессор?

Тамганы бүүдгэр ногоон гэрэлд Харри Дамблдор харласан гараараа цээжээ барихыг харлаа.

- Явж Северусыг сэрээ. Түүнд юу болсныг хэлээд нааш нь авчир. Өөр юу ч хийх хэрэггүй жанчаа бүү тайлж хэнтэй ч битгий ярилцаарай. Би энд хүлээж байя гэж сулхан боловч тод хэллээ.

- Гэхдээ ...

- Чи надад захирагдана гэж амалсан, Харри! Яв!

Харри эргүүлгэн шатны хаалга руу ухасхийсэн ч төмөр цагариг барьж амжихаас нь урьтаж хаалганы нөгөө талаас хэн нэгэн гүйж ирэх чимээ сонсогдов. Тэр Дамблдор руу харахад хажуу тийшээ бол гэж дохив. Харри хаалганаас холдоод шидэт саваагаа гаргалаа.

Үүд тасхийн нээгдэж хэн нэгэн үсрэн гарч ирээд,

- Экспеллиармус! гэж хашгирлаа.

Харрийн бүх бие агшин зуур хөшин хөдөлгөөнгүй болж цамхагийн хана налан хөшөө шиг зогсоод хөдөлж, үг хэлэх чадваргүй боллоо. Тэр яагаад ингэсэн болохыг ойлгосонгүй ... Экспеллиармус Хөлдөөдөг шившлэг биш шүү дээ.

Тэгтэл тамганы гэрэлд Дамблдорын шидэт саваа цамхагийн хана цохин унахыг хараад ойлголоо ... Дамблдор үгэн бус шившлэгээр түүнийг хөдөлгөөнгүй болгосон учир хамгаалах боломжоо алджээ.

Тэр хананы урд цонхийн цайсан царайтай зогсоод ямар ч айсан зовсон шинж үзүүлсэнгүй. Тэгээд ердөө зэвсэггүй болсон хүний байдалтай,

- Оройн мэнд, Драко гэв.

Малфой урагш алхаад хэн нэгэн байгаа эсэхийг түргэн шалгалаа. Түүний харц хоёр дахь шүүр дээр тусав.

- Өөр хэн энд байгаа юм?

- Асуултыг би таньд тавих болно. Эсвэл та ганцаараа байгаа юм уу?

Харри тамганы ногоон гэрэлд Малфойн цайвар нүд ахин Дамблдор руу тусахыг харлаа.

- Үгүй. Би нэмэлт хүч авсан. Энэ шөнө сургуульд Үхэл залгигчид ирсэн.

- Тийм байж хэмээн Дамблдор Малфой түүнд ихээхэн найдлага тавьсан гэрийн даалгавар үзүүлсэн мэт өнгөөр хэлээд,

- Энэ ч муугүй шүү. Та тэднийг нааш нь авчрах арга олсон хэрэг үү? гэв.

- Тиймээ. Хамар дор чинь хийж байхад та юу ч ажиглаагүй! гэж Малфой хүндээр амьсгаадан батлав.

- Ухаалаг байна. Ингэхэд ... намайг уучлаарай ... тэд одоо хаана байна? Би таны туслагч нарыг харахгүй байх чинь.

- Тэд танай зарим харуулуудтай тулгарсан. Доор тулалдаж байгаа. Гэвч энэ удаан үргэлжлэхгүй ... Би түрүүлж ирсэн. Би ... надад хийх ажил бий.

- Тийм тохиолдолд түүнийгээ хий, хүү минь гэж Дамблдор аяархан хэлэв.

Нам гүм болов. Харри мэдээ алдсан биетэй шоронд хориотой байгаа юм шиг үзэгдэхгүй зогсоод тэдэн рүү харах зуураа алсад Үхэл залгигчдын тулааны чимээг сонсохыг хичээлээ. Түүний өмнө зогсож байсан Драко Малфой юу ч хийлгүй зөвхөн Дамблдор луу харахад гайхалтай нь урдаас нь инээмсэглэв.

- Драко, Драко та чинь алуурчин биш биз дээ.

- Та хаанаас мэдэж байгаа юм? гэж Малфой агшин зуур хэлэв.

Ингээд харваас асуултаа хүүхэд шиг сонсогдсоныг ойлгосон бололтой тамганы ногоон гэрэлд улайлаа.

- Та намайг юу чадахыг мэдэхгүй. Юу хийснийг минь мэдэхгүй! гэж Малфой шийдэмгий хэлэв.

- Өө, мэдэлгүй яахав. Та Кэти Белл болон Рональд Уизлиг арай алаагүй. Та энэ жилийн туршид намайг цөхөрсөн аргаар дуусгахыг хичээж байгаа. Өршөөгөөрэй Драко гэхдээ энэ чинь сул оролдлого байсан ... маш сул үнэнийг хэлэхэд би таныг бүх сэтгэл зүрхээ зориулаагүй гэж бодож ...

- Зориулаагүйдээ яасан юм! гэж Малфой уурсаад,

- Би бүтэн жилийн турш өнөөдрийг хүртэл ажилласан ... гэв. Шилтгээний гүнд хашгиралт дуулдав. Малфой хөшсөнөө эргэж харлаа.

- Тэнд хэн нэгэн муугүй тэмцэлдэж байгаа бололтой гэж Дамблдор хэлээд,

- Тэгэхээр та хэлэхдээ ... Тиймээ та хэлэхдээ миний сургуульд Үхэл залгигчдийг авчирсан гэсэн. Би үүнийг боломжгүй гэж бодож байгаагаа хүлээн зөвшөөрөх ёстой ... Та үүнийг яаж хийгээ вэ? гэлээ.

Гэвч Малфой юу ч хэлсэнгүй дор болж байгаа үйл явдлын чимээг Харрийн адил мэдээгүй болсон аятай сонслоо.

- Магадгүй та ажлаа ганцаараа хийхэд хүрэх болох нь. Хэрвээ миний харуулууд нэмэгдэл хүчинд чинь саад болвол? Та энэ шөнө сургуульд Фениксийн бүлгийн гишүүд байгаа гэдгийг хэдийн ойлгосон байх. Тэгээд ч хувьдаа хэлэхэд таньд ямар ч тусламж хэрэггүй ... надад саваа байхгүй ... өөрийгөө хамгаалах зүйл юу ч байхгүй.

Малфой түүн рүү үргэлжлүүлэн харсаар байлаа.

- Ойлгомжтой гэж Дамблдор Малфойн үг хэлэхгүй хөдөлгөөнгүй байгааг харж найрсагаар хэлээд,

- Та тэднийг ирэхээс наана эхлэхээс айж байна гэв.

- Би айгаагүй! гэж Малфой зандарсан хэр нь Дамблдорыг гэмтээх ямар нэг оролдлого хийсэнгүй.

- Харин та л айх ёстой!

- Юунаас тэр вэ? Би таныг намайг ална гэдэгт эргэлзэж байна, Драко. Аллага бол энгийн зүйл биш ... Гэхдээ надад яаж ийш нь найзуудаа авчирснаа хэлээч? Харваас та хэрэгтэй аргаа олоход багагүй хугацаа зарцуулсан бололтой.

Малфой хашгирах хүсэлтэйгээ юмуу бөөлжих хүсэлтэйгээ тэмцэж байгаа мэт харагдав. Тэр шүлсээ залгиад хэдэн удаа гүнзгий амьсгал авахдаа Дамблдороос ууртай харцаа салгалгүй шидэт саваагаа зүрх рүү нь чиглүүлсэн хэвээр байлаа. Ингээд эцэст нь тэссэнгүй бололтой,

- Би олон жилийн өмнөөс хэн ч ашиглаагүй алга болдог шүүгээг зассан юм.

Жилийн өмнө Монтегюгийн орсон гэв.

- А-а-а гээд Дамблдорын санаа алдалтын хагас нь ёолох дуу боллоо. Тэр нүдээ анив.

- Энэ ухаалаг хэрэг болж ... тэд хоёр байсан уу?

- Хоёр дахь нь «Горбин ба Бэркс» мухлагт байсан. Тэд хоорондоо нэг төрлийн хонгилоор холбоостой байсан. Монтегю надад хэлэхдээ дотор нь орох үед хаа байгаа нь тодорхойгүй нэг бол Хогвартсад байгаа юм шиг заримдаа дэлгүүрт байгаа ч юм шиг яг л шүүгээ тэдний хооронд шилжээд дууг нь хэн ч сонсож чадахгүй байгаа юм шиг байсан гэсэн. Эцсийн эцэст тэр хэдийгээр шалгалт өгөөгүй ч гэсэн тэндээс шилжин гарсан. Үүндээ арай л үхээгүй юм. Бүгд Монтегюгийн яриаг сонсоод

санаанаасаа зохиосон түүх гэж бодсон ч би ганцаараа юу болсныг ойлгосон юм. Тэр ч байтугай Горбин хүртэл энэ тухай мэдэхгүй. Би ганцаараа л эвдэрсэн шүүгээг зассан тохиолдолд Хогвартет орох зам нээгдэнэ гэдгийг ойлгосон.

- Маш сайн байна. Тэгэхээр Үхэл залгигчид «Горбин ба Бэркс»-ээр дамжин сургуульд ирэхийн тулд танаас тусамж авчээ ... Ухаалаг төлөвлөгөө байлаа, маш ухаалаг шүү ... гэхдээ та яаж миний хамар дор гэж яаж хэлж чадав.

- Тиймээ шүү гэж Малфой гайхалтай нь Дамблдорыг магтаалд зүрх орсон бололтой,

- Тиймээ, яг тийм! гэв.

- Гэхдээ үүнд багагүй хугацаа орох болохоор та шүүгээг засч чадна гэдэгтээ эргэлзсэн биз дээ? Иймээс бүдүүлэг аргаар надад хараалтай зүүлт илгээсэн нь бусдын гарт золтой л орчихоогүй ... бас хордуулсан балын ундаа илгээсэн ч хэзээ нэг цагт уух магадлал бага байсан ...

- Тэгээд юу гэж та ард нь хэн байсныг ойлгоогүй биз дээ? гэж Малфой шоолонгуй хэлэв.

Дамблдор хүч алдсан бололтой хөл нь хана налан гулгахад Харри хүлсэн шившлэгтэйгээ амжилтгүйхэн тэмцлээ.

- Ер нь хэлэхэд ойлгож байсан. Би таныг гэдэгт итгэлтэй байсан.

- Тэгвэл яагаад надад саад болоогүй юм? гэж Малфой шаардлаа.

- Би оролдсон, Драко. Профессор Снегг таныг миний тушаалаар харж байсан юм ...

- Тэр таны тушаалыг биелүүлээгүй, тэр миний эхэд амалсан ёсоороо ...

- Мэдээж тэр таньд тэгж хэлсэн ч Драко, үнэн хэрэгтээ ...

- Тэр бол хоёр талын тагнуул та хөгшин тэнэг болохоор өөртөө ажиллаж байсан гэж бодож байна!

- Тэгвэл бидэнд өөрсдийнхөө бодолтой үлдэх хэрэг гарч дээ, Драко. Би профессор Снеггэд итгэдэг ...

- Тэгвэл та эрх мэдлээ алдаж! гэж Малфой инээвхийлээд,

- Тэр бүх алдрыг минь булаахыг хүсэж надад тусламж үзүүлэхийг санал болгон «Та юу хийж байгаа юм бэ? Та зүүлтийг шургуулсан уу, энэ чинь бүгдийг баллаж болох тэнэг хэрэг байлаа ...» гэж байсан. Гэхдээ би түүнд Шаардлагатай өрөөнд юу хийж байгаагаа хэлээгүй. Тэр маргааш өглөө

сэрэхэд бүх зүйл хэдийн дуусаж Хар лордын ойрын хүн байхаа болино. Надтай харьцуулахад тэр юу ч биш, юу ч биш шүү! гэв.

- Тиймээ, энэ ч таатай хэрэг шүү гэж Дамблдр тайвнаар зөвшөөрөөд,

- Бид бүгдэд өөрсдийн хөдөлмөрөө өндөр үнэлүүлэх явдал таалагддаг ... Гэхдээ та ямар нэг хамсаатангүй бол бүтэхгүй байсан ... Таньд Кэтид зүүлтийг өгөхийн тулд

Хогсмидэд хэн нэгэн хэрэгтэй байж ... а-а-н ... гээд нүдээ унтах гэж буй мэт аниад толгой дохисноо,

- Тэгэлгүй яахав ... Розмерта. Тэр хэр эртнээс Имперуус шившлэгийн нөлөөн дор байгаа юм бэ? гэв.

- Эцэст нь ойлгов уу? гэж Малфой шоолонгуй инээмсэглэв.

Доор ахин нэг орилолт сонсогдож энэ удаад илүү чанга сонсогдлоо. Малфой түгшин эргэж харснаа яриагаа үргэлжлүүлж буй Дамблдор луу харлаа.

- Тэгэхээр хөөрхий Розмерта хүчээр жорлонд нуугдаад Хогвартсын эхний ганцаар орж ирсэн сурагчид зүүлтийг дамжуулах ёстой байсан уу? Бас хордуулсан ундаа ... Мэдээж зөвхөн Розмерта л түүнийг лонхонд савлаж надад зул сараар бэлэглэхээр Слизнортод илгээхээс өмнө хор нэмж чадах байж. Тиймээ, цэвэр ажил ... маш цэвэр ... Хөөрхий ноён Филч мэдээж хэрэг Розмертагийн илгээсэн лонхыг шалгахгүй ... Гэхдээ та сургуулийн энэ бүх хараа хяналтан дор түүнтэй яаж холбоотой байсан бэ?

- Илбэдсэн зоос гэж Малфой хүчлэн хэлэхэд гартаа барьсан саваа нь чичирлээ.

- Надад нэг нь, нөгөө нь түүнд байж бид хоорондоо мэдээлэл солилцож байсан

...

- Энэ нууц холбооны арга чинь өнгөрсөн жил өөрсдийгөө «Дамблдорын арми» гэж нэрлэж байсан бүлгийн ашиглаж байсан арга биш биз? гэж Дамблдор асуув. Тэр хөнгөхөн ярих хэдий ч Харри түүний хана налан ахин гулсахыг харлаа.

- Тиймээ, би тэднээс санаа авсан юм гэж Малфой гашуунаар инээмсэглэн хэлээд,

- Харин хорны тухай санааг бохир цуст Грэйнджерээс авсан юм. Тэр номын санд

Филчийг уусмал ялгах чадваргүй гэж ярьж байсан ... гэв.

- Эелдэг байж миний өмнө бүдүүлэг үг хэрэглэхгүй байхыг гуйя. Малфой сөөнгөтөн хөхрөв.

- Би таныг алах гэж байхад та «бохир цустан» гэсэн үгэнд санаа зовж байгаа юм уу?

- Тиймээ, зовж байна гэж Дамблдор батлахад Харри түүнийг цэхлэн зогсохын тулд хөлөө хүчлэн жийхийг харлаа.

- Намайг алахын хувьд бол Драко, таньд үүнийг хийх багагүй хугацаа байсан.

Бид ганцаар байна. Түүгээр ч барахгүй би таны мөрөөдөөд ч барахгүй хамгаалалтгүй нөхцөлд байхад одоо хүртэл юу ч хийгээгүй байна ...

Малфой ямар нэг гашуун зүйл амталсан мэт уруулаа ярвайлаа.



- Тэгэхээр энэ шөнө юу болсныг жаахан тааварлах гээд үзье ... Та миний сургуулийг орхихыг яаж мэдсэн хэрэг вэ? гэж Дамблдор асууснаа өөрөө өөрийнхөө асуултанд хариулж,

- Мэдээж Розмерта явахыг минь хараад таньд гайхамшигтай зоосоо ашиглан мэдэгдсэн гэдэгт итгэлтэй байна гэв.

- Яг тийм. Гэхдээ тэр таныг уухаар явсан болохоор удахгүй ирнэ гэж хэлсэн.

- Би үнэхээр уусан ... тэгээд ч эргэж ирсэн ... хэрвээ үүнийг тэгж нэрлэж болох бол. Тэгэхээр та намайг занганд оруулахаар шийдээ юу?

- Бид цамхагийн дээр Хар тамга хөөргөн таныг хэн алагдсаныг харахаар яаран ийшээ ирэхээр болгосон. Тэгээд ч энэ бүхэн ажилласан! гэж Малфой батлав.

- Тийм л дээ. Гэхдээ миний ойлгосноор хэн ч үхээгүй хэрэг үү?

- Хэн нэгэн үхсэн нь тодорхой гэж Малфой дуугаа өндөрсгөлөө. Таны хүмүүсийн нэг ... харанхуй байсан болохоор хэн гэдгийг нь мэдэхгүй байна ... Би биен дээгүүр нь алхан гарсан ... Би энд таны эргэж ирэхийг энд хүлээж байх ёстой байсан ч галт шувуу чинь үргэлж хөлийн дор эргэлдээд саад болоод байсан.

- Тиймээ, үүнийг тэд чадна.

Дор ахин тасхийх чимээ гаран хашгиралт сонсогдоод улам чангарснаас үзэхэд тэмцэл Дамблдор, Малфой болон үл үзэгдэх цувтай зүрх нь хүчтэй цохилон зогсож буй Харри руу хөтлөн аваачих эргүүлгэн шатан дээр явагдаж байгаа бололтой. Хэн нэгэн үхсэн ... Малфой биеэн дээгүүр алхан гарсан ... хэн байсан юм болоо?

- Бидэнд хугацаа бага үлдлээ. Иймээс таны боломжын тухай ярилцъя, Драко.

- Миний боломжын тухай гэнээ! Би таны өмнө алах гээд шидэт саваатай зогсож байхад ...

- Хонгор хүү минь дүр эсгэхээ орхиж үз. Хэрвээ та намайг алах байсан бол шууд зэвсэггүй болгох шид хэрэглэснийхээ дараа хийх байснаас биш таатай яриа өрнүүлээд зогсохгүй байсан.

- Надад сонголт байхгүй! гээд Малфой гэнэтхэн Дамблдор шиг цонхийн цайлаа. Би үүнийг хийх ёстой. Тэр намайг ална! Манай бүх гэр бүлийг ална!

- Таны байдал хүнд байгаа нь надад ойлгомжтой байна. Яагаад намайг урьд нь нүүр тулан уулзаагүй гэж бодож байна? Яагаад гэвэл би лорд Волан-де-Морт сэжиглэж байгааг минь ойлговол таныг ална гэдгийг мэдэж байсан юм.

Малфой энэ нэрийг сонсоод агзасхийлээ.

- Би таньд өгсөн даалгаварын тухай ярилцаж зүрхлэхгүй ч энэ аюултай учир легилменций хэрэглэж сургасан болохыг нь мэдэж байна. Гэвч одоо бид эцэстээ илэн далангүй ярилцаж чадах боллоо ... Таньд сонгосон хохирогчоо амьд үлдээн хэнийг ч гэмтээгээгүйгээрээ ямар ч гай учрахгүй харин ч аз авчрах боломжтой ... Би таньд тусалж чадна, Драко.

- Үгүй, чадахгүй гээд Малфойн саваатай гар харахад аймшигтай чичирлээ.

- Хэн ч чадахгүй. Тэр намайг үүнийг хийж чадахгүй бол ална гэсэн. Надад сонголт байхгүй.

- Зөв талд ор, Драко. Бид таныг бүрэн нууж чадна. Бас өнөө шөнө Фениксийн бүлгийн гишүүдийг эх рүү чинь илгээн нууж чадна. Эцэг чинь одоо Азкабанад байгаа болохоор аюулгүй ... цаг нь ирэхэд бид бас түүнийг хамгаалах болно ... зөв талд ор, Драко ... та чинь алуурчин биш шүү дээ ...

Малфой Дамблдор руу нүдээ томруулан харлаа.

- Гэхдээ би хэтэрхий хол явсан. Тэд таныг дуусгахаар явсан гэж бодож байхад би энд ... та миний гарт байна ... саваа ч гэсэн надад байна ... та миний энэрэнгүй сэтгэлийг хөдөлгөх ...

- Үгүй Драко. Энэ миний энэрэнгүй сэтгэл болохоос биш чинийх биш гэж Дамблдор аяархан хэлэв.

Малфой чимээгүй болоход саваа нь чичирсэн хэвээр байлаа. Харрид тэр одоохон унах гэж байгаа юм шиг санагдав.

Гэнэтхэн шатаар хөлийн чимээ нижигнэж хормын дараа Малфойг хажуу тийшээ холдоход дөрвөн хар жанч цамхагийн хаалгаар үсрэн гарч ирлээ. Харри хөшсөн хэвээр нүд цавчилгүй үл таних хүмүүсийг айдаст харлаа. Харваас Үхэл залгигчид дор болсон тулаанд ялсан бололтой.

Нүсэр биетэй хачирхалтай муруй амтай шидтэн сөөнгөтөн хөхөрлөө.

- Дамблдорыг буланд шахаж! гээд харваас дүү нь бололтой намхан эмэгтэй рүү эргэн инээмсэглэв. Дамблдор шидэт саваагүй, Дамблдор ганцаар байна! Маш сайн байна, Драко сайн байна!

- Оройн мэнд, Амикус гэж Дамблдор аяга цай уухаар зочид ирсэн мэт тайван хэллээ.

- Алектог бас авчраа юу ... маш тааламжтай байна ... Шидтэн эмэгтэй уурсан инээд алдсанаа,

- Энэ тоглоом чинь таньд үхэхийн өмнө туслана гэж бодож байна уу? гэж ёжлон сониучирхав.

- Тоглоом гэнээ? Үгүй дээ энэ бол ердөө хүмүүжил.

- Алив, эхэлцгээе гэж Харрид бусдаасаа илүү ойрхон зосож байсан биерхүү өндөр буурал үс сахалтай, багадсан юм шиг хар жанчтай Үхэл залгигч хэлэв.

Тийм хоолой Харри урьд нь хэзээ ч сонсож байсангүй. Хоолойноосоо илүү хуцалт шиг сонсогдлоо. Харри эрэгтэй хүнээс заваан хөлсний үнэр хүчтэй ханхалж цус үнэртэхийг мэдэрлээ. Түүний бохир гар нь урт шар хумстай ажээ.

- Энэ та юу, Фенрив? гэж Дамблдор асуув.

- Биеэрээ байна. Уулзсандаа таатай байна уу, Дамблдор?

- Үгүй, ингэж хэлэхээргүй л юм байна ...

Фенрир Сивый хурц шүдээ ярзайлган инээмсэглэв. Түүний эрүүг даган цус дуслахад уруулаа удаанаар долоолоо.

- Та намайг жижиг хүүхдүүдэд дуртайг мэднэ биз дээ, Дамблдор.
  - Таныг арван тавны сар гараагүй байхад дайрч байна гэж ойлгож болох уу?
- Энэ ч ер бусын юм ... Сард нэг удаа хүний бие амтлах нь хангалтгүй байгаа хэрэг уу?
- Яг тийм гэж Сивый батлаад,
  - Энэ таныг цочирдуулж байна уу, Дамблдор? Айлгаж байна уу? гэв.
  - Жигшүүртэй мэдрэмж төрж байна. Тэгээд ч Драко таныг сургуульд найзаараа тоохон урьсанд багагүй гайхаж байна ...
  - Би түүнийг уриагүй гэж Драко шивнээд харахыг хүсэхгүй байгаа мэт Сивый руу харсангүй.
  - Би түүнийг ирнэ гэдгийг мэдээгүй.
  - Би Хогвартсад ирэх боломжыг алдахыг хүснэ гэж үү, Дамблдор. Энд хоолой давуулах юм хичнээн их байна гээч ... амттай, амттайхан ...

Ингээд тэрбээр Дамблдор руу шүдээ ярзайлгаснаа шар хумсаараа шүдээ чигчийлэв.

- Харин би амттанаар нь таныг иднэ, Дамблдор ...
- Үгүй! гэж дөрөв дэх Үхэл залгигч болох хэрцгий царайтай шидтэн хэлээд,
- Бидэнд тушаал байгаа. Үүнийг Драко хийх ёстой. Алив, Драко түргэл гэв.

Гэвч Малфой шийдэмгий өнгөө алджээ. Тэр улам хүчтэй цонхийж цамхагийн хана даган гулгасан Дамблдорын царай руу эмээнгүй харлаа.

- Минийхээр бол тэр энэ хорвоо дээр удаан амьдрахгүй! гэж мурий амтай шидтэн дүүтэйгээ нийлэн ахин инээд алдаад,
- Түүнийг хараач ... чамд юу тохиолдоо вэ, Дамби? гэв.
- Өө, суларч доройтсон бие организмын эсэргүүцэл удаан хариу үйлдэл, Амикус. Товчхондоо хөгширөлт ... хэзээ нэгэн өдөр таньд ч гэсэн тохиолдох боломжтой ... хэрвээ таньд аз таарвал ...
- Энэ чинь юу гэсэн үг юм? Юу гэж байгаа юм? гэж гэнэтхэн уурласан Үхэл залгигч хашгираад,
- Үргэлж ийм байх юм даа, Дамби? Та зөвхөн ярьж чадахаас өөр юу ч хийж чадахгүй. Таныг яагаад Хар лорд алах хэрэг гарсныг ойлгохгүй байна! Алив, Драко үүнийг хий! гэв.

Энэ агшинд шатан дээр түчигнэх чимээ сонсогдоод хэн нэгний хоолой,

- Тэд шатыг хаажээ! Редукто! Редукто! гэж хашгирлаа.

Харрийн зүрх үсчин цохиллов. Энэ дөрөв бүх өрсөлдөгчөө устгаагүй зүгээр л дээд талын цамхаг руу гараад ардаа хаалт үүсгэсэн бололтой ...

- Алив, Драко түргэлээрэй! гэж хэрцгий шидтэн ууртай хашгирлаа.

Гэвч Малфойн гар хүчтэй чичирч байсан учир бай руугаа чиглүүлж чадсангүй.

- Алив, би үүнийг хийе гэж Сивый архираад Дамблдор руу гараа сунган шүдээ ярзайлган ухасхийлээ.

- Би үгүй гэж хэлсэн биз дээ! гэж шидтэн зандраад гэрэл гялсхийхэд хүн чоно хажуу тийшээ шидэгдэж хана цохин гуйвлаад уурсан харлаа.

Харрийн зүрх сонсогдох шахам хүчтэй цохилоход Дамблдорын шидэнд хориотой хэвээр зогсоод ... хэрвээ зөвхөн хөдөлж чаддаг бол тэдэн рүү жанчин дороос шившлэг илгээж ...

- Драко үүнийг хий эсвэл холдоод бидний нэгд хийх боломж олго... гэж эмэгтэй хашгирах агшинд цамхагийн хаалга ахин саван нээгдэж босгоор Снегг гартаа шидэт саваа барин орж ирлээ. Түүний хар нүд хананд шахагдсан Дамблдор болон дөрвөн Үхэл залгигч, уурласан хүн чоно, Малфойг гүйлгэн харлаа.

- Бидэнд асуудал үүсээд байна, Северус гэж нүсэр биетэй Амикус хэлээд шидэт саваагаа Дамблдор руу чиглүүлж,

- Хүү үүнийг хийж чадахгүй нь ... гэв.

Гэвч хэн нэгэн Снеггийн нэрийг сонсдох төдий хэллээ.

- Северус ...

Энэ бүх үдшийн эцэст чимээ Харрийг улам айлгалаа. Дамблдорын хоолойд анх удаагаа гуйлт сонсогдов.

Снегг юу ч хэлэлгүй хэдэн алхам урагшлаад Малфойг замаасаа түлхэн холдуулав. Гурван Үхэл залгигч чимээгүйхэн ухрав. Тэр ч байтугай хүн чоно хүртэл сүрдсэн байртай харагдав.

Агшин зуур Снегг Дамблдор руу харахад царайд нь жигшүүр үзэн ядалт илрэн гарч ирэв.

- Северус ... чамаас гуйя ...

Снегг саваагаа өргөн Дамблдор руу чиглүүллээ.

- Авада Кедавра!

Снеггийн шидэт саваанаас ногоон дөл гялсхийгээд Дамблдорын цээж рүү онолоо. Харри айдаст автан орилсон ч чимээ уруулыг нь даван гарсангүй. Тэр чимээгүй хөдөлгөөнгүй зогсоод Дамблдор хэрхэн гялалзсан гавлын дор түр хөшсөнөө дараа нь том үнгэгдсэн хүүхэлдэй адил арагшаа удаанаар унаж цамхагаас нисэн алга болохыг харлаа.

## БҮЛЭГ 28: ЭРЛИЙЗ ХУНТАЙЖ ЗУГТСАН НЬ

Харрид өөрөө хоосон орон зай руу нисэж байгаа юм шиг санагдав. Байж боломжгүй юм ... байж боломжгүй юм ...

- Түргэн явцгаая гэж Снегг хэлэв.

Тэр Малфойн шилэн хүзүүнээс бариад хаалганы зүг хүчтэй түлхлээ. Сивый баярлаж хөөрсөн намхан ах дүүсийн араас дагалдав. Тэднийг хаалгаар далд орохтой зэрэгцэн Харри ахин хөдлөх чадвартай болсноо мэдрэв. Хананд түүнийг барьж байсан зүйл шид биш айдас цочирдол байлаа. Тэр үл үзэгдэх цуваа тайлахад цамхагийн оройгоос хамгийн сүүлд хэрцгий царайтай Үхэл залгигч гарч байлаа.

- Петрификус Тоталус!

Үхэл залгигч нуруу руугаа хүнд зүйлээр цохиулсан мэт урагш шал цохин уналаа. Харри түүнийг дээгүүр харайгаад харанхуй шатаар доош уруудав.

Айдас зүрхийг нь тасчин хаях шиг болов. Тэр Дамблдорыг олж, Снеггийг гүйцэх ёстой! Ямар аргаар энэ хоёр даалгаварыг биелүүлэх вэ ... Тэр хоёуланг нь олох юм бол болсон бүх явдлыг засаж чадна ... Дамблдор үхэж чадахгүй ...

Тэр эргүүлгэн шатны сүүлчийн арваад гишгүүрийг алгасан харайгаад саваагаа барин газардав. Бүдэг гэрэлтэй хонгилд дүүрэн тоос бургилж адрын тал нь цөмрөн унаад энд тэмцэл өрнөж байлаа. Хэн хэнтэйгээ үзэлцэж байгааг ойлгож амжаагүй байтал үзэн ядмаар хоолой «Бүх зүйл дууссан, явцгаая!» гэх нь сонсогдоод Снегг хонгилын булангаар эргэн алга болох нь үзэгдэв. Тэр харваас Малфойг тулааны талбараас эсэн мэнд гаргасан бололтой. Харри түүний араас яаран ухасхийтэл тэмцлийн дундаас хүн чоно Сивый үсрэн гарч ирлээ. Тэр Харриг саваагаа өргөж амжихаас нь урьтаж даран унахад нуруугаараа газар унаад ширэлдсэн үстэй нүүр, шинэхэн цусанд будагдсан өмхий ам хамар болон хүзүүндээ халуун амьсгал мэдэрлээ ...

- Петрификус Тоталус!

Харри Сивый дээр нь сулрахыг мэдрээд бүх хүчээ гарган түлхэж шалан дээр унагаад түүний зүг нисэн ирсэн ногоон очноос бултаж үсрэн босоод тонгойн гүйлээ. Түүнийг тэмцлийн гүнд орох үед хөл дор нь ямар нэгэн зөөлөн гуламтай зүйл гишгэгдэхэд хоёр бие доошоо харан цусанд будагдан хэвтэж байсанд хэн байсныг нь ялгах цаг байсангүй. Урд нь галын дөл адил шаргал үс гялсхийн Жинни нүсэр биетэй Үхэл залгигч Амикустай үзэлцэж шившлэг илгээхэд нь бултлаа. Амикус хөхрөөд таатайгаар,

- Круцио! Круцио! Чи үүрд бүжиглэж чадахгүй, хөөрхөн минь гэв.

- Остолбенеи! гэж Харри хашгирав.

Шившлэг Амикусын цээж рүү оноход өвдсөндөө гахай шиг чарлаад хана мөргөн унаж тус бүрдээ Үхэл залгигчидтай тулалдаж байгаа Рон, профессор МакГонагалл, Люпин нарын цаагуур оров. Харри тэдний дунд Тонксын үзэлцэж байгаа том биетэй

цайвар үстэй шидтэн зүг бүр рүү замбараагүй шившлэг илгээхэд нэг нь хана цохин чулуу буталж бусад нь ойролцоох цонх хагалахыг харлаа ...

- Харри чи хаанаас гараад ирэв? гэж Жинни хашгирсан ч хариулах цаг байсангүй.

Тэр толгойгоо бөхийлгөөд бүх хүчээ гарган хонгилоор гүйхэд дээгүүр нь шившлэг нисэн өнгөрч хана цохин бутрав. Снегт зугтах ёсгүй, тэр Снеггийг гүйцэх ёстой ...

- Үүнийг чамд! гэж профессор МакГоаналл хашгирахад Харри нүднийхээ булангаар эмэгтэй Үхэл залгигч Алектон хонгилоор толгойгоо гараараа барин зугтаад араас нь ах нь гүйхийг харлаа. Харри тэдний араас ухасхийсэн ч дараагийн агшинд хэн нэгний хөлд бүдрээд эргэж харвал шалан дээр Невиллийн цонхигор дүгэриг царай харагдав.

- Невилл, чи ...

- Зүгээр дээ гэж бувтнаад гэдсээ барьж,

- Харри ... Снегт Малфойтой хамт байсан ... саяхан үүгээр өнгөрсөн гэв.

- Би мэднэ, араас нь явж байна! гээд Харри шалан дээрээс том биетэй цайвар үстэй Үхэл залгигч руу шившлэг илгээв. Түүний нүүрэнд цохилт ирэхэд өвдсөндөө хашгираад гуйвалсаар ах дүү хоёрын араас гүйлээ.

Харри шалан дээрээс өндийгөөд хонгилоор гүйхдээ найзууд нь араас дуудахыг тоосонгүй.

Тэр буланд гулган зогсоход кэт нь цусанд хальтирлаа. Снегт хэдийн холдсон болохоор магадгүй Шаардлагатай өрөөнд ороод алга болдог шүүгээний өмнө зогсож байгаа байх ... Эсвэл бүлэг түүнд саад болж Үхэл залгигчид ирсэн шигээ буцаж чадахгүй юм болов уу? Харри хонгилоор гүйхдээ хөлийн чимээнээсээ ондоо дуу сонссонгүй бөгөөд зүрх нь үсчин цохиллов. Түүнийг дараагийн хоосон хонгилд хүрэхэд шалан дээр цустай мөр дуслан нэг Үхэл залгигч үүдний хаалга руу чиглэснээс үзэхэд Шаардлагатай өрөө хаалттай байж болох юм ...

Түүнийг өөр нэг булан гулган тойрмогц дэргэдүүр нь шившлэг гялсхийн өнгөрч рыцарын дуулга онон дэлбэрэв. Тэр ах дүү хоёр Үхэл залгигч гантиг шатаар уруудан гүйхийг хараад хэдэн шившлэг илгээсэн авч шатны дээр өлгөөтэй хэдэн хиймэл үстэй шидтэний хөрөг оногдон унахад хашгиралдан зэргэлдээх хөрөг рүүгээ гүйлээ. Түүнийг хэмхэрсэн дуулганы дээгүүр харайхад шинэ хашгиралт сонсогдон шилтгээнд бусад хүмүүс сэрж эхэллээ ...

Тэр товч замаар гүйхдээ ах дүү хоёрыг Снегт Малфой хоёрт хүрэхээс урьд гүйцэнэ байх гэж найдав. Нууц шатны дундах алга болдог гишгүүр дээгүүр харайхаа маргалгүй хөрөгний цаанаас гарч ирэхэд хонгилд дүүрэн унтлагын хувцастай Пуффендуйчууд зогсож байлаа.

- Харри! Бид чимээ шуугиан сонслоо. Тэнд бас Хар тамганы тухай ярьж байна ... гэж Эрни Макмиллан хэлэв.

- Замаас холд! гэж Харри орилоод хоёр хүүг түлхэж гантиг шатаар уруудан гүйлээ. Үүдний царсан хаалга цэлийтэл нээлттэй шалны чулуун хавтан дээр цусны толбо дусалж айсан хэдэн сурагчид хананд наалдан зогсоод зарим нь нүүрээ гараараа дарсан байлаа. Гриффиндорын элсэн цаг шившлэгэнд цохигдон хэмхэрч бадмаараг нь чулуун хавтан дээр унаж байв ...

Харри үүдний танхимаас гарч харанхуй хашаанд гүйн гарахад алсад гурван дүрс нуга дээгүүр гүйн шилжиж чадах газар болох хаалга руу чиглэхийг харлаа. Энэ бол том биетэй цайвар үстэй Үхэл залгигч болон арай хойно Снегг, Малфой хоёр байв.

Шөнийн хүйтэн агаарт Харри араас нь гүйхдээ алсад гэрэл гялсхийхтэй зэрэгцэн тэдний дүрсийг харлаа. Тэд шившлэг илгээхэд хэтэрхий хол зайтай байсан тул юу болсныг ойлголгүй үргэлжлүүлэн гүйсээр байлаа.

Ахин гэрэл гялсхийж хашгиралт дуулдан хариу оч нисэхэд Харри ойлгов. Хагрид овоохойноосоо үсрэн гараад Үхэл залгигчдын зугталтыг таслан зогсоохыг оролджээ. Түүнийг амьсгалах тоолонд уушиг нь урагдаж байгаа юм шиг болж цээжинд нь халуу оргиход урагш улам хурдан гүйхдээ дотор нь «зөвхөн Хагридыг л биш шүү ... Хагридыг бас биш шүү» гэсэн бодол төрлөө.

Ямар нэгэн зүйл шилэн хүзүү рүү нь хүчтэй цохиход нүүрээрээ газар саван унаад хоёр хамраас нь цус гоожлоо. Тэр шидэт саваагаа барьж өнхрөөд ах дүү хоёрыг товч замаар гүйцэж ардаа гаргасныг ойлголоо ...

- Импедимента! гэж тэр орилоод ахин өнхөрч харанхуй газар нуугдан агийхад шившлэг шидээр нэгийг нь онож нөгөө нь түүнд бүдэрч унав. Харри үсрэн босоод цаашаа Снеггийн араас гүйлээ ...

Тэр гэнэтхэн үүлсийн завсар гийгүүлсэн хавирган сарны гэрэлд Хагридын нүсэр том дүрс рүү цайвар үстэй Үхэл залгигч ээлж дараалан шившлэг илгээхийг харсан ч түүний аварга биет эхээсээ өвлөн авсан бөх арьс сайн хамгаалж байв. Энэ зуур Снегг, Малфой хоёр үргэлжлүүлэн гүйсээр удахгүй шилжиж чадах газар болох хаалгаар гарах нь ...

Харри Хагрид болон өрсөлдөгчийнх нь дэргэдүүр өнгөрөөд Снеггийн нуруу руу саваагаа чиглүүлэн,

- Остобней! гэж хашгирлаа.

Тэр алдаж улаан оч Снеггийн толгой дээгүүр ярсхийн өнгөрөхөд «Гүй, Драко!» гэж хашгираад Харритай эргэн нүүр тулгарлаа. Тэд хорин ярдын зайнаас бие биеэн рүүгээ харж зэрэг саваагаа өргөөд,

- Кру ...

Гэвч Снегг шившлэгийг няцаахад Харри руу эргэн ойж хөл рүү нь онолоо. Харри газар унаад босоход том биетэй Үхэл залгигч нурууных нь ард,

- Инсендио! гэж орилов.

Ямар нэг юм дэлбэрэх чимээ гарснаа эргэн тойрныг галын дөл бүжиглэн гийгүүлэхэд Хагридын овоохой шатлаа.

- Тэнд Соёт байгаа шүү дээ, ёрын амьтан ...! гэж Хагрид дэлбэрэв.
- Кру ... гэж Харри ахин хашгираад галын гэрэлд урдаа байгаа дүрс рүү чиглүүлсэн ч Снегт шившлэгийг хааж шоолонгуй инээмсгэлэв.
- Ямар ч Уучлашгүй шившлэг биш шүү, Поттер! гэж Снегт хашгирахад галын дөл хуйлрах, Хагридын орилох, түгжээтэй байшинд Соёт галзуу юм шиг хуцах дуу хадав.
- Чамд үүнийг хийх зориг ухаан хангалтгүй ...
- Инкар гэж Харри орилсон ч Снегт шившлэгийг бараг залхуутайгаар гараа даллан хаав.
- Тэмц! Тэмцээч, хулчгар минь ... гэж Харри орилов.
- Чи намайг хулчгар гэж нэрлэж байгаа юмуу, Поттер? Чиний эцэг чинь намайг дөрвүүлээ нэгийн эсрэг байхдаа дайрдаг байсан. Чи түүнийг юу гэж дуудах гэж байгаа чинь сонирхолтой? гэж Снегт хашгирлаа.
- Остол ...
- Ахиад л хаах болно цааш цаашдаа чамайг амаа хамхиж ухаанаа хааж суртал чинь хаах болно, Поттер! гэж Снегт хорон инээмсэглэн шившлэгийг хааснаа,
- Хангалттай! гээд Харрийн ард байгаа том биетэй Үхэл залгигч руу,
- Эндээс явахгүй бол удахгүй ид шидийн яамныхан ирнэ гэж хашгирлаа.
- Импеди ...

Гэвч Харри шившлэгээ хэлж амжихаас урьд тэсэхийн аргагүй өвдөхөд өвдгөөрөө ногоон дээр уналаа. Хэн нэгэн хашгирахад тэр зовж шаналсандаа үхэж байгаа гэдэгтээ итгэлтэй байлаа. Снегт түүнийг галзууртал юмуу үхтэл нь тамлах болно ...

- Үгүй! гэж орилох Снеггийн хоолой гарахад өвдөлт эхэлсэн шигээ агшин зуур намдав. Харри харанхуй ногоон дээр гартаа шидэт саваагаа барьж амьсгаадсаар атиралдан хэвтэхэд Снегт хаа нэгтгээгээс,
- Чи тушаалыг мартаа юу? Поттер Хар лордод зориулагдсан болохоор бид түүнийг орхих ёстой! Явцгаая! явцгаая! гэлээ.

Харри нүүрнийх нь дор газар чичигнэхийг мэдэртэл ах дүү хоёр, том биетэй Үхэл залгигчийн хамтаар хаалга руу гүйлээ. Харри уур хилэнд автсандаа энэ агшинд амьд үхсэн эсэх нь хамаагүй боллоо. Тэр хөл дээрээ хүчлэн босож одоо Волан-де-Мортоос ч илүү үзэн ядаж байгаа Снеггийн зүг рүү найган явлаа ...

- Сектум ...!

Снегт саваагаа даллахад шившлэг ахиад л няцаагдан Харри галын дөлний туяанд дайсныхаа царайд эцэст нь жигшүүртэй инээмсэглэл биш уур хилэн тодрохыг харав. Тэр бүх хүчээ хураан төвлөрөөд, «Леви» ... гэж бодлоо.

- Үгүй, Поттер! гэж Снегт орилов.



Чанга тасхийх чимээ гараад Харри ар нуруугаараа агаарт үсрэн газар хүчтэй цохин унахад саваа гараас нь мулт үсэрлээ. Тэр Хагридын орилолт, Соёотын хуцалтыг сонсов. Снегт ойртон ирээд Дамблдорын адил саваагүй хамгаалалтгүй хэвтэж байгаа түүн рүү харлаа. Галын дөл Дамблдор руу шившлэг илгээсэн Снеггийн үзэн ядмаар царайг гийгүүлэв.

- Чи миний зохиосон шившлэгийг эсрэг ашиглаж зүрхэлнэ гэнээ, Поттер? Үүнийг чинь би зохиосон юм ... Би эрлийз Принц! Харин чи миний бүтээлийг жигшүүртэй эцгийнхээ адил эсрэг ашиглана гэнээ? Тэгж бодохгүй байна ... Үгүй ээ!

Харри саваа руугаа ухасхийсэн ч Снегт шившлэг илгээхэд цохигдон хэдэн алхамын зайд нисээд харанхуйд алга болов.

- Тэгвэл намайг ал! гэж Харри амьсгаадан хэлэхэд ямар ч айдас байсангүй зөвхөн уур хилэн байлаа.

- Түүнийг алсан шигээ ал хулчгар ...

- Бүү зүрхэл! гэж Снегт хашгирахад царайд нь гэнэтхэн хүний бус ухаангүй уур хилэн тодорч,

- Намайг хулчгар гэж хэлж бүү зүрхэл! гэв.

Тэр саваагаа агаарт шавхуурдахад Харрийн нүүр лүү цагаан ташуур шиг зүйл ороолгон арагшаа саван уналаа. Гэрлийн толбо нүдний өмнүүр нь эргэлдэн амьсгалж чадахгүй болсон юм шиг санагдсан ч дээр нь далавч исгэрэх чимээ гарч ямар нэг том зүйл ододын доогуур нисэхийг харлаа. Клювокрыл Снегт руу дайран сахлын хутга шиг хурц хошуугаа тас няс хийлгэн ухраав. Харри хүчлэн өндийгөөд сүүлчийн цохилтоос хойш толгой нь эргэсэн хэвээр байсан учир Снегт далавчаа тас няс хийлгэн дэвж хэзээ ч сонсоогүй муухай дуугаар орилох Клювокрылээс зугтахыг харлаа ...

Харри хөл дээрээ найган босоод Снеггийн араас ахин хөөхөөр эргэн тойрноо харж саваагаа хайсан авч ногоон дээрээс мөчир тэмтрэн олох үедээ хэтэрхий хожимдсон гэдгээ ойлголоо. Эцэст нь саваагаа олох үед хаалган дээр эргэлдэж буй Клювокрылыг харав. Снегт хэдийн сургуулийн талбайгаас гарч амжаад шилжин алга болжээ.

- Хагрид гэж Харри шивнэснээ эргэн тойрноо мэгдэн харлаа. Хагрид?

Тэр шатаж буй овоохой руу бүдчин ойртоход ойн сахиулын том бие дөлнөөс Соёотыг зөөн гаргаж ирлээ. Харри талархсандаа хашгиран өвдөг дээрээ унахад хөл гар нь чичирэн, бүх бие нь янгинан өвдөж, амьсгалах тоолонд цээжээр нь хатгуулж байв.

- Чи зүгээр үү, Харри? Зүгээр биз дээ? Ямар нэг юм хэлээч, Харри ...

Хагридын үсэрхэг том царай Харрийн дээрээс ододыг хаан бөхийлөө. Тэр шатаж байгаа модны үнэр болон нохойн үсийг мэдэрлээ. Түүний дэргэд Соёт налаад чичирч байв.

- Би зүгээр гэж Харри амьсгаадаад,
- Харин чи? гэлээ.
- Мэдээж ... намайг тийм ч амархан дуусгахгүй шүү.

Хагрид гараа сунган Харриг хүчтэй өргөн босгоход хөл нь газраас хөндийрөв. Тэр Хагридын нүдэн дорх гүн шархнаас хавдсан хацар дээгүүр нь цус урсахыг харлаа.

- Гэрийг чинь унтраах хэрэгтэй байна. Алив хамтдаа «Агуаменти» шид хэрэглэцгээе ...

- Нэг тиймэрхүү зүйл хэлэх хэрэгтэйгээ санаж байна гэж Хагрид бувтнаад уугьж буй байшин руу ягаан шүхрээ чиглүүлэн,

- Агуаменти! гэв.

Тэгтэл шүхрийн үзүүрээс ус шүршигдлээ. Харри тугалга шиг хүнд болсон саваагаа өргөөд бас «Агуаменти!» гэж шивнэлээ. Тэд хоёул байшинг сүүлчийн галын дөлийг унтартал усаар шүршив.

- За яахав тийм ч муугүй боллоо гэж Хагрид хэдэн хормын дараа найдангуй бувтнаад уугьж буй үлдэгдэл рүү харж,

- Дамблдор дор нь засчихна ... гэв.

Энэ нэрийг хэлэхэд Харрийн дотор төөнөн өвдөж айдас эргэн тойрны нам гүм шиг дотрыг нь атган авлаа.

- Хагрид ...

- Би лукотрусын хөлийг эмчилж байтал гэнэтхэн ирж байгаа чимээ сонссон гээд Хагрид овоохойноосоо үлдсэн хэсэг рүү гунигтай харж,

- Тэд хамт шатсандаа, хөөрхий жижигхэн амьтад ... гэв.

- Хагрид ...

- Юу болсон бэ, Харри? Үхэл залгигчид шилтгээн рүү яаж орсон юм бол? Бас Снегг тэдэнтэй ямар чөтгөрөө хийж байгаа хэрэг вэ? Тэр хаашаа ... тэдний араас хөөж байсан уу?

- Тэр гээд Харри утаа болон цочирдлоос хатсан хоолойгоо засан ханиалгалаа.

- Тэр ... тэнд аллага үйлдсэн, Хагрид ...

- Аллага гэнээ? хэмээн Хагрид чанга хэлээд Харри руу харж,

- Снегг алсан юм уу? Чи юуны тухай яриад байна, Харри? гэв.

- Дамблдорыг. Снегг алсан ... Дамблдорыг.

Хагрид чимээгүйхэн юу ч ойлгосон шинжгүй түүнийг харж байв.

- Дамблдорыг яасан гэнээ, Харри?

- Тэр үхсэн. Снегг түүнийг алсан ...

- Тэгж бүү ярь гэж Хагрид бүдүүлгээр таслаад,
- Снегг Дамблдорыг алсан гэнээ ... Бүү тэнэг юм ярь, Харри. Чи яагаад тэгж хэлж байгаа юм бэ? гэлээ.
- Би яаж болсныг нь харсан.
- Чи түүнийг харж чадахгүй.
- Би харсан, Хагрид.

Хагрид толгойгоо үл итгэсэн байртай өрөвдөнгүй сэгсрэв. Харваас ойн сахиул Харриг толгойгоо хэтэрхий чанга цохьсоны улмаас будилж байна гэж бодов бололтой ...

- Дамблдор Снеггэд Үхэл залгигчидтай яв гэж хэлсэн байх хэмээн Хагрид итгэлтэй хэлээд,
- Тэд түүнийг илрүүлэхгүй тулд. Сонсооч сургууль руу буцацгаая. Явъя, Харри ...

Харри тайлбарлахыг хичээн маргасангүй. Тэр дагжтал чичирч байлаа. Хагрид удахгүй бүгдийг мэдэх болно хэтэрхий түргэн ... Цамхагт ойртоод Харри олон тооны гэрэл асаатай байхыг харж дотор юу болсныг төсөөлөв. Хүмүүс өрөөгөөр гүйлдэн бие биендээ шилтгээнд Үхэл залгигчид орж ирснийг хэлж Хогвартсын дээгүүр Хар тамга хөөрч байгаагаас үзэхэд хэн нэгнийг алсан ...

Үүдний царсан хаалга нээлттэй довжооны өмнөх зүлгэн дээр гэрэл тусаж байлаа. Шатны гишгүүр дээгүүр удаан итгэлгүйхэн унтлагын хувцастай сурагчид багш нарын хамт гарч ирээд эргэн тойрондоо Үхэл залгигчидын шинж тэмдэг байгаа эсэхийг харав. Гэвч Харрийн нүд өндөр цамхагийн дор төвлөрлөө. Тэнд ногоон дээр том хар зүйл хэвтэж байгаа юм шиг санагдсан ч ялгаж харахад хэтэрхий хол байлаа. Тэгтэл Дамблдорын бие хэвтэж байх ёстой гэж бодсон газар луу хүмүүс явж эхлэх нь үзэгдэв.

- Тэд нар юугаа хараад байгаа юм бэ? гэж Хагрид шилтгээн рүү ойртохдоо хэлэхэд Соёт эзнийхээ хөлд ойрхон гүйж байлаа.
- Тэнд ногоон дээр юу хэвтэж байгаа юм бэ? гэж тэр огцом нэмэрлээд одон орны цамхаг руу зүглэхэд хэдийн багахан хүмүүс цугларчээ.
- Чи харж байна уу, Харри? Цамхагийн дор баруун талд? Хар тамганы дор ...

Чөтгөр гэж ... хэн нэгнийг унагасан гэж бодож байна уу..?

Тэгснээ Хагрид чимээгүй болоод айсан төрхтэй болов. Харри түүний хажууд алхахдаа хагас цагийн өмнө өөр хоорондоо ялгаатай шившлэгэд цохиулсан нүүр болон хөл нь янгиан өвдөхийг мэдэрлээ. Тэр энэ ойлгомжгүй өвдөлт дэргэдээ яваа өөр хэн нэгнийг өвтгөхийг мэдэрлээ. Энэ бол жинхэнэ аймшигтай цээжин дэх тэвчихийн аргагүй шаналал байлаа ...

Тэр Хагридын хамт зүүдэлж байгаа юм шиг явсаар цугласан хүмүүсийн захад хүрэхэд багш сурагчид нар хэсэгхэн газар цоорхой үүсгэн зогсчээ.

Харри Хагридын өвдөж цочирдсондоо ёолохыг сонссон ч зогссонгүй удаанаар урагшлан Дамблдорын бие хэвтэж байгаа газар хүрлээ.

Тэр агшинд Дамблдорын хөшөөсөн шившлэг цуцлагдах үед шившлэгийг болиулах найдлага үгүй байж түүнийг илгээсэн даруй үхсэн болохыг ойлголоо. Түүний урд хамгийн агуу шидтэн газар гараа дэлгээд хэвтэж байв ...

Дамблдорын нүд аниастай бөгөөд хөл гар нь нугалараагүй бол унтаж буй мэт санагдана. Харри гар сунгаж махигар хамар дээрх шилийг засаад амнаас нь урссан цусыг ханцуйгаараа арчлаа. Дараа нь хөгшин ухаалаг царай руу хараад тэсэхийн аргагүй үнэнийг ойлгохыг хичээв. Дамблдор хэзээ ч түүнтэй ярихгүй, хэзээ ч туслахаар ирэхгүй ...

Харрийн нурууны ард хүмүүс аяархан ярилцав. Удаан хугацаа өнгөрөх шиг санагдсан ч тэр өвдөглөн суугаад доошоо харсаар байлаа.

Олон цагийн өмнө Дамблдорын авсан зүүлт халааснаас нь унажээ. Харваас газар цохин унахдаа гуу нь нээгдсэн бололтой. Тэр айдас гашуудалд нэрвэгдэн зүүлтийг газраас аваад гууг нь гаран дээрээ эргүүлэв ...

Зүүлт Харрийн гүн ухааны цүнхээлд харсантай адил том биш бөгөөд Слизериний тэмдэг болох чимэглэгдсэн «С» үсэг байсангүй. Түүнчлэн дотроос нь жижигхэн хуйлсан цаас цухуйж байлаа.

Өөрийн мэдэлгүй юу хийж байгаагаа ч бодолгүй Харри цаасны өөдсийг авч тэнийлгээд олон тооны шидэт савааны гэрэлд уншлаа.

Хар лордод.

Би удахгүй үхнэ гэдгээ мэдэж байгаа ч хэрвээ чи үүнийг уншиж байвал нууцыг чинь нээснээ хэлэхийг хүссэн юм. Би жинхэнэ крестражыг устгахын тулд хулгайлан авсан бөгөөд удахгүй үүнийг хийх болно. Би үхлийн царай руу чамайг удахгүй түүнтэй ердийнөөр тулгарах болно гэж найдан харж байна.

Р.А.Б

Энэ илгээмж юу илэрхийлж байгааг Харри мэдсэнгүй мэдэхийг ч хүссэнгүй. Зөвхөн ганц л зүйл чухал байлаа. Энэ бол крестраж биш байв. Дамблдор суларч доройтон байж бүх хүчээ гарган аймшигтай уусмалыг уусан. Харри цаасыг гартаа базаад нүдэнд нь нулимс халуу оргих агшинд ард нь Соёот ульж эхлэв.

## БҮЛЭГ 29: ГАЛТ ШУВУУНЫ НУЛИМС

- Явъя, Харри ...
- Үгүй.
- Чи энд үлдэж болохгүй, Харри... Алив ээ, явъя...
- Үгүй.

Тэр Дамблдорыг орхихыг хүссэнгүй ер нь хаашаа ч явахыг хүссэнгүй. Хагридын гар мөрөн дээр нь чичирлээ. Дараа нь өөр хоолой,

- Харри, явъя гэлээ.

Хэн нэгний жижигхэн дулаахан гар түүний гарыг дээш өргөлөө. Харри юу ч бодолгүй араас нь дагалдав. Ингээд цугласан хүмүүсийн дундуур юу ч харахгүй гарахдаа гэнэтхэн агаарт цэцэгний анхилам үнэр ханхлан Жинни түүнийг шилтгээн рүү буцаан авч явж байгаа болохыг ойлгов. Ойлгомжгүй дуу чихэнд нь сонсогдон, цурхиралт хашгиралт шөнийн харанхуйг эвдэхэд Харри, Жинни хоёр явсаар үүдний танхимын гишгүүр лүү өгслөө. Харри нүднийхээ булангаар хүмүүс түүний зүг харж гайхан шивнэлдэхийг харсан бөгөөд гантиг шатны зүг явахад Грриффиндорын бадмаараг шалан дээр цусан дусал шиг гялтагнаж байлаа.

- Эмнэлэг рүү явъя гэж Жинни хэлэв.
- Би шархдаагүй.
- Энэ бол МакГонагаллын тушаал. Одоо тэнд Рон, Гермиона, Люпин гээд бүгд байгаа ...

Харрийн цээжинд айдас хуралдахад бусад ард үлдсэн хөдөлгөөнгүй биений тухай мартсан байлаа.

- Өөр хэн үхээ вэ, Жинни?
- Бидний хэн ч биш айх хэрэггүй.
- Гэхдээ хар Тамга ... Малфой хэлэхдээ биен дээгүүр алхан гарсан гэсэн ...
- Тэр Биллийн биен дээгүүр гарсан юм. Гэхдээ түүний бүх зүйл хэвийн амьд байгаа.

Гэхдээ түүний хоолойноос Харри гай зовлон тохиолдсоныг ойлголоо.

- Чи итгэлтэй байна уу?
- Мэдээж, итгэлтэй байна ... тэр ... жаахан шархадсан тэгээд л тэр. Түүнийг Сивый дайрсан юм. Хатагтай Помфри хэлэхдээ түүнийг ... урьдынх шигээ харагдахгүй гэсэн гээд Жиннигийн хоолой үл мэдэг чичирлээ.
- Бид Сивый хүн чоно болохоор цаашдаа яахыг нь мэдэхгүй байгаа ч гэхдээ энэ шөнө хувирахгүй байх.
- Харин бусад нь ... Тэнд өөр биеүүд байсан ...

- Невилл шархдаад эмнэлэгт хэвтэж байгаа хатагтай Помфри хэлэхдээ түүнийг бүрэн эдгэрнэ гэсэн. Бас профессор Флитвик оногдсон ч дажгүй хөл дээрээ сулхан босож байгаа. Тэр түүнийг даруйхан гаргаж Когтевранчууд дээр очуулахыг шаардсан. Бас нэг Үхэл залгигч үхсэн. Тэр цайвар үстэй том биетэй шидтэний хаа сайгүй илгээсэн шившлэгт өртсөн юм. Харри хэрвээ чиний Феликс байгаагүй бол шившлэг бидний дэргэдүүр өнгөрөхгүй бүгдийг нь алах байсан гэж бодож байна ...

Тэд хэдийн эмнэлэгийн жигүүрт хүрээд Харри хаалга нээж орон дээр унтаж байгаа Невиллийг харлаа. Рон, Гермиона, Полумна, Тонкс, Люпин нар өрөөний алсын буланд өөр нэг орны дэргэд зосож байв. Хаалга чахрах чимээг сонсоод бүгд эргэж харлаа. Гермиона Харри руу ухасхийн тэвэрлээ. Люпин түгшсэн байртай угтан алхав.

- Чи зүгээр үү, Харри?

- Тиймээ ... Билл яаж байна?

Түүнд хэн ч хариу хэлсэнгүй. Харри Гермионагийн мөрөн дээгүүр Биллийн дэрэн дээр хэвтэж байгаа танигдахын аргагүй болсон царайг харлаа. Хатагтай Помфри түүний шарханд хурц үнэртэй ногоон тос түрхсэн байв. Харри гэнэтхэн Снегт Малфойн Сектусемпра шившлэгийн шархыг саваагаараа амархан эмчилснийг саналаа.

- Биллийг ямар нэг шившлэгээр эмчилж болохгүй юм уу?.

- Шид энд тус болохгүй. Хүн чонын хазалтанд ямар ч эм үйлчилэхгүй болохоор би бүгдийг нь оролдож үзсэн гэж хатагтай Помфри хэллээ.

- Гэхдээ түүнийг арван тавны сартай байхад хазаагүй гэж Рон ахынхаа царай руу харцаараа эмчлэх юм шиг найдангүй харж хэлээд,

- Сивый хувираагүй байсан болохоор Билл болохгүй ... жинхэнэ ...? гэлээ. Ингээд тэр Люпин руу итгэлгүйхэн харлаа.

- Үгүй, би Биллийг жинхэнэ хүн чоно болно гэж бодохгүй байна. Гэхдээ энэ цус ямар нэг хэмжээгээр бохирдоогүй гэсэн үг биш. Энэ бол хараалын шарх. Тэр бүрэн эдгэрэх хэдий ч ... Билл хэсэг хугацааны дараа чонын авиртай болох боломжтой.

- Дамблдор яаж туслахыг мэдэж байгаа байх. Тэр хаана байна? Билл энэ гаж донтонтой түүний тушаалаар тулалдсан. Дамблдор түүнийг ийм байдалтай байхад нь орхиж болохгүй гэж Рон хэлэв.

- Рон ... Дамблдор үхсэн гэж Жинни хэллээ.

- Үгүй! гээд Люпин Жинни, Харри хоёр луу үгүйсгэхийг найдсан мэт харсан ч чимээгүй байсан тул Биллийн орны дэргэдэх сандал дээр лагхийн суугаад нүүрээ алгаараа дарлаа. Харри Люпины хэзээ ч биеэ барих чадвараа алдаж

байсныг хараагүй болохоор эвгүйцэн эргээд Роны харцтай тулгаран

Жиннигийн хэлсэн үг үнэн гэдгийг харцаараа баталлаа.

- Тэр яаж үхсэн юм бэ? Юу болсон юм? гэж Тонкс асуув.

- Снегг түүнийг алсан. Би тэнд байсан болохоор бүгдийг харсан. Бид Хар тамга дээр нь байсан болохоор одон орны цамхаг руу шууд нисэн ирсэн ... Дамблдорын бие их суларсан байсан ч хэн нэгэн шатаар гүйж ирэхэд занга гэдгийг нь ойлгосон байх гэж бодож байна. Тэр намайг хөдөлгөөнгүй болгоод би юу ч хийж чадаагүй, үл үзэгдэх цувтай байсан ... тэгтэл хаалгаар Малфой үсрэн гарч ирээд түүнийг зэвсэггүй болгосон ...

Гермиона алгаараа амаа дарахад Рон дуу алдан ёолоод, Полумнагийн уруул чичирлээ.

- Дараа нь Үхэл залгигчид ирсэн ... тэгээд Снегг ... Снегг түүнийг алсан. Авада Кедаврагаар ... гээд Харри цааш нь ярьж чадсангүй.

Хатагтай Помфри инулимс цийлэгнүүлэв. Жиннигээс өөр хэн ч түүнд анхаарал хандуулсангүй тэр гэнэтхэн,

- Чш-ш! Сонсож байна уу! гэлээ.

Хатагтай Помфри нулимсаа арчаад хуруугаараа амаа дарж нүд нь томорлоо. Хаа нэгтээ харанхуйд галт шувуу дуулж тийм дууг Харри амьдралдаа сонсож байсангүй. Гайхамшигтай сайхан гашуудлын өнгө аястай дуу байв. Харри галт шувууны дотор хөгжим эгшиглэн шидэт аргаар дуу болж хувираад шилтгээний нутаг дэвсгэрт цуурайтахыг мэдэрлээ.

Тэд хэр удаан чимээгүй байж сонссоныг мэдэхгүй ч сонсох тусам яагаад ч юм гашуудлын шарх хөнгөрөх шиг санагдав. Тэгтэл эмнэлэгийн хаалга ахин нээгдэж өрөөнд профессор МакГонагалл орж ирэв. Тэр бусдын адил саяхан болсон тулалдааны ул мөртэй байсан бөгөөд нүүр нь шалбаран жанч нь урагджээ.

- Молли, Артур хоёр ийшээ ирж байгаа гэж хөгжмийн аялгууг эвдэн хэлэхэд бүгд давхийн ховсдолын байдлаас гараад ахин Билл руу харахад нүдээ арчих нь арчиж, толгойгоо сэгсэрлээ.

- Юу болоо вэ, Харри? Хагридын үгээр бол чамайг профессор Дамблдортой хамт байсан гэсэн ... энэ хэзээ болсон юм бол. Тэр бас профессор Снегг үүнд холбоотой гэсэн ...

- Снегг Дамблдорыг алсан гэж Харри хэлэв.

Тэр агшин зуур түүн рүү түгшин харснаа найгахад хатагтай Помфри харваас биеэ эзэмдсэн бололтой урагш ухасхийгээд агаараас сандал илбэдэн гаргаж МакГонагаллын дор тавив.

- Снегг гэж МакГонагалл сандалд унаад сулхан давтлаа.

- Бид бүгд гайхаж байна ... тэр итгэдэг байсан ... үргэлж ... Снегг ... би үүнд итгэж чадахгүй нь ...

- Снегг хэний ч эзэмдэж байгаагүй окклюменцийст гэж Люпин сөөнгөтөн хэлээд,

- Бид үргэлж үүнийг мэддэг байсан гэв.

- Гэхдээ Дамблдор түүнийг манай тал гэж тангарагласан! Би Дамблдор түүний тухай бидний мэдэхгүй зүйлийг мэддэг байх гэж бодсон гэж Тонкс шивнэлээ

...

- Тэр үргэлж Снеггэд итгэх шалтгаан байгаа гэж хатуу баталдаг байсан хэмээн профессор МакГоннагалл бувтнаад нулимсаа дөрвөлжин хээтэй нусны алчуураар арчиж,

- Би Снеггийн өнгөрсөн үеийг ... мэдээж олон хүн гайхаж байсан ... гэвч Дамблдор надад Снеггийг жинхэнээсээ гэмшсэн гэж хэлсэн ... тэр ч байтугуй түүний эсрэг үг сонсохыг хүсээгүй! гэв.

- Снегг түүнийг итгүүлэхийн тулд юу хэлснийг мэдэх юмсан гэж Тонкс хэлэв.

- Би мэднэ гэж Харри хэлэхэд бүгд түүн рүү эргэлээ.

- Снегг Волан-де-Мортод мэдээлэл өгч ээж аав руу минь явуулсан. Харин дараа нь Дамблдорыг яаж итгүүлснийг ойлгохгүй байгаа ч тэдний үхэлд үнэнээсээ харамсаж байна гэж хэлсэн гэсэн.

- Тэгээд Дамблдор түүнд итгэсэн хэрэг үү? гэж Люпин мэгдэн асуугаад,

- Снегг Жеймсийн үхэлд харамсаж байна гэсэнд итгэсэн хэрэг үү? Тиймээ Снегг Жеймсийг үзэн яддаг байсан ... гэв.

- Тэр миний ээжийг цэвэр цусны гэж бодоогүй байх. Учир нь тэр бас маглаас гаралтай ... тэр түүнийг бохир цустан гэж нэрлэж байсан ...

Хэн ч үүнийг яаж мэдсэнийг Харригаас асуусангүй. Бүгд аймшигтай үнэнг сонсоод түүн рүү айдаст автан харлаа.

- Энэ бүхэн миний буруу! гэж гэнэтхэн профессор МакГонагалл хэлээд нусны алчуураа гартаа базлаа.

- Миний буруу! Би шөнө Филиусыг Снегг рүү илгээж туслуулахаар дуудсан!

Хэрвээ би түүнийг Снегг рүү илгээгүй бол Үхэл залгигч нартай нэгдэж чадахгүй байсан. Филиус тэднийг энд байгаа гэж хэлээгүй бол Снегг энэ тухай мэдэхгүй байсан.

- Чи юунд ч буруугүй, Минерва гэж Люпин хатуу хэлээд,

- Бид бүгд тусламж дуудахыг хүсч байсан болохоор Снегг ирвэл баярлах байсан ... гэв.

- Тэгэхээр тэр тэмцэл явагдаж байхад Үхэл залгигч нартай нийлсэн хэрэг үү? гэж Харри асуугаад Снеггийг үзэн ядах илүү их шалтгаан хэрэгтэй байсан тул нарийвчлан тодруулахыг хүслээ.



- Би юу болсныг сайн мэдэхгүй байна гэж профессор МакГонагалл сэтгэл зовон хэлээд,

- Бүх зүйл тодорхойгүй байсан ... Дамблдор хэдэн цаг сургуулийг орхих тулд биднийг хонгилд эргүүл хийх хэрэгтэй гэсэн ... Бидэнтэй Римус, Билл, Нимфадор нар нэгдэх ёстой байсан ... тэгээд бид жижүүрлэсэн. Бүх зүйл нам гүм байх шиг санагдсан. Сургууль руу ордог нууц хонгилоуд хаалттай байсан. Шилтгээний бүх үүд хүчирхэг шившлэгээр хамгаалттай байсан. Би Үхэл залгигч нар яаж орж ирснийг мэдэхгүй юм ... гэв.

- Би мэдэж байна гэж Харри ахин оролцоод шидийн замаар холбогддог хоёр алга болдог шүүгээний тухай ярилаа.

- Тэд ингэж Шаардлагатай өрөөгөөр дамжин орж ирсэн юм.

Ингээд Рон, Гермиона хоёр руу хяламхийн харахад хоёул балмагдсан төрхтэй харагдав.

- Би алдсан, Харри гэж Рон гунигтай хэлэв.

- Бид чиний хэлснээр хийсэн. Тэнүүлчний газрын зургийг шалгасан ч Малфой түүн дээр харагдаагүй болохоор Шаардлагатай өрөөнд байгаа байх гэж бодсон. Жинни, Невилл бид гурав харуулдахаар очсон юм ... гэхдээ Малфой бидний дэргэдүүр өнгөрсөн ...

- Тэр биднийг харуулдсанаас хойш өрөөнөөс бараг цагийн дараа гарч ирсэн.

Гартаа аймшигтай хатсан гар бариад ... гэж Жинни хэлэв.

- Алдрын гар. Зөвхөн барьж байгаа хүндээ гэрэл нь харагддагыг санаж байна уу? гэж Рон хэллээ.

- Ер нь бол тэр эхлээд зам чөлөөтэй эсэхийг шалгаад дараа нь Үхэл залгигч нарыг гаргасан байх яагаад гэвэл биднийг харангуутаа агаарт юм хаяхад эргэн тойрон нэвтэршгүй харанхуй болсон ...

- Перугийн дарь гэж Рон гашуунаар хэлээд,

- Фред, Жорж хоёрынх ... Би тэдэнтэй хэнд юу худалдаж байгаа талаар нь ярих болно гэв.

- Бид юу эсийг оролдож үзсэн гээч. Люмос, Инсендио гэвч юу ч энэ харанхуйг нэвтлээгүй болохоор зөвхөн хонгилоос гарах ганц арга үлдсэн. Энэ зуураа дэргэдүүр хэн нэгэн гүйж өнгөрөхийг сонссон юм. Харваас Малфой гараараа замаа гэрэлтүүлэн араасаа бусдыг дагуулсан байх. Бид бусдыгаа цохихоос айгаад шишлэг ашиглаж зүрхлээгүй тэгээд гэрэлтэй хонгилд хүрэхэд тэд хэдийн үгүй болсон байсан.

- Аз болоход Рон, Жинни, Невилл нар бараг даруй бидэн дээр хүрч ирээд юу болсон тухай ярьсан гэж Люпин сөөнгөтөн хэллээ. Хэдэн хормын дараа бид Үхэл залгигч нарыг олох үед одон орны цамхаг руу чиглэн явж байсан. Малфой харваас хүчирхэгжүүлсэн хамгаалалт хүлээгээгүй болохоор илүү их дарь аваагүй бололтой.

Тулалдаан эхлэхэд тэд зугтаж бид араас нь элдсэн. Тэдний нэг болох Гиббон цамхагын шат руу гүйн гараад ...

- Тамга тавихын тулд уу? гэж Харри асуулаа.
  - Тэгсэн байх. Тэд энэ тухайгаа Шаардлагатай өрөөнөөс гарч ирэхийн өмнө тохиролцсон биз. Гэхдээ би Гиббон ганцаараа Дамблдорын хүлээх байсан гэж бодохгүй байна. Яагаад гэвэл тэр удахгүй бууж ирээд тулаанд нэгдэн орохдоо намайг алах гэсэн үхлийн шившлэгэнд оногдсон.
  - Тэгэхээр хэрвээ Рон Шаардлагатай өрөөг Жинни, Невилл хоёрын хамт харж байсан юм бол гээд Харри Гермионад хандан,
  - Чи хаана байсан юм? гэв.
  - Снеггийн өрөөний гадаа жижүүрлэж байсан гэж Гермиона нүдэндээ нулимс мэлтэлзүүлэн хэлээд,
  - Полумнатай хамт. Тэнд мөнх удсан ч юу ч болоогүй болохоор дээр ямар зүйл болсныг бид мэдээгүй ... Рон Тэнүүлчний газрын зургийг өөртэйгээ авч явсан байсан ... харин ойролцоогоор шөнө дундын үед газар дорхи хонгил руу профессор Флитвик гүйж ирсэн. Тэр Үхэл залгигч нарын тухай үг хашгираад Полумна бид хоёрыг ажиглаагүй шууд Снеггийн өрөөнд орсон. Гэхдээ бид Снегг түүнд туслахаар явах ёстой гэж хэлэхийг сонссон. Дараа нь чанга цохилт сонсогдоод Снегг өрөөнөөс үсрэн гарч биднийг хармагц ... тэгээд ...
  - Яасан? гэж Харри шаардангуй асуулаа.
  - Би тэнэг, Харри! гэж Гермиона нарийхан хоолойгоор хэлээд,
  - Тэр профессор Флитвикийг ухаан алдсан болохор биднийг өрөөнд орж санаа тавь гэсэн ... тэр өөрөө Үхэл залгигч нартай тэмцэхээр явлаа гэсэн ... гээд ичсэндээ нүүрээ алгаараа дарж хурууныхаа завсраар яриагаа үргэлжлүүлэн,
  - Бид өрөөнд профессор Флитвикт туслахаар орсон ч тэр шалан дээр ухаангүй хэвтэж байсан ... өө, одоо л бүх зүйл ойлгомжтой болж байна. Снегг түүнийг хөшөөгөөд харин бид үүнийг ойлгосонгүй, Харри ойлгосонгүй Снеггэд цааш явах боломж өгсөн! гэв.
  - Энэ та нарын буруу биш гэж Люпин хатуу хэлээд,
  - Хэрвээ та нар Снеггийн замд саад болсон бол хоёуланг чинь гарцаагүй алах байсан гэв.
  - Тэгэхээр тэр дээшээ гүйж гараад та нарын тэмцэж байгаа газар хүрсэн байж гээд Харри бодолдоо Снегг шидэт саваагаа бариад гантиг шатаар хар жанчаа намируулан гүйж тулалдааны газар хүрснийг харлаа ...
  - Бидэнд бас гарз учирсан гэж Тонкс нам дуугаар хэлээд,
  - Гиббон алагдсан ч үлдсэн Үхэл залгигчид тулалдаж үхэхэд бэлэн байсан.
- Невилл шархдаж, Билл Сивыйд хазуулаад ... бүх зүйл харанхуй болж ... эргэн тойрон шившлэг нисээд л ... Малфой хаа нэг тийш алга болсон бидний дэргэдүүр өнгөрөөд

шатаар өгссөн байх байх ... дараа нь бусад Үхэл залгигч нар түүний араас гүйхэд нэг нь ардаа байгаа шатыг ямар нэг шидээр хаасан ... Невилл түүн рүү ухасхийгээд агаарт үсэрч ... гэв.

- Хэн ч үүнийг нэвтэрч чадаагүй. Том биетэй Үхэл залгигч хаа сайгүй шившлэгэн хана босгосныг бид золтой мөргөөгүй ... гэж Рон хэллээ.

- Тэгэхэд Снегг гарч ирсэн ч гэж Тонкс яриаг нь таслаад,

- Тэр яагаа ч үгүй ... гэв.

- Би нүднийхээ булангаар түүний гүйж ирэхийг харсан ч том биетэй Үхэл залгигч ахин над руу шившлэг илгээж Снеггийг хараанаас алдсан гэж Жинни дуугарлаа.

- Би түүнийг хараал идсэн саадыг шууд нэвтэрхийг харсан. Би түүний араас дагахыг оролдсон ч Невилл шиг үсэрсэн ... гэж Люпин хэлэв.

- Тэр харваас бидэнд мэдэхгүй шившлэг мэддэг байж. Эцсийн эцэст тэр хар уралагаас хамгаалах хичээлийн багш шүү дээ ... Би түүнийг цамхаг руу Үхэл залгигч нарыг гүйцэхээр яаран орсон гэж бодож байна хэмээн МакГонагалл шивнэлээ.

- Тэр яаран орсон! гэж Харри уурсан хэлээд,

- Гэхдээ тэднийг зогсоохоор биш харин туслахаар ... бас энэ саадыг зөвхөн Хар тамгатай хүмүүс нэвтэрч чадах байсан гэж мөрийцсөн ч бэлэн байна ... Тэгээд түүнийг эргэж ирэхэд юу болсон бэ? гэв.

- Том биетэй Үхэл залгигч шившлэг хэрэглэн саадаар хаасан шатны адрын талыг нураасан. Бид бүгд түүн рүү ухасхийсэн ч, ямар ч байсан тэр үед хөл дээрээ зогсож байсан нь ... тоосон үүлэн дундаас Снегг хүүтэй гарч ирэхэд ... мэдээж бидний хэн ч дайраагүй ... гэж Люпин хэллээ.

- Бид зүгээр л тэднийг дэргэдүүрээ өнгөрүүлсэн гэж Тонкс хөндий дуугараад,

- Түүнтэй Үхэл залгигч нарын араас хөөе гэж бодсон ч ... дараагийн агшинд бусад Үхэл залгигч нар Сивыйгийн хамт эргэж ирээд ахиад л тулалдаж эхэлсэн. Минийхээр бол Снегг ямар нэг учир нь олдохгүй зүйл хашгирсан гэв.

- Тэр бүх зүйл дууссан гэж хашгирсан. Тэр тэгж хийхийг хүссэн гэж Харри хэлэв.

Бүгд чимээгүй болов. Фоуксын гашуудлын дуу шилтгээний харанхуй газар нутаг дээгүүр цуурайтсан хэвээр байв. Хөгжим агаарыг цуурайтуулахад Харрийн толгойд гэнэтхэн нэг бодол орлоо ... Тэд Дамблдорын биеийг цамхагын дороос авсан болов уу? Түүний дараа юу болсон бол? Хаана байлгаж байгаа бол? Харри халаасандаа нударга зангидтал хуурамч крестражын хүйтэн төмөр мэдрэгдлээ.

Эмнэлгийн хаалга тасхийн нээгдэхэд бүгд айсандаа цочин харвал өрөөнд ноён ба хатагтай Уизли яаран орж ирэхэд араас нь үзэсгэлэнтэй царайдаа айдас тодруулсан Флер дагалджээ.

- Молли, Артур гэж профессор МакГонагалл дуу алдаад тэднийг утан,

- Надад их харамсалтай байна гэлээ.
  - Билл. Өө, Билл минь! гэж хатагтай Уизли шивнээд хүүгийнхээ гэмтсэн царайг харж МакГонагаллын дэргэдүүр ор луу нь ухасхийлээ.
- Люпин, Тонкс хоёр яаран босч холдоод суудлаа ноён ба хатагтай Уизлид тавьж өгөв. Хатагтай Уизли хүү рүүгээ тонгойгоод цус болсон духанд нь уруулаа хүргэлээ.
- Та нар түүнийг Сивый дайрсан гэж хэлсэн үү? хэмээн ноён Уизли профессор МакГонагаллаас түгшин асуугаад,
  - Гэхдээ тэр хувирахгүй биз дээ? Тийм зүйл болохгүй биз дээ? Биллд юу тохиолдох бол? гэлээ.
  - Бид үүнийг мэдэхгүй байна гээд профессор МакГонагалл Люпин руу тусламж эрэн харлаа.
  - Ямар нэгэн халдвар орсон нь тодорхой, Артур. Ховорхон тохиолдолд байж болох юм, маш ховорхон ... Бид түүнийг сэрээд ямархуу авиртай болохыг мэдэхгүй байна ...
- Хатагтай Уизли хатагтай Помфригоос хурц үнэртэй тос авчраад Биллийн шарханд түрхэж эхлэв.
- Дамблдор ... Энэ үнэн үү, Минерва ... Тэр үнэхээр ...? гэж ноён Уизли хэлэв. Профессор МакГонагалл толгой дохьсон ч энэ агшинд Харри дэргэдээ ямар хөдөлгөөн мэдрээд Жинни руу харав. Тэр Билл рүү хөшин ширтэж буй Флер рүү нүдээ нарийсган харлаа.
  - Дамблдор үхсэн гэж ноён Уизли шивнэсэн ч хатагтай Уизли одоо зөвхөн том хүүгийнхээ тухай бодож байлаа. Тэр Биллийн зэрэмдэглэгдсэн царай дээр нулимс дуслуулан уйлав.
  - Мэдээж тэр яаж харагдах нь ямар ялгаа байх вэ ... Энэ тийм ч их чухал биш ... тэр сайхан хүү байсан ... үргэлж маш царайлаг ... бас гэрлэх гэж байлаа!
  - Байсан гэдэг чинь юу гэж байгаа юм? гэж Флер гэнэтхэн чангаар хэлэв. Тэр гэрлэх гэж байсан гэдэг чинь юу гэж байгаа юм?
- Хатагтай Уизли түүн рүү нулимс дүүрэн нүдээр айн эргэж харлаа.
- Би ... зөвхөн ...
  - Билл надтай гэрлэхийг хүсэхгүй гэж бодож байна уу? Түүнийг хазсаны дараа намайг хайрлахаа болино гэж бодож байна уу? хэмээн Флер уурсан хэлэв.
  - Үгүй, би тэгж хэлээгүй ...
  - З'йтэй яагаад гэвэл тэр үүнийг улам их хүсч байгаа! гэж Флер мэдэгдээд цэхлэн зогсож цайвар үсээ нуруу руугаа хаялаад,
  - Биллийг хайрл'хад надад ямар нэг хүн ч'но саад болж чадахгүй! гэв.
  - Тиймээ, тийм тэгэлгүй яахав гэж хатагтай Уизли яаран батлаад,

- Гэхдээ би зүгээр л тэгж бодсон юм ... тэр одоо магадгүй ... болсон болохоор ... гэв.

- Та намайг түүнтэй гэрлэхийг хүсэхгүй гэж бодоо юу? хэмээн Флер хамраа саргалзуулан ууртай асуулаа.

- На'майг зөвхөн түүний гадаад үзэмжийг с'нирхдог гэж бодоо юу? Миний гоо 'зэсгэлэн бидэнд хоёуланд маань хангалттай гэж бодож байна! Харин энэ сорви зөвхөн миний нөхөр хэр зоригтой гэдгийг үзүүлэх болно! Алив би өөрөө! гэж тэр дуу алдаад хатагтай Уизлиг түлхэн гараас нь тосыг булааж авлаа.

Хатагтай Уизли хойш нөхөр рүүгээ ухраад сэтгэлээр унасан байртай Флер хэрхэн Биллийн шарханд тос түрхэхийг харлаа. Бүгд чимээгүй болоход Харри хөдөлж зүрхэлсэнгүй. Үлдсэн бүх хүмүүс ямар нэгэн тэсрэлт хүлээж байгаа бололтой.

- Манай нагац эгч Мюриэлд маш ховор үзэсгэлэнтэй титэм байгаа ... албингуудийн хийцийн эд ... би түүнийг хуримын үеэр титмийг өгүүлэхээр ятгаж болно гэдэгт эргэлзэхгүй байна. Тэр Биллд их хайртай болохоор титэм чиний үстэй маш сайхан зохицоно гэж удаан хугацааны дараа хатагтай Уизли хэлэв.

- Баярлалаа. Түүнийг с'йхан гэдэгт 'тгэлтэй байна.

Тэгээд Харри юу болсныг ажиглаж амжаагүй байтал хоёр эмэгтэй хоорондоо уйлалдан тэврэлдлээ. Харри бүх ертөнц ухаан солиороогүй байгаа даа гэж үл итгэн бодоод эргэн тойрноо харав. Рон тэвдсэн байртай харагдсан бөгөөд, Жинни, Гермiona хоёр гайхсандаа харц солилцов.

- Харж байна уу гэх хүчилсэн хоолой гарлаа. Тонкс Люпин руу уурсан харав.

- Тэр түүнийг хазуулсан ч гэсэн гэрлэхийг хүсч байна! Түүнд энэ хамаагүй байна!

- Энэ чинь өөр хэрэг. Билл бүрэн хүн чоно болоогүй. Энэ чинь хоёр ондоо зүйл ... гэж Люпин уруулаа үл ялиг хөдөлгөн хэлэв.

- Надад ч гэсэн хамаагүй! гэж Тонкс дуу алдаад Люпины жанчны захнаас шүүрэн сэгсэрч,

- Би чамд мянган удаа хэлсэн биз дээ ... гэв.

Тэгтэл Тонксын шинэ Патронус болон, саарал үсний шалтгаан түүнчлэн Сивый хэн нэгэн рүү дайрсан гэх цуу яриаг сонсоод Дамблдорыг хайж байсан бүхэн гэнэтхэн Харрид тодорхой болов. Харваас Тонкс Сириуст хайртай байгаагүй бололтой ...

- Би ч гэсэн чамд мянган удаа хэлсэн биз дээ гээд Люпин Тонкс руу харахгүйг хичээж,

- Би чамд хэтэрхий хөгшин, хэтэрхий ядуу ... хэтэрхий аюултай ... гэв.

- Чамайг өөрийгөө инээдтэй авч явж байна гэж хичнээн удаа хэлэх юм бэ, Римус гэж хатагтай Уизли Флерийн мөрөн дээгүүр мэдэгдээд нурууг нь үргэлжлүүлэн илэв.

- Ямар ч инээдтэй зүйл алга. Тонкс хэн нэг залуу эрүүл хүнтэй суух гавьяатай гээд Люпин бууж өгсөнгүй.

- Гэхдээ түүнд чи хэрэгтэй гэж хатагтай Уизли сулхан инээмсэглэн хэлээд,

- Тэгээд ч эцсийн эцэст Римус залуу эрүүл хүн заавал үргэлж тиймээрээ үлдэх албагүй гэлээ.

Ингээд тэрбээр гашуудалтай Биллийн хэвтэж байгаа ор луу зангав.

- Одоо ... одоо энэ тухай ярих цаг биш гэж Люпин хэлээд өрөөн дундуур харсан ч бүгдийн харцнаас зугтах газар байсангүй. Дамблдор үхсэн ...

- Дамблдор энэ ертөнцөд бага ч гэсэн хайр байгааг мэдсэн бол жаргалтай байх байсан гэж профессор МакГонагалл огцом хэлэх агшинд эмнэлэгийн хаалга ахин нээгдэж Хагрид орж илрээ.

Түүний царайны үс сахлаар халхлагдаагүй хэсэг норж хавджээ. Хагрид чичирэн уйлж гартаа том бохир алчуур барьсан байлаа.

- Би ... би бүгдийг хийсэн, профессор гэж тэр хоолой нь зангиран хэлээд,

- Түүнийг авчирсан. Профессор Стебль хүүхдүүдийг ор луу нь буцаасан.

Профессор Флитвик хэвтэж байгаа ч удахгүй дээрдэнэ гэж хэлсэн. Харин профессор Слизнорт ид шидийн яаманд мэдэгдсэн гэв.

- Баярлалаа, Хагрид гээд профессор МакГонагалл босож тэдэн рүү эргэж хараад,

- Ид шидийн яамныхан энд ирэхэд би сайдад тайлбарлах хэрэг гарна. Хагрид минь тэнхимийн эрхлэгч нарыг дуудаач ... Слизнортод Слизеринийг хариуцах болсон гэж хэлээрэй. Би тэдэнтэй даруйхан өрөөндөө уулзахыг хүсч байна. Хэрвээ чамайг тэдэнтэй нэгдвэл бас баяртай байх болно гэв.

Хагрид толгой дохиод эргэж өрөөнөөс гарлаа. Профессор МакГонагалл Харри руу харав.

- Эрхлэгч нартай уулзахаас өмнө би таньтай түргэхэн ярих хэрэгтэй байна, Харри. Хэрвээ та надтай явахыг зөвшөөрвөл ...

- Харри босож Рон, Гермиона, Жинни нарт хандан түргэхэн гэж бувтнаад профессор МакГонагаллыг даган өрөөнөөс гарлаа. Хонгил хоосон бөгөөд зөвхөн алсад галт шувууны гашуудах дуу сонсогдоно. Харри хэдэн хормын дараа тэд профессор МакГонагаллын өрөө рүү биш харин Дамблдорынх руу явж байгаа болохыг ойлгоод түүнийг сургуулийн захирлын орлогч ... харваас одоо захирал болсон болохоор ... өрөөг хамгаалж байгаа луу хамаарагдах болсныг төсөөлөв ...

Тэд чимээгүйхэн эргүүлэн шатаар өгсөж дугуй өрөөнд орлоо. Харри түүнийг юу хүлээж байгааг мэдсэнгүй. Магадгүй өрөөнд хар бүтээлэг унжуулсан юмуу эсвэл түүн дээр Дамблдорын бие хэвтэж байж болох юм. Гэвч бүгд Дамблдорын хамт эндээс явсан шиг үеийнх байсан бөгөөд урт хөлтэй ширээ дээр мөнгөн эдлэлүүд жингэнэж, Гриффиндорын илд шилэн нүүртэй шүүгээнд сарны гэрэлд гялалзан

харин хуваарилах бүрх малгай бичгийн ширээний дээрх тавиур дээр байлаа. Фоуксын хонуур хоосон байсан бөгөөд галт шувуу гашуудлын дуугаа дуулан үргэлжлүүлэн ниссээр байлаа. Өмнөх захирлын хөргүүд дээр нэмэгдэн шинэ хөрөг бий болжээ. Дамблдор алтан хүрээтэй хөргөнд ширээнийхээ ард хөдөлгөөнгүй нойрсон суугаад махигар хамар дээр нь нүдний шил тавиаастай юунд ч түгшсэн байргүй тайван харагдаж байлаа.

Профессор МакГонагалл түүн рүү хальт харснаа нударга зангидах гэж байгаа мэт хачирхалтай хөдөлгөөн хийн ширээг тойроод Харри руу харан хөмсөг зангидав.

- Харри би профессор Дамблдор та хоёр өнөө үдэш суруулийг орхиод юу хийснийг мэдэх хэрэгтэй байна.

- Үүнийг таньд хэлж чадахгүй нь, профессор гэж Харри хэлэв. Тэр асуулт хүлээж байсан болохоор хариулт бэлэн байлаа. Энд яг энэ өрөөнд Дамблдор түүнд хичээлийн тухай Рон, Гермиона хоёроос ондоо хэнд ч хэлж болохгүй гэж хэлсэн билээ.

- Харри энэ маш чухал гэж профессор МакГонагалл хэлэв.

- Яг тийм энэ маш чухал. Гэхдээ тэр намайг хэн нэг хүнд энэ тухай хэлэхийг хүсээгүй.

Профессор МакГонагалл түүн рүү таагүй харлаа.

- Поттер (Харри энэ шинэ дуудлагыг мэдэрлээ) профессор Дамблдор үхсэн болохоор та үйл явдал өөрчлөгдсөн гэдгийг ойлгох ёстой ...

- Би тэгж бодохгүй байна гээд Харри мөрөө хавчив.

- Профессор Дамблдор надад хэзээ ч түүний үхэл тушаалыг нь биелүүлэхгүй байх шалтгаан биш гэж хэлээгүй.

- Гэхдээ ...

- Ид шидийн яамны хүмүүс ирэхээс өмнө та нэг зүйл мэдэх ёстой. Хатагтай Розмерта Имперуус шившлэгийн нөлөөн дор байгаа бөгөөд тэр л Малфой болон Үхэл залгигчдад туслан, түүний тусламжтай зүүлт, хордуулсан ундааг оруулж ирсэн ...

- Розмерта гэнээ? хэмээн профессор МакГонагалл үл итгэн асуулаа. Гэвч түүнийг ямар нэг үг хэлж амжихаас урьтаж хаалган цохин өрөөнд профессор Стебль, Флитвик, Слизнорт болон араас нь Хагрид орж ирлээ. Ойн сахиул урьдын адил гашуудан уйлж нүсэр том бие нь чичирч байв.

- Снегг! гэж Слизнорт уулга алдаад,

- Снегг! Би түүнийг сургасан! Би түүнийг мэддэг гэж бодсон юмсан! гэв.

Түүнд хэн нэгэн хариулж амжихаас урьтаж шарангуй нүүртэй шидтэн хоосон хөшигтэй жаазанд гарч ирээд огцом хоолойгоор,

- Минерва сайд энд хормын дараа ирнэ. Тэр саяхан ид шидийн яамнаас шилжсэн гэв.

- Баярлалаа, Эдвард гээд профессор МакГонагалл яаран багш нар луу эргэж,

- Түүнийг энд ирэхээс өмнө би та нартай Хогвартст тохилдсон явдлын тухай ярилцахыг хүсч байна гэж түргэхэн хэлээд,

- Би хувьдаа сургууль дараа жил ахин нээгдэнэ гэж бодохгүй байна. Мэргэжил нэгт нөхөр болох захирлын үхэл Хогвартсын түүхэнд том хар толбо боллоо. Айшигтай юм гэв.

- Би Дамблдор сургууль ажиллахыг хүсэх байсан гэдэгт итгэлтэй байна.

Минийхээр бол хэрвээ нэг л сурагч ийшээ ирэхийг хүсвэл сургууль онгорхой үлдэх ёстой гэж профессор Стебль хэлэв.

- Гэхдээ ийм явдал болсны дараа нэг ч сурагч үлдэх үү? гээд Слизнорт торгон нусны алчуураар хөлстэй духаа арчиж,

- Эцэг эхчүүд гэр лүүгээ хүүхдээ авч явахыг хүсвэл би лав тэднийг буруутгахгүй. Би Хогвартст том аюул заналхийлж байгаа гэж бодохгүй байгаа ч эцэг эхчүүдээс ийм бодол хүлээх хэрэггүй. Тэд хүүхдүүдээ дэргэдээ байлгахыг хүсэх нь мэдээж гэв.

- Зөвшөөрч байна гээд профессор МакГонагалл,

- Ямар ч тохиолдолд Дамблдор хэзээ ч ийм явдал хүлээгээгүй болохоор Хогвартс хаагдахад хүрч болно. Нууц өрөө нээгдэхэд тэр сургуулийг хаах тухай бодож байсан. Гэвч профессор Дамблдорын аллага надад Слизериний мангасаас илүү аймшигтай санагдаж байгааг нуух юун гэв.

- Бид энэ тухай ивээн тэтгэгч нартай ярилцах хэрэгтэй гэж профессор Флитвик хэлэхэд духан дээр нь Снеггийн өрөөнд ухаан алдаж унахдаа мөргөсөн бололтой том шарх үүссэн харагдав. Бид журмыг баримтлах ёстой. Яаран шийдвэр гаргаж болохгүй.

- Хагрид чи юу ч хэлсэнгүй гэж профессор МакГонагалл ойн сахиулд хандаад,

- Чи Хогвартс үргэлжүүлэн ажиллах талаар юу бодож байна? гэв.

Хагрид энэ бүх хугацаанд чимээгүй алчуур луугаа уйлж байснаа улайж хавдсан нүдээ өргөн,

- Би мэдэхгүй байна, профессор ... эрхлэгчид л болон захирал шийдэг ... гэв.

- Профессор Дамблдор үргэлж чиний бодлыг үнэлдэг байсан болохоор би мөн адил байх болно гэж профессор МакГонагалл эелдэгээр хэлэв.

- Би үлдэнэ гээд Хагрид нүднээс том нулимс бөмбөрөн сахал руу нь ороод,

- Тэнд миний гэр гучин жилийн туршид байсан ... Хэрвээ хэн нэг хүүхэд хүсч байвал би тэднийг сургах болно ... Гэхдээ ... мэдэхгүй юм ... Хогвартс Дамблдорын үгүйд яахыг ... гэв.



Тэр шүлсээ залгиад ахин нусны алчуурын цаана нүүрээ нуулаа. Нам гүм болов.

- За сайн байна гээд профессор МакГонагалл цонхоор сайдын ирж байгаа эсэхийг харж,

- Тийм тохиолдод би Филиусыг зөвшөөрч байна бид ивээн тэтгэгч нартай ярьж тэд эцсийн шийдвэр гаргаг ... Одоо сурагчдыг гэр рүү нь буцаах хэрэгтэй ...

харваас үүнийг яарсан нь дээр байх. Хэрвээ шаардагдахад хүрвэл «Хогвартс экспресс»-ийг маргаашийн дотор ч бэлэн болгосон болох юм ... гэлээ.

- Дамблдорыг хаана оршуулах юм? гэж Харри эцэст нь ам нээн асуулаа.

- Юу гэвэл гээд профессор МакГонагаллын хоолой ажил хэрэгч өнгөө алдаж,

- Би ... Би Дамблдор энд Хогвартст үлдэхийг хүсч байсныг мэдэж байна гэв.

- Тэгвэл тийм байх ёстой биз дээ? гэж Харри ширүүн хэлэв.

- Хэрвээ яамныхан үүнийг нийцсэн гэж үзвэл. Ямар ч захирлыг Хогвартст оршуулж байгаагүй юм ...

- Гэхдээ тэдний хэн ч сургуулийн төлөө ийм их зүйл хийгээгүй хэмээн Хагрид гүвтнэв.

- Хогвартс Дамблдорын тайвширлыг олох сүүлчийн газар байх ёстой гэж профессор Флитвик хэллээ.

- Бүрэн зөвшөөрч байна гэж профессор Стебль дэмжив.

- Ийм тохиолдод сурагчдыг оршуулга дуустал гэр лүү нь буцааж болохгүй. Тэд хүсэх ...

- Салах ёс гүйцэтгэхийг хэмээн Харрийн хоолойд тээглэсэн үгийг профессор Стебль дуусгав.

- Яг үнэн гэж профессор Флитвик дэмжээд,

- Яг үнэн! Манай сурагчид түүнд хүндэтгэл үзүүлэх ёстой, энэ их ухаалаг хэрэг. Дараа нь бид тэднийг гэрт нь хүргэх ажлыг зохион байгуулна гэв.

- Дэмжиж байна гэж профессор Стебль хэлэв.

- Би ч гэсэн тийм гэж бодож байна гэж Слизнорт хэлэхэд Хагрид зөвшөөрсний тэмдэг болгон нулимс асгаруулав.

- Тэр энд ирчихэж гэж профессор МакГонагалл гэнэтхэн цонхоор харан хэлээд,

- Сайд ... бүлэг төлөөлөгчид дагуулж гэв.

- Би явж болох уу, профессор? гэж Харри даруйхан асуулаа.

Тэр өнөөдөр Руфус Скримжертэй уулзаж байцаалтад нь хариулах ямар ч хүсэл байсангүй.

- Болно. Зөвхөн түргэн шүү.

Тэр хаалга руу очоод нээж Харриг гаргав. Тэр яаран эргүүлгэн шат уруудаад хоосон хонгилд гүйн гарахад үл үзэгдэх цув нь одон орны цамхаг дээр үлдсэн ч ямар ч хэрэг байсангүй бөгөөд хонгил хоосон байж тэр ч байтугай Филч, хатагтай Норрис, Пивз хүртэл байсангүй. Тэр нэг ч амьд амьтантай тааралдалгүй явсаар Гриффиндорын амралтын өрөөнд оров.

- Энэ үнэн үү? Үнэхээр үнэн үү? Дамблдор үхсэн юм уу? гэж тарган хатагтай түүнийг ойртоход шивнэлээ.

- Тиймээ гэж Харри хэлэв.

Тэр ёлон дуу алдсанаа нууц үг хүлээлгүй хажуу тийш болон Харриг оруулав.

Түүний бодсоноор зочны өрөө дүүрэн хүнтэй байлаа. Түүнийг хөргөн нүхээр ормогц бүгд чимээгүй болов. Харри Дин, Симус хоёр сурагчдаар тойруулан суусныг хараад унтлагын өрөө хоосон болохыг мэдэв. Тэгээд нэг ч үг хэлэлгүй амралтын өрөөн дундуур явж хөвгүүдийн унтлагын өрөө рүү оров.

Рон орон дээрээ суугаад түүнийг хүлээж байв. Харри өөрийнхдөө суугаад бие биеэ рүүгээ харлаа.

- Тэд сургуулийг хаах тухай ярилцаж байна гэж Харри хэллээ.

- Люпин ч гэсэн тэгнэ гэж байсан. Тэд ахин чимээгүй боллоо.

- Юу болсон бэ? гэж Рон унтлагын өрөөний тавилга сонсохоос айсан мэт маш аяархан асуугаад,

- Чи түүнийг олсон уу? Тэр ... крестражыг? гэв.

Харри толгойгоо сэгсэрлээ. Харанхуй нууранд болсон явдал эртний хар дарсан зүүд шиг санагдана. Үнэхээр бүгд хэдхэн цагийн өмнө болсон гэж үү?

- Олоогүй гэж үү? Тэр тэнд байсангүй юу? хэмээн Рон даруй асуулаа.

- Үгүй. Хэн нэгэн хэдийн аваад хуурамчыг үлдээсэн байсан.

- Хэдийн авсан гэдэг чинь?

Харри чимээгүйхэн халааснаасаа зүүлтийг гаргаж ирээд нээн Ронд сунгав. Тэр бүтэн түүх хүлээж байсан байж болох ч ... өнөөдөр энэ чухал биш ... эцсийн эцэст Дамблдорын амьдралын төгсгөл болсон болохоор тэдний утгагүй адал явдал ерөөсөө ч чухал биш ...

- Р.А.Б гэж хэн бэ? хэмээн Рон шивнэлээ.

- Мэдэхгүй гээд Харри хувцастайгаа орон дээр хэвтээд адар өөд ширтэв. Түүнд Р.А.Б-ыг сонирхох ямар ч хүсэл байсангүй бөгөөд хэзээ нэг цагт сонирхоно гэдэгтээ эргэлзэж байлаа. Тэгээд орондоо хэвтсээр шилтгээнд гэнэтхэн нам гүм болсныг ойлголоо. Фоуксын дуу намджээ.

Ингээд Харри яагаад гэдгийг мэдэхгүй ч галт шувуу байхгүй Хогвартсыг үүрд орхисон гэдгийг яг л Дамблдор сургуулиа болон энэ ертөнцийг ... Харриг орхисон шиг орхисон болохыг мэдэрлээ.

## БҮЛЭГ 30: ЦАГААН БУНХАН

Бүх хичээл цуцлагдаж шалгалтууд хойшиллоо. Дараагийн хоёр хоногт зарим сурагчдын эцэг эх яаран хүүхдээ авахаар Хогвартст ирлээ. Ихэр хоёр Патил сургуулийг Дамблдорын үхлийн дараагийн өдөр орхиж, өглөөний цайны үеэр Захария Смитыг шилтгээнээс ихэмсэг төрхтэй эцэг нь авч явлаа. Өөр өнцгөөс бол Симус Финниган эхтэйгээ гэр лүүгээ буцахаас татгалзаж тэд удтал үүдний танхимд маргалдсаны эцэст оршуулга дуустал сургуульд үлдэх шийдвэр гаргав. Ээжид нь Хогсмидэд өрөө олоход хэцүү байсан бөгөөд Симус Харри, Рон хоёрт тосгон Дамблдортой салах ёс гүйцэтгэхээр ирсэн шидтэнгүүдээр дүүрсэн гэж хэлжээ.

Зарим бага сурагчид урьд нь хэзээ ч харж байгаагүй аварга том цагаан дэлтэй арван хоёр далавчтай морьд хөллөсөн цагаан цэнхэр өнгийн байшингийн хэмжээтэй сүйх тэрэг оршуулгын өмнөх орой Хориотой ойн цоорхойд газардахад багагүй догдлов. Харри цонхоор аварга том биетэй хар үстэй үзэсгэлэнтэй эмэгтэй сүйх тэрэгний гишгүүр дээрээс буугаад Хагридын тэврэхийг хүлээхийг харлаа. Энэ үед шилтгээнд ид шидийн яамны хамгийн гол төлөөлөгчид ирэн байрлав. Харри тэдэнтэй уулзахаас овжин бултаж байсан ч эрт орой хэзээ нэгэн цагт Дамблдортой сүүлд аяласан тухайгаа хэлэх болно гэдэгт эргэлзсэнгүй.

Харри, Рон, Гермiona, Жинни нар эдгээр өдрүүдийг хамтдаа өнгөрүүлэв. Цаг агаар гайхамшигтай байж Харри хэрвээ Дамблдор үхээгүй бол тэд хичээлийн жилийн эцэс хүртэл хамт суралцаж Жинни шалгалтаа өгч дуусган гэрийн даалгаварын дарамтаас ангижрах байсан тухай төсөөлөв ... Харин одоо хамгийн гол нь тайтгарлын эх сурвалжаасаа татгалзахад хэтэрхий хүнд байсан учир хэлэх ёстой зүйлээ цаг үргэлж хойшлуулж байв.

Тэд хоёр өдрийг эмнэлэгт өнгөрөөлөө. Невилл гарч, Билл хатагтай Помфрийн асрамжинд үлдэв. Шарх нь тийм ч сайн эдгэрээгүй тул Билл Хурц нүдэтийг санагдуулам болсон ч аз болоход хоёр нүд хөл нь бүтэн бөгөөд дотроо бол урьдын хэвээр үлджээ. Түүнд өөрчлөгдсөн зүйл гэвэл Билл дутуу шарсан бифштекст туйлын дуртай болсон явдал байлаа.

- Тэр надтай гэрлэхээр болсон сайн хэрэг гэж Флер Биллийн дэрийг засан баяртайгаар мэдэгдээд,
- Британчуудыг махаа хэт болгодог гэж би үргэлж хэлдэг байсан гэлээ.
- Би тэднийг үнэхээр гэрлэнэ гэдэгтэй эвлэрэх хэрэгтэй болсон бололтой хэмээн тэр үдэш Жинни Харри, Рон, Гермiona нарын хамт Гриффиндорын амралтын өрөөнд онгорхой цонхоор үдшийн бүрэнхийг харж суухдаа хэллээ.
- Тэр муугүй шүү дээ гэж Харри хэлснээ,
- Тийм ч хөөрхөн биш гэж Жиннигийн хөмсөг дээшлэхийг хараад яаран хэлэв.

Тэр дургүйхэн инээмсэглэв.

- За яахав хэрвээ ээж үүнийг тэсвэрлэх юм бол би ч гэсэн тэсэх болно.

- Өөр хэн нэгэн танил хүн үхэж үү? хэмээн Рон «Үдшийн зөнч» сонин дээгүүр харан асуулаа.

Түүний дууны хатуу өнгөнд Гермиона үрчийлээ.

- Үгүй гэж тэр зэмлэнгүй хэлээд сонинг хумхиж,
- Снеггийг хайсан хэвээр байгаа ч ямар ч үр дүнд үрсэнгүй ... гэв.
- Өөр яана гэж хэмээн Харри энэ сэдвийг дурьдах болгонд уурсдаг ёсоороо хэлээд,
- Снеггийг олохын тулд эхлээд Волан-де-Мортыг олох ёстой харин тэд энэ бүх хугацааны турш илрүүлж чадахгүй байгаа биз дээ ... гэв.
- Би явж унтлаа гэж Жинни эвшээснээ,
- Удтал унтсангүй ... за ер нь бол унтахад садаа болохгүй байх гэв.

Тэр Харриг үнсээд (Рон цаашаа харцаа буруулжээ) ахдаа болон Гермионад гар даллан охидын унтлагын өрөө лүү явлаа. Түүнийг хаалга хаамагц Гермиона урагш бөхийн царайны хувирал нь зөвхөн Гермионагийн маягтай болов.

- Харри би өнөө өглөө номын сангаас зарим нэг зүйл оллоо ...
- Р.А.Б. уу? гэж Харри тавцан дээр цэхлэн сууж асуув.

Тэр өмнөх шигээ нууцын гүнд хүрэх гэсэн догдол сониучирхлыг мэдэрсэнгүй. Тэр зүгээр л урд нь Дамблдорын хамт хөл тавьсан харанхуй зам байгааг мэдэж байсан тул одоо ганцаар явж хуурамч крестражын тухай бүх үнэнийг мэдэх ёстой болсноо ойлгож байв. Крестражууд хаа нэгтээ нуугдсан хэвээр тэд дөрвүүлээ байсан учир Волан-де-Мортыг дуусгахаас өмнө тус бүрийг нь олоод устгах шаардлагатай байлаа. Харри бодолдоо тэдний нэрийг давтаж жагсааж байв «Зүүлт ... аяга ... могой ... Гриффиндор болон Когтевранаас залгамжлагдсан ямар нэгэн зүйл ... Зүүлт ... аяга ... могой ... Гриффиндор болон Когтевранаас залгамжлагдсан ямар нэгэн зүйл».

Энэ уншлага Харрийн бодлыг өдөр шөнөгүй эзлэн зүүд нь хүрч чадахгүй аяга, зүүлт болон нууцлаг зүйлсээр дүүрч хэдийгээр Дамблдор туслахыг хичээх ч Харриг авирахаар олсон шатанд дөнгөж хүрмэгц могой болон хувирах аж ...

Тэр зүүлтний дотор байсан зурвасыг Гермионад Дамблдорын үхлийн маргааш өглөө нь үзүүлэхэд тодорхойгүй нэрний товчлол үсгийг хаа нэгтгээгээс уншиж байсанаа шууд таньсангүй бөгөөд гэрийн даалгавар хийх гэж байгаа мэт номын сан руу гүйсэн юм.

- Үгүй. Би хичээсэн ч Харри юу ч олсонгүй ... тэнд нэрний үсгийг санагдуулам хоёр алдартай шидтэн болох Розалинда Антигон Бочкис болон Руперт «Ампутатор» Брукстэнтон байсан ... гэвч тэд бидэнд ямар ч хамаагүй. Зурваст крестражыг хулгайлсан хүн Волан-де-Мортыг мэддэг байсан болохоор Бочкис, Ампутатор хоёрын тухайд гэвэл ямар ч баталгаа олсонгүй ... үнэнийг хэлэхэд ... би Снеггийн тухай л оллоо.

Энэ нэрийг хэлсэн нь Харрийн бухимдлыг төрүүлэхэд,

- Тэгээд юу гэж? хэмээн гашуунаар асуугаад сандалд лагхийн суулаа.
  - Гэхдээ миний эрлийз хунтайжын түүх зарим талаараа үнэн байсан байна гэж Гермиона болгоомжтой хэлэв.
  - Чамд заавал үүнийг дурсах нь ямар хэрэгтэй юм бэ? Надад ямар мэдрэмж төрж байгааг ойлгохгүй байна уу?
  - Үгүй ... Харри би энэ тухай яриагүй! гэж Гермиона яаран хэлээд ойр хавьд хүн байгаа эсэхийг шалган харлаа.
  - Энэ ном Эйлин Принцээс залгамжлагдан ирсэн гэдэг миний зөв байсан. Ойлгож байна уу ... тэр Снеггийн эх нь байж!
  - Харин тэр надад царайлаг биш гэж санагдаж байна хэмээн Рон хэлэв. Гермиона түүнд анхаарал хандуулсангүй.
  - Би үлдсэн бүх хуучин «Зөнч» сониныг эргүүлж үзээд жижигхэн мэдээлэл олсон. Эйлин Принц, Тобиас Снегг гэсэн нэртэй хүнтэй гэрлээд түүнээс арай хожуу хүүхэд нь мэндэлсэн тухай ...
  - ... алуурчин! гэж Харри хэлэв.
  - Тийм л дээ гэж Гермиона батлаад,
  - Гэхдээ миний зөв байсан биз дээ. Снегг «эрлийз Принц» гэдэг нэрээрээ бахархаж байсныг ойлгож байна уу? «Зөнч» сонинд Тобиас Снегг магл байсан гэж бичсэн байсан гэв.
  - Тиймээ бүгдийн учир олдож байна. Тэр цэвэр цусны шидтэнгүүд болох Люциус Малфой болон бусадтай тэдний адил юм шиг тоглож байж ... яг л Волан-де-Мортын адил. Эхийн цус цэвэр харин эцэг нь магл ... хоёулаа эцэг эхээсээ ичиж хүмүүсийг айлгахын тулд хар урлагийг ашиглан өөрсдөдөө сэтгэгдэл төрүүлэм нэр бодож олсон ... лорд Волан-де-Морт ... эрлийз хунтайж ... Дамблдор яагаад тааварлаагүй юм бол?
- Харри чимээгүй болоод цонхоор харлаа. Тэр Дамблдорын Снеггэд итгэж байсан уучлашгүй итгэлийн тухай бодлоо хөөж чадсангүй ... хэдийгээр Гермиона санамсаргүй түүнд сануулсан ч юунд ч итгээгүй ... Шившлэг аймшигтай байсныг үл харгалзан тэр тийм ухаантай тэгж их тусалсан хөвгүүний тухай муу юм бодохоос татгалзаж билээ ...
- Түүнд тусалсан ... Одоо энэ бодол тэвчихийн аргагүй байлаа ...
- Би түүнийг яагаад чиний номыг ашиглаж байсныг хэнд ч хэлээгүйг ойлгохгүй байна. Тэр чамайг хаанаас авсан гэдгийг мэдэх ёстой байсан гэж Рон хэлэв.
  - Тэр мэдэж байсан гэж Харри гашуунаар хэлээд,
  - Намайг Малфойд Сектусемпра шившлэг хэрэглэх үед ойлгосон. Ямар ч легилменцийн хэрэг байгаагүй ... харин урьд нь Слизнортын миний уусмалын

хичээлийн гялалзсан амжилтын тухай ярианаас ойлгож болох байж. Түүний шүүгээний ёроолд л хуучин сурах бичиг нь үлдсэн биз дээ?

- Тиймээ, гэхдээ тэр яагаад чамайг барьж өгөөгүй юм бол?

- Энэ номтой холбоотой болохоор хүсээгүй байх гэж бодож байна. Дамблдор энэ тухай сонсоод таалагдахгүй байсан. Тэр ч байтугай Снегг түүнд хамаагүй мэт төрх гаргасан ч Слизнорт бичгийн хэвийг дор нь таних байсан гэж бодож байна. Ямар ч тохиолдолд ном Снеггийн хуучин ангийн шүүгээнд хэвтэж байсан биз дээ. Харин Дамблдор түүний эхийн овог «Принц» гэдгийг мэдэж байсан гэдэгт мөрийцсөн ч болох юм хэмээн Гермiona хэлэв.

- Би номыг Дамблдорт үзүүлэх ёстой байж. Тэр надад хичнээн удаа Волан-де-Морт сургуульд байхдаа хорон санаатай байсан гэдгийг үзүүлж байхад би гартаа Снегг тийм гэдгийн баталгааг барьж байж ...

- Хорон санаа бол хэтэрхий хүчтэй үг гэж Гермiona аяархан хэлэв.

- Чи надад ном аюултай гэж баталж байсан биз дээ!

- Би өөр зүйлийн тухай ярьж байхад харин өөрийгөө буруутгаж байна, Харри.

Би хунтайжыг жигшүүртэй араншинтай гэж бодож байснаас биш алуурчин гэсэн бодол толгойд орж ирээгүй.

- Тиймээ бидний хэн ч Снегг тийм гэдгийг тааварлаагүй гэж Рон хэлэв.

Тэд чимээгүй болоод бүгд өөр өөрсдийн бодолдоо автахад Харри найзууд нь түүний адил маргааш өглөө Дамблдорын биеийг үдэх тухай бодож байгаа гэдэгт эргэлзсэнгүй. Сириусын үхлийн дараа оршуулах боломжтой бие үлдээгүй болохоор Харри урьд нь хэзээ ч оршуулганд оролцож байсангүй. Тэр юу хүлээж байгааг ч мэдэхгүй ч юу мэдрэх талаараа багагүй түгшиж байлаа. Ингээд Дамблдорын үхэл түүний хувьд бодит байна гэдгийг тааварлав. Цаг нь болон үхлийн айдас түүнийг эзэмдэн авахад Дамблдор үнэхээр байхгүй болсон гэдэгт итгэхэд бэрх байлаа. Үнэнийг хэлэхэд Харри Сириусын үхлийн дараах шиг Дамблдор ямар нэг аргаар эргэж ирж болох юм гэдэгт өөрийгөө итгүүлэн хайсангүй. Тэр одоо халаасандаа хаа сайгүй авч явах болсон сахиус болгосондоо ч биш харин түүнд хийх ёстой ажил үлдсэн гэдгийг сануулах хуурамч крестражын хүйтэн гинжийг мэдэрлээ.

Маргааш өглөө нь Харри өглөө эрт босож «Хогвартс Экспресс» галт тэргээр оршуулгын дараа явахаар юм хумаа зэхэв. Түүнийг доош буух үед Их танхим нам гүм байлаа. Бүгд ёслолын хувцасаа өмсөж хэн ч өлсөөгүй боллоотой. Профессор МакГонагаллын зүүн талд байгаа багш нарын ширээний голын хаан шиг суудал хоосон байлаа. Хагридын суудал бас хоосон байсныг бодвол өглөөний цайнд ирж чадсангүй биз. Гэвч Снеггийн суудлыг Руфус Скримжер эзэлжээ. Харри танхимийг гүйлгэн харж буй сайдын шар нүдний харцтай тулахгүйг хичээхэд Скримжер түүнийг харж байгаа юм шиг эвгүй мэдрэмж төрөв. Түүнчлэн сайдын дэргэд шаргал үс, эвэр хүрээтэй нүдний шил бүхий Перси сууж байх нь үзэгдэв. Рон төрсөн ахаа таньсны ямар ч шинж тэмдэг үзүүлсэнгүй бөгөөд зөвхөн утсан загасаа сэрээгээрээ ууртай хатгалаа.

Слизериний ширээнд Крэбб, Гойл хоёр аяархан ярилцаж байлаа. Тэдний дунд сууж байдаг өндөр цонхигор Малфойн үгүйд тэд хоёулаа хачирхалтай ганцаардмал харагдав. Харри Малфойг эдгээр өдрүүдэд бараг санасангүй. Түүний бүх бодлыг Снегг эзлээд мартсандаа ч биш харин цамхагын орой дээр Үхэл залгигчид ирэхэд саваагаа буулгасан айдсыг мартаагүй байлаа. Харри Малфой Дамблдорыг алж чадах байсан гэдэгт итгэсэнгүй. Тэр урьд нь Малфой хар урлагт автсан байдлыг үзэн яддаг байсан бол харин одоо өрөвдөх болжээ. Харри Малфой Волан-де-Мортын ажлыг хийгээгүйд эцэг эхийнх нь хамт алсан эсэхийг гайхширлаа.

Жинни түүний бодлогоширлыг таслан тохойгоороо хавирга руу нь нударлаа. Профессор МакГонагалл ширээнээс босоход танхим агшин зуур чимээгүй болов.

- Цаг боллоо. Шилтгээнээс өөрсдийн эрхлэгчээ дагаж гарцгаана уу.

Гриффиндорынхон миний араас гэж профессор МакГонагалл хэлэв.

Бүгд сандлаасаа чимээгүйхэн бослоо. Харри Слизеринчүүдийн эгнээний тэргүүнд Слизнорт гайхамшигтай сайхан маргад ногоон өнгийн мөнгө хатгамласан жанчтай байхыг ажиглалаа. Бас Пуффендуй тэнхимийн эрхлэгч професор Стебль хэзээ ч харагдаж байгаагүйгээрээ цэвэрхэн байж нэг ч толбогүй малгай өмссөн байв. Тэд үүдний танхимд хүрэх үедээ Филчийн дэргэд зогсож байсан хатагтай Пинс өвдөг хүрсэн гивлүүр бүхий даашинз өмссөн бөгөөд харин тэр өөрөө маш хуучин загварын хар хүрмэн дээр нафталины эхүүн үнэртэй зангиа зүүснийг харлаа.

Үүдний хаалгаар гараад чулуун довжоогоор буухдаа Харри нуурын зүг чиглэж байгаа болохыг ойлголоо. Нүүр төөнөсөн дулаахан нарны илчин дор бүгд профессор МакГонагаллын араас зуугаад сандал эгнүүлэн тавьсан эгнээ рүү чимээгүйхэн зүглэв. Эгнээ хооронд жигүүр гаргасан бөгөөд хамгийн эхэнд нь гантиг ширээ тавьжээ. Энэ нь зуны цэлмэг сайхан өдөр байлаа.

Сандлын талыг хэдийн элэгдсэн ноорхой, ганган дэгжин хувцас бүхий хөгшин залуу хүмүүс янз бүрийн хүмүүс эзэлжээ. Харри тэдний ихэнхийг мэдэхгүй ч дунд нь Фениксийн бүлгийн танил гишүүд байхыг харав. Кингсли Брустевр, Хурц нүдэт Грюм түүнчлэн үс нь эргээд хурц ягаан болон хувирсан Тонкс, Римус Люпинтэй гараасаа бариад зогсож байлаа. Түүнчлэн ноён ба хатагтай Уизли, Флерээр дэмнүүлсэн Билл, тэдний ард Фред, Жорж хоёр лууны хар ширэн хүрэмтэй зогсож харагдана. Энд бас Хатагтай Максим шууд хоёр хүний суудал эзлэн суусан байсан бөгөөд «Цоорхой тогоо»-ны эзэн Том, Харрийн хөрш сангасваа болох Арабелла Фигг, «Эмгэн шулмас» хамтлагын үсэрхэг баз гитарчин, «Шөнийн хүлэг баатар» автобусны жолооч Эрник Прэнг, Тахир гудамжинд жанч зардаг дэлгүүрийн эзэн хатагтай Малкин, «Гахайн толгой»-ны үйлчлэгч болон «Хогвартс Экспресс» галт тэргэнд тэргэнцэртэй идэх юм зардаг шидтэн эмэгтэй байлаа. Шилтгээний хий үзэгдлүүд бас байлцсан нь хурц нарны гэрэлд үзэгдэхүйц байсан бөгөөд хөдлөхөд нь агаар гялсхийх аж.

Харри, Рон, Гермиона, Жинни нар эгнээний эцэст нуурын ойролцоо суудал олж суулаа. Хүмүүс өөр хоорондоо шивнэлдэх нь зуны сэвшээ салхинд ногоо сэрчигнэх

адил сонсогдож алсад шувуудын жиргээ сонсогдоно. Цугласан хүмүүс үргэлжлүүлэн нэмэгдэхэд Харри Невилл Полумнад суухад эелдэгээр туслахыг харав. ДА-гийн гишүүдээс зөвхөн тэр хоёр Дамблдор үхдэг шөнө Гермионагийн дуудлагад хариу өгсөн бөгөөд Харри яагаад гэдгийг нь мэдэж байв. ДА-гийн бусад гишүүд больсон байхад ... зөвхөн тэд л ахин уулзана гэж найдан зоосоо үе үе шалгадаг байж.

Эхний эгнээ рүү золгүй царайтай Корнелиус Фаж ердийнхөөрөө гартаа ногоон бүрхээ эргэлдүүлэн өнгөрөв. Харри ард нь яваа Рита Скитерийг жигшин таниад улаан хумстай хуруундаа дасал болсон тэмдэглэлийн дэвтрээ барьсан байхыг нь харав. Дараа нь Харри уурандаа давхийсан бөгөөд түүний нүдэнд Долорес Амбриж бахын царайдаа уй гашуу тодруулж мушгиа үсэн дээрээ хар хилэн тууз зүүсэн харагдав. Тэрбээр усны дэргэд харуул аятай зогсож байгаа Флоренц хүн морийг ажигламагц яаран түүнээс хол байр эзлэв.

Эцэст нь багш нар суулаа. Харри Скримжер баргар төрхтэйгээр эхний эгнээнд профессор МакГонагаллын дэргэд суухыг хараад сайд Дамблдорын үхэлд үнэнээсээ харамсаж байгаа болов уу? гэж бодлоо. Тэгтэл газрын бус хачирхалтай хөгжим эгшиглэхэд саяхан сайдад дургүйцэж байснаа мартаад эргэн тойрноо харлаа. Зөвхөн тэр ч биш олонхи хүмүүс түгшсэн байртай эргэн харцгаав.

- Тэнд гэж Жинни чихэнд нь шивнэв.

Ингээд тэднийг харах үед нарны гэрэл туссан ногоовтор усны мандал дээр инферналуудыг аймшигтай санагдуулам усны хүмүүс суугаад ойлгогдохын аргагүй хэлээрээ дуу дуулж байв. Дуучдын үхлийн цонхигор царайг тойрон ягаавтар үс нь хөвнө. Хөгжим Харригийн үсийг босгосон ч таагүй байсангүй. Хөгжим уйтгар гуниг цөхрөлийг тод илтгэж байв. Тэр дуучдын царай руу хараад Дамблдорын үхэлд гашуудаж байгааг нь ойлгов. Тэгтэл Жинни ахин нударч тэднээс харц салгав.

Сандлын хоорондох эгнээ дундуур Хагрид удаанаар гарч ирлээ. Нүдэнд нь нулимс гялтагнаж чимээгүйхэн уйлсаар гартаа хүрэн улаан өнгийн алтлаг одод бүхий гялалзсан хуйлаастай зүйл барьсаныг Харри Дамблдорын бие болохыг нь ойлгоод цээж нь хөндүүрлэн өвдлөө. Рон цонхийн цайж мэгдсэн харагдсан бөгөөд Жинни, Гермиона хоёр өвдөг рүүгээ нулимс асгаруулав.

Урд нь юу болсныг Харри тодорхой харсангүй. Хагрид биеийг болгоомжтой ширээн дээр тавилаа. Дараа нь тэр эгнээ хооронд буцахдаа нусаа бүрээ үлээж байгаа юм шиг чанга нийхэд хэдэн ууртай харцаар шагнуулсаны тоонд Долорес Амбриж орлоо ... гэхдээ Харри Дамблдор үүнийг тоохгүй байсныг мэдэж байв. Харри түүнийг дэргэдүүрээ өнгөрөхөд нөхөрсөг толгой дохьсон ч ойн сахиулын хавдаж бөлцийсөн урдаа байгаа хүнийг харж чадахааргүй болжээ. Харри эргээд түүнийг арын эгнээнд сууж байгаа жижигхэн асрын хэмжээтэй өмд, цамц өмсөөд үхэр чулууны хэмжээтэй толгойгоо дуулгавартай бараг хүн шиг бөхийлгөсөн аварга биет Грохх руу очихыг харав. Хагридыг дэргэд нь суумагц Грохх толгойг нь илэхэд сандлын хөл газар шигдлээ. Харри гайхамшигтай энэ агшинд инээхийг хүссэн ч хөгжим намдахад урд талын гантиг ширээ рүү эргэж харлаа.



Жижигхэн биетэй, сэгсгэр үстэй энгийн хар жанч өмссөн хүн хөл дээрээ босож Дамблдорын биений өмнө зогслоо. Түүний юу ярьсныг Харри сонсож чадсангүй. Хачирхалтай үгнүүд түүний толгой дээгүүр өнгөрч байв. «Уужим сэтгэл» ...

«ухаалаг хувь нэмэр» ... «аугаа их сэтгэл» ... энэ бүхэн Харрид ойлгогдсонгүй. Тэр Дамблдорыг энэ үгтэй бараг холбоогүй болохыг мэдэж байв. Харри гэнэтхэн түүнийг дүйнгэ, хөөс, үлдэгдэл, мэх гээд инээмсэглэж байсныг саналаа ... энэ өнөөдөр юу илтгэж байгаа юм бол?

Зүүн талд аяархан ус цацлах чимээ гараад усны ард түмэн салах ёс гүйцэтгэх үгийг сонсохын тулд нуураас гарч ирэх нь үзэгдэв. Тэр Дамблдор хоёр жилийн өмнө Харрийн сууж буй газартай ойролцоо эрэг дээр бөхийгөөд лусын хэлээр тэдэнтэй ярилцаж байсныг саналаа. Дамблдор тэдний хэлийг хаана сурсан нь сонирхолтой юм. Тэд хичнээн удаа уулзаж байсан хэр нь нэг ч удаа энэ тухай хөгшин шидтэнгээс асууж байсангүй ...

Тэгтэл түүнийг Дамблдор үхсэн байхгүй болсон гэдэг аймшигтай маргашгүй үнэн нөмрөн авлаа ... Харри хүйтэн зүүлтийг алгаа өвдтөл чанга атгахад нулимсыг нь зогсоосонгүй. Тэр Жиннигийн харцнаас зугтан нуурын дээгүүр ой руу ширтэхэд жижигхэн хүний дуу гүнгэнэсээр байв. Тэгтэл гэнэтхэн мододын дунд хөдөлгөөн гарч хүн морьд бас хүндэтгэл үзүүлэхээр ирлээ ... Тэд мододын сүүдрээс гарсангүй ч Харри шидтэнгүүдийн зүг харан чимээгүйхэн зогсоод нумаа буулгахыг харлаа. Ингээд түүнд анхны хар дарсан зүүд шиг шөнө ойд хийсэн аялалд Волан-де-Морттой тулгарахад дараа нь Дамблдортой хийсэн ярианыхаа тухай саналаа. Хамгийн гол нь тэмцэх гэж Дамблдор тэгэхэд хэлээд ахин дахин тэмцлээ үргэлжлүүлж байж хорон муу санааны үндсийг тасалж чадна гэсэн билээ ...

Ингээд энд нарны хурц гэрэлд сууж байхдаа Харрид гэнэтхэн дэргэд нь эх, эцэг, загалмайлан эцэг, Дамблдор гээд тус бүрдээ түүнийг хамгаалахыг хүсэж байсан хүмүүс зогсож байх нь үзэгдэв. Гэвч одоо энэ бүхэн төгсчээ. Тэр одоо хэнд ч Волан-де-Морт тэдний хооронд босохыг зөвшөөрөхгүй болохоор эцэг эхийнхээ гар дор байхад гай зовлонгоос зайлсхийж чадна гэсэн хуурамч үзэгдлээс үүрд татгалзах болно. Энд шөнийн хар дарсан зүүд байхгүй, түүнийг аюулгүй байгаа гэж тайвшируулсан шивнэлт ч байхгүй ердөө энэ бүхэн түүний төсөөлөл байлаа. Сүүлчийн агуу хамгаалагч нь үхсэн болохоор тэр урьд өмнөхөөс илүү ганцаардмал болжээ.

Жижигхэн хар хувцастай хүн эцэст нь чимээгүй болоод суудалдаа суулаа. Харри хэн нэгэн магадгүй сайд босож ярихыг хүлээсэн ч хэн ч хөдөлсөнгүй.

Дараа нь хэдэн хоолой хашгирлаа. Хурц цагаан дөл ярсхийн Дамблдорын бие хэвтэж байгаа ширээг хучин авч улам өргөссөөр биеийг нөмрөн авлаа. Цагаан утаа тэнгэрт хөөрөн хачирхалтай дүрс үүсгэв. Харри галт шувуу цэнхэр тэнгэрт нисэхийг хараад зүрх нь агшин зуур зогсох шахсан ч дараагийн агшинд гал алга болов. Тэнд Дамблдорын биеийг тавьсан ширээг далдлан цагаан гантиг бунхан бий болсон байлаа.

Ахин айж цочирдсон хашгиралт сонсогдож агаарт бүлэг сум хөөрсөн ч хүмүүст хүрэхээс өмнө газар унав. Тэгэхэд Харри хүн морьд сүүлчийн удаа салах ёс гүйцэтгэснийг ойлгож шитэнгүүд рүү нуруу харуулан ой руугаа буцахыг харлаа. Үүний адил усны ард түмэн удаанаар ногоон ус руугаа орж нүднээс далдлагдав.

Харри Жинни, Рон, Гермиона нар руу харлаа. Роны царай нарны хурц гэрэлд үрчийж, Гермионангийн царайд нулимс гялтагнах хэдий ч Жинни удаан уйлсангүй. Тэр Харри руу квиддичийн цом хожсоны дараа тэврэн авсан үе шигээ төөнөсөн харцаар харж байсан болохоор энэ агшинд тэд бие биенийгээ маш сайн ойлгож түүнд хийх гэж байгаа зүйлээ хэлэх ёстойгоо «болгоомжтой бай» эсвэл «үүнийг бүү хий» гэсэн ч энэ бол түүний эцсийн шийдвэр бөгөөд учир нь тэр түүнээс өөр юу ч хүлээх боломжгүй байлаа. Тэр эцэст нь Дамблдор үхсэнээс хойш хэлэх ёстой байсан зүйлээ хэлэхээр сэтгэл шулуудав.

- Жинни сонсооч гэж хүмүүсийн дүнгэнэх чимээ гаран эргэн тойрон суудлаас босохтой зэрэгцэн хэлэв.

- Би чамтай хамт байж чадахгүй. Бид уулзахаа болих хэрэгтэй. Бидэнд хамтдаа байх боломж байхгүй.

Тэр хачирхалтай инээмсэглэлээр хариулав.

- Энэ бүхэн чинь ямар нэг тэнэг уужим сэтгэлийн шалтгаанаас болоод тэр үү?

- Энэ яг л ... би чамтай сүүлчийн долоо хоногийг өнгөрүүлэхдээ ... өөр хүний амьдралаар амьдарсан юм шиг. Гэхдээ би чадахгүй ... бид боломжгүй ... Надад ганцаараа хийх ёстой зүйл байгаа.

Тэр уйлсангүй зүгээр л түүн рүү харлаа.

- Волан-де-Морт хүмүүсийг дайсандаа ойртохын тулд ашигладаг. Тэр хэдийн нэг удаа чамайг миний сайн найзын дүү байсны төлөө ашигласан. Хэрвээ бид урьдын хэвээр үлдвэл ямар аюул чамд заналхийлж байгааг бодоод үз. Тэр энэ бүгдийг мэдэх болно. Тэгээд надад хүрэхийн тулд чамайг ашиглах болно.

- Хэрвээ энэ бүхэн надад хамаагүй байвал яах вэ? гэж Жинни хүчлэн асуулаа.

- Надад хамаатай. Хэрвээ энэ чиний оршуулга байсан бол би юу мэдрэх байсан бол ... энэ миний буруу байх болно ...

Жинни түүнээс эргээд нуур луу харлаа.

- Би хэзээ ч чиний тухай бодохоо больж байгаагүй. Зүгээр л чадаагүй. Үргэлж найдаж байсан ... Гермиона надад өөрийн амьдралаа хөөх ёстой магадгүй өөр хүмүүстэй уулзах ёстой гэж баталж байсан ч би чамайг дэргэдээ байхад илүү чөлөөтэй болохоо мэдэрч гэхдээ дэргэд чинь ам нээж чаддаггүй байсныг санаж байна уу? Тэр хэрвээ намайг жаахан өөрөөрөө байх юм бол чи илүү анхаарал хандуулна гэж бодсон юм.

- Гермиона ухаалаг охин гэж Харри инээмсэглэхийг хичээн хэлээд,

- Би чамтай эртхэн найзлаагүй нь харамсалтай байна. Бидэнд хичнээн их хугацаа байж болох вэ ... сарууд ... магадгүй жилүүд ... гэв.

- Тэгэхэд чи шидэт ертөнцийг тасралтгүй авраад завгүй байсан гэж Жинни инээвхийлэн хэлээд,

- Иймээс ... чи намайг гайхуулсан гэж хэлж чадахгүй нь. Би эрт орой хэзээ нэгэн цагт ийм зүйл болно гэдгийг мэдэж байсан. Чамайг Волан-де-Мортыг хөөгөөд аз жаргалгүй байх болно гэдгийг мэдэж байсан. Магадгүй ийм учраас надад таалагдсан ч байж болох юм.

Харри эдгээр үгийг сонсоод цаашид Жиннигийн дэргэд суувал шийдэмгий байдал нь алдагдах нь гэж бодов. Тэр эргэж харахад Рон мөрөн дээрээ уйлж байгаа Гермионаг тэврээд урт хамрынх нь үзүүрийг даган нулимс дусалж байв. Тэр Жиннитэй салах ёс гүйцэтгэн даллаад босож Дамблдорын бунхан руу алхан нуурыг тойрон явлаа. Явах нь нэг газраа суухаас амар байлаа. Замдаа крестраж болон Волан-де-Мортын алахын тулд түүнийг юу хүлээж байгаа тухай бодон ...

- Харри!

Тэр эргэж харлаа. Руфус Скримжер эрэг дээгүүр таяг руугаа хазайн доголсоор ойртож ирэв.

- Би чамтай хэдэн үг солино гэж найдаж байлаа ... Хэрвээ чи эсэргүүцэхгүй бол жаахан хамт алхах уу?

- Үгүй гэж Харри хайхрамжгүй хэлээд цааш явлаа.

- Харри энэ бол аймшигтай эмгэнэлтэй явдал гэж Скримжер аяархан хэлээд,

- Намайг энэ мэдээ хичнээн айлгасныг хэлж ч чадахгүй нь. Дамблдор агуу шидтэн байсан. Бидний санал зөрөлддөг байсан хэдий ч хэн ч түүнийг надаас дээр ойлгохгүй болохыг чи мэднэ ... гэв.

- Та юу хүсээ вэ? гэж Харри уйтгартай асуулаа.

Энэ асуулт Скримжерийн уурыг хүргэсэн хэдий ч түргэн царайны хувирлаа өөрчлөөд гашуудалтай ойлгосон төрх тодруулав.

- Харваас та гашуудсан бололтой. Би таныг Дамблдортой маш дотно байсныг мэдэж байна. Таныг хамгийн хайртай сурагч нь байсан гэж бодож байна. Та хоёрын хоорондын холбоо ...

- Та юу хүсээ вэ? гэж Харри зогсоод давтлаа.

Скримжер бас зогсоод Харри руу бөхийн гярхай харцаар харлаа.

- Түүнийг үхдэг шөнө таныг хамт байсан гэж ярьцгааж байна?

- Хэн хэлсэн юм? гэж Харри асуулаа.

- Дамблдорын үхлийн дараа хэн нэгэн цамхаг дээрээс Үхэл залгигчдийн нэг рүү шившлэг илгээсэн байсан. Бас тэнд хоёр шүүр байсан. Ид шидийн яам тоолж чаддаг юм шүү, Харри.

- Энэ тухай сонсоход баяртай байна. Тэгэхээр би Дамблдортой хаана байж тэнд юу хийж байсан нь миний хэрэг. Тэр энэ тухай хэн нэгэн мэдэхийг хүсээгүй.

- Биширмээр үнэнч зан байна даа хэмээн Скримжер уураа хүндхэн барьж хэлээд,

- Гэхдээ Дамблдор үхсэн, Харри. Тэр биднийг орхисон гэв.

- Дамблдор сургуулийг түүнд үнэнч хэн нэгэн үлдэхгүй болохоос нааш орхихгүй гэж Харри инээмсэглэн хэллээ.

- Хонгор хүү минь ... Дамблдор эргэж ирэх хүч байхгүй ...

- Би түүнийг ингэх хүчтэй гэж хэлээгүй байна. Та ойлгосонгүй. Тэгэхээр надад таньд хэлэх юу ч байхгүй.

Скримжер тээнэгэлзсэнээ дараа нь илүү ажил хэрэгч өнгөөр,

- Ид шидийн яам таньд бүх төрлийн хамгаалалт гаргаж өгөхөд бэлэн байна, Харри. Би таньд үйлчүүлэхээр баяртайгаар хоёр мракоборецоо өгөх байна ... гэв.

Харри инээлээ.

- Волан-де-Морт намайг алахыг хүсвэл ямар ч мракоборецууд түүнд саад болж чадахгүй. Ийм учраас санал болгосон явдалд чинь баярлалаа гэхдээ баярлалаа хэрэггүй.

- Тэгвэл гэж Скримжер хүйтнээр хэлээд,

- Миний таньд зул сараар хандсан хүсэлтийн тухайд гэвэл ... гэв.

- Ямар хүсэлт? Аан тийм л дээ ... Намайг бүгдэд таныг хэрхэн сайн ажиллан хуурч байгааг ...

- Энэ бүгдийн сэтгэл санааг өргөнө! гэж Скримжер огцом зандарлаа. Харри түүн рүү анхааралтай харлаа.

- Стэн Шапанькыг та тавиагүй л байгаа биз дээ?

Скримжерийн царай Вернон ахыг санагдуулам хүрэн улаан өнгөтэй болов.

- Би таны ...

- Бүрэн дүүрэн Дамблдорын хүн болсон гэдгийг харж байна гэж үү. Яг үнэн.

Ингээд хэдэн хормын дараа Скримжер эргээд өөр үг хэлэлгүй ууртай доголон буцлаа. Харри Перси түүнийг төлөөлөгч нарынхаа хамт хүлээх зуураа сандалд суун үлдээд нулимс асгаруулж байгаа Хагрид болон Грохх руу бухимдангуй харц шидэхийг харлаа. Рон, Гермиона хоёр яаран Харри руу явахдаа дэргэдүүрээ Скримжерийг өнгөрүүлэв. Харри эргээд удаанаар цааш явж найзуудынхаа гүйцэхийг хүлээгээд эцэст нь эвэрлэг модны сүүдэрт суулаа.

- Скримжер юу хүсээ вэ? гэж Гермиона шивнэн асуув.

- Зул сарын баяраар хүсч байсан зүйлээ. Намайг Дамблдорын тухай мэдээлэгч болгон ид шидийн яамны шинэ сурталчилгааны хөвгүүн болгохыг хүссэн гэж Харри мөрөө хавчив.

Энэ агшинд Рон өөртэйгээ тэмцэх шиг санагдсанаа дараа нь Гермionado чангаар,

- Сонсооч би гүйгээд Персигийн хоншоор луу тавиад өгье гэв.
- Үгүй гэж тэр хатуу хэлээд гараас нь зуурлаа.
- Тэгвэл надад дээрдэх юм шиг санагдаж байна!

Харри инээлээ. Тэр ч байтугай Гермiona хүртэл инээмсэглэсэн ч шилтгээн рүү харахдаа царай нь барайв.

- Бид ийшээ эргэж ирнэ гэж бодож байна уу? Хогвартс хаагдах болов уу?
- Магадгүй хаагдахгүй байх. Гэхдээ гэрт байх эндэхээс аюулгүй биш биз дээ?

Одоо хаа сайгүй адил байгаа. Би Хогвартсад хамгаалах олон шидтэнгүүд байгаа болохоор илүү аюулгүй гэж хэлэх байна. Харин чи юу бодож байна, Харри? гэж Рон хэлэв.

- Би сургууль ахин нээгдсэн ч ирэхгүй гэж Харри хэлэв. Рон нүдээ бүлтийгээд Гермiona гашуудалтайгаар,

- Би чамайг ингэж хэлэхийг чинь мэдэж байсан юм. Гэхдээ чи юу хийх гэж байна даа? гэлээ.

- Дамблдорын хүсэл ёсоор ахин нэг удаа Дурслынх руу явна. Гэхдээ тэнд удахгүй үүний дараа тэднийг үүрд орхих болно.

- Чи тэгээд сургууль руу ирэхгүй юм бол хаачих юм бэ?

- Годрикийн хонхор руу эргэж очдог юм билүү гэж бодож байна гэж Харри аяархан хэлэв. Энэ бодол түүний толгойд Дамблдор үхдэг шөнө орсон билээ.

- Надад бүх зүйл тэнд эхэлсэн шиг санагдаж байна. Ингээд үргэлж би тэнд очих ёстой юм шиг санагдаг байсан. Бас нас барсан эцэг эхийнхээ булшыг эргэхийг хүсч байна.

- Дараа нь? гэж Рон асуулаа.

- Дараа нь үлдсэн крестражуудыг эрж олох замдаа орно гэж Харри хэлээд нуурын усанд цайвалзан тусаж буй Дамблдорын цагаан бунхан руу харлаа.

- Тэр надаас үүнийг хүссэн учир бүх зүйлийг ярьсан. Хэрвээ Дамблдорын зөв байвал хаа нэгтээ дөрвөн крестраж нуугдаастай байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Би тэднийг эрж олоод устгах ёстой дараа нь Волан-де-Мортын долоо дахь сүнсний хэсэг биед нь байгаа учир түүнийг алах ёстой. Хэрвээ миний замд Северус Снегг тааралдвал надад хийснээс нь дээргүй зүйлийг өгөх болно.

Удтал чимээгүй болов. Цугласан хүмүүс тарахад хамгийн сүүлд Гроххын сүрлэг дүрс өмнөхийн адил гашуудан уйлж буй Хагридыг тэврэн гэлдэрлээ.

- Бид чамтай хамт, Харри гэж Рон хэлэв.

- Юу гэнээ?
- Танай нагац ах эгчийн чинь гэрт. Ер нь чамайг хаашаа ч явсан тэр гэсэн.
- Үгүй ... гэж Харри түргэн эсэргүүцэв. Тэр үүнийг тооцоогүй болохоор найзуудаа аюултай замаар дагуулалгүй ганцаар явах болно.
- Чи бидэнд урьд нь хэрвээ хүсч байвал цаг хугацааг буцааж болно гэж хэлсэн. Одоо цаг нь болоогүй гэж үү? хэмээн Гермiona хэллээ.
- Бид юу ч болсон гэсэн чамтай хамт. Гэхдээ найз минь чи Годрикийн хонхор луу чиглэхээс өмнө ээж аавын гэрээр орох хэрэг гарах байх гэж Рон хэлэв.
- Яах гэж?
- Билл, Флер хоёр гэрлэх гэж байгааг мартаагүй биз дээ?

Харри мэгдэн түүн рүү харав. Энэ хорвоо дээр хурим шиг тийм энгийн зүйл байдаг гэдэг нь итгэмээргүй гайхамшигтай санагдав.

- Тиймээ бид үүнийг алгасч болохгүй байх гэж эцэст нь дуугарлаа.

Түүний гар өөрийн мэдэлгүй хуурамч крестражад хүрэхэд урд нь хүлээж байгаа өшөө хорслын харанхуй замын эцэст Волан-де-Морттой тулгарах хүртэл сар, жил, арван жил болох ч бай түүнтэй Рон, Гермiona хоёр сүүлчийн аз жаргалтай өдрөө өнгөрүүлж байгаад зүрх нь баяртай цохилон.

ТӨГСӨВ